



ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ

МОНГОЛЫН ШҮҮХ, ЭРХ ЗҮЙ СУДЛАЛ

2025 №1 (111)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ:

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, дэд профессор,
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн захирал

ГИШҮҮД:

Ж.АМАРСАНАА

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc.D./, профессор

С.НАРАНГЭРЭЛ

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc.D./, профессор

Ж.БЯМБАА

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, профессор

Б.АМАРСАНАА

Хууль зүйн ухааны доктор /LL.D./, профессор

Ч.ХОСБАЯР

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, Улсын дээд шүүхийн
Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн

Г.БАНЗРАГЧ

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, Улсын дээд шүүхийн шүүгч

Д.ЦОЛМОН

Улсын дээд шүүхийн шүүгч

Н.БАЯРМАА

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, Улсын дээд шүүхийн шүүгч

Ц.ЦОГТ

Хууль зүйн ухааны доктор /LL.D./, Улсын дээд шүүхийн шүүгч

Д.ГАНГАБААТАР

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, дэд профессор, Үндсэн хуулийн цэцийн гишүүн

Б.БАТЦЭРЭН

Улсын дээд шүүхийн шүүгч

Х.ЭРДЭМ-УНДРАХ

Хууль зүйн ухааны доктор /Dr.jur./, дэд профессор, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал

М.УЯНГА

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, дэд профессор

Ч.НЯМСҮРЭН

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, профессор

РУДОЛЬФ ХЭЛМХАГЕН

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын

Бавари мужийн Пассау хот дахь Мужийн шүүхийн Ерөнхий шүүгч

ТАКАХАШИ АКИО

Осакагийн их сургуулийн хүндэт профессор, Отомон Гакуин их сургуулийн

Хууль зүйн факультетын профессор

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ДӨЛГӨӨН

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./,
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн
Шүүхийн судалгааны төвийн дарга

I ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛ5

Н.Баярмаа, Улсын дээд шүүхийн шүүгч

**ГЭМ ХОРЫН ЭРХ ЗҮЙН ТАЛААРХ ЗАРИМ ЭРГЭЦҮҮЛЭЛ: ЭДИЙН
БА ЭДИЙН БУС ХОХИРОЛ 6**

Л.Галбадар, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн

Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч

М.Мөнхбаатар, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн

Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч

**ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ОЙЛГОЛТ
БА ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛ.....41**

Б.Дөлгөөн

**УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД ХЯНАЛТЫН ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАХ ШАЛГУУР:
"ЭРХ ЗҮЙН ШИНЭ ОЙЛГОЛТ, ЭСХҮЛ ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭГ ТОГТООХОД
ЗАРЧМЫН ХУВЬД НИЙТЛЭГ АЧ ХОЛБОГДОЛТОЙ" ГЭХ ОЙЛГОЛТЫН ТАЛААР 61**

Б.Марал, Аюулгүй байдал судлалын докторант,

УИХ-ын даргын ажлын албаны ажилтан

**ХҮНИЙ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙГ ХАНГАХАД ХОГ
ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АСУУДАЛ 87**

С.Бямба-Эрдэнэ, Их Засаг Олон Улсын их сургуулийн докторант

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ..... 98**

Э.Эрхбилгүүн, УДШ-ийн дэргэдэх Шүүхийн академийн судлаач

Б.Тэлмэн, Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч

**ТӨВ БАНКНЫ ЦАХИМ МӨНГӨНИЙ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ: ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА..... 119**

Д.Отгонбаяр

**ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БА АРГАГҮЙ ХАМГААЛАЛТЫН
ХАРИЛЦАН ХАМААРАЛ..... 131**

Б.Сарнай

**ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ GERMAN УЛС БОЛОН АВСТРИ
УЛСЫН ХУУЛЬ ЁСНЫ ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ144**

Ж.Баасанжав, Их Засаг Олон Улсын их сургуулийн

Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч

ТОРГОХ ЯЛ: ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, ЭРХ ЗҮЙН

ЗОХИЦУУЛАЛТ ШҮҮХИЙН ПРАКТИК15

II СУДАЛГААНЫ ТАЙЛАН..... 165

УДШ-ийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи

"ПАБЖИ МОБАЙЛ" /PUBG MOBILE/ ТОГЛООМЫН ТАЛААРХ

ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....166

УДШ-ийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи

BNPL (ОДОО АВААД ДАРАА ТӨЛ) ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОЛОН УЛС ДАХЬ

ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ СУДАЛГАА192

III ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ 217

УДШ-ийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТОГТВОРЖУУЛАХ

ГЭРЧИЛГЭЭГЭЭР ТАТВАРЫН ХУВИАС ГАДНА ТАТВАР НОГДУУЛАХ

АРГАЧЛАЛЫГ ДАВХАР ТОГТВОРЖУУЛАХ ЭСЭХТЭЙ ХОЛБОГДОХ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ218

УДШ-ийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи

ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ГАРГАСАН ЗӨРЧИЛДӨӨ ШУУД САНААТАЙ,

ЭСХҮЛ ИЛТЭД БОЛГООМЖГҮЙ ГЭМ БУРУУТАЙ БОЛ ХУУЛЬД ЗААСАН

ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХТЭЙ ХОЛБООТОЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ

ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ..... 233

IV УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭЭС ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ ...247

Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхим

2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДРИЙН "АРИЛЖААНЫ ЕРӨНХИЙ

ХУУЛЬ"-ИЙН ТӨСӨЛД УДШ-ЭЭС 2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 13-НЫ

ӨДРИЙН АЛБАН БИЧГЭЭР ХҮРГҮҮЛСЭН САНАЛ 248

Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхим

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДРИЙН "СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН

ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН

СУУЦНЫ ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ"-ИЙН

ТӨСӨЛД УДШ-ЭЭС 2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДРИЙН

АЛБАН БИЧГЭЭР ХҮРГҮҮЛСЭН САНАЛ 253



**ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ
БҮТЭЭЛ**



ГЭМ ХОРЫН ЭРХ ЗҮЙН ТАЛААРХ ЗАРИМ ЭРГЭЦҮҮЛЭЛ: ЭДИЙН БА ЭДИЙН БУС ХОХИРОЛ

Н.БАЯРМАА¹

I. Гэм хорын эрх зүйн бүтэц: Хамгаалалтын зүйл

- Иргэнлэг эрх зүйн гэм хорын эрх зүйн бүтэц
- Нийтлэг (хэвшүүлсэн) эрх зүй дэх гэм хорын эрх зүйн бүтэц
- Явцын дүгнэлт

II. Гэм хор учруулсны үр дагавар

- Гэм хорын улмаас бий болсон эдийн засгийн хохирол
- Гэм хорын улмаас бий болсон эдийн бус хохирол

III. Гэм хорын эрх зүйн холбогдолтой зарим шүүхийн маргаан: Монгол Улс, 2023 он

IV. Дүгнэлт

¹ Улсын дээд шүүхийн шүүгч, хууль зүйн ухааны доктор /Ph.D./.



ГЭМ ХОРЫН ЭРХ ЗҮЙН ТАЛААРХ ЗАРИМ ЭРГЭЦҮҮЛЭЛ: ЭДИЙН БА ЭДИЙН БУС ХОХИРОЛ

Н.БАЯРМАА Улсын дээд шүүхийн шүүгч, хууль зүйн ухааны доктор /Ph.D./

Түлхүүр үг

Гэм хорын эрх зүй, гэм хор, гэм хорын бүрэлдэхүүн, гэм буруу, эдийн хохирол, эдийн бус хохирол, хамгаалагдах зүйл, гэм хорын үр дагавар, туйлын эрх, бусдын эрх, төсөөтэй бусад эрх, хувь хүний нийтлэг эрх, сэтгэл санааны хохирол, цочрол, өвдөлт, шаналал, *Action for iniuria, lex Aquilia*, сэтгэцэд учирсан гэм хор.

Хураангуй: Монгол Улс дахь гэм хорын эрх зүй нь иргэний эрх зүйн бусад салбаруудтай харьцуулбал бага судлагдсан салбар боловч нийтийн эрх зүйн хэрэг маргааныг хянах шүүх болох захиргааны болон эрүүгийн шүүх нь иргэний хэргийн шүүхийн нэгэн адил холбогдох эрх зүйн эх сурвалжийг хэрэглэн энэ төрлийн хэрэг маргааныг түгээмэл шийдвэрлэдэг онцлогтой. Энэ ч агуулгаар гэм хорын эрх зүй нь шүүхийн дагналт, мэргэшсэн байдлаас үл хамааран нийтлэг ач холбогдол бүхий сэдэв мөн. Гэвч судалгааны дүнгээс харвал шинэ үеийн Монгол Улсын иргэний эрх зүйн эх сурвалж, үе үеийн хууль тогтоомж дахь гэм хорын эрх зүйн хөгжил удаан, 1953 оны Иргэний хуульд анхлан туссан гэм хорын эрх зүйн үндсэн бүтэц өнөөдрийг хүртэл хэвээр хадгалагдаж, үзэл баримтлалын шинжтэй маш цөөн өөрчлөлт орж байв.

Гэм хорын эрх зүй нь эрх зүйн, сахилгын, ёс суртахууны хүрээнд үйлдэл, эс үйлдэхүйг бүхэлд нь хамарч, нийгмийн хөгжлийн шууд тусгал болон хөгжих, уян хатан салбар мөн. Улс орны түүхэн хөгжил, эрх зүйн өв уламжлалын онцлогоос шалтгаалан гэм хорын эрх зүйгээр санал болгож буй хамгаалалтын тогтолцоо харилцан адилгүй байх ба зарим улсад гэм хорын хэм хэмжээгээр хамгаалагдах зүйлийн хүрээг тодорхой тогтоож, учрах хор уршгийг хэрхэн арилгах талаар харьцангуй хязгаарлагдмал хандлагатай шүүхийн практик тогтсон бол зарим улсад хамгаалагдах эрх ашгийг нээлттэй үлдээж, хор хохирлын хэмжээг төдийлөн хязгаарлахгүй байх шинж ажиглагдаж байна. Өөрийн улсын түүхэн хөгжил, онцлог, эрх зүйн бүлийн чиг баримжааг харгалзан хууль хэрэглээний нэгдмэл чиг хандлагыг төлөвшүүлэх нь нэг талаас хууль тодорхой байх зарчмыг дэмжих бол нөгөө талаас иргэд, хуулийн этгээдийн эрх ашгийг тэнцвэртэй хангах хүчин зүйл юм.

Тус судалгааны ажил нь үндсэн гурван хэсэг болон дүгнэлтээс бүрдэх



бөгөөд гэм хорын эрх зүйн бүтэц гэх нэгдүгээр хэсэгт иргэнлэг ба нийтлэг эрх зүйн орнуудын гэм хорын эрх зүйн ерөнхий бүтцийн төстэй ба ялгаатай талыг хөндөхийн зэрэгцээ Монгол Улсын эрх зүй дэх гэм хорын эрх зүйн түүхэн хөгжлийг цухас авч үзсэн болно. Иргэнлэг эрх зүйн орнуудын гэм хорын эрх зүйн бүтцийг энэ бүлийн томоохон төлөөлөл болох Герман болон Франц улсын хуулийн зохицуулалт, шүүхийн шийдвэрлэсэн онцлог хэрэг маргааны жишээнд тулгуурлан хөндлөө.

Судалгааны ажлын хоёр дахь хэсэгт гэм хорын бүрэлдэхүүн, хууль бус үйлдэл, эс үйлдэхүйгээс үүдсэн эдийн ба эдийн бус хохирлыг арилгуулах онцлог, эдийн бус хохирлыг мөнгөөр тооцон арилгах жишээ, аргачлалын загварууд, Монгол Улсын гэм хорын эрх зүйд нэвтэрсэн сэтгэцийн гэм хорыг арилгах асуудлыг хөндөхийг зорилоо. Түүнчлэн эдийн хохирлыг арилгаж буй улс орнуудын ялгаатай байдал, түүний шалтгаан нөхцөлийг авч үзэн, гэм хорын эрх зүйгээр хамгаалагдах зүйлийг хэрхэн тодорхойлсон нь эдийн хохирлын агуулгыг тогтооход нөлөөлдөг гэх харьцуулсан эрх зүйн зарим судлаачийн үзэл санааг хуваалцлаа.

Монгол Улсын шүүхээс 2023 онд хянан шийдвэрлэсэн анхаарал татахуйц зарим хэрэг маргааны шийдвэр, эрхийн актын агуулгыг товч хөндөн, тухайн шийдвэрт дурдагдсан үндсэн дүгнэлт болон дүгнэлтийн онолын үндэслэлийг хураангуйлан хүргэв.

Тус өгүүллийн хэсэг тус бүрд явцын дүгнэлт өгч, агуулгыг тухай бүр хураангуйлахыг эрмэлзсэн бөгөөд явцын болон нэгдсэн дүгнэлт нь Монгол Улсын дахь гэм хорын эрх зүйн бүтэц, хөгжлийн хандлагыг танин мэдэх судлаачийн зорилгод чиглэсэн.

1. Гэм хорын эрх зүйн бүтэц: Хамгаалалтын зүйл

1.1. Иргэнлэг эрх зүйн гэм хорын эрх зүйн бүтэц

Орчин үеийн иргэнлэг эрх зүй дэх гэм хорын ойлголт

Иргэнлэг эрх зүйн бүлийн улсын иргэний хууль тогтоомжид хэн нэгний буруу үйлдэл, эс үйлдлээс бий болсон гэм хорыг арилгах үндсэн зохицуулалтыг тусгахдаа хуулиар хамгаалагдаж байгаа үнэт зүйлийн жагсаалтыг нээлттэй үлдээх, эсхүл нэрлэн жагсааж хаалттай хуульчлах аргын аль нэгийг сонгосон байна. Ийм хоёр өөр бүтэц бүхий иргэнлэг эрх зүйн бүлийн улсуудаас нээлттэй хэлбэрийн жишээнд Франц улс, хамгаалагдах зүйлийг жагсаан хязгаарласан улсын жишээнд ХБНГУ-ын Иргэний хуулийг тус тус нэрлэдэг.

Франц Улсын Иргэний хуулийн 1240 дүгээр зүйлд "Аливаа үйлдлээрээ бусдад гэм хор учруулсан хүн түүний үйлдлийн улмаас учирсан гэм хор (dommage)-ийг нөхөн төлөх үүрэгтэй" гэж, 1241 дүгээр зүйлд "Үйлдэл нь бусдад гэм хор учрах шалтгаан болсон бол тухайн этгээд гагцхүү үйлдлийнхээ төлөө төдийгүй хайхрамжгүй байдлынхаа төлөө хариуцлага хүлээнэ" гэж тус тус заасан байна. Францын хуульчид Иргэний хуулийн 1240 дүгээр зүйл дэх гэм хорын зохицуулалт нь санаатай учруулсан үйлдлийг хэлэх бол 1241 дүгээр зүйл нь гэм буруугийн



болгоомжгүй хэлбэрээр хийгдсэн үйлдэлд хамаарахаар заасан гэж үздэг.

Харин ХБНГУ-ын Иргэний хуульд энэ талаар бага зэрэг өөр зохицуулалтыг санал болгож, тус хуулийн 823 дугаар зүйлд "Бусдын амь нас, бие махбод, эрүүл мэнд, эрх чөлөө, өмчлөх эрх, эдгээртэй төстэй бусад эрх (sonstiges)-ийг санаатай ба болгоомжгүйгээр хууль бус (widerrechtlich)-аар хохироосон бол учруулсан хохирлоо нөхөн төлөх үүрэгтэй." гэж заасан. Судлаачдын үзэж байгаагаар "хууль бусаар" гэдэг нь "санаатай ба болгоомжгүй" гэсэн ойлголтыг тодруулж буй хэлбэр бөгөөд хэрэв гэм буруугүй бол хариуцлага хүлээхгүй байх санааг илтгэнэ¹. Энэ санаа Францын Иргэний хуульд ч нэгэн адил туссан боловч Германы Иргэний хуульд заасан шиг тодорхой байдаггүй.

Түүнчлэн гэм хорын эрх зүйн хувьд Франц ба Германы Иргэний хуулийн гол ялгаа нь Герман Улсын хувьд хуулиар хамгаалагдах үнэт зүйл буюу эрх ашгийг нэрлэн заасан бол Францын хууль энэ талаар нээлттэй байх хандлагыг баримталсан. Германы хууль ийнхүү хамгаалагдах эрх ашгийг нэрлэсэн нь хүний хувийн байдал, эрхэмсэг оршихуй, хүн, эсхүл эд хөрөнгөд учирсан гэм хортой хамааралгүй эдийн засгийн алдагдал гэх мэт нөхөн сэргээх боломжгүй гэм хоргардагтай холбоотой². Нөгөө талаас хамгаалагдах үнэт зүйл, эрхийг жагсааж болох ч үүнийг хаалттай томьёолох боломжгүй. Энэ ч учраас Германы Иргэний хуульд "эдгээртэй төстэй бусад эрх" гэх томьёоллыг нэмж тусгасан гэж судлаачид үздэг. Харин энэхүү өргөжүүлсэн томьёоллын хязгаар хаа хүрэх тухайд Германы шүүхийн практик ба судлаачдын онолын тайлбар төдийлөн зөрдөггүй бөгөөд энэ нэр томьёоны хүрээнд туйлын бусад эрхийг ойлгоно гэж адил агуулгаар тайлбарладаг байна. Тодруулбал, өмчлөх эрх нь Иргэний хуулийн 823.1 дэх хэсгээр хамгаалагдах бие даасан зүйл мөн бол эдийн баялгийн хязгаарлагдмал эрх болон эзэмшил нь туйлын эрхтэй төсөөтэй тул "эдгээртэй төстэй бусад эрх" гэдэгт хамаарна гэж үздэг.

Монгол Улсын Иргэний хуулийн 497.1-д "Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй" гэж хамгаалагдах үнэт зүйл, эрхийг жагсаан нэрлэснээрээ Германы Иргэний хуультай төстэй бүтэцтэй. Гэвч энэ жагсаалтын эхэнд байгаа "Бусдын эрх" гэдгийг хэрхэн тайлбарлан хэрэглэх талаар судлаачид санал солилцох, зөв практикийг хөгжүүлэх нь хууль хэрэглээний ач холбогдолтой. Германд "төсөөтэй эрх" гэх дээрх нэр томьёог агуулгаар нь тайлбарлаж, өмнө хэсэгт жагсаасан хамгаалагдах зүйл, эрхийн үндсэн мөн чанар болох хувь хүний салшгүй байдал (амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө), абсолют буюу туйлын эрх (өмчлөх эрх)-тэй төстэй байх зайлшгүй шинжийг агуулсан байхаар тайлбарладаг бөгөөд ийм шинжгүй, үүргийн харьцангуй эрх гэх мэт бусад эрхийг хамааруулдаггүй онцлогтой. Энэ талаар Германы хуульч Шварц, Вандт нар "... хамгаалагдсан зүйл ба эрх гэсэн ойлголтыг тусад нь авч үздэг. Хамгаалагдсан зүйл гэдэг нь амь нас, бие махбод, эрүүл мэнд ба эрх чөлөөг ойлгодог. Эдгээр нь тодорхой нэгэн тусгай эрхэд хамаарах юмс биш. Харин хувь

¹ James Gordley, Hao Jiang, Arthur Taylor von Mehren, An Introduction to the Comparative study of Private law: Readings, cases, materials, 2021, Cambridge University Press, p-301.

² Мөн тэнд, х-302.



хүний салшгүй хэсэг байдаг. 823.1-д заасан "эрх" гэдэг ойлголт өөр агуулгатай (жиш: өмчлөх эрх ба бусад эрх)" гэж тэмдэглэсэн байна³.

Хувь хүний салшгүй эрх болон туйлын бусад эрх гэм хорын эрх зүйгээр хамгаалагдана гэх Германы хуульчдын хандлага нь зөрчигдсөн эрхийг сэргээх нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлоход нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл туйлын эрхийг зөрчсөнөөр шууд буюу бодит хохирлыг арилгах үндсэн чиг тогтсон бөгөөд дамжмал шинжтэй, цэвэр эдийн засгийн агуулгатай хохирлыг арилгах нь туйлын эрхийн хамгаалалттай уялдахгүй гэж үзэх шүүхийн практик тогтжээ. Харин Франц Улсын гэм хорын эрх зүй дэх хамгаалагдах зүйл, эрхийн нээлттэй байдал нь хохирлын хэмжээг тогтооход Герман Улсаас өөр практик тогтох үндэслэл болсон. Ийнхүү эх газрын эрх зүйн бүлийн голлох хоёр улсын ялгаатай шүүхийн практик гэм хорын эрх зүйн хамгаалах зүйлийн хүрээг хэрхэн тогтоосноос ихээхэн хамаарчээ.

Манай улсын гэм хорын эрх зүйн зохицуулалтыг Герман Улсын зохицуулалттай шууд адилтгах боломжгүй хэдэн шинж байдгийн нэг нь Герман Улс гэм хорын эрх зүйгээр хамгаалагдах зүйлийн хүрээг жагсааж, хаалттай томьёолсон боловч Иргэний хуулийн 823.2-т "хуулиар хамгаалагдсан бусад эрх"-ийг зөрчсөнөөс хохирол учирсан бол хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээхээр зохицуулалтын хүрээг өргөжүүлсэн байдаг. Манай улсын Иргэний хуулийн 497.1 дэх хэсэгт "Бусдын эрх"-ийг хамгаалахаар заасан. Германы Иргэний хуулийн 823.1-д заасан аль нэг эрхийг зөрчөөгүй ч 823.2-т заасан хамгаалагдах хуульд заасан бусад эрхийг зөрчиж гэм хор учруулсан үйлдэл, эс үйлдэхгүйг санаатай хийсэн бол нэхэмжлэгч учирсан хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй байгаа нь манай Иргэний хуулийн 497.1-д заасан "Бусдын эрх" гэдэгтэй агуулгын хувьд дүйх эсэх нь сонирхол татна.

Герман Улсын хуульчид Иргэний хуулийн 823.2-т заасан "хуулиар хамгаалагдсан бусад эрх" гэх ойлголтыг "хамгаалагдах хууль"-ийн тухай ойлголттой холбон хөгжүүлсэн. Харин манай улсын хууль дахь "Бусдын эрх" нь "хамгаалагдах эрх"-ийн тухай ойлголтод суурилж байна.

Герман Улсын тухайд хуулиар хамгаалагдсан эрхийг гэм буруугүйгээр зөрчсөн нь хууль бусд тооцогдож болох ч нөхөн төлөх хариуцлагыг гагцхүү гэм буруутай үед л хүлээх онцлогтой. Ямартай ч Германы Иргэний хуулийн 823.2 дахь хэсэг нь хамгаалагдах зүйлсийн жагсаалтыг өргөжүүлсэн үр дагавартай нь тодорхой хэдий ч өмнө дурдсан туйлын эрх байх шаардлагаас илүүтэй зөрчигдсэн гэж үзэж байгаа тухайн эрхийг агуулсан хэм хэмжээнд цогцоор нь анализ хийх зарчмаар гэм хорын эрх зүйгээр хамгаалагдах эсэхийг тогтоох хууль хэрэглээг төлөвшүүлжээ. Тодруулбал, зөрчигдсэн гэж үзэж байгаа тухайн эрхийг агуулсан хууль нь нэг бүрчилсэн хамгаалалтыг бий болгосон байх ёстой. Нэг бүрчилсэн буюу индивидуал хамгаалалт гэдэг нь тодорхой этгээдэд чиглэсэн хамгаалалт гэсэн агуулгыг илэрхийлнэ. Тухайн хэм хэмжээгээр нийтлэг хамгаалалт санал болгосон бол энэ нь гэм хорын эрх зүйн нөхөн төлөх хариуцлагад хамааралгүй.

³ Кристиан Шварц, Манфред Вандт, *Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй*, орч. Л.Эрдэнэ-Очир, 3 дахь хэвлэл, орчуулга хийгдсэн 2017 он, 9 дэх тал.



Иймд тухайн хуулийн хэм хэмжээний чиг үүрэг нь нэг бүрчилсэн этгээдийг хамгаалах явдал байх учиртай⁴ гэж үздэг. Энэ үүднээс хуульч Шварц, Вандт нар Эрүүгийн хуулийн хэм хэмжээ нь бүхэлдээ нэг бүрчилсэн хамгаалалт бий болгосон онцлогтой боловч бичиг баримт хуурамчаар үйлдэх явдал нь баримт бичгийн үнэн зөв, баталгаатай байдлыг хангахад чиглэгдсэн баримт бичиг гэдэг институтыг хамгаалах олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн хэм хэмжээ гэж үзэн "хуулиар хамгаалагдсан бусад эрх"-д хамааруулахгүй талаар Германы дээд шүүх шийдвэрлэж байсныг дурджээ. Үүний нэгэн адил Мөнгө угаах тухай хуулийн хэм хэмжээг ч нэг бүрчилсэн хамгаалалтыг санал болгосон хууль гэж үзээгүй шүүхийн практикийг дээрх судлаачид мөн дурдсан байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 497.1-д заасан "Бусдын эрх"-ийг хуульд тусгайлан заасан байх агуулга хуулийн үндсэн текстэд тусгагдаагүй хэдий ч энэ эрх нь Иргэний болон бусад хуульд тодорхой заасан эрх байхыг шаардах шүүхийн практик давамгайлж байна. "Бусдын эрх" нь абсолют эрхийн шинжийг агуулсан байхыг шаардах эсэх нь шүүхийн практикт тодорхой болоогүй ч энэ нь нийтлэг бүрэн эрхээс илүүтэй хувь хүний эрхийг хамгаалсан байх хандлага шүүхийн практикт давамгайлж байна. Нөгөө талаас энэ эрхийг тухайлан хуульд томъёолоогүй ч тодорхой этгээдэд үүрэг үүсгэх замаар эрхийн хамгаалалтыг санал болгосон гэх агуулгатай шүүхийн шийдвэр гарсан байна. Хэрэв "Бусдын эрх" нь Иргэний хуулийн 497.1-д заасан туйлын эрхийн шинжийг агуулсан байх ёстой гэж үзвэл түүний хэрэгжилтийг хангах үүргийг Үндсэн хуулиас бусад хууль, хууль тогтоомжид үгчлэн заасан байх ёстой гэж үзэх нь ерөөсгөл болно. Учир нь туйлын эрх гэх ойлголт нь өөрөө туйлын утгаар хамгаалалтыг бий болгож, эрх эзэмшигчийн нөгөө талд буй тодорхой бус бүх этгээд уг эрхийг хамгаалах, хүндэтгэх үүрэг үүсдэг онцлогтой. Түүнчлэн чухамхүү өөрт нь тухайлан хүлээлгэсэн тодорхой үүргээ уг этгээд биелүүлээгүй эс үйлдэхүй нь учирсан гэм хортой хамааралтай эсэхийг тогтоох замаар гэм хорыг арилгаж буй шүүхийн практик ажиглагдаж байна. Энэ нь шууд утгаараа "Бусдын эрх"-ийн тухай биш ч тодорхой этгээдэд тодорхой үүрэг үүсгэснээрээ нөгөө талд тодорхой шаардах эрх бий болгож байгааг илтгэх үзэгдэл юм. Жишээ нь:

Монгол Улсын дээд шүүх, 2024.05.07, 001/ХТ2024/00098 дугаар тогтоол,
 Ч.С ба Т ББСБ, Э, Сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал

С, А нар нь орон нутгийн замд зам тээврийн осолд орсон. Осолд А-ийн гэм буруугаас болсон нь тогтоогдсон. Осол нь гол ба туслах замын уулзвар дээр болсон ба энэ үед бүрэнхий болж, үзэгдэх орчин ихээхэн хязгаарлагдсан байсан. Шинжээч дүгнэлтдээ тус зам дээр дарааллын тэмдэг байрлуулаагүйгээс анх удаа зорчиж байгаа жолооч гарцыг ялгахгүй байх боломжтой талаар дурдсан. Нэхэмжлэгч С хариуцагчаар автомашины өмчлөгчийг татсаны зэрэгцээ замын тэмдгийг байрлуулж, аюулгүй иргэдийг аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх үүргээ биелүүлээгүй гэж сумын засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурлыг хариуцагчаар татаж учирсан гэм

⁴ Кристиан Шварц, Манфред Вандт, Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй, орч Л.Эрдэнэ-Очир, 3 дахь хэвлэл, орчуулга хийгдсэн 2017 он, 114 дэх тал.



хороо нэхэмжилсэн. Улсын дээд шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, хариуцагч нарыг гэм буруутай гэж үзсэн. Ингэхдээ тээврийн хэрэгслийн өмчлөгчийн хувьд Иргэний хуулийн 499.1 ба 499.4-т заасан шаардах эрхийг, харин Засаг дарга ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хувьд Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасан шаардах эрхтэй гэж дүгнэсэн. Хариуцагч Засаг дарга ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын эс үйлдэхгүйг тогтооходоо шүүх нэхэмжлэгчийн эрүүл мэнд, эд хөрөнгийн эрхийг хамгаалсан Иргэний хуулийн гэм хорын шаардах эрхийн заалтыг баримтлахаас гадна энэ осол гарахад хүргэсэн эс үйлдэхүй буюу үүрэгжүүлсэн заалтыг тодорхойлох алхмыг хийсэн байна. Өөрөөр хэлбэл, хүний эрүүл мэнд, эд хөрөнгө нь хамгаалагдах эрх мөн боловч эг эрхийг хөндсөн эс үйлдэхүй гаргасан эсэхийг тогтооходоо тодорхой үүрэгжүүлсэн заалтыг хайх шаардлага үүссэн гэж үзнэ. Тус хэргийн тухайд Замын хөдөлгөөний дүрмийн 9.4.6 дахь заалтыг шаардах эрхийг бий болгосон тодорхой үүрэг гэж шүүх үзжээ⁵:

Түүнчлэн Германы гэм хорын эрх зүйд "өмчлөх эрх"-ийг хамгаалахаар заасан бол Монгол Улсын Иргэний хуулийн 497.1-д "эд хөрөнгө"-д учирсан гэм хорыг арилгахаар зохицуулсан. Энэ нь хууль хэрэглээний хувьд анхаарах шаардлагатай томъёолол. Тодруулбал, хэн нэгний өмчлөх эрхэд байгаа эд хөрөнгийг эвдэж чанарыг нь дордуулах, алга болгох нь өмчлөх эрхэд халдсан үйлдэл мөн. Харин хэн нэгнийг хууран мэхэлсний улмаас мэхлэгдсэн этгээд 5000 төгрөгийн зах зээлийн үнэтэй хувьцааг 500,000 төгрөгөөр гуравдагч этгээдээс худалдаж авсан бол худалдан авагчийн хувьцааны өмчлөх эрхэд хохирол учраагүй гэж үздэг. Учир нь тухайн хувьцаа угаас 5000 төгрөгийн үнэтэй байсан бөгөөд одоогийн өмчлөгчийн өмчлөлд байхдаа ч энэ үнэ өөрчлөгдөхгүй тул түүний хувьцаа өмчлөх эрхэд хохирол учраагүй. Харин мэхлэгдсэн этгээд 5000 төгрөгөөр авч болох хувьцааг 500,000 төгрөгөөр л авсан үйл баримт болжээ. Энэ нь угтаа хувьцааны өмчлөх эрхэд гэм хор учруулсан гэж үзэхэд хүндрэлтэй нөхцөлийг бий болгож байгаа юм. Иймд Монгол Улсын Иргэний хуульд "өмчлөх эрх" бус "эд хөрөнгө" гэж хуульчилсан нь зарим талаар дээрхээс ялгаатай тайлбар дагуулах боломжтой.

Энэ мэтээр хоёр хуулийн холбогдох зохицуулалтууд ялимгүй мэт боловч агуулгын ялгаатай байх ба томъёоллын агуулга, мөн чанар, хууль тогтоогчийн үзэл баримтлалыг зөв анзаарч, өөрийн улсын онцлогийг таньсан хууль хэрэглээг тогтоож, шүүхийн практикаар Монгол Улсын гэм хорын эрх зүйг хөгжүүлэх нь зүйтэй.

Ромын эрх зүй дэх гэм хорын ойлголт

Ромын хуульч Гаус (*Gaius*) үүргийг зөрчил (*delictus*) ба гэрээ (*contractus*) гэж анх удаа ялган ангилсан бөгөөд тэрээр гэм хорын эрх зүйн ерөнхий зарчмыг бус харин гэм хорын тодорхой төрлийг авч үздэг байв. Ромын эрх зүйд зөрчлийн улмаас нэхэмжлэгчийн гаргаж болох шаардлага (*action*)-ыг үндсэнд нь *iniuria action*, *lex Aquila action* гэж хоёр төрөлд хуваадаг байсныг Ромын болон дундад

⁵ Ч.С-ын нэхэмжлэлтэй, Т, Э, Сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал нарт холбогдох иргэний хэрэг, 2024.05.07-ны өдөр, 001/ХТ2024/00098 дугаар тогтоол, https://shuukh.mn/single_case/10488?daterange=2024/01/01%20-%202024/06/07%20&id=3&court_cat=1&bb=1.



зууны судлаачид олон зууны турш хөгжүүлж иржээ.

Action for iniuria- Энэ төрлийн нэхэмжлэлийг бусдыг цохих, хатгах зэргээр зохисгүй авирласан этгээдийн эсрэг гаргаж болохыг Ромын эрх зүйд зөвшөөрдөг байв. Түүнчлэн үнэн хэрэгтээ цохиулаагүй ч цохихоор гар далайхад ч хүчирхийлэлд өртлөө хэмээн айж мэгдэх нь *iniuria* нэхэмжлэл гаргах үндэслэл болно гэж Ромын хуульчид тайлбарласан байна. Ромын Дигестэд энэ төрлийн нэхэмжлэлийн талаар олон жишээ дурдсаны дотор

"... хэн нэгнийг дайрч, даажигнаж дуу зохиох, эзэн хаанд бичсэн өргөдөл, гомдолдоо нэр төрийг нь гутаах, хэн нэгний боолыг зодох⁶, гэртээ олон хүн цуглуулж, дуу чимээ гаргах, шуугиан тарих зэрэг тохиолдлуудад *iniuria* нэхэмжлэл гаргаж болно. Эмэгтэй хүнийг өдөж хоргоох, эсхүл олон нийтийн газар эмэгтэй хүнтэй заавал хамт байх ёстой дагуулыг нь авч явах, хулгайлах нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болох"⁷ талаар Ромын хуульч Ульпиан Дигестийн 47.10.15.20 дахь хэсгүүдэд бичиж үлдээжээ.

Дундад зууны үеэс XVIII зууныг хүртэл хугацаанд *iniuria* нэхэмжлэлийг хэн нэгний нэр төр, эрхэмсэг оршихуйд халдсан буруу үйлдлийн эсрэг гаргах нь нэгэнт тогтсон ойлголт болсон байв. Хуульч Рэйнард Зиммерманн "Бусдыг элэг доог хийж, тахир дутуу, бөгтөр гэх зэргээр дуудах нь хүний төрөлхийн халдашгүй байдлыг хөндсөн, гэм хор учруулах үйлдэл мөн. Хэн нэгнийг егөөдөж "*bonus patiens vir*" (хууртагдсан, араар тавиулсан нөхөр) гэж нэрлэх, эсхүл "*ego saltem scortator non sum*" (завхай, шалиг этгээд) гэх, ... зэргээр бусдыг хочлон нэрлэх нь амаар гэм хор учруулах хэлбэрт тооцогдоно. Бусдын нүүр амыг татах, хэлээ гаргах, хүсэл зоригийнх нь эсрэг эмэгтэй хүнийг үнсэх зэрэг нь *iniuria* нэхэмжлэлийн үндэслэл болно" гэж XVIII зууны үед Германд тогтсон *iniuria* нэхэмжлэлийн талаар жишээ татсан байна⁸.

Монгол Улсын Иргэний хуулийн 497 дугаар зүйлд хувь хүний нэр төр, алдар хүндэд нь сэв суулгаж, хохирол учруулсан тохиолдолд гэм буруутай этгээд хариуцлага хүлээх, мөн хуулийн 21 дүгээр зүйлд иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг тухайлан хамгаалж, хохирлыг хэрхэн арилгах талаар тус тус зохицуулсан нь Ромын эрх зүйн *iniuria* нэхэмжлэлийн хэв маягийг уламжилж үлдсэнийг илтгэх юм.

Харин одоогийн Францын Иргэний хуулийн 1240-1, Германы Иргэний хуулийн 823.1 дэх хэсгүүд нь нэхэмжлэлийн дараагийн төрөл болох *lex Aquilia*-аас үүсэлтэй талаар судлаачид тэмдэглэсэн байдаг. Энэ төрлийн нэхэмжлэлийг гаргахад урьдчилсан хоёр нөхцөл бүрдсэн байхыг шаардана. Үүнд: нэгт, хариуцагч гэм буруутай байх, хоёрт, нэхэмжлэгчид гэм хор учирсан байх нөхцөлүүд хамаарна. Ромын эрх зүйн ихэнх жишээнд эд хөрөнгө бодитой эвдэрч гэмтээгүй ч эд

⁶ Энэ нь бусдын бие махбодод гэмтэл учруулж байгаагаараа *lex Aquila* нэхэмжлэл гаргах байдлаар орчин үед ойлгож болох хэдий ч тухайн үед боол нь хувь хүн бус, хэн нэгний хөрөнгө гэж тооцогддог байсны хувьд боолыг нь зодсоноор түүний эзнийг доромжлон харьцсантай адилтан үздэг байжээ.

⁷ James Gordley, Hao Jiang, Arthur Taylor von Mehren, *An Introduction to the Comparative study of Private law: Readings, cases, materials*, 2021, Cambridge University Press.

⁸ Reinhard Zimmermann, *The law of Obligations: Roman Foundations of the Civilian Tradition*, 1990, 1065-66.



хөрөнгөө алдсан тохиолдолд энэ төрлийн нэхэмжлэлийг гаргахаар дурдсан байдаг.

Харин Ромын эрх зүйд нэхэмжлэгчийн эд хөрөнгө биш өөрөө гэмтсэн бол *lex Aquilia* нэхэмжлэлийг гаргах замаар хохирлоо нөхөн төлүүлэх боломжгүй гэж үздэг атлаа нэхэмжлэгч өөрөө бус түүний захиргаанд байх хүүхдэд нь ийм гэм хор учирсан бол энэ хохирлыг арилгуулахаар эцэг нь шаардах эрхтэй гэж үздэг байсан нь сонирхол татаж байна. Энэ эрхийг хүлээн зөвшөөрсөн тун цөөн жишээ тэмдэглэгдэн үлдсэнээс хуульч Ульпианы бичсэн дараах хоёр жишээг эш татах нь нийтлэг байжээ:

*"... Гуталчин өөрийн шавь, эрх чөлөөт хүүг муу сурсан гэж буруутган хүзүүнд нь цохисноос хүүгийн нүд бүлтэрчээ. Багшийн энэ үйлдэл шавиа доромжлох, гутаах бус, сургах, заах зорилготой байсан тул энэ тохиолдолд *iniuria* нэхэмжлэл тохиромжгүй. Багш шавиа сургах зорилгоор хөнгөн цээрлүүлэх, зэмлэхийг л зөвшөөрдөг тул энэ нь багш шавийн хооронд байгуулсан сургалтын гэрээний үүргийн зөрчил байж болох юм. Гэвч миний бодлоор энэ нь *lex Aquilia* нэхэмжлэлийг багшийн эсрэг гаргах үндэслэл мөн⁹.*

*Хэрэв эрчүүд бөх барилдах, бокс тоглох үедээ хэн нэгнийхээ амийг хохироосон бол энэ нь нийтийн тэмцээний үед болсон явдал тул *lex Aquilia* нэхэмжлэлийг гаргах боломжгүй. Учир нь тэмцээн нь хэн нэгнийг гэмтээх бус сүр жавхлантай эрхэмсэг ялалтыг авчрах зорилготой...¹⁰"*

Дундад зууны үеийн гэм хорын ойлголт, философи үндэслэлийг хөгжүүлэх оролдлого

Хэдийгээр гэм хорын нэхэмжлэлийн онолын үндэслэл тодорхой болоогүй ч Ромын хуульчдын текстийг тайлбарлах замаар гэм хорын төрлийг нэмэх явдал дундад зууны эхэн үед нэн өргөжсөн байна. Глоссаторууд (XIII зууны дунд үеийн хууль тайлбарлагчид) нэхэмжлэгчийн бие махбодод гэмтэл учирсан бол гэм хорыг арилгуулах үндэстэй гэж үзэх болсон. Ийм ч учраас энэ үед хэн нэгний захиргаанд байгаагаас үл хамааран хүү алагдсан бол гэм хороо арилгуулах боломжтой гэж тайлбарлаж эхэлсэн бөгөөд ингэхдээ хуульч Ульпианы дээрх хоёр жишээнд тулгуурладаг байв. Энэ тохиолдолд нэхэмжлэгч нь нас барсан этгээдийн өв залгамжлагч, хамаатан нь байх ба нас барагчийн эхнэр, хүүхдүүд дэмжигчээ алдсаны хохирлыг шаардах эрхтэй төдийгүй амссан өвчин, шаналлаа ч нөхөн төлүүлэх боломжтой гэх үзлийг XVII зууны үеэс эхлэн хүлээн зөвшөөрөх болжээ¹¹. Харин бодит алдагдал, гэмтэлд үл хамаарах эдийн засгийн хохирлыг гаргуулах тухай тодорхой дүрэм тогтоогүй бөгөөд дундад зууны үеийн хуульчид нөхөн төлүүлж болох эсэх талаар ялгаатай жишээ гарган үндэслэлийг тайлбарласан судалгаа цөөнгүй байна.

Орчин үеийн Иргэний хуулиудад Ромын үеэс улбаатай *lex Aquilia* нэхэмжлэлийн олон төрлийг хөгжүүлж ирсний зэрэгцээ гэм хорын эрх зүйн ерөнхий онол,

⁹ Dig.9.2.5.3. дам ишлэв.

¹⁰ Dig.9.2.7.4. дам ишлэв.

¹¹ Reinhard Zimmermann, *The law of Obligations: Roman Foundations of the Civilian Tradition*, 1990, 1024-6.



зарчмыг тодорхойлох оролдлогууд гарч эхлэв. Дундад зууны үеийн хуульчид гэм хорын эрх зүйн фиолософи үндэслэл, ерөнхий зарчмыг тогтоохыг эрмэлзэхээс илүүтэй Ромын хуульчдын гаргасан жишээ, кэйсийг тойрон хэлэлцэх замаар тайлбарыг хөгжүүлж байсан бол сүүлийн үеийн хуульчид гэм хорын эрх зүйн философи үндэслэлийг эрэлхийлж, энэ талаар Аристотель, Аквины Фомагийн сургаалыг эшлэх болжээ. Тодруулбал Аристотелийн солилцооны зүй ёсны онол¹²-оор хүмүүс хооронд сайн дурын ба сайн дурын бус солилцоо явагдах бөгөөд сайн дурын солилцоо хийсэн бол хүлээн авсан зүйлийнхээ хариуд зохист төлбөрийг төлөх нь шударга буюу зүй ёсны үүрэг гэж үздэг¹³. Харин хэн нэгэн этгээд түүнд зүй ёсоор хуваарилагдах ёстой нөөц баялгаа өөрөөс үл хамаарах шалтгаанаар бусдад алдсан бол энэ нөөц баялгийг авсан этгээд хохирогчид ногдох хэсгийг нөхөн төлөх үүрэгтэйг солилцооны зүй ёсны онол номлодог¹⁴.

Аристотелийн энэхүү номлолыг хожим олон алдартай иргэний эрх зүйчид хөгжүүлсний дотор хуульч Гротиус

"Гэрээний тухайд хангалттай ярилаа. Одоо буруу зүйл хийснээс үүдэх жам ёсны хуулийн талаар ярилцах нь зүйтэй. ... Хэрэв буруу зүйл хийснээс хохирол учирсан бол энэ хохирлыг арилгах үүрэг жам ёсных байх учиртай. Хохирол (Damage-eng damnumlat) гэдэг нь хэн нэгэнд жам ёсоор ногдох зүйл, эсхүл өмчлөх эрх болон хуулийн дагуу харьяалагдаж байсан зүйл нь багасахыг хэлнэ. Түүнд жам ёсоор харьяалагдах зүйл гэдэгт түүний амьдрал, бие махбод, эрхтэн, нэр төр, үйл хөдлөлийн эрхийг ойлгоно. ... хүн өмчийн эрх, эсхүл гэрээгээр аливаа эд хөрөнгийг өөртөө авч болохын адил үйл хөдлөлөөр ч жам ёсны бусад зүйлүүд түүнд харьяалагдаж болно" гэж дэлгэрүүлэн тайлбарлажээ¹⁵.

Дундад зууны үеийн хуульчид Ромын эрх зүйгээс уламжлагдан ирсэн гэм хорын олон төрөлд хариуцлага хүлээлгэх онолын үндэслэлийг тодорхойлж, чухамхүү ямар шалтгаан, үндэслэлээр эрхийг сэргээн, хохирол барагдуулж, нөхөн төлөх шаардлагатай болохыг эртний сэтгэгчдийн үзэл сургаалд тулгуурлан хөгжүүлсэн нь гэм хорын эрх зүйн хөгжилд үнэтэй алхам болжээ.

Монгол Улс дахь гэм хорын эрх зүйн хөгжил

Олноо өргөгдсөн Монгол Улсын үеийн хууль тогтоомжийг эрүүгийн ба иргэний эрх зүйн эх сурвалж гэж ангилан эмхэтгэсэн судалгааны ажлуудаас үзвэл 1926 оны Иргэний хуулиас өмнөх он жилүүдэд иргэний бие даасан хууль байгаагүй. Илүүтэй зөрчлийн тодорхой шинжээр төрөлжсөн, тусгай хууль тогтоомж үйлчилж байжээ. Тодруулбал, "Мөрийцөн пай наадсан тайж, ардыг шүүн тодорхойлж, хүнд нэмэгдүүлэн шийтгэх дүрэм", Архи ууж, самууран явагчдыг шийтгэх дүрэм",

¹² Хуульч Ж.Оюунтунгалаг нь *Харьцуулсан иргэний эрх зүй* (2013) бүтээлдээ Аристотелийн "commutative justice" гэх нэр томъёог "солилцооны зүй ёс" хэмээн анх удаа орчуулан буулгасан байдаг. *Харьцуулсан эрх зүй* бүтээлийн 40 ба 43 дугаар талуудаас дэлгэрүүлэн үзнэ үү

¹³ James Gordley, Hao Jiang, Arthur Taylor von Mehren, *An Introduction to the Comparative study of Private law: Readings, cases, materials*, 2021, Cambridge University Press, p-305.

¹⁴ James Gordley, Hao Jiang, Arthur Taylor von Mehren, *An Introduction to the Comparative study of Private law: Readings, cases, materials*, 2021, Cambridge University Press, p-305.

¹⁵ James Gordley, Hao Jiang, Arthur Taylor von Mehren, *An Introduction to the Comparative study of Private law: Readings, cases, materials*, 2021, Cambridge University Press, p-309.



Аливаа чинээ бүхий наймаачин хүн нар хөдөө газраас ирэх хонь, мал, тос, өвс, түлээг зам тосон авах тухай цаазлан зогсоох тухай дүрэм", Аливаа лам нар хороо харчуудын газраа хольцолдон муу самуун явахыг цагдан цээрлүүлэх учраа тогтоосон гучин хоёр зүйлийн дүрэм", "Аливаа архи уух, мөрийцөн наадах зэргээр аар саар хэргийг өөр өөрийн харьяат газарт шийтгүүлэх тухай дүрэм", Нийслэл хүрээнд худалдахаар ирэх зүйлийг замаас тосон авч худалдахыг хориглосон дүрэм", Аливаа гал алдаж түймэр тавьсан ба төмөр утасны модыг түлсэн, эвдсэн хүмүүсийг хэрхэн шийтгэх тухай зэрэг төрөлжсөн дүрэм" журмуудыг Богд хааны зарлигаар 1913–1918 оны хооронд батлан мөрдүүлж байсан нь тэмдэглэгдэн үлджээ.

Шинэ үеийн Монголын хууль цаазын түүхэнд гэм хорын эрх зүйн бие даасан хууль батлаагүй ч 1926 онд баталсан Иргэний хуулийн Аливаа иргэний хэргийн учир харилцан эдлэх ба хүлээх эрх үүргийн тухай гэх наймдугаар бүлгээр гэрээний үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулсан. Энэ бүлгийн 155 дугаар зүйлийн хоёр дахь өгүүлбэр болох "... хэрэв ямарваа хүмүүн буюу ... хүмүүний эрхийг эдлэх газрууд аливаа хүмүүн буюу мөн газруудад хорлол сүйтгэл болгох жич бусдын эд хөрөнгөд халдах зэрэг зүй бусаар ашиглаваас мөн эцсийн аливаа үүргийг хууль дүрмийн ёсоор хүлээвээс зохимой¹⁶" гэж заасан нь гэрээ хэлцэлд хамааралгүй, үүргийн эрх зүйн гэм хорын шинжтэй бусад харилцааг зохицуулсан эх сурвалж гэж үзэж болохоор байна.

Харин 1952 онд батлагдсан Иргэний хуулийн "Бусдад хор хүргэснээс үүсэх үүрэг" гэх арван долоодугаар бүлгийн 253–268 дугаар зүйлээр гэм хорын эрх зүйн бүтцийг бий болгосон хэм хэмжээг бүтээжээ. Хуулийн 253 дугаар зүйлд "Хүний бие ба түүний эд хөрөнгөнд хор хүргэсэн этгээд нь учруулсан хорыг арилгах үүрэгтэй болно. ..." гэж зааснаараа хамгаалагдах зүйлийн хүрээг "хүний бие, түүний эд хөрөнгө"-өөр хязгаарласан бол мөн зүйлд үргэлжлүүлэн "... хэрэв уг учруулсан хорыг урьдаас болгоомжлон зайлуулж чадахгүй байсан буюу эсвэл хуульд байж болохуйц байдлаар уг хорыг учруулахад төлөөлөгдсөн хийгээд эсхүл хохирсон этгээдийн өөрийн зориуд санаатайгаар буюу хэтэрхий болгоомжгүйгээс болсныг баталбал хариуцахаас хэтэрнэ¹⁷" гэж заасан нь гэм хорын эрх зүйд гэм буруугийн зарчим үйлчлэх учиртайг тогтоосон байна.

Түүнчлэн орчин тойрондоо аюултай зүйлс, эрх, үүргийг эдлэх чадваргүй этгээд, насанд хүрээгүй хүний учруулсан хохирол, регрессийн зарчмын талаарх анхны нарийвчилсан зохицуулалтыг тус хуульд тусгасан байна.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Иргэний хууль дахь гэм хорын эрх зүйн бүтэц 1962 оны Иргэний хуулийн бүтцээс төдийлөн ялгаагүй байна. Зарим нэг социалист үзэл санаатай үг хэллэг, агуулгыг өөрчилсөн байх боловч үндсэн бүтэц, гэм буруугийн зарчим, гэм хорын ерөнхий ба тусгай шаардах эрхийн дараалал, зүйл заалтын тоо, үйлчлэх цар хүрээ нь 1994 оны шинэчлэн найруулсан Иргэний хуулийн гэм хорын хэсэгтэй нэлээд төстэй байна. 1962 оны Иргэний хуулийн арван наймдугаар бүлэг нь иргэдийн амь бие, эд хөрөнгө, албан байгууллагад гэм хор учрах явдлаас сэргийлэх, учирсан тохиолдолд хамгаалах,

¹⁶ Ред Ц.Зориг, Ж.Наранпүрэв, Ч.Нямсүрэн, *Монголын шүүх- эмхэтгэл 1*, 315-р тал.

¹⁷ Ред Ц.Зориг, Ж.Наранпүрэв, Ч.Нямсүрэн, *Монголын шүүх- эмхэтгэл 1*, 505-р тал.



сэргээх зорилготой байгаа бол 1994 оны Иргэний хуулийн 377.1 дэх хэсгээр хамгаалагдах зүйлийн хүрээг бусдын амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгө болгон өргөжүүлж, улмаар тусгай шаардах эрхийн бүлэгт бараа, ажил үйлчилгээний дутагдлын улмаас үүссэн гэм хорын тусгай шаардах эрхээр нэмэн, эдийн бус хохирлыг арилгах зарчмын өөрчлөлт оруулснаараа дэвшилттэй болсон.

Улмаар 1994 оны шинэчлэн найруулсан Иргэний хууль дахь гэм хорын бүтэц өдгөө хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2002 оны Иргэний хуульд үзэл баримтлалын ялгаагүй шахам уламжлагдсан бөгөөд сүүлд орсон сэтгэцэд учирсан гэм хорыг арилгах тухай нэмэлт, өөрчлөлт нь үзэл баримтлалын дэвшил болсон нь маргаангүй.

1.2. Нийтлэг (хэвшүүлсэн) эрх зүй дэх гэм хорын эрх зүйн бүтэц

Нийтлэг эрх зүйд нэхэмжлэгчид хохирол учирсан эсэх, хариуцагч бусдын тодорхой эрх, эсхүл түүнтэй төстэй эрхийг зөрчсөн эсэхэд шууд анхаарлаа хандуулдаггүй. Харин энэ төрлийн зөрчлөөс үүдсэн гэм хорын нэхэмжлэлийг хүлээн авах жишиг шүүхийн практикт тогтсон эсэхийг л анхаардаг. Нийтлэг эрх зүйн шүүх шийдвэрлэдэг хэргийн жагсаалт буюу врит (writ-анг) дэх гэм хорын нэхэмжлэл (нийтлэг эрх зүйд анх гэм хорын ба гэрээний эрх зүй гэх уламжлалт ангилал байгаагүй хэдий ч өнөөдөр гэм хорын эрх зүй сайн хөгжсөн)-д гагцхүү "trespass" буюу хэн нэгэн эд бараагаа алдсаны улмаас хохирсон, эсхүл цохиулж, зодуулсны улмаас гэмтэл учирсан үед гаргах бүлэг нэхэмжлэлийг ойлгож заншсан байв.

Энэхүү врит буюу хэрэг, нэхэмжлэлийн жагсаалт нь хуулиар хамгаалагдвал зохих эрх, ашиг сонирхлын жагсаалт биш бөгөөд илүүтэй XII, XIII зууны үеийн хааны шүүх хүлээн авч шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн "хэргийн төрөл" байв. XIX зуунд врит буюу нэхэмжлэлийн төрлийг хүчингүй болгох тухай хууль батлагдаж, иргэд нэхэмжлэлээ гаргахын өмнө түүний шаардлага нь вритэд багтсан эсэхийг урьдчилан шалгах хэрэггүй болжээ¹⁸. Англи, Америкийн эрх зүйн бүлд "trespass" бүлэгт дор дурдсан нэхэмжлэлийн төрлүүд багтдаг байсан талаар судлаачид дурдсан байна. Үүнд:

1. Хүний биед халдах (Trespass in Assault and Battery)
2. Хүнийг саатуулах, хорих (False Imprisonment)
3. Үл хөдлөх эд хөрөнгөд нь халдах (*trespass quare clausum fregit*)
4. Хөдлөх эд хөрөнгөд нь халдах (*trespass de bonis asportatis and trover*)

Улмаар нийтлэг эрх зүйн хуульчид энэ үеэс эхлэн хуулийг системчлэх талаар анхаарч эхэлсэн нь Блэкстөүний "Английн хуулийн тайлбар"¹⁹, Паулийн "Нийтлэг

¹⁸ James Gordley, Hao Jiang, Arthur Taylor von Mehren, *An Introduction to the Comparative study of Private law: Readings, cases, materials*, 2021, Cambridge University Press, p-309.

¹⁹ William Blackstone, *Commentaries on the Laws of England* номыг 1765-1769 оны хооронд анх хэвлүүлсэн бөгөөд https://avalon.law.yale.edu/subject_menus/blackstone.asp цахим хуудаснаас үзэх боломжтой. Тус ном нь Английн хуулийн системчлэлд чухал хувь нэмэр оруулсан гэж үздэг ба танилцуулга, хүний тухай, юмсын тухай, хувийн эрх зүй дэх зөрчил, нийтийн эрх зүй дэх зөрчил гэх хэсгүүдээс бүрдэнэ.



эрх зүй дэх гэрээний тухай анхны бүтээл"²⁰, Хиллардын "Нийтлэг эрх зүй дэх зөрчлийн тухай анхны бүтээл"²¹ зэрэг бүтээлүүд бичигдсэнээс харж болно.

Өнгөрсөн хугацаанд тогтсон врит нь орчин үеийн гэм хорын төрөл болох эхлэлийг XIX зууны хуульчид анх тодорхойлж, иргэнлэг эрх зүйн хуульчдын олон зуунд судалж ирсэн санаатай болон болгоомжгүй аль ч хэлбэрээр гэм хор учруулсны хариуцлага хүлээх үндэслэлийг зөвшөөрөн гэм хорын бүтцэд "negligence" буюу "хайхрамжгүй хандан гэм хор учруулах" зөрчлийг оруулсан нь нийтлэг эрх зүйн хөгжилд чухал дэвшил болсон²². Учир нь вритэд болгоомжгүй гэм хорд хариуцлага хүлээлгэх жишиг тогтоогүй бөгөөд энэ нэхэмжлэлийг хэзээ ч бие даасан гэм хорын төрөлд тооцож байгаагүй тул ийм хэрэг шийдвэрлэгдэж байсангүй²³.

Түүнчлэн вритэд дурдагдсан нэхэмжлэлийн төрлүүдийг задлан шинжилж, түүгээр хамгаалагдаж байгаа эрх, ашиг сонирхлын ерөнхий зүй тогтол, үндэслэлийг тодорхойлохыг хичээж байсан нь энэ үеийн хуульчдын нийтлэг эрх зүйн хөгжилд оруулсан хувь нэмэр байлаа. Тухайлбал, врит дэх "trespass" ангиллын нэхэмжлэлийг хуульч Блэкстөүн хөдлөх эд хөрөнгөд хамаарах нэхэмжлэл (*trespass de bonis asportatis and trover*), үл хөдлөх эд хөрөнгөд хамаарах нэхэмжлэл (*trespass quare clausum fregit*), хувийн халдашгүй байдал буюу хүний амь нас, эрүүл мэнд, бие махбод, эрхтэн, нэр төрд учруулсан гэм хорыг арилгуулах нэхэмжлэл гэж ангилснаас үзвэл энэ үеийн хуульчид нэхэмжлэл тус бүрд хамаарах нийтлэг зүй тогтлыг танин гэм хорын эрх зүйг системчлэхийг оролдож байв. Мөн энэ үеийн хуульчид хүнийг хүсэл зоригийнх нь эсрэг хорих, саатуулах нь нэхэмжлэгчийн чөлөөтэй зорчих үндсэн эрхийг хязгаарласан тул зүй ёсоор хамгаалагдах учиртай гэж үзжээ.

Түүнчлэн зарим хуульчид вритийн нэхэмжлэлүүдийн нийтлэг зүй тогтлыг тодорхойлох явцдаа гэм хорын төрөл, эвдрэл, гэмтэл, хор уршгийг задлан шинжилж, хохирол учраагүй бол гэм хор гэж үзэхгүй байх санал дэвшүүлж байв. Гэвч бие махбодод хүсэл зоригийнх нь эсрэг хүрэх (*battery*), гэмтэл учруулахаар айлгах (*assault*) зэрэг зөрчил гаргасан бол гэм хор учирсан байхыг шаардахгүйгээр хариуцлага хүлээлгэж байсан хааны шүүхийн уламжлалт шийдвэрүүдийг үндэслэн энэ саналыг үгүйсгэж байжээ. Өөрөөр хэлбэл, хэн нэгний биед хүсэл зоригийнх нь эсрэг хүрч, таагүй байдал үүсгэснээр хор уршиг бий болоогүй ч энэ нь доромж бөгөөд бүдүүлэг үйлдэл тул хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж үзэж байв. Энэ талаар хуульч Кларк "хүний бие махбодын халдашгүй дархан байдал нь нэн чухал гэж хууль үзсэн"²⁴ гэж, хуульч Сиви "хамгийн наад захын халдлага ч энэ зөрчилд хамаарна", учир нь бие махбодын халдашгүй байдал бол ... хамгийн дээд түвшинд хамгаалагдвал зохих ашиг сонирхол мөн²⁵ гэж тус тус тайлбарлажээ.

²⁰ Powell, *The first treatise on the Common law of contracts*, 1790.

²¹ Francis Hillard, *The first treatise on the common law of torts*, 1861.

²² James Gordley, Hao Jiang, Arthur Taylor von Mehren, *An Introduction to the Comparative study of Private law: Readings, cases, materials*, 2021, Cambridge University Press, p-310.

²³ James Gordley, Hao Jiang, Arthur Taylor von Mehren, *An Introduction to the Comparative study of Private law: Readings, cases, materials*, 2021, Cambridge University Press, p-310.

²⁴ George L. Clark, *The Law of Torts* 10, 1926.

²⁵ Warren Seavy, "Principles of Torts", *Harvard Law review* 56, 1942, 72.



1.3. Явцын дүгнэлт

Эдүгээ голлож буй эрх зүйн үндсэн хоёр бүлийн гэм хорын эрх зүйн ерөнхий бүтэц, онцлог ялгааг анзаарвал хоёр уламжлалын аль аль нь гэм хорын төрлийг эхлэн тодорхойлж, зөрчил буюу буруутай үйлдэл, эс үйлдэхүйн олон төрлийг бий болгох замаар хөгжиж эхэлсэн боловч түүхэн хөгжлийн явцад хүний аливаа үйлдлийг буруу, зөв хэмээн ялган зааглах онолыг хөгжүүлэн, хариуцлага хүлээлгэх шударга тогтолцоог эрэлхийлж ирсэн нь харагдана.

Эх газрын эрх зүйн орны хувийн эрх зүйн онцлогийг системчлэгдсэн хуулиас салгаж ойлгох боломжгүй бөгөөд үүргийн эрх зүйн хэм хэмжээг гэрээний ба гэм хорын эрх зүйгээр ялган хөгжүүлж байсан нь олон талаар ач холбогдлоо алдаагүй төдийгүй нийтлэг эрх зүйн бүлийн орнууд ч хожмоо хүлээн зөвшөөрч, нутагшуулж эхэлжээ.

Эрх зүйн хоёр бүлийн гол ялгаа гэм хорын эрх зүйн шаардах эрхийг хэрхэн авч үзэж байсан түүхэн уламжлалаар тодорхойлогдож байна. Иргэнлэг эрх зүйн системд хувь этгээдийн халдашгүй байдал, эрх чөлөөг эрхэмлэн энэ төрлийн ашиг сонирхлыг хамгаалахаар *iniuria* нэхэмжлэл, эд баялаг өмчлөх эрхийн зайлшгүй шинжийг хамгаалж *lex Agiulia* нэхэмжлэлийн янз бүрийн төрлийг бий болгон хөгжүүлж ирсэн бол нийтлэг эрх зүйн тогтолцооны орнууд хааны шүүхэд хүлээн авч заншсан тухайлсан хэргийн жагсаалт тогтоох замаар гэм хорын эрх зүйг бүтээж байсан.

Иргэнлэг эрх зүйн орнуудын хувьд Ромын эрх зүйгээс улбаатай хэм хэмжээгээр хамгаалагдах эрх, ашиг сонирхлын нийтлэг зүй тогтлыг танин мэдэх замаар гэм хорын эрх зүйн өөрийн бүтцийг бий болгосон бол нийтлэг эрх зүйн бүлийн орнууд практикаас урган гарч шүүхээс зөвшөөрсөн тодорхой хэрэг ба нэхэмжлэл тус бүрийг тоочин, жагсаалтыг өргөжүүлэх замаар гэм хорын эрх зүйн бүтцээ тогтоожээ. Иргэнлэг эрх зүйн томоохон төлөөлөл болсон голлох хоёр орны гэм хорын эрх зүй харьцангуй ялгаатай байх бөгөөд Франц Улс хамгаалагдах эрхийн нийтлэг зүй тогтлыг тодорхойлсон хатуу шалгуур үгүй бол Герман Улсын хувьд хамгаалагдах зүйл, эрхийн мөн чанарыг хувь хүний салшгүй байдал, туйлын эрхтэй уяснаараа Франц улсаас ялгаатай байна. Энэ ялгаа гэм хорын эрх зүйн үүднээс хохирлыг арилгаж, үр дагаврыг шийдвэрлэх хоёр өөр замналыг бий болгох үндэслэл болжээ.

Монгол Улсын гэм хорын эрх зүйн хэм хэмжээний хөгжил зогсонги байдалд орж, хуулийн хэрэглээ, тайлбар тогтворгүй байна. Хуулийн томьёолол, бичиглэлээс үзвэл гэм хорын хэм хэмжээгээр хамгаалагдах зүйл, эрхийг Герман улсын нэгэн адил жагсаах, мөн чанарыг туйлын эрх, хувь хүний салшгүй байдалтай уялдуулан холбох үзэл баримтлал байж болохыг үгүйсгэхгүй. Гэвч хуулийн үзэл баримтлалыг тодорхой болгох, жагсаалтад өөрчлөлт оруулах, нэмэх, хасах тохиолдолд үндсэн чиг хандлагыг чанд баримтлах нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг төлөвшүүлэх, хангахад нэн чухал.



2. Гэм хор учруулсны үр дагавар

Гэм хорын бүрэлдэхүүн хангагдаж, объектив ба субъектив угтвар нөхцөлүүд бүрдсэн бол учирсан хохирлыг арилгах замаар үр дагаврыг хариуцна. Монгол Улсын Иргэний хуулийн 497–504 дүгээр зүйл нь гэм хорын ерөнхий ба тусгай зохицуулалт буюу гэм хорын бүрэлдэхүүн, 505–511 дүгээр зүйл нь гэм хорын хэмжээ буюу үр дагавар болох хохирлыг арилгахтай холбоотой зохицуулалтууд байна.

Зөрчлийн улмаас үүссэн хохирол буюу учирсан гэм хор нь мөнгөөр хэмжигдэх боломжтой буюу эдийн, эсхүл боломжгүй буюу эдийн бус шинжтэй байна. Түүнчлэн хохирол нь хувь хүнд, хуулийн этгээдийн онцгой эрх²⁶-д, эсхүл эд хөрөнгөд учирсан байж болно. Хохирлын эрх зүйн үүднээс хохирол нь бодитой, эсхүл орох байсан орлогыг хязгаарлах байдлаар үүсэх боломжтой. Харин хохирол учирсан этгээдийн тухайд гэм хорын үр дүнд шууд, эсхүл шууд бусаар хохирсон байх тохиолдлууд бий.

Мөнгөөр хэмжигдэх боломжтой буюу эдийн шинжтэй хохирол нь бодитой бөгөөд шууд байх, шаардлага гаргаж буй этгээд нь шууд хохирогч байх тохиолдолд хохирлын хэмжээг тодорхойлоход төдийлөн бэрх биш. Харин хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хохирогчийн, бие махбод, эрүүл мэндэд гэм хор учирч хөдөлмөрийн чадвараа алдсан, буурсан, хэрэгцээ өссөн, ашиг орлого алдагдаж, сувилгаа, амьжиргааны нэмэлт зардал үүссэн, хүүхдийн биед гэм хор учирснаас эцэг, эх, асран хамгаалагчид нэмэлт зардал үүссэн, гэм хорын үүднээс шууд бус хохирогч болсон зэрэг тохиолдолд хохирлын хэмжээг тогтоох, нөхөн төлөх арга, хэлбэрийг тодорхойлох нь харьцангуй бэрхшээлтэй.

2.1. Гэм хорын улмаас бий болсон эдийн засгийн хохирол

Гэм хорын улмаас учирсан хохиролд эдийн засгийн алдагдал, олох байсан үр ашгийг тооцон нэхэмжлэх явдал цөөнгүй гардаг. Франц Улсын Иргэний хуулийн 1240-1-д хариуцагч учруулсан хохирлоо хариуцан арилгана гэж заасан тул гэм хорын улмаас бий болсон хохирол нь эдийн засгийн шинжтэй эсэхээс үл хамааран барагдуулах үүргийг хүлээнэ.

Франц Улсын дээд шүүх, 1970.05.08, *Compagnie franciase du methone vs. Lafarge*

Аж ахуй эрхлэгч *Lafarge*, бульдозероор ажил гүйцэтгэх явцдаа *AFL* компанийн үйлдвэрт хий нийлүүлэх үйлчилгээ үзүүлдэг *CFM* компанийн хийн хоолойг гэмтээсэн байна. Францын дээд шүүх хийн хоолой гэмтлээс болж *AFL* компанийн үйлдвэрийн үйл ажиллагаа тасалдсанаас тус компанид учирсан хохирол нь гэмтлийн шууд үр дагавар тул хохирлыг *Lafarge* хариуцах үүрэгтэй гэсэн давж заалдах шатны шүүхийн дүгнэлттэй санал нэгдсэн байна²⁷.

Франц Улсын дээд шүүх, 1984.10.17, *JCP*

²⁶ Зохиогч: Энэ хэсгийг тус нийтлэлийн хүрээнд дэлгэрүүлэн хөндөөгүй болно.

²⁷ James Gordley, Hao Jiang, Arthur Taylor von Mehren, *An Introduction to the Comparative study of Private law: Readings, cases, materials*, 2021, Cambridge University Press, p-409.



Хариуцагч нь нягтлан бодогч бөгөөд түүний бэлтгэсэн санхүүгийн дүгнэлтэд үндэслэн нэхэмжлэгч компани N компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд санхүүжилт хийсэн. Гэвч санхүүгийн дүгнэлт алдаатай буюу N компани үнэн хэрэгтээ 480,000 франкийн өртэй байв. Улмаар N компани төлбөрийн чадваргүй болсон байна. Хариуцагч нь нэхэмжлэгчид учирсан хохирлыг хариуцах үүрэгтэй гэж шүүх үзсэн²⁸.

Франц Улсын давж заалдах шатны шүүх, 1955.04.20, D. 1956.J.723

Хөл бөмбөгчин Кэмп Мэц клубт тоглохоор тохирч гэрээ байгуулсан байв. Гэвч Кэмп амь насаа алдсан бөгөөд осолд хариуцагчийг гэм буруутай гэж үзсэн. Мэц клуб Кэмптэй байгуулсан гэрээний үүрэг хэрэгжих боломжгүй болсноос тус клубт учирсан санхүүгийн алдагдлыг хариуцагчаас нэхэмжилжээ. Клубын нэхэмжлэлд дурдсанаар хөл бөмбөгийн багийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан төдийгүй Кэмнийг клубтэй байгуулсан гэрээний үүргээс чөлөөлж, өөр клубт тоглуулахаар шилжүүлэх үед олох байсан орлогыг алдсан. Гэрээ нь бүтэн улирлын хугацаанд хүчинтэй, жил бүр шинэчлэн байгуулагдах боломжтой, хатуу нөхцөлөөр цуцлагдах гэрээ байсан. Мэц бусад клубийн хэд хэдэн саналыг хүлээн аваагүйн дотор 2,000,000 франкийн санал байсан. Кэмптэй жишигдэхүйц тоглогчийг олж авахын тулд энэ хэмжээний төлбөрийг дахин төлөх шаардлага үүснэ. Кэмнийг нас барахаас өмнө тус клуб нь үндэсний хэсгийн 18 багаас 10 дугаарт эрэмбэлэгдэж байсан бол Кэмнийг нас барсны дараах улиралд 16, түүний дараа жил 18 дугаар байранд орж үндэсний хэсгээс хасагдан хоёрдугаар хэсэгт тоглох болсон гэжээ. Шүүх клубт учирсан хохирлыг арилгах үндэстэй гэж үзэн нэхэмжилсэн дүнг хангаж шийдвэрлэсэн байна. Ингэхдээ "хувь хүн, түүнчлэн хуульд эрх зүйн этгээд гэж зөвшөөрсөн байгууллага бүр аль нэг этгээдийн гэм буруутай үйлдлийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй. Энэ хэргийн хувьд учирсан хор уршиг нь тодорхой байх тул нөхөн төлүүлэх бүрэн боломжтой" гэжээ²⁹.

Ийнхүү гэм хорын улмаас учирсан цэвэр эдийн засгийн шинжтэй хор уршиг нь хууль бус үйлдэлтэй шууд холбоотой бөгөөд хохирлын хэмжээ тодорхой бол нөхөн төлөх үндэстэй гэж үзэх шүүхийн практик Франц Улсад нэгэнт тогтсон байна.

Харин Герман Улсын шүүхийн практикт энэ талаар эсрэг байр суурь давамгайлдаг. XIX зууны сүүл үе, XX зууны эхээр анхлан Германд, аажимдаа Англи, Америк зэрэг орнуудад "цэвэр эдийн засгийн хор уршиг"-ийг арилгах боломжгүй гэх дүрэм хөгжиж эхэлсэн³⁰. Нэхэмжлэгчид өөрт нь болон эд хөрөнгөд нь учирсан бодит хохиролтой хамааралгүй хор уршигийг "цэвэр эдийн засгийн хор уршиг" гэж үздэг³¹.

Герман Улсын гэм хорын эрх зүйд тогтсон нэхэмжлэгчид учирсан бүх төрлийн хохирлыг арилгах боломжгүй гэх үзэл санаа нь Ромын хуульчдын тайлбараас үүдэлтэй. Германы хуульч Рудолф фон Иеринг хариуцлагыг тодорхой

²⁸ Мөн тэнд.

²⁹ Мөн тэнд.

³⁰ Мөн тэнд, 410 дахь тал.

³¹ Мөн тэнд.



үндэслэлээр хязгаарлаж, хэт өргөжүүлэхээс сэргийлэх нь зүйтэй гэж үзэн энэ талаар дараах байдлаар тайлбарлаж байв:

"Хэрэв хүн бүрийг санаатай үйлдсэн буруу зүйл (wrongdoing-Eng, dolus-Lat)-ийнх нь төлөө бус гэрээний харилцаанаас үүсээгүй амал хайхрамжгүй гаргасан бүх алдаа (gross negligence-Eng, culpa lata-Lat)-ных нь төлөө хариуцлага хүлээлгэх бол ямар үр дагавар үүсгэхийг бодолцох хэрэгтэй! Алдаатай илтгэл, хоосон цуурхал, худал тайлагнал, муу зөвлөгөө, тааруу шийдвэр, ажил олгогчийн үнэнд нийцээгүй тодорхойлолт, зам асуусан аялагчид буруу чиглэл заах зэрэг бүх төрлийн зөрчлийг санамсаргүй гаргасан эсэхээс үл хамааран бүх хохирлыг хариуцна гэсэн үг..."³²

Герман Улсад эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж байгаа Иргэний хуулийн боловсруулалтын явцад төсөл бичигчид гэм хорын улмаас бий болсон хохирлын хэмжээг хэрхэн хариуцах талаар зөрүүтэй байр суурь илэрхийлж ирсэн талаар судлаачид дурддаг боловч хууль батлагдахдаа нэхэмжлэгч гагцхүү тус хуулийн 823 дугаар зүйлд заасан зөрчилд хариуцлага хүлээх үзэл баримтлалыг барихаар тогтсон байна. Хуулийн төслийн ажлын хэсгийн эхэн үеийн хэлэлцүүлэгт эрхийн зөрчил гэх ойлголтыг хэрхэн тодорхойлох талаар санал солилцсон байх ба гагцхүү туйлын хамгаалалт шаардах эрхийн зөрчлийг ойлгох, эсхүл хуулиар хориглосон бүх хэм хэмжээг зөрчсөнийг хамааруулах эсэхийг энэ уулзалтаар хэлэлцэн тогтжээ. Хэлэлцүүлгийн эцэст ажлын хэсэг эхний хувилбарыг баримтлахаар санал нэгдсэн бөгөөд туйлын эрхийг бусад бүх этгээдийн эсрэг хэрэгжүүлэх боломжтой бол гэрээний эрхийг гагцхүү гэрээлэгч нөгөө талын эсрэг хэрэгжүүлнэ. Нэгэнт гэрээний нөгөө талын эсрэг хэрэгжүүлэх учир гэм хорын эрх зүйн харилцаа энэ эрхийн зөрчилд хамааралгүй гэж үзжээ.

Төсөл боловсруулагчид харин "цэвэр эдийн засгийн хохирол"-ын талаар хэлэлцээгүй, илүүтэй туйлын эрхийг бүхний эсрэг, харьцангуй эрхийг тодорхой этгээдийн эсрэг хэрэгжүүлдэг талаар санал нэгдсэн нь харьцангуй эрх (ихэнхдээ эдийн засгийн боломж олгодог)-ийн зөрчлийг гуравдагч этгээдэд хамаатуулахгүй тул гэм хорын эрхийн хүрээнд "цэвэр эдийн засгийн хохирол"-ыг шаардахгүй гэх дүгнэлтэд хүргэжээ³³. Герман Улсын шүүх 1901 онд нэхэмжлэгчийн эдийн засгийн эрх чөлөөг хөндсөн нь Иргэний хуулийн 823.1-д заасан эрх чөлөөнд халдсанд тооцогдохгүй гэх дүгнэлтийг, 1904 онд эдийн засгийн хор уршиг нь (*Vermögensschadigung*) хуулийн 823.1 дэх зүйлээр хамгаалагдсан хор уршигт хамаарахгүй гэх дүгнэлтийг тус тус хийжээ³⁴. Өнөөдрийн Германы шүүхийн практикт нэгэнт хүлээн зөвшөөрсөн цэвэр эдийн засгийн хохирлыг эс хариуцах дүрэм нь хэрэв А нь С-ийн өмнө хүлээсэн Б-ийн үүргийн гүйцэтгэлийг хөндсөн бол С нь А-ийн эсрэг шаардлага гаргахгүй, учир нь С үүргийг А-аас биш гагцхүү Б-ээс шаардах эрхтэй гэх үндэслэлд суурилсан гэж үзэж болно.

Дээрхтэй адил аргументыг ХХ зууны эхэн үеийн Английн хуульчдын гэм хорын эрх зүйн бүтээлд бичих болсон байна. Мөн энэ цаг үетэй зэрэгцэн

³² Дам ишлэв. R. von Jhering, "Culpa in contrahendo oder Schadensersatz bei nichtigen oder nicht zur Perfektion gelangten Verträgen," Jherings Jahrbucher 4 (1861), 12-13.

³³ James Gordley, Hao Jiang, Arthur Taylor von Mehren, *An Introduction to the Comparative study of Private law: Readings, cases, materials*, 2021, Cambridge University Press, p-412.

³⁴ Мөн тэнд.



Английн шүүх ч хэд хэдэн хэрэгт цэвэр эдийн засгийн хохирлыг гаргуулахгүйгээр шийдвэрлэжээ. *Cattle v. The Stockton Waterworks Co* компаниудын хооронд үүссэн маргааны үеэр хариуцагчийн хайхрамжгүй байдлын улмаас гуравдагч этгээдийн газар үерт автаж нэхэмжлэгч барилгын ажлаа гүйцэтгэх явцдаа нүхэн гарц барих нэмэлт зардал гаргасан гэх нэхэмжлэлийг Английн шүүх 1875 онд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байсан³⁵ бол 1908 онд нэхэмжлэгчийн усан онгоц хариуцагчийн учруулсан гэмтлийн улмаас гуравдагч этгээдийн усан замын боомт эвдэрч ашиглаж чадаагүйн улмаас учирсан хохирол нэхэмжилснийг эдийн засгийн чанартай хохирол бөгөөд энэ нэхэмжлэлийг хангах нь олон тооны бусад нэхэмжлэлийг эхлүүлнэ гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгож байжээ³⁶. Түүнчлэн зарим хэрэгт хохирол нь үйл явдлаас хэт алслагдсан гэх үндэслэлээр шүүхээс хангаагүй тохиолдол гарч байв.

Ийнхүү нэхэмжлэгчид учирсан цэвэр эдийн засгийн агуулгатай хор хохирлыг гаргуулах эсэх асуудлыг улс орнууд өөр өөрөөр шийдвэрлэж ирсэн хэдий ч тус бүр үндэслэлээ тодорхойлж, хуулиа үзэл баримтлалынх нь дагуу тайлбарлан хэрэглэж байна. Франц ба Герман Улсууд эх газрын эрх зүйн тогтолцоонд багтсан нэг эрх зүйн бүлийн улс хэдий ч гэм хорын эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдах зүйлсийг хуулиар тогтоосон үзэл баримтлалын ялгаа тэдгээр улсын шүүхэд эдийн засгийн гэм хорыг арилгах эсэх асуудлаар харилцан адилгүй практик тогтох нөхцөлийг бүрдүүлжээ.

Харин Англи, Америкийн хувьд үзэл баримтлалын аргументийг хожим дэмжих болсон агаад үүнээс өмнө хохирол ба хууль бус үйлдлийн холбоос хэт алслагдсан, эдийн засгийн өндөр үнэлгээтэй хохирлыг нэг этгээдэд олон тоогоор холбогдуулан гаргах эдийн засгийн эрсдэлээс сэргийлж нэхэмжлэлийн хэрэгсэхгүй болгох шүүхийн практик тогтсон байна.

2.2. Гэм хорын улмаас бий болсон эдийн бус хохирол

Гэм хорын бүрэлдэхүүн: Франц, Герман

Гэм хорын эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдах зүйлс, эрхийг зөрчсөнөөр бусдад эдийн бус хохирол учирч болно. Эдийн бус хохирол нь сэтгэл санааны давчдал, түгшүүр, өвдөлт, шаналал, сэтгэл мэдрэлийн цочрол зэрэг байдлаар илэрч болох бөгөөд хэдий хэмжигдэхүйц биш ч өөр ямар нэг хэлбэрээр арилгах боломжгүй тул мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө. Сэтгэл санаа хүчтэй цочрох, өвдөх, шаналах, амьдралаас таашаал авахгүй болох, энэ мэдрэмж буурах нь хүн бүрийн зан авир, онцлогоос хамаарч ялгаатай байх боломжтой тул гэм хорын ноцтой, эсхүл ялимгүй эсэхээс үл хамааран зөрчил бүрд мөнгөн төлбөрийн үүрэг ногдуулж, сэтгэл санааг тайвшруулах арга хэрэглэх нь эргэлзээтэй. Үүнд хохирогчийн сэтгэл санааг тавгүйдэхэд хүргэсэн зөрчлийн шинж, гэм хорын эрх зүйгээр хамгаалагдсан эсэх, зөрчлийн үр дагаврыг бусад хэлбэрээр арилгах боломжтой эсэх нь нөлөөлнө.

Франц Улсын гэм хорын эрх зүйд хамгаалагдах зүйлийн нээлттэй байдал нь

³⁵ Sandy Thomson, Negligence and Economic Loss, *The Modern Law Review*, Vol 40, No 6, 714-718, <https://www.jstor.org/stable/1094921> цахим хуудаснаас үзэх боломжтой.

³⁶ James Gordley, Hao Jiang, Arthur Taylor von Mehren, *An Introduction to the Comparative study of Private law: Readings, cases, materials*, 2021, Cambridge University Press.



түүнээс учрах материаллаг бус хохирлыг арилгах харьцангуй чөлөөтэй хандлага тогтоход нөлөөлсөн. Аливаа этгээдийн эд хөрөнгийн бус амины эрх зөрчигдсөн бол материаллаг бус гэм хорыг хариуцан арилгах үндэслэл бүрдэнэ гэж үзэх бөгөөд асуудлын гол нь эд хөрөнгийн бус амины эрхийн тухайд бус харин энэ гэм хорыг хэрхэн мөнгөөр тооцон төлөх явдал болдог.

Харин Герман Улсын хувьд эдийн бус хохирол, гэм хор учирсныг мөнгөөр нөхөн төлөх үндэстэй эсэхийг ярихын өмнө ийм хохирол учрах үндэслэл болсон үйлдэл, эс үйлдэхүй нь Иргэний хуулийн 823.1-д заасан ямар зүйл, эрх ашгийг зөрчсөнийг тогтооход анхаарлаа хандуулна. Өөрөөр хэлбэл, хувь хүний салшгүй зүйл болох амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, эрхэмсэг оршихуйд хор хохирол учруулахаас гадна тэдний өмчлөх эрх, тэдгээртэй төстэй бусад туйлын эрхийг зөрчсөн нь тогтоогдсоноор уг зөрчлөөс үүдэлтэй материаллаг бус хохирлыг арилгах, мөнгөөр нөхөн төлүүлэх эсэх асуудал яригдана. Тухайлбал, хувь хүний эрх чөлөөнд гэм хор учруулах гэх ойлголтод бие махбодын хувьд чөлөөтэй байх буюу өөрийн хүслээр үйлдэх, хөдлөх, эс хөдлөхийг хамааруулах тул хүнийг тодорхой зайнд түгжих, усанд сэлж байгаа хүний хувцсыг авч одох, баривчлахад хүргэх зэргийг эрх чөлөөнд халдсанд тооцох талаар судлаачид жишээ аван дурдсан байна³⁷. Эрх чөлөөнд халдах зөрчил бие махбодийн байдлаар илрэхээс гадна эдийн засгийн буюу оюун санааны эрх чөлөөг ч хязгаарлах зөрчлүүд гарч болно³⁸.

Хүний амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө зэрэг хувь хүнийг тодорхойлогч зүйлд халдаж эдийн бус хохирол учруулахаас гадна хувь хүний онцгой болон нийтлэг эрхийн зөрчил нь эдийн бус хохирол учруулах үндэслэл болно³⁹. Хувь хүний тухайлсан субъектив эрх тухайлбал, нэрийн болон дүрсийн эрх зэргийг хувь хүний онцгой эрх гэж үздэг бол Германы шүүхийн практик Үндсэн хуулийн 1-р зүйл (хүний нэр төр), 2-р зүйл (чөлөөтэй байх эрх)-ээс ургуулан Иргэний хуулийн 823.1 дэх зүйлээр хамгаалагдах абсолют шинжтэй хувь хүний нийтлэг эрхийг тодорхойлсон⁴⁰.

Хувь хүний нийтлэг эрхэд хамаарах олон өвөрмөц хэргийг Герман Улсын дээд шүүхээс эцэслэн шийдвэрлэсэн байх бөгөөд эдгээрийн дотор бэлгийн чадавх сайжруулах бэлдмэлийн сурталчилгаанд морь унаж авхуулсан зургийг нь зөвшөөрөлгүйгээр ашигласан нь хувь хүний эдийн засгийн ашиг сонирхлыг зөрчсөн гэж, санаа бодлоо хуваалцах зорилгоор бусадтай ярилцсаныг нууцаар дууны хальсанд буулгасан нь хувь хүний мэдээллийн халдашгүй байдалд халдсан гэж, нууц харилцаатай байсан бүсгүйдээ эхнэрээсээ салж, гэрлэлтээ цуцлуулна гэж удаан хугацаанд хуурсан нь чөлөөтэй шийдвэр гаргах эрхийг нь зөрчсөн гэж, шуудангийн хайрцагтаа сурталчилгааны материал хүлээн авахгүй гэх шийдвэрийг нь хүндлэлгүй сурталчилгаа хийсээр байсан нь хувийн орон зайд нь нөлөөлсөн гэж үзсэн хэргүүдийг тус тус дурдаж болохоор байна⁴¹.

³⁷ Кристиан Шварц, Манфред Вандт, *Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй*, орч Л.Эрдэнэ-Очир, 3 дахь хэвлэл, орчуулсан огноо 2017 он, 14 дэх тал.

³⁸ Мөн тэнд.

³⁹ Мөн тэнд.

⁴⁰ Мөн тэнд.

⁴¹ Мөн тэнд, 38, 39 дэх тал.



Дээрх тохиолдлуудын аль нь ч хуулийн тодорхой заалтаар шууд хамгаалагдаагүй боловч хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдаас ялгарах шинжээ өөрөө тодорхойлох, ялгаварлан гадуурхуулахгүй байх зарчимд тулгуурлаж эдгээр үйлдлийн дүнд нэр төр, алдар хүнд нь гутаагүй байсан ч хамгаалах учиртай гэж үзсэн байна. Энэ төрлийн хэргийн саяхны жишээнд холливудын алдарт жүжигчин Скарлэт Жонсоны дуу хоолойг 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр нээлтээ хийсэн ChatGPT-4o загварт ашигласан гэх маргааныг дурдаж болох юм.

ChatGPT-4o загвар нь 5 янзын дуу хоолойг ашигладгаас "Скай" гэх нэртэй эмэгтэй дуу хоолой нь жүжигчин Скарлэт Жонсоны дуу хоолойн өнгөтэй адил байв. Энэ загвар гарсны дараа жүжигчин өөрийн "X" хуудсанд дургүйцлээ илэрхийлэн мэдэгдэл хийхдээ өнгөрсөн оны 9 дүгээр сард OpenAI-ийг үүсгэн байгуулагч ноён Алтман түүнд хандан дуу хоолойг нь ашиглах зөвшөөрөл хүсэхэд татгалзсан ч 2 сарын дараа энэ талаар түүнийг дахин бодож үзэхийг хүссэн тухай дурдсан байна. Харин ноён Алтман хариу мэдэгдэл хийхдээ "Скай"-ийн хоолой жүжигчнийх биш бөгөөд энэ талаар нотлох баримт гаргах болно гэж өөрийн "X" хуудсанд жиргэжээ.

Энэ хэрэг Цахиурын хөндийд шуугиан тарьж, өнөөгийн эрх зүйн орчин хувь хүний дуу хоолойтой холбоотой үүсэх аливаа асуудлыг зохицуулж, хангалттай хамгаалалт бий болгож чадаагүйн жишээ болж, хууль, эдийн засаг, ёс зүй, нийгмийн олон асуулт дагуулсан байна. Хуульчдын үзэж байгаагаар хүний дуу хоолой нь текст бичсэн цаасан баримтаас ч илүүгээр хувь хүнээс салгах боломжгүй хамгаалагдах учиртай эрх ашиг юм.⁴²

Хувь хүний онцгой эрх буюу хүний нэр төр, алдар хүндийг гутаасан нь гэм хорын бүрэлдэхүүн болохын зэрэгцээ хуулиар тухайлан хамгаалагдаагүй ч Үндсэн хуулийн үзэл санааны түвшинд зохицуулсан хувь хүний нийтлэг эрхүүд, туйлын эрх, түүнтэй төстэй бусад эрхийн зөрчил нь гэм хорын бүрэлдэхүүн болж, учирсан эдийн болон эдийн бус хохирлыг арилгуулах үндэслэл гэж үзэх нь гаднын орнуудын шүүхийн практикт нэгэнт тогтсон ойлголт болжээ.

Гэм хорын бүрэлдэхүүн: Монгол

Монгол Улсын Иргэний хуулийн 497.1 дэх хэсэгт гэм хорын эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдах зүйлийн жагсаалтыг бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, сэтгэц, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй гэж заасан. Тус зүйлийн "сэтгэцэд" гэх нэмэлтийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр оруулсан бөгөөд үүнтэй уялдуулан мөн хуулийн 230.2 дахь хэсгийг "Сэтгэцэд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгах бөгөөд бусад эдийн бус гэм хорыг гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөн хэлбэрээр арилгана" гэж өөрчлөн найруулжээ. Эдгээр өөрчлөлт орохоос өмнө Иргэний хуулийн 230.2 дахь хэсэгт "Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө"

⁴² Paulius Jurcys, Mark Fenwick, Aidas Liaudanskas, *Voice cloning in an age of generative AI: Mapping the limits of the law and Principles for a new social contract with technology*, ssnr-4850866.pdf



гэж заасан байв.

Хувийн өмчид суурилсан эдийн засгийг төлөвшүүлэх зарчимд суурилсан Иргэний хууль нь энэ зорилтод чиглэсэн олон өөрчлөлтийг үе шаттай хэрэгжүүлэх үзэл санаатай нь илэрхий байдаг. Үүний нэгэн адил гэм хор учруулсны улмаас бий болсон эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгах хэрэглээг Иргэний хууль үе шаттай бий болгохыг зорьсон. Өөрчлөлт орохоос өмнөх Иргэний хуулийн 230.2 дахь хэсэгт зааснаар эдийн бус хохирлыг арилгах боломжтой хэдий ч энэ шаардах эрх гагцхүү хуульд тусгайлан заасан үед үүсэхээр байжээ. Харин энэхүү 230.2-т заасан мөнгөөр хохирлоо арилгуулах боломжтой "хуульд тусгайлан заасан" байх шаардлагыг эргэлзээгүй хангасан ганц гэм хорын бүрэлдэхүүн нь бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд гэм хор учруулах зөрчил байв. Энэ зөрчлөөс учирсан сэтгэл санааны хохирлыг мөнгөөр арилгах зохицуулалтыг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд шууд зааснаар "хуульд тусгайлан заасан" байх 230.2 дахь хэсгийн шаардлага хангагдсан юм⁴³.

Тодруулбал, Иргэний хуулийн 497.1-д заасан хамгаалагдах бүх зүйлд халдсанаар эд хөрөнгийн хохирол амсах, бие махбодын гэмтэл учрахаас гадна өвдөх, шаналах, гомдол, түгшүүр мэдрэх, ердийн мэдрэмж, таашаал, амьдралын хэвийн хэмнэлээ алдах, зорилго тэмүүлэлгүй болох зэргээр сэтгэл зүйн янз бүрийн өөрчлөлт гарч болно. Гэвч хууль тогтоогч энэ бүх зөрчилд биш, гагцхүү бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан гэм хорын бүрэлдэхүүнээс бий болсон эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгах зохицуулалтыг Иргэний хуулийн 230.2, 511.1-д анх тусгаж байжээ.

Харин 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Иргэний хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр мөн хуулийн 230.2-т сэтгэцэд учирсан эдийн бус хохирлыг мөнгөөр арилгахаар заасан байна. Өөрөөр хэлбэл, амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, хувийн онцгой эрх болон бусад туйлын эрх зэрэг үнэт зүйлд гэм хор учруулахаас гадна бусдын сэтгэцийн эрүүл мэндэд хохирол учруулах явдал нь эдийн бус хохирол арилгуулах үндэслэл болно гэж үзжээ.

Хувь хүний эрүүл мэнд нь биеийн, сэтгэцийн, нийгмийн гэх төрлүүдэд хуваагдаж болох бөгөөд сэтгэцийн эрүүл мэнд гэх ойлголт нь гагцхүү сэтгэц мэдрэлээр хязгаарлагдахгүй, сэтгэхүй, сэтгэл хөдлөл, оюун санаа, бие хүний хувьд ямар нэг эмгэггүй байх явдлыг илтгэх талаар судалгаа⁴⁴-нд дурдсан байна. Гэвч Иргэний хууль анх батлагдах үеэс эхлэн 497.1 дэх хэсгийн дагуу хамгаалагдах зүйлийн жагсаалтад байгаа "эрүүл мэнд" гэх ойлголт нь "сэтгэцийн эрүүл мэнд"-ийг агуулгын хувьд багтаана. Гагцхүү сэтгэцийн эрүүл мэндэд учруулсан эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгах хариуцлагыг хүлээлгэх эсэх нь энэ төрлийн гэм хорыг мөнгөөр арилгахаар хуульд тусгайлан тодорхой заах эсэхээс шалтгаалах байв. Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 497.1-д заасан хамгаалагдах зүйлийн жагсаалтад "сэтгэц" гэх нэр томъёог нэмсэн эсэхээс үл хамааран сэтгэцийн эрүүл мэндэд гэм хор учруулах нь нэгэнт хуулиар хориглогдсон тул энэ заалтад сэтгэц гэх үгийг нэмсэн нь төдийлөн нөлөөгүй, харин тухайн үеийн

⁴³ Г.Алтанчимэг, УДШ-ийн иргэний хэргийн танхимын тэргүүн шүүгч, 2024. Иргэний хэргийн танхимын нийт шүүгчдийн хуралдаанд хэлсэн үг.

⁴⁴ Хууль зүйн судалгааны төв, Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцох аргачлал, гадаадын зарим улсын туршлага /харьцуулсан судалгаа/, 2021, 16 дахь тал, Улаанбаатар.



230.2 дахь зүйлийн томьёоллын дагуу сэтгэл санааны гэм хор учирсан бол мөнгөөр төлөх гэм хорын бүрэлдэхүүнийг хуульд зааж өгөх шаардлагатай байв.

Улмаар 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс сэтгэцийн эрүүл мэндэд учирсан эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх үүргийг Иргэний хуулийн 230.2 дахь хэсэгт "Сэтгэцэд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгах бөгөөд бусад эдийн бус гэм хорыг гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөн хэлбэрээр арилгана" гэж, 511.3-т "Энэ хуулийн 230.2-т заасан сэтгэцэд учруулсан гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгах үүргийг гэм хор учруулсан этгээд хүлээнэ" гэж тус тус өөрчлөн найруулсан. Эндээс үзвэл гэм хорын бүрэлдэхүүний буюу зөрчлийн төрлийг сонгож заагаагүй, харин сэтгэцэд гэм хор учруулсан үр дагавартай л бол бүх зөрчилд энэ зохицуулалт үйлчлэх агуулга илэрч байна. Өөрөөр хэлбэл, дээрх өөрчлөлтөөс өмнө Иргэний хуулийн гэм хорын эрх зүй дэх сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөх эсэх объектив шалгуур нь гэм хорын бүрэлдэхүүн буюу тодорхой төрлийн зөрчил (нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд гэм хор учруулах) байхаар тогтсон байсан бол нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу ямар зөрчил байхаас үл хамааран сэтгэцэд нь хохирол учирсан л бол гэм хорын аль ч бүрэлдэхүүний улмаас мөнгөн төлбөр шаардах боломжийг олгосон гэж үзэхээр томьёологдсон байна.

Гэвч нөгөө талаас хууль тогтоогч Иргэний хуульд дээрх өөрчлөлтийг оруулахаас гадна Шүүх шинжилгээний тухай хуулийг энэ цаг мөчид шинэчлэн найруулж баталсан. Үнэн хэрэгтээ Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дээрх хууль нь Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж орсон. Шүүх шинжилгээний тухай хуулийн "Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох үнэлгээ" гэсэн нэртэй.

40 дүгээр зүйлд Эрүүгийн хуулийн тодорхой тооны гэмт хэргийг жагсаан тусгаж шинжилгээний байгууллага сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох дүгнэлт гаргахаар заажээ.

Магадгүй хууль тогтоогч дээрх зүйл, заалтыг Шүүх шинжилгээний тухай хуульд оруулахдаа учирсан гэм хорыг мөнгөөр арилгуулах зөрчлийн бүрэлдэхүүнийг дээрх тооны тодорхой гэмт хэргийн төрлөөр хязгаарлахыг зорьсон байхыг үгүйсгэхгүй. Гэвч иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн диспозитив зарчмыг шүүхийн шинжилгээг хэрхэн хийх ажиллагааг процессжуулсан хуулийн зохицуулалтаар хязгаарлах эсэх, улмаар Иргэний хуулийн гэм хорын ерөнхий шаардах эрхийн хүрээг мөн зохицуулалт хумьж чадах эсэхийг анхаарах учиртай.



Эдийн бус хохирлыг мөнгөөр илэрхийлэх арга зүй

Герман Улсын шүүхийн практик тогтсоноор өвдөлт, шаналлын төлбөрийг зөвхөн дараах нөхцөл бүрдсэн үед мөнгөөр шаардах эрхтэй:

- Хохирлыг өөр хэлбэрээр барагдуулах боломжгүй байх
- Учруулсан хохирол нь хүнд байх⁴⁵.

Учруулсан гэм хорыг залруулга, эсхүл няцаалт хийснээр барагдуулсан гэж шүүх үзвэл эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгах шаардлагагүй гэж үздэг. Харин хохирлын хэмжээг тогтоож учруулсан хохирлын хүнд, хөнгөнийг дэнслэхээ гэм хор учруулсан үйлдлийн агуулга, хор уршиг, гэм хор учруулагчийн санаа, сэдэлт болон гэм буруугийн зэргийг харгалзана. Сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр тайвшруулахаас илүүтэй уучлалт гуйж, хүссэн хэлбэрээр нь залруулга, няцаалт хийх байдлаар арилгасан нь хангалттай байж болно. Хэрэв хохирлыг энэ хэлбэрээр арилгасныг хангалттай бол мөнгөөр төлөхийг шаардах нь шударга бус.

Эдийн бус хохирлын өөр нэгэн онцлог нь шууд бус хохирогчтой холбоотой үүснэ. Гэм хорын улмаас шууд бусаар хохирох тохиолдол эдийн бус хохирлын хэлбэрээр илрэх нь цөөнгүй. Жишээ нь ойр дотнын хэн нэгнээ осолд орсныг сонсоод сэтгэл мэдрэлийн цочролд орох тохиолдол гарч болно. Энэ нь гэм хорын эрх зүйн онцлог бөгөөд хэрхэн арилгахтай холбоотой ярвигтай үр дагавар үүснэ. Шаналал, уй гашуу, цөхрөнгөө барсан байдал зэрэг сэтгэл санааны цочрол бүр мөнгөн хөрөнгө шаардах угтвар нөхцөлд тооцогддоггүй. Энэ нь бие махбодын, сэтгэл мэдрэлийн гэмтэл авсан буюу анагаах ухааны ойлголтод багтах өвчин гэж тооцогдох шинж төлөвтэй нөлөөлөл байх ёстой⁴⁶ гэж Германы шүүхийн практикт үздэг байна.

Гэм хор учирснаас хохирогч цөхрөн балмагдаж, шаналал, уй гашууд автах бүрийд мөнгөн хэлбэрээр тооцон төлүүлэх боломжгүй гэдэгтэй санал нэгдэх нь зүйтэй. Ийнхүү хохирогчийн сэтгэл санаанд бий болсон өөрчлөлтийг мөнгөн хэлбэрт тооцох аргачлал, шалгуурыг улс орнууд өөр өөрийн онцлогт тохируулан тогтоосон байна. Бие махбодод нь гэмтэл учирч, эд эрхтнээ алдах, эмчилгээ, сувилгаанд түр, эсхүл байнга хамрагдах шаардлагатай болох, насан туршид нь хэвийн амьдралынх нь хэмнэл алдагдаж, урьдынхтайгаа адилгүй болсныг мөнгөөр тооцон, аль болох ердийн байдалд ойр, дөхөх хэмжээнд очиход нь туслахаар шүүхийн практик ба аргачлал тогтоогддог.

Сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгуулах эрх үүсэх сэтгэцийн өөрчлөлтийн зэрэг, хүндрэлийн босго хэмжээг Австрали Улсын Шинэ Өмнөд Уэльс мужийн Иргэний хариуцлагын тухай 2002 оны хуульд тогтоосон нь харьцангуй ойлгомжтой байна. Тус хуулийн дагуу хүнд хэргийн улмаас учирсан гэмтлийн үнэлгээг 100 хувь гэж үзвэл түүний 15 хувиас доошгүй хэмжээтэй

⁴⁵ Кристиан Шварц, Манфред Вандт, *Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй*, орч Л.Эрдэнэ-Очир, 3 дахь хэвлэл, орчуулга хийгдсэн 2017 он, 44 дэх тал.

⁴⁶ Кристиан Шварц, Манфред Вандт, *Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй*, орч Л.Эрдэнэ-Очир, 3 дахь хэвлэл, орчуулга хийгдсэн 2017 он, 86 дахь тал.



тэнцэх нь эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр гаргуулах босго хэмжээс болох аж⁴⁷. Харин "хүнд хэрэг" гэдэг нь хуульд заасан хамгийн онц ноцтой хэрэг гэх ангилалд хамаарах хэргүүд буюу жишээлбэл, нурууны сээр ясны хугарал, тархины хүнд гэмтэл, хүнд хэлбэрийн түлэгдэлт зэрэг гэмтлийн дээд хэлбэрийг хэлнэ⁴⁸ гэжээ. Түүнчлэн сэтгэл санааны хохирлыг мөнгөөр хөрвүүлэхдээ дээд хэмжээг дээрх мужийн хууль тогтоомжийн дагуу 350,000 доллароор тогтоож ба хүндрэлийн зэрэг 15 хувь бол 350,000 долларын 1 хувьтай тэнцэх, 16 хувь бол 1.5 хувьтай тэнцэх мөнгөн дүнг шаардаж болохоор хувьчлан тооцсон хэм хэмжээ үйлчилж байгаа талаар дээрх судалгаанд дурджээ.

Манай улсын хувьд сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрт хөрвүүлсэн энэ загварыг авсан байх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, хүн амь нас хохирсон тохиолдолд төлөх төлбөрийн хэмжээг тогтоосныг хамгийн хүнд нөхцөлд хамааруулбал бусад зөрчлийн улмаас бий болох хор уршгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх дүн энэ хэмжээнээс илүү гарах боломжгүй байх юм. Гэвч хүний амь нас хохирох гэмт хэргийн төрөл өөр хоорондоо ихээхэн ялгаатайн зэрэгцээ энэ хохирлын улмаас сэтгэгцэд нь гэмтэл учрах хохирогч хэд хэд ч байх боломжтой. Энэ нөхцөл байдлыг Иргэний хуулийн холбогдох өөрчлөлт төдийлөн ялгамжтай зохицуулаагүй тул шүүхийн практикаар зөв жишиг тогтоон хуулийг хэрэглэх шаардлага үүсэх юм.

Гэм хорын улмаас сэтгэл санаанд үүсэж байгаа хор хохирлыг үндсэнд нь хоёр хэсэгт хувааж болохоор байна. Үүнд: нэгдүгээрт, бие махбодод нь гэмтэл учирснаас бий болдог сэтгэл санааны хохирол, хоёрт бие махбодтой хамааралгүй цэвэр сэтгэл санааны хохирол гэж ангилж болно. Энэ хоёр хохирол нэг этгээдэд нэгэн зэрэг учирч болохын зэрэгцээ цэвэр сэтгэл санааны хохирол бие махбодын өвдөлт, шаналалгүйгээр дангаараа учирч ч болно. Хэрэв нэг этгээдэд хоёул учирсан бол аль алиныг нь хангаж болох бөгөөд ийнхүү цугтаа учрах нь шууд хохирогчийн хувьд түгээмэл тохиолдоно.

Эхний төрлийн хохирлын хувьд улс орнууд гэмтлийн зэргийн хүндрэлийг үндсэн шалгуур болгож, бусад нэмэлт хүчин зүйлсийг үнэлэн хохирлын хэр хэмжээг тодорхойлох аргачлал гаргахыг оролдож байгаа бол хоёр дахь бүлэг хохирлын хувьд сэтгэцийн өвчин үүссэн байхыг шаардах хандлагыг баримталж байгаа нь иргэнлэг ба нийтлэг эрх зүйн бүлийн хоёр томоохон төлөөлөл болох Австрали болон Германы эрх зүйн зохицуулалтаас харагдаж байна.

Эхний бүлэг хохирлын хувьд улс орнуудын тогтоосон аргачлал харилцан адилгүй ч уг чанартаа тулгуурлаж байгаа үндсэн үзүүлэлтүүд нь төстэй гэж хэлж болно. Ихэнх тохиолдолд гэмтэлтэй байх хугацаа (түр, эсхүл байнга), хохирогчийн амьдралын янз бүрийн орчин хүрээлэлд үзүүлэх нөлөөлөл гэсэн хоёр шалгуурыг баримтлан зэрэглэлд хувааж, үнэлгээнд шилжүүлж байна. Жишээлбэл, Австрали Улсын хувьд сэтгэцийн эмгэгийн үнэлгээг хүний

⁴⁷ Хууль зүйн судалгааны төв, "Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцох аргачлал, гадаадын зарим улсын туршлага /харьцуулсан судалгаа/", Улаанбаатар, 2021, 67 дахь тал.

⁴⁸ Мөн тэнд.



амьдралын дараах таван хүрээлэлд хуваах зарчмыг барьжээ⁴⁹. Үүнд:

1. Өдөр тутмын амьдрал
 - a. Өөртөө анхаарал тавих байдал
 - b. Нийгмийн болон амралт, чөлөөт цагийн үйл ажиллагаа
 - c. Аялал жуулчлал
2. Нийгмийн амьдрал (харилцаа холбоо)
3. Төвлөрөлт, тууштай байдал,
4. Дасан зохицох чадвар
5. Ерөнхий үр нөлөө

Харин Франц Улсын хувьд гэмтлийн үр дагаврын үргэлжлэх хугацааг түр зуурын ба байнгын гэж ангилан, Австрали улстай төстэй амьдралын аль нэг хүрээлэлд үзүүлж байгаа нөлөөллийн хэр хэмжээг тогтоон үнэлгээ гаргах суурь индикатор болгож байна. Тухайлбал түр зуурын гэм хорын үнэлгээг тогтоохдоо

1. Өдөр тутмын амьдрал дахь нөлөөлөл,
2. Эрүүл мэнд сэргээгдэх хүртэлх хугацааны өвдөлт шаналлын нөлөөлөл,
3. Гадаад төрх үзэмжийн нөлөөлөл гэсэн хүрээнд хувааж, хүрээ тус бүр нь 1-5 хүртэл гэх мэт түвшинд хуваагдан ялгаатай оноо өгнө.

Харин байнгын гэм хорын үнэлгээг

1. Өдөр тутмын амьдралыг хязгаарласан нөлөөлөл,
2. Гадаад төрхөд гэмтэл учруулсны нөлөөлөл,
3. Чөлөөт цагийг хязгаарласан нөлөөлөл,
4. Дотно харилцааны амьдралын нөлөөлөл,
5. Амьдрал хэвийн үргэлжлэхтэй холбоотой нөлөөллийн хүрээнд үнэлэн мөнгөн төлбөрийн хэмжээг тогтооход ашиглаж байна.

Цөөн зарим улсын хувьд дээрх хохирлын мөнгөн илрэлийг эд эрхтэнд учирсан гэмтлийн хүндрэлийн зэрэг, уг гэмтлийг эмчлүүлэхэд шаардлагатай эмнэлэгт хэвтсэн хугацаа зэрэгтэй холбон тогтоосон жишээ байна. Жишээлбэл, гэм хорын улмаас гараа тайруулах, нэг нүд хараагүй болох, хоёр нүд хараагүй болох, өвдөлт шаналалтайгаар олон хоног, сараар эмнэлэгт хэвтэх зэрэг нөхцөл байдлыг шалгуур болгон үнэлгээ тогтоох тоон утгыг гаргахад ашигласан байдал ажиглагдаж байна.

Гэм хорын улмаас сэтгэл санаанд үүсэж болох хоёр дахь хэсэг болох цэвэр сэтгэл санааны шинжтэй хохирол буюу цочролын шинжтэй хохирол ихэнхдээ шууд бус хохирогчид учрах нь олонтаа байх ба үүнийг гэм хорын эрх зүйд гуравдагч этгээдэд учирсан хохирол, шууд бус хохирол, дагалдах хохирол гэх мэт нэр томъёогоор нэрлэж байна. Улс орон бүрийн гэм хорын эрх зүйн орчин, шүүхийн практикийн онцлогоос шалтгаалан шууд бус хохирогчийг шууд

⁴⁹ Хууль зүйн судалгааны төв, "Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцох аргачлал, гадаадын зарим улсын туршлага /харьцуулсан судалгаа/", Улаанбаатар, 2021, 58 дахь тал.



хохилогчтой холбоотой буюу холбоогүй гэж хоёр ангилж болно. Зарим улс орнууд шууд бус хохирогчийг дан ганц "холбоотой этгээд"-ээр хязгаарлахгүй бөгөөд хохирогчийн эцэг, эх, хүүхэд, төрөл садан байхаас гадна гэмт үйлдэл, үзэгдлийг харж цочролд орсон бусад этгээд байж болохоор хуульчилсан нь бий.

Герман Улсын хувьд Иргэний хуулийн 823.1 дэх хэсэг нь гэм хор учруулсан үйлдлийн талаарх мэдээг хүлээн авч цочролд орсон этгээдийн эрүүл мэндийг хамгаалах эсэх нь тодорхойгүй талаар хүлээн зөвшөөрдөг хэдий ч "шууд бус хохирогч"-д учирсан гэм хорыг нөхөн төлүүлэх үндэслэл нь амьдралд тохиох нийтлэг эрсдэл ба зөрчлийн эрх зүйн дагуу хүлээх хариуцлагын хязгаарлалтаар тодорхойлогдоно гэж үздэг. Жишээ нь:

Эхнэр, нөхөр Э-гийн гурван хүүхэд нь Б-ийн гэм буруугаас үүдсэн осолд өртөн бүгд амь насаа алдсанаас эхнэр, нөхөр Э-ийн бие махбод ба сэтгэл мэдрэлд хүнд хохирол учирсан хэрэгт Нюрнбэрг хотын дээд шүүх эхнэр, нөхөр Э нар Иргэний хуулийн 823.1-д заасан шаардах эрхийг эдлэх боломжтой гэж үзсэн⁵⁰. Германы шүүхийн практикаар хөгжүүлсэн цочролын хохирлыг хамаатуулах норматив шалгуур болох а. Эрүүл мэндэд учруулсан хохирол нь сэтгэл санааны энгийн давчдалаас хэтэрсэн байх, б. Хүнд осол гарсан байх шалгуурууд хангагдсан гэж үзсэн⁵¹. Герман Улс харин хохирогчийн ойр дотнын биш хүн, "энгийн" осолд орсны улмаас сэтгэл санааны хямралд орох нь ердийн бус тохиолдол тул бусад этгээдэд эрүүл мэндийн хохирол учирна гэдгийг урьдчилан тооцох боломжгүй бөгөөд энэ төрлийн дагалдах хохирлыг хохирол учруулагчид хамаатуулахгүй гэж үзсэн байна⁵².

Иргэний хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал ба хууль хэрэглээ

Сэтгэцийн гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгах шинэлэг зохицуулалт нь бодит ач холбогдолтой хийгээд эрх зүйг хөгжүүлэх алхам болсон нь дамжиггүй. Сэтгэцэд учирсан гэм хороо мөнгөн хэлбэрээр арилгуулах нь хуулиар хамгаалагдах эрх ашиг нь зөрчигдсөн аливаа этгээдийн субъектив шаардах эрх мөн бөгөөд Иргэний хуульд орсон шинэлэг зохицуулалт энэ ойлголтын хүрээнд томъёологдох учиртай. Гэвч нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг тайлбарлан хэрэглэх шатанд нөхөн төлбөрийг сэтгэцэд нь гэмтэл учирсан этгээд бүрт шаардах эрх үүссэн эсэхийг нь үндэслэн олгох, эсхүл амь насаа алдсан хохирогчийн гэр бүл, ойр дотнын этгээдүүдийн сэтгэл санааг тайвшруулах зорилгоор тэдгээрийн дунд нэг удаагийн шинжтэй нөхөх олговор⁵³ хэлбэрээр олгох аль үзэл баримтлалыг хууль тогтоогч баримталсныг тодорхойлоход бэрхшээлтэй байна.

⁵⁰ Кристиан Шварц, Манфред Вандт, *Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй*, орч Л.Эрдэнэ-Очир, 3 дахь хэвлэл, орчуулга хийгдсэн 2017 он, 86 дахь тал.

⁵¹ *Мөн тэнд.*

⁵² *Мөн тэнд.*

⁵³ Зохиогч: Иргэний хуулийн 511.5-д нөхөн төлбөрийн хэмжээг тодорхой заасантай холбоотойгоор хохирогч нас барсан тохиолдолд түүний сэтгэцэд нь гэм хор учирсан гэр бүлийн гишүүн тус бүрд хуульд заасан нөхөн төлбөрийг олгох зохицуулалтыг Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн үр хүүхдэд нэг удаагийн нөхөх олговор олгох зохицуулалттай адил агуулгаар хэрэглэх хандлага ажиглагдаж байна. Тэр тусмаа хохирогчийн ар гэрт бага насны хүүхэд үлдсэн бол хүүхдийн сэтгэцэд гэм хор учирсан эсэхээс үл хамааран дээрх хандлагаар хэрэглэж шууд олгох эсэх талаар зөрүүтэй шүүхийн практик ажиглагдаж байна.



Хууль тогтоогч холбогдох өөрчлөлтийг хийхдээ гэм хорын эрх зүйд хамгаалагдах зүйлийн жагсаалтыг Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д тодорхойлсныг анхаарч, сэтгэцэд гэм хор учирсан бол зөрчлийн бүрэлдэхүүнээс үл хамаарч хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгуулах үзэл баримтлалыг тусгасан мэт байх боловч Шүүх шинжилгээний тухай хуулиар энэ хүрээгээ хумихыг зорьсон мэт ойлголт төрөхөөр байна. Гэвч шаардах эрхийн жагсаалтыг тогтоосон суурь хуулийн зохицуулалтыг шүүхийн шинжилгээг хэрхэн хийх процессын зохицуулалт бүхэлдээ хязгаарлаж чадах эсэх нь эргэлзээтэй. Энэ талаар шүүхийн практик хэрхэн хөгжих нь хуульчдын хувьд таамаглахад бэрх үзэгдэл болж байна.

Түүнчлэн Иргэний хуулийн холбогдох зохицуулалтын томьёоллоос үзвэл шаардах эрх бүхий этгээдийг тодорхойлохдоо сэтгэцэд нь гэм хор учирсан гэр бүлийн гишүүнээр хязгаарласан байна. Ингэснээр шууд бус хохирогчийн хүрээг хумьсан байх боломжтой.

Хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Шүүх шинжилгээний тухай хуулийн зохицуулалттай уялдуулахыг хууль тогтоогч илэрхий эрмэлзсэн байна. Ингэхдээ сэтгэл санааны гэм хорыг шаардах эрхтэй этгээд иргэний хэрэг хянан шийдвэрлэх диспозитив зарчмын хүрээнд нэхэмжлэлээ гаргах, хохирлоо өөрөө нотлон мэтгэлцэх талуудын зарчимтай хэрхэн уялдуулсан нь тодорхой биш. Зүй нь шүүхийн шинжилгээ нь нотолгооны процесс бөгөөд хохирогч, хэргийн оролцогч шаардлага, татгалзлаа нотлох нэгэн хэрэгсэл юм. Гэтэл Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268 А/275 дугаартай "Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах" тухай журмын дагуу тодорхой төрлийн гэмт хэргийн улмаас бий болох сэтгэцийн гэм хор аль зэрэглэлд хамаарахыг урьдчилан шууд тогтоосон нь сэтгэцийн гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгуулахаар шаардах эрхийн субъектив шинж, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны талуудын зарчмыг бууруулсан, тухайн төрлийн гэмт хэрэг, зөрчил бий болсон л бол сэтгэцэд гэм хор автоматаар учирсан байх агуулгыг нийтэд үүсгэж байна.

Ийнхүү шууд зэрэглэл тогтоосон дээрх журмын агуулгыг сэтгэцийн гэм хор учирсан эсэхийг анагаах ухаан, сэтгэл зүйн үүднээс шинжлэн тогтоох шинжээчийн хүрэлцээгүй байдалтай холбон тайлбарлах магадтай ч энэ шалтгаан хангалтгүй. Учир нь хохирогчийн сэтгэл санаанд гэм хор учирсан эсэхийг тодорхойлох мэргэжлийн этгээдийн хүрэлцээ, хангамжийн асуудал нь зах зээлийн ба эрэлт хэрэгцээний хуулиар шийдэгдэх учиртай бөгөөд үүнээс хавьгүй чухал зүйл болох зөрчигдсөн эрхийг хамгаалах, сэргээн тогтоох зарчмын шинжтэй үзэл санааг бүдгэрүүлэх үндэслэл болох учиргүй. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг, зөрчлийн бүрэлдэхүүн бий болсон хэдий ч хохирогчийн сэтгэцэд гэм хор учраагүй бол тухайн гэмт хэрэг, зөрчлийн улмаас сэтгэцийн гэм хорыг мөнгөөр арилгах харилцаа үүсэхгүй. Иймд сэтгэцийн гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгахад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх диспозитив болон талуудын зарчмын дагуу нотлогдсон сэтгэцийн хямрал, цочрол, өвчин шаналал, эсхүл байнга ба түр хугацааны хөгжлийн бэрхшээл үүссэн эсэх нь эн тэргүүний бөгөөд эргэлзээгүй тогтоогдсон байх урьдчилсан нөхцөл мөн.



Явцын дүгнэлт

Гэм хорын улмаас бий болсон эдийн болон эдийн бус хохирлыг арилгах нь тодорхой боловч хохирлын хэмжээг хэрхэн тогтоох нь улс орнуудад багагүй ялгаатай байна. Гэм хорын эрх зүй дэх гэм хорын бүрэлдэхүүн харьцангуй өргөн хүрээг буюу гэмт хэргээс төдийгүй гэмт хэргийн шинжгүй зөрчлөөс хувь этгээдэд хохирол учрахтай холбоотой харилцаанд үйлчлэх онцлогтой. Энэ үүднээс хохирлын хэмжээг хэт өргөн тогтоох нь зөв биш талаар үе үеийн хуульчид тайлбарласаар иржээ.

Түүнчлэн гэм хор учруулснаас бий болсон эдийн хохирлын хэмжээг хэрхэн тодорхойлох нь гэм хорын эрх зүйн хамгаалах зүйлийн онцлогтой уялдаж байх ба цэвэр эдийн засгийн шинжтэй хохирол нь ихэнх тохиолдолд өөр нэгэн харьцангуй эрхээс үүдэлтэй тул гэм хорын хэм хэмжээгээр хамгаалагдаж байгаа туйлын эрх, эсхүл түүнтэй төстэй эрхтэй шууд хамааралгүй гэх эрх зүйн үндэслэл иргэнлэг эрх зүйн бүлийн орнууд төдийгүй нийтлэг эрх зүйн улсад ч хүлээн зөвшөөрөгдсөн байна. Харин хувь хүний хувьд орох байсан орлого, цалин хөлсний зөрүү зэрэг хор хохирлыг шаардах нь цэвэр эдийн засгийн шинжтэй хохиролд хамаарахгүйн зэрэгцээ энэ нь ихэнх улс орнуудад хуульд тодорхой заасан бие даасан шаардах эрх байдаг.

Эдийн бус хохирлыг арилгахтай холбоотой харилцаанд мөнгөөр тооцох боломжгүй үр дагаврыг мөнгөн хөрөнгөд шилжүүлэх арга зүйг зөв тогтоох, тулгуур үзүүлэлтийг тодорхойлж, анхдагч нэгжийг бий болгох нь чухал. Үүний тулд гэм хороос учирч болох сэтгэл санааны үндсэн хоёр төрлийн хохирол болох бие махбодын гэмтэл (байнга, түр), сэтгэлийн шаналал ба цочрол (байнга, түр) нь нэг этгээдэд давхцан, эсхүл ялгаатай хохирогчид тусдаа үүссэн эсэхийг анхаарч, хохирогчийн амьдралын тодорхой орчилд үзүүлэх нөлөөллийг үнэлэн тогтоох нь олон улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал болжээ.

Иргэний хуульд орсон саяхны өөрчлөлт болох сэтгэл санааны гэм хорыг мөнгөн хэлбэрээр тооцон арилгах тухай хуулийн үзэл баримтлалыг энэ төрлийн гэм хорын бүрэлдэхүүний хохирол арилгах үндсэн зарчим, субъектив шаардах эрхийг сэргээх зорилгын хүрээнд тайлбарлан, хууль хэрэглээний зөв хандлагыг тогтоох нь нэн чухал. Хууль тогтоогчийн үзэл санаа сэтгэл санааны гэм хорыг мөнгөөр арилгуулахдаа зөрчлийн төрлийг сонгон заах арга зүйг хэрэглэж ирсэн уламжлал байх ба үүнийгээ гэмт хэргийн тодорхой төрлөөр нэмэн баяжуулсан хандлага байх боловч Шүүх шинжилгээний тухай хуульд оруулсан үзэл баримтлал нь энэ зорилгод бүрэн үйлчилж чадах эсэхийг дүгнэх замаар шүүхийн практик хөгжих нь дамжиггүй.



3. Гэм хорын эрх зүйн холбогдолтой зарим шүүхийн маргаан: Монгол Улс, 2023 он

Монгол Улсын дээд шүүх, 2023.10.17, 001/ХТ2023/00188⁵⁴

Хүсэлт гаргагч Н нь хөдөө орон нутагт бичил уурхайн эрхлэхээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн боловч экологийн цагдаагийн албанаас хууль бусаар үйл ажиллагаа явуулж байгаль орчинд 256,000 төгрөгийн хохирол учруулсан хэргээр 2020.08.25-ны өдөр яллагдагчаар татан шалгасан байна. Сум дундын эрүүгийн хэргийн шүүх 2021.12.24-ний өдөр хэргийг хэлэлцэн Н-ийг цагаатгасан ба давж заалдах шатны шүүх шийдвэрийг хэвээр үлдээсэн. Н иргэний хэргийн шүүхэд хүсэлт гаргаж 2020 онд уурхайн үйл ажиллагаанаас олох байсан орлого, ажил хийх боломжгүй байсан 18 сарын цалин, ажилтнуудад авсан байсан хоол хүнсний үнэ, Б-ийн эмчилгээний зардал, битүүмжилсэн эд хөрөнгийг зөөвөрлөхөд зарцуулсан шатахууны зардал, эрүүгийн хэргийн өмгөөлөгчийн хөлс, сэтгэл санааны хохирол, нийт 320 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргуулахаар шаардлагаа тодорхойлсон. Шүүх эд хөрөнгийг битүүмжлэх арга хэмжээг авахдаа Н-ийн зардлаар эд хөрөнгийг зөөвөрлөснөөс Н-д учирсан хохирол болох шатахууны үнэ 6 сая төгрөг, өмгөөлөгчийн хөлс 1.5 сая төгрөгийг гаргуулж, бусад хохирлыг хэрэгсэхгүй болгосон. Шүүх цагдаагийн байгууллагаас авсан албадлагын арга хэмжээ ба шалгаж буй гэмт үйлдлийн хор уршгийн хэмжээ харилцан тэнцвэртэй байх шаардлага хангагдаагүй, өндөр үнэтэй олон тээврийн хэрэгслийг Н-ийн зардлаар зөөвөрлүүлсэн нь түүнд учирсан гэм хор мөн, хууль зүйн туслалцааны зардлыг цагдаагийн байгууллагын хууль бус ажиллагаанаас учирсан хохиролд тооцохоор хуульд тусгайлан заасан гэж үзсэн байна.

Харин уурхайн үйл ажиллагаа явуулаад олох байсан орлого, ажилтнуудад авсан хоол хүнсний үнэ гэх зардлуудыг нотолж чадаагүй гэж үзэн хэрэгсэхгүй болгосон бол 18 сарын цалин гаргуулах шаардлагыг ажиллах боломжийг хязгаарласан хууль бус үйлдэл тогтоогдоогүй гэж, хуульд тусгайлан заасан байх шаардлагыг хангаагүй тул сэтгэл санааны хохирлыг энэ төрлийн гэм хорын бүрэлдэхүүнд гаргуулах үндэслэлгүй гэж дүгнэн холбогдох шаардлагуудыг тус тус хэрэгсэхгүй болгожээ.

Монгол Улсын дээд шүүх, 2023.09.19, 001/ХТ2023/00158⁵⁵

Зохиогчийн эвлэрлийг баталсан 2014.04.21-ний өдрийн шүүгчийн захирамжид Д нь Б-д 43 сая төгрөг төлөх үүргийг хүлээж, энэ үүргээ сайн дураар биелүүлээгүй бол барьцааны зүйл болох түүний өмчлөлийн орон сууцыг албадан худалдаж өрийг төлүүлэхээр заасан. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа 2014.07.31-ний өдөр үүссэн. Уг ажиллагааг дуусгавар болгосон шийдвэр гүйцэтгэгчийн эрхийн акт болон бусад ажиллагаанд төлбөр төлөгч Д гомдол гаргаж шүүхэд маргаан үүсгэснийг шүүх шийдвэрлэн анхны ба хоёр дахь дуудлага худалдаа явуулах тогтоол, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг дуусгавар болгосон тогтоолуудыг тус тус хүчингүй болгожээ. Улмаар НШШГ барьцааны зүйлийг төлбөр авагчид санал

⁵⁴ Дэлгэрүүлэн үзнэ үү, https://shuukh.mn/single_case/10357?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1.

⁵⁵ Дэлгэрүүлэн үзнэ үү, https://shuukh.mn/single_case/10347?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=.



болгосон ажиллагааг шүүх хүчингүй болгоогүй гэх үндэслэлээр энэ шатнаас ажиллагааг дахин үргэлжлүүлж, орон сууцыг төлбөр авагчид шилжүүлэн, 2018.01.04-ний өдөр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон байна. Төлбөр авагчид шилжүүлсэн орон сууц цааш 2 удаа дамжин борлогдсон. Төлбөр төлөгч Д шүүхэд дахин нэхэмжлэл гаргаж 2018.01.04-ний өдрийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болгосон тогтоолыг хүчингүй болгуулах, орон сууц өмчлөх эрхээ буцаан сэргээлгэх, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хууль бус явагдсаны улмаас учирсан хохирол буюу бусдын байрыг түрээслэн амьдарч байрны хөлсөнд төлсөн 42,500,000 төгрөгийг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан. Шүүх нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Шүүх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дахин явуулахдаа буруу шатнаас эхлүүлсэн тул хууль зөрчсөн гэж үзсэн хэдий ч үр дагаврыг нэгэнт худалдагдсан орон сууцны өмчлөх эрхийг буцаан шилжүүлэх замаар арилгах боломжгүй, орон сууцны одоогийн өмчлөгч нар өмчлөх эрхийг шударгаар олж авсан гэж дүгнэжээ. Түүнчлэн орон сууцыг бусдад шилжүүлснээс байр түрээслэн амьдарч хохирол учирсан гэх үндэслэлгүй, учир нь 2014 онд байгуулсан эвлэрлийн гэрээндээ төлбөрийг сайн дураараа биелүүлээгүй бол орон сууцыг худалдан борлуулах ажиллагаа явуулахыг Д нэгэнт зөвшөөрсөн бөгөөд үүнээс 4 жилийн дараа төлбөрийг төлөөгүй хэвээр байсан тул орон сууцны эзэмшлээ шийдвэр гүйцэтгэлийн журмаар алдах нь төлбөр төлөгч бөгөөд шийдвэр гүйцэтгэлийн маргааны нэхэмжлэгч Д-ийн хувьд хохирол шаардах үндэслэл болохгүй гэж үзсэн байна.

Энэ нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг удаашруулсан төлбөр төлөгч нь шийдвэр гүйцэтгэлийн хууль бус ажиллагааны улмаас өөрт учирсан хохирлоо нэхэмжилсэн хэрэг бөгөөд түүний шаардсан хохирлын агуулга түрээсийн хөлс байна. Хэрэв шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу төлбөрөө төлөхгүй бол шийдвэрт заагдсан барьцааны зүйл болох орон сууцыг нь хураан авах, битүүмжлэх ажиллагаа хийгдэж, улмаар эзэмшлээ алдах нь илэрхий тул үйлдэл, хохирлын шалтгаант холбооны талаарх "ердийн боломжит байдлын онол", шүүхийн шийдвэрийн дагуу заавал төлөх хохирлоо төлөөгүй "хохирогчийн буруутай үйл ажиллагаа" гэх үндэслэлийн хүрээнд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

Монгол Улсын дээд шүүх, 2023.02.09, 001/ХТ2023/00024⁵⁶

Байгаль орчин, аялал жуулчлалын яам А компанид 2015 онд газар ашиглах эрх олгож, гэрээ байгуулан газрын төлбөр авч эхэлсэн. Хожим буюу 2018 онд газар ашиглуулах боломжгүй байрлалд газрын эрх өгсөн үндэслэлээр шийдвэрээ хүчингүй болгосон байна. А компани захиргааны шүүхэд хандсан бөгөөд яам алдаагаа засаж тушаал гаргасан гэж шүүх үзэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. А компани иргэний хэргийн шүүхэд хандан хууль бус тушаал гаргаснаас учирсан хохирол гэж газрын төлбөрт шилжүүлсэн мөнгөн дүн болон газрыг хөгжүүлэх зорилгоор зураг төсөл боловсруулсан хөлсийг яамнаас гаргуулахаар нэхэмжилжээ. Анхан болон давж заалдах шатны шүүх Иргэний хуулийн 497 дугаар зүйлд заасан үндэслэлээр төлсөн төлбөрийг буцаан гаргуулахаар шийдсэн бол дээд шүүх Иргэний хуулийн 492 дугаар зүйлд заасны үндэслэлээр

⁵⁶ Дэлгэрүүлэн үзнэ үү, https://shuukh.mn/single_case/10160?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=



буцаан гаргуулах нь зүйтэй гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, төлбөр төлөх үндэслэл болсон газар ашиглах гэрээ нь хожим дуусгавар болсон нь Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1.1-д заасан үндэслэлийг бүрдүүлнэ, газар ашиглагч этгээд газрыг ашиглах хугацаандаа төлбөрөө төлж байсан нь тухайн үед байгуулсан гэрээнд үндэслэсэн тул гэм хорын бүрэлдэхүүн бий болоогүй гэх агуулгатай дүгнэлтийг дээд шүүх хийжээ. Хэрэв үндэслэлгүй хөрөнгөжсөн гэж үзвэл зураг төсөл боловсруулсан хөлсөнд холбогдох шаардлага хангагдахгүй тул энэ шаардлагыг хэрэгсэхгүй болгож, гагцхүү газрын төлбөрт холбогдох хэсгийг хангаж, төлбөрийг буцаан гаргуулсан байна.

Улсын дээд шүүх, 2023.10.26, 001/ХТ2023/00200⁵⁷

Давж заалдах шатны шүүх, 2024.04.09, 210/МА2024/00891⁵⁸

Нэхэмжлэгч Д нь 2013 онд зам тээврийн осолд орсон байх ба ослын улмаас эрүүл мэндэд нь хүнд гэмтэл учирч, 97 сая төгрөгийн хохирол бий болжээ. Тус осолд цагдаагийн албан хаагч ажилтай Г гэм буруутай байх ба Г-ийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөгч Э шалгасан. Хэргийг мөрдөж байх хугацаанд Г оргон зайлж, гадаад улс руу гарсан байна. Улмаар Г-г интерполын шугамаар эрэн сурвалжилж байх үед буюу 2020.03.08-ны өдөр Г Швед Улсын Акала хотод зөрчил гарган саатуулагдсан талаарх мэдээллийг цагдаагийн байгууллага хүлээн авчээ. Дүүргийн прокурорын байгууллага 2020.05 сард хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэргийг хаасан.

Нэхэмжлэгч нь мөрдөгч Э таслан сэргийлэх ажиллагааг тохируулан аваагүй, эрэн сурвалжлагдаж буй этгээд гадаад улсад саатуулагдсан байх үед сэжигтнийг шилжүүлэн авахаар шуурхай ажиллаж чадаагүй хууль бус эс үйлдэхүй гаргасан гэж үзэн ослын улмаас учирсан хохирол 97 сая төгрөгийг мөрдөгч Э-ээс гаргуулахаар шүүхэд нэхэмжилсэн байна.

Шүүх хэргийг анхан шатны журмаар хоёр удаа, давж заалдах шатны журмаар хоёр удаа, хяналтын шатны журмаар нэг удаа хянан шийдвэрлэсэн байх ба хяналтын шатны шүүх нэхэмжлэлийг хангасан шийдэлтэй анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгон хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаахдаа шалтгаант холбооны талаар дэлгэрэнгүй дүгнэлт хийх, мөрдөгч Э-ийн ямар эс үйлдэхүй 97 сая төгрөгийн хохиролтой шалтгаант холбоотой болохыг тогтоох нь зүйтэй гэж үзсэн байна.

Энэ хэрэг нь гэм хорын бүрэлдэхүүний хууль бус үйлдэл, эс үйлдэхүй нь хохиролтой эквивалент шалтгаант холбоотой байх онолыг хөндсөн байх ба нэхэмжлэгч Д-ийн биед учирсан гэмтлийн улмаас 97 сая төгрөгийн хохирол нь мөрдөгч Э-ийн эс үйлдэхүйтэй үр дагаврын шалтгаант холбоотой байх эквивалент онолын шаардлагыг хангасан эсэх нь эргэлзээтэй гэж хяналтын шатны шүүх үзжээ.

⁵⁷ Дэлгэрүүлэн үзнэ үү, https://shuukh.mn/single_case/10361?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1

⁵⁸ Дэлгэрүүлэн үзнэ үү, https://shuukh.mn/single_case/30308?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1



Анхан болон давж заалдах шатны шүүх хэргийг дахин хэлэлцэж нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэхдээ мөрдөгч Э-ийн хууль бус эс үйлдэхүй гаргаагүй гэж дүгнэсэн байх ба тус хэрэгт нэхэмжлэгчийн гаргасан хяналтын гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлд заасан улсын дээд шүүх хэлэлцэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзэн хүлээн авахаас татгалзжээ.

4. ДҮГНЭЛТ

Гэм хорын эрх зүйн дотоодын хэм хэмжээг өсөн нэмэгдэж байгаа нийгмийн хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх, өөрийн орны онцлог, Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ хэлцлийн зорилгод нийцсэн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг шүүх, эрх зүйч-судлаачийн тусламжтай төлөвшүүлэх шаардлага байна. Монгол Улсын гэм хорын эрх зүйн хэм хэмжээний бүтцийг 1953 оны Иргэний хуулиар анхлан тогтоосноос хойш 1994 оны шинэчилсэн найруулгаар хамгаалагдах зүйлийн жагсаалтыг нэмэгдүүлж, эдийн бус хохирол арилгаж болох зарчим тусгасан нь нэгэн ахиц мөн. Улмаар 2002 оны Иргэний хуульд сэтгэл санааны гэм хорыг мөнгөөр арилгахтай холбоотой зарим зохицуулалтыг нэмж тусгасан нь үзэл баримтлалын дэвшил болсон.

Гэвч гэм хорын эрх зүйн хөгжил зогсонги байдалд орсон байна. Холбогдох хэм хэмжээг нарийвчлан судлах нь хууль хэрэглэх чадварыг нэмэгдүүлэхээс гадна эрх зүйг оновчтой хөгжүүлэхэд тус дөхөм⁵⁹ болно. Өдгөө хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2002 оны Иргэний хуулийн 497.1-д "Бусдын эрх" гэх ойлголтыг нэмснээрээ 1994 оны шинэчилсэн найруулгаас хамгаалагдах зүйлийн хүрээг өргөжүүлсэн боловч үүнийг хэрхэн тайлбарлах талаар нэг мөр ойлголт тогтоогүй байна. Шүүх энэ нэр томъёонд тухайлан хамааруулсан, ийнхүү хамааруулсан шалтгаанаа тайлбарлан хэрэглэсэн тохиолдол түгээмэл⁶⁰ биш тул энэ концепцын хүрээ хязгаар тодорхой бус байна. Уг нэр томъёоны араас жагсаан тогтоосон бусад эрхүүдтэй харьцуулан үзвэл энэ нь туйлын эрхийн шинжийг агуулах нь зохистой мэт боловч "төсөөтэй бусад эрх" гэх ойлголтыг туйлын эрх гэж тайлбарладаг Герман Улсын хувьд Иргэний хуулийн 823.1-д жагсаасан суурь агаад хүний салшгүй эрхүүдээс гадна гэм хорын бусад бүрэлдэхүүн болох "хамгаалсан хууль", "ёс заншилд харшлах" зөрчлийг өргөжүүлэн нэмж тусгасан онцлогтой.

Түүнчлэн гэм хорын хэм хэмжээгээр ийнхүү хамгаалах эрхийн зүйлсийг жагсаан тогтоосон Герман Улсын хууль судлаачдын үндэслэл нь хохирлын хэр хэмжээг хэрхэн зохистой тогтоохтой уялдаатай байх ба "хамгаалсан хууль", "ёс заншилд харшлах" зөрчлийн улмаас бий болсон хохирлын хэр хэмжээнд энэ үзэл санаа ч нөлөөлсөөр байдаг. Олон зууны туршид нийтээр хүлээн зөвшөөрч ирсэн Германы хуульч Рудолф фон Иерингийн хариуцлагыг тодорхой үндэслэлээр хязгаарлах, хэт өргөжүүлэхээс сэрэмжлэх үзэл санаа хүчтэй хэвээр байна.

⁵⁹ Б.Тамир, *Бүтээгдэхүүний доголдлын үүсэх хариуцлага, түүний иргэний эрх зүйн зохицуулалт*, сэдвээр докторын зэргийг 2021 онд хамгаалсан байна.

⁶⁰ Судалгааны ажлын хүрээнд сонгон авсан шийдвэр, магадлал, тогтоолын дунд ийм жишээ таарсангүй.



Тус судалгааны ажлын хүрээнд гэм хорын үр дагавар, тэр дундаа эдийн бус хохирлыг арилгуулахтай холбоотой харилцаа, эрх зүйн хэмжээний чанарын талаар хөндөхийг зорилоо. Сэтгэц буюу хүний эрүүл мэндэд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгахтай холбоотой зохицуулалтыг хуульд тодруулан тусгасан. Энэ төрлийн арга хэрэгслийг нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хохироосноор хэрэглэх боломж хууль зүйн хувьд нээлттэй байсан. Одоо тус зүйл заалт дахь "сэтгэц" гэх ойлголтоо хэрхэн тодорхойлох талаар нэг мөр шүүхийн практик тогтоох, улмаар хохирлыг мөнгөн дүнд шилжүүлэх суурь үзүүлэлт, хөрвүүлэх аргачлалыг сайжруулах шаардлага байна. Ингэхдээ гэм хороос учирч болох сэтгэл санааны үндсэн хоёр төрлийн хохирол болох бие махбодийн гэмтэл (байнга, түр), сэтгэлийн шаналал ба цочрол (байнга, түр) нь нэг этгээдэд давхцан, эсхүл ялгаатай хохирогчид тусдаа үүссэн эсэхийг анхаарч, хохирогчийн амьдралын тодорхой орчилд үзүүлэх нөлөөллийг үнэлэн тогтоох нь олон улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал болсныг анхаарах нь зохистой.

Иргэний хуульд орсон саяхны өөрчлөлт болох сэтгэл санааны гэм хорыг мөнгөн хэлбэрээр тооцон арилгах тухай хуулийн үзэл баримтлалыг энэ төрлийн гэм хорын бүрэлдэхүүний хохирол арилгах үндсэн зарчим, субъектив шаардах эрхийг сэргээх зорилгын хүрээнд тайлбарлан, хууль хэрэглээний зөв хандлагыг тогтоох нь нэн чухал. Зарим төрлийн гэмт хэргийн улмаас сэтгэцэд автоматаар хохирол учирна гэх агуулгаар хууль хэрэглээг төлөвшүүлэх нь ихээхэн хортой бөгөөд гэмт хэрэг, зөрчлийн бүрэлдэхүүн бий болсон хэдий ч хохирогчийн сэтгэцэд гэм хор учраагүй бол тухайн гэмт хэрэг, зөрчлийн улмаас сэтгэцийн гэм хорыг мөнгөөр арилгах харилцаа үүсэхгүй. Иймд сэтгэцийн гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгахад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх диспозитив болон талуудын зарчмын дагуу нотлогдсон сэтгэцийн хямрал, цочрол, өвчин шаналал, эсхүл байнга ба түр хугацааны хөгжлийн бэрхшээл үүссэн эсэх нь эн тэргүүний бөгөөд эргэлзээгүй тогтоогдсон байх урьдчилсан нөхцөл болохыг анхаарвал зохино.

Монгол Улсын шүүхийн практикийг сүүлийн цөөн жилийн хэрэг маргааныг шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийх замаар тодорхойлох боломжгүй. Судалгааны явцад авч үзсэн цөөн тооны эрхийн актын хүрээнд авч үзвэл эрүүгийн хэргийн улмаас учирсан гэм хор, эрүүгийн хэргийн бүрэлдэхүүн хангагдаагүй зөрчлийн шинжтэй зам тээврийн осол, төрийн албан хаагчийн үйл ажиллагаанаас учирсан гэм хор, тэр дундаа цагдаагийн албан хаагч, мөрдөгч, прокурор, шийдвэр гүйцэтгэгч, ажил олгогчийн хөдөлмөрийн эрх зүйн журам зөрчиж гаргасан эрхийн акт, үйл ажиллагаанаас учирсан хохирол, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсанаас учирсан гэм хор, хөдөлмөрийн гэрээний дагуу ажил үүргээ гүйцэтгэж байхдаа хөрөнгө дутаасан, алдсан, гэмтээснээс учирсан хохирлыг арилгуулахтай холбоотой маргаан нийтлэг тохиолдож байна.

Шүүхүүд эдгээр хэрэг маргааныг шийдвэрлэхдээ үйлдэл, эс үйлдэхүй ба хор хохирлын шалтгаант холбоог тодорхойлох эквивалент болон ердийн боломжит байдлын онолд түлхүү суурилан хохирлын хэр хэмжээг тогтоодог нь анзаарагдаж байна. Харин хамгаалагдах зүйлийг нарийвчлан тодорхойлж,



гэм хорын бүрэлдэхүүн хэрхэн хангагдсаныг ойлгомжтой, тодорхой байдлаар шийдвэрт заах нь төдийлөн хангалттай биш байна.

Гэм хорын эрх зүй дэх шууд бус хохирогч, гэм хорын улмаас хамтран хариуцлага хүлээх үндэслэл, хамтран хариуцагчдын хохирлыг хариуцах шалтгаант холбооны хамаарал, хохирлын хэмжээ нэмэгдэхэд хүргэх бусад үндэслэлүүдийн талаар цааш нарийвчлан судлан зохих цаг хүчийг зарцуулах нь энэ салбарын цаашдын хөгжилд чухал түлхэц болох сэдэв болохыг дурдаж байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

Монгол Улсын дээд шүүх, 2023.10.17, 001/ХТ2023/00188, Н ба Засгийн газрын нөөц санд холбогдох иргэний хэрэг, https://shuukh.mn/single_case/10357?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1

Монгол Улсын дээд шүүх, 2023.09.19, 001/ХТ2023/00158, Д ба Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт холбогдох иргэний хэрэг, https://shuukh.mn/single_case/10347?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=

Монгол Улсын дээд шүүх, 2023.02.09, 001/ХТ2023/00024, байгаль орчин аялал жуулчлалын яам ба А компанид холбогдох иргэний хэрэг, https://shuukh.mn/single_case/10160?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=

Улсын дээд шүүх, 2023.10.26, 001/ХТ2023/00200, Д ба Цагдаагийн ерөнхий газарт холбогдох иргэний хэрэг, https://shuukh.mn/single_case/10361?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1

Давж заалдах шатны шүүх, 2024.04.09, 210/МА2024/00891, Д ба Цагдаагийн ерөнхий газарт холбогдох иргэний хэрэг, https://shuukh.mn/single_case/30308?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1

Улсын дээд шүүх, 2024.05.07, 001/ХТ2024/00098, Ч.С-ын нэхэмжлэлтэй, Т, Э, Сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал нарт холбогдох иргэний хэрэг, https://shuukh.mn/single_case/10488?daterange=2024/01/01%20%202024/06/07%20&id=3&court_cat=1&bb=1

Б. Ном, сурах бичиг

1. Ред Ц.Зориг, Ж.Наранпүрэв, Ч.Нямсүрэн, Монголын шүүх- эмхэтгэл 1.
2. Кристиан Шварц, Манфред Вандт, Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй, орч Л.Эрдэнэ-Очир, 3 дахь хэвлэл, орчуулга хийгдсэн 2017 он.
3. Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, Мөнхийн Үсэг ХХК, 2013 он.



В. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Б.Тамир, *Бүтээгдэхүүний доголдлын үүсэх хариуцлага, түүний иргэний эрх зүйн зохицуулалт*, сэдэвт докторын зэрэг хамгаалсан бүтээл, 2021 он.

Г. Бусад

1. Хууль зүйн судалгааны төв, Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцох аргачлал, гадаадын зарим улсын туршлага /харьцуулсан судалгаа/, Улаанбаатар, 2021 он.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Англи хэл дээр

1. George L. Clark, *The Law of Torts* 10, 1926.
2. James Gordley, Hao Jiang, Arthur Taylor von Mehren, *An Introduction to the Comparative study of Private law: Readings, cases, materials*, 2021, Cambridge University Press, p-301.
3. Paulius Jurcys, Mark Fenwick, Aidas Liaudanskas, [Voice cloning in an age of generative AI: Mapping the limits of the law and Principles for a new social contract with technology](#), [ssrn-4850866.pdf](#)
4. Reinhard Zimmermann, *The law of Obligations: Roman Foundations of the Civilian Tradition*, 1990.
5. R. von Jhering, "Culpa in contrahendo oder Schadensersatz bei nichtigen oder nicht zur Perfektion gelangten Verträgen," *Jherings Jahrbucher* 4, 1861.
6. Warren Seavy, "Principles of Torts", *Harvard Law review* 56, 1942.

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ОЙЛГОЛТ БА ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛ

Л.ГАЛБАДАР¹

М.МӨНХБААТАР²

- Удиртгал
- Зорчих эрхийг хязгаарлах ялын үзэл санааны үндэс
- Монгол Улсад зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж буй шүүхийн практик
- Дүгнэлт

¹ Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч, хууль зүйн магистр /LL.M./.

² Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч, хууль зүйн магистр /LL.M./.



ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ОЙЛГОЛТ БА ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛ

Л.ГАЛБАДАР *Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч, хууль зүйн магистр /LL.M./*

М.МӨНХБААТАР *Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч, хууль зүйн магистр /LL.M./*

Түлхүүр үг

Цахим хяналт, зорчих эрхийг хязгаарлах ял, ялын зорилго, орчин үеийн чиг хандлага, үзэл баримтлал, хууль хэрэглээний нэгдмэл байдал

Хураангуй: Зорчих эрхийг хязгаарлах ял нь 2015 оны Эрүүгийн хуульд хуульчлагдсан урьд манай улсын эрүүгийн хуульд байгаагүй ялын нэн шинэ төрөл юм. Энэхүү ялын мөн чанар нь орчин үеийн технологийн ололтод тулгуурлан ял эдлүүлэх ажиллагааг боломжтой болгож буйд оршино. Энэ нь бусад төрлийн ялаас зорчих эрхийг хязгаарлах ялыг ялгах онцлог шинжийг тодруулдаг. 2021 оноос шүүхийн практикт хэрэглэж эхэлснээс хойш 3 жил орчим хугацаа өнгөрөөд байна. Өгүүллийн хүрээнд Монгол Улсад зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж байгаа шүүхийн практикт дүн шинжилгээ хийсэн болно. Ингэхдээ шүүхүүд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж буй нь хууль хэрэглээний нэгдмэл байх шаардлагад нийцэж байгаа эсэхийг судлав. Хууль хэрэглээний нэгдмэл байдал нь хуулийг нэг мөр зөв ойлгон хэрэглэх, шүүхэд итгэх ард түмний итгэлийг бэхжүүлэх, хүний эрхийг хангах талаас чухал ач холбогдолтой билээ. Мөн шүүхийн шийдвэрийг хууль зүйн үндэслэл бүхий таамаглах боломжтой байх нь гэмт үйлд дүгнэлт хийх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагааны үед хэргийг хялбаршуулан шийдвэрлэх хүсэлт гаргаснаар яллагдагчийн эрх зүйн байдал дээрдэх зэрэг ач холбогдолтой билээ.

I. Удиртгал

Шүүгч хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хуульд захирагдаж хуулийн хэм хэмжээг тайлбарлан хараат бусаар шийдвэр гаргадаг. Харин ийнхүү хуулийг тайлбарлаж шийдвэр гаргахдаа хууль хэрэглээний нэгдмэл байдлыг зайлшгүй анхаарах учиртай. Шүүхүүд хуулийг өөр өөрөөр тайлбарлан хэрэглээд байж боломгүй. Ер амьдралд тохиолдож буй эрх зүйн фактууд хоорондоо ихээхэн ижил төсөөтэй байх нь элбэг. Ижил төсөөтэй тохиолдолд шүүхээс гарах шийдвэр ч мөн ижил байх учиртай. Хараат бусаар шийдвэр гаргах асуудал нь хэн нэгний нөлөөллөөс ангид байх тухайд болохоос хуулийг дур зоргоор тайлбарлах тухай ойлголт ердөөсөө биш. Энэхүү өгүүллэгээр Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан



зорчих эрхийг хязгаарлах ялын агуулгыг өөр өөр байдлаар тайлбарлан хэрэглэж ял оногдуулж буй асуудалд анхаарал хандуулахыг хүссэн юм.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь 2015 оны Эрүүгийн хуульд хуульчлагдсан ялын нэн шинэ төрөл мөн. Энэхүү ял нь гэрийн хорио, нутаг заан суулгах, цөлөх зэрэг ялын төрлүүдээс агуулга, мөн чанарын хувьд ялгаатай юм. Манай улсад зорчих эрхийг хязгаарлах ялыг 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн шинэчлэн найруулсан Эрүүгийн хуультай хамт хэрэглэх боломжгүй байв. Тоног төхөөрөмж, мэргэжилтнүүд, хяналтын системийн хөгжүүлэлт бэлэн бус байснаас 2021 оноос эхлэн шүүхийн практикт хэрэглэж эхэлсэн байна. Бидний хувьд энэ ялын мөн чанар, хэрэгжүүлэх арга зам, үр дүн гээд бүх л зүйл нь шинэ байгаа билээ. Тиймээс ялын хэрэглээний хувьд алдаа оноо, засах сайжруулах зүйлс их байна. Техник болон программ хангамжийн хувьд ч шинэчлэлтүүд хийгдсээр байгаа аж. Харин одоо шүүхийн практикт хэрэглэж буй асуудал руу нь анхаарал хандуулах цаг иржээ.

Зорчих эрхийг хязгаарлах ялын мөн чанар луу эхлээд өнгийж үзэх нь зүйтэй юм. Түүхэн үүсэл үзэл санааны эх үндсийг нь эрвэл XVIII зууны үеийн Английн алдарт философич Ж.Бентамын панептиконтон гэх шоронгийн байгууламжийн төсөлтэй танилцах хэрэг гарна. Мэдээж XVIII зууны англичад цахим хяналт бүү хэл цахилгааны тухай ч төсөөлөл хомсхон байсан биз. Онцлохын учир нь харин Ж.Бентам хоригдлын ухамсар сэтгэхүйд нөлөөлөх нөлөөллийн талаар санал дэвшүүлсэн билээ. Энэ үзэл санааны эх сурвалж ялтны ухамсар сэтгэхүйд нүдэнд үл үзэгдэх хяналтанд байгаа гэх тэр сэрэл мэдрэмжийг бодит хяналт болгох оролдлогоор уламжлан хөгжжээ.

1960-аад онд АНУ-д радио дохиог хүлээн авч буцаан дамжуулах замаар байршлаа мэдээлэх төхөөрөмжийг ах дүү Габель нар зохион бүтээснээр ял эдлүүлэх ажиллагаанд шинэ боломж нэмэгдсэн байна. Харин 20 орчим жилийн дараа буюу 1983 онд АНУ-ын шүүхийн практикт "Electronic monitoring tag" буюу орчуулбал цахим хяналтын гавыг анх удаа ашиглажээ. Үүнээс хойш дэлхийн олон улс оронд амжилттай хэрэгжиж төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг энэ төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд түгээмэл нэвтрүүлэх болов. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд 2021 оноос Монгол Улсад хэрэглэж эхэлсэн хяналтын төхөөрөмжүүд нь илүү дэвшилтэт орчин үеийн GPS технологид суурилсан байна. Энэ нь ялтны зорчих эрхийг хязгаарласан бүсчлэлүүдийг нарийвчлан заах боломжийг бүрдүүлж, хөдөлгөөнт хяналтыг үр дүнтэй болгож байгаа юм.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахдаа үйлдсэн гэмт хэргийн шинж, хувийн байдал зэргийг харгалзана. Мэдээж ялын интервал дотроос сонгон оногдуулах эрх хэмжээ гагцхүү шүүгчид л бий. Харин ялын интервал дотроос сонгох шүүгчийн эрх хэмжээ ялын үр нөлөөг бууруулахад чиглэсэн байх учиргүй. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд бүсчлэлийг хэт өргөн эсхүл явцуу байдлаар ялгамжтай тогтоох тохиолдол их байна.



Манай улсад зорчих эрхийг хязгаарлах ялын талаар Нээлттэй нийгэм форум ТББ-ын захиалгаар 2 судалгаа, цөөн тооны магистрын зэрэг горилсон судалгаа, мөн нэг сэдэвт нэг бүтээл, эрдэм шинжилгээний өгүүллүүд бичигджээ.

Энэхүү өгүүллийн шинэлэг талыг ял шийтгүүлсэн хүний эрхийг хангах, зорчих эрхийг хязгаарлах ялын бүсчлэлийг ямар нөхцөл байдал үнэлэмжээр тогтоох ёстой тухайд болон объектив шалгууруудыг хөндөхийг хичээлээ. Технологийн боломжуудад тулгуурлан ял эдлүүлэх ажиллагааны зохистой үр нөлөөтэй байдалд үнэлэлт өгөх цаашлаад хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бий болгохын тулд хууль тогтоогч, дээд шүүхээс даруй хэрэгжүүлбэл зохих арга хэмжээнд санал өгөхийг зорьсон юм. Мөн ялын зорилгод тулгуурлан бүсчлэлийг тогтоохдоо хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах хэрэгцээ шаардлагыг хамтатган авч үзсэн болно.

II. Зорчих эрхийг хязгаарлах ялын үзэл санааны үндэс

Зорчих эрхийг хязгаарлах ялын үндэс улбааг үзэл санааны хувьд болон технологийн хувьд авч үзэх боломжтой. Доктор, профессор Д.Баярсайхан (Ph.D) ялын зорилгыг "орчин үед эрүүгийн эрх зүйн салбарын тэргүүлэх чиглэл болон хөгжиж буй гуманизаци, криминализацийн хандлага нь ялын либерал онолын хүрээнд хүч түрэн орж ялын агуулга, зорилгыг шинээр томъёолон шаардлагыг бий болгож байна. Либерал онолчдын үзэж байгаагаар ял шийтгэл хэдий ч гэмт этгээдэд итгэл үзүүлэх, засаж төлөвшүүлэх нийгмийн арга хэмжээ гэж үзэж ялын зорилго нь нийгэмшүүлэх, иргэншүүлэх тал нь давамгайлсан цээрлэл шийтгэлийн хосолмол систем байх ёстой"¹ хэмээн тодорхойлжээ.

Зорчих эрхийг хязгаарлах ялын анхны үзэл санааг Английн философич Ж.Бентамын XVIII зууны үед боловсруулсан панаптикон (panopticon) хэмээх хорих байрны загвартай холбон авч үздэг талаар дээр дурдсан. Энэхүү байрны онцлог нь байгууламжийн гол цамхагт ганцхан харуул байх ба харуул хаашаа харж байгааг хоригдлууд мэдэх боломжгүй гагцхүү хяналтад байгаа гэсэн сэтгэл зүйд тулгуурлан хорих байрыг зохион байгуулах санаа байжээ. Зарим судлаачид Ж.Бентамын энэ загвар нь ирээдүйд зорчих эрхийг хязгаарлах ялын талаарх үзэл санаа бүрдэх үүсэл болсон гэж үздэг². Орчин үед хорих ялыг орлох хамгийн боломжит хувилбар нь зорчих эрхийг хязгаарлах ял болоод байгаа бөгөөд үзүүлж буй эерэг нөлөөллүүдийг хангалттай дурдаж болохоор байна. Зорчих эрхийг хязгаарлах ялыг Ж.Бентамын үзэл санаатай холбохын учир нь цөөн хүн, хүчний нөөцөөр олон ялтныг хянах боломжийг бүрдүүлж буйгаар тодорхойлж болно. Цахим хяналтын төхөөрөмжийн тусламжтайгаар хяналтад буй ялтнуудын хувьд үргэлж өөрийг нь хянаж байгаа гэх бодол, мэдрэмж нь хяналт буюу ял эдлүүлэх ажиллагааг илүү үр нөлөөтэй болгодог байна.

¹ Д.Баярсайхан, "Орчин үеийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага", *Шударга ёс сэтгүүл*, (№3) 2010.

² Д.Бадам, М.Мөнхбаатар, Л.Галбадар, "Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх арга зам", 2020, 7 дахь тал.



Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх технологийн онцлог

Зорчих эрхийг хязгаарлах ял нь ялын уламжлалт төрлүүдээс ялгаатай нь орчин үеийн техник технологийн ололтод тулгуурлан энэ ялыг хэрэглэх боломжтой болсон явдлаар илэрнэ. 1960-аад оны эхэн үед хөдөлгөөнт объектын байршлыг тогтоож чадах зөөврийн төхөөрөмжийг Харвардын их сургуулийн судалгааны баг бүтээжээ. Улмаар энэхүү төсөл хөгжсөөр радио дохио дамжуулах замаар хөдөлгөөнт объектын байршлыг мэдээлэх анхны цахим хяналтын төхөөрөмж бий болсон байна. Гэвч радио дохио дамжуулах төхөөрөмж нь зөвхөн гэрт нь байрлуулсан үндсэн төхөөрөмжөөс тодорхой зайд холдоход дохиолон мэдээлж байсан нь цахим хяналтыг гэрийн хориотой нэлээдгүй төстэй байдлаар хэрэглэх боломжийг олгож байв. 1990-ээд оноос АНУ-ын цэргийн технологид хэрэглэж байсан GPS технологи иргэдийн хэрэглээнд нэвтэрч эхэлснээр 24/7 байршил мэдээлэх боломжийг цахим хяналтын төхөөрөмжид олгосон юм. GPS хяналтын төхөөрөмж нь дэлхийн тойрог замд байгаа нам болон өндрийн хиймэл дагуулаас мэдээлэл авах, дамжуулах зарчмаар ажиллахдаа объектын байршлыг хөдөлгөөнт байдлаар явсан замын хамтаар мэдээлэх, хадгалах боломжтой болжээ.

Ийнхүү радио дохио дамжуулах төхөөрөмж хэрэглэж байснаас илүүтэйгээр хяналтын бүсчлэлийг илүү уян хатан тогтоох, зорчих замыг тэмдэглэх, очихыг хориглосон газруудыг бүртгэн хянах, уулзахыг хориглосон хүнд тодорхой зайнд ойртоход дохиолон мэдээлэх зэргээр зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаа илүү шинэ түвшинд очсон байна. Мөн үүний зэрэгцээ тодорхой цагийн тохируулга хийх замаар шөнө оройн цагаар гэрээсээ гарахыг хориглох, зөвхөн амралтын өдөр л сүмд очих маршрут нээгдэх зэрэг олон сонголтууд нь ялын үр нөлөөтэй байхад ч эерэг үр дүнг авчирчээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45/110 дугаар тогтоолоор "Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм"-д "Гишүүн орнууд нь хорих ялыг хэрэглэх явдлыг багасгах замаар бусад боломжийг хангах, эрхийн зөрчил гаргагчийг нийгэмд хэвийн амьдралд эргэж орох хэрэгцээ, нийгмийн шударга ёсны шаардлага, хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан эрүүгийн байцаан шийтгэх салбар дахь бодлогыг оновчтой болгох зорилгоор өөрийн эрхийн системийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг боловсруулна"³ гэж заасан. Монгол Улс цаазаар авах ялаас татгалзсан нь ялын шинэчлэлд хийсэн томоохон алхам болсон бол зорчих эрхийг хязгаарлах ялыг Эрүүгийн хуульдаа хуульчилж 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэглэж эхэлсэн нь шинэчлэлийн дараагийн том алхам гэж дүгнэж байна.

Цахим хяналтыг хэрэглэж буй Европ, Америк, Австрали тивийн орнуудад шүүхийн өмнөх шатанд (таслан сэргийлэх арга хэмжээ хэлбэрээр) барьцаат батлан даалт⁴, ялын төрөл⁵ (гэм буруутай нь тогтоогдсон хүнд оногдуулах ял

³ Монгол Улсын Хүний Эрхийн Үндэстний комисс, *Олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхэтгэл*, 2012, <https://www.mn-nhrc.org/153-rt-r-rrsryosrrs-uus-susrryorr-rsrir-ssrrsrr-srrrrrrrs-rrrr-rrssr-rryosryori-ryissr-rrryeryorr-rrtyissr.html>, (Сүүлд үзсэн: 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдөр).

⁴ Rory Geoghegan, *Future of Corrections: Exploring the Use of Electronic Monitoring*, (London: Policy Exchange, 2011), <https://policyexchange.org.uk/publication/future-of-corrections-exploring-the-use-of-electronic-monitoring/>, (Сүүлд үзсэн: 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдөр.)

⁵ New Economics Foundation, *Justice for sale – the privatisation of offender management services*,



хэлбэрээр), ял эдлэхийг хойшлуулах, хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө суллах⁶ зэрэг тохиолдлуудад хяналт тавихдаа хэрэглэж байна. Жишээлбэл Нэгдсэн вант улсад (ИБУИНВУ цаашид Нэгдсэн вант улс гэх) хийсэн судалгаагаар 2021 оны 3 дугаар сарын байдлаар цахим хяналтыг хэрэглэж буй 14.000 тохиолдол бүртгэгдсэн байгаа нь өмнөх жилүүдээс 34.3 хувиар өсжээ. Цахим хяналтыг хэрэгжүүлэх ач холбогдлыг хорих ялын альтернатив хувилбар болгох, хорих ялын хэрэглээг бууруулах, рецидивизмыг бууруулах гэж тодорхойлсон. 2022 оны 3 дугаар сарын байдлаар нийт хэрэглээний 39 хувийг шүүхийн өмнөх шатанд таслан сэргийлэх арга хэмжээ хэлбэрээр, 36 хувийг ял шийтгэл хэлбэрээр, 18 хувь нь хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан этгээдэд хяналт тавих хэлбэрээр хэрэглэсэн⁷ байна. Харин нэгэн сонирхолтой тоо баримт дурдвал 2021–2022 оны хооронд АНУ-д цагаачлалын болон гаалийн албанаас цахим хяналтын төхөөрөмжийн хэрэглээг эрс нэмэгдүүлж 360,000 хүнд хэрэглэсэн байдаг.⁸ АНУ болон Европын өндөр хөгжилтэй орнуудад цагаачлалын давлагаа үүсэж байгаатай холбоотойгоор эрсдэлт бүлэгт хамаарч буй цагаачдыг хянах зорилгоор сүүлийн үед цахим хяналтын төхөөрөмжийг ашиглах болжээ.

Цахим хяналт нь гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг албадан шоронд хорихоос илүүтэй хүмүүнлэг бөгөөд хорих ялыг орлох сонголтод хувилбар болдог. Гэмт хэрэг үйлдсэн хүнд нийгмийн дунд засрал хүмүүжил олох боломжийг бий болгодог⁹ тул үр нөлөөтэй хувилбар гэж үздэг байна. Цахим хяналт нь санхүүгийн өндөр төлбөр шаарддаг, нийгмийн аюулгүй байдал, ялсныг нийгэмшүүлэх тухайд зорилгодоо хүрч чадаж байгаа эсэх нь эргэлзээтэй талаар шүүмжлэх хандлага¹⁰ ч бас бий.

АНУ-д эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүст хөлийн шилбэ, шагайнд зүүх болон гарын бугуйнд зүүж хөдөлгөөнийг хянах төхөөрөмжийн хэрэглээ 2005–2015 оны хооронд 140 хувиар нэмэгдсэн байна. Тодруулбал 2005 онд 53.000 орчим төхөөрөмж хэрэглэгдэж байсан бол 2015 онд энэхүү тоо нь нэг өдөрт 125.000 төхөөрөмжөөр мөн тооны ялтнуудад хяналт тавих хүртлээ өсөж¹¹ АНУ-ын 50 мужид хэрэглэж байгаа ажээ. Мөн 2005–2015 оныг хамруулсан судалгаагаар GPS төхөөрөмжийн хэрэглээ нэмэгдэж (2005 онд 2897 төхөөрөмж хэрэглэж

(London: TUC publications, 2014), 11–28.

⁶ Anthea Hucklesby, "Vehicles of desistance? The impact of electronically monitored curfew orders", *Criminology and Criminal Justice* (2008), 51–71, https://www.researchgate.net/publication/249786441_Vehicles_of_desistanceThe_impact_of_electronically_monitored_curfew_orders, (Сүүлд үзсэн: 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр).

⁷ HM Government, *Electronic monitoring caseload*, <https://data.justice.gov.uk/contracts/electronic-monitoring>, (Сүүлд үзсэн: 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдөр).

⁸ Vera Institute of Justice, *Vera Institute of Justice Issues Report on the Growth of Electronic Monitoring in the United States*, <https://www.vera.org/newsroom/vera-institute-of-justice-issues-report-on-the-growth-of-electronic-monitoring-in-the-united-states>, 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр хандав.

⁹ Kate Weisburd et al., *Electronic Prisons: The Operation of Ankle Monitoring in the Criminal Legal System*, *George Washington University Law School №2021–41*, 2021, 4.

¹⁰ James Kilgore, *Electronic Monitoring: A Survey of the Research for Decarceration Activists*, <https://www.realcostofprisons.org/writing/kilgore-survey-of-em-research.pdf>, (Сүүлд үзсэн: 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр).

¹¹ The Pew Charitable Trusts, *Use of Electronic Offender-Tracking Devices Expands Sharply. Number of monitored individuals more than doubled in 10 years*, <https://www.pewtrusts.org/en/research-and-analysis/issue-briefs/2016/09/use-of-electronic-offender-tracking-devices-expands-sharply>, (Сүүлд үзсэн: 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр).



байсан бол 2015 онд 88172 төхөөрөмж хэрэглэж байна), RF төхөөрөмжийн хэрэглээ буурсан (2005 онд 50132 төхөөрөмж хэрэглэж байсан бол 2015 онд 37706 төхөөрөмж хэрэглэж байна)¹² үзүүлэлтийг харуулсан нь зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх техник технологийн сонголт нь GPS төхөөрөмж рүү илүүтэй чиглэгдэж байгааг харуулж байна.

Манай улсын хувьд зөвхөн GPS төхөөрөмжийг хэрэглэдэг. GPS төхөөрөмжийн хэрэглээ цар хүрээг үүрэн телефоны операторуудын сүлжээний тархац, хөдөлгөөнт интернэтийн хэрэглээний цар хүрээгээр тогтоох боломжтой. Ерөөс сүлжээний тархцын хангалттай биш байдалтай холбон зорчих эрхийг хязгаарлах ялын үр нөлөө, хэрэглээг шүүмжлэх нь утгагүй хэрэг юм. Ямар ч технологи өндөр хөгжсөн оронд гар утас, хөдөлгөөнт интернэтийн сүлжээгүй бүс, орон зай байдаг нь хэн ч маргашгүй баримт билээ. Wifi сүлжээ унтрах, дүрст дуудлага хурлын үед тасалдах, гацах, системийн алдаа зэрэг зүйлс өдөр тутмын амьдралд тохиолдсоор байдаг. Зорчих эрхийг хязгаарлах ял буюу цахим гавын хяналтыг 1980 оноос хойш хэрэгжүүлэх явцад хяналтын төхөөрөмжтэй холбоотой алдаа дутагдлууд маш их илэрч байсан бөгөөд үүнд тухайлбал худал дохио илгээх, цахим гавыг амархан салгаж авах гэх зэрэг асуудлууд үүссээр ирсэн байна. Хэдийгээр энэ мэтчилэн төхөөрөмж, техник, технологитой холбоотой асуудлууд үүссээр байгаа боловч хорих ялын хэрэглээ, хорих ангиудын ачааллыг бууруулах зорилгын үүднээс энэхүү ялын хэрэглээ нь өсөн нэмэгдсээр байгаа талаар тэмдэглэжээ¹³.

Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэглээ өсөн нэмэгдэхийн зэрэгцээ эерэг болон сөрөг талуудыг судлаачид шүүмжлэх болсон байна. Зарим судлаачдын үзэж байгаагаар цахим хяналтын төхөөрөмж ашиглах нь дахин гэмт хэрэг үйлдэх, гэмт хэрэгт холбогдох явдлыг бууруулдаг^{14,15} гэж үзсэн жишээ бий. Шүүмжлэх чиг хандлага нь ялгаварлан гадуурхалт, сэтгэл санааны дарамт бий болгодог, санхүүгийн хувьд цахим гавын төлбөр нь санхүүгийн дарамт бий болгодог зэрэг агуулгад түлхүү ханджээ. Харин нөгөө талаас цахим хяналтын төхөөрөмж ашиглах нь хорих ялын зардлыг бууруулдаг бөгөөд өдөрт 70–80 ам.долларын зардлыг өдөрт 4–9 ам.долларын зардал болтол бууруулдаг¹⁶ гэсэн судалгаа хийгджээ.

Монгол Улсын хувьд зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны хувьд 1 сард 39,000–42,500 төгрөгийн ашиглалтын зардал төлдөг. Үүнийг өдөрт хуваан авч үзвэл нэг өдөрт 1300–1500 төгрөгийн зардлыг ялтан төлөх үүрэг хүлээдэг байна. Энэхүү үнэд цахим бугуйвчны болон үүрэн холбооны сүлжээний ашиглалтын зардлыг багтдаг ажээ.

¹² Dennis Doffing, BLU+ RF Monitoring, *The Journal of Offender Monitoring* 25 no. 2, 2014, 19.

¹³ Jack Karsten and Darrell M. West, *Decades later, electronic monitoring of offenders is still prone to failure*, 2017, <https://www.brookings.edu/articles/decades-later-electronic-monitoring-of-offenders-is-still-prone-to-failure/>, (Сүүлд үзсэн: 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр).

¹⁴ William Bales et al., *A Quantitative and Qualitative Assessment of Electronic Monitoring*, 2010, <https://www.ojp.gov/pdffiles1/nij/grants/230530.pdf>, 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр хандав.

¹⁵ Marc Renzema and Evan Mayo-Wilson, Can electronic monitoring reduce crime for moderate to high-risk offenders?, *Journal of Experimental Criminology* №1, 2005, 215–237.

¹⁶ Jack Karsten and Darrell M. West, *Decades later, electronic monitoring of offenders is still prone to failure*, (2017), <https://www.brookings.edu/articles/decades-later-electronic-monitoring-of-offenders-is-still-prone-to-failure/>, (Сүүлд үзсэн: 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр).



Улсын хэмжээнд хорих ял эдэлж буй хоригдол, хоригдолд хяналт тавих урсгал зардал 1 жилд дунджаар 36 тэрбум төгрөг байгаа бол зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд биечилсэн болон техникийн хяналт тавих урсгал зардал 1 жилд дунджаар 900 орчим сая төгрөг байхаар тооцоологдсон¹⁷ гэсэн байна. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга, хурандаа Ц.Очгэрэлийн ярилцлагадаа "ял эдлүүлэх ажиллагааны зардлын хувьд улсын төсөвт үзүүлэх ачааллыг нэлээдгүй хувиар буулгах тооцоо гарсан, хорих ялтай харьцуулахад 10–15 хувиар, бусад урсгал зардал 25–30 дахин бага зардлаар хэрэгжүүлэх тооцоо гарсан. Энэ нь улс орны эдийн засгийн хүндрэлтэй байгаа өнөөгийн цаг үед төсвийн хэмнэлтийг бий болгоход маш чухал үүрэгтэй юм¹⁸" гэжээ.

III. Монгол Улсад зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж буй шүүхийн практик

2015 оны Эрүүгийн хуульд хуульчлагдсан зорчих эрхийг хязгаарлах ял нь техникийн нөхцөл бүрэн хангагдаагүй, ял эдлүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамж, хяналтыг хэрэгжүүлэх хүний нөөц бүрдээгүй зэрэг шалтгаанаар шууд хэрэгжиж эхлээгүй юм. Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд зааснаар 2021 оноос эхлэн шүүхийн практикт хэрэглэж эхэлжээ. Зорчих эрхийг хязгаарлах ялыг шүүхийн практикт хэрэглэж эхэлснээс хойш хорих ялын хэрэглээ огцом буурсан эерэг үр дүнг үзүүлжээ.

Тухайлбал 2020 онд¹⁹ анхан шатны шүүхээс 13391 хүн ял шийтгүүлснээс 27.4 хувьд нь хорих ял, 2021 онд²⁰ 11263 хүн ял шийтгүүлснээс 22.3 хувьд нь хорих ял, 9.3 хувьд нь зорчих эрхийг хязгаарлах ял, 2022 онд²¹ 14394 хүн ял шийтгүүлснээс 19.5 хувьд нь хорих ял, 12.2 хувьд нь зорчих эрхийг хязгаарлах ял, 2023 онд²² 14192 хүн ял шийтгүүлснээс 17.9 хувьд нь хорих ял, 12.7 хувьд нь зорчих эрхийг хязгаарлах ял, 2024 оны эхний хагас жилд²³ 7422 хүн ял шийтгүүлснээс 17.6 хувьд нь хорих ял, 11.9 хувьд нь зорчих эрхийг хязгаарлах ял тус тус оногдуулсан байна.

¹⁷ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын 2024.08.20-ны өдрийн 05/2040 дүгээр албан бичгийн хавсралт.

¹⁸ "Ц.Очгэрэл: Зорчих эрхийг хязгаарлах ял нь Монгол Улсын эрүүгийн ял шийтгэлийн бодлого дахь шинэтгэлийн нэг үндсэн чиглэл", *ubn.mn*, 2022, <https://ubn.mn/p/27894>, (Сүүлд үзсэн: 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр).

¹⁹ Шүүхийн ерөнхий зөвлөл, "2020 оны Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны дүн мэдээ", https://admincourt2.gov.mn/site/full_story/2339, (Сүүлд үзсэн: 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр)

²⁰ Шүүхийн ерөнхий зөвлөл, "2021 оны Монгол Улсын шүүхийн Шүүн таслах ажиллагааны дүн мэдээ", https://www.judcouncil.mn/site/news_full/11991, (Сүүлд үзсэн: 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр).

²¹ Шүүхийн ерөнхий зөвлөл, "2022 оны Монгол Улсын шүүхийн Шүүн таслах ажиллагааны дүн мэдээ", https://judcouncil.mn/site/news_full/12877, (Сүүлд үзсэн: 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр).

²² Шүүхийн ерөнхий зөвлөл, "2023 оны Монгол Улсын шүүхийн Шүүн таслах ажиллагааны дүн мэдээ", https://judcouncil.mn/site/news_full/13967, (Сүүлд үзсэн: 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр).

²³ Шүүхийн ерөнхий зөвлөл, "2024 оны хагас жилийн Монгол Улсын шүүхийн Шүүн таслах ажиллагааны дүн мэдээ", https://judcouncil.mn/site/news_full/14338, (Сүүлд үзсэн: 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр).



Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж эхэлсэн 2021 оноос 2024 оны эхний хагас хүртэлх шүүн таслан ажиллагааны тайлан мэдээнд дурдсанаар анхан шатны шүүхээс нийт 47271 хүнд ял шийтгэл оногдуулснаас 5513 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулжээ. Энэ нь шүүхээс оногдуулж буй ялын 11.6 хувийг зорчих эрхийг хязгаарлах ял эзэлж байгаа бол хорих ял 19.6 хувь, торгох ял 57.2 хувь, нийтэд тустай ажил хийлгэх ял 11.2 хувь, бусад нь албадлагын арга хэмжээ хэрэглэсэн байна. 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж эхэлснээс хойш анхан шатны шүүхээс оногдуулж буй хорих ялын эзлэх хувь 27 хувиас 17.6 хувь хүртэл буурсан тоон үзүүлэлт гарч байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь Эрүүгийн хуульд заасан үндсэн 4 төрлийн ялын нэг бөгөөд нийт ял шийтгэл эдэлж байгаа хүний 11–12 хувь нь зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлж байгаа гэсэн тоон судалгаа гарсан. Эрүүгийн эрх зүйд үндсэн ялыг хүндээс хөнгөн рүү нь гэсэн дарааллаар системчлэн байршуулдаг билээ. Зорчих эрхийг хязгаарлах ял нь Эрүүгийн хуульд системчлэгдэн хуульчлагдсанаар хорих ялын дараа орох хүнд төрлийн ялд хамаарч байгааг дурдах нь зүйтэй.

Эрүүгийн хуульд зааснаар "Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ"²⁴, "Шүүх тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан ялтныг бусдад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглож болно"²⁵ гэж хуульчилсан.

Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулсан 2024 оны шийдвэрүүдээс дурын сонголтоор 55 шүүхийн шийдвэрт зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахдаа шүүхээс хүлээлгэж буй үүрэг, хязгаарлалтын бүсчлэл, ялын хугацаа, ял шийтгэгдэж буй хүний хүний хувийн байдлыг судлан авч үзлээ.

Шүүхийн шийдвэрт хийсэн судалгаанаас үзэхэд "оршин суугаа газар" гэдгийг шүүх харилцан адилгүй байдлаар тайлбарлан хэрэглэж байгаа нөхцөл байдал тогтоогдож байна. Тодруулбал оршин суугаа газар болох хорооны нутаг дэвсгэрээс гарахыг хориглосон 5, багийн нутаг дэвсгэрээс гарахыг хориглосон 2, дүүргийн нутаг дэвсгэрээс гарахыг хориглосон 15, 2–3 дүүргийн нутаг дэвсгэрээс гарахыг хориглосон 4, сумын нутаг дэвсгэрээс гарахыг хориглосон 20, сумын төвөөс гарахыг хориглосон 2, нийслэлийн буюу Улаанбаатар хотын нутаг дэвсгэрээс гарахыг хориглосон 6, аймгийн нутаг дэвсгэрээс гарахыг хориглосон 1 шийдвэр судлагдсан байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангид зорчих эрхийг хязгаарлах ялыг 1 сараас 5 жил хүртэл хугацаагаар оногдуулахаар хуульчилсан. Эрүүгийн хуулийн тусгай

²⁴ Эрүүгийн хууль (2015)-ийн 5.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

²⁵ ЭХ-ийн 5.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.



ангид заасан гэмт хэргүүдэд 1 сараас 3 сар хүртэл, 1 сараас 6 сар хүртэл, 1 сараас 1 жил хүртэл, 6 сараас 3 жил хүртэл, 6 сараас 5 жил хүртэл, 1 жилээс 5 жил хүртэл гэсэн байдлаар оногдуулахаар заасан. Мөн судлан үзсэн 55 шийдвэрүүдэд 2 тохиолдолд 3 жилийн хугацаагаар, 8 тохиолдолд 2 жилийн хугацаагаар, бусад тохиолдолд 1 жил 10 сараас бага хугацаагаар, бусад 45 тохиолдолд 1 сараас 1 жил 10 сарын хооронд ял оногдуулжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газраас ирүүлсэн тоон судалгаанд зорчих эрхээ хязгаарлуулсан нийт 6136 ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьсан талаар дурджээ. Тус судалгаанд ялтны хориглолт, хязгаарлалтын бүсчлэлийг Улаанбаатар хот, аймгийн нутаг дэвсгэрээр тогтоосон 1905 ялтан, дүүрэг, сумын нутаг дэвсгэрээр тогтоосон 4080 ялтан, хороо, багийн нутаг дэвсгэрээр тогтоосон 119 ялтан, гэрийн тоот хаягаар тогтоосон 28 ялтан, тодорхой газар очихыг хориглосон 4 ялтан байна гэжээ.

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас 2024 онд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн тогтоолуудаас түүвэр болгон авсан болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн тоон мэдээллээс шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахдаа "оршин суух газраас явахыг хориглох" гэдгийг засаг захиргааны бүхий л нэгжээр буюу баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрээр болон оршин суугаа гэрийн тоот хаягаас гарч явахыг хориглох гэсэн байдлаар ялгамжтай хэрэглэн шийдвэрлэж байна.

Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах дээд шүүхийн үүргийн талаар доктор, профессор Н.Лүндэндорж (Sc.D) "шүүхийн хараат бус байдлын зарчмын үүднээс Улсын дээд шүүхийг эрх зүйн маргааныг эцэслэн хянадаг, шүүхийн хууль хэрэглээний нэгдмэл чанарыг хангаж, үндэсний эрх зүйг хөгжүүлдэг, эрх хэмжээ нь улсын нийт хүн ам, нутаг дэвсгэрийг хамардаг буюу бүс нутаг, засаг захиргааны нэгжээр үйл ажиллагаа нь хязгаарлагддаггүй шүүхийн оюун ухаан, соёлын цөм болсон шүүх гэж ойлгох нь зөв юм²⁶" гэж тодорхойлжээ.

Улсын Дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангаж 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн Дугаар 166 тогтоолд "...анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Б.Э-д оногдуулсан 2 жил 5 сар, Ч.Х-т оногдуулсан 1 жил 6 сарын хугацаагаар оногдуулсан хорих ялыг Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т зааснаар зорчих эрхийг хязгаарлах ялаар солихдоо ялтны чөлөөтэй зорчих хүрээ хязгаарыг хэт өргөн буюу Нийслэлийн нутаг дэвсгэрээр тогтоосон нь эрүүгийн хариуцлагын зорилгод нийцээгүй байна гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ. Зорчих эрхийг хязгаарлах ял нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих үүргийг хүлээлгэж, нийгмээс тусгаарлахгүйгээр засарч хүмүүжих боломжийг олгох зорилготой бөгөөд үйлдсэн гэмт хэргийнх нь шинж чанар, хувийн байдлыг нь харгалзан чөлөөтэй зорчих хүрээ хязгаарыг нь хумьж, чиглэлийг тогтоох зэргээр чөлөөтэй зорчих эрхэд нь тодорхой хугацаанд хязгаарлалт тогтоож буй ял шийтгэлийн төрөл юм. Иймд шүүгдэгч Ч.Х-ын оршин суугаа газар буюу Улаанбаатар хотын

²⁶ Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар*, 2022, 798 дахь тал.



Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрээр, шүүгдэгч Б.Э-г Хөвсгөл аймгийн Мөрөн сумын нутаг дэвсгэрээр зорчих эрхийг хязгаарлах нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн үзэв²⁷ гэж шийдвэрлэжээ.

Монгол Улсын хууль тогтоомжуудад "оршин суух газар", "байнга оршин суугаа", "оршин суугаа газар", "оршин суугаа газрын хаяг" зэргээр олон янзын агуулга бүхий томъёоллоор хуульчлагджээ. Тухайлбал, Иргэний хуульд "Иргэний оршин суугаа газрыг хуулийн дагуу түүний харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр тодорхойлно²⁸", "Иргэн бүртгүүлсэн газраа байнга оршин суудаггүй бол гол төлөв амьдран суудаг, эсхүл тухайн этгээдийн эд хөрөнгийн дийлэнх хэсэг байгаа газрыг түүний оршин суугаа газар гэж тодорхойлж болно"²⁹ гэж заасан бол Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нутаг дэвсгэрийн "нэгж" гэж аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороог хэлнэ гэж заасан байна.

Эрүүгийн хуульд "өөрийн оршин суух газраас явахыг хориглох³⁰" гэж заасан бол дээр дурдсан Улсын Дээд шүүхийн тогтоолд "ялтны чөлөөтэй зорчих хүрээ хязгаар" гэсэн нэр томъёо хэрэглэн хязгаарлах бүсчлэлийг дүүрэг, сумын нутаг дэвсгэрээр тогтоосон нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл оршин суух газрыг аймаг, нийслэл гэсэн засаг захиргааны хамгийн том нэгжээр ойлгон хүрээг тогтоох нь ялыг үр нөлөөгүй болгох, ялын зорилгод нийцэхгүй гэдгийг Улсын Дээд шүүх онцолжээ. Улмаар ялтны чөлөөтэй зорчих хүрээ гэсэн нэр томъёо хэрэглэсэн нь цаашид зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахдаа эрүүгийн хариуцлагын цээрлүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгод нийцүүлэн үр нөлөөтэй байдлаар хэрэглэх шаардлага чухлаар тавигдаж байна.

Жишээлбэл Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ижилхэн гэмт хэрэг үйлдсэн 2 шүүгдэгчид тус тус 3 сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах оногдуулсан гэж төсөөлөн эхний шүүгдэгчид Улаанбаатар хотын нутаг дэвсгэрээс гарахыг хориглох, нөгөө шүүгдэгчийг гэрээсээ гарахыг хориглох хязгаарлалт тогтоон шийдвэрлэж шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсан гэж үзье. Энэ тохиолдолд ялын бодлого, хүлээлгэх үүрэг, хязгаарлалт харилцан ялгаатай байгаа нь Монгол Улсын Үндсэн хуульд "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна³¹" гэж заасанд зарчимд нийцэж, алагчлалгүйгээр тэгш хандаж чадаж байна уу гэдгийг анхаарч үзэх шаардлага тавигдана.

Улсын Дээд шүүхийн шүүгч, доктор Ц.Цогт (LL.D), судлаач С.Цэрэндолгор нар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг онцлохдоо "Энд нэгэн зүйл тодотгон дурдахын учир нь шүүгчийн дотоод итгэл гэдэг зүйл гагцхүү нотлох баримтын үнэлгээ дээр яригдахаас бус хуулийг дотоод итгэлээр тайлбарлана гэж байж болохгүй нь мэдээж тул хууль хэрэглээ нэгдмэл байх учиртай³²" гэсэн байна.

²⁷ Улсын дээд шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн дугаар 166 тогтоол, https://shuukh.mn/single_case/3233?daterange=2022-01-01%20-%202022-12-03&id=3&court_cat=2&bb=1.

²⁸ Иргэний хууль (2002)-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг.

²⁹ ИХ-ийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг.

³⁰ ЭХ-ийн 5.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

³¹ Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

³² Ц.Цогт, С.Цэрэндолгор, "Монгол Улсын Шүүхийн тогтолцоон дахь Улсын Дээд Шүүхийн хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх чиг үүрэг: Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах нь",



Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрх болох хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийн асуудал энэ хүрээнд хөндөгдөнө. Улсын Дээд шүүхийн шүүгч П.Соёл-Эрдэнэ энэ талаар “Хууль хэрэглээний нэгдмэл байдал гэдэг нь маргааны үйл баримт нь адил тохиолдолд эрх зүйн үр дагавар нь бүх хүнд адилхан байхыг хэлнэ. Адилхан хэрэг маргааныг Дарханд нэг өөр, Нийслэлд нэг өөр шийдэж байвал хууль хэрэглээний нэгдмэл байдал алдагдаж, ойлгомжгүй байдал үүснэ. Хууль хэрэглээний нэгдмэл байдал бий болсноор хууль шүүхийн өмнө бүгд эрх тэгш байх зарчим хангагдана³³” гэжээ.

Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахын ач холбогдол нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх, шүүхийн шийдвэрт эргэлзэхгүй байх, шүүхийн шийдвэр ойлгомжтой байх, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийн хэрэгжилт хангагдахад чухал ач холбогдолтой. Үүний зэрэгцээ шүүхээс гарах шийдвэрийг таамаглах боломж чухал бөгөөд энэ нь хэргийн онолыг зөв тодорхойлж хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх, шүүх хуралдааныг хялбаршуулж явуулах зэрэг процесс ажиллагааг хөнгөвчлөх, зардал хэмнэх зэрэг эерэг үр нөлөөтэй юм.

Герман улсын эрдэмтэн П.Казиске өөрийн бүтээлдээ “Хуулийг нэгдмэл байдлаар хэрэглэнэ гэдэг бол маш чухал. ХБНГУ-ын систем нь хуулийн нэгдмэл байдлыг өдөр тутмын практикаар бий болгодог. Өөрөөр хэлбэл, ХБНГУ-ын шүүгчид практикийг дагах хандлагатай байдаг. Нэгэнт өөрийнх нь гаргасан шийдвэр нь практикийн эсрэг гарвал тухайн шийдвэр цуцлагдах магадлал өндөртэй учраас шүүгч нар дийлэнхдээ нийтлэг хандлагаа дагаж шийдвэрлэдэг³⁴ гэжээ. Зорчих эрхийг хязгаарлах ялын бүсчлэлийг зөв сонгох тухайд Улсын Дээд Шүүхээс хэрэг маргааныг шийдвэрлэх замаар Эрүүгийн хуулийн холбогдох зүйл хэсгийг тайлбарлан тогтоол гаргаж шийдвэрлэсэн жишиг шийдвэрийг дагах нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бий болгоход нэн чухал ач холбогдолтой байна.

Үүний зэрэгцээ зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл, технологи, хяналтын программ зэрэг нь цаг үеэ даган хөгжиж байгаа тул ялыг илүү үр нөлөөтэйгөөр эдлүүлэх боломжийг эрэлхийлэн орчин үеийн технологийн ололт боломжуудыг танин мэдэж хэрэглэх хэрэгцээ үүсжээ.

Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны ял эдлэх бүсийг хяналтын программ хангамжид дараах байдлаар тусгаж байна. Үүнд:

- эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглохоор заасан бол оршин суугаа хаягийг тогтоож, зөвшөөрсөн бүсийг боломжит хэмжээ, хязгаараар
- эрх бүхий байгууллагын хяналтад тодорхой газар очихыг хориглохоор заасан бол хориглосон газрын хаяг, байршлыг тогтоон нэвтрэхийг

Монголын төр, эрх зүй сэтгүүл, №1/103, 2023, 40 дэх тал.

³³ “П.Соёл-Эрдэнэ: Хууль хэрэглээний нэгдмэл байдал нь хүн бүр хуулийн өмнө тэгш байх зарчимд нийцнэ”, *itoim.mn*, <https://itoim.mn/a/2024/10/08/society/erg?9ceef2256a9864b59f1c1092cb02289b>, (Сүүлд үзсэн: 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр).

³⁴ Петер Казиске, Орч Б.Буяншиг, *Эрх зүйн онолын ерөнхий, тусгай зарчмууд, түүний хэрэглээ*, 2024, 10–11 дэх тал.



хориглох бүсийг боломжит хэмжээ, хязгаараар,

- эрх бүхий байгууллагын хяналтад тодорхой чиглэлээр зорчихоор заасан бол оршин суугаа хаяг, байршлаас зөвшөөрсөн газар хүртэл явганаар болон тээврийн хэрэгслээр зорчих чиглэлийг тодорхойлж, боломжит хэмжээ, хязгаараар,
- эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суух газраа өөрчлөх гэж заасан бол оршин суугаа засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээгээр,
- тодорхой хүнтэй уулзах, бусадтай харилцахыг хориглохоор заасан бол уулзахыг хориглосон иргэний оршин суугаа газар, ажлын байр, зорчих чиглэлийн дагуу ялтныг нэвтрэхийг хориглосон бүсийг боломжит хэмжээ, хязгаараар³⁵ тус тус тогтоохоор заажээ.

Энэхүү журамд зааснаар болон зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих системийн боломжтой судлаачид танилцсан юм. Зөвхөн засаг захиргааны нэгж болох нийслэл, аймаг, дүүрэг, сум, хороо, багийн нутаг дэвсгэрийн хилийн цэсээр хязгаарлагдахгүйгээр тодорхой чиглэл, маршрутаар зорчин явах, хориглосон бүс тогтоох, тодорхой хүнтэй уулзахыг хориглох хязгаарлалт тогтоох зэрэг ял эдлүүлэх ажиллагааны өргөн боломжууд үүнд байгаа ажээ.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж буй ялтны хувьд Монгол Улсын Үндсэн хуульд заасан чөлөөтэй зорчин явах, амьдрах газраа чөлөөтэй сонгох эрхэд хязгаарлалт тогтоох байдлаар хэрэгжиж байна. Хэдийгээр гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн боловч хүний эрхийн тодорхой хэрэгжилтийг хангах хэрэгцээ шаардлага зайлшгүй үүснэ. Тухайлбал эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, хөдөлмөрлөх, шашин шүтэх зэрэг эрхийг ял эдэлж буй ялтны ялын дэглэм, нөхцөлтэй холбогдуулан эдлэх боломжоор хангах нь зүйтэй гэж судлаачийн зүгээс үзэж байгаа юм. Үүнд дараах зарим эрхийн хэрэгжилтийг хангахын чухлыг онцлог авч үзлээ.

- Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх

Шүүхийн практикт ихэвчлэн оршин суух хороо, дүүргээс гарч явахыг хориглох байдлаар ялын нөхцөлийг тодорхойлон зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж байгаа үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхэд нэлээдгүй хязгаарлалт бий болдог байна. Ял эдэлж буй зарим ялтнуудтай уулзаж ярилцлага хийхэд тухайн дүүргийн нутаг дэвсгэрт байрладаггүй эмнэлэгт үзүүлэх, эмчилгээ хийлгэх, шинжилгээ өгөх, хэвтэн эмчлүүлэх зэрэг нь хүндрэлтэй байдаг. Зөвхөн улсын эмнэлгийн хүрээгээр хязгаарлах, дүүргийн эмнэлэгт эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх боломжгүй тохиолдолд дараагийн шатлалын эмнэлэгт үзүүлэх боломж хязгаарлагдмал байгаа нь хүндрэлтэй байдаг ажээ.

³⁵ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2017 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн Дугаар А-234, А/103 хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам", 6 дахь хэсэг.



Дэлхийн улс орнуудын хувьд цахим хяналтын төхөөрөмжийг хэрэглээд багагүй хугацаа өнгөрсөн тул иргэдийн хувьд цахим хяналтын төхөөрөмж зүүсэн хүнийг гэмт хэрэгтэн, ялтан гэж хардаг тул нийгмийн харилцааны хувьд хүндрэл бэрхшээл үүсдэг байна. Манай улсын хувьд 2021 оноос хойш энэхүү ялыг шүүхийн практикт нэвтрүүлэн хэрэглээд 3 дахь жилдээ хэрэглэж байгаа тул иргэдийн хувьд төдийлөн энэ талаар мэдлэг, мэдээлэл байхгүй, төхөөрөмжийг ухаалаг цагнаас ялгадаггүй тул өнөөдрийн байдлаар нийгмийн зүгээс хяналтын төхөөрөмж зүүсэн хүнийг нийгмээс гадуурхан авч үзэх хандлага бага байгааг дурдах нь зүйтэй.

АНУ, ИБУИНВУ зэрэг цахим хяналтын төхөөрөмжийг шүүхийн өмнөх шатанд таслан сэргийлэх арга хэмжээ хэлбэрээр болон ял эдлүүлэх ажиллагаа, хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд хяналт тавих, цагаачилж буй хүмүүст хяналт тавих хэлбэрээр хэрэглэж буй орнуудын хувьд сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудлыг ихэд чухалчлан авч үздэг байна³⁶.

Европын орнуудад түүний дотор Нэгдсэн вант улсад цахим хяналтыг хэрэгжүүлж буй нөхцөл байдлыг сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, хүний эрхийн олон улсын баримт бичгүүд, түүний дотор Европын хүний эрхийн конвенцийн хүрээнд судлан авч үзсэн байна³⁷. Манай улсад энэ чиглэлээр хийсэн судалгаа, ялтны сэтгэл зүйн байдлыг судалсан судалгаа байхгүйгээс гадна эрүүл мэндийн талаарх хууль, тогтоомжуудад холбогдох зохицуулалт байхгүй байгаа юм.

Эрүүгийн хуульд зааснаар зорчих эрхийг хязгаарлах ялын хугацаа 1 сараас 5 жил хүртэл хугацаагаар тогтоосон нь дэлхийн нийтийн жишгээс хэт өндөр байна. Дэлхий нийтийн нийтлэг жишиг хандлага нь шүүхийн практикт 6 сараас 12 сар хүртэл хугацаагаар хэрэглэдэг. Хуульд зааснаар 24 сараас хэтэрдэггүй ажээ. Үүнийг хэд хэдэн шалтгаанаар тайлбарлах боломжтой. Төхөөрөмжийн баталгаат хугацаа 24 сараас төдийлөн их байдаггүй, хэт удаан хугацаагаар хяналтад байлгах нь ял эдэлж буй хүнийг сэтгэл зүйн хямралд, стресс, депрессийг бий болгодог тул анхаарч үзэх нь зүйтэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд ашиглаж буй гар болон хөлийн 4 төрлийн цахим бугуйвчны баталгаат хугацааны мэдээллийг ирүүлжээ. Үүнд DDX-04 загварын гарын цахим бугуйвч баталгаат хугацаа 1 жил, R12W загварын хувьд 2 жил, DDX-14 загварын хувьд 1 жил, МТХ-60 загварын хувьд 2 жил гэж тус тус тодорхойлсон³⁸

³⁶ Joint report by Bail for Immigration Detainees (BID), Medical Justice and the Public Law Project, *Ground-breaking new report examines the mental and physical effects of Global Positioning System (GPS) ankle tags on migrants*, 2022, <https://www.ein.org.uk/news/ground-breaking-new-report-examines-mental-and-physical-effects-global-positioning-system-gps>, (Сүүлд үзсэн: 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр).

³⁷ Sepand Malek et al., *Legal and human rights issues in the use of electronic monitoring (using GPS 'tracking' technology) in forensic mental health settings in the UK*, 2023, <https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC10725617/#bibr3-00258024231174820>, (Сүүлд үзсэн: 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр).

³⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын 2024.08.20-ны өдрийн 05/2040 дугаар албан бичгийн хавсралт.



байна. Гэтэл манай Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялыг 1 сараас 5 жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан нь хэт урт хугацаагаар хуульчилсан гэж үзэхээр байна. Энэ нь дээр дурдсан эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх асуудлаас гадна төхөөрөмжийн хэвийн ажиллах баталгаат хугацаанаас урт хугацаатай байгааг анхаарах нь зүйтэй. Харин шүүхийн практикт ихэвчлэн 24 сар хүртэл хугацаагаар хэрэглэж байна.

- Хөдөлмөрлөх эрх

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх хугацаанд хөдөлмөр эрхлэх нь хоёр шаардлагын хүрээнд чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа юм. Нэгдүгээрт ажил хөдөлмөр эрхлэх нь нийгэм, хөдөлмөрийн хамт олны дунд засарч хүмүүжих боломж олгох, нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх тухайд ялын зорилгыг биелүүлэх, хоёрдугаарт зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд төхөөрөмжийн ашиглалтын зардлыг ялтан өөрөө төлөх үүрэг хүлээдэг тул ажил хөдөлмөр эрхлэх, цалин орлоготой байх нь уг ялыг хэрэгжүүлэхээр тодорхойлогдоно.

Мөрдөн шалгах ажиллагааны үед гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг тогтоох ажиллагаа түүний дотор оршин суух газар болон хөдөлмөр эрхлэлтийн талаар хангалттай мэдээлэл, баримтууд авагдаагүйн улмаас шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахдаа хөдөлмөр эрхлэх боломжийн талаар тодорхой шийдвэрлэхэд төвөгтэй нөхцөл байдал үүсдэг. Эрүүгийн хуульд зааснаар шүүхээс тогтоосон чиглэлээр зорчин явахаар хязгаарлалт тогтоох боломжтой атал ийнхүү тогтоон шийдвэрлэх тохиолдол маш бага байна. Үүний улмаас оршин суух баг, сум, аймаг, дүүргээсээ гарч явахыг хориглосон тохиолдолд өөр газарт байрлах ажлын байр луугаа зорчин очиж хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагддаг. Мөн ажлын байр, байршил тогтмол бус тухайлбал барилга дээр ажиллаж буй тохиолдол байршил тогтмол өөрчлөгдөх нөхцөл байдлууд үүсдэг ажээ.

- Сурч боловсрох эрх

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны чухал зорилт нь дээр дурдсанчлан ялтныг хүмүүжүүлж, нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөв дадал зан үйлд төлөвшүүлэх болно. Монгол Улсын хэмжээнд зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэл оногдуулсан хүний тоон мэдээлэлтэй танилцахад 2021 онд 1049 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулснаас өсвөр насны хүн 21, 2022 онд 1761 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулснаас өсвөр насны хүн 44, 2023 онд 1814 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулснаас өсвөр насны хүн 77 тус тус байна³⁹.

Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнийг гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн⁴⁰ гэх ойлголтод хамааруулдаг. Иймээс гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх хугацаанд сурч боловсрох боломжийг олгох нь нэн чухал. Мөн үүнээс гадна мэргэжлийн боловсрол эзэмших, их, дээд сургууль, коллежид

³⁹ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн №03/1456 албан тоотын хавсралт.

⁴⁰ ЭХ-ийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.



суралцах, мэргэжил дээшлүүлэх зэргээр суралцах боломжийг олгоход анхаарч зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөлийг шүүхээс тодорхойлон тогтоох, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцад энэхүү эрхийн хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд хэд хэдэн тулгамдсан асуудал үүсэж байгааг дурдах нь зүйтэй. Тухайлбал төхөөрөмжийн цэнэг барих хугацаа, цэнэглэх боломж нөхцөл нь хэвийн суралцах нөхцөлийг хангахад бэрхшээл учруулдаг ажээ. Мөн үе тэнгийнхний зүгээс болоод сургуулийн орчинд зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн хүнийг гадуурхах, сөрөг хандлага бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ шаардлагатайг дурдах нь зүйтэй.

- Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүрэг

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн хүний хувьд үр хүүхдээ асран хүмүүжүүлэх үүргээс чөлөөлөгдөхгүй. Энэ тохиолдолд үр хүүхдээ сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгөх, эмнэлэгт үзүүлэх, эмчилгээ хийлгэх зэрэг амьдралын наад захын хэрэгцээ үүсдэг. Үр хүүхдээ эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахад эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувьд зайлшгүй эмнэлэгт хамт очих, сахиураар хамт байх шаардлага бий болно. Тиймээс мөрдөн байцаалтын шатанд яллагдагчийн хувийн байдлыг сайтар тогтоох, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхтэй холбоотойгоор зорчих чиглэл нэмж тогтоолгох хүсэлт гаргах боломжийг нарийвчлан хуульчлах боломжтой юм.

- Шашин шүтэх, эс шүтэх эрх, эвлэлдэн нэгдэх болон улс төрийн бусад эрх

Цахим хяналтын төхөөрөмжийг амжилттай хэрэглэж буй АНУ, Нэгдсэн вант улс зэрэг христийн шашинтай орнуудын хувьд 7 хоног бүрийн тогтмол өдөр шашны цуглаанд очих амьдралын хэв маяг бий. Харин ял эдлүүлэх ажиллагаанд энэхүү боломжийг ханган оролцуулдаг. Хүний шашин шүтэх, эс шүтэх эрх нь ямар ч тохиолдолд хязгаарлаж үл болох туйлын эрх болохын хувьд ял эдэлж буй ялтны хувьд энэхүү эрхээ эдлэх боломжоор хангах нь чухал. Шашин нь нэг талаас итгэл үнэмшилтэй байх эрхийн хэлбэр бол нөгөө талаас хүнийг зөв дадал зан үйлд сургах ач холбогдолтойг бас ял эдлүүлэх ажиллагаанд анхаарч үзэн боломжит байдлаар эрхийг нь эдлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

IV. ДҮГНЭЛТ

Зорчих эрхийг хязгаарлах ял нь 2015 оны Эрүүгийн хуульд хуульчлагдсан шинэ төрлийн ял болохын хувьд уламжлалт ялын төрлүүдтэй харьцуулахад энэхүү ялыг нэг мөр зөв ойлгон хэрэглэх асуудал шүүхийн практикт бүрэн хэвшиж тогтоогүй байна. Эрүүгийн хуулийн ерөнхий ангид зорчих эрхийг хязгаарлах ялыг хуульчилсан байдал хэт ерөнхий байгаа нь шинэ төрлийн ялын хувьд ерөнхий утга санааг илэрхийлж шүүхүүд өөр өөрөөр тайлбарлан хэрэглэх нөхцөл болжээ. Энэхүү ялын гол онцлог нь хорих, нийтэд тустай ажил хийлгэх, торгох зэрэг ялаас технологийн ололт, дэвшлийг ашиглан хэрэглэх боломж бүрдүүлснээр ялгагдана. Иймээс зорчих эрхийг хязгаарлах ялын технологийн шийдэл, боломжийг бүрэн судлан мэдэх хэрэгцээ шаардлага нэгэнт үүсжээ.



Шүүхийн шийдвэрүүдэд судалгаа хийж үзэхэд бүсчлэлийг хэт өргөн тогтоосноор ялын үр нөлөө, мөн чанар, зорилго алдагдаж байна. Орчин үеийн ялын онолд нийгэмшүүлэх чиг үүргийг онцолж байгаа хэдий ч гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө цээрлэл хүлээх тухай сонгодог онолын үзэл баримтлал зэрэгцэн оршсоор байгааг дурдах нь зүйтэй. Иймд ял шийтгүүлсэн хийгээд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зохицуулалт хоёр угтаа нэг мэт байж болохгүй. Харин зорчих эрхийг хязгаарлах ялын бүсчлэлийг хэт явцуу тогтоох нь ял шийтгүүлсэн хүнийг нийгмийн дунд хүмүүжих, нийгэмшүүлэх үүрэгтэй зөрчилдөж байхын зэрэгцээ хүний үндсэн эрхийг зөрчсөн зөрчлийг үүсгэж болзошгүй юм.

Манай улсын хувьд зөвхөн нийслэл хотод гэхэд 80 орчим хувийг нь гэр хороолол эзэлдэг. Төвлөрсөн дулаан, усан хангамж байхгүй зэргээс хамаарч түлээ түлшээ авах, хэрэглээний усаа зөөх зэрэг хэрэгцээ шаардлага үүсдэг. Сургууль цэцэрлэгийн хүрэлцээгүй байдлаас хамаарч оршин суугаа газраас хол зайд үр хүүхдээ сургууль, цэцэрлэгт хүргэх хэрэгцээ ч нэмэгдэнэ. Иймээс мөрдөн шалгах ажиллагааны үед яллагдагчийн хувийн байдлыг тогтоох, нотлох баримтыг бүрэн гүйцэд цуглуулах нь шүүхээс ял оногдуулахад хүний эрхийн зөрчил бий болгохгүй байх, ялын зорилгод нийцэх ач холбогдолтой.

Зорчих эрхийг хязгаарлах ялын хязгаарлалтын бүсчлэлийг зөв тогтоож чадаагүйн улмаас гарч болох сөрөг үр дагаврууд нь энэхүү ялын эерэг үр нөлөөг багасгах эрсдэлийг бий болгож байна. Энэ нь эргээд зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэглээнээс татгалзах сөрөг нөхцөл байдалд ч хүргэж болно. Дэлхий дээр цөөнгүй улс орнууд зорчих эрхийг хязгаарлах ялыг туршиж үзсэн боловч татгалзсан жишээ бий.

Цаг, минут, секундйн хурдтай хөгжиж буй технологийн дэвшлийн үр дүнд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаа илүү шинэ түвшинд хүрч программ хангамж болоод техникийн нөхцөл боломжууд нэмэгдсээр байна. Манай улсын хувьд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх технологийн боломжуудыг ч нэмэгдүүлсээр байгаа ажээ. Иймээс энэ төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд гарч буй дэвшилт, технологийн боломжуудын талаарх мэдээллээр шүүх, прокурор, мөрдөх албадыг байнга тогтмол хангаж ажиллах хэрэгцээ шаардлага зайлшгүй үүснэ.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Үндсэн хууль, 2002 он.
2. Эрүүгийн хууль, 2015 он.
3. Иргэний хууль, 2002 он.
4. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2017 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн Дугаар А-234, А/103 хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан



шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам".

5. Улсын дээд шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн дугаар 166 тогтоол.

Б. Ном, сурах бичиг

1. Д.Бадам, М.Мөнхбаатар, Л.Галбадар нар, *Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх арга зам*, 2020 он.
2. Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар*, 2022 он.
3. Петер Казиске, Орч Б.Буянхишиг, *Эрх зүйн онолын ерөнхий, тусгай зарчмууд, түүний хэрэглээ*, 2024 он.

В. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Ц.Цогт, С.Цэрэндолгор, "Монгол Улсын Шүүхийн тогтолцоон дахь Улсын Дээд Шүүхийн хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх чиг үүрэг: Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах нь", *Монголын төр, эрх зүй сэтгүүл* №1/103, 2023 он.
2. Д.Баярсайхан, *Орчин үеийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага, Шударга ёс сэтгүүл*, №3, 2010 он.

Г. Бусад

1. Шүүхийн ерөнхий зөвлөл, "2020–2024 оны хагас жилийн Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны дүн мэдээ".
2. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комисс, *Олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхэтгэл*, 2012 он.
3. "П.Соёл-Эрдэнэ: Хууль хэрэглээний нэгдмэл байдал нь хүн бүр хуулийн өмнө тэгш байх зарчимд нийцнэ", *itoim.mn*, 2024 он.
4. "Ц.Очгэрэл: Зорчих эрхийг хязгаарлах ял нь Монгол Улсын эрүүгийн ял шийтгэлийн бодлого дахь шинэтгэлийн нэг үндсэн чиглэл", *ubn.mn*, 2022 он.

2. Гадаад эх сурвалж:

1. Anthea Hucklesby, *Vehicles of desistance? The impact of electronically monitored curfew orders*, *Criminology and Criminal Justice*, 2008.
2. Dennis Doffing, *BLU+ RF Monitoring*, *The Journal of Offender Monitoring* 25 no. 2, 2014.
3. HM Government, *Electronic monitoring caseload*.
Jack Karsten and Darrell M. West, *Decades later, electronic monitoring of offenders is still prone to failure*, 2017.
James Kilgore, *Electronic Monitoring: A Survey of the Research for Decarceration Activists*,



- Joint report by Bail for Immigration Detainees (BID), Medical Justice and the Public Law Project, *Ground-breaking new report examines the mental and physical effects of Global Positioning System (GPS) ankle tags on migrants*, 2022.
- Kate Weisburd et al., *Electronic Prisons: The Operation of Ankle Monitoring in the Criminal Legal System*, *George Washington University Law School* №2021-41, 2021.
- Marc Renzema and Evan Mayo-Wilson, *Can electronic monitoring reduce crime for moderate to high-risk offenders?* *Journal of Experimental Criminology* №1, 2005.
4. Vera Institute of Justice, *Vera Institute of Justice Issues Report on the Growth of Electronic Monitoring in the United States*,
 5. Rory Geoghegan, *Future of Corrections: Exploring the Use of Electronic Monitoring*, London: Policy Exchange, 2011.
 6. Sepand Malek et al., *Legal and human rights issues in the use of electronic monitoring (using GPS 'tracking' technology) in forensic mental health settings in the UK*, 2023.
 7. The Pew Charitable Trusts, *Use of Electronic Offender-Tracking Devices Expands Sharply. Number of monitored individuals more than doubled in 10 year*.
 8. William Bales et al., *A Quantitative and Qualitative Assessment of Electronic Monitoring*, 2010.

3. Цахим эх сурвалж

1. <https://legalinfo.mn/mn>.
2. <http://www.shuukh.mn>
3. <https://www.mn-nhrc.org>
4. <https://ubn.mn>
5. <https://www.judcouncil.mn>
6. <https://admincourt2.gov.mn>,
7. <https://www.brookings.edu>
8. <https://www.realcostofprisons.org>
9. <https://www.ein.org.uk>
10. <https://www.vera.org>
11. <https://policyexchange.org.uk>
12. <https://www.ncbi.nlm.nih.gov>
13. <https://www.pewtrusts.org>
14. <https://www.ojp.gov>
15. <https://data.justice.gov.uk/>

**Abstract****THE PUNISHMENT OF RESTRICTION ON THE
RIGHT TO TRAVEL AND IT'S APPLICATION
CHALLENGES OF CRIMINAL LAW****GALBADAR, L.***Master of laws (LL.M)**Judge of the Circuit Criminal Court of First Instance of Bayanzurkh,
Sukhbaatar, and Chingeltei Districts***MUNKHBAATAR, M.***Master of laws (LL.M)**Judge of the Circuit Criminal Court of First Instance of Bayangol,
Khan-Uul, and Songinokhairkhan Districts*

The punishment of restriction of the right to travel is a new type of punishment that was not previously included in the criminal code of our country, which was legalized in the Criminal Code of 2015. The essence of this punishment is that it makes it possible to serve the sentence based on the achievements of modern technology. This distinguishes the punishment of restriction of the right to travel from other types of penalties. About 3 years have passed since it began to be used in court practice in 2021. This article analyzes the court practice of imposing a punishment of restriction of the right to travel in Mongolia. In doing so, it examines whether the courts' different interpretations of the Criminal Code when imposing a punishment of restriction of the right to travel comply with the requirements of unity of law. Unity of law is important in terms of understanding and applying the law correctly, strengthening people's trust in the courts, and ensuring human rights. Also, being able to predict court decisions based on legal grounds is important for making conclusions about crimes, preventing crimes from happening, and improving the legal status of the accused by requesting a simplified resolution of the case during the investigation.

Keywords: Electronic monitoring, travel restrictions, purpose of punishment, modern trends, concepts, and the uniformity of law application.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД ХЯНАЛТЫН ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАХ ШАЛГУУР: "ЭРХ ЗҮЙН ШИНЭ ОЙЛГОЛТ, ЭСХҮЛ ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭГ ТОГТООХОД ЗАРЧМЫН ХУВЬД НИЙТЛЭГ АЧ ХОЛБОГДОЛТОЙ" ГЭХ ОЙЛГОЛТЫН ТАЛААР

Б.ДӨЛГӨӨН¹

- Оршил
- Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.г хуульчлагдсан нь
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.4-т заасан үндэслэлээр хүлээн авсан маргаан
- Гадаадын зарим орны шүүхийн практик
- Дүгнэлт

¹ Хууль зүйн ухааны доктор /Ph.D./.



УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД ХЯНАЛТЫН ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАХ ШАЛГУУР: "ЭРХ ЗҮЙН ШИНЭ ОЙЛГОЛТ, ЭСХҮЛ ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭГ ТОГТООХОД ЗАРЧМЫН ХУВЬД НИЙТЛЭГ АЧ ХОЛБОГДОЛТОЙ" ГЭХ ОЙЛГОЛТЫН ТАЛААР

Б.ДӨЛГӨӨН *Хууль зүйн ухааны доктор /Ph.D./*

Түлхүүр үг

Эрх зүйн шинэ ойлголт, хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой, хууль хэрэглээний нэгдмэл байдал, улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргах

Хураангуй: Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 2023 оны 06 сарын 16-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр Улсын дээд шүүх нь "эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой" гэх үндэслэлээр хяналтын гомдлыг хүлээн авахаар болсон. ХЗБХ-ны 2021 оны 01 сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс харвал тус ойлголтыг тухайн хэргийг шийдвэрлэх нь ижил төстэй хэргүүдийг цаашид шийдвэрлэхэд ач холбогдолтой байхыг ойлгох тухай санал гарч байсан байна. Харин бусад улсын хувьд хууль тайлбарлахад чухал, нийтлэг, суурь ач холбогдолтой гэх ойлголтыг тухайн хэргийг шийдвэрлэх замаар эргэлзээ бүхий хуулийн заалтыг тайлбарласнаар, цаашид ижил төсөөтэй маргаан гарахад жишиг болох ач холбогдолтой байхыг олгоно хэмээн үзэж байна. Монгол Улсын шүүхийн практикаас үзвэл маргааныг шийдвэрлэх гол зангилаа болох хуулийн зохицуулалтыг нэг мөр болгон тодорхойлон, тайлбарласан байх бөгөөд энэ нь цаашид адил төсөөтэй маргааныг шийдвэрлэхэд ач холбогдол болох хууль хэрэглээг тогтоосон байна. Харин бусад улс болох Герман, Япон, АНУ болон Их Британийн хувьд "хууль тайлбарлахад чухал ач холбогдолтой, нийтлэг, суурь ач холбогдолтой" зэрэг үндэслэлээр хүлээн авсан гомдлыг шийдвэрлэсэн шийдвэрийн ихэнх нь хуулийн зохицуулалтыг тодорхойлж, тайлбарлах гэхээс илүүтэйгээр захиргааны эрх зүйн зарчмуудыг амилуулж, хэрэглэсэн шинжтэй байна. Мөн Монгол болон бусад улсын шүүхийн практикаас үзвэл тус үндэслэлээр хүлээн авч, хянан шийдвэрлэж буй хэргийн хувьд хамгаалж буй эрх, ашиг сонирхол болон урд өмнө гарсан жишиг байгаа эсэхээр харилцан адилгүй байна.



I. Оршил

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 2021 оны шинэчилсэн найруулгын 25 дугаар зүйлийн 25.7.5-д Улсын дээд шүүх ямар тохиолдолд хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэх талаар зохицуулсан. Тус хуульд 2023 оны 06 сарын 16-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр Улсын дээд шүүх нь "эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой" гэх үндэслэлээр хяналтын гомдлыг хүлээн авахаар тусгагдсан юм. Энэхүү зохицуулалт нь нэгдүгээрт "эрх зүйн шинэ ойлголт" , хоёрдугаарт "хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой" гэх хоёр агуулгыг багтаасан байна. Уг өгүүллээр:

- "эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой" гэх ойлголтын талаарх хууль тогтоогчийн үзэл баримтлалыг тогтоох;
- Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим "эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой" гэх үндэслэлээр хүлээн авч, хянан шийдвэрлэсэн маргаанд дүн шинжилгээ хийх;
- Гадаадын зарим орны шүүх "хууль тайлбарлахад чухал, нийтлэг, суурь ач холбогдолтой" гэх үндэслэлээр ямар төрлийн маргааныг хянан шийдвэрлэж буй талаар практикийг судлах замаар тус ойлголтыг хэрхэн тодорхойлох нь зохистой талаар судлаачийн байр суурийг илэрхийлэхийг зорилоо.

II. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5-г хуульчлагдсан нь

2.1. 2021 оны Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга

2021 оны Монгол Улсын Шүүхийн тухай хууль (цаашид "ШТХ" гэх)-ийн 25 дугаар зүйлд Улсын дээд шүүх (цаашид "УДШ" гэх) шүүн таслах ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гээд тус зүйлийн 25.7.5-д Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэх:

25.7.5.а.анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;

25.7.5.б.хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;

25.7.5.в.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэж хуульчилсан байжээ.

Өөрөөр хэлбэл 2021 оны ШТХ-д УДШ-д хяналтын гомдол гаргах шалгуурт "эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой" гэх үндэслэл багтаагүй байсан байна. Гэхдээ хуулийн



төслийн анхны хэлэлцүүлэг буюу Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн тэмдэглэлээс¹ үзвэл УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар, Ажлын дэд хэсгийн гишүүн УДШ-ийн шүүгч Ц.Цогт нарын зүгээс "хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холболтой" гэх шалгуурыг оруулах тухай санал гарч байсан байна. Тэмдэглэлээс тодруулбал:

Ц.Мөнх-Оргил: ... Хаана ч байна шүү дээ дээд шүүх ямар асуудлыг авч хэлэлцэх вэ гэдгээ өөрөө мэддэг эрх байгаа. Ямар ч улсын дээд шүүх хуулийн хэрэглээ зөрчигдсөн байна нэгдмэл хэрэглээ алдагдсан байна гэж үзвэл энийг нь бол авч хэлэлцэх хэрэггүй юм байна, шаардлагагүй юм байна гээд буцаачихдаг. Энийг бол авч хэлэлцэх хэрэгтэй юм байна гээд өөрөө мэддэг эрх нь үлдэх хэрэгтэй. ... 2 дугаарт тэнд бол дээд шүүхийн нөгөө дэг журмаар процессоороо яваад хуулийн хэрэглээний нэгдмэл байдалд үнэхээр ноцтой ач холбогдолтой юм байна гэдгээ тогтоосон байхад энийг асуудлыг хэлэлцээд явчихад бол ерөөсөө асуудал байхгүй. Тэгэхгүй бол юу үүсэх вэ гэхээр энэ 3 эхний бидний тавьсан 3 хязгаарт аль алинд нь ороогүй боловч магадгүй энэ хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой асуудлууд цаана нь үлдчихэж магадгүй байхгүй юу...

Б.Энхбаяр: ... Яагаад зарчмын ач холбогдолтой гэж үзвэл гэж ер нь яг юу гэсэн үг вэ? Энэ нэгдмэл байдлаар ойлгогдож тайлбарлагддаг үг мөн үү эсхүл улс төрийн үг үү. Энэ хуулийн лав их дээд сургуульд зарчмын ач холбогдолтой нь энэ, зарчмын ач холбогдолгүй нь энэ гэж заадаг юм би мэдэхгүй юм байна. Шүүхээр хэлэлцэгдэж байгаа бүх асуудал тэгвэл ач холбогдолтой л асуудал шүү дээ. Зарчмын. Шүүх одоо зарчмын ач холбогдолгүй асуудал хэлэлцдэг юм уу.

Ц.Цогт: Энэ улсын дээд шүүхийн хэрэг нэхэмжлэл хүлээж авах энэ шалгууртай холбоотой асуудал дээр гишүүд болгоомжтой хандаж байгааг бол бас ойлгож байна. Ялангуяа ажлын хэсгийн ахлагчийн хэлж байгаа тайлбараар нэг талаас. Нөгөө талаас энэ эрх зүйн соёл хэр тогтсон байгаа юм бэ гэдгээс энэ асуудал шалгагдах байх л даа. Тэрнээс бид нар өнөөдөр дээд шүүх хэрэгтэй хэргээ сонгож аваад ач холбогдолтой хэргээ шийдэх гээд байна тийм агуулгаар ийм заалт орж ирэх гэж байна гэж үзэхгүй байна. Ер нь бол. Энэ яг томьёоллын хувьд бол хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад зарчмын ач холбогдолтой гэж ийм томьёолол байгаа л даа. Тэгэхээр яа вэ энэ бол тухайн хэргийг шийдвэрлэснээр тэр хуулийг ижил төстэй өрсөлдөөнт хэм хэмжээнүүдээс ялгаж салгаж шийдвэрлэх ижил төстэй хэргүүд энэ дээд шүүхийн тайлбарлаж хэрэглэсний дагуу цаашдаа хэрэглэж шийдэх ийм ач холбогдлыг л үүсгэх болохуйц тийм одоо хэрэг маргааныг шийдвэрлэх боломжтой байхаар ингэж томьёолж өгвөл уг нь бас боломжтой юм байгаа юм. Гэхдээ хууль тогтоогчдын өөрсдийнх нь шийдэх асуудал байх энэ бол.

О.Мөнхсайхан: ...Манайд бол дээд шүүх бол фактын асуудал руу эсхүл хууль хэрэглээний тийм ноцтой биш юм руу орох хуулийн процессын зохицуулалт байхгүй. Уг нь хэрэглээний л тэр ноцтой асуудал дээр төвлөрнө гэж байгаа. Гэтэл манай дээд шүүх бол хэдийгээр нийт тэр хэрэг маргааны 2, 3 хувийг шийддэг гэж

¹ Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 01 сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, <https://www.parliament.mn/nn/13622/>, (Сүүлд үзсэн: 2025.02.15) .



байгаа боловч хүссэн юмаа зарчмын ач холбогдолтой гээд орчихдог нь энэний цаана бол янз бүрийн үзэмж дур зорог яваад байна уу гэдэг үндэслэл бүхий хардлагыг үүсгээд байгаа юм. Тэгэхээр энэ нөхцөлд таарсан байдлаар ажлын хэсгээс 25.6.5 гэсэн энэ зүйл дээр 3 маш тодорхой үндэслэлийг оруулж ирж байгааг бол би судлаачийн хувьд одоогийн эрх зүйн соёлд нийцсэн тодорхой заалт байна гэж харж байгаа. Шүүгчдийн маань хэлж байгаа энэ зүйлүүд бас энэ 6.5.1, 6.5.2-т байж байгаа хүрээнд шийдэгдэх бүрэн боломжтой. ... Үнэхээр зөрүүтэй юмыг л хэрэглээний хувьд нэгдмэл болгох үндэслэл байна. Энэнээс гадуур зарчмын ач холбогдолтой юм гэхээр юу байх вэ гэдэг юм байгаа юм....

Дээрхээс үзвэл хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход зарчмын ач холбогдолтой зүйл мөн байна гэж үзвэл УДШ хүлээн авч шийдвэрлэх тухай санал гарсан боловч "хууль хэрэглээний зөрүүг арилгах" гэсэн үндэслэлийн хүрээнд уг асуудлыг шийдвэрлэх боломжтой, эс бөгөөс УДШ дур зоргоороо хэргийг хүлээн авна гэх эсрэг саналуудыг Ажлын хэсгийн ахлагч Б.Энхбаяр, мөн дэд хэсгийн гишүүн О.Мөнхсайхан нар хэлж, дэмжигдээгүй байна. Ийнхүү ШТХ-ийн 2021 оны шинэчилсэн найруулгаар УДШ нь 3 үндэслэлээр буюу анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах; хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн; хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэх үндэслэлээр хяналтын гомдлыг хянан шийдвэрлэх болсон байна.

2.2. Хяналтын журмаар гомдол гаргах шалгуурыг өргөжүүлсэн нь

ШТХ батлагдсаны дараа УДШ-д хяналтын журмаар гаргах гомдол нь 3 агуулгаар хязгаарлагдаж байгааг өргөжүүлэх шаардлагатай талаар хуульч, судлаач нар байр сууриа илэрхийлж байсан. Тухайлбал: хууль зүйн доктор Ц.Цогт болон судлаач С.Цэрэндолгор нар ШТХ-д заасан хяналтын гомдлын үндэслэлийг нарийвчлан тайлбарлах замаар илүү боловсронгуй болгох боломжтой гэж дурдсан бөгөөд тус саналд "хууль, эрх зүйн шинэ ойлголтын хэрэглээ тогтоох"² тухай дурдсан байна. Ийнхүү боломжийг нээлттэй болгох нь Үндсэн хуулиар баталгаажуулсан шүүхэд мэдүүлэх эрх болон Шүүхийн тогтолцоонд дээд шүүхийн хуулийн нэгдмэл хэрэглээг тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой³ хэмээн дүгнэсэн байна.

Мөн бусад судлаач, хуульчдын зүгээс УДШ-ийн хүлээн авах хяналтын гомдлын үндэслэлийг хэт хязгаарласан гэх шүүмжлэлүүд гарч байсан бөгөөд нэр бүхий иргэд ийнхүү хязгаарлан хуульчилсан нь Үндсэн хууль зөрчиж байна гэх агуулга бүхий мэдээллийг Үндсэн хуулийн цэцэд (цаашид "ҮХЦ" гэх) гаргасан⁴.

² Ц.Цогт, С.Цэрэндолгор, "Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоон дахь улсын дээд шүүхийн хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх очиг үүрэг: хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах нь", Монголын төр, эрх зүй, 2023, №1(103), 46 дахь тал.

³ Мөн тэнд.

⁴ Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а, 25.7.5.б дэд заалт; Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.3 дахь заалт; Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.3 дахь заалт, мөн хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг; Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1, 172.2.2, 172.2.3 дахь заалт, 173 дугаар зүйлийн 173.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн



А. Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 сарын 03-ны өдрийн 02 дугаар дүгнэлт

ҮХЦ нь 2023 оны 02 дугаар дүгнэлтээр⁵ "...Улсын дээд шүүхээс доод шатны шүүхийн шийдвэрийг "анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн", "хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн" тохиолдолд хянан шийдвэрлэхээр хуульчилсан нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгыг бүрэн хангаагүй, хэргийн оролцогчдын хяналтын шатны шүүхэд хандах боломжийг хязгаарласан байна. Тодруулбал, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг алдагдуулсан бусад тохиолдлуудыг Улсын дээд шүүх хянах боломжгүй болгон явцууруулж хуульчилсан нь Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг хөндсөн байна. Иймд Монгол Улсын Шүүхийн тухай хууль болон эрүү, иргэн, захиргааны процессын хууль хоорондын уялдааг хангах хүрээнд шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хязгаарласан эрх зүйн хийдлийг арилгах шаардлагатай байна." гээд, ШТХ болон процессын хуулиуд дахь маргаан бүхий заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн "... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ..." гэж заасанд нийцээгүй байна гэж үзсэнээр, ШТХ-ийн 25.7.5.а "анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах"; 25.7.5.б "хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн" гэх заалтууд болон процесс хуулиудын холбогдох заалтуудыг түдгэлзүүлсэн байна.

Цэцийн тус шийдвэр гарснаар ШТХ дахь УДШ-ийн хяналтын журмаар хянан шийдвэрлэх маргаанд тавигдах шалгууртай холбоотой зохицуулалтыг хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтоох зорилгыг бүрэн хангахуйц байдлаар өөрчлөн найруулах шаардлагатай болсон юм.

Б. Шүүхийн тухай хуульд 2023 оны 06 сарын 16-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлт

Ингээд 2023 оны 06 сарын 16-ны өдөр ШТХ-д нэмэлт, өөрчлөлт орж хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэх болсон:

- шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах (25.7.5.а)
- хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн (25.7.5.б)
- хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн (25.7.5.в)
- эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой (25.7.5.г).

14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн гэх агуулга бүхий мэдээлэл гаргасан байна.

⁵ Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 сарын 03-ны өдрийн 02 дугаар дүгнэлт, <https://legaldata.mn/tsets/shiidver/view/9444a1fe8798>, (Сүүлд үзсэн: 2025.02.15).



Дээрх нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцсэн Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 06 сарын 13-ны тэмдэглэлээс⁶ үзэхэд ажлын хэсгийн гишүүд дараах байр суурийг илэрхийлж байжээ.

Ц.Цогт: ... Өнгөрсөн Шүүхийн тухай хууль хүчин төгөлдөр болж, мөрдөж эхэлсэн 2 жилийн хугацааны статистик тоон мэдээг авч үзэх юм бол Монгол Улсын Дээд шүүх хяналтын шатны журмаар нийтдээ гомдол гарсан хэргийн 15 орчим хувийг хүлээн авч, хянан шийдвэрлэдэг болсон байгаа. Үндсэн хуулийн цэцээс гомдол ялгаж шийдвэрлэдэг журмыг бол үндсэндээ Үндсэн хууль зөрчөөгүй байна гэж үзсэн. Харин явцуу байна. 2 заалт нь явцуу байгаа учраас энийг өргөтгөж шүүхэд хяналтын шатны шүүхэд гомдол гаргах тэр боломжийг өргөтгөх ёстой гэсэн шийдвэр гарсан байгаа. Үүний дагуу нэгэнт цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээж авсан учраас Шүүхийн тухай хуулийн 25.8-д зааснаар Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос Улсын дээд шүүхэд хандаж, энэ заалт, хэсгийг боловсронгуй болгох саналаа ирүүл гэсэн. Үүний дагуу бид санал хүргүүлсэн байгаа.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа яах, "г"-г нэмээд 25.7.5-г-г нэмээд өөрөөр хэлбэл эрх зүйн шинэ ойлголт эсвэл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэснээр арай өргөтгөж байна тийм үү. Тэрийг бол ойлгож байгаа юм.

Ийнхүү ҮХЦ-ийн 02 дугаар дүгнэлтийн дагуу ШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.7.5-д нэмэлт, өөрчлөлтийг оруулснаар Дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгын дагуу хүлээж авах маргааны агуулга өргөжсөн юм. "Эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой" гэдгийг хэрхэн ойлгох талаар тодорхой саналууд 06 сарын 13-ны өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдаан дээр гараагүй байна. Харин 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс үзвэл "эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой" гэдэг нь тухайн хэргийг шийдвэрлэх нь ижил төстэй хэргүүдийг цаашид шийдвэрлэхэд ач холбогдолтой байхыг ойлгох тухай санал гарч байсан байна.

III. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.4-т заасан үндэслэлээр хүлээн авсан маргаан

ШТХ-д 2023 оны 06 сарын 16-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн дараа зөвхөн "эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой" гэх үндэслэлээр УДШ-ийн захиргааны хэргийн танхим нийт 5 тогтоолыг хүлээн авч, хянан шийдвэрлэсэн байна⁷.

⁶ Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, <https://www.parliament.mn/nn/30664/>.

⁷ Хууль зүйн бүтээлийн нэгдсэн сан болох legaldata.mn-ийн "Шүүхийн шийдвэрийн сан" болон Улсын дээд шүүхийн цахим хуудас болох <https://www.supremecourt.mn/mn/>-ий шүүхийн шийдвэрийн тойм хэсэгт хайлт хийсэн болно. Анхан шатны шүүх рүү буцаасан, түдгэлзүүлсэн хэргүүдийг оруулаагүй болно.



Хүснэгт 1. ЗХШХШТХ-ийн 123.2.4-т заасан үндэслэлээр хүлээн авсан маргаан

Шийдвэрийн дугаар	Маргаан бүхий хуулийн заалт	Хуулийн зохицуулалтын тайлбар	Маргаан бүхий акт	Шийдэл	Өмнөх жишиг байгаа эсэх
УДШ-ийн 2024.02.19-ны өдрийн 001/ХТ2024/0022 дугаар тогтоол	- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 - Зөрчлийн тухай хуулийн 11.30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1	Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг тогтоож, нийтэд хандан илэрхийлж, сурталчилдаг худалдагч, үйлчлэгч талд хамааралтай зохицуулалт	4.000.000 төгрөгийн шийтгэл оногдуулах тухай	Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн	УДШ-ийн 2020.05.06-ны өдрийн 156 дугаар тогтоол, УДШ-ийн 2023.12.11-ний өдрийн 001/ХТ2023/0099 тогтоол"
УДШ-ийн 2024.09.23-ны 001/ХТ2024/0085 дугаар тогтоол	- Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12.3 - Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 7.3	Татварын хяналт шалгалтад шаардлагатай санхүүгийн болон бусад баримтыг шаардсаны дагуу цахим болон цаасан хэлбэрээр татварын албанд гарган өгөх үүргийг татварын албаны санаачилгаар явагдаж байгаа хяналт шалгалтын үед татвар төлөгчөөс шаардахаас бус эрхийнхээ хүрээнд гаргасан хүсэлтэд үндэслэсэн хяналт шалгалтын үед шаардахгүй	4.000.000 төгрөгөөр торгох тухай	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон	
УДШ-ийн 2024.10.07-ны өдрийн 001/ХТ2024/0089 дугаар тогтоол	- Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 - Зөрчлийн тухай хуулийн 11.12 дугаар зүйлийн 8	Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 29.2 дахь "нэмэлт мэдээлэл" гэдэгт банкнаас шаардаж буй SCV мэдээлэл нэмэлт мэдээлэлд хамаарахгүй	20 сая төгрөгийн торгууль оногдуулах тухай	Шийдвэр, магадлалын баримталсан хуулийн заалтыг өөрчлөн, бусад хэсгийг хэвээр үлдээсэн	



УДШ-ийн 2024.11.11-ний 001/ХТ2024/0109 дугаар тогтоол	- Иргэний үнэмлэхийн дүрмийн 2.7.1 - Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 4	Иргэний үнэмлэхээ цэвэр, гамтай эзэмшээгүй, хадгалаагүй эсхүл хаяж үрэгдүүлсэн нь нийтийн эрх зүйн хүрээний зөрчилд тооцогдохгүй	30.000 төгрөгийн торгууль оногдуулах тухай	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон	
Дампуурлын хэрэг гүйцэтгэгч А.Э-н нэхэмжлэлтэй, Улсын бүртгэлийн ерөнхий газарт холбогдох хэрэг	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд шүүхийн шийдвэрээр дампуурсан хуулийн этгээдийг бүртгэлээс хасах талаар тусгайлан зохицуулаагүй тул хуулийн 24 дүгээр зүйлд заасан нийтлэг зохицуулалтыг хэрэглэнэ.		татвар төлөх үүргийг нь дуусгавар болгож хасуулсан хуульд заасан баримт бичгийг бүрдүүлэх тухай	Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, хууль хэрэглээний хувьд өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн	-

Кэйс №1. УДШ-ийн 2024.02.19-ний өдрийн 001/ХТ2024/0022 дугаар тогтоол⁸

Хэргийн тухай товч: Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохион байгуулалтын газрын хянан шалгагч нь Т.Ө, "Пл" ХХК-ийн харилцан тохиролцож байгуулсан "Үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээгээр гэрээний дүнг ам.доллороор илэрхийлж гүйцэтгэсэн" нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасныг зөрчсөн гэж үзэж, Зөрчлийн тухай хуулийн 11.30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад заасныг баримтлан "П л" ХХК (худалдан авагч тал)-ийг 40,000,000 төгрөгөөр, иргэн Т.Ө (худалдагч тал)-ыг 4,000,000 төгрөгөөр торгох шийтгэлийг тус тус оногдуулсан байна. Худалдагч тал шүүхэд гомдол гаргасан (худалдан авагч тал болох П л ХХК-ний хувьд шүүхэд гомдол гаргаж, шүүхээс шийтгэлийн хуудсыг хүчингүй болгосон).

УДШ-ийн тогтоол, үндэслэл: ... Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн зохицуулалтын дагуу тодорхойлохоор байх ба уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно" гэжээ⁹. ... Дээрхээс дүгнэхэд, хууль тогтоогч үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг эрсдэлээс хамгаалах зорилгоор аливаа бараа, үйлчилгээний үнийг гадаад валют, тооцооны нэгжээр тогтоож, илэрхийлэх,

⁸ УДШ-ийн 2024.02.19-ний өдрийн 001/ХТ2024/0022 дугаар тогтоол, шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://legaldata.mn/shiidver/zahirгаа/view/2888?whr=s>, (Сүүлд үзсэн: 2025.02.25).

⁹ УДШ-ийн 2024.02.19-ний өдрийн 001/ХТ2024/0022 дугаар тогтоолын 11.1 дэх цогцолбор.



сурталчлах, төлбөр тооцоо гүйцэтгэхийг хориглосон агуулгыг хуульд тусгасан бөгөөд энэ нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг авдаг хэрэглэгч гэхээсээ бараа, үйлчилгээний үнийг тогтоож, нийтэд хандан илэрхийлж, сурталчилдаг худалдагч, үйлчлэгч талд хамааралтай, эсрэгээр ханшийн эрсдэлийг эцсийн хэрэглэгч болох худалдан авагч, хэрэглэгч талд үүрүүлэхээс сэргийлэх зорилгоор батлагджээ¹⁰. ... Энэ үүднээс байрны үнийг ам.доллороор тогтоосон, илэрхийлсэн, улмаар гүйцэтгүүлсэн борлуулагч талд хариуцлага тооцсон шийтгэлийн хуудас хуульд нийцсэн, ... Зөрчлийн тухай хууль энэхүү харилцаанд нарийвчилсан хууль байх тул Иргэний хуульд заасан (хувийн эрх зүйд хамаарах) "үүрэг гүйцэтгэх" тухай ойлголтын агуулгаар (нийтийн эрх зүйд хамаарах) хуулийг тайлбарлах боломжгүй юм. Анхан шатны шүүхээс тухайн тохиолдолд илүү нарийвчилсан зохицуулалт болох Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг хэрэглэх ... хэмээн хууль хэрэглээний талаар зөв дүгнэжээ¹¹.

Дээрх маргааны хувьд Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдэж буй бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээ хамаарах бөгөөд аливаа бараа, бүтээгдэхүүнийг борлуулагч, үйлчлэгч талд хамааралтай зохицуулалт болохыг тайлбарласан байна. Энэхүү шийдвэр хүчин төгөлдөр болсноор гомдол гаргагч 4 сая төгрөг төлөх эрх зүйн үр дагавар үүсэх юм. Гэхдээ тус маргаантай ижил, төсөөтэй маргааныг өмнө нь УДШ-ээс шийдвэрлэж байсан. Тухайлбал: УДШ-ийн 2020.05.06-ны өдрийн 156 дугаар тогтоолоор "А" ХК нь гадаад валютаар бондын үнийг тогтоож, түүнийгээ сурталчилж, нэр бүхий иргэдэд худалдсан зөрчил гаргасандаа буруутгагдаж, хариуцлага хүлээж байгаа, харин тухайн бүтээгдэхүүнийг нь худалдан авсан иргэдийг шийтгэх нь Зөрчлийн тухай хуулийн зорилгод нийцэхгүй" гэж¹², УДШ-ийн 2023.12.11-ний өдрийн 99 дүгээр тогтоолоор "Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр нийтэд чиглэн нийтлэг үйл ажиллагаа явуулж буй этгээдийг гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоож, түүнийгээ нийтэд илэрхийлж, Төлбөр тооцоо гүйцэтгэх, түүнийг зарлан сурталчлахыг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулиар хориглосон бөгөөд энэ нь нийтийн эрх зүйн хүрээнд үүсэх харилцаа юм. Энэ тохиолдолд, гомдол гаргагч компани нь худалдан авагчийн хувьд иргэнтэй Үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний үнийг "доллар болон Төлбөр"-өөр гүйцэтгэх нөхцөлөөр харилцан зөвшөөрч байгуулсан, гэрээний үүргийн дагуу Төлбөрөө гадаад

¹⁰ Мөн тэнд, 11.4 дэх цогцолбор.

¹¹ Тус шийдвэрт УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа тусгай санал бичсэн бөгөөд "... Аж ахуй эрхлэгч биш этгээдүүдийн хооронд аж ахуйн зорилгоор бус хувийн зорилгоор нэг удаагийн шинжтэй хэлцэл, гэрээний харилцаанд оролцогч талууд төлбөр тооцоог сайн дурын үндсэн дээр харилцан тохиролцсоны дагуу гүйцэтгэх боломжтой, энэ тохиолдолд иргэний эрх зүй дэх "хуулиар хориглосноос бусад зөвшөөрөгдөх", "гэрээний чөлөөт байдал"-ын зарчим үйлчлэх учиртай". хэмээн зөрчлийн тухай хуулиар зөрчилд тооцогдох үйлдлийн шинжийг хуулийн зорилготой уялдуулан тайлбарлаж, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хуулийн тус заалт хамаарахгүй гэжээ.

¹² УДШ-ийн 2020.05.06-ны өдрийн 156 дугаар тогтоол, шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://legaldata.mn/shiidver/zahirgaa/view/2264?whr=s>, (Сүүлд үзсэн: 2025.02.18).



валютаар төлсөн үйлдлийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтэд хандаж барааны үнийг гадаад валютаар тогтоосон, илэрхийлсэн, сурталчилсны улмаар Төлбөр гүйцэтгэсэн гэх Зөрчлийн (нийтийн) эрх зүйд хамаарах хориглосон үйл ажиллагааг явуулсан гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна". гэж¹³ шийдвэрлэсэн байна. Ийнхүү урд өмнө шийдвэрлэсэн байдлыг харгалзан үзэж анхан болон давж заалдах шатны шүүхээс шийдвэр, магадлалыг гаргасан бөгөөд УДШ-ээс шийдвэр, магадлалыг хэвээр үлдээжээ.

Кэйс №2. УДШ-ийн 2024.09.23-ны өдрийн 001/ХТ2024/0085 дугаар тогтоол¹⁴

Хэргийн тухай товч: "Р Н" ХХК-аас "нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтийг буцаан авах тухай" хүсэлт гаргасан. Татварын улсын байцаагч нарын хяналт шалгалтын дүнд ногдуулсан нөхөн татвар болон төсвөөс буцаан авах нэмэгдсэн өртгийн албан татварын үлдэгдэл дээр маргаж, дээд шатны татварын алба шинээр хянан шалгалт явуулах болсон. Хяналт шалгалтын ажиллагааг шинээр явуулахдаа татвар төлөгчөөс баримт шаардахад "Р Н" ХХК "2007-2018 онд хэрэгжүүлсэн төсөвтэй холбоотой ерөнхий болон туслах гүйцэтгэгчийн гэрээ, бүтээгдэхүүн, бараа материал худалдан авах, захиалга"-ын зэрэг баримтуудад "урьд маргаан таслах зөвлөлийн тогтоол, болон шүүхийн шийдвэрээр эцэслэн дүгнэлт өгсөн, 2012-2016 оны баримтуудыг дахин шаардаж байгаа нь хууль бус" гэх агуулгаар гаргаж өгөхөөс татгалзсан. Улмаар татварын улсын байцаагч нар Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12.3-т заасан буюу "татварын хяналт шалгалтад шаардлагатай санхүүгийн болон бусад баримтыг шаардсаны дагуу цахим болон цаасан хэлбэрээр татварын албанд гарган өгч, татварын хяналт шалгалтад хамрагдах" үүргээ зөрчсөн гэж үзэн Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 7.3-д "татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй" гэх үндэслэлээр шийтгэл оногдуулжээ.

УДШ-ийн тогтоол, үндэслэл: Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4¹⁵-д зааснаар татварын хяналт шалгалтыг татварын алба эрсдэлд үндэслэн өөрийн, эсхүл хүсэлтээр буюу татвар төлөгчийн санаачилгаар хэрэгжүүлэхээр байна¹⁶. Татварын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д татвар төлөгч "илүү төлсөн татварыг буцаан авах, суутган тооцуулах, алданги тооцон нэхэмжлэн авах" эрхтэй байхаар хуульчилсан бөгөөд "Р Н" ХХК тухайн эрхийн хүрээнд

¹³ УДШ-ийн 2023.12.11-ний өдрийн 99 дүгээр тогтоол, шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://legaldata.mn/shiidver/zahirгаа/view/2868?whr=s>, (Сүүлд үзсэн: 2025.02.18).

¹⁴ УДШ-ийн 2024.09.23-ны 001/ХТ2024/0085 дугаар тогтоол, шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://legaldata.mn/shiidver/zahirгаа/view/2943?whr=s>, (Сүүлд үзсэн: 2025.02.18).

¹⁵ Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4 "Татварын алба эрсдэлд, эсхүл татвар төлөгчийн хүсэлтэд үндэслэн татвар төлөгчийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг хянан шалгана".

¹⁶ УДШ-ийн 2024.09.23-ны 001/ХТ2024/0085 дугаар тогтоолын 16 дахь цогцолбор.



"нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтийг буцаан авах тухай" хүсэлтээ гаргажээ¹⁷. Татвар төлөгчийн нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтийг буцаан авах хүсэлтэд үндэслэн тухайн татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийх тохиолдолд татварын улсын байцаагч холбогдох баримтыг шаардаж болох боловч шаардсан баримтыг гаргаж өгөөгүй нь татвар төлөгчийг татварын хууль тогтоомжийг зөрчсөн буюу Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12.3-т заасан үүргээ биелүүлээгүй гэх үндэслэл болохгүй. Өөрөөр хэлбэл, татварын хяналт шалгалтад шаардлагатай санхүүгийн болон бусад баримтыг шаардсаны дагуу цахим болон цаасан хэлбэрээр татварын албанд гарган өгөх үүргийг татварын албаны санаачилгаар явагдаж байгаа хяналт шалгалтын үед татвар төлөгчөөс шаардахаас бус эрхийнхээ хүрээнд гаргасан хүсэлтэд үндэслэсэн хяналт шалгалтын үед шаардахгүй¹⁸.

Энэхүү маргааныг шийдвэрлэх замаар УДШ нь Татварын ерөнхий хуулийн 41.12.3-т заасан "татварын хяналт шалгалтад шаардлагатай санхүүгийн болон бусад баримтыг шаардсаны дагуу цахим болон цаасан хэлбэрээр татварын албанд гарган өгч, татварын хяналт шалгалтад хамрагдах" гэх зохицуулалтыг тайлбарласан байна. Тодруулбал, татварын хяналт, шалгалтад шаардлагатай баримтыг татварын албанд гаргаж өгөх үүрэг нь татварын албаны санаачилгаар явагдаж байгаа хяналт, шалгалтын үед хамааралтай, татвар төлөгч эрхийнхээ хүрээнд гаргасан хүсэлтэд үндэслэсэн хяналт шалгалтын үед шаардахгүй гэж тус зохицуулалтыг нэг мөр болгож, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон. Ийнхүү шийдвэрлэснээр "Р Н" ХХК нь татварын байцаагчийн ногдуулсан 4 сая төгрөгийг төлөх үр дагавар үүсэхгүй бөгөөд нөгөөтээгүүр дээд шүүхээс тус заалтыг тайлбарлаж, хэргийг шийдсэнээр татвар төлөгчийн "илүү төлсөн татварыг буцаан авах, суутган тооцуулах, алданги тооцон нэхэмжлэн авах эрх" (ТЕХ-ийн 12.1.4) -ийг хамгаалсан байна. Урд өмнө Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12.3-ыг хэрэглэж, тайлбарласан маргаан гарч байгаагүй байна.

Кэйс №3. УДШ-ийн 2024.10.07-ны өдрийн 001/ХТ2024/0089 дугаар тогтоол¹⁹

Хэргийн тухай товч: Хадгаламжийн даатгалын корпорацийн хянан шалгагч, улсын байцаагч нь "Х х банк" ХК-ийг SCV загварын дагуу мэдээллийг 6 удаа ирүүлээгүй, 2023 оны 4 дүгээр сард 1 удаа ирүүлсэн мэдээлэл нь алдаатай болох нь холбогдогчийн хууль ёсны төлөөлөгч, гэрчийн мэдүүлгээр нотлогдсон, мэдээллийг ирүүлээгүй нь Банкин дахь

¹⁷ Мөн тэнд, 17 дахь цогцолбор.

¹⁸ Мөн тэнд, 18 дахь цогцолбор.

¹⁹ УДШ-ийн 2024.10.07-ны өдрийн 001/ХТ2024/0089 дугаар тогтоол, шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://legaldata.mn/shiidver/zahirgaa/view/2954?whr=s>, (Сүүлд үзсэн: 2025.02.17)



мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасныг зөрчсөн гэж үзэж, Зөрчлийн тухай хуулийн 11.12 дугаар зүйлийн 8-д зааснаар 20,000,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан.

УДШ-ийн тогтоол, үндэслэл: Харин хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасан нэмэлт мэдээллийг Корпорацийн хүсэлтээр тухай бүр өгөх ба тухайн нэмэлт мэдээлэл нь тогтоосон загвар, аргачлалтай байж болох бөгөөд түүнийг заавал тусад нь батлуулах шаардлагагүй (Журмын 2.2, 3.5-ын агуулгыг тайлбарлавал), энэ талаарх хариуцагчийн тайлбар үндэслэлтэй²⁰. Гэтэл хариуцагчийн шаардаж буй "Нэг харилцагчийн зарчим буюу Single customer view (SCV)-ын загвар"-ын дагуу өгөх мэдээлэлд хадгаламж эзэмшигчийн гэрийн хаяг, эцэг, эхийн нэр, ургийн овог, хүйс, төрсөн он, сар, өдөр, регистрийн дугаар, иргэншил, бизнесийн нэр, утасны төрөл, хадгаламжийн дэлгэрэнгүй нэр (хүүхдийн хадгаламж, орон сууцны хадгаламж 36 сар гэх мэт), зээлийн бүтээгдэхүүний дэлгэрэнгүй нэр (цалингийн зээл, тэтгэврийн зээл, мортэйж, зээлийн карт гэх мэт) зэрэг нийт 12 төрлийн багц, 144 хүснэгт бүхий харилцагч, хадгаламж эзэмшигчийн дэлгэрэнгүй мэдээлэл нь Хадгаламжийн даатгалын корпорацийн тухай хуульд заасан ямар чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай болохыг хариуцагч нотолж чадаагүй байна²¹. Түүнчлэн, "нэмэлт мэдээлэл" гэдэг нь үндсэн мэдээллээ нөхөх зорилготой, цар хүрээний хувьд үндсэн мэдээллийнхээ агуулгад хамаарах, хэмжээний хувьд бага, ихэнхдээ нэг удаагийн шинжтэй байх агуулгыг илэрхийлэх атал дээр дурдсан өргөн цар хүрээтэй дэлгэрэнгүй мэдээлэл нь ямар үндсэн мэдээллийг яаж нөхөж байгаа нь тодорхойгүй, энэ утгаараа нэмэлт мэдээлэлд хамаарахгүй талаарх анхан шатны шүүхийн дүгнэлт үндэслэлтэй²².

Энэхүү шийдвэрээр Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 29.2 дахь "нэмэлт мэдээлэл" гэдэгт банкнаас шаардаж буй SCV мэдээлэл хамаарах эсэхийг тайлбарласан бөгөөд шүүхээс тус мэдээлэл нь нэмэлт мэдээлэлд хамаарахгүй гэж үзэж "Х х банк" ХК-д ногдуулсан торгууль буюу 20 сая төгрөгийн торгуулийн хуудсыг хүчингүй болгосон байна. Ийнхүү шийдвэрлэж, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалын баримталсан хуулийн заалтыг өөрчлөн, бусад хэсгийг хэвэр үлдээсэн. Урд өмнө адил төсөөтэй маргаан гарч байгаагүй байна.

²⁰ Мөн тэнд, 18 дахь цогцолбор.

²¹ Мөн тэнд, 20 дахь цогцолбор.

²² Мөн тэнд, 21 дэх цогцолбор.

**Кэйс №4. УДШ-ийн 2024.11.11-ны өдрийн 001/ХТ2024/0109 дүгээр тогтоол²³**

Хэргийн тухай товч: Иргэн П.Х нь "иргэний үнэмлэхээ үрэгдүүлсэн" гэх үндэслэлээр иргэний үнэмлэх дахин авах хүсэлт гаргасан байх бөгөөд улсын бүртгэлийн байгууллагаас "Иргэний үнэмлэхийн дүрмийн 2.7.1-д заасан улсын бүртгэлийн тогтоосон журам зөрчсөн" гэж үзэн, зөрчлийн хэрэг үүсгэж, 30000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан байна. Улмаар энэхүү зөрчлийн хэргийг хянасан прокуророос "зөрчлийн хэрэг биш" гэсэн үндэслэлээр уг шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулахаар шүүхэд ханджээ.

УДШ-ийн тогтоол, үндэслэл: ... "зөрчлийн эрх зүй" нь нийтийн эрх зүйд хамааралтай, нийтийн эрх зүйн хүрээнд хариуцлага хүлээлгэх "зөрчил" нь нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдсан эрх, үүргийг зөрчсөн байх, тухайн зөрчлийн үр дагавар нь нийтийн эрх ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн байх зэрэг эрх зүйн үр дагавар, шинжийг шаардана.Өөрөөр хэлбэл, аливаа хууль, хэм хэмжээний актыг зөрчсөн тохиолдол бүр нь нийтийн эрх зүйн хүрээнд зөрчил үйлдсэнд тооцогдохгүй, Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй, нийтийн эрх зүйн харилцааны явцад хууль, хэм хэмжээний актын заалт зөрчигдсэн боловч энэ нь тухайн этгээдэд зөвхөн өөрт нь хамааралтай, эсхүл уг харилцаанд оролцогч талуудад хамааралтай бөгөөд нийтийн эрх зүйн хүрээнд ямар нэг үр дагавар үүсгээгүй бол нийтийн эрх зүйн хүрээнд зөрчил үйлдсэнд тооцохгүй, ийм зөрчилд торгууль шийтгэл хүлээлгэх үндэслэлгүй²⁴. Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 396 дугаар тогтоолоор "Монгол Улсын иргэний үнэмлэхийн дүрэм"-ийг баталсан, уг дүрмийн 2.7-д "Иргэн иргэний үнэмлэхээ эзэмшихэд дараах үүрэг хүлээнэ", 2.7.1-д "иргэний үнэмлэхийг цэвэр гамтай эзэмших, хадгалах" гэж заасныг маргааны үйл баримтад хамааруулан тайлбарлахад, иргэний үнэмлэхээ цэвэр, гамтай эзэмшээгүй, хадгалаагүй эсхүл хаяж үрэгдүүлсэн нь нийтийн эрх зүйн хүрээний зөрчилд тооцогдохгүй, учир нь иргэн өөрийн иргэний үнэмлэхээ гамгүй эзэмшсэн эсхүл гээсэн нь нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн үр дагавар үүсгэхгүй, нийтээр тогтоосон журам, зан заншлын хэм хэмжээнд сөргөөр нөлөөлөхгүй, нийгэмд хор уршиг учруулахгүй, өөр бусад хэн нэгний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй, зөвхөн хувь иргэнд өөрт нь эрх зүйн үр дагавар үүсэх боломжтой байх тул улсын бүртгэлийн байгууллага тухайн иргэнийг зөрчил үйлдсэнд тооцож Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэж шийтгэл оногдуулсан нь буруу байна²⁵.

²³ УДШ-ийн 2024.11.11-ны 001/ХТ2024/0109 дүгээр тогтоол, шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://legaldata.mn/shiidver/zahirгаа/view/2975?whr=s>, (Сүүлд үзсэн: 2025.02.17).

²⁴ Мөн тэнд, 13 дахь цогцолбор.

²⁵ Мөн тэнд, 14 дэх цогцолбор.



Энэхүү шийдвэрээр Монгол Улсын иргэний үнэмлэхийн дүрмийн 2.7.1 болон Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 4-ийг тайлбарласан байна. Тодруулбал Зөрчлийн тухай хуулийн зорилгоос үзвэл, нийтийн эрх зүйн хэм хэмжээг зөрчих үйлдэл бүр нь зөрчилд хамаарахгүй бөгөөд зөвхөн өөрт чиглэсэн үр дагавар үүсгэх тохиолдолд зөрчлийн тухай хуулийн дагуу торгууль ногдуулах үндэслэл болохгүй гэж үзсэнээр зөрчилд тооцогдох үйлдлийн шинжийг тайлбарласан ач холбогдолтой байна. Ийнхүү шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосноор, иргэн 30000 төгрөгийн торгуулийг төлөх эрх зүйн үр дагавар үүсэхгүй байна. Урд өмнө адил төсөөтэй маргаан гарч байгаагүй байна.

Кэйс №5. Дампуурлын хэрэг гүйцэтгэгч А.Э-н нэхэмжлэлтэй, Улсын бүртгэлийн ерөнхий газарт холбогдох хэрэг²⁶

Хэргийн тухай товч: Дампуурлын хэрэг гүйцэтгэгчээс "Шүүхийн журмаар татан буугдаж буй хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасуулах"-аар Улсын бүртгэлийн ерөнхий газарт ханджээ. Улсын бүртгэлийн ерөнхий газар албан бичгээр "татвар төлөгч хуулийн этгээдийг татан буугдсан, дампуурсан тухай шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд харьяа татварын албанд хандаж татвар төлөх үүргийг нь дуусгавар болгож хасуулсан хуульд заасан баримт бичгийг бүрдүүлэн хандах нь зүйтэй" талаар хариу өгчээ. Үүнтэй холбогдуулан дампуурлын хэрэг гүйцэтгэгчээс "улсыг бүртгэлийн байгууллага бүрдүүлбэр хангахыг шаардах, татварын байгууллагын улсын бүртгэлд тавьсан хоригийг цуцлуулах зэрэг шаардлага тавьж буй нь хууль бус" үндэслэлээр тус албан бичгийг хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгуулах, шүүхийн журмаар дампуурсанд тооцож татан буулгахаар шийдвэрлэсэн хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасаж бүртгэн, шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг даалгах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргасан.

УДШ-ийн шийдвэр, үндэслэл: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд шүүхийн шийдвэрээр дампуурсан хуулийн этгээдийг бүртгэлээс хасах талаар тусгайлан зохицуулаагүй байна. Иймд уг хуулийн 24 дүгээр зүйлд заасан нийтлэг зохицуулалтыг хэрэглэнэ. Уг хуулийн дагуу дампуурлын хэрэг гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрээр дампуурсанд тооцогдсон хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасуулахын тулд татан буулгах ажиллагаа дуусгавар болсныг нотлох баримтуудыг улсын бүртгэлийн байгууллагад бүрдүүлж өгөх үүрэгтэй байна. Тухайлбал, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасан бүрдүүлбэрээс татвар төлөгчийн хасалтын карт, улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт зэргийг зайлшгүй бүрдүүлж өгөх шаардлагатай. Энэхүү маргааны хувьд нэхэмжлэгч эдгээр баримтыг

²⁶ Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 128/ШШ2024/0719 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 221/МА2024/0743 дугаар магадлалтай хэрэг.



бүрдүүлж өгөөгүй байх тул хариуцагчаас баримт бичгийн бүрдэл дутуу гэсэн үндэслэлээр бүртгэл хийхээс татгалзсан нь үндэслэлтэй. Харин Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасан бусад баримтын тухайд дампуурсан хуулийн этгээдийн онцлогт тохируулан тайлбарлан хэрэглэх шаардлагатай гэж үзлээ. Тухайлбал, "татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/"-ыг дампуурсанд тооцсон тухай шүүхийн шийдвэр гэж ойлгож болно. Мөн шүүхээс дампуурлын хэрэг үүсгэх үед зар гаргадаг тул "татан буулгасан тухай өдөр тутмын сонинд зарлуулсан зар" шаардлагагүй, нэгэнт дампуурсан хуулийн этгээдийн тухайд "өртэй эсэх талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа" шаардлагагүй гэж үзэв²⁷.

Тус шийдвэрээр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд шүүхийн шийдвэрээр дампуурсан хуулийн этгээдийг бүртгэлээс хасах талаар тусгайлан зохицуулаагүй байгаа тохиолдолд тус хуулийн 24 дүгээр зүйлд заасан нийтлэг зохицуулалтыг хэрэглэнэ хэмээжээ. Тиймээс шүүхийн шийдвэрээр дампуурсанд тооцогдсон хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасуулахын тулд хуулийн 24.1-т заасан бүрдүүлбэрийг гаргаж өгнө, харин 24.1-т заасан бусад материалыг дампуурсан хуулийн этгээдийн онцлогоос хамааран тайлбарлана. Тухайлбал, эрх бүхий байгууллагын шийдвэр болон өртэй эсэх талаар лавлагааг маргаан бүхий хэргийн хувьд хэрхэн ойлгох талаар тайлбарласан байна. Урд өмнө нь адил төсөөтэй маргааныг шийдвэрлэсэн тохиолдол байхгүй бөгөөд дээд шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, хууль хэрэглээний хувьд өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байна.

Явцын дүгнэлт:

УДШ-ийн захиргааны хэргийн танхим ЗХШХШТХ-ийн 123 дугаар зүйлийн 123.2.4-т заасан үндэслэлээр хүлээн авч, хянан шийдвэрлэсэн 5 маргааныг танилцууллаа. Маргааны төрлөөр авч үзвэл 4 нь салбарын хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзэж, Зөрчлийн тухай хуульд заасан торгууль оногдуулсантай холбоотой буюу зөрчлийн эрх зүйн маргаан байна. Мөн маргаан бүхий актын 4 нь иргэн, хуулийн этгээдэд 30,000 төгрөгөөс 20 сая төгрөг хүртэлх торгууль оногдуулах тухай, 1 актын хувьд дампуурсан хуулийн этгээдийг бүртгэлээс хасуулах тухай акт байна. Кэйс 1-ийн хувьд үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг эрсдэлээс хамгаалах хууль тогтоогчийн үзэл баримтлалд тулгуурлан хуулийг тайлбарлах замаар төрийн эдийн засгийн бодлогыг хамгаалсан байна. Харин кэйс 2-ын хувьд Татварын ерөнхий хуулийн 41.12.3-ыг тайлбарлах замаар татвар төлөгчийн илүү төлсөн татварыг буцаан авах, суутган тооцуулах, алданги тооцон нэхэмжлэн авах эрхийг хамгаалсан байна. Кэйс 3-ын хувьд Хадгаламжийн даатгалын корпорац нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бус бусад мэдээллийг бүрэн эрхээ хэтрүүлэн банкнаас шаардахгүй гэж хуулийг

²⁷ УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн шүүх хуралдааны шийдвэрийн тойм, <https://www.supremecourt.mn/mn/home?page=judgments&id=17&pr=0&tp=list&pg=1>, (Сүүлд үзсэн: 2025.03.17).



тайлбарласнаар, хуулийн зохицуулалтыг нэг мөр болгосон байна. Мөн адил кэйс 5-ын хувьд шүүхийн журмаар татан буугдаж буй хуулийн этгээдийн хувьд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйл буюу нийтлэг зохицуулалт хэрэглэгдэх тухай тайлбарласнаар цаашид шүүхийн журмаар татан буугдах хуулийн этгээдийн хувьд хууль хэрэглээг нэг мөр болгож тайлбарласан байна. Кэйс 4 нь нийтийн эрх зүйн хэм хэмжээг зөрчих үйлдэл бүр нь зөрчилд тооцогдохгүй, тухайн зөрчлийн үр дагавар нь хувь этгээдэд чиглэсэн тохиолдолд захиргааны эрх зүй дэх зөрчилд тооцохгүй хэмээн зөрчлийн эрх зүйн шинжийг цаашид жишиг болохуйцаар тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл, "эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой" гэх үндэслэлээр хүлээн авсан захиргааны хэргүүдийн хувьд, хуулийн зохицуулалтыг тодорхой тайлбарлах замаар, цаашид адил төсөөтэй маргааныг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хууль хэрэглээг тогтоосон байна.

Түүнчлэн 4 тогтоолоор УДШ-ээс тухайн маргааныг шийдвэрлэх замаар анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон эсхүл хууль хэрэглээний хувьд өөрчлөлт оруулсан байна. Энэ нь давж заалдах шатны шүүхийн алдаатай хууль хэрэглээг жишиг болгож үлдээх нь зохисгүй тохиолдолд дээд шүүх ЗХШХШТХ-ийн 123 дугаар зүйлийн 123.2.4-т заасан үндэслэлээр хүлээн авч байна гэж дүгнэх боломжтой юм. Гэхдээ 1 тогтоолын /Кэйс 1/ хувьд урд өмнө адил төсөөтэй маргааныг шийдвэрлэсэн УДШ-ийн тогтоол байсан, мөн тус хэргийг шийдвэрлэхдээ анхан, давах нь өмнө гарсан УДШ-ийн жишгээр хуулийг тайлбарлаж, шийдвэрлэсэн байхад УДШ тус хэргийг ЗХШХШТХ-ийн 123 дугаар зүйлийн 123.2.4-т заасан үндэслэлээр хүлээн авсан байна.

IV. Гадаадын зарим орны шүүхийн практик

Гадаадын ихэнх орны хувьд дээд шүүх нь бүх л гомдлыг хүлээж авахгүйгээр, зөвхөн тодорхой шалгуур хангасан хяналтын гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэдэг. Энэ нь дээд шүүх нь онолын шүүх буюу хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтоох зорилготой холбоотой юм. Эх газар болон Англи Саксоны эрх зүйн бүл бүхий улсуудын төлөөлөл болох Япон, АНУ, Их Британи, Герман зэрэг улсуудад дээд шүүхэд хяналтын гомдол гаргах шалгуур дотор "хууль тайлбарлахтай холбоотой чухал асуудал", "нийтлэг ач холбогдолтой", "суурь ач холбогдолтой" зэрэг үндэслэл багтдаг байна.

Тухайлбал, Япон улсын дээд шүүх нь "хууль тайлбарлахтай холбоотой чухал асуудал (法令の解釈に関する重要な事項- material import in the interpretation of laws)" гэх үндэслэлээр гомдлыг хүлээн авдаг. Энэ нь маргаан бүхий хуулийн зохицуулалтыг тайлбарлах нь тухайн хэрэг маргааныг л шийдвэрлэхэд чухал бус, ирээдүйд ижил төсөөтэй маргааныг шийдвэрлэхэд нийтлэг байдлаар нөлөө үзүүлэх ач холбогдолтой байхыг илэрхийлнэ²⁸. Тодруулбал:

²⁸ 賀集唱ほか編『基本法コンメンター Ⅲ [第三版追補版] 民事訴訟法3』 [上野泰男] (日本評論社、2012) 79 頁。



- дээд шүүх урьд нь шийдэж байгаагүй бөгөөд маргаан бүхий зохицуулалтыг тайлбарлах шаардлагатай тохиолдол
- дээд шүүхээс урьд өмнө гаргасан шийдвэрээ өөрчлөх шаардлагатай тохиолдол
- давж заалдах шатны шүүхээс хуулийн зохицуулалтыг алдаатай тайлбарласан бөгөөд тухайн алдаатай хуулийн тайлбарыг хүчин төгөлдөр болгон үлдээх нь зохисгүй тохиолдол хамаарна²⁹.

Судлаачдын зүгээс "чухал (重要な)" гэх ойлголтыг гомдол гаргаж буй хүний хувьд чухал байхаас гадна адил төрлийн ашиг сонирхол бүхий хүмүүсийн хувьд ч чухал байхыг ойлгох³⁰ бөгөөд өөрөөр хэлбэл тухайлсан хэрэг маргааныг шийдвэрлэх нь адил төрлийн асуудалтай хүмүүст нөлөө үзүүлэхүйц байхыг ойлгоно гэж үздэг байна.

Мөн АНУ-ын хувьд дээд шүүх нь "нийтлэг ач холбогдолтой (public importance)" хяналтын гомдлыг авч хэлэлцдэг³¹ бол Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын дээд шүүх нь нийтлэг ач холбогдолтой (general public importance) гомдлыг хянан шийдвэрлэнэ³². Харин Герман улсын Холбооны захиргааны шүүхийн хяналтын гомдлыг хүлээн авах шалгуурт "суурь ач холбогдолтой (fundamental significance, grundsätzliche Bedeutung)" гэх шалгуурыг тогтоожээ³³. Өгүүллийн энэхүү хэсэгт дээрх үндэслэлээр хүлээн авч шийдвэрлэсэн маргаануудаас leading case болгож 5 шийдвэрийг хураангуйлан хүргэе.

4.1. Сангийн яамны трансжендэр албан хаагчийг эмэгтэй ариун цэврийн өрөө хэрэглэхийг хориглосонтой холбоотой маргаан³⁴

Хэргийн тухай товч³⁵: А-ийн биологийн хүйс нь эрэгтэй боловч дааврын эм ууж, эмчилгээ хийлгэснээр эр дааврын хэмжээ нь хэвийн хэмжээнээс бага болсон. А нь Сангийн яаманд ажилд орох үед эрэгтэй хувцас өмсөж, эрэгтэй ариун цэврийн өрөөг ашигладаг байсан. Харин тодорхой хугацаа өнгөрсний дараа А нь удирдлагадаа хүйсийн зөрчилтэй байгаагаа мэдэгдэж ажлын байранд эмэгтэй хувцас өмсөх мөн эмэгтэй ариун цэврийн өрөө ашиглахыг хүссэн хүсэлт өгсөн. Ингээд бусад албан хаагчдад А-ийн нөхцөл байдлыг тайлбарлахад А-ийн ажилладаг алба байрладаг давхрын албан хаагчид А-г эмэгтэй ариун цэврийн өрөөг ашиглахад дургүйцэж байгаагаа илэрхийлсэн. Тиймээс А нь өөр давхруудын эмэгтэй ариун цэврийн өрөөг хэрэглэж, эмэгтэй хувцас өмсөж ажилдаа ирэх болсон. А нь 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Төрийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлд заасны дагуу ажлын байранд /өөрийн алба байрлах давхрын/ эмэгтэй ариун цэврийн өрөөг чөлөөтэй ашиглах, мөн

²⁹ 法務省民事局参事官室編の『一問一答新民事訴訟法』（1996年）354頁。

³⁰ 三宅省三「最高裁判所の役割の変化」三宅省三ほか編 新民事訴訟法大系理論と実務第四巻（1997年）75頁。

³¹ 28 U.S.C. § 2101(e), Supreme Court Rule 11

³² Administration of Justice Act (1960), <https://www.legislation.gov.uk/ukpga/Eliz2/8-9/65/section/1#commentary-c10099>

³³ Code of Administrative Court Procedure, 1991, https://www.gesetze-im-internet.de/englisch_vwgo/englisch_vwgo.html

³⁴ 最判令和5年7月11日 https://www.courts.go.jp/app/hanrei_jp/detail2?id=92191

³⁵ 野川 忍, 「トランスジェンダーの経産省職員に対するトイレ使用制限の適法性」, 《WLJ 判例コラム 特報》第294号、2頁。



эмэгтэй ажилтнуудтай адил байдлаар харьцаж байх тухай хүсэлт өгсөн ч Хүний нөөцийн газраас тус хүсэлтийн алийг ч зөвшөөрөөгүй тул А шүүхэд хандсан.

Шүүхийн шийдвэр, үндэслэл: Хүний нөөцийн газраас А-ийн хүсэлтийг татгалзаж шийдвэрлэсэн нь тус яамны бусад албан хаагчдыг илүүтэйгээр харгалзан үзэж, А-д үүсэж буй сөрөг нөлөөллийг үндэслэлгүйгээр үл тоосон байх бөгөөд А болон бусад албан хаагчдын үр нөлөөтэй ажиллах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх гэсэн өнцгөөс харж шийдвэр гаргаагүй, үндсэн хуульд нийцээгүй шийдвэр гэж үзсэн³⁶.

4.2. Агаарын бохирдлыг үүсгэгч эх үүсвэрийг тодорхойлсон Байгаль орчныг хамгаалах агентлагийн журмын заалт нь хуулийн зорилгод нийцсэн эсэхтэй холбоотой маргаан³⁷

Хэргийн тухай товч:³⁸ 1977 онд Цэвэр агаарын тухай хууль (Clean air act)-д нэмэлт өөрчлөлт орж, агаарын бохирдолтой мужуудад "шинээр станц барих эсхүл станцыг өөрчлөх" тохиолдолд авах арга хэмжээг батлах эрхийг гүйцэтгэх эрх мэдэлд шилжүүлсэн. Тиймээс Байгаль орчныг хамгаалах агентлагаас (EPA) шинэ зохицуулалт гаргаж, үйлдвэрүүдэд нэгэн төрлийн "bubble concept" буюу үйлдвэрийн бүх тоног төхөөрөмжийг нэг бохирдлын эх үүсвэр гэж үзэхээр болсон. Өөрөөр хэлбэл өмнө нь үйлдвэр доторх утаа гаргагч төхөөрөмж тус бүрээр ялгаруулах бохирдлын хэмжээг хэмждэг байсан бол шинэ зохицуулалтаар нэг үйлдвэр эсвэл байгууламж доторх бүх бохирдлын эх үүсвэрийг нэг эх үүсвэр гэж үзэж тооцох болсон. Үүнийг Байгалийн нөөцийг хамгаалах зөвлөл (Natural Resources Defense Council) -өөс Цэвэр агаарын тухай хуулийн зорилгод нийцэхгүй бөгөөд шинэ тоног төхөөрөмж тус бүрийн бохирдлыг хатуу хянах ёстой гэж маргаж, шүүхэд хандсан. Энэхүү маргаан нь хуульд "станц" (stationary source) буюу суурин эх үүсвэрийг тодорхойлоогүй байхад, EPA-аас гаргасан журам дахь "эх үүсвэр"-ийн тайлбар нь хуульд нийцэж буй эсэхтэй холбоотой маргаан юм.

Шүүхийн шийдвэр, үндэслэл:³⁹ Дээд шүүхээс тус хэргийг шийдвэрлэхдээ Chevron-ы зарчим (Chevron deference)-ыг анх гаргаж ирсэн. Chevron-ы зарчим гэдэг нь 2 нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд шүүх эргэлзээ бүхий хуулийн зохицуулалтыг тайлбарлах эрхийг захиргааны байгууллагын сонгох боломжид олгох ёстой гэх зарчим юм. Өөрөөр хэлбэл, шүүхээс нэгдүгээрт, маргаан бүхий асуудлын талаар хууль тогтоогчийн тайлбар, үзэл баримтлал байгаа эсэхийг шалгаж үзэх бөгөөд хэрвээ хууль тогтоогчийн үзэл баримтлал нь тодорхой байгаа тохиолдолд тухайн үзэл баримтлалтай үл нийцэж буй захиргааны байгууллагын шийдвэрийг хүчингүй болгоно. Харин маргаантай зохицуулалт /асуудал/-ын талаар хууль тогтоогчийн үзэл баримтлал нь тодорхой бус, эргэлзээ бүхий байвал шүүхээс захиргааны байгууллагын хүлээн зөвшөөрөгдөхүйц тайлбарыг

³⁶ 吉原秀、「経産省トイレ使用制限事件判決は何を示し、何を示さなかったのか—補助線としての二重の基準論と司法府の役割論—」、OBA Monthly Journal 2023.12、60頁。

³⁷ Chevron U.S.A. Inc. v. Natural Resources Defense Council, Inc., 467 U.S. 837 (1984).

³⁸ Chevron USA Inc. v. Natural Resources Defense Council, Inc., https://www.casebriefs.com/blog/law/administrative-law/administrative-law-keyed-to-lawson/scope-of-review-of-agency-action/chevron-usa-v-natural-resources-defense-council-inc/?_cf_chl_tk=Pao1lfuHsdIKe4j9AvddpC44chCmnhXhOOby_nTLQpl-1738219618-1.0.1.1-GYUTF6y7KbLV7U7WSf8QkYXVfntQAochrCbVwVVL9kl

³⁹ Supra note 37.



(permissible) хүлээн зөвшөөрнө⁴⁰. Тус хэргийн хувьд маргаан бүхий асуудал болох бохирдуулагч эх үүсвэрийн тодорхойлолтын талаар хууль тогтоогчийн үзэл санаа нь тодорхой бус байх тул ЕРА-ийн журмаар эх үүсвэрийг тайлбарласан байдал нь үндэслэл бүхий, хүлээн зөвшөөрөгдөхүйц гэж үзсэн.

4.3. АНУ-ын Үндэсний далайн загас агнуурын газрын баталсан журам нь хуулиар тогтоогоогүй агуулгыг журамласан эсэхтэй холбоотой маргаан⁴¹

Хэргийн тухай товч: АНУ-ын далайн загас агнуурыг зохицуулах тухай хуулиар загас агнуурын нөөцийг хамгаалах, хяналт тавихтай холбоотой журам батлах эрхийг Үндэсний далайн загас агнуурын газарт олгосон. Үүний дагуу тус газар нь тухайлсан загас агнуурын хөлөг онгоцнуудад хяналтын ажиглагчдыг авч явахыг шаардсан бөгөөд эдгээр ажиглагчдын зардлыг хөлөг онгоцны эзэд өөрсдөө хариуцах ёстой тухай журамд тусгасан байна. Компаниудын зүгээс хуулиар хөлөг онгоцны эзэд ажиглагчдын зардлыг хариуцахыг шаардаагүй тул, тус журам нь хуульд нийцээгүй хэмээн маргасан⁴².

Шүүхийн шийдвэр, үндэслэл⁴³: Энэхүү шийдвэрээр дээд шүүхээс жишиг болон тогтсон байсан Chevron-ий зарчмыг үгүйсгэсэн. Шүүхээс үзэхдээ эргэлзээ бүхий хуулийн зохицуулалтыг тайлбарлах нь шүүх эрх мэдлийн чиг үүрэг ба гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын шийдвэр, санал бодол нь шүүхээс гаргах шийдвэрт хэрэгтэй "мэдээлэл" бөгөөд шүүхийн шийдвэрээс давуу байх ёсгүй. Хуулийн эргэлзээ бүхий зохицуулалтыг тайлбарлах, нөхөн зохицуулахыг хууль тогтоогчоос гүйцэтгэх эрх мэдэлд шилжүүлж буй гэж үзэх нь эндүүрэл бөгөөд жишээлбэл, санамсаргүйгээр эргэлзээ бүхий агуулгатай болсон, эсхүл хууль тогтоогч тухайн асуудлын талаар хангалттай хэлэлцээгүй зэрэг тохиолдлууд байдаг. Тиймээс захиргааны байгууллагад эргэлзээ бүхий хуулийн зохицуулалтыг шийдвэрлэх, тайлбарлах тусгай чадвар байхгүй нөгөөтээгүүр, шүүх нь хуулийг тайлбарлах тухайд мэргэшсэн байдаг гэж үзсэн.

4.4. Их Британийн Ерөнхий сайд Парламентын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотой маргаан⁴⁴

Хэргийн тухай товч⁴⁵: 2019 оны 8-р сард тухайн үеийн Ерөнхий сайд Борис Жонсон Хатан хаан II Елизабетэд хандаж, парламентын үйл ажиллагааг 2019 оны 9-р сарын 10-наас 10-р сарын 14 хүртэл зогсоох хүсэлт гаргасан. Гэвч Их Британи Европын холбооноос гарахыг шийдэх эцсийн хугацаа нь 2019 оны 10-р сарын 31 байсан. Өөрөөр хэлбэл, 10 сарын 14-ээс Парламентын шинэ чуулган эхэлсний дараа тус асуудлыг хэлэлцэхэд маш бага хугацаа үлдэх байсан. Тиймээс иргэд Европын Холбооны эгнээнээс гарахын тулд ардчиллын үнэт зүйлсэд халдаж, ард иргэдийнхээ хүсэл зоригийг үл хайхарч байна хэмээн маргасан.

⁴⁰ 塚本宏達、佐藤恭平、本田圭「Chevron法理を否定した連邦最高裁場所判決（Loper Bright事件 Relentless事件）」, 2024年9月No. 128.

⁴¹ Loper Bright Enterprises v. Raimondo, No. 22-451, 603 U.S. ____ (2024), Relentless, Inc. v. Department of Commerce, No. 22-1219, 603 U.S. ____ (2024).

⁴² 塚本 前掲注（40）.

⁴³ Supra note 41.

⁴⁴ R (Miller) v the Prime Minister [2019] UKSC 14.

⁴⁵ Case summary – R (Miller) v the Prime Minister [2019] UKSC 14, <https://news.bylawyers.co.uk/s/blog-article/a63Tg000000PrIAE/case-summary-r-miller-v-the-prime-minister-2019-uksc-14>



Шүүхийн шийдвэр, үндэслэл: Дээд шүүхээс парламентын үйл ажиллагааг түр зогсоосон нь хууль бус гэж үзсэн. Парламентын үйл ажиллагааг түр зогсоосон нь засгийн газрын Европын холбооноос гарах төлөвлөгөөний эсрэг парламентын хяналтыг зайлуулах гэсэн зүй бус зорилготой байсан гэж үзсэн⁴⁶. Мөн тус шийдвэрээр парламентын үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр нь шүүхийн хяналтад багтана хэмээн дүгнэснээрээ ач холбогдолтой юм.

4.5. Герман улсын иргэншил авахын тулд Йордан улсад амьдардаг гэр бүлээ тэжээн тэтгэх эдийн засгийн чадамжтай байх шаардлагатай эсэх талаарч маргаан⁴⁷

Хэргийн тухай товч⁴⁸: Өргөдөл гаргагч нь харьяалалгүй Палестин гаралтай иргэн бөгөөд Германд байнга оршин суух зөвшөөрөлтэй. Хүсэлт гаргагч нь 2003 онд Йордан улсын иргэнтэй гэрлэсэн бөгөөд 3 хүүхэдтэй. Эхнэр болон хүүхдүүд нь Йордан улсад оршин суудаг. Хүсэлт гаргагч нь 1999 оноос хойш цалинтай ажил эрхэлж байсан бөгөөд нийгмийн халамж авдаггүй байсан. Тэрээр 2009 оны 7 сард иргэншил авах хүсэлт гаргасан боловч тус улсад оршин сууснаас хойш бага орлоготой байсан бөгөөд эхнэр болон хүүхэд нь Германд ирсэн тохиолдолд гэр бүлээ тэжээж чадахгүй гэх үндэслэлээр 2010 оны 11 сард татгалзсан байна. Хүсэлт гаргагчийн эхнэр болон хүүхдүүд нь Германд очиж, амьдрах талаар ямар нэгэн төлөвлөгөө байхгүй байсан бөгөөд хүсэлт гаргагч нь цаашдаа ч гэр бүл нь "хол зайн гэрлэлт (distant marriage)"-ийг үргэлжлүүлэх хүсэлтэй байгааг тодорхой илэрхийлсэн.

Шүүхийн шийдвэр, үндэслэл⁴⁹: Энэхүү маргааны гол асуудал нь Йордан улсад амьдарч буй гэр бүл нь Германд очиж, амьдарна гэх таамаглалыг иргэншил олгох тухай шийдвэр гаргахад хэрхэн харгалзах тухай юм. Германы Иргэншлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн (1)-т Германд хууль ёсны дагуу байнгын оршин суугаа гадаад улсын иргэн нь "өөрийгөө болон өөрийн гэр бүлийг тэжээн тэтгэх чадвартай" байх тохиолдолд хүсэлтийн дагуу иргэншил олгох боломжтой. Өөрөөр хэлбэл хүсэлт гаргагч нь өөрийгөө болон гэр бүлээ аливаа хязгаарлалтгүйгээр тэжээн тэтгэх тухай хуулийн үзэл баримтлал байна. Энэ нь хэдийн Германд амьдарч буй гэр бүл болон иргэншил авах үед Германд амьдрахыг тодорхой зорьж буй гэр бүлийн хувьд гэж хязгаарлаагүй бөгөөд гадаад улсад амьдарч буй гэр бүлийн хувьд ч хамаарна.

Явцын дүгнэлт:

Дээрх хэсэгт Герман, Япон, АНУ болон Их Британийн шүүхээс хууль тайлбарлахад чухал, нийтлэг, суурь ач холбогдолтой зэрэг үндэслэлээр хүлээн авсан хэргүүдийг танилцууллаа. Дээрх шийдвэрүүдээс Герман улсын иргэншил хүссэнтэй холбоотой маргааны хувьд Иргэншлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн (1)-ийн агуулгыг тодорхой тайлбарласан байна. Харин бусад 4 кэйсийн хувьд тодорхой хуулийн зохицуулалтыг тайлбарлах бус захиргааны хэргийн шүүхийн хяналтын

⁴⁶ Ibid.

⁴⁷ BVerwG 1 C 23.14, <https://caselaw.statelessness.eu/caselaw/germany-federal-administrative-court-judgment-1-c-2314>

⁴⁸ Germany – Federal Administrative Court, judgment 1 C 23.14, <https://caselaw.statelessness.eu/caselaw/germany-federal-administrative-court-judgment-1-c-2314>

⁴⁹ Ibid.



хүрээний талаар зарчмуудыг шинэчлэн тогтоох, нэгэнт хэвшсэн зарчмуудыг өөрчилсөн шинжтэй байна. Тухайлбал: Трансжендэр албан хаагч өөрийн ажлын орчинд хүссэн буюу тохирсон ариун цэврийн өрөөг ашиглах эрхийг захиргааны байгууллагаас хязгаарласан нь үндсэн хуульд заасан аз жаргалтай байх эрх /right to the pursuit of happiness, Япон Улсын Үндсэн хуулийн 13 дугаар зүйл/-ийг хөндсөн бөгөөд захиргааны байгууллага нь шийдвэр гаргахдаа зөвхөн нэг талын ашиг сонирхлыг илүүтэйгээр харгалзан үзэхгүй буюу пропорциональ байх зарчмын талаар хөнджээ. Харин кэйс 2 болон 3-ын хувьд хуулийн тодорхой бус зохицуулалтыг тайлбарлах эрх нь гагцхүү шүүх эрх мэдэлд хадгалагдах бөгөөд гүйцэтгэх эрх мэдэл хуулиас давж хэм хэмжээ тогтоохгүй талаар жишиг болох зарчмыг тогтоосон юм. Мөн кэйс 4-ийн хувьд ерөнхий сайд өөрийн бүрэн эрхийг хэтрүүлэн аливаа шийдвэр гаргах нь шүүхийн хяналтад байх тухай зарчмыг хөндсөн байна. Өөрөөр хэлбэл, бусад улсын хувьд "хууль тайлбарлахад чухал ач холбогдолтой, нийтлэг, суурь ач холбогдолтой" зэрэг үндэслэлээр хүлээн авсан гомдлыг шийдвэрлэсэн шийдвэрийн ихэнх нь хуулийн зохицуулалтыг тодорхойлж, тайлбарлах гэхээс илүүтэйгээр захиргааны эрх зүйн зарчмуудыг амилуулж, хэрэглэсэн шинжтэй байна.

Түүнчлэн, шүүхээс тухайн шийдвэрийг гаргах замаар хамгаалж буй эрх, ашиг сонирхол нь нэг талаас үндсэн хуульд заасан иргэний эрх, тодруулбал аз жаргалтай байх эрх байх /гэхдээ Япон улсын ердийн шүүх нь үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг гэдгийг анхаарах нь зүйтэй/ ба, нөгөөтээгүүр, улсын үндэсний язгуур ашиг сонирхол байна /Их Британи болон Германы кэйс/.

V. Дүгнэлт

Энэхүү өгүүлээр УДШ-ийн хяналтын гомдолд тавигдах шалгуурын нэг болох "эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой" гэх шалгуурын агуулгыг онол болон практикийн хувьд тодорхойлохыг зорилоо. ХЗБХ-ны 2021 оны 01 сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс харвал тус ойлголтыг тухайн хэргийг шийдвэрлэх нь ижил төстэй хэргүүдийг цаашид шийдвэрлэхэд ач холбогдолтой байхыг ойлгох тухай санал гарч байсан байна. Харин бусад улсын хувьд хууль тайлбарлахад чухал, нийтлэг, суурь ач холбогдолтой гэх ойлголтыг тухайн хэргийг шийдвэрлэх замаар эргэлзээ бүхий хуулийн заалтыг тайлбарласнаар, цаашид ижил төсөөтэй маргаан гарахад жишиг болох ач холбогдолтой байхыг олгоно хэмээн үзэж байна.

Монгол Улсын УДШ-ийн Захиргааны хэргийн танхим нь зөвхөн ЗХШХШтХ-ийн 123 дугаар зүйлийн 123.2.4-т заасан үндэслэлээр хүлээн авч, хянан шийдвэрлэсэн 5 тогтоол байна. Тус 5 тогтоол нь маргааныг шийдвэрлэх гол зангилаа болох хуулийн зохицуулалтыг нэг мөр болгон тодорхойлон, тайлбарласан байх бөгөөд энэ нь цаашид адил төсөөтэй маргааныг шийдвэрлэхэд ач холбогдол болох хууль хэрэглээг тогтоосон байна. Эдгээр тогтоол нь ихэнх тохиолдолд тодорхой иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрхийг хамгаалсан, мөн үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг эрсдэлээс хамгаалах хууль тогтоогчийн үзэл баримтлалд



нийцүүлж шийдвэрлэсэн агуулгатай байна. Түүнчлэн УДШ нь дийлэнх тохиолдолд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, тогтоолыг хүчингүй болгож, эсхүл хууль хэрэглээний хувьд өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байгаагаас харвал, давж заалдах шатны шүүхийн алдаатай хууль хэрэглээг жишиг болгож үлдээх нь зохисгүй тохиолдолд ЗХШХШТХ-ийн 123 дугаар зүйлийн 123.2.4-т заасан үндэслэлээр хүлээн авч байна гэж дүгнэх боломжтой. Мөн дээрх 5 тогтоол нь "эрх зүйн шинэ ойлголт" гэхээс илүүтэйгээр "хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой" гэх шалгуурт илүү нийцсэн байна.

Герман, Япон, АНУ болон Их Британийн хувьд "хууль тайлбарлахад чухал ач холбогдолтой, нийтлэг, суурь ач холбогдолтой" зэрэг үндэслэлээр хүлээн авсан гомдлыг шийдвэрлэсэн шийдвэрийн ихэнх нь хуулийн зохицуулалтыг тодорхойлж, тайлбарлах гэхээс илүүтэйгээр захиргааны эрх зүйн зарчмуудыг амилуулж, хэрэглэсэн шинжтэй байна. Түүнчлэн, шүүхээс тухайн шийдвэрийг гаргах замаар хамгаалж буй эрх, ашиг сонирхол нь нэг талаас үндсэн хуульд заасан иргэний эрх, тодруулбал аз жаргалтай байх эрх байх /гэхдээ Япон улсын ердийн шүүх нь үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг гэдгийг анхаарах нь зүйтэй/ ба нөгөөтээгүүр, улсын үндэсний язгуур ашиг сонирхол байна /Их Британи болон Германы кэйс/.

Монгол Улсын хувьд "эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой" гэх үндэслэлийг хуульд шинээр оруулсан нь иргэдийн шүүхэд хандах эрхийг өргөжүүлэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтоох боломжийг нэмэгдүүлэх, цаашлаад нийгмийн харилцаа, технологийн дэвшил, хөгжлөө дагаад үүсэж буй эрх зүйн шинэ тутам ойлголт, маргааныг шийдвэрлэх гарцыг нээх зорилготой билээ. Тийм ч учраас, хуулийн үзэл баримтлал, зорилго болон захиргааны эрх зүйн зарчмыг бодит кэйс дээр тайлбарлан амилуулах шаардлагатай тохиолдлуудыг ч дээрх үндэслэлээр хүлээн авах нь цаашид ижил төрлийн маргаан гарахад хууль хэрэглээний хувьд жишиг, голлох эх сурвалж болох тул ач холбогдол бүхий байна. Мөн тухайн хэргийг шийдвэрлэх замаар эргэлзээ бүхий хуулийн зохицуулалтыг тайлбарласнаар хэний, ямар эрх, ашиг сонирхлыг хамгаалж чадах, жишиг болохуйц хууль хэрэглээг тогтоосноор цаашид ямар бүлгийн буюу нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах боломжтойг харгалзан үзэх нь зүйтэй.



НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Ц.Цогт, С.Цэрэндолгор, "Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоон дахь улсын дээд шүүхийн хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх чиг үүрэг: хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах нь", *Монголын төр, эрх зүй сэтгүүл*, 2023, №1(103).
2. Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 сарын 03-ны өдрийн 02 дугаар дүгнэлт.
3. УДШ-ийн 2024.02.19-ний өдрийн 001/ХТ2024/0022 дугаар тогтоол.
4. УДШ-ийн 2020.05.06-ний өдрийн 156 дугаар тогтоол.
5. УДШ-ийн 2023.12.11-ний өдрийн 99 дүгээр тогтоол.
6. УДШ-ийн 2024.09.23-ны 001/ХТ2024/0085 дугаар тогтоол.
7. УДШ-ийн 2024.10.07-ны өдрийн 001/ХТ2024/0089 дугаар тогтоол.
8. УДШ-ийн 2024.11.11-ний 001/ХТ2024/0109 дугаар тогтоол.
9. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 221/МА2024/0743 дугаар магадлал.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. 賀集唱ほか編『基本法コンメンター ル [第三版追補版] 民事訴訟法 3』 [上野泰男] (日本評論社、2012)。
2. 法務省民事局参事官室編の『一問一答新民事訴訟法』 (1996年)。
3. 小室直人 上訴制度の研究 (1961年)。
4. 三宅省三「最高裁判所の役割の変化」三宅省三ほか編 新民事訴訟法大系理論と実務第四巻 (1997年)。
5. 野川 忍, 「トランスジェンダーの経産省職員に対するトイレ使用制限の適法性」, 《WLJ 判例コラム 特報》第294号。
6. 吉原秀, 「経産省トイレ使用制限事件判決は何を示し、何を示さなかったのかー補助線としての二重の基準論と司法府の役割論ー」, *OBA Monthly Journal* 2023. 12。
7. 塚本宏達、佐藤恭平、本田圭「Chevron法理を否定した連邦最高裁場所判決 (Loper Bright事件 Relentless事件)」, 2024年9月No. 128.
8. 28 U.S.C. § 2101(e), Supreme Court Rule 11.
9. Administration of Justice Act (1960).
10. Code of Administrative Court Procedure, 1991.
11. Chevron U.S.A. Inc. v. Natural Resources Defense Council, Inc., 467 U.S. 837 (1984).
12. Loper Bright Enterprises v. Raimondo, No. 22-451, 603 U.S. (2024).
13. Relentless, Inc. v. Department of Commerce, No. 22-1219, 603 U.S.(2024).
14. R (Miller) v the Prime Minister [2019] UKSC 14.
15. BVerwG 1 C 23.14.

**3. Цахим эх сурвалж:**

1. Монгол Улсын Их Хурлын цахим хуудас: www.parliament.mn
2. Хууль зүйн бүтээлийн цахим сан: www.legaldata.mn
3. Шүүхийн шийдвэрийн цахим сан: www.shuukh.mn
4. Улсын дээд шүүхийн цахим хуудас: www.supremecourt.mn

**Abstract** **GROUNDS FOR APPEAL TO THE SUPREME COURT:
CONSIDERATION OF "NEW LEGAL CONCEPTS
AND PRINCIPLES OF GENERAL IMPORTANCE IN
DETERMINING THE APPLICATION OF THE LAW"****DULGUUN, B.***Doctor of Law (Ph.D)*

According to an amendment to the Mongolian Court Law on June 16, 2023, the Supreme Court will be able to accept requests for review on the grounds that the case "is of general importance in principle to the establishment of new legal concepts or the application of the law." According to the minutes of the January 5, 2021 meeting, there was a proposal to understand this concept as meaning that the resolution of one case will have significance for the resolution of similar cases in the future. However, in other countries, the concept of important, common, and fundamental importance in interpreting the law is considered to be that by resolving a case, the interpretation of a dubious legal provision will be interpreted and will serve as a precedent for similar disputes in the future. According to Mongolian judicial practice, it clearly defines and explains important legal regulations for resolving disputes, through which the application of law is established, which will be important in resolving similar disputes in the future. In countries such as Germany, Japan, the United States and the United Kingdom, most cases accepted on the grounds of "significant, general and fundamental importance for the interpretation of law" tend to revive and apply principles of administrative law rather than defining and interpreting legal regulations. Moreover, according to judicial practice in Mongolia and other countries, cases accepted and adjudicated on this basis vary in terms of the rights and interests protected and the existence of precedents.

Keywords: New legal concepts, general importance in principle to determine the application of the law, uniformity of law application, Grounds for appeal to the Supreme Court

ХҮНИЙ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙГ ХАНГАХАД ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АСУУДАЛ

Б.МАРАЛ¹

- Оршил
- Сэдвийн судлагдсан байдал
- Үндсэн хэсэг
- Дүгнэлт

¹ Аюулгүй байдал судлалын докторант, УИХ-ын даргын ажлын албаны ажилтан.



ХҮНИЙ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙГ ХАНГАХАД ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АСУУДАЛ

Б.МАРАЛ Аюулгүй байдал судлалын докторант, УИХ-ын даргын ажлын албаны ажилтан.

Түлхүүр үг

Хог хаягдал, хууль, эрх зүйн орчин, хог хаягдлын менежмент

Хураангуй: Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрхүүдийн дотроос эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад хог хаягдлын менежмент тэргүүн зэргийн ач холбогдолтой. Хог хаягдалтай холбогдсон харилцааг хог хаягдлын тухай хуулиар зохицуулж байна. Нийгмийн аливаа харилцаа, үзэгдэл, үйл явцын хөгжил түүнийг зохицуулж буй хууль эрх зүйн орчин, түүний хэрэгжилтийн түвшнээр хэмжигдэж байдаг. Улаанбаатар хотын хог хаягдлын хэмжээ жил ирэх тутам өсөн нэмэгдэж байгаа нь хууль болон журамд алдаа эндэгдэл гарч байгаа эсвэл менежмент нь алдаатай эсэх Монгол хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад нөлөөлж буй хүчин зүйл болж байна.

I. Оршил

Улаанбаатар хотын хог хаягдлын хэмжээ жил бүр тогтмол өсөн нэмэгдэж байгаа нь олон шалтгаантай байж болох ч системийн хувьд авч үзвэл эрх зүйн орчин хамгийн чухал хэсэг нь юм. Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилт хангалттай байснаар иргэн бүр үүргээ ухамсарлан хуулийг биелүүлж эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээ эдлэх юм. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар батлагдсан хуулийн хэрэгжилтийг 5 жил тутамд үнэлж байх заалттай боловч хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилт анх батлагдсан цагаас өнөөдрийн хүртэл хуулийн хэрэгжилтийг үнэлээгүй байна¹. Хүний эрхийн үндэсний комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлд дэлхийн улс орнууд хүрээлэн буй орчны асуудлаар тогтвортой бодлого хэрхэн хэрэгжүүлж байгааг тодорхойлох индексээр манай улс 29.6 оноо авч дэлхийн 180 орноос 155 дугаар байрт, Ази номхон далайн 25 орноос 19 дүгээр байрт эрэмбэлэгдсэн тухай бичсэн байна². Энэхүү тайланд иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт, нөхцөл байдлыг 8 хуулийн хэрэгжилтийг үнэлэн тооцоолсон

¹ Хууль тогтоомжийн тухай хууль (2015)-ийн 51 дүгээр зүйлийн 51.2.

² Хүний эрхийн үндэсний комисс, *Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл*, 2023 он, 11 дэх тал.



байдаг. Энэхүү судалгаагаар хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад нөлөөлж буй хүчин зүйлүүдийн дотроос хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилт болон Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийн системийг сайжруулах боломжийг санал болж байна.

II. Сэдвийн судлагдсан байдал

Манай улсын хувьд хог хаягдлын менежмент, хүрээлэн буй орчны бохирдлын талаар доктор О.Болормаа³, доктор Б.Цогоо⁴ нар судалж, докторын зэрэг хамгаалсан байна. Б.Эрдэнэ, Д.Ичинхорлоо нар хог хаягдлын менежмент нэг сэдэвт бүтээл туурвисан байна. Мөн 2024 онд Хүний эрхийн үндэсний комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлээр "Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт, нөхцөл байдал"-ыг танилцуулсан.

III. Үндсэн хэсэг

Монгол Улсын Үндсэн хуульд иргэн "... эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй⁵" гэж заасан. Эрүүл, аюулгүй орчин нь шим ертөнц (хөрс, ус, агаар, ургамал, амьтан), нийгэм, хүний амьдралд халгүй, хор хөнөөлгүй, таатай боломжийн зохистой, түвшинд байснаар хангагдана. Зохистой түвшин (таатай боломжийн) гэдэг нь харьцангуй бөгөөд шинжлэх ухаан, техник, технологийн хөгжлийг даган тухайн цаг үеийн индексжүүлсэн үзүүлэлт нь хувьсан өөрчлөгдөх үзүүлэлтээр хэмжигдэнэ. Тухайлбал хөрс, ус, агаарын ариун чанар, эрүүл, аюулгүй байгаа эсэхийг тухайн үеийн үзүүлэлтээр зохистой төвшинд байгаа эсэхийг хянана гэсэн үг.⁶

Хог хаягдлын тухай хуулийг баталсан нь монгол хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах бодлогын зорилттой нягт уялдаатай.

Монгол Улсын Үндсэн хууль болон 1998 онд батлагдсан "Ариун цэврийн тухай хууль"-аар хувь хүнийг эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах орчноор хангах эрхийн талаар заасан бөгөөд, хүн амыг унд, ахуйн усаар хангахад тавигдах шаардлага, орчны агаарын чанарт тавигдах шаардлага, хөрсний ариун цэвэрт тавигдах шаардлагын талаар "Ариун цэврийн тухай хууль"-ийн 5, 6, 7-р зүйлд тусгасан байна.

"Хог хаягдлын тухай хууль"-ийг 2000 онд анх удаа баталсан бөгөөд хог хаягдлын менежменттэй холбоотой үйл ажиллагааг Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэхийг хориглох, экспортлох тухай (2000 он), ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай (2003 он), зарим нийлэг хальсан

³ О.Болормаа, Хүрээлэн буй эрсдэлийн үнэлгээ, бохирдлыг бууруулах метрохимийн үндэстэй цогц судалгаа, 2013, 8 дахь тал.

⁴ Б.Цогоо, Улаанбаатар хотыг үйлдвэрлэлийн болон автомашины хаягдлаас хамаарсан агаарын бохирдлын загварчлал, Байгалийн шинжлэх ухааны докторын диссертаци, 2012, 6 дахь тал.

⁵ Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн 16 дугаар зүйлийн 16.2.

⁶ Н.Лүндэндорж, Монгол улсын үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, 2024, 211 дэх тал.



уутны хэрэглээг хориглох тухай (2009 он) хуулиудаар зохицуулж байв. Эдгээр нь манай улсын хувьд хог хаягдлын менежментийн эрх зүйн орчны үндэс нь болсон юм.

2012 онд эдгээр хуулиудыг нэгтгэн шинэчлэн найруулж хог хаягдлын тухай хууль болгон баталсан нь 2017 оны 5 сарын 12-ны өдөр батлагдсан "Хог хаягдлын тухай хууль"-ийн үндэс болсон төдийгүй хог хаягдлын менежментийг үндэсний хэмжээнд сайжруулах далайцтай ажил болж хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах 3R зарчмыг танилцуулсан түүхтэй.

Сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгаагаар "Хог хаягдлын тухай" хуулиар зохицуулсан хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, практик хэрэгжилт хангалтгүй байгаа⁷-г тодорхой харж болно. (Хүснэгт. 1)

1 дүгээр хүснэгт: Хуулийн давхардал, зөрчил, хийдлийн судалгаа

№	Хог хаягдлын тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийн шалгуур	Хуулийн зүйл, заалтын тайлбар
Давхардал		
1	Тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн, эсхүл агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх;	Хуулийн 5.3-д хуульчилсан өмчлөх эрх дуусгавар болох хэм хэмжээний агуулгыг 5.4 дэх заалтад давтсан байна. Агаарын тухай хуулийн 20.6. Зориулалтын бус газарт хог хаягдал хаях, ил задгай шатаах болон хог хаягдал устгах стандартын шаардлага хангаагүй аливаа үйл ажиллагааг хориглоно. Энэ заалттай Хог хаягдлын тухай хуулийн 10.3.3-д "хог хаягдлыг ил задгай шатаах;" гэсэнтэй агуулгын хувьд давхардалтай.
2	Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх;	Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7-д ЗГ-ын баталсан энэ журмын – тайлангийн маягтыг БОАЭТЗТБ батлахаар хуульчилсан нь төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийн нэгдмэл байдлыг хангаагүй. - Хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 болон 8.3.5 дахь заалтуудын агуулга, зохицуулалт давхацсан.
Зөрчил		

⁷ "Байгаль орчны салбарын хуулиудын давхардал, зөрчил, хийдлийг арилгах дүн шинжилгээ хийх, салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах судалгаа," 2023, 336 дах тал.



1	Хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх;	<p>-Хуулийн 4 дүгээр бүлэг "Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах" гэсэн нэртэй. Энэ хуулийн 4 дүгээр зүйл дэх хуулийн нэр томъёоны тодорхойлолт дотор цэвэрлэх, булшлах гэсэн нэр томъёоны агуулга, хамрах хүрээг нарийвчлан тодорхойлоогүй.</p> <p>- Хуулийн 42.2.1. энэ хуулийн 7.1.1-д заасан үндэсний хөтөлбөрт хог хаягдлын талаарх боловсрол олгох зорилго, хэрэгжүүлэх арга хэмжээг тусгах". Энэ хуулийн 7.1.1 дэх дэд заалтыг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон тул энэ зохицуулалт зөрчилтэй.</p>
2	Хуулийн зүйл, заалт нь тухайн хууль болон өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх.	Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-ийн агуулга нь УИХ-ын хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үндсэн чиг үүргийг ⁸ зөвхөн "Засгийн газраас зохион байгуулж байгаа ажил" гэж хязгаарласан байна.
Хийдэл		
1	Тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх;	Хуулийн 8.1.12. хог хаягдлын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг батлах;" гэсний дагуу зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг баталсан эрх зүйн акт ЗХХАУНБүртгэл болон Эрх зүйн актын мэдээллийн нэгдсэн санд байхгүй байна.
2	Тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх этгээд нь тодорхой эсэх;	<p>Хуулийн 16.5. Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах байгууламжийн ажилтан тухайн ажлын байрны шаардлагад нийцсэн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн байна" хэрэгжүүлэх субъект тодорхойгүй.</p> <p>Хуулийн 16.2. Энгийн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагаанд хяналт тавих төлөвлөгөөг боловсруулж, байгууллагын удирдлагаар батлуулсан байна". Ямар байгууллага нь тодорхойгүй.</p> <p>Энэ хуулийн 10 дугаар зүйлд хуульчилсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх үүргийг тус тусад нь хуулийн зүйл болгон хуульчлаагүй тул эрх, үүргийн хувьд тодорхой зааг байхгүй байна.</p>

⁸ Монгол Улсын Их хурлын тухай хууль (2024)-ийн 3 дугаар зүйлийн 3.2.



3	Төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудал шийдвэрлэхээр хуульд заасан бол уг асуудлыг шийдвэрлэх хугацааг тодорхой заасан эсэх;	Хуулийн 14.4. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоож, сум, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөнө, гэсэнд батлах хугацаа тодорхойгүй. Хуулийн 16.2. Энгийн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагаанд хяналт тавих төлөвлөгөөг боловсруулж, байгууллагын удирдлагаар батлуулсан байна.
4	Хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх;	Хуулийн 8 дугаар зүйлийн 8.8.2. хог хаягдлыг сэргээн ашиглах үйл ажиллагаанаас гарган авсан эрчим хүчний үнийн тооцоог хянах, тарифыг батлах гэсэн дээр нэмж тайлан гаргах гэх Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1. хог хаягдлын талаар төрөөс баримтлах бодлогын+хууль тогтоомжийн гэж нэмэх хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;
5	Хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь ойлгомжтой байгаа эсэх.	Хуулийн 19.1. Ландфиллыг бүрэн болон хэсэгчлэн хааж болно гэсэн нь хаах үндэслэл тодорхойгүй. Хаах шийдвэрийг ямар субъект гаргах нь тодорхойгүй. Хуулийн 10.2.18. аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах, аюулгүй ажиллагааг хангах. Энэ заалт дахь шаардлагатай арга хэмжээ гэдэгт ямар үйл ажиллагаанууд хамаарах тухай нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Хог хаягдлын тухай хуульд дээрх давхардал, зөрчил, хийдэл байгааг мэргэжлийн шинжээч судалсан байна. Энэ хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд нөлөөлөхүйц хүчин зүйл юм.

2012 оны хог хаягдлын тухай хуульд хог хаягдлын хууль тогтоомж зөрчсөн талаарх мэдээллийг мэдээлсэн хүнд урамшуулал олгох тухай нарийвчилсан зохицуулалт байгаагүй бөгөөд зөвхөн улсын мэргэжлийн хяналтын байгууллага, албан тушаалтан, бүх шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих тухай ерөнхий агуулга бүхий ойлголтыг хуульчилсан байв.

Харин 2017 онд шинэчлэн найруулсан тус хуулиар хог хаягдлын талаарх зөрчлийг мэдээлсэн хүнд урамшуулал олгох тухай зохицуулсан нь хүрээлэн буй орчны гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг илрүүлэх, түүнээс улбаалан гарч буй хор уршгийг олон нийтэд таниулахад чухал нэмэр болох ойлголтыг оруулсан гэж үзэхээр байна⁹.

Хог хаясан нь тогтоогдсон тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар иргэнийг 300 мянга, хуулийн этгээдийг 3 сая төгрөгөөр торгох¹⁰ эрх зүйн зохицуулалттай.

⁹ Хог хаягдлын тухай хууль (2017)-ийн 41 дүгээр зүйлийн 41.2.

¹⁰ Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 6 дугаар зүйлийн 6.1.



Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг мэдээлэх, үүнд иргэдийн оролцоог хангах бол манай улсын байгаль орчин, хүрээн буй орчны эрх зүйн салбарт анхаарах ёстой нэг асуудал болж байгаа бөгөөд энэ талаар жишээ нь хог хаягдлын тухай хуульд гэхэд ердөө ганцхан зүйл ангиар зохицуулалт хийж өгсөн¹¹ нь хүрээлэн буй орчны гэмт хэрэг зөрчлийг илрүүлэхэд иргэдийн оролцоог хангах талаар эрх зүйн хэм хэмжээ, нэмэлт зохицуулалт шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол Улсад хог хаягдлын тухай гэмт хэрэг, зөрчилд эрүүгийн хуулиар хариуцлага тооцохоор хуульчилж, 2002 оноос Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, 2017 оноос Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын болон Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг гэдэг төрөлд хамааруулж ирсэн. (Хүснэгт 2)


2 дугаар хүснэгт: Хог хаягдлын тухай гэмт хэрэг, зөрчилд эрүүгийн хуулиар хариуцлага тооцох төрөл, зүйл

Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002 он	Монгол Улсын Эрүүгийн хууль, 2017 он	Хамаарах зөрчил, гэмт хэрэг
Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	Аюултай хог хаягдал, химийн хорт, аюултай бодисыг хаях үйлдлүүд
	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	Агаар бохирдуулах, байгаль орчныг бохирдуулах, химийн гаралтай хорт бодис, үйлдвэрлэлийн хог хаягдал цэвэрлэх, тээвэрлэх, булшлах журам зөрчих, газрын хөрс, усыг бохирдуулах, химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж зөрчих зэрэг үйлдлүүд

Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж, шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн тоо өнгөрсөн жилүүдэд тогтмол өсөлттэй явж ирсэн байна¹² (зураг).

¹¹ Хог хаягдлын тухай хуулийн (2017)-ийн 41 дүгээр зүйлийн 41.13.

¹² Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, "Гэмт хэргийн статистик-2022," 2023, 5 дахь тал, <https://downloads.1212.mn/hZlI2rb2ltdtpFKFS-Ml-4rBs7xxGsGO5nZfDsu8.pdf>.



Зураг 1. Хог хаягдлын тухай гэмт хэрэг, зөрчилд эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэсэн гэмт хэргийн үзүүлэлт

Үндэсний статистикаар дээрх ангилал, төрөл зүйлд ерөнхийд нь хамааруулж шийтгэл оногдуулж, хариуцлага тооцож байгаа нь хог хаягдлын тухай хууль, тогтоомжийн зүйл, заалтын зөрчлийг нарийвчлан авч үзэх, түүний мөрөөр арга хэмжээ авах боломжийг бүдгэрүүлж байна.

2020 оны эхний 11 сард Зөрчлийн тухай хуулийн 7.15.8 /усан сан бүхий газарт хог хаягдал хаях/ дахь хэсгээр улсын хэмжээнд 128 зөрчил бүртгэгдсэн талаар дээрх тайланд дурдсан байна. Эдгээрээс үзвэл хог хаягдлын талаарх гэмт хэргийн гаралт, түүний илрүүлэлт тун бага хувьтай байгаа бөгөөд жилд 3 удаагийн гэмт хэргийн тохиолдол бүртгэгдсэн байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх үйл явц, түүнд нөлөөлөх хууль эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Улаанбаатар хотын хог хаягдлын менежментэд тулгарч буй сорилт, бэрхшээл

Монгол Улсын Засгийн газраас хог хаягдлын менежменттэй холбоотой асуудал, бэрхшээлүүдийг даван туулж, шийдвэрлэх ажлын хүрээнд хууль эрх зүйн орчныг сайжруулж, бодлогын чанартай олон арга хэмжээг үе шаттай авч байгаа. Гэвч үндэсний хэмжээнд бодлого, зохицуулалтын хувьд дараах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд:

- Нийслэл, орон нутгийн түвшинд хог хаягдлын менежментийн удирдлага зохион байгуулалтын бүтэц (институци), санхүүгийн менежментийг оновчтой болгох;
- Инженер, техникийн ажилтнууд болон хүний нөөцийг системтэй бэлтгэж чадавхжуулах, технологи, инновацыг нутагшуулж, нэвтрүүлэх;
- Олон удаагийн хуулийн нэмэлт өөрчлөлт, тогтворгүй засаглал, сонгуулийн тогтолцоотой холбоотойгоор улс төрийн нам хүчин солигдоход тухайн асуудлыг хариуцсан албан тушаалтан, мэргэжилтнүүд, тэдний үүрэг, хариуцлага байнга солигддог, бодлогын тодорхойгүй, тогтворгүй байдал;
- Салбар хоорондын байгаль орчны талаарх хууль эрх зүйн орчны уялдаа холбоо сул;



- Хог хаягдлын болон бусад салбаруудын бодлогын уялдаагүй бүтэц, зохион байгуулалт нь нөөцийг оновчтой ашиглах, чадавхжуулах бүхий л боломж, нөөцийг алдагдахад хүргэж байна.

IV. Дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн хоёрт эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан. Үндсэн хуульд хуульчлан заасан энэ эрхийг бусад хуулиудаар баяжуулан хүний эрхийг хангаж ажиллах нь хууль тогтоох байгууллагын үүрэг. Нөгөө талаас иргэний эрхийг хангах хүрээнд төр тухайн эрхэд хамаарах үзүүлэлтүүдийг гаргаж тухайн цаг үед нийцсэн хэмжилт хийж байхыг ойлгоно гэж Үндсэн хуулийн тайлбар тольд тайлбарлан бичсэн байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Усны тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн Хог хаягдлын тухай хуулийн найруулгыг шинэчлэн баталсан. Энэ хуулиар хог хаягдалтай холбоотой харилцааг зохицуулж байна.

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар хог хаягдлын төвлөрсөн 396 цэг байгаа бөгөөд эдгээр нь нийтдээ 3811.6 га талбайг эзэлж байна. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн тоог 2021 онтой харьцуулахад 9 цэг буюу 2.3 хувь, төвлөрсөн цэгийн талбай 104.7 га талбай буюу 2.8 хувиар тус тус өссөн байна. Улсын хэмжээнд цуглуулж, тээвэрлэсэн энгийн хатуу хог хаягдлын хэмжээ 2020 онд 2244.0 мянган тонн байсан бол 2021 онд 2402.5 мянган тонн болж, 7.1 хувиар нэмэгдсэн байна. 2021 онд 2402.5 мянган тонн байсан бол 2022 онд 2496.5 мянган тонн болж, 3.9 хувиар нэмэгдсэн байна¹³.

Дээрх тоо баримтаас харахад хог хаягдлын тухай хуульд давхардал, зөрчил, хийдэл нь хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэж болохоор байна. Иймд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд;

- Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх;
- Хог хаягдлын тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах;
- Хог хаягдлын тухай хуульд хууль бусаар хог хаяж байгааг баримтжуулан мэдээлсэн иргэнд олгох урамшууллыг нэмж, тухайн дүүргийн иргэдийн хурал нь үүнийг иргэдэд уриалдаг байх, харин хууль зөрчсөн этгээдийн нарийвчлан шалгаж, аюултай хог хаягдал хаясан тохиолдолд зөрчлийн хуулиар торгоод өнгөрөх биш эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байх;
- Хог хаягдлын талаар боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сургуулийн өмнөх болон бага,

¹³ Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорвоо, *Хатуу хог хаягдлын данс*, 2022, 7 дах тал, https://downloads.1212.mn/CnDXenDYFO6eT1-Ess9US_yln-Kp9QLgj-CnP9_.pdf.



дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын сургалтын хөтөлбөрт хог хаягдлын талаарх боловсролын агуулгыг тусгах гэснийг хассан нь иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилттой харшсан. Тухайн байгууллага нь хог хаягдлын талаар иргэдийн боловсролыг дээшлүүлэх, бага наснаас нь эхлэн хог хаягдлын талаар сурталчлан таниулах үүрэгтэй оролцох нь зүйн хэрэг гэж үзэж байна.

- Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулахын тулд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүрэн хариуцаж 21 аймаг Улаанбаатар хотын хог хаягдлын талаар нэгдсэн бодлого, арга зүйн хувьд системтэй ажилласнаар хог хаягдлын хэмжээ бодитоор буурч болно.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Монгол Улсын Их хурлын тухай хууль, 2024 он.
3. Хог хаягдлын тухай хууль, 2017 он.
4. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он.
5. Зөрчлийн тухай хууль, 2017 он.

Б. Ном, сурах бичиг

1. Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар*, 2024 он.

В. Эрдэм шинжилгээний бүтээл

1. О.Болормаа, "Хүрээлэн буй эрсдэлийн үнэлгээ, бохирдлыг бууруулах метрохимийн үндэстэй цогц судалгаа," 2013 он.
2. Б. Цогоо, *Улаанбаатар хотыг үйлдвэрлэлийн болон автомашины хаягдлаас хамаарсан агаарын бохирдлын загварчлал*, Байгалийн шинжлэх ухааны докторын диссертац, 2012 он.

Г. Бусад

1. "Байгаль орчны салбарын хуулиудын давхардал, зөрчил, хийдлийг арилгах дүн шинжилгээ хийх, салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах судалгаа," 2023 он.
2. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, "Гэмт хэргийн статистик-2022, <https://downloads.1212.mn/hZlI2rb2ltdtpFKFS-Ml-4rBs7xxGsGO5nZfDsu8.pdf>.
3. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, *Хатуу хог хаягдлын данс, 2022*, https://downloads.1212.mn/CnDXenDYFO6eT1-Ess9US_yIn-Kp9QLgj-CnP9_-.pdf.
4. Хүний эрхийн үндэсний комисс, "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл," 2023 он.
5. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал, *legalinfo.mn*, 2016 он.

**Abstract****WASTE MANAGEMENT ISSUES IN ENSURING HUMAN HEALTH AND THE RIGHT TO LIVE IN A SAFE ENVIRONMENT****MARAL, B.**

*Ph.D. candidate in national security studies, Officer,
Office of the Chairman of the State Great Hural (Parliament) of Mongolia*

Among the rights stipulated in the Mongolian Constitution, waste management is of paramount importance in ensuring the right to live in a healthy and safe environment. Relations related to waste are regulated by the Law on Waste. The development of any social relationship, phenomenon, or process is measured by the legal framework that regulates it and the level of its implementation. The amount of waste in Ulaanbaatar city is increasing year by year, and whether there are errors in laws and regulations or whether management is faulty is a factor affecting the right of Mongolians to live in a healthy and safe environment.

Keywords: Waste, law, legal environment, waste management.

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

С.БЯМБА-ЭРДЭНЭ¹

I. Оршил

II. Үндсэн хэсэг

- Монголын төр эрх зүйн түүхийн эртний үед /МЭӨ III-МЭ XIII зуун/
- Монголын төр эрх зүйн түүхийн дундад зууны үед /XIII-XX зууны эх/
- Монголын төр эрх зүйн түүхийн шинэ үед /XX зууны 20-оод оноос 90 он/
- Монголын төр эрх зүйн түүхийн нэн шинэ үед /XX зууны сүүлч 90 оноос хойших/

III. Дүгнэлт

¹ Их Засаг Олон Улсын их сургуулийн докторант.



МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

С.БЯМБА-ЭРДЭНЭ *Их Засаг Олон Улсын их сургуулийн докторант.*

Түлхүүр үг

Иргэний хэргийн шүүх, шүүх эрх мэдэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа.

Хураангуй: Монгол Улсад шүүх байгууллагын бие даасан тогтолцоо, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж ирсэн түүхийг ардын хувьсгал ялж, 1921 онд Ардын шүүх үүсэх нөхцөл бүрдэж, 1924 оны анхны Үндсэн хуулиа баталж, 1926 оноос анхны шүүх албан ёсоор байгуулагдан монгол гэрт үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн цаг мөчөөс эхлэн тоолдог. Харин монголын эрт цагийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх эрх мэдлийг хэн хэрэгжүүлж байсан, тухайн цаг мөчид бие даасан шүүхийн тогтолцоо байсан эсэхийг Монголын төр, эрх зүйн түүхийн хүрээнд судалж мэдэх нь өндөр ач холбогдол дагуулна. Учир нь ардын хувьсгал ялахаас өмнө шүүх эрх мэдлийг олон зууны туршид хаад, ноёдод төвлөрүүлсээр ирсэн бөгөөд анхны Үндсэн хуулиа баталж, шүүх эрх мэдлийг ардын шүүхэд шилжүүлсэн байдаг. Хэдий эрт дээр үед шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, шүүн таслах эрх хаад, ноёдод олгогдож, зарлиг, шийдвэр нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил эрх зүйн бичмэл болон бичмэл бус акт байсан бөгөөд зарлигийг гүйцэтгэх процесс нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эхлэл болж хөгжиж ирсэн талаар энд өгүүлэх болно.

I. Оршил

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний хэргийн шүүхээс гарсан хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хариуцагч сайн дураар биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэрийг үндэслэн гаргасан шүүгчийн албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудсыг үндэслэн эрх бүхий этгээд иргэний шийдвэр гүйцэтгэлийн баталгаажуулах арга хэмжээг хэрэглэх замаар иргэний зөрчигдсөн эрхийг сэргээж, хохирлыг нөхөн төлүүлэх цогц арга хэмжээ билээ. Уг арга хэмжээнд хамааруулж шүүх засаглал, шүүн таслах ажиллагаа /хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа/, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн түүхэн уламжлалыг судлан мэдэх нь онолын өндөр ач холбогдолтой юм. Тухайлбал,

Шүүн таслах ажиллагаа бүр өнө эртнээс бий болсон бөгөөд эртний Ромд гэхэд л удаан хугацааны туршид хөгжиж олон хэлбэрийг бий болгосон. Товч



дурдвал хуульд хатуу заасан хэлбэрээр явагддаг *Legis actio* байцаан шийтгэх ажиллагаа, мэргэжлийн хуульч преторийн өгсөн зааврын дагуу хэргийг шийдвэрлэдэг *Per formulas* байцаан шийтгэх ажиллагаа, эзэн хааны эрх мэдэлд байдаг, харгис хэрцгий байцаалтын аргаар явагддаг *Extra Ordinem* буюу онцгой байцаан шийтгэх ажиллагаа зэрэг хэлбэрүүд байжээ¹. Хувийн эрх зүй үүсэж хөгжсөн эртний Ромд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тухайн үеийн хааны албат, мэргэжлийн хуульчид хэрэгжүүлж байсан боловч шүүх эрх мэдэл хааны гарт төвлөрч байсан.

Нэрт эрдэмтэн С.Нарангэрэл бүтээлдээ "Шүүн таслах ажиллагаа (лат. *Justice*; англ. *justice*) – төрийн үйл ажиллагааны хуульд үндэслэгдсэн хараат бус, тал тохой татдаггүй, шударга шүүхээс бүрдэх онцгой төрөл. Монгол Улсын Үндсэн хуульд эл нэр томъёог хэрэглэсэн" гэж тайлбарлажээ².

Доктор Б.Буянхишиг бүтээлдээ "Соён гэгээрлийн сэтгэлгээ Европын улс орнуудад хувийн эрх зүйн кодификац³ бий болох гол түлхэц болсон бол Монголын нийгэм, улс төрийн нөхцөл байдал дээрх орнуудтай ижил байгаагүй илт" гэж цохон тэмдэглэжээ⁴. Ромын эзэнт гүрэнтэй адилтгахуйц эрх зүйн томоохон бүлд Монголын нүүдэлчин улс үндэстнүүд хамрагдаж байсан хэмээн судлаач П.А.Фейрбах 200 жилийн өмнө тэмдэглээд үүний *Pax Mongolica* хэмээн нэрлэсэн байдаг⁵.

Монгол Улсын иргэний хэргийн шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн түүхэн уламжлалыг монголын төр, эрх зүйн түүхийн үечлэл тус бүрээр он цагийн түүхэн цаг хугацаанд судлах нь судалгааны ач холбогдлыг дагуулна.

Монголын төр, эрх зүйн түүх судлалд үнэтэй хувь нэмэр оруулсан доктор (Sc.D) И.Дашням "Монголын Улсын төр, эрх зүйн түүх (НТӨ III- НТ V зуун)" бүтээлдээ Монгол Улсын төр, эрх зүйг түүхийн түүний хөгжлийн үечлэлийн дагуу судлах хэрэгтэй хэмээгээд түүхэн хөгжлийг хүн төрөлхтний болон монголын соёл иргэншлийн хөгжлийн ерөнхий үе шат, алив үзэгдлийг үечлэхэд баримталдаг зарчим, шалгуур, арга зүйг ашиглан эртний үе, дундад үе, шинэ үе, нэн шинэ үеийн төр эрх зүй хэмээн 4 хэсэгт хуваан ангилдаг гэж тэмдэглэжээ⁶.

Судлаачийн зүгээс монголын төр, эрх зүйн түүхэн үечлэл тус бүрд иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ойлголтыг хэрхэн тусгаж ирсэн талаар түүхэн эх сурвалж, баримтуудад үндэслэн тайлбарлах, дүгнэлт хийх, санал дэвшүүлэх зорилгоор энэхүү өгүүллийг бичлээ. Мөн зорилгын хүрээнд дараах 4 зорилтыг дэвшүүлж байна.

¹ М.Х.Хунтыз, *Римское частное право*, 1995, 28 дахь тал.

² Б.Нарангэрэл, *Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг*, 2021, 583 дахь тал.

³ Кодификац гэдэг нь тухайн актад нэмэлт өөрчлөлт оруулах, хуучирсан заалтыг хүчингүй болгох, шинээр хэм хэмжээ тогтоох зэргээр төрөлжүүлэн цэгцэлж янз бүрийн өөрчлөлт, шинэчлэлтийг тухайн төрлөөр нь цэгцэлж системчлэх арга. Д.Баярсайхан, *Эрх зүйн онол*, 2020, 140 дэх тал.

⁴ Б.Буянхишиг, *Монгол Улсын Хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт*, 2021, 17 дахь тал.

⁵ Radbruch: Anselm Feuerbach in VR 305 S, Wien 1934, S. 193. Б.Буянхишиг, *Монгол Улсын Хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт*, 2021, 17 дахь тал;

⁶ И.Дашням, *Монголын Улсын төр, эрх зүйн түүх (НТӨ III- НТ V зуун)*, Тэргүүн боть, УБ., 2012, 16 дахь тал.



1. Монголын төр, эрх зүйн түүхийн эртний үед иргэний хэргийн шүүх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ойлголт ямар түвшинд байсан эсэх талаар судлах,
2. Монголын түүхэнд дундад зууны үед шүүх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэлбэр хэрхэн хөгжиж байсан эсэх талаар судлах,
3. Монголын төр эрх зүйн түүхийн шинэ үед иргэний хэргийн шүүх, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэрхэн хөгжиж ирсэн талаар судлах,
4. Монголын төр, эрх зүйн түүхийн нэн шинэ үед буюу орчин үеийн иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хөгжлийн талаар судлах.

II. Үндсэн хэсэг

1. Монголын төр эрх зүйн түүхийн эртний үед /МЭӨ III-МЭ XIII зуун/

"Монгол газар нутагт 200 мянгаад жилийн тэртээ хүмүүс амьдран сууж, хоёр мянган жилийн өмнө төр ёс тогтсон билээ⁷. Гэвч төр улс үүсэхээс өмнө тогтсон хууль, цааз нь зөвхөн зан заншил дээр тулгуурлан нүүдлийн соёл иргэншилд нийцүүлэн заншлын эрх зүй хөгжсөн байдаг. Эртний улс, орнуудад төрийн бүх эрх мэдэл тэр тусмаа шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх нь хэмжээгүй эрхт хааны гарт төвлөрч, хааны гаргасан зарлиг, цааз нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил эрх зүйн хүчин чадалтай акт байсан.

Монголын төр эрх зүйн түүхийн эртний үеийг одоогоос 2200 гаруй жилийн өмнө эртний нүүдэлчин овгуудыг МЭӨ 209 онд нэгдсэн захиргаанд холбон зангидаж, Хүннү гүрнийг үндэслэн байгуулсан Модун Шаньюгийн төр улсаа удирдан жолоодож явсан тухайн цаг мөчөөс эхлүүлж, Хүннү гүрэнг мөхсөний дараа төр эрх зүйн түүхийг залгамжилж, оршин тогтнож байсан Сүмбэ, Нирун, Хятан, Түрэг, Уйгар, Кидан зэрэг эртний улсуудын төр эрх зүйн түүхийг хамруулан ойлгоно.

Нэрт эрдэмтэн С.Нарангэрэл "Заншлын эрх зүй гэдэг нь удаа дараа уламжлагдан хэрэглэгдсэн ба засаг төрөөс зөвшөөрсний үр дүнд нийгэмд бүрэлдэн тогтсон зан үйлийн журмын (заншлын) нийлбэр цогц" гэж тайлбарласан⁸.

Доктор Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар Хүннүгийн эрх зүйн хэм хэмжээний уг гарвал нь зан заншлын ёс горимууд байсан. Хүннүгийн хууль цааз хатуу чанд учраас зүрхлэн зөрчигчид цөөхөн байжээ⁹ гэж цохон тэмдэглэжээ.

Доктор Г.Баярхүү "Хүннү, Кидан гүрний үед нийгмийн харилцааг заншлын хэм

⁷ Г.Баярхүү, *Монголын нэгдсэн төрийн болон дараа үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь /XIII-XVIII зуун/,* сэдэвт хууль зүйн ухааны дэд докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол, Уб., 1995, 2 дахь тал.

⁸ С.Нарангэрэл, *Эрх зүйн толь бичиг.* Уб., 2007, 201 дэх тал. Д.Баярсайхан, *Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал.* Уб., 2012, 109 дэх тал.

⁹ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. *Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал.* Уб., 1997, 19 дэх тал. Д.Баярсайхан, *Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал.* Уб., 2012, 120 дахь тал.



хэмжээгээр зохицуулж байсан нь хаадын зарлиг, хад, чулуу, хашаанд сийлсэн бичээс зэргээс батлагдана¹⁰ гэж үзжээ.

Хүннүгийн төр, эрх зүйн түүх судлаач Г.Сүхбаатар "Хүннүгийн хууль бичигдмэл бус бөгөөд овгийн байгууллаас уламжлалтай, аливаа хориглох заншилд тулгуурласан, хэв хуулийн шинжтэй байсан гэж үзэх үндэслэлтэй" гэж бичсэн байдаг¹¹.

Доктор Д.Баярсайхан "Хэв хууль гэдэг ойлголт нь эдүүгээгийн Хууль гэсэн нэр томъёоноос огт өөр бөгөөд энэ нь нэг талаас овгуудын холбоо, угсаатны нийтлэг зан үйлийн уламжлалаас үүдэлтэй нүүдлийн ёс заншлын хорио цээрийн болон тогтвортой, албан ёсны дэг жаяг, хэв ёсны горимуудыг агуулдаг бол нөгөө талаас төрөөс хамгаалагдсан буюу хаан, захирагч, зонхилогчдын тогтоон хэвшүүлсэн цааз, зарлиг, хориг, хэвшүүлэлт, тэдгээрийн хууль цаазын холбогдол бүхий хэм хэмжээнүүдийг мөн адил илэрхийлнэ" гэж бичжээ¹².

Судлаач Б.Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав нар "Хаант засаглал бүхий эртний улс, орнуудад шүүн таслах үйл ажиллагаа гагцхүү хааны хүсэл зоригоос шууд хамааралтай, хаан шүүн таслах дээд эрхийг эдэлж, харин зарим нэгэн түшмэлд тусгайлан шүүгч, заргач гэх мэт цол өргөмжлөн томилж, хааны аман болон бичгийн хэлбэрээр үйлдэгдсэн зарлиг, нийгэмд үйлчилж буй шашны болон заншлын хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, зарим нэгэн шийтгэл ногдуулж байсан ажээ. Энэхүү хэлбэрийг монголчууд бие даасан шүүхтэй байсан гэж үзэх боломжгүй" гэж үзжээ¹³.

Тухайн цаг мөчид нүүдэлчин ард түмэнд гойд нийцэж байсан заншлын эрх зүй хүчтэй хөгжиж байсан агаад хэмжээгүй эрхт хааны зүгээс гүйцэтгэх, шүүх, хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж, хааны зарлиг нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил хэрэгжиж байсан бөгөөд бие даасан шүүх байгаагүй ч иргэний хэргийн шүүх, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны анхны хэлбэр нь хааны зарлиг гаргасан гүйцэтгэх алба, зарлиг гүйцэтгэх ажиллагаа гэж хэлж болно.

2. Монголын төр эрх зүйн түүхийн дундад зууны үед /XIII-XX зууны эх/

Нэгт, Эзэн богд Чингис хааны 1206 онд үүсгэн байгуулсан Их Монгол Улсад төрийн бүх эрх мэдэл хэмжээгүй эрхт хаант засаглалыг хэрэгжүүлэгч их хааны мэдэлд байсан.

Чингис хаан өөрийн феодалын хүчирхэг нэгдсэн улсдаа чухал хууль, цаазыг тухай бүр зарлиг буулган Улсын заргач Шихихутугаар зохиолгож байснаас хамгийн алдартай нь Их засаг хууль билээ.

Академич Ч.Далай өөрийн бүтээлдээ "Их Монгол Улсын төрийн гол хууль бол Засаг хууль байлаа. Рашид-Ад-Дини "Судрын чуулган"-д Засаг хуулийг 1210, 1218 онд Их хуралдайгаар хэлэлцэж, нэмэлт оруулав. Мөн тэр үедээ зарлиг гаргаж

¹⁰ Г.Баярхүү, *Монголын нэгдсэн төрийн болон дараа үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь /XIII-XVIII зуун/*. Хууль зүйн докторын диссертац. УБ., 1995, 43 дахь тал.

¹¹ Г.Сүхбаатар, *Монголын эртний түүх судлал I боть. Монголчуудын эртний өвөг*, 2000, 73 дахь тал.

¹² Д.Баярсайхан, *Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал*, 2012, 121 дэх тал.

¹³ Б.Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав, *Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн дүн шинжилгээ* (Улаан хацарт), 2010, 15 дахь тал.



засаг хуулийг "Их засаг" гэж нэрлэтүгэй хэмээн тушаав" тодотгон бичжээ¹⁴. Эл хуулиар хүний жам ёсны эрхийг шударга шүүхээр хамгаалах урьдач нөхцөл болсон гэж үзэж болно. Тухайлбал,

Их засагт иргэний эрх зүйтэй холбоотой заалт ховор боловч тэр бүр нарийвчилж зааж өгөөгүй. Жишээ нь, "Их түшмэд бусад ард иргэд үхсэн хойно хэн ч энэ эд хөрөнгөд нь халдаж болохгүй, үхэгсэд залгамжлах үр хөвгүүнгүй болбоос эд хөрөнгийг түүний шавь буюу зарцад өгч болохоос биш, Улсын санд оруулж болохгүй" гэж заасан байдаг¹⁵.

"Манай нэрт түүхч Ш.Сандаг, Н.Ишжамц нарын бүтээл болон сурвалж бичгүүдэд өгүүлснээр Чингис эхлээд улсаа гурван том хэсэгт хуваарилаад Боорч, Мухлай, Наяа гурван ноёноор захируулж, Шихихутгийг хууль цаазны дээд эрхтэн "Улсын заргач" /шүүгч/ болгожээ¹⁶. Үүнээс харахад Чингис хаан шүүн таслах ажиллагааны эрхийг Шихихутугт өгсөн явдал нь шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үүсэл, хөгжлийн эртний эх сурвалж болохуйц түүхэн баримт болно.

Судлаач Т.Байгалмаа бүтээлдээ "Их Монгол Улсын үед шүүн таслах дээд эрхийг их хаан, түүнээс эрх олгосны дагуу Төрийн заргач хэмээх албан тушаалтан хэрэгжүүлж байсан. Их хаанд шүүхийн дээд эрх мэдэл байдаг ч хэрэг дээрээ Төрийн заргач хэмээх албан тушаалтан, түүний түшмэд шүүхийн тогтолцооны цөм болж байсан гэхэд хилсдэхгүй" гэж бичжээ¹⁷.

Эзэн Богд Чингис хаан шүүн таслах дээд эрхийг /Орчин цагийн Дээд шүүхийн эрх/ өөрт үлдээж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх эрхийг өөрийн нэрийн өмнөөс Шихихутугт шилжүүлэн өгч улсын заргач болгосон нь монголын түүхэнд дэх шүүхийн байгууллагын үүсэл хөгжлийн эхлэл болохуйц үйл хэрэг билээ.

Хоёрт, Чингис хааны залгамжлагч их хаан Өгөөдэй Их Монгол Улсыг эзэнт гүрэн болгон хөгжүүлснээс эхлээд Монголын эзэнт гүрний сүүлчийн их хаан Мөнх нас барсны дараагаас Монголын эзэнт гүрэн задарч, Хятадад Юань улс, дундаж азид Цагаадайн улс, Иранд Хүлэгүгийн удмын Илхаадын улс, орос, казахстанд Зүчийн удмын Алтан ордны улс бие даасан шинжтэй байсан. XIII-XIV зуунд дэлхийн сая сая ард түмнийг нэгтгэн холбосон монголчууд тухайн цаг мөчдөө супер их гүрний хэмжээнд дэлхийн бодлогыг тодорхойлж байсныг бид мартаж өсгүй. Их Монгол Улсын төрт ёсны чухал эрх зүйн эх сурвалж Их засаг хууль нь эзэнт гүрэн, Чингис хааны үр ач нарын байгуулсан тус тусын улсад хэрэглэгдэж ирсэн уламжлалтай.

Доктор Т.Мөнхжаргал бүтээлдээ "Монгол нутагт Их засаг хууль цаашид үйлчилсэн хэвээр байсан гэх боловч хятад хэсэгт нь Алтан улсын хууль эхэн үед нь үйлчилж улмаар Хубилай хааны санаачилсан "Их Юань Улсын нэвтэрхий толь", "Их Юань Улсын хууль цаазын бичиг" гэсэн 2 чухал эх сурвалж голлох үүрэгтэй

¹⁴ Ч.Далай, *Их Монголын Улс*, 2006, 315 дахь тал. Б.Баярсайхан, *Монголын эрх зүйн түүх, соёлын судалгаа*, 2021, 19 дэх тал.

¹⁵ О.Отгонтуяа, О.Амарсанаа, *Иргэний эрх зүй*, 2022, 34 дэх тал.

¹⁶ Г.Баярхүү, *Монголын нэгдсэн төрийн болон дараа үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь /XIII-XVIII зуун/. Хууль зүйн ухааны докторын диссертаци*, 1995, 46 дахь тал.

¹⁷ Т.Байгалмаа, *Шүүн таслах ажиллагаан дахь мэтгэлцэх зарчим*, 2014, 19 дэх тал.



байжээ" гэж бичжээ¹⁸.

Доктор И.Дашням бүтээлдээ "Их Юань Улсын нэвтэрхий толь, Их Юань Улсын хууль цаазын бичиг зэрэгт хууль тогтоомжийн бичмэл актуудаас гадна заншлын хэм хэмжээний систем хамрагдаж байв. Тухайлбал, аж ахуй эрхлэх, хөтлөн явуулах, арилжаа солилцоо хийх, нүүдэл, суудал, аян жин тээх, мал маллах, ан авлах, ашиг шимийг нь хүртэх, гэр барих, гэр бүл болох, үр хүүхдээ хүмүүжүүлэх зэрэг иргэний эрх, үүрэгтэй холбоотой зохицуулалт агуулагдаж байв. Дээрх эх сурвалж нь хэв шинжийн хувьд Дорно дахины, Азийн хэв маягтай, олон төрлийн харилцааг зохицуулсан хэм хэмжээгээ төрөлжүүлэн бүлэглэсэн эмхэтгэлийн шинжтэй байжээ" гэж тэмдэглэсэн байна¹⁹.

Шүүх эрх мэдлийг хаан хэмжээгүй эрхт засаглалынхаа хүрээнд хэрэгжүүлж байсан боловч угтаа Их засаг хуулийн хүрээнд өөрийн шүүх эрх мэдлийг албат, зарлиг гүйцэтгэгчид олгож байгаа үйл хэрэг нь шүүх засаглалыг хаан, түүний албат дангаар эдэлж байсны илрэл болно. Жишээ нь:

Нэрт эрдэмтэн С.Нарангэрэл "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо" бүтээлдээ "Зарим судлаачид шүүн таслах үйл ажиллагаа, шүүхийг Их Монгол Улсын үеэс буюу 1206 оноос нарийн тогтолцоотой байсан мэтээр "Шүүхийг боловсронгуй болгох" гэж оролцож байсныг Их засаг хууль харуулдаг²⁰ гэж бичжээ.

Доктор Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар "Бидэнд мэдэгдэж байгаагаар "Их засаг" хууль тухайн үеийн шүүхийн тогтолцоо, зохион байгуулалтыг тусгасан заалт үгүй боловч, шат шатны шүүн таслах үүргийг хэв хуулийн дагуу түмт, мянгат, зуут, аравтын ноёд гүйцэтгэж, онц аюултай гэмт хэрэгтнийг хаан, улсын заргачид өргөн мэдүүлж шүүж байжээ²¹ гэж үзжээ.

Б.Лхагважав, Б.Батбаяр, Б.Баярсайхан нар "Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн дүн шинжилгээ (Улаан хацарт)" бүтээлдээ "Аливаа этгээдээс тогтсон зан үйл, зан заншил, ёс суртахууны зэрэг нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ зөрчсөн үйлдэлд овгийн ахлагч, хаан, засаг ноёд, тусгайлан эрх олгосон түшмэл гэх мэт албан тушаалтан, язгууртнууд өөрсдийн үзэмжээр шийтгэл ногдуулж байсан түүхэн хөгжлийн үйл явцыг шүүн таслах ажиллагааны нэг хэлбэр гэж үзнэ" гэж тайлбарласан байна²². Хааны зарлиг гүйцэтгэгч "Чинсан²³"-ний талаар энд дурдахгүй өнгөрч болохгүй буйзаа. Тухайлбал, Чингис хааны удаах залгамжлагч Өгэдэй их хаан анх Алтан улсын бууж

¹⁸ Т.Мөнхжаргал, *Монгол Улсын Иргэний цаазын товчоон*, 2012, 61 дэх тал. Б.Буянхишиг, *Монгол Улсын Хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт*, 2021, 25 дахь тал.

¹⁹ И.Дашням, *Монгол Улсын төр, эрх зүйн түүх (Дэлхий дорно, өрнө дахинд байгуулагдсан монголын хаант улсуудын төр, эрх зүйн түүх)*, Дэд боть, 2011, 167 дахь тал. Б.Буянхишиг, *Монгол Улсын Хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт*, 2021, 25-26 дахь тал.

²⁰ С.Нарангэрэл, *Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо*, 2001, 96 дахь тал. Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав, Б.Баярсайхан, *Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн дүн шинжилгээ (Улаан хацарт)*, 2010, 15 дахь тал.

²¹ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан, *Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал*, 1997, 64 дэх тал.

²² Б.Лхагважав, Б.Батбаяр, Б.Баярсайхан, *Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн дүн шинжилгээ (Улаан хацарт)*, 2010, 15 дахь тал.

²³ Хааны зарлиг гүйцэтгэгч Чинсан цол нь (ханз:丞相, пиньин галиг:chéng xiàng) эртний хятадын хаант улсуудын үед хуандигийн дараа орохуйц албан тушаал байсан цол юм. Энэ нь орчин үеийн ерөнхий сайдын албан тушаалтай дүйцнэ.



өгсөн газрын хэргийг захируулахаар хуучин захиргааг байгуулахад хоёр чинсанд итгэл хүлээлгэн томилсон байдаг. Тухайлбал,

Доктор Г.Баярхүү бүтээлдээ "Монголчуудын төр ёсоо хүндлэн дээдлэх, хуулиа чанд сахин биелүүлэх нь хэдийгээр нэгдсэн төр түүнээс өмнөх үеийн улсын хуулийн хэм хэмжээний хүчин чадлын нэгэн илрэл боловч монголчууд нэн эртнээс эхлэн "Хөх тэнгэр"-ийг шүтэн биширч Хааныг тэнгэртэй адилтгаж түүний гаргасан зарлигийг бүхнээс хүчтэй хэмээн үзэж байсан нь монголчуудын төрөө хүндлэх, хуулиа дээдлэх үзэл бодол төлөвшихөд чухал нөлөө болсон байна" гэж бичсэн²⁴-ээс харахад монголын төр, эрх зүйн түүхийн дундад зууны үед заншлын эрх зүй өндөр хөгжсөнийг илэрхийлнэ.

Гуравт, Өвөг дээдэс маань дотоодын үймээн самуун эв түнжингүй байдлаасаа болж Өвөр Монгол, Ойрад Монгол, Халх Монгол болж хуваагдан талцаж, Манж чин улсын эрхшээлд дагаар орох болон байлдан эзлэгдэх замаар олон зуун жил дарлагдаж байсан түүхэн сургамжийг бид мартаж өсгүй юм. Алтан ургийн сүүлчийн хаан Лигдэн 1636 онд өөд болсноор манжууд Өвөр Монголыг эрхэндээ оруулж, 1688 онд Халх, Ойрадын дайнд Зүүн гарын хаант улсын Галдан хаан ялж, халхын Чахундорж, Занабазар нарын Халхын ноёд 1688 оны 9 сард Ар элстэй гэдэг газар чуулган чуулж, Манжийн хаанд харьяат ард нарынхаа хамт захирагдахыг албан ёсоор зөвшөөрсөн бичиг үйлдэн өргөн барьж, 1691 онд Долоннуурт болсон чуулганаар Халхыг манжийн харьяат гэж албан ёсоор тунхагласан түүхэн цаг мөчүүд нь харамсмаар боловч тухайн мөчид Монголын ард түмний түүх болоод эрх зүйн түүх зогсоогүй бичигдсээр ирсэн байдаг. Жишээлбэл,

Доктор О.Отгонтуяа бүтээлдээ "Халх журамд Иргэний эрх зүйн талаар нэлээдгүй заалт байх ба "Ямарваа гэсэн юмыг олсон хүн ноёд айлтгаж, сайдад мэдүүлж зарла. Эзнийг олж харвал эзэнд өг. Гээсэн юмыг олсон хүн ямар ч байсан гурван хувийг авах" зэрэг харьцангуй нарийвчлалтайгаар уг харилцааг зохицуулж байсан байна" гэж бичжээ²⁵.

Монголын төр, эрх зүйн түүхийн дундад зууны үеийг хамгийн хүнд үе гэж хэлж болох бөгөөд манжийн харийн түрэмгийлэгчдийн ноёрхолд монголчууд бидний өвөг дээдэс тусгаар тогтнолоо алдаж 220 жил дарлагдсан түүхийн хүнд хэцүү цаг үед шүүн таслах ажиллагаа тодорхой түвшинд хөгжиж байсан.

Нэрт эрдэмтэн Т.Сэнгэдорж "Монгол Улсын төр эрх зүйн үндэс" бүтээлдээ "Манжийн ноёрхлын үед шүүн таслах эрхийг хошууны засаг ноён, аймгийн чуулган дарга, Улиастай, Ховд, Хүрээн дэх амбан сайд, монгол журган, манжийн эзэн хаан хэрэгжүүлж байв. Түүнчлэн Эрдэнэ Шанзодбын Яам шүүн таслах эрх эдэлж байсан" гэж тайлбарлан бичсэн²⁶. Түүнчлэн Улаан хацарт хэмээх Их шавийн яамнаас хэрэг шийтгэсэн хуулга данс нь монголын шүүн таслах ажиллагааны түүхэн эх сурвалжид хамаарах чухал баримт болдог.

²⁴ Г.Баярхүү, *Монголын нэгдсэн төрийн болон дараа үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь /XIII-XVIII зуун/, Хууль зүйн докторын диссертаци, 1995, 76 дахь тал.*

²⁵ О.Отгонтуяа, О.Амарсанаа, *Иргэний эрх зүй, 2022, 35 дахь тал.*

²⁶ Т.Сэнгэдорж, *Монгол Улсын төр эрх зүйн үндэс, 2000, 61 дэх тал.*



Доктор Б.Дашзэвэг бүтээлдээ "Манжийн²⁷ үед цэрэг-захиргааны дэглэмийн салшгүй нэг хэсэг нь шүүх байсан ба шүүн таслах эрхийн анхан шат нь: хошуу, засаг, хоёрдугаар шат нь: аймгийн чуулганы дарга, гуравдугаар шат нь: Улиастайн жанжин, Хүрээ, Ховдын амбан, дөрөвдүгээр шат нь Монгол Жургаан, тав дахь нь Манжийн эзэн хаан байжээ" гэж тэмдэглэсэн²⁸, зэргээр харахад шүүн таслах дээд эрхийг хаанд олгосон байдаг нь шүүх засаглал хараат байсны илрэл юм.

Б.Лхагважав, Б.Батбаяр, Б.Баярсайхан нарын судлаачид өөрсдийн бүтээлдээ "Улаан хацарт нь Их шавийн яамнаас таслан шийдвэрлэсэн эрүү, иргэн, захиргааны гэж ангилж болохуйц эрх зүйн зөрчил гэж үзсэн үйлдлийг эрх бүхий албан тушаалтнаас шийтгэсэн эрх зүйн зөрчлийг нэгтгэсэн данс, дүрэм болно гэж бичжээ²⁹. Эл үеийн шүүхийн тогтолцоо захиргааны удирдлагаас салаагүй боловч аливаа зөрчлийг хууль цаазаар эрх олгогдсон албан тушаалтан шийдвэрлэж, тэрхүү шийдвэрийн гүйцэтгэлийг мөн л эрх зүйн хэм хэмжээний хүрээнд ялангуяа торгуулийн шийтгэлийг тухайн хэргийг таслах шийдвэрлэсэн ноёны шийдвэрээр томилсон элч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулж байжээ³⁰.

Б.Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав нарын судлаачид "Түүхэн хөгжлийн явцад монгол нутагт манжийн төрийн бодлогоор монголд тусгайлсан эрх зүйн систем, системчлэгдсэн хуулийн дэглэм тогтоохын хирээр шүүхүүдийг байгуулах зайлшгүй шаардлагын үүднээс Хиагт, Хүрээнд заргачийн газрыг анх удаа байгуулсан. Тэдгээр нь монгол, орос, хятад худалдааны иргэдийн хооронд үүссэн өр, авлагыг зохицуулах, гарсан маргааныг хянан шийдвэрлэх зорилготой байсан³¹, Хиагтын заргачийн газар 1727 онд хиагтад манж, хятадын худалдаачдын асуудлыг хариуцсан заргачийн газрыг анх байгуулсан. Хиагт оростой хил залгаа худалдааны чухал боомт газар байсан. Энэ заргачийн газрыг "журганы занги" хэмээх манж, хятад хүмүүс толгойлон захирч байсан. Тэдгээрийг Гадаад Монголын төрийг засах явдлын яамнаас томилж байсан тул "журганы занги гэж нэрлэж байжээ" гэж бичсэн байна³². Үүнээс харахад тухайн үеийн монголчууд хэдийгээр манж чин улсын эрхшээлд байсан боловч иргэний хэргийн шүүхийн үйл ажиллагааны анхны хэлбэр монгол нутагт явагдаж байсан гэж үзэх боломжтой байна.

Дөрөвт, Зүүнгарын хаант улс 1755 онд манжуудад бүрэн эзлэгдсэнээр өвөр Монгол, Халх, Ойрадууд цөм XX дугаар зууны эхэн үе хүртэл Манж чин улсын эрхшээлд орж, гадаад ертөнцөөс бүрэн тусгаарлагдсан байдаг ч Монголын төр эрх зүйн түүхийн дундад зууны үед хамаарах эл үед Галдан хааны хаанчлалын үед

²⁷ Манжийн ноёрхлын үед хэрэг шийдвэрлэхэд баримталж байсан хуулиудыг 3 ангилдаг. 1-рт Эзэнт гүрний хэмжээнд үйлчлэх ерөнхий хууль цааз /Манж чин улсын бүх хууль/ 2-рт Монголчуудын зохион байгуулсан хууль цааз /Халх журам/, 3-рт Монголыг захирахад шууд зориулсан Манжийн хууль цааз /Гадаад Монголын хууль зүйлийн бичиг/. ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн. Шийдвэр гүйцэтгэлийн судалгааны тайлан, 2020, 45 дахь тал.

²⁸ Б.Дашзэвэг, *Манжийн эрхшээлийн үеийн хууль цааз, шүүн таслах ажиллагааны үеийн үе шат*, 2011, 103 дахь тал.

²⁹ Б.Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав, *Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн дүн шинжилгээ (Улаан хацарт)*, 2010, 9 дэх тал.

³⁰ *Мөн тэнд*, 19 дэх тал.

³¹ *Мөн тэнд*, 16 дахь тал.

³² *Мөнд тэнд*, 17, 18 дахь тал.



шүүн таслах явдал ба шүүхийн байгуулалтын тухай их цаазад заагдсан зүйл нь Галдан хааны зарлигаар нэмэгдэж улам дэлгэрэнгүй болсон байдаг.

Доктор О.Отгонтуяа бүтээлдээ "Монгол-Ойрадын цааз бичигт мал аж ахуй эрхлэх, ан гөрөө хийх, гэрлэлт, гэр бүлийн эрх, үүрэг, өв залгамжлал, ер авлага, зээлийн талаар заалтууд байдаг. Жишээ нь: Эцэг нь хүүгээ ерх тусгаарлахад өмч хөрөнгө өгч байх, хэрэв хөрөнгө хомс, ядуу бол 5 бодын нэгийг өгч байх зэргээр заасан" гэж тэмдэглэн бичжээ³³.

Доктор Т.Алтангэрэл "Монгол-Ойрадын их цааз төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болох нь" бүтээлдээ "Тийнхүү эрх зүйн онолын үүднээс авч үзвэл монголчуудын олон зууны туршид дагаж шүтэн ирсэн нүүдлийн соёл иргэншлийн томоохон хэсэг болох монгол зан заншил нь заншлын эрх зүй болон хөгжиж, Их засаг, Цагаан түүх, Алтан ханы хууль болон XVII зууны Монголын цааз эрхэмжийн бичгийн заалтууд Их Цаазад удаа дараа тусгагдаж түүний дараа үеийн хуулиудын эх сурвалж болж ирсэн³⁴ гэж тэмдэглэжээ. Мөн тэрээр бүтээлдээ "Аливаа хэргийг үнэн худлыг заавал шүүхээр магадлаж байх, тухайн аймаг, хошуудын дотор ба аймаг хошуудын хооронд гарсан нэхэмжлэлээр хэрэг үүсгэн шүүхэд шүүн таслах тухай Их цаазад заасан байна. Хоёр ялт хүн шүүхэд зарга заалдахдаа заавал хоёулаа ирсэн байх, зарга үүсгэхдээ заавал гэрчтэй байх, боол эмийг гэрчид үл тооцох, гэрчийг малаар шагнах, заргалдагч хоёр хүн зэрэг ирээгүй бол заргыг үл хагалах, заргачид гурвантаа хэлж авах, сайн гэрчтэй хэл, жилийсэн малыг лав гэрчтэй авахуул гэх зэрэг заалтууд Их цаазад бичигдсэн байдаг нь сонирхол татна" гэж бичжээ³⁵.

Түүнчлэн аливаа заргыг шүүж хагалдаг, шүүх хагалахдаа нотлох баримтыг ашигладаг, гол нотлох баримт нь гэрчийн мэдүүлэг байдаг, гэрчийг нийгмийн давхарга хүйсээр нь ялгаж заасан ба итгэлтэй сайн хүн байх ёстой, зөв гэрчилсэн гэрчид мал зэргийг урамшил болгон өгч болох зэргийг хуульчилж байсан нь дундад зууны үед шүүн таслах ажиллагаа хөгжиж байсныг харуулна.

Доктор Т.Алтангэрэл "Харин шүүхийн тогтолцооны тухай заалт тусгагдаагүй нь засаг захиргааны байгууллага, шүүхийн байгууллага хоёр тодорхой зааггүй, зарга шүүх ажлыг отог, отгын ноёд шийдвэрлэж байсантай холбоотой. Галдан хунтайжийн 1678 онд шүүхийн талаар Их цаазад хожим нь оруулсан нэмэлтэд нэлээд зүйлийг тусгасан байдаг" гэжээ³⁶.

Мөн тэрээр бүтээлдээ шүүгчийн талаар "Ер заргачин заргын газраас гадна зарга хагалахгүй. Заргач хүн гурван удаа зарга буруу хагалбал тушаалаас огцруулах: хотонгийн өөр зуурын заргыг хотонгийн заргачин, Нируны заргыг их заргачин мэдэх гэх мэт заалтууд байдаг. Энэ нь заргыг заавал зарга хагалах буюу цаазын газарт, шүүхэд хагалах, шүүх нь хоёр шатны тогтолцоотой болсныг илэрхийлдэг.

Доктор Т.Алтангэрэл бүтээлдээ "Мөн их цаазад шүүгчийн талаар заасан заалт

³³ О.Отгонтуяа, О.Амарсанаа, *Иргэний эрх зүй*, 2022, 34 дэх тал.

³⁴ Т.Алтангэрэл, *Монгол-Ойрадын их цааз төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болох нь*, хууль зүйн докторын диссертаци, 2000, 35 дахь тал.

³⁵ *Мөн тэнд*, 36 дахь тал.

³⁶ *Мөн тэнд*, 80 дахь тал.



нэлээд тааралддаг. "Аливаа зарга шийтгэгч өөрийн заргыг өөрөө мэдэж шүүнэ. Хэрэг мунгинаж заргыг буруу хагалсан, хахууль авсан бол түүний эд хөрөнгийг хураан авч заргачийн тушаалыг байлга гэж" гэх хэсгийг бичсэн байдаг³⁷. Дээрх заалт нь өнөөдөр ач холбогдлоо алдаагүй монголын орчин цагийн шүүх, шүүгчийн үйл ажиллагааны түүхэн ач холбогдолтой байна.

Тав, Монголчуудын үндэсний тусгаар тогтнолын төлөөх тэмцлийн үр дүнд Манжийн 220 жилийн ноёрхлыг түлхэн унагааж, 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Их хүрээнд Богд гэгээн (Жибзундамба хутагт)-ийг Монгол Улсын хаан ширээнд өргөмжлөх ёслол болж хэмжээгүй эрхт хаант засаглалтай, 5 яамтай, Олноо өргөгдсөн Монгол Улсыг байгуулсан билээ. Богд хаант Монгол Улсын анхны 5 яамны нэг нь Шүүх яам байсан. Богд хаанд шүүх эрх мэдлийг төвлөрүүлж, өмнөх үеийн төрт улсуудын феодалын нийгмийн эрх зүйн түүхэн уламжлалыг Олноо өргөгдсөн Монгол Улсад хэвээр хадгалан үлдээсэн байдаг. Тухайлбал,

Олноо өргөгдсөн Монгол Улсын шүүх мэдлийн талаар доктор Т.Алтангэрэл бүтээлдээ "Тухайн үед шүүхийн дээд шат нь хаан, Шүүх яам, дунд шат нь аймгийн чуулган дарга, Улиастай, Ховд, Хүрээн дэх хэрэг шийтгэх сайд, доод шат нь хошууны засаг ноён байв. Цаазаар авах ялыг Богд хааны зарлигаар гүйцэтгэдэг байжээ" гэж бичжээ³⁸.

Мөн 1917 онд Октябрын хувьсгалаар Хаант Орос улс мөхөж дотоодын үймээн самуунтай байсан үеийг далимдуулан 1919 онд Дундад иргэн улс Ар Монголын автономийг хүчээр устгаж өөртөө шууд нэгтгэн захирсан нь Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн дахин өрнөхөд хүргэж, монгол ардын болон Барон Унгерний цэргийн хамтарсан хүчин, Их хүрээг гамин цэргээс чөлөөлж, Богд хаант Монгол Улсынхаа тусгаар тогтнолыг сэргээсэн цаг мөчүүд нь монголын төр эрх зүйн түүхийн нэгэн чухал хэсэг болж түүхэнд бичигдсэн.

3. Монголын төр, эрх зүйн түүхийн шинэ үед /XX зууны 20-иод оноос 90 он/ Монголын төр, эрх зүйн түүхийн шинэ үед /XX зууны 20–90 он/

XX зууны 20-иод оноос Монголын орчин үеийн иргэний хэргийн шүүх, иргэний хэрэг хянан шийдвэрлэх болон иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтууд нь социалист чиг баримжаанд тулгуурлан монголын төр, эрх зүйн түүхийн шинэ үед маш хурдацтай хөгжин цэцэглэж ирсэн нь дараах түүхэн үйл явдлуудтай шууд холбогдоно. Тухайлбал,

Феодалын нийгмийг халах, ард түмний засаглалыг тунхаглах зорилгоор 1921 оны 3-р сарын 13-ны өдөр Ардын түр засгийн газрыг байгуулсан нь Богд хааны хэмжээгүй эрхт хаант засаглалд цэг тавих эхлэл болж, 1921 оны 7 дугаар сарын 06-ны өдөр Зөвлөлт Орос Улсын³⁹ Улаан арми, Монгол ардын журамт цэргийн нэгдсэн хүч нэгэн цагт гамин цэргээс Их хүрээг чөлөөлж өгсөн цагаантны цэргийг нутгаасаа хөөн гаргасан байдаг.

³⁷ Мөн тэнд, 81 дэх тал.

³⁸ Т.Алтангэрэл, *Монгол-Ойрадын их цааз төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болох нь*, хууль зүйн докторын диссертаци, 2000, 62 дахь тал.

³⁹ 1920 оны 6-р сарын 25-ны өдөр Монголд үндэсний ардчилсан хувьсгал ялж, Монгол ардын нам байгуулагдаж, монголчууд тухайн үеийн Зөвлөлт Орос Улсыг түших ёстой гэсэн бодлого баримталж байснаас шалтгаалж, ЗХУ-ын дайсан Хаант Орос Улсын үлдэгдэл Цагаантны цэргийн үлдэгдэл ангийг хөөн гаргасан.



Улмаар 1921 оны 7-р сарын 10-ны өдөр Нийслэл "Их хүрээ" хотод Хэмжээт Цаазат Хаант Ардын засгийн газар байгуулагдаж, улс төрийн бодлогыг Монгол Ардын намын гишүүдийн байгуулсан Засгийн газар, Их Хурлын болон Бага Хурлын тэргүүлэгчид тодорхойлох болсон нь олон зууны турш хааны хэрэгжүүлж байсан шүүх эрх мэдлийг ард түмний мэдэлд авсан чухал үйл хэрэг болсон байдаг.

Бүрэн эрхт байдлаа баталгаажуулах, тусгаар тогтносон бие даасан улс болох амаргүй байсан ч гадаад бодлогоор Зөвлөлт Орос улсыг түшиж, их гүрний нөмөрт хятадуудын эсрэг тууштай тэмцсэний үр дүнд феодалын нийгмийн үе улиран сонгогдох ноён, зарц, хамжлагат ард хүний эрхийн ялгаварлан гадуурхалтыг үндсээр нь халж, бүх иргэн адил тэгш эрх эдлэх талаарх үзэл санааг агуулсан анхны Үндсэн хуулиа 1924 онд тунхаглан баталсан байдаг. Анхны Үндсэн хууль батлагдсантай холбоотойгоор шүүх эрх мэдлийг бие даасан хараат бус шинжтэй ажлууд бодитоор хэрэгжиж эхэлсэн.

Мөн 1925 онд хуралдсан Улсын 2 дугаар их хурлаар анх удаа шүүхийн зохион байгуулалт үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, Монгол Улсад шүүхийн байгууллагын бие даасан тогтолцоо байгуулах тогтоол гаргасан байдаг. Улсын Их Хурлын шийдвэрийн үндсэн дээр Улсын Бага Хурлын тэргүүлэгчид 1926 онд "БНМАУ-ын аливаа шийтгэх, таслах газруудыг байгуулах тухай дүрэм", "Улс төрийн хэрэгт холбогдох этгээдийг таслан шийтгэх газрын түр дагаж явах дүрэм", 1927 онд Улсын дээд шүүх таслах газрын дүрмийг баталж байжээ.

Судлаач Н.Чинбат бүтээлдээ "1920-оод оны дунд үеэс анхны бие даасан буюу төрөлжсөн Иргэний хуулийг батлан гаргах ажлыг тухайн үеийн төр засгийн бодлогоор хийж гүйцэтгэсэн байдаг. Энэ хуулийн онцлог нь нэгдүгээрт, европын буюу эх газрын системтэй иргэний эрх зүйн тогтолцоог хуульчлан тодорхойлох алхмыг хийсэн, хоёрдугаарт, энэ хуулийн нэг бүрэлдэхүүн хэсэг болгон гэр бүлийн харилцааны асуудлыг иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн үндсийг тодорхойлох замаар хуульчлан тогтоосон, гуравдугаарт, гэрээний харилцааны үндсийг анхлан тодорхойлсон, дөрөвдүгээрт, иргэний гүйлгээнд төрийн оролцоог хуульчлан тогтоосон байдагт оршино"⁴⁰ гэж тэмдэглэжээ.

Монголын төр эрх зүйн түүхийн шинэ үеийн эрх зүйн түүхэн цаг хугацаанд Монгол Улсын Үндсэн хуулийг 1924, 1940, 1960 онд, Иргэний хуулийг 1926-1929 он, 1952, 1967 онд, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбоотой 1926, 1952, 1967 онд тус тус баталж тухайн цаг мөчид хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан нь иргэний хэргийн шүүх, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн түүхэн уламжлалд шууд хамаарах хуулиуд болно. Тухайлбал,

Профессор Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар бүтээлдээ "БНМАУ-ын Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хуульд /1926/ Иргэний, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах журмыг хамтад нь хуульчилж өгсөн" гэжээ⁴¹. Энэ нь Монгол Улсад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмыг зохицуулсан анхны нэгдмэл акт байснаараа түүхэн ач холбогдолтой байна" гэж тэмдэглэжээ⁴².

⁴⁰ Н.Чинбат, *Иргэний эрх зүй лекцийн товчоон (ерөнхий анги)*, 2014, 32 дахь тал.

⁴¹ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан, *Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал*, 1997, 274 дэх тал.

⁴² С.Энхбаяр, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд /1926, 1952,*



Мөн уг хууль 9 бүлэг, 111 зүйлтэй байсан бөгөөд 9 дүгээр бүлэгтээ Шүүх таслах газруудын тогтоолыг гүйцэтгэх тухай /104–111 дүгээр зүйл/ тусгайлан заасан нь иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны анхны зохицуулалт гэж хэлж болно.

Мөн 1926 оны хуульд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тусгажээ. Уг хуулийн 105 дугаар зүйлд "Аливаа иргэний хэргийг шийтгэсэн тогтоол хүчин төгөлдөр болсны дараа нэхэмжилсэн этгээдээс гуйвал уг хэргийг шийтгэсэн тогтоол хүчин төгөлдөр болсны дараа нэхэмжилсэн этгээдээс гуйвал уг хэргийг гүйцэтгэн шийтгүүлэхээр харьяат шүүх таслах газрын түшмэдээс түүнд тусгай хуудас олговол зохино" Мөн хуулийн 110 дугаар зүйлд "Аливаа өр ширийн зүйлүүдийг нэхэмжлэгдсэн этгээдийн хөрөнгө хогшлыг дээр дурдсан ёсоор битүүмжлэх ба худалдахад түүнийг эм хүн буюу ураг төрөлд нь зөвхөн амьдралын хувь үлдээхээс гадна аж үйлдвэрт чухам холбогдох бүхий зүйлүүдийг хураан авч үл болно" гэж тусгайлан заасан байдаг⁴³.

Профессор Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар бүтээлдээ "Монгол Улсад ул төрийн нийтээр хоморголсон хэлмэгдүүлэлт, халх голын дайн зэрэг зовуурь бэрхшээлийг амссаар 1940 онтой золгожээ" гэж дурджээ⁴⁴. Үүнээс харахад 1924 оны Үндсэн хуулийн үйлчлэл дуусгавар болж, тухайн цаг үеийн Монгол Улс 1940 онд 2 дахь Үндсэн хуулиа социалист чиг баримжаатайгаар баталсан үе юм. Эл хуулийг ард олны дунд Маршал Х.Чойбалсангийн хууль гэж хэлэгдэж ирсэн байдаг.

Доктор, профессор А.Лхагваа бүтээлдээ "1949 оны Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн VI бүлэг нь "Шүүхийн гүйцэтгэгч нар" гэсэн нэртэй байсан" гэж дурджээ⁴⁵. Үүнээс харахад шүүгчийн хяналтад шийдвэр гүйцэтгэгч нар хамаарч байсныг харуулна.

1952 онд батлагдсан "Бүгд найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хууль нь 22 бүлэг 161 зүйлтэй. Эл хуулийн онцлог нь Иргэний хэргийн аль я үе шатанд прокурор өөрийн үзэмжээр оролцдог. Шүүхийн шийдвэрийг шүүх яамны сайд, улсын прокурор авч хянадаг байсан нь шүүх байгууллага хараат байсны илрэл мөн" байсан⁴⁶.

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг уг хуульд "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий байдал" гэж нэрлээд, мөн хуулийн 119–131 дүгээр зүйл, "Эд хөрөнгөнөөс төлбөрийг гаргуулах тухай" 132–151 дүгээр зүйл, "Улсын хоршоо, олон нийтийн байгууллагуудаар өр төлүүлэх" 152–157 дугаар зүйл, "Ажлын хөлс ба зохигчдын шагналаас төлбөрийг гаргуулах тухай" 158–161 дүгээр зүйлд тус тус тодорхой заажээ⁴⁷. Тухайлбал, Шүүхийн гүйцэтгэгч буюу сумын хөдөлмөрчдийн депатуудын хурлын гүйцэтгэх захиргааны газруудаас гүйцэтгэх зүйлүүд гэвэл:

1967, 1994, 2002 он/ 2005, 9 дэх тал.

⁴³ Мөн тэнд., 13 дахь тал.

⁴⁴ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан, *Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал*, 1997, 280 дахь тал.

⁴⁵ А.Лхагваа, *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй /ерөнхий, тусгай анги/, 2024*, 137 дахь тал.

⁴⁶ С.Энхбаяр, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд /1926, 1952, 1967, 1994, 2002 он/, 2005, 14–15 дахь тал.*

⁴⁷ Мөн тэнд., 83–90 дэх тал.



А. Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр ба нотариатын конторын гүйцэтгэх хуудсууд,

В. Торгууль хүлээлгэх ба нэхэмжлэлийг хангах тухай иргэний ба эрүүгийн хэргийн талаар шүүхээс гаргасан магадлалууд, түүнчлэн хулгайлсан ба үрэгдүүлсэн зүйлийг төлүүлэх тухай шийтгэсэн тогтоолууд,

С. Улсын арбитрын шийдвэрүүд,

Д. Зохигчдоос шүүхэд батлуулж эвлэрсэн хэлэлцээний тухай магадлалыг тус тус гүйцэтгэх ёстой гэжээ⁴⁸.

Тухайн цаг мөчид шүүх байгууллага хэдийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хараа хяналтад байсан боловч иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүхийн гүйцэтгэгч, шүүхийн тогтоол гүйцэтгэгчийн шууд удирдлага нь шүүх байжээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 1940 оны Үндсэн хуулийг хүчингүй болгож, 1960 оны 3 дахь удаагаа Үндсэн хууль шинээр батлагдсантай холбоотойгоор тухайн үед манай улс социалист системийг улам төгөлдөржүүлэх зорилгоор холбогдох хуульд өөрчлөлт орж байсны нэг нь Иргэний байцаан шийтгэх хууль билээ. Тухайлбал,

1967 онд батлагдсан "Бүгд найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хууль нь 6 хэсэг, 39 бүлэг 313 зүйлтэй. Эл нь өмнөх хуулийн нэгэн адил "шүүх байгууллагад прокурор хяналт тавьсаар байсан"⁴⁹ нь учир дутагдалтай боловч иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамаарах зохицуулалт нь нэлээд боловсронгуй болж хөгжсөн байдаг.

Түүнчлэн 1967 оны Иргэний байцаан шийтгэх хуулийн 5 дугаар хэсгийг Тогтоол гүйцэтгэлийн ажиллагаа гэж нэрлээд, 35 дугаар бүлэг, "Ерөнхий заалт" гээд 251-267 дугаар зүйл, 36 дугаар бүлгийг "Иргэдэд холбогдолтой тогтоол ба шийдвэрийг гүйцэтгэх" гээд 268-301 дүгээр зүйлд тухайн үед одоогийн иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эмх цэгцтэй дэс дараалалд оруулан бичиж хуульчилжээ.

Мөн хуулийн 251 дүгээр зүйлд "Энэ хуулийн 252 дугаар зүйлд дурдсан шүүхийн шийдвэр ба бусад байгууллагын тогтоолыг аймаг, хотын шүүхийн тогтоол гүйцэтгэгчид энэ хуулийн 5 дугаар хэсэгт заасан журмаар гүйцэтгэнэ. Тогтоол гүйцэтгэлийн ажилд хяналт тавих, дээр дурдсан шийдвэр, тогтоолыг цаг тухайд нь зөв гүйцэтгүүлэх хариуцлагыг шүүгч хүлээнэ" гэж тусгайлан заасан байдаг⁵⁰. Эл хууль нь иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, шийдвэр гүйцэтгэгчид ажилд шүүгч хяналт тавьдаг онцлогтой байсан. Мөн иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдалд шууд хамаарах дараах хоёр эрх зүйн актыг хамааруулан ойлгож болно.

⁴⁸ Мөн тэнд, 83, 84 дэх тал.

⁴⁹ БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хууль, (1967)-ийн 151 дүгээр зүйлд "Зөвлөлдөх үед хэрэгт ач холбогдолтой шинэ байдлыг тодруулах буюу шинэ нотлох баримтыг шинжлэх шаардлагатай гэж үзвэл шүүх хурлын ажиллагааг сэргээн явуулах тухай магадлал гаргана. Шүүх хурлын ажиллагаа дууссаны дараа шүүхийн шүүмжлэл ба прокурорын дүгнэлтийг шүүх шинээр сонгоно" гэж бичжээ. С.Энхбаяр, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд /1926, 1952, 1967, 1994, 2002 он/, 2005, 152-153 дахь тал.

⁵⁰ Мөн тэнд, 190 дэх тал.



Доктор, профессор А.Лхагваа бүтээлдээ "1978 онд батлагдсан БНМАУ-ын Шүүхийн байгууламжийн хууль /61-63 дугаар зүйл/, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1985 оны 237 дугаар тогтоолоор батлагдсан Шүүхийн тогтоол гүйцэтгэх журмын тухай заавар" зэргийг дурдаж бичсэн байдаг⁵¹. Энэ нь иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэл, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэгч нарын ойлголтыг өөртөө шингээсэн байдаг.

Доктор, профессор А.Лхагваа бүтээлдээ "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй нь ял эдлэх, эдлүүлэх ажиллагаанд оролцогчдын заавал дагаж мөрдвөл зохих зан үйлийн журам буюу хэм хэмжээг төрөөс батлан гаргадаг. Өнгөрсөн 80 гаруй жилийн хугацаанд ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад шууд хамаарагдах найман хууль батлагдан хэрэгжиж ирсэн уламжлалтай гэж тэмдэглэжээ⁵².

Монголын төр эрх зүйн түүхийн шинэ үед хамаарах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын орчин үеийн түүхийг 1921 онд байгуулагдсан "Гяндан салаа" тоолж эхэлдэг бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой 1931, 1966, 1981 хуулиуд, мөн Монголын төр эрх зүйн түүхийн нэн шинэ үед хамаарах 1993, 1995, 1996, 1999, 2000 оны хуулиуд нь ял, шийтгэл эдлүүлэх ажиллагааны талаар бичигдсэн тул иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн түүхэн эх сурвалж шууд утгаараа болох боломжгүй. Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 2002, 2017 оны хуулиуд нь эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар бичигдсэн онцлогтой байсан юм.

4. Монголын төр эрх зүйн түүхийн нэн шинэ үед /XX зууны сүүлч 90 оноос хойших/

Орчин цагийн Монгол Улсын хувьд 1990 онд Зөвлөлт холбоот улс задарч, Монголд 1991 онд ардчилсан хувьсгал ялснаар Монгол Улс социалист нийгмээс чөлөөт зах зээлийн нийгэм рүү шилжиж, 1992 оны 1 дүгээр сарын 13-нд Шинэ Үндсэн хуулиа баталж, ардчилсан үнэт зүйлийг эрхэмлэсэн шүүхийн шинэчлэл хийгдсэн.

Монголын төр эрх зүйн түүхийн нэн шинэ үеийн эхлэл болсон 1992 оны одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" гэж шүүх засаглалыг бэхжүүлэх, шүүх, шүүгчийн хараат бус, бие даасан байх боломжийг ардчилсан үндсэн хуулиар тунхаглаж чадсан талаар өмнөх дурдсан билээ. Тухайлбал,

1994, 2002 онд батлагдсан Иргэний хууль, түүнд нийцүүлэн батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл санаа нь ардчиллын үнэ цэнийг нэмэгдүүлдэг. Тухайлбал,

1994 онд батлагдсан /18 бүлэг, 242 зүйлтэй/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд "Хэрэг хянан шийдвэрлэх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлэх, шүүгч хараат бус байж гагцхүү хуульд заригдах" гэж заажээ. Мөн хуулийн 16 дугаар бүлгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэж

⁵¹ А.Лхагваа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй /ерөнхий, тусгай анги/, 2024, 137 дахь тал.

⁵² Мөн тэнд, 12 дахь тал.



нэрлээд 191–234 дүгээр зүйлээр иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохицуулж байсан. Өмнөх иргэний процессын эрх зүйн уламжлалын дагуу шүүгч гүйцэтгэгч нарт хяналт тавьдаг тогтолцоо хэвээр хадгалагдсан байдаг.

1994 онд Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай анхны хууль болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хууль /4 бүлэг, 16 зүйл/ батлагдан гарсан байдаг.

Доктор, профессор А.Лхагваа өөрийн бүтээлдээ "иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бие даасан хууль гарах болсон шалтгааны нэгд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны үйл ажиллагаа олон арван эрхийн актаар зохицуулагдаж ирснийг тусгайлан хуульчлах шаардлагатай болсон, хоёрт, шийдвэр гүйцэтгэлийн албаны цар хүрээ өргөжин тэлэхийн хэрээр ажилтнуудын эрх, үүргийг ойртуулан авч үзэх шаардлагатай болсон, гуравт, шийдвэр гүйцэтгэлийн албыг харьцангуй бие даалгах нийгмийн шаардлага тавигдсан зэрэгтэй холбон үзэж болно" гэж тайлбарлажээ⁵³.

Хэдий иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бие даасан хууль батлагдсан боловч иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шүүх эрх мэдлийн хүрээнд шүүгч шийдвэр гүйцэтгэгчид хяналт тавьж ирсэн тогтолцоо өөрчлөгдөөгүй байдаг.

1996 онд батлагдсан /6 бүлэг, 108 зүйлтэй/ "Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн 2 дугаар бүлэгт Эд хөрөнгийн холбогдолтой эрүүгийн болон иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх" гэж заасан⁵⁴.

Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтан нь шийдвэр гүйцэтгэгч болон хорих байгууллагын албан хаагчаас бүрдэнэ. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтан төрийн төлөөлөгч мөн" гэж заажээ⁵⁵. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шүүгч хяналт тавьж байсан тогтолцоо энэ үеэс эхлэн Засгийн газрын гүйцэтгэх эрх мэдэлд шилжсэн гэж үзэж болно.

Доктор, профессор А.Лхагваа бүтээлдээ "Монгол Улсын Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын нэгдсэн орчин бүрдэх, мөн бүх төрлийн ял эдлүүлэх, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагааг нэг байгууллагын чиг үүрэгт харьяалуулах үйл явц улам гүнзгийрэн баталгаажсаны тод жишээ бол УИХ-аас 2002 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдан мөрдөгдөж байсан явдал юм гэж бичжээ⁵⁶.

2002 онд батлагдсан /20 бүлэг, 195 зүйлтэй/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Шүүх эрх мэдлийг хуулийн дагуу байгуулагдсан шүүх хэрэгжүүлнэ" гэж заасан. Уг хуулийн 18 дугаар бүлгийг "Шүүхийн шийдвэр гүйцэтгэл" гэж томьёолоод 183–188 дугаар зүйлээр зохицуулж байсан.

⁵³ А.Лхагваа, *Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж*, 2014, 147 дахь тал.

⁵⁴ *Мөн тэнд*, 169 дэх тал.

⁵⁵ *Мөн тэнд*, 166 дахь тал.

⁵⁶ А.Лхагваа, *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй /профессорын эрдмийн дээжис/*, 2024, 140 дэх тал.



Тухайн үед 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2 дугаар хэсгийг Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэж томёолоод 2–10 дугаар бүлэг, 10–90 дүгээр зүйлээр зохицуулахаар тусгайлан хуульчилж, 1996 оны Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн нэгэн адил иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шүүгч хяналт тавихгүй бөгөөд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болох Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдэлд хэвээр үлдсэн юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /2002 он/ хуулийн 83 дугаар зүйлд Шийдвэр гүйцэтгэгчийг урамшуулах" талаар тусгайлан заасан байдаг. Тухайлбал,

Мөн хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэгт "Шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчийг төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан мөнгөний болон эд хөрөнгийн үнийн дүнгийн 0,5–10 хүртэлх хувиар урамшуулна" гэж заасан байдаг нь 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдан гарч хэрэгжиж эхэлснээр хүчингүй болсон боловч тухайн цаг мөчдөө шинэлэг заалт болж чадаж байсан. Тухайн үед Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад харьяалагдаж байсан иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэгч нар төрийн тусгай албанд харьяалагдаж байсан боловч урамшуулал авдаг тул цэргийн цол хэрэглэдэггүй, энгийнээр ажилладаг байсан. Харин ахлах шийдвэр гүйцэтгэгч нь урамшуулал авдаггүй, цэргийн цол хэрэглэдэг байсан онцлогтой.

III. Дүгнэлт

Иргэний хэргийн шүүх байгууллагын үүсэл нь 1926 оноос эхлэх боловч ардын хувьсгал ялахаас өмнө олон зуун жилийн турш үргэлжилсэн феодалын нийгэмд шүүн таслах дээд эрх хааны гарт төвлөрч, хааны зарлиг нь шүүхийн дээд хүчин чадалтай акт байсныг түүхэн эх сурвалжууд нотолж байна. Тухайлбал,

Монголын төр, эрх зүйн түүхийн эртний үед Модун шаньюгийн үүсгэн байгуулсан нүүдэлчдийн анхны төрт ул болох Хүннү гүрэн болоод монгол нутагт Хүннү гүрний дараа байгуулагдаж оршин тогтнож байсан олон олон эртний улсуудад заншлын эрх зүй хүчтэй хөгжиж байсан бөгөөд тухайн цаг мөчид бичигдмэл бус хууль буюу хориглох заншилд тулгуурласан, хэв хуулийн шинжтэй эрүүгийн цаазуудыг хааны зарлигаар тогтоож, хаанд төрийн хэмжээгүй эрх мэдлийг олгож, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүн таслах дээд эрхийг хаан ганцаараа эдэлж байснаас дүгнэн харахад шүүх байгууллага төрөлжиж хөгжөөгүй байсан байна. Мөн хааны зарлиг, зарлигийг гүйцэтгэх алба, албатуудыг орчин үеийн шүүх, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эртний хэлбэр гэж үзэж болохоор байна.

Мөн төр, эрх зүйн түүхийн дундад зууны үед их эзэн Чингис хаан Их Монгол Улсдаа нүүдэлчдийн анхны бичмэл хууль болох "Их засаг" бичмэл хуулийг улсын заргач Шихихутугаар зохиолгож, түүнд шүүн таслах эрхийг өгч, хаанд шүүн таслах дээд эрхийг үлдээсэн боловч агуулгын хувьд хаан шүүн таслах эрхийг өөрийн албат ноёнд шилжүүлэн өгсөн нь шүүх байгууллагын анхны бие даасан



хувилбар байж болох талтай юм гэсэн дүгнэлтэд хүрсэн. Харин Их Монгол Улс задарч, Хятадад Юань улс, дундаж азид Цагаадайн улс, Иранд Илхаадын улс, орос, казахстанд Алтан ордны улс бие даасан шинжтэй оршин тогтнож байсан боловч эзэнт гүний үед хэрэгжиж байсан Их засаг хуулийг эрх зүйн баримт бичигт чухал эх сурвалж гэж үзэж, шүүн таслах дээд эрхийг хаанд, шүүн таслах бусад эрхийг албат ноёдууддаа олгож байснаас харахад шүүх байгууллагын бие даасан байдлын анхны хэлбэр дундад зууны үед бүрэлдэн тогтсон гэж үзэж болох талтай байна.

Бидний өвөг дээдэс дотоодын үймээн самуунаас үүдэн Өвөр Монгол, Ойрад Монгол, Халх Монгол гэсэн үндсэн гурван хэсэгт тарж хуваагдан талцаж байх зуурт тухайн үеийн Мин улсыг мөхөөсөн Манж чин улс дагаар оруулах болон байлдан эзлэх бодлогыг хүчтэй явуулсаар бүх монголыг эрхшээлдээ оруулахаас өмнө шүүн таслах бүх эрхийг ноёдууд хариуцсан нутагтаа бие даан эдэлж байсан.

Харин манжийн ноёрхлын үед шүүн таслах эрхийг хошууны засаг ноён, аймгийн чуулган дарга эдлэхээс гадна манжийн хааны томилсон Улиастай, Ховд, хүрээн дэх манжийн амбан сайд, монгол журган, шүүн таслах дээд эрхийг манжийн хаанд төвлөрүүлж, манжийн хаанаас Эрдэнэ Шанзодбын Яаманд шүүн таслах эрх олгосон зэрэг нь Улаан хацарт гэж алдаршсан Их шавийн яамнаас хэрэг шийтгэсэн хуулга дансанд тэмдэглэгдэн үлдсэн байдаг.

Шүүн таслах дээд эрхийг Манжийн хаан эдэлж байсан нь уламжлал ёсоор шүүн таслах дээд эрх мэдэл хаанд үлдэж, Чингис хааны албат улсын заргач Шихихутуг шиг Манжийн хааны албат манж, монгол ноёдууд бүс нутагтаа шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байсан зэрэг нь түүхэн ач холбогдолтой байна.

Дундад зууны үеийн төгсгөл болсон 20 дугаар зууны эхэн үед Монголчууд Манжийн ноёрхлыг түлхэн унагааж, Богд хаант Монгол Улсыг байгуулж, шүүх яам байгуулсан боловч өмнөх төрт улсуудын нэгэн адил Богд хаанд шүүн таслах дээд эрх мэдлийг төвлөрүүлсэн байгаа нь шүүх эрх мэдэл нэг хүний гарт төвлөрсөөр байсны илрэл гэж дүгнэлээ.

Монголын төр, эрх зүйн түүхийн шинэ үе нь ардын хувьсгал явж, феодалын нийгмийг халсан 1921 оноос эхлэх бөгөөд тухайн цаг мөчид орчин үеийн шүүх байгуулах, шүүхийн хараат бус бие даасан байдлыг эрх зүйн тогтолцоонд бий болгох эхлэл цэг 1924 онд анхны Үндсэн хуулиа баталж, 1926 онд Иргэний хууль, Иргэний процессын хуулиа тус тус баталж, 1926 онд анхны бие даасан шүүхээ байгуулсан зэргээр тодорхойлогдож байна.

Мөн 1921–1991 онд хэдий социалист нийгмийн үзэл суртал шингэсэн Үндсэн хуулиуд, Иргэний хууль, Иргэний процессын хуулиуд батлагдан мөрдөгдөж байсан боловч шүүхийн байгууллагын хараат бус, бие даасан байдал төгөлдөржин хөгжиж байсан бөгөөд шүүхээс гарсан шийдвэр бүр заавал биелэгдэх шинжийг агуулах бөгөөд биелэгдэхгүй байгаа шийдвэрт иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүхийн хяналтад явуулж ирсэн байна.

Монголын төр, эрх зүйн түүхийн нэн шинэ үе болох хувийн өмчийг ардчилсан Үндсэн хуулиар тунхаглан баталсан цаг мөчөөс хойш өнөөг хүртэл хугацаанд



шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлж, шүүх хараат бус бие даасан шинжтэй үйл ажиллагаа явуулж, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмыг баримталж 1996 оноос өмнө шүүхээс иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлж, шүүх шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавьсаар иржээ. Харин 1996 оноос хойших хугацаанд буюу одоог хүртэлх хугацаанд иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлж байна.

Иймд монголын түүхэнд хэдэн зуун жилийн турш шүүх эрх мэдлийг хаад, ноёдын гарт төвлөрүүлж байсан уламжлалыг одоогоос 100 гаруй жилийн өмнө хаант засаглалыг халж, нийгмийн эрс шинэчлэлт хийх үедээ анхны шүүхээ байгуулж, шүүх эрх мэдлийг гагцхүү шүүхэд олгож ирсэн нь монголын төр, эрх зүйн түүхэнд орчин үеийн шүүх байгуулагдах эхлэл цэг болж, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүх бие даан гүйцэтгэж байсныг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хариуцуулж, шүүх эрх мэдлийн тодорхой хэсгийг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад шилжүүлсэн зэргээс үл хамааран шүүхээс гарсан шийдвэр бүр заавал биелэгдэх зарчмаа алдахгүй эрх зүйн баримт бичгүүдээр төгөлдөржин хөгжсөөр байгааг онцлон тэмдэглэж энэхүү өгүүллээ төгсгөж байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Ном, сурах бичиг

1. И.Дашням, *Монголын Улсын төр, эрх зүйн түүх (НТӨ III- НТ V зуун)*, Тэргүүн боть, Уб., 2012 он.
2. Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан, *Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал*, 1997 он.
3. Б.Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав, *Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн дүн шинжилгээ (Улаан хацарт)*, 2010 он.
4. Д.Баярсайхан, *Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал*, 2012 он.
5. Т.Байгалмаа, *Шүүн таслах ажиллагаан дахь мэтгэлцэх зарчим*, 2014 он.
6. Д.Баярсайхан, *Эрх зүйн онол*, 2020 он.
7. Б.Баярсайхан, *Монголын эрх зүйн түүх, соёлын судалгаа*, 2021 он.
8. Б.Буяншиг, *Монгол Улсын Хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт*, 2021 он.
9. Ч.Далай, *Их Монгол Улс*, 2006 он.
10. И.Дашням, *Монгол Улсын төр, эрх зүйн түүх (Дэлхий дорно, өрнө дахинд байгуулагдсан монголын хаант улсуудын төр, эрх зүйн түүх)*, Дэд боть, 2011 он.
11. Б.Дашзэвэг, *Манжийн эрхшээлийн үеийн хууль цааз, шүүн таслах ажиллагааны үеийн үе шат*, 2011 он.
12. Т.Мөнхжаргал, *Монгол Улсын Иргэний цаазын товчоон*, 2012 он.



13. С.Нарангэрэл, *Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо*, 2001 он.
14. Б.Нарангэрэл, *Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг*, 2021 он.
15. А.Лхагваа, *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй /ерөнхий, тусгай анги/, 2024 он.*
16. О.Отгонтуяа, О.Амарсанаа, *Иргэний эрх зүй*, 2022 он.
17. Т.Сэнгэдорж, *Монгол Улсын төр эрх зүйн үндэс*, 2000 он.
18. Г.Сүхбаатар, *Монголын эртний түүх судлал I боть. Монголчуудын эртний өвөг*, 2000 он.
19. Н.Чинбат, *Иргэний эрх зүй лекцийн товчоон (ерөнхий анги)*, 2014 он.
20. С.Энхбаяр, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд /1926, 1952, 1967, 1994, 2002 он/, 2005 он.*
21. Radbruch: Anselm Feuerbach in VR 305 S, Wien 1934, Б.Буянхишиг.

Б. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Т.Алтангэрэл, *Монгол-Ойрадын их цааз төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болох нь*, хууль зүйн докторын диссертац, 2000 он.
2. Г.Баярхүү, *Монголын нэгдсэн төрийн болон дараа үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь /XIII-XVIII зуун/, сэдэвт хууль зүйн ухааны дэд докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол*, Уб., 1995 он.
3. ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн, "Шийдвэр гүйцэтгэлийн судалгааны тайлан", 2020 он.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Орос хэл дээр

1. М.Х.Хунтыз. *Римское частное право*, 1995, 28 дахь тал.

**Abstract****LEGAL HISTORICAL TRADITION OF THE CIVIL COURT AND THE ENFORCEMENT OF COURT DECISIONS IN MONGOLIA****BYAMBA-ERDENE, S.***Doctoral student at Ikh Zasag International University*

In Mongolia, the history of an independent judicial system and the execution of civil case decisions is traced back to the victory of the People's Revolution, the establishment of the People's Court in 1921, the adoption of the first Constitution in 1924, and the official formation of the first courts in 1926, which initially operated in traditional Mongolian yurts. However, studying the history of civil case proceedings and the exercise of judicial power in ancient Mongolia—who was responsible for administering justice and whether an independent judicial system existed at the time—is of great importance within the framework of Mongolia's state and legal history.

Before the People's Revolution, judicial power had been concentrated in the hands of khans and nobles for centuries. It was only after the adoption of the first Constitution that judicial authority was transferred to the People's Court. In ancient times, the right to administer justice and adjudicate disputes was granted to khans and nobles, and their decrees and rulings functioned as both written and unwritten legal acts, similar to judicial decisions. The process of executing these decrees marked the beginnings of judicial enforcement procedures, which continued to develop over time. This paper will explore these historical aspects in detail.

Keywords: Civil court cases, judicial power, procedural activities in case adjudication, and judicial enforcement actions.

ТӨВ БАНКНЫ ЦАХИМ МӨНГӨНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

Э.ЭРХБИЛГҮҮН¹
Б.ТЭЛМЭН²

- Оршил
- Үндсэн хэсэг
 - Үндэсний төлбөрийн систем
 - Цахим мөнгө ба түүний эрх зүйн зохицуулалт
 - Төв банкны цахим мөнгөний талаарх ойлголт
- Харьцуулсан судалгаа
- Дүгнэлт

¹ Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн судлаач, хууль зүйн магистр /LL.M./.

² Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч.



ТӨВ БАНКНЫ ЦАХИМ МӨНГӨНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ : ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

Э.ЭРХБИЛГҮҮН Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн судлаач, хууль зүйн магистр /LL.M./

Б.ТЭЛМЭН Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч

Түлхүүр үг

Төв банк, үндэсний төлбөрийн систем, цахим мөнгө, дижитал хөрөнгө, олон нийтэд зориулсан, банк санхүүгийн байгууллагад зориулсан.

Хураангуй: Сүүлийн жилүүдэд олон улсад төв банкны цахим мөнгөний талаарх судалгаа, туршилтын ажил эрчимжиж байна. Санхүү эдийн засаг, технологийн талаас хийх судалгаанууд явагдахаас гадна эрх зүйн талаас ч мөн адил судалгаанууд хийгдэж байна. Харин Монгол Улсын хувьд эрх зүйн талаас хийсэн судалгаа одоогийн байдлаар байхгүй байгаа тул энэ судалгаа нь суурь судалгаа болох ач холбогдолтой.

Энэхүү судалгааны үндсэн хэсэгт Монгол Улс дахь цахим мөнгөний эрх зүйн зохицуулалт, цахим мөнгөний хэрэгжилт, төв банкны цахим мөнгө болон бусад цахим мөнгөний ялгааг товч авч үзсэн. Дараагийн хэсэг буюу харьцуулсан судалгааны хэсэгт олон улсад эрх зүйн талаас төв банкны цахим мөнгөтэй холбоотой ямар асуудал хөндөгдөж байгааг судалсан. Судалгааны дүгнэлт хэсэгт Монгол Улсад төв банкны цахим мөнгөний талаарх асуудлыг хуулиар хэрхэн зохицуулах боломжтой талаар саналаа дэвшүүлсэн болно.

I. Оршил

Санхүүгийн системийг санхүүгийн зах зээл, санхүүгийн зуучлагч, санхүүгийн зохицуулалт гэж ангилдаг. Санхүүгийн зах зээл нь хөрөнгийн зах зээл, мөнгөний зах зээлээс бүрдэх бол санхүүгийн зуучлагч гэдэг нь арилжааны банк, хадгаламж зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын сан гэх мэт санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагаас бүрдэнэ. Санхүүгийн зохицуулалт гэдэг нь "Санхүүгийн зах зээл маш олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон тэдгээрийн хэрэглэгчээс бүрддэг. Үүнийг зохицуулагч байгууллага бол бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгож буй санхүүгийн байгууллагуудыг хянах, үйл ажиллагааг нь найдвартай байлгах тогтолцоо, арга механизм, эдийн засгийг тогтворжуулах, өсөлтийг нэмэгдүүлэх чиг үүргийг



хэрэгжүүлэх зорилготой төрийн захиргааны байгууллага юм"¹ гэж тодорхойлжээ. Санхүүгийн зохицуулагч байгууллагад Сангийн яам, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо багтана. Сангийн яам нь санхүүгийн зах зээлийг зохицуулах хууль эрх зүйн актуудыг боловсруулан батлуулахаар Монгол Улсын Их Хуралд өргөн барих үүргийг хүлээх бөгөөд санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд ерөнхий хяналтыг тавьж ажиллана².

Монгол Улсын хэмжээнд санхүүгийн зах зээлийг зохицуулах болон тогтвортой байдлыг хангах чиг үүргийг Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо гэсэн хоёр субъект аль алийг нь хосолсон байдлаар хэрэгжүүлдэг. Монголбанк нь Монгол Улсын хэмжээнд мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, төгрөгийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ арилжааны банкны үйл ажиллагаа, үндэсний төлбөрийн системийг хянан зохицуулж ажилладаг³ бол Санхүүгийн Зохицуулах Хороо нь банкнаас бусад санхүүгийн зах зээлийг зохицуулж, тогтвортой байдлыг ханган ажилладаг⁴. Тухайлбал даатгал, үнэт цаас, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо зэрэг байгууллагуудад хяналт тавьдаг.

Олон улсын төлбөр тооцооны банкнаас төлбөрийн систем гэдгийг "төлбөр гүйцэтгэгч, хүлээн авагчийн хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа, түүнийг гүйцэтгэх, үр дүнгийн тооцооллыг хийх эрх бүхий байгууллага, холбогдох дүрэм, журам, гэрээ болон төлбөрийн хэрэгслийн цогц нэгдэл"⁵ гэж тодорхойлсон байдаг. Олон улсын хэмжээнд өндөр түвшний техник технологи хурдацтай нэвтэрч байгаатай холбоотойгоор зах зээлийн хөгжлийн хандлага, эрэлт шаардлагад нийцсэн, арилжааны банк, төлбөрийн картаар үл хязгаарлагдах бэлэн бус төлбөрийн хэрэгслүүд хурдацтайгаар бий болж, төлбөр тооцоог түргэн шуурхай, үр ашигтай гүйцэтгэх боломжууд нэмэгдсээр байна. Үндэстэн дамнасан зөвлөх үйлчилгээний компани болох Capgemini-аас гаргасан дэлхийн төлбөр тооцооны тайлангаас үзвэл 2023 оны байдлаар дэлхий даяар бэлэн бусаар хийгдсэн төлбөр тооцооны хэмжээ 1.3 триллионд хүрсэн бөгөөд цаашдаа жил бүр 15 хувиар өсөх хандлагатай байна⁶. Бэлэн бус төлбөрийн хэрэгслийн эрэлт, хэрэглээ нэмэгдэх тусам төв банкнаас хэвлэдэг бэлэн мөнгөний хэрэглээ буурах бөгөөд энэ хэрээрээ төв банк санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх⁷ үндсэн үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл үүснэ. Тиймээс төв банкууд цахим мөнгө (Central Bank Digital Currency) гарган гүйлгээнд нэвтрүүлэх замаар үүний эсрэг хариу арга хэмжээ авах санаачилга гаргасан. Одоогийн байдлаар 3 улсын⁸ төв банк

¹ Монголбанк, Санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалт ба даатгал, 2022, 9 дэх тал. <https://www.mongolbank.mn/file/files/documents/financialliteracy/publications/36.pdf> (Сүүлд үзсэн: 2025.02.11).

² Мөн тэнд.

³ Төв банк /Монголбанк/-ны тухай хууль (1996)-ийн 3.1, 4.1 дүгээр зүйл.

⁴ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль (2005)-ийн 1.1 дүгээр зүйл.

⁵ "Монгол Улсын төлбөрийн системийн товч танилцуулга", 2021, <https://www.mongolbank.mn/mn/p/1301>, (Сүүлд үзсэн: 2025.02.11).

⁶ The Capgemini Research Institute, "2023 World Payments Report", 2023, <https://www.capgemini.com/news/press-releases/global-non-cash-transaction-volumes-set-to-reach-1-3-trillion-in-2023/>, (Сүүлд үзсэн: 2025.02.11).

⁷ Lambis Dionysopoulos, "Central Bank Digital Currencies: A Critical Review", 2023, p3. <https://www.sciencedirect.com/science/article/pii/S1057521923005471>, (Сүүлд үзсэн: 2025.02.11).

⁸ Бахамын арлууд, Ямайк, Нигери, <https://www.atlanticcouncil.org/cbdctracker/>, (Сүүлд үзсэн: 2025.02.11).



цахим мөнгийг бүрэн нэвтрүүлсэн боловч хөгжингүй улсын төв банкнаас цахим мөнгийг нэвтрүүлсэн тохиолдол байхгүй байна. Гэхдээ ойрын хэдэн жилүүдэд үүнийг нэвтрүүлэх боломжийн талаарх судалгаа болон туршилтын ажиллагаа явагдаж байна.

Олон улсад төв банкны цахим мөнгөний талаарх судалгаанууд нь санхүү эдийн засаг, технологийн талаас авч үзсэн судалгаанууд их ч сүүлийн үед эрх зүйн талаас авч үзэж байна. Энэхүү өгүүлээр манай улс дахь цахим мөнгөний эрх зүйн зохицуулалт, олон улсад төв банкны цахим мөнгөнд холбогдох эрх зүйн асуудал зэргийг судалсны үндсэн дээр манай улсад төв банкны цахим мөнгийг нэвтрүүлэхэд учирч болох эрсдэл түүнийг хэрхэн зохицуулахыг эрх зүйн талаас бичихийг зорилгоо.

II. Үндсэн хэсэг

Энэхүү хэсэгт манай улсын үндэсний төлбөрийн системийн ойлголт, цахим мөнгөний талаарх эрх зүйн зохицуулалт, төв банкны цахим мөнгөний тухай ойлголтын талаар авч үзэх болно.

1. Үндэсний төлбөрийн систем

Монгол Улсын үндэсний төлбөрийн системд Монголбанк, системийн оролцогч, системийн оператор оролцдог⁹. Жишээ нь системийн оролцогч гэдэгт клирингийн, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх, системд шууд болон шууд бусаар төлбөр илгээх, хүлээн авах эрхтэй этгээдийг хэлэх бол системийн оператор гэдэгт Монголбанк, систем ажиллуулах Монголбанкны зөвшөөрөл бүхий хуулийн этгээд. Монголбанк нь төлбөрийн системийн үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, үйл ажиллагаанд оролцох, системд хяналт шалгалт тавих, системийг хөгжүүлэхэд удирдан чиглүүлэх үүрэгтэй. Системийн оролцогчийн Үндэсний төлбөрийн систем нь их дүнтэй гүйлгээний "Банксүлжээ" (RTGS) төлбөрийн систем, бага дүнтэй гүйлгээний "Автомат клиринг хаус" (ACH+) төлбөрийн систем болон төлбөрийн картын систем гэсэн 3 системээс бүрддэг¹⁰.

Их дүнтэй гүйлгээний системээр 5 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ дамждаг бөгөөд Их дүнтэй төлбөрийн системийн дүрмийн 4.2-т зааснаар Монголбанк ажлын өдрийн 09.10–16.30 цаг хүртэл хэрэглэгчийн төгрөгөөр хийгдэх их дүнтэй гүйлгээг, 09.10–17.10 цаг хүртэл санхүүгийн байгууллага хоорондын төгрөгийн гүйлгээг, 09.10–17.00 цаг хүртэл оролцогч хоорондын валютын гүйлгээг тус тус дамжуулна. Жишээ нь А банкны харилцагч Ц банкны харилцагчийн данс руу 6 сая төгрөг шилжүүлэх тухай хүсэлтээ А банканд өгсний дараа тус банк Монголбанкны Банксүлжээ систем рүү хандана, Банксүлжээний системд арилжааны банкуудын харилцах дансууд байдаг тул энэ тохиолдолд А банкны данснаас Ц банк руу 6 сая төгрөг шилжсэн тухай бичилт хийгддэг¹¹. Бага дүнтэй гүйлгээний мөнгөн

⁹ Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал, Монголбанкнаас төлбөрийн системийн талаар баримтлах бодлого (2012), 3 дугаар хэсэг <https://www.mongolbank.mn/mn/tr/2931>, (Сүүлд үзсэн: 2025.02.11).

¹⁰ Өмнөх эшлэл 5.

¹¹ Насан туршийн боловсролын үндэсний төв, "Санхүүгийн боловсрол: Төлбөрийн систем", 2020 <https://www.youtube.com/watch?v=8Q0lw7lQjLE>.



дүнгийн дээд хязгаарыг 3 сая төгрөгөөр тогтоосон¹² ба 24 цагийн хугацааны туршид тасралтгүй мөнгөн гүйлгээг дамжуулдаг. Жишээ нь А банкны харилцагч Ц банкны харилцагчийн данс руу 2 сая төгрөг шилжүүлэх тохиолдолд А банк гүйлгээний хүсэлтийг Монголбанкны Төлбөр тооцооны газрын Үндэсний цахим гүйлгээний төвд илгээдэг, хүсэлтийг хүлээн авсны дараа Ц банканд хүсэлтийг дамжуулснаар Ц банкны харилцагчийн дансанд 2 сая төгрөг байршина. Гүйлгээ хийгдэж дууссаны дараа Үндэсний цахим гүйлгээний төв төлбөр тооцоог Монгол банкны Банксүлжээ системд илгээснээр бичилт хийгддэг¹³. Төлбөрийн картын системийн хувьд гүйлгээ нь Монголбанкны Төлбөр тооцооны газрын Үндэсний цахим гүйлгээний төвөөр дамжин явагддаг.

2. Цахим мөнгө ба түүний эрх зүйн зохицуулалт

Монгол Улс 2018 оноос эхлэн Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг даган мөрдөж байгаа бөгөөд тус хууль батлагдсанаар Монгол улсын хэмжээнд төлбөрийн системд банкнаас бусад хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр оролцох боломжтой болсон бөгөөд төлбөрийн хэрэгслийн хэд хэдэн төрлийг ч тус хуулиар зөвшөөрсөн. Тэдгээрийн нэг нь цахим мөнгө бөгөөд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.25 дах хэсэгт "цахим мөнгө гэж Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгтэй адил үнэ цэнэ бүхий Монгол банкны зөвшөөрөлтэй гаргасан бэлэн бус төлбөрийн хэрэгслийг ойлгоно" гэж заасан. Мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 05 сарын 10-ны өдрийн А-91 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Төлбөрийн системийн журам"-ын 3.4 дэх хэсэгт зааснаар цахим мөнгө нь мөнгөн хөрөнгөд, мөнгөн хөрөнгө нь цахим мөнгөнд чөлөөтэй хөрвөдөг, төгрөгтэй 1:1 хэмжээтэй, мөнгөн хөрөнгөөр баталгаажсан төлбөрийн хэрэгсэл юм. Энэ нь харилцагчид ямар нэг эрсдэл үүсэхээс хамгаалж байгаа хэрэг юм¹⁴.

Цахим мөнгө нь жижиглэнгийн, өдөр тутмын төлбөр төлөхөд зориулсан төлбөрийн хэрэгсэл бөгөөд нэг гүйлгээний дүн нь 5 сая төгрөгөөр хязгаарлагдаж, өндөр дүнтэй хөрөнгө оруулалт хийх, үл хөдлөх хөрөнгө худалдаж авах зорилготой төлбөрийн хэрэгсэл биш.¹⁵ Цахим мөнгө гаргагчид тавигдах шаардлага, цахим мөнгөний үйлчилгээны зохицуулалт, үйл ажиллагаанд тавих хяналт зэргийг Монголбанкнаас тусгайлан зохицуулдаг. 2024 оны 02 дугаар сарын байдлаар Монгол Улсын зах зээлд нийт 8 байгууллага цахим мөнгө гаргах тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна¹⁶. Жишээ нь Монпэй, Покет, Төгс цахим хэтэвч (токи), Супер ап хэтэвч, Хайпэй, Пасс гэх мэт. 2022 оны 2 дугаар улирлын байдлаар нийт гаргасан цахим мөнгөний тоо 11.7 тэрбум, нийт бүртгэлтэй цахим мөнгө хэрэглэгчдийн тоо 1.3 саяд хүрсэн байна¹⁷. Эндээс

¹² Монголбанкны ерөнхийлөгчийн тушаал, Автомат клиринг хаус системээр бодит цагийн горимоор дамжих гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаар батлах тухай, 2021, <https://www.mongolbank.mn/mn/r/3225>, (Сүүлд үзсэн: 2025.02.11).

¹³ Мөн тэнд.

¹⁴ "Big Data" системийг нэвтрүүлснээр банкуудын тайлан тооцоог өдөр бүр хүлээн авах боломж бүрдэнэ", 2023, <https://www.mongolbank.mn/mn/r/5314> (Сүүлд үзсэн: 2025.02.11).

¹⁵ Монголбанк, Төлбөрийн системийн журмын тайлбар, 2024.

¹⁶ "Төлбөрийн хэрэгсэл-цахим мөнгө", 2024, <https://www.mongolbank.mn/file/files/documents/paymentsystems/zuvshuurul.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.02.11).

¹⁷ "Монпэй цахим мөнгөний хугацаагүй зөвшөөрөлтэй боллоо," 2022, <https://lemonpress.mn/post/860zJOMkr3d>, (Сүүлд үзсэн: 2025.02.11).



дүгнэхэд Монгол Улсын хэмжээнд мөн адил санхүүгийн зах зээлд бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээ жил тутам ихсэх хандлагатай байна. Үүний эсрэг олон улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд төв банкууд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах хүрээнд цөөнгүй арга хэмжээг авч байгаа бөгөөд тэдгээрээс хамгийн үр дүнтэй нь төв банк цахим мөнгө гаргах зохицуулалт¹⁸ бөгөөд олон улсууд төв банкны цахим мөнгө гаргах талаар дотооддоо хэлэлцэж байна.

3. Төв банкны цахим мөнгөний талаарх ойлголт

Монголбанкнаас гаргасан судалгаанд дараах шинжүүдийг агуулсан цахим мөнгийг Төв банкны цахим мөнгө гэж үзэх боломжтой гэжээ¹⁹. Үүнд: (i) төв банкнаас гаргасан (ii) албан ёсоор хуульчлагдсан (iii) төв банкаар баталгаажсан (iv) гүйлгээ нь дундын зуучлагчгүй хийгдэх боломжтой (vi) программчлах боломжтой зэрэг орно. Харин Япон Улсын Төв банкнаас (i) цахимжсан, (ii) хууль ёсны мөнгөн тэмдэгт байх, (iii) төв банкнаас гаргасан гэсэн 3 шинжийг хангасан бол төв банкны цахим мөнгө гэж тодорхойлжээ²⁰. Эндээс дүгнэхэд Төв банкнаас цахим хэлбэрээр гүйлгээнд гаргасан мөнгөн тэмдэгтийг төв банкны цахим гэж энгийнээр ойлгохоор байна.

Төв банкны цахим мөнгө нь үндсэн шинжийн хувьд дээр дурдсаны дагуу мөнгөн хөрөнгөд, мөнгөн хөрөнгө нь цахим мөнгөнд чөлөөтэй хөрвөдөг, тухайн улсын үндэсний мөнгөн тэмдэгттэй 1:1 хэмжээтэй, мөнгөн хөрөнгөөр баталгаажсан шинжээрээ адил боловч гол ялгаа нь төв банкнаас цахим хэлбэрээр гүйлгээнд гаргасан шинжээрээ бусад цахим мөнгөнөөс ялгаатай.

Төв банк цахим мөнгө гаргаснаар төлбөрийн системийн тогтвортой байдал, бэлэн мөнгөтэй холбогдон гарах зардал буурах, төрийн тусламж үйлчилгээний цар хүрээ, үйл ажиллагаа сайжрах, санхүүгийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын шилжих сувгийн үр нөлөөг бэхжүүлэх, татварын орчныг сайжруулах, үндэсний мөнгөн тэмдэгтийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нэмэгдүүлэх, төв банкны мөнгөний бүрэн эрхт байдлыг хадгалахуйц цахим мөнгө болох, олон улс хоорондын төлбөр тооцоог сайжруулах зэрэг давуу тал үүснэ²¹. Гэхдээ эдийн засагт давуу тал авчрах боловч банкны салбар зуучлагчийн үүрэг гүйцэтгэхээ болих, төв банкны зардлыг нэмэгдүүлэхээс гадна нэр хүндийн эрсдэлийг дагуулах, шинэ санхүүгийн хэрэгсэл, ойлголтууд, түүнийг зохицуулах хууль, журмын дутмаг байдлаас хамааран санхүүгийн эрсдэл үүсэж болзошгүй, дэд бүтцийн зардал их, бэлэн мөнгийг хэрэглээнээс хасах эсвэл хязгаарлах нь төлбөрийн системийн уян хатан байдлыг бууруулж, нийгмийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарах зэрэг хүндрэлүүд үүсэх эрсдэлтэй²².

¹⁸ European Central Bank, University of Bern and Study Center Gerzensee, "The Economics of Central Bank Digital Currency", 2024.10. p.222, <https://www.ijcb.org/journal/ijcb24q4a4.pdf>. (Сүүлд үзсэн: 2025.02.11).

¹⁹ Монголбанк, "Төв банкны цахим мөнгөний чиг хандлага, үр дүн, анхаарах асуудал" 2022, 25 дахь тал, https://www.mongolbank.mn/file/files/documents/20220822_2.pdf. (Сүүлд үзсэн: 2025.02.11).

²⁰ 「中央銀行デジタル通貨とは何ですか」 <https://www.boj.or.jp/about/education/oshiete/money/c28.htm>. (Сүүлд үзсэн: 2025.02.11).

²¹ Монголбанк, *Өмнөх эшлэл* 19, 28–30 дахь тал.

²² *Мөн тэнд*, 30–31 дахь тал.



Төв банк цахим мөнгө гаргахдаа хэнд зориулж, Төв банк ямар үүрэг оролцоотой байх, дэд бүтэц технологийн шийдэл, системийн нууцлал аюулгүй байдал зэргээ тодорхойлох шаардлагатай²³. Хэнд зориулж буюу хамрах хүрээг олон нийтэд зориулсан (retail) болон банк санхүүгийн байгууллагад зориулсан (wholesale) гэж 2 ангилдаг. Олон нийтэд зориулсан гэдэг нь бага дүнтэй гүйлгээ, төлбөр тооцоо хийхэд ашиглагддаг нийтээр хүлээн зөвшөөрсөн цахим мөнгө бол банк санхүүгийн байгууллагад зориулсан гэдэг нь зөвхөн тодорхой шаардлага хангасан байгууллагуудын хувьд л ашиглах боломжтой (банк эсвэл банк бус санхүүгийн байгууллага гэх мэт) цахим мөнгийг ойлгоно²⁴. Банк санхүүгийн байгууллагад зориулсан хувилбар нь банк хоорондын төлбөрийн системээ илүү үр ашигтай болгохыг зорьж буй хөгжиж буй орнуудад илүү тохиромжтой байдаг гэжээ²⁵.

Төв банкны оролцооны хувьд шууд, шууд бус, хосолмол гэсэн загвартай. Дэд бүтэц, технологийн шийдлийн хувьд уламжлалт буюу төвлөрсөн систем, тархмал бүртгэлийн систем, хосолмол гэсэн 3 ялгаатай хувилбараар зохицуулагдах боломжтой. Системийн нууцлал аюулгүй байдлын хувьд токенд суурилсан, дансанд суурилсан гэсэн 2 загвартай. Токенд суурилсан систем нь төлбөр хүлээн авагчийн тухайн гүйлгээний баталгаажуулалт үнэн зөв эсэхийг хангаж чадаж байгаа эсэх дээр тулгуурладаг бол дансанд суурилсан тогтолцоо нь данс эзэмшигч өөрийгөө мөн болохыг баталж буй байдалд үндэслэдэг²⁶.

Манай улсад төв банкны цахим мөнгөтэй холбоотой судалгаа хийгдсэн боловч хараахан туршилт хийгдэж эхлээгүй ч ирээдүйд судалгаа, туршилтын ажиллагаа эрчимжиж бүрэн нэвтрүүлэх нь цаг хугацааны асуудал юм. Тус судалгаанд төв банкны цахим мөнгийг төлбөр тооцонд ашиглагдаж буй хэлбэрээс манай улсад банк санхүүгийн байгууллагад зориулсан хэлбэрийг нэвтрүүлэх боломж бололцоо байгаа талаар дурджээ²⁷.

Манай улсад одоогоор төв банкны цахим мөнгөний талаар хууль, журамд тусгасан зүйл үгүй бөгөөд нийтлэг цахим мөнгөний талаар зохицуулж буй зохицуулалтуудын хүрээнд төв банкны цахим мөнгийг зохицуулах, хязгаарлах боломжгүй юм. Олон улсын түвшинд бэлэн бус төлбөрийн хэрэгслийн давлагааг сөрж, төв банкны эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болох боломжтой төв банкны цахим мөнгөний эрх зүйн асуудлыг бусад улсууд хэрхэн авч үзэж байгаа талаар танилцуулья.

III. Харьцуулсан судалгаа

Өгүүллийн өмнөх хэсэгт төв банкны цахим мөнгөнөөс гадна үндэсний төлбөрийн систем, цахим мөнгөний эрх зүйн зохицуулалтын талаар авч үзсэн бол харьцуулсан судалгааны хэсэгт олон улсад эрх зүйн талаас төв банкны цахим мөнгийг хэрхэн авч үзэж байгаа талаар судлах болно.

²³ Мөн тэнд, 31 дэх тал.

²⁴ Мөн тэнд, 26 дах тал.

²⁵ Мөн тэнд, 32 дэх тал.

²⁶ Мөн тэнд, 38 дахь тал.

²⁷ Монголбанк, өмнөх эшлэл 9, 52-р хуудас.



Швейцарт төвтэй Төлбөр тооцооны олон улсын банк (the Bank for International Settlements) нь Төв банкны цахим мөнгөтэй холбоотой хэд хэдэн судалгаа хийсэн. Эдгээр судалгаануудыг Америк, Хонконг, Өмнөд Солонгос, Япон, Швед, Сингапур, Өмнөд Африк, Швейцар гэх мэт улсын төв банкууд хамтран гүйцэтгэсэн байна. Сүүлд 2024 оны 11 дүгээр сард олон нийтэд зориулсан Төв банкны цахим мөнгөний эрх зүйн талаас (Legal aspects of retail CBDCs) авч үзэн судалгаа хийгджээ.

Энэхүү судалгаагаар төв банкны цахим мөнгөнд дараах эрх зүйн асуудлуудыг дэвшүүлсэн²⁸. Эдгээрт (1) олон нийтэд зориулсан төв банкны цахим мөнгө эрх зүйн аль салбарт хамаарах эсэх, (2) олон нийтэд зориулсан төв банкны цахим мөнгөний системд оролцогчийн үүрэг болон хариуцлагын асуудал, (3) нууцлал болон санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, (4) хил дамнан төв банкны цахим мөнгөний асуудлуудыг дурджээ.

Нэгдүгээрт, цахим мөнгө нь дижитал хөрөнгө бөгөөд энэ нь өмчлөх эрхэд хамаарах уу гэдэг асуулт үүсэж байгаа бөгөөд зарим судлаач нар цахим мөнгийг уламжлалт өмчийн эрхийн ойлголтоос ялгаатай үзэж байгаа бол UNIDROIT дээр дижитал хөрөнгийг өмчийн эрхийн нэг төрөл гэж үзэн дижитал хөрөнгө эзэмших нь эд хөрөнгийг өмчлөх гэсэн уламжлалт ойлголтыг орлох болно гэжээ²⁹.

Хоёрдугаарт, цахим мөнгөний системд (1) Төв банк, (2) хэрэгжүүлэгч оператор, (3) зуучлагч, (4) хэрэглэгч оролцох боловч эдгээр нь ямар үүрэгтэй байх нь тодорхой бус байна. Хуулийн талаас урьдчилан тооцох боломжгүй эрсдэл үүсэхийг үгүйсгэхгүй гэжээ. Жишээ нь зуучлагч болон оролцогч нарын хооронд комплайнсын эрсдэл үүсэх боломжтой³⁰.

Гуравдугаарт, Төв банк нь мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргаж зохицуулах чиг үүрэгтэй (Monetary Sovereign)³¹ учир цахим мөнгө гаргах нь үүнд хамаарна. Гэхдээ Төв банкнаас цахим мөнгө гаргах нь түүний дээрх чиг үүрэгт зөвхөн хамаарах асуудал бус иргэдийн үндсэн эрхийг зөрчих эрсдэл ч байгаа³². Жишээ нь Төв банкны цахим мөнгөний систем хакердуулсан тохиолдолд иргэдийн халдашгүй чөлөөтэй байх, өмчлөх эрх ноцтой зөрчигдөнө. Америкийн Нэгдсэн Улс, Их Британи, Шинэ Зеландад нийтийг хамарсан хэлэлцүүлэг өрнүүлсэн бол Япон Улсын хувьд нийт иргэдийн ердөө 4.7 хувь нь л Төв банкны цахим мөнгөний талаарх ойлголттой байхад Төв банк нь 2023 оны 03 дугаар сарын 28-нд цахим мөнгө хэвлэн гаргах тухайгаа мэдэгдсэнийг зарим судлаач нар нь шүүмжилсэн³³.

Тухайлбал Япон Улсын Төв банк нь цахим мөнгөтэй холбоотой судалгааны тайланг өөрсдийн албан ёсны цахим хуудсанд³⁴ байршуулж байгаа нь Япон

²⁸ Bank for International Settlements (BIS), "Central bank digital currencies: legal and system design considerations" 2024, https://www.bis.org/publ/othp88_legal.pdf (Сүүлд үзсэн: 2025.02.11).

²⁹ *Ibid*, p. 9-11.

³⁰ *Ibid*, p. 15-16.

³¹ Улс орон нь өөрийн мөнгөн тэмдэгтийн зохицуулах эрхтэй гэдгийг 1929 онд Олон Улсын Шүүхийн шийдвэрээр (Serbian Loans Case, 1929) хүлээн зөвшөөрчээ, https://www.worldcourts.com/pcij/eng/decisions/1929.07.12_payment1.htm, (Сүүлд үзсэн: 2025.02.11).

³² 久保田隆「金融システムと経済安全保障—全体像と中央銀行デジタル通貨（CBDC）の課題」法律時報96巻1号（2024年）39頁。

³³ 前掲注）39～40頁。

³⁴ Япон Улсын Төв Банкнаас цахим мөнгөтэй холбогдох судалгааны материалуудыг доорх хэсгээс



Улсын Төв Банкны тухай хууль³⁵ (日本銀行法)-ийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Төв банкны мөнгөн тэмдэгт болон мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх бие даасан байдлыг хүндэтгэх ёстой" мөн тус зүйлийн 3.2-т "Төв банк нь мөнгөн тэмдэгт болон мөнгөний бодлоготой холбогдох шийдвэрийн агуулга, үйл явцыг ард иргэдэд тайлагнах үүрэгтэй" гэж заасантай нийцэж байгаа ч Бүгд Найрамдах Хятад Ард Улс гэх мэт улс төрийн авторитари дэглэмтэй улсаас ялгаатай нь парламентын ардчилсан засаглалтай улс тул Төв банк нь олон нийтэд чиглэсэн хэлэлцүүлэг өрнүүлэх ёстой гэж шүүмжилж байжээ³⁶. 2024 оны 03 дугаар сард Төв банкны цахим мөнгөний талаар нийт иргэдийн 3.1 хувь байгаа учир олон нийтэд зориулсан Төв банкны цахим мөнгийг нэвтрүүлэх эсэх талаар олон нийтийн хэлэлцүүлэг шаардлагатай гэжээ³⁷. Европын холбооны Төв банк 2023 онд цахим мөнгөний журмын төслийг (Digital Euro Regulation) өргөн барьсан. Энэхүү журамд албан ёсоор цахим мөнгө буюу дижитал еврог нэвтрүүлэх хүртэлх процессыг зохицуулсан байна.

Дөрөвдүгээрт, хил дамнасан төв банкны цахим мөнгөний асуудал бөгөөд үүнд гадаадын иргэнд төв банкны цахим мөнгө авах эрх олгох, талуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд харьяаллыг шийдвэрлэх зэрэг асуудлууд хамаарна. Юун түрүүнд гадаадын иргэнд төв банкны цахим мөнгө авах эрхийг олгох эсэх асуудал нь зарчмын хувьд үндэсний мөнгөн тэмдэгтийн гадагш гарах урсгалын тогтвортой байдалтай холбогдоно. Тиймд хэрвээ гадаадын иргэнд төв банкны цахим мөнгө авах эрх олгох тохиолдолд түүнтэй холбогдох дүрэм журмыг Монгол Улсын нутаг дэвсгэрт Монгол Улсын иргэнд үйлчилдгээс өөрөөр зохицуулах шаардлагатай. Ялангуяа худалдаж авч байгаа улсын валютын өртгийг ямар ханшаар тооцох болон мөнгө угаахтай холбоотой эрсдэлийг илүү нарийн зохицуулах шаардлагатай болно. Гадаадын иргэнд төв банкны цахим мөнгө авах эрхийг тодорхой дүнгийн хязгаарлалттайгаар олгох нь мөнгө угаах зэрэг эдийн засгийн гэмт хэргийн эрсдэлийг бууруулах арга байж болох юм.

Харьяалалтай холбогдох өөр нэг асуудал нь талуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд хэрэглэх хуулийг тодорхойлох асуудал юм. Хэрэглэх хуулийг сонгох хүрээнд олон улсад уламжлалт арга, системээр тодорхойлох арга, хуулиар шинэ харьяалал тогтоох аргуудаас аль нэгийг эсхүл хослуулах байдлаар сонгон ашиглахыг санал болгож байна. Энэ асуудлын хүрээнд хуулиар шинэ харьяалал тогтоох аргыг ашиглах хандлагатай байна.

IV. Дүгнэлт

Манай улсад цахим мөнгөний талаарх эрх зүйн зохицуулалт байгаа бөгөөд хувийн байгууллагаас гаргасан цахим мөнгө зонхилж байна. Одоогоор төв банкны цахим мөнгөний талаар хууль, журамд тусгасан зүйл үгүй бөгөөд төв банкны цахим мөнгөний тогтолцоог нэвтрүүлсэн тохиолдолд одоогийн эрх зүйн зохицуулалт

үзнэ үү, <https://www.boj.or.jp/paym/digital/index.htm>, (Сүүлд үзсэн: 2025.02.11).

³⁵ Япон Улсын Төв Банкны тухай хууль (1997), <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3788>, (Сүүлд үзсэн: 2025.02.11).

³⁶ 前掲注) 40頁。

³⁷ 久保田隆「中央銀行デジタル通貨(CBDC)と経済安全保障を巡る法的視座」国際商事法務52巻5号(2024年)566頁。



нь учир дутагдалтай.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд эрх зүйн талаас үүсэж болох асуудлууд байгаа ч эдгээрээс өөр урьдчилан таамаглах боломжгүй асуудлууд бий болохыг үгүйсгэхгүй юм. Юуны өмнө төв банк олон нийтэд зориулсан цахим мөнгө гүйлгээнд нэвтрүүлэх нь хүний үндсэн эрхтэй холбогдох учраас олон улсад олон нийтийн асуулга явуулахыг чухалчилж байна. Төв банкны цахим мөнгөний харилцаанд оролцох этгээдүүдийн хоорондын харилцааг хэрхэн зохистой зохицуулах эсэх нь тодорхойгүй байна.

Гадаадын иргэнд төв банкны цахим мөнгө авах эрхийг хязгаарлалттайгаар олгох нь эдийн засгийн гэмт хэргийн эрсдэлийг буруулахад ач холбогдолтой. Түүнчлэн маргаан үүссэн тохиолдолд хэргийн харьяаллыг сонгох 3 аргыг санал болгож байгаа ч тэдгээрээс хууль, журмаар шинэ харьяалал тогтоох аргыг ашиглах хандлагатай байна. Иймд судлаач нарын зүгээс дараах саналыг дэвшүүллээ.

- Монгол банк төв банкны цахим мөнгөтэй холбоотой мэдээллийг иргэдэд өргөн хүрээнд түгээж, иргэдийн мэдээллийг дээшлүүлэх;
- Төв банкны тухай хуульд цахим мөнгөний талаарх зохицуулалтыг тусгах;
- Төв банкны цахим мөнгөний харилцаанд оролцогч нарын эрх үүрэг, хариуцлагыг холбогдох хуулиудад нарийвчлан заах;
- Хуулиар гадаадын иргэнд төв банкны цахим мөнгө авах эрхийн дүнг заах;
- Төв банкны цахим мөнгө өөрийн гэсэн онцлогтой учраас маргаан үүссэн тохиолдолд хэргийн харьяаллыг сонгох аргуудаас хуулиар шинэ харьяалал тогтоох аргыг ашиглах.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, 1996 он.
2. Санхүүгийн Зохицуулах Хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 2005 он.

Г.Бусад

3. Монгол банк "Төв банкны цахим мөнгөний чиг хандлага, үр дүн, анхаарах асуудал."

2. Гадаад эх сурвалж

А. Англи хэл дээр

1. The Capgemini Research Institute, "2023 World Payments Report", 2023.
2. Lambis Dionysopoulos, "Central Bank Digital Currencies: A Critical Review", 2023.
3. Patrick Schueffel, "CBDCs: Pros and Cons A comprehensive list and discussion of the advantages and disadvantages of central CBDC", 2023.
4. European Central Bank, University of Bern and Study Center Gerzensee, "The



Economics of Central Bank Digital Currency", 2024.

5. Bank for International Settlements (BIS), "Central bank digital currencies: legal and system design considerations", 2024

Б. Япон хэл дээр

6. 久保田隆「金融システムと経済安全保障—全体像と中央銀行デジタル通貨（CBDC）の課題」法律時報96巻1号（2024年）
7. 久保田隆「中央銀行デジタル通貨（CBDC）と経済安全保障を巡る法的視座」国際商事法務52巻5号（2024年）
8. Япон Улсын Төв Банкны тухай хууль (1997)

3. Цахим эх сурвалж

1. Монголбанкны цахим хуудас: <https://www.mongolbank.mn/mn/>
2. Япон Улсын эрх зүйн хэм хэмжээний актын орчуулгын цахим хуудас: <https://www.japaneselawtranslation.go.jp/en/dicts/>
3. Япон Улсын Төв банкны цахим хуудас: <https://www.boj.or.jp/paym/digital/index.htm>
4. Lemonpress цахим хуудас: <https://lemonpress.mn/>



Abstract

LEGAL REGULATION OF CENTRAL BANK DIGITAL CURRENCY: INTERNATIONAL APPROACH

ERKHBILGUUN, E.

Master of laws (LL.M)

Researcher, Judicial Academy under the Supreme Court of Mongolia

TELMEN, B.

Lawyer, member of Mongolian Bar Association

In recent years, research and experimentation on Central bank digital currency has intensified. In addition to financial, economic, and technological study, legal studies are also being conducted. However, since there is currently no research conducted on the legal aspect in Mongolia, this study is important as a baseline study. The body of this study discusses the legal regulation of digital currency in Mongolia, the implementation of digital currency, and the differences between central bank digital currency and other digital currency. The comparative study section examined the legal issues raised internationally regarding central bank digital currency. The conclusion presented suggestions on how the issue of central bank digital currency can be regulated by law of Mongolia.

Keywords: Central bank, national payment system, digital currency, digital assets, retail, wholesale

ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БА АРГАГҮЙ ХАМГААЛАЛТЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Д.ОТГОНБАЯР¹

-
- Удиртгал
 - Үндсэн хэсэг
 - Нийгэмд аюултай үйлдэлд аргагүй хамгаалалт хийх эрх
 - Аргагүй хамгаалалтын шинжид гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив ба субъектив шинж агуулагдах нь
 - Аргагүй хамгаалалтаар хэргийг хэрэгсэхгүй болгож буй шүүхийн практик
 - Дүгнэлт, санал
-

¹ Хууль зүйн магистр /LL.M-NUM/.



**ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХҮҮН
БА АРГАГҮЙ ХАМГААЛАЛТЫН
ХАРИЛЦАН ХАМААРАЛ**

Д.ОТГОНБАЯР *Хууль зүйн магистр /LL.M-NUM/.*

Түлхүүр үг

Гэмт хэрэг, гэмт хэргийн бүрэлдэхүүн, аргагүй хамгаалалт, гэмт хэргийн шинжгүй, довтолгоо.

Хураангуй: Гэмт хэрэг мөн эсэхийг шалгаж тогтооход гэмт хэргийн бүрэлдэхүүний онолыг ашиглах бөгөөд тухайн гэмт хэрэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив, субъектив шинжийг хангасан тохиолдолд гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хангасан гэж үзэж тухайн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Гэмт хэргийн бүрэлдэхүүн гэдэг ойлголтыг зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангитай холбон тайлбарлах нь өрөөсгөл ойлголт юм. Судлаачийн зүгээс аргагүй хамгаалалт нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулдаг эсэх асуудлыг дэвшүүлж, аргагүй хамгаалалтыг гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож буй асуудалд дүн шинжилгээ хийж, энэ асуудлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой талаар дүгнэлт, санал дэвшүүлсэн болно.

I. Удиртгал

Амьд явах эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар баталгаажуулсан нь хүний жам ёсны эрх болохыг хүлээн зөвшөөрсөн явдал ба энэ эрхийг баталгаатай эдлүүлэх бүхий л арга хэмжээг төр авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Амьд явах нь өргөн агуулгатай ба энэ эрхийн агуулгад аюултай нөхцөл байдал илэрсэн үед өөрийгөө хамгаалах эрх хамаардаг. Харин Эрүүгийн хуулиар аргагүй хамгаалалт хийх эрхийг олгосон нь хүний амьд явах эрхийн зарчимд нийцүүлсэн төдийгүй иргэн жам ёсны эрхээ эдэлж хууль бус халдлага, довтолгооноос хамгаалах боломжийг бүрдүүлсэн явдал билээ.

Аргагүй хамгаалалт нь хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд хохирол учруулдаг гэмт хэргийн шинжтэй үйлдэл боловч нийгэмд ашигтай үйлдэл байдаг тул гэмт хэрэгт тооцдоггүй. Гэмт хэрэгт холбогдсон этгээдийг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал буюу аргагүй хамгаалалт хэрэглэсэн гэж дүгнэсэн мөртлөө гэмт хэргийн шинжгүй, гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал



тогтоогдсон гэх өөр өөр үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа тохиолдол нэлээдгүй байна.

Харин аргагүй хамгаалалтын шинж нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжтэй салшгүй холбоотой ойлголт бөгөөд аргагүй хамгаалалтыг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэх агуулгаар тайлбарлан хэрэглэж буй асуудлыг аргагүй хамгаалалтын шинжийн үүднээс тус тусдаа өөр өөр ойлголт болохыг тайлбарлах болно. Харин энэ өгүүлэлд гэмт хэргийн бүрэлдэхүүн гэх бие даасан ойлголтын талаар өгүүлээгүй гэдгийг дурдах нь зүйтэй.

II. Үндсэн хэсэг

1. Нийгэмд аюультай үйлдэлд аргагүй хамгаалалт хийх эрх

Аргагүй хамгаалалт хийх нь шударга бус явдлыг таслан зогсоох гэсэн зарчмын агуулгыг илэрхийлэх¹ бөгөөд нэг талаас жам ёсны эрхээ эдлэх, нөгөө талаас эрх зүйн баталгаа болдог байна. Аргагүй хамгаалалтын онолын үндэслэл нь Үндсэн хуулийн амьд явах эрхтэй холбогдоно. Аргагүй хамгаалалт нь хүнийг зориудаар үхэлд хүргэх цорын ганц энх тайвны үндэслэл бөгөөд амьд явах эрхийг бүх эрхийн тулгуур цэг, дээд эрх гэх мэтээр тодорхойлжээ². Хувь хүн өөрийн жам ёсны эрхээ хууль бус халдлагаас хамгаалах боломжийг хүн бүрд олгосон ба аргагүй хамгаалалт хийх эрх нь хүний хамгийн үнэ цэнтэй, суурь эрх болох амьд явах эрхээс үүсэлтэй. Иймээс энэ эрхийг Үндсэн хуулиас үүсэл бүхий эрх хэмээн ойлгож болно³ гэсэнтэй санал нийлж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж заасан нь өргөн утгаараа гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлуудыг Эрүүгийн хуулиар тогтоох үйл ажиллагааны эрх зүйн үндэс болж байна⁴.

Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал гэдэгт бусдын хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол халдаж бусдад гэм хор учруулсан боловч эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг няцааж буй онцлог нөхцөл байдлыг ойлгох ба хууль тогтоогчийн зүгээс гэмт хэргийн тухай асуудалд бодитой хандсаны илрэл болдог. Гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлыг үгүйсгэлийнх нь шалгуур шинжээр нь хууль зүйн болон онолын гэж ангилдаг⁵ байна. Хууль зүйн үндэслэлд аргагүй хамгаалалт, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах,

¹ Entscheidungssammlung des Reichsgerichts in Strafsachen 21, 168, 170.

² Jan Arno Hessbruegge. *Human rights and personal Self-Defense in international law*, New York, NY: Oxford University press, 2017, p.103.

³ Т.Золбоо, *Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/. Гэмт хэргийн бүтээц*, гурав дахь хэвлэл, УБ., 2023, 116 дахь тал.

⁴ С.Жанцан, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /гэмт хэргийн тухай сургаал/, I боть*, УБ., 2009, 665 дахь тал.

⁵ С.Жанцан, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол*, УБ., 2009, 752 дахь тал; С.Нарангэрэл, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/, УБ., 1999, 190 дэх тал*; Ж.Авхиа, Б.Ганболд, *Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар*, УБ., 2002, 132 дахь тал; Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал*, УБ., 2004, 109 дэх тал.



саатуулах үед гэм хор учруулах, гарцаагүй байдал, үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл, тушаал, захирамж биелүүлэх нөхцөлүүдийг Монгол Улсын Эрүүгийн хуулиар баталгаажуулсан байна. Харин онолын үндэслэлд бие махбод, сэтгэл санааны тулган хавчилт, мэргэжлийн болон албаны хувьд гүйцэтгэх үүргээ биелүүлэх, хохирогчийн зөвшөөрөл, өөрийн эрхээ эдлэх, хууль биелүүлэх зэрэг хамаарна.

Гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийж, халдагч этгээдэд гэм хор учруулан өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах эрхийг иргэнд хуулиар зөвшөөрсөн бөгөөд аргагүй хамгаалалт хийсэн хүний санаа сэдэл, учруулсан хохирол нь бодит агуулгаараа нийгэмд ашигтай буюу гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэдгээрээ чухал ач холбогдолтой байдаг.

Аргагүй хамгаалалтын үед хүний амь насыг хохироох явдал гарахыг үгүйсгэхгүй бөгөөд хүний амь насыг хохироох нь үндэслэлтэй, үндэслэлгүй төрөлд хуваагддаг⁶. Үндэслэлгүй хохироох гэмт хэрэгт хүнийг санаатай алах, үхэлд хүргэх нөхцөл байдлыг бий болгох⁷ /хүнийг амиа хорлох нөхцөл байдал хүргэх/, болгоомжгүйгээр хүний амь насыг хохироох зэрэг хамаарна. Үндэслэлтэй хүний амь насыг хохироох гэдэгт дайн байлдааны үед дайснаа хөнөөх, өөрийгөө хамгаалах зорилгоор эрх зүйн хэм хэмжээний дотор хүний амь насанд хүрэхийг ойлгоно. Хүний амь насыг хөнөөх, бие махбодод хүнд гэмтэл учруулах зорилгоор бусдын халдлагаас өөрийгөө болон бусдын хамгаалах нь хүлээн зөвшөөрөгдсөн хандлага болсон байна. Өөрөөр хэлбэл, хэрэг үйлдэж буй этгээд бусдын орон байр руу дайран орох, бусдын амь насанд заналхийлсэн үйлдэл хийснээр өөрийн амьд явах эрхээ алддаг.

2. Аргагүй хамгаалалтын шинжид гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив ба субъектив шинж агуулагдах нь

Гэмт хэрэг мөн эсэхийг тодорхойлохдоо гэмт хэргийн бүрэлдэхүүнийг шалгах бөгөөд аль нэг шинж нь үгүйсгэгдсэн тохиолдолд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй хэмээн үзэж зүйлчлэх боломжгүй юм. Энэ талаар Б.Содовсүрэн "Тус улсын эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэж шийтгэл оногдуулахын үндэс бол уг этгээдийн үйлдэлд гэмт хэргийн бүрэлдүүн байгаа эсэхийг тогтоох явдал мөн. Гэмт хэрэг, гэмт хэргийн бүрэлдүүний тухай саланги болгож болохгүй, тодорхой этгээдийн үйлдэлд гэмт хэргийн бүрэлдүүн байснаар тодорхой гэмт хэргийн ойлголт бий болно" гэсэн нь гэмт хэргийг зүйлчлэхэд гэмт хэргийн бүрэлдэхүүн чухал болохыг харуулж байна.

Эрүүгийн эрх зүйн анхны бүтээл гэгддэг "БНМАУ-ын эрүүгийн эрх. Ерөнхий анги" бүтээлд гэмт хэргийн бүрэлдүүнийг "эрүүгийн хуульд заасан тодорхой гэмт хэргийн объектив, субъектив шинж тэмдгүүдийг тодорхойлсон эрхийн хэм хэмжээний цогцолбор"⁸ гэж тодорхойлсон юм. Мөн гэмт хэргийн бүрэлдэхүүний талаар академик С.Нарангэрэл "гэмт хэргийн гол, зайлшгүй чухал, нийтлэг

⁶ Robin Heid, *The right of self defense supersedes the right to life*, Colorado, 1992, p.1.

⁷ Ямар ч нөхцөл байдлын улмаас өөрт хамааралтай этгээдэд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, ёс суртахуунгүй үйлдэл гаргах замаар амиа хорлох нөхцөл байдалд хүргэнэ. Шалтгаан нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хөрөнгө мөнгө, албан тушаал зэрэг ямар ч шалтгаантай байж болно. /Д.О/

⁸ Б.Содовсүрэн, *БНМАУ-ын эрүүгийн эрх. Ерөнхий анги*, УБ., 1969, 67 дахь тал.



шинжийг агуулсан тодорхой төрлийн гэмт хэргийн хуульчлан тогтоосон загварчлал мөн"⁹ гэж тодорхойлсон байна.

Аргагүй хамгаалалтын шинжийг¹⁰ тодорхойлбол:

- I. Аргагүй хамгаалалтын объектив элемент
 1. Аргагүй хамгаалалт хийх нөхцөл
 - A. Довтолгоо
 - B. Довтолгоо байгаа эсэх
 - B. Довтолгооны хууль бус байдал
 2. Аргагүй хамгаалалтын үйлдэл
 - A. Үйлдэл нь довтлогчийн эсрэг байна.
 - B. Үйлдэл нь зайлшгүй байх
 - аа) Үйлдэл тохирсон байх
 - бб) Үйлдэл боломжит бага хохирол учруулсан байх
 3. Үр дүнтэй аргаар хамгаалалт хийх
 - A. Довтолгоо болон эрх ашгийн хоорондох тэнцвэртэй байдал
 - B. Гэм буруугүйгээр довтлох /бага насны хүүхэд, сэтгэцийн өөрчлөлттэй хүн, согтуу хүн/
 - C. Ойр дотны хүмүүсийн довтолгоон
 - D. Өдөөн хатгалтын үр дүнд хийсэн хязгаарлалт
- II. Аргагүй хамгаалалтын субъектив элемент
 1. Хамгаалах зорилготой хүсэх элемент

Хүснэгт 1. Аргагүй хамгаалалтын шинж

Аргагүй хамгаалалт хийх эрх нь нэг талаас иргэн үндсэн эрхээ эдлэх боломж байх ба нөгөө талаас хамгаалалт хийсний үр дүнд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигддөг тул аргагүй хамгаалалт хууль ёсны байх шинжийг хангах шаардлагатай. Хамгаалагч этгээдийн эсрэг Эрүүгийн хуулийн тусгай ангиар хориглосон үйлдэл хийгдэхийг халдлага нийгэмд аюултай байх гэж ойлгоно. Тухайлбал, бусдын амь насыг хохироох, бие махбодод нь гэмтэл учруулах, бэлгийн эрх чөлөөг зөрчиж хүчиндэх, халдашгүй чөлөөтэй байх эрхэд халдаж хүн хулгайлах, хүн барьцаалах, дээрэмдэх, хулгайлах зэрэг хүч хэрэглэсэн гэмт хэргийн үеийн халдлага ямагт хохирол учруулахаар шууд заналхийлсэн шинжтэй тул нийгэмд аюултай халдлага байдаг. Халдлага үйлдэж буй этгээдээс шууд заналхийлсэн шинжтэй үйлдэл гаргавал аргагүй хамгаалалт хийх эрхтэйг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгээр авч үзсэн. Хэлбэрийн шинжтэй хэрэг үйлдсэн боловч тэр нь нийгмийн аюулын хувьд ялимгүй бол аргагүй хамгаалалтын нөхцөлд байсан гэж үзэхгүй¹¹, хамгаалалт

⁹ С.Нарангэрэл, *Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс (онол, практик)*, УБ., 1988, 54 дэх тал.

¹⁰ Т.Золбоо, *Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/. гэмт хэргийн бүтээц*, УБ., 2023, 118 дахь тал; Rudolf Rengier. *Strafrecht Allgemeiner Teil /Grundrisse des Rechts/*, s.143

¹¹ С.Нарангэрэл, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/*, УБ., 1999, 193 дахь тал.



хийж гэм хор учруулсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх талаар Дээд шүүх дүгнэж бичсэн¹² байна.

Эрүүгийн хуульд заасан аргагүй хамгаалалтын шинжийг хангахын тулд объектив шаардлага буюу халдлага байх ёстой. Халдлага гэдэг нь хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд шууд заналхийлсэн шинжтэй үйлдлийг ойлгоно¹³.

Монгол Улсын эрүүгийн хуулиар аргагүй хамгаалалтын объектыг "Өөрийн, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг ..." гэж тодорхойлжээ. Энэ нь аргагүй хамгаалалт хийхийн тулд дээр дурдсан объектыг л хамгаалах зорилго, сэдэлттэй байна. Манай улсын аргагүй хамгаалалтын объектыг амьд явах эрх, эрүүл мэндийн эсрэг эрх гэсэн нь эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудын эрх зүйн зохицуулалттай төстэй байна.

Хамгаалалтын объектоос аргагүй хамгаалалт болон эрүүгийн эрх зүйн тусгай ангийн уялдаа холбоо харагдаж байна. Тухайлбал, аргагүй хамгаалалт нь зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүний амьд явах эрх, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг дээр л хэрэглэгдэх боломжтой. Өмнөх эрүүгийн хуулиудын хамгаалалтын объектоор холбоотойгоор эрүүгийн хуулийн тусгай ангийн нэлээдгүй хэрэгт аргагүй хамгаалалт хийх боломжтой байв.

Аргагүй хамгаалалт хийх объектив талын эхний шинж нь довтолгоон байх бөгөөд довтолгоон нь хууль бус, бодитой байх шинжийг өөртөө агуулдаг. Довтолгоон гэдгийг хуулиар хамгаалагдсан амь нас, эрүүл мэндийг аюулд оруулах эсвэл гэмтээж байгаа зөвхөн бие хүний зан үйл гэж тодорхойлжээ. Довтолгоон нь голдуу идэвхтэй үйл ажиллагаагаар илэрдэг ч эс үйлдэхүйгээр илэрч болно. Тухайлбал, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 10.5 дугаар зүйл.

Аргагүй хамгаалалтыг өмнөх эрүүгийн хуулиар нийгэмд аюултай халдлага гэж тодорхойлсон бол шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг хийх шаардлага тавигдах болсонд судлаачид шүүмжлэлтэй хандсан юм. Тухайлбал, Эрүүгийн хуулиар аргагүй хамгаалалт хийх эрхийг зөвхөн довтолгооноор хязгаарлаж, угтаа амь насанд аюултай хүч хэрэглэхээр бодитой заналхийлэх тохиолдолд гэм буруутай этгээдэд гэм хор учруулсан бол аргагүй хамгаалалт гэж тооцохоо больсон байна¹⁴. Мөн Эрүүгийн хуульд заасан хууль бус довтолгоо гэсэн нь хэт хэлбэрийн шинжийг агуулсан талаар дурджээ. Халдлага нь хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд заналхийлсэн үйлдэл бол довтолгоон өөрийн үйлдлийг удирдаж, ухамсарлаж байгаа боловч бусдыг гэмтээх, аюул учруулахуйц үйлдэл гаргахыг ойлгох юм. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулиар халдлага гэснийг халж, хууль бус довтолгоо гэж тодорхойлсон нь "заналхийлэх" үйлдэл нь бие даасан гэмт хэрэг болж, хуульчилсантай холбоотой байж болох юм. Учир нь бусад этгээдээс амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн үйлдэл гаргавал эрх бүхий байгууллагад хандаж, гэм буруутайн тогтоогдвол эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой

¹² Улсын дээд шүүхийн 1980.09.10-ны өдрийн 30 дугаар тогтоол.

¹³ Schönke/Schröder/Perron/Eisele, § 32 Rn. 3; so auch Kindhäuser, LPK-StGB, § 32 Rn. 9; Roxin, AT, § 15 Rn. 6; Wessels/Beulke/Satzger, AT, § 10 Rn. 494.

¹⁴ С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж*, нэгэнт сэдэвт бүтээл. УБ., 2019, 174 дахь тал.



юм. Харин аргагүй хамгаалалт хийх эрхийг бусад этгээдээс заавал хууль бус довтолгоо эхлэх гэж байгаа, эхэлсэн үргэлжилж байгаа, довтолгоо төгсөөгүй байх шинжүүд хамаарах юм.

Зарим тохиолдолд довтолгоон үргэлжлэх шинжтэй байдаг тул объектив нөхцөл байдалд зөв дүгнэлт хийсний үндсэн дээр өрсөж хамгаалалт хийж буй үйлдлийг аргагүй хамгаалалтын хүрээнд хийгдсэн гэж үзнэ. Үргэлжилсэн довтолгооны үед халдагч этгээдийн зүгээс дахин халдлага үйлдэх нь бодитоор бий болсон, түүний нийгэмд аюултай, хууль бус үйлдлийн улмаас өөрийн эсхүл бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учрах нь тодорхой болсон тохиолдолд дахин довтолгоон эхлүүлэхийг хүлээх нь аргагүй хамгаалалтыг хэрэгжүүлэх боломжит цаг хугацаа, магадлалыг бууруулж болзошгүй юм. Тиймээс дахин довтолгоон ирэхийг хүлээхгүйгээр хамгаалалт хийсэн тохиолдолд хууль ёсны гэж үзнэ.

Аргагүй хамгаалалтын үеийн довтолгоон идэвхтэй үйл ажиллагаар илрэх ба эс үйлдэхгүйгээр илрэх боломжгүй юм. Тушаал авсан цэргийн албан хаагч санаатайгаар биелүүлээгүй, татгалзсанаас цэргийн албаны үйл ажиллагаанд ноцтой хохирол учрахаар байвал хууль бус ажиллагааг таслан зогсоох зорилгоор түүнд аргагүй хамгаалалтын арга хэмжээг хэрэглэж болно¹⁵ гэж дүгнэсэнтэй санал нийлэх боломжгүй. Учир нь довтолгоон нь хүний амь нас, эрүүл мэндийг аюулд оруулах нөхцөл байдал үүсдэг тул албаны үйл ажиллагаа алдагдахыг эс үйлдэхгүйгээр илэрсэн довтолгоо гэж үзэхгүй.

Довтолгоо төгссөн хойно хийсэн үйлдлийг аргагүй хамгаалалтад тооцохгүй байхаар гэж заасан. Өөрөөр хэлбэл, гэмт халдлага, хүч хэрэглэсэн довтолгоон бодитой нэгэнт эхэлсэн, Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд хохирол учруулах нь хэн бүхэнд илэрхий, тодорхой, ойлгомжтой болсон, аюул занал бодитой оршиж, халдлага үргэлжилж буй, довтолгоо дуусаагүй үед хамгаалалт хийх эрх үүснэ. Энэ үед өрсөж хамгаалах нь аргагүй хамгаалалтын хүрээнд хийгдсэн хууль ёсны үйлдэлд тооцогддог ба харин дээрх бодит аюул тулгараагүй тохиолдолд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал үүсэхгүй.

Аргагүй хамгаалалт хийх объектив талын хоёр дахь шинж нь довтолгоон бодитой байх явдал юм. Халдлага бодитой эхэлсэн, хуулиар хамгаалагдсан эрх ашиг сонирхолд хохирол учруулах нь тодорхой болсон үед хамгаалалт хийх эрх үүснэ. Довтолгоо бодитой байх гэдгийг довтолгоон шууд өөрт хандан эхлэх гэж байгаа нь тодорхой болсон, эхэлсэн эсвэл эхлээд үргэлжилж байхыг хэлнэ¹⁶. Өөрөөр хэлбэл, довтолгоон эхлэх нь тодорхой болсныг бодитой заналхийлэл болсон гэж үзнэ. Энэ талаар академич С.Нарангэрэл "хэрэв халдлага эхэлсэн буюу эсхүл хэргийн нөхцөл байдлаас шалтгаалж тэр даруйхан эхлэх байсныг халдлага бодитой болсонд тооцно. Мөн аргагүй хамгаалалтыг нийгэмд аюултай халдлагын төдийгүй довтолгооны заналхийлэл шууд тулгарсан нөхцөлд хийж болно"¹⁷ гэж дүгнэжээ.

¹⁵ С.Жанцан, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /I боть/*. УБ., 2009, 679 дэх тал.

¹⁶ С.Нарангэрэл, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/*, УБ., 1999. 193 дахь тал; Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган, *Монгол Улсын эрүүгийн Эрх зүйн удиртгал*, УБ., 2004, 109 дэх тал.

¹⁷ С.Нарангэрэл, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/*, УБ., 1999. 194 дэх тал.



Аргагүй хамгаалалтын үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй үйлдэл мөн. Гэмт хэргийн шинжтэй үйлдэл гэдгийг Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй юм. Харин аргагүй хамгаалалтыг хууль ёсны дагуу хийсэн гэж шүүхээс дүгнэсэн тохиолдолд гэмт хэргийн шинжгүй гэдэг үндэслэлээр хэрэгсэхгүй болгох нь утгагүй зүйл юм. Өөрөөр хэлбэл, аргагүй хамгаалалт хийх үеэс гэмт хэргийн шинжийг агуулж байдаг гэсэн үг.

Гэмт хэргийн шинжгүй үндэслэлд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй¹⁸ гэж заасныг хамааруулж болно.

Аргагүй хамгаалалтын үйлдэл нь халдагч этгээдийн халдлагын эсрэг чиглэсэн байх ба довтолгооны эсрэг чиглэсэн байх, зайлшгүй байх, хамгаалалт хийхээс өөр аргагүй байх үндсэн шинжийг агуулна. Эхний шинж болох аргагүй хамгаалалтын үйлдэлд халдагч, хамгаалагч этгээдээс өөр гуравдагч этгээдийн асуудал яригдах боломжгүй. Учир нь халдагч этгээд, хамгаалагч этгээдийн хоорондын харилцааг аргагүй хамгаалалтаар зохицуулагдах боломжтой. Энэ талаар доктор Т.Золбоо "гуравдагч этгээдтэй холбоотой харилцааг аргагүй тусламжийн ойлголтоор тодорхойлно" гэж бичсэн байна.

Өөрийгөө хамгаалж буй этгээдийн үйлдэл нь довтолгооныг зогсоох, дуусгах, зайлуулах хэмжээтэй байх нь аргагүй хамгаалалтын үйлдэл зайлшгүй чухал байна гэж ойлгож болно. Хэргийн нөхцөл байдлын улмаас субъект довтолгооны эсрэг тухайн үйлдлийг хийхээс өөр аргагүй байдалд орсон байхыг үйлдэл тухайн нөхцөл байдал зайлшгүй шаардлагатай байх явдал гэж үздэг байна.

Аргагүй хамгаалалтын субъектив талд субъект тухайн үйлдлийг хийхдээ сэдэлт, зорилгын хувьд хэрхэн хандсан байдлыг ойлгох¹⁹ ба аргагүй хамгаалалт хийж буй этгээд өөрийн хийж буй үйлдлийг мэдэж байх тул хүсэх элементийн үндсэн дээр үүсдэг. Харин хүсэх элементийн үндсэн дээр хийж буй үйлдлийг санаатай гэмт хэргээс ялгахын тулд түүний сэдэлт, зорилгыг тогтоох шаардлагатай. Хамгаалалт нь өөрийгөө болон бусдыг хамгаалах зорилготойгоор хийгддэг.

Гэмт хэргийн шинжтэй үйлдэл гэдэг нь Эрүүгийн хуулийн тусгай ангид хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй буюу гэмт хэргийн шинжийг бүрэн хангасныг ойлгоно. Энэ гэмт хэргийн шинжтэй үйлдэл нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг хангаж байвал гэмт хэргийн шинжээ алдаж, гэмт хэрэгт тооцохгүй байх үндэслэл болдог.

3. Аргагүй хамгаалалтаар хэргийг хэрэгсэхгүй болгож буй шүүхийн практик

Хэргийн зүйлчлэлийн явцад гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдвол тухайн хэргийг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон үндэслэлээр

¹⁸ Эрүүгийн хууль (2015)-ийн 2.1-р зүйлийн 4 дэх хэсэг.

¹⁹ Т.Золбоо, *Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/. гэмт хэргийн бүтээц.*, УБ, 2023, 125 дахь тал.



шүүхээс тогтоол гаргаж, хэргийг хэрэгсэхгүй болгох нь тодорхой. Энэ талаар өмнө нь 2002 оны Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйл /аргагүй хамгаалалт/-ийг зөв хэрэглэх зөвлөмжийг Улсын дээд шүүх гаргасан²⁰ байна. Зөвлөмжийн 11 дэх хэсэгт "Прокуророос яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг аргагүй хамгаалалт гэж үзсэн тохиолдолд шүүх Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийг баримтлан тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй тухай "Шүүхийн тогтоол"-ыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 250 дугаар зүйлийн 250.1 дэх хэсгийг удирдлага болгон гаргаж байвал зохино" гэж заасан бөгөөд зөвлөмж нь одоог хүртэл хүчинтэй хэвээр байна. Харин шүүгдэгч аргагүй хамгаалалт хэрэглэсэн гэж үзвэл шүүхээс цагаатгах тогтоол гаргах нь эргэлзээтэй юм.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2017–2023 оны хооронд нийт 67 хэргийг аргагүй хамгаалалт хэрэглэсэн гэж үзэж, хэргийг хэрэгсэхгүй болгосон²¹ бөгөөд хүний амьд явахын эсрэг, эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хийсэн үйлдлүүд хамаарч байна. /хавсралт 1-с дэлгэрэнгүй үзнэ үү/ Энэ нь хуулиар хамгаалсан аргагүй хамгаалалтын объектой холбоотой юм. Тухайн хэргийн нөхцөл байдлыг аргагүй хамгаалалт гэж дүгнэсэн мөртлөө гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр 17 хэрэг, гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон үндэслэлээр 47 хэрэг, тухайн үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон үндэслэлээр 2 хэрэг, хууль зүйн үндэслэл бичээгүй 1 хэргийг тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Харин Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 2017–2023 оны хооронд нийт 35 хэргийг аргагүй хамгаалалтын нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг үйлдсэн гэж үзсэн ба үүнээс гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон үндэслэлээр 26 хэрэг, гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр 7 хэрэг, үндэслэл бичээгүй 2 хэргийг тус тус шийдвэрлэсэн байна. /хавсралт 2-оос дэлгэрэнгүй үзнэ үү/.

Монгол Улсын дээд шүүх 2017–2023 оны хооронд нийт 23 хэргийг аргагүй хамгаалалт хэрэглэсэн гэж үзсэн ба үүнээс гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон үндэслэлээр 18 хэрэг, гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр 4 хэрэг, тухайн үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон үндэслэлээр 1 хэргийг тус тус хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ. /хавсралт 3-с дэлгэрэнгүй үзнэ үү/.

Үүнээс үзвэл 3 шатны шүүх аргагүй хамгаалалтын нөхцөл байдал тогтоогдсон гэж дүгнэсэн мөртлөө гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох²², зарим тохиолдолд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож²³ байгаа нь харагдаж байна. Эндээс

²⁰ Монгол Улсын дээд шүүхийн 2007.03.27-ны өдрийн "Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйл /аргагүй хамгаалалт/-ийн зөв хэрэглэх тухай" зөвлөмж.

²¹ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн нэгдсэн цахим сан shuukh.mn case-ээс шүүлт хийсэн болно.

²² Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020.09.01-ний өдрийн 786 дугаартай шийдвэр; Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020.10.13-ны өдрийн 1315 дугаартай магадлал; Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023.01.13-ны өдрийн 88 дугаартай шийдвэр.

²³ УДШ-ийн 2021.09.22-ны өдрийн 272 дугаартай тогтоол; УДШ-ийн 2021.06.18-ны өдрийн 253 дугаартай тогтоол;



гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох буруу жишиг тогтож байна. Аргагүй хамгаалалт нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив, субъектив шинжийг агуулах ба хамгаалалт хийж буй этгээд халдлага үйлдэж буй этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг зөрчихөөс гадна өөрийн үйлдлийг хянаж, өөрийн болон бусад этгээдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгыг агуулж, хамгаалалтын үйлдэл болон түүнээс учирсан хохирлын хооронд шалтгаант холбоо байдагтай холбоотой. Иймд аргагүй хамгаалалт гэж үзсэн тохиолдолд түүнийг гэмт хэргийн шинжгүй /бүрэлдэхүүнгүй/ гэж хэрэгсэхгүй болгох нь онолын ойлголттой нийцэхгүй юм. Гэмт хэргийн шинжгүй үндэслэл нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хангахгүй, анхнаасаа эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд зөрчигдөөгүй, гэмт хэрэг биш байдгаараа гэмт хэрэг үгүйсгэх нөхцөл байдлаас ялгагддаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй хэд хэдэн тохиолдлыг авч үзсэн²⁴ ба үүнд гэмт хэргийн шинжгүй үндэслэлийг хамааруулсан байна. Хэрэг бүртгэлтийн үе шатанд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдвол хэрэг бүртгэлтийн хэргийг гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох нь ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй холбоотой. Энэ хэсэгт гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон гэдэг үндэслэл байхгүй тул хуулийг хэрэгжүүлж буй этгээдүүд аргагүй хамгаалалтыг гэмт хэргийн шинжгүй үндэслэлд хамааруулдаг байна. Судалгааны объект болох аргагүй хамгаалалт нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг бүрэн хангадаг тул түүнийг гэмт хэргийн шинжгүй үндэслэлд хамааруулж хэрэгсэхгүй болгох боломжгүй юм.

Шүүхийн шийдвэр нь шийтгэх, эсхүл цагаатгах хэлбэрээр гарах ба шүүх хуралдааны явцад шүүгдэгч гэм буруутай болох нь нотлогдсон тохиолдолд шүүх шийтгэх тогтоол²⁵, шүүгдэгчийн холбогдсон үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжгүй, эсхүл шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй бол цагаатгах тогтоол²⁶ гаргана. Шүүх хуралдааны явцад гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдлийг ЭХХШТХ-ийн 34.19 дүгээр зүйлийн 1.8 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд шүүхийн шийдвэр цагаатгах, шийтгэх аль ч хэлбэрээр гарч байна. Энэ нь ЭХХШТХ-ийн 36.2 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэгтэй холбоотой. Өмнө нь дурдсан аргагүй хамгаалалт нь гэм буруутай үйлдэл биш тул шүүхээс шийтгэх тогтоол гаргах боломжгүй. Мөн аргагүй хамгаалалт хэрэглэсэн этгээдийн үйлдэл нь гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, гэмт хэргийн шинжтэй үйлдэл тул түүнийг гэмт хэргийн шинжгүй, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй үндэслэлээр цагаатгах нь зохимжгүй. Иймд энэ зохицуулалтыг хэрэгжүүлж буй этгээдэд хүндрэлтэй байдаг тул шинэчлэх шаардлагатай байна.

²⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

²⁵ ЭХХШТХ (2017)-ийн 36.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг.

²⁶ ЭХХШТХ (2017)-ийн 36.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.



III. Дүгнэлт, санал

Эх газрын эрх зүйн бүлийн томоохон төлөөлөл болох ХБНГУ-д аргагүй хамгаалалтын шинжид гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив болон субъектив элементийг хамааруулж системчилсэн байна. Аргагүй хамгаалалтын шинж нь объектив болон субъектив элементээс бүрдэх ба объектив шинжид довтолгоо байх, уг довтолгоо нь хууль бус байх, үйлдэл байх, үйлдэл нь довтоллогчийн эсрэг байх зэрэг хамаарна. Гэмт хэрэг үгүйсгэх нөхцөл байдал болох аргагүй хамгаалалтын үед субъект юу хийж байгаага мэдэж, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хууль бус довтолгооноос хамгаалахын тулд довтолгооч этгээдийн эсрэг нийгэмд аюултай үйлдлийг хийхдээ хүсэж үйлдэл хийдэг тул аргагүй хамгаалалтын субъектив элементийн шинж хангагдаж байна.

Шүүхийн практикт аргагүй хамгаалалт гэж үзсэн мөртлөө тухайн үйлдлийг гэмт хэргийн шинжгүй үйлдэлд хамааруулж хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа нь аргагүй хамгаалалтын шинжид нийцэхгүй байна. Учир нь аргагүй хамгаалалт нь гэмт хэргийн шинжгүй гэдэг ойлголтоос өөр ойлголт төдийгүй аргагүй хамгаалалтын үед объектив болон субъектив шинж хангагдаж байдаг тул түүнийг гэмт хэргийн шинжгүй үндэслэлд хамааруулах боломжгүй юм. Энэ гажуудлын тодорхой хэсэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай холбоотой гэж үзлээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдлыг авч үзсэн байх ба шүүхийн өмнөх шатанд нийгэмд аюултай үйлдлийг аргагүй хамгаалалт гэж үзсэн тохиолдолд хэрэгсэхгүй болгох үндэслэлд үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон үндэслэл байхгүй тул гэмт хэргийн шинжгүй үндэслэлд хамааруулахаас өөр аргагүй болдог байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлд "гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон" гэсэн нэмэлт оруулж, энэ асуудлыг даван туулах боломжтой байна.

Мөн шүүхийн шатанд аргагүй хамгаалалт гэж үзсэн тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.8 дахь хэсгийг удирдлага болгон хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй. Учир нь гэмт хэргийн шинжгүй үндэслэлийг удирдлага болгох нь аргагүй хамгаалалтын шинжтэй нийцэхгүй юм.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

A. Эрх зүйн эх сурвалж

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017).
2. Монгол Улсын Дээд шүүхийн 1980.09.10-ны өдрийн 30 дугаар тогтоол.
3. Монгол Улсын Дээд шүүхийн 2021.06.18-ны өдрийн 253 дугаартай тогтоол.
4. Монгол Улсын Дээд шүүхийн 2021.09.22-ны өдрийн 272 дугаартай тогтоол.
5. Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020.10.13-ны өдрийн 1315 дугаартай магадлал.
6. Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020.09.01-ний өдрийн 786 дугаартай шийдвэр.



7. Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023.01.13-ны өдрийн 88 дугаартай шийдвэр.

Б. Ном, сурах бичиг

1. Б.Содовсүрэн, БНМАУ-ын эрүүгийн эрх. Ерөнхий анги.,УБ, 1969 он.
2. Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал. УБ., 2004 он.
3. Ж.Авхиа, Б.Ганболд, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар.УБ., 2002 он.
4. С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /гэмт хэргийн тухай сургаал/. I боть. УБ., 2009 он.
5. С.Нарангэрэл, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/.УБ., 1999 он.
6. С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, "Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж".нэгэнт сэдэвт бүтээл.УБ., 2019 он.
7. Т.Золбоо, Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/.Гэмт хэргийн бүтээц. гурав дахь хэвлэл.УБ., 2023 он.

В. Бусад

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948).
2. Монгол Улсын Дээд шүүхийн 2007.03.27-ны өдрийн "Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйл /аргагүй хамгаалалт/-ийн зөв хэрэглэх тухай" зөвлөмж.

2. Гадаад хэл дээрх сурвалж:

1. Annabell Krappidel. Zur Straflosigkeit bei Vorliegen von Notwehr und Notwehrexzess gemäß §§ 32, 33 StGB.Diplomarbeit, 2019.
2. Jan Arno Hessbruegge. Human rights and personal Self-Defense in international law.,New York, NY: Oxford University press, 2017.
3. Robin Heid. The right of self defense supersedes the right to life.Colorado.,1992.
4. Rudolf Rengier. Strafrecht Allgemeiner Teil /Grundrisse des Rechts/, C.H. Beck. 2021.

**Abstract****THE CONNECTION BETWEEN THE ELEMENTS OF A CRIME AND THE SELF DEFENSE****OTGONBAYAR, D.***Lawyer, Master of Laws /LL.M-NUM/*

When determining whether an act constitutes a crime, the theory of criminal elements is applied. If the act meets both the objective and subjective elements of a crime, it is considered to fulfil the characteristics of a criminal offense, and the individual is held criminally liable. The concept of criminal elements should not be interpreted solely in connection with the Special Part of the Criminal Code, as this would be a narrow perspective. The researcher raises the issue of whether self-defense constitutes the elements of a crime, analyses the practice of dismissing self-defense cases on the grounds of absence of criminal elements, and proposes that this issue could be addressed by amending the Criminal Procedure Law.

Keywords: Crime, body of crime, self defense, absence of criminal elements, attack

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС БОЛОН АВСТРИ УЛСЫН ХУУЛЬ ЁСНЫ ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Б.САРНАЙ¹

I. Оршил

II. Үндсэн хэсэг

Нэгдүгээр хэсэг. Австри улс дахь хууль ёсны өв залгамжлал

a. Тээгч эхийн хүүхдийн өв залгамжлал

b. Эцэг, эхийн систем /Das Parentelensystem/

c. Өв залгамжлалын эрх зүй дэх төлөөлөл ба үрчлэлт

Хоёрдугаар хэсэг. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс дахь
хууль ёсны өв залгамжлал

a. Төрөл төрөгсдийн систем

b. Өв залгамжлал дахь өмчийн дэглэм

III. Дүгнэлт

¹ Хууль зүйн магистр /LL.M./.



ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС БОЛОН АВСТРИ УЛСЫН ХУУЛЬ ЁСНЫ ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Б.САРНАЙ Хууль зүйн магистр /LL.M./

Түлхүүр үг

Иргэний хууль, өв залгамжлал, Австри улс, ХБНГУ, хөрөнгө, нас барсан этгээд.

Хураангуй

Хууль, эрх зүй орчны шинэчлэлийг хийхдээ олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх, өмнөх үеийн эрх зүйн ололт, амжилтыг залгамжлан үргэлжлүүлэх, нэг улсын зохицуулалтаас эрх зүйн рецепц хийх / зээлдэн нутагшуулах/ үзэгдэл ажиглагдаж байна. Энэ зээлдэн нутагшуулах үйл явц сайн туршлагыг нэвтрүүлэх, эрх зүйн тогтолцооны гажуудлыг хурдан хугацаанд даван туулах зэрэг эерэг талтай. Судлаачийн зүгээс өв залгамжлалын эрх зүйн сэдвийн хүрээнд харьцуулсан судалгаа хийх зорилгоор эх газрын эрх зүйн бүлийн томоохон төлөөлөл болох ХБНГУ, Австри улсын өв залгамжлалын эрх зүй дэх хууль ёсны өв залгамжлалын зарим асуудлыг судалж, дүгнэлт өгөхийг зорьсон болно. Энэ хоёр улсын өв залгамжлалын эрх зүйн зарим асуудлыг судалснаар бусад этгээд шинэ мэдлэг, мэдээлэл олж авахаас гадна цаашид манай хууль, эрх зүйн салбарт тулгарч болох асуудлыг шийдвэрлэх боломжтой санал, шийдэл байхыг үгүйсгэхгүй юм.

I. Оршил

Даяарчлагдаж буй өнөө цаг үед дэлхий улс орнууд улс төр, эдийн засаг, соёл, нийгэм, түүх зэрэг олон нөхцөл байдлаас шалтгаалан өөр хоорондоо эрх зүйн харилцан үйлчлэлд оршиж байна. Энэ үзэгдэл нь манай орны хууль, эрх зүйн салбарт томоохон өөрчлөлтийг бий болгож байгааг нуух юун. Хуулийн төсөл боловсруулахаас эхлээд эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэхдээ тухайн зохицуулалтыг өөр бусад улсын хууль, эрх зүйн зохицуулалттай харьцуулан үзэж, дүгнэлт гаргах явдал түгээмэл болсон байна. Харьцуулсан судалгаа хийх улс орныг сонгохдоо ихэвчлэн эрх зүйн системчлэл /бүл/ ойр улсыг сонгон судалдаг байна. Энэ хүрээнд эх газрын эрх зүйн бүлийн томоохон төлөөлөл болох ХБНГУ болон Австри улсын Иргэний хууль дахь хууль ёсны өв залгамжлалын зарим зохицуулалтыг судлахыг зорьсон болно. Зарим асуудал гэдэг нь тухайн улсын хууль ёсны өв залгамжлал тухай ойлголтыг бүхэлд нь хамруулахгүйгээр зарим



гол гол асуудлыг авч үзэж, манай улсын эрх зүйн зохицуулалтаас ялгагдах онцлог зохицуулалт юу болох талаарх асуудлыг дэвшүүлсэн болно.

Ингэхдээ Австри улсын Иргэний хууль дах хууль ёсны өв залгамжлалын асуудлыг i) тээгч эхийн хүүхдийн өв залгамжлал, ii) эцэг, эхийн систем буюу өв залгамжлалын бүлэг, iii) өв залгамжлалын эрх зүй дэх төлөөлөл ба үрчлэлт хэмээх ойлголтоор тус тус хязгаарласан болно. Харин Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Иргэний хууль дахь өв залгамжлалын асуудлыг i) төрөл төрөгсдийн систем буюу өв залгамжлалын зэрэг, ii) өв залгамжлал дахь төлөөлөл ба үрчлэлт гэсэн ойлголтоор тус тус хязгаарласан болно. Энэ хоёр улсын зохицуулалтыг авч үзсэн шалтгаан нь энэ төрлийн судалгааны ажил хийж буй хуульч, судлаач, оюутан залуучуудыг мэдээллээр хангах, эх сурвалж болон бусад мэдээллийг олж авах боломжтой гэж үзсэн бөгөөд харьцуулсан судалгааны аргыг ашигласан болно. ХБНГУ ба Австри улсын өв залгамжлалын эрх зүйн асуудлаар өмнө нь бичигдэж байсан судалгааны ажил харахан байхгүй байна.

II. Үндсэн хэсэг

Нэгдүгээр хэсэг. Австри улс дахь хууль ёсны өв залгамжлал

Нас барсны дараа юу болдог бэ? гэсэн асуултад хүн бүр өөрөөсөө асуух шаардлагатай. Энэ асуултын талаар маш цөөхөн хүн боддог байна. Энэ асуултыг өөрөөсөө асууснаар хууль ёсны хөрөнгөө хэрхэн зохицуулахаа шийдэх боломжтой. Нас барсан хүмүүсийн 90 хувьд хууль ёсны өв залгамжлал хэрэгждэг¹ тул практикт ихээхэн ач холбогдолтой байна. Австри болон ХБНГУ-д хууль ёсны өв залгамжлал дараах байдлаар үүсдэг байна. Үүнд:

- Өв залгамжлалын хийгдээгүй тохиолдолд хууль ёсны өв залгамжлал хэрэгжинэ;
- Гэрээслэл хийгдээгүй;
- Гэрээслэл нь гэрээслүүлэгчийн бүх хөрөнгийг хамраагүй, тодорхой хөрөнгийг гэрээсэлсэн тохиолдолд;
- Өв залгамжлагч нь өвийг хүлээн авахаас татгалзсан;
- Өв залгамжлагч өвийг хүлээн аваагүй².

Нийт хөрөнгийн зарим хэсэгт гэрээслэл үйлдсэн бол хууль ёсны өв залгамжлал нь зөвхөн захиран зарцуулагдаагүй үлдсэн хэсэгт хамаарна.

Австри улс дахь хууль ёсны өв залгамжлал

Хууль ёсны өв залгамжлалыг "Интестат өв залгамжлал" гэж нэрлэгддэг. Энэ нь гэрээслэл эсхүл өв залгамжлалын гэрээгээр өв залгамжлагчийг тодорхойлоогүй тохиолдолд хэрэгждэг³. Хүчин төгөлдөр гэрээслэл байгаа тохиолдолд хууль ёсны өв залгамжлагч өв залгамжлах эрхгүй болно. Хууль ёсны өв залгамжлагчид өв

¹ Zankl Wolfgang, Erbrecht (facultas Universitätsverlag 2017).s.33.

² Rafaela Goj. Die gesetzliche Erbfolge in Österreich und Deutschland. Diplomarbeit aus Bürgerlichem Recht., Salzburg, September 2018, s.37.

³ Eccher Bernhard, Erbrecht (Verlag Österreich 2016).s.31.



залгамжлалын эд хөрөнгө бүхэлд нь эсхүл хэсэгчлэн шилжих гурван тохиолдлыг Иргэний ерөнхий хуулийн 727, 728 дугаар хэсэгт⁴ авч үзсэн байна. Үүнд:

Нэг. Нас барсан этгээд гэрээслэл бичээгүй, гэрээслэл үлдээгүй, эсхүл гэрээслэлээ хүчингүй болгосон тохиолдолд хэрэгжинэ.

Хоёр. Нас барсан этгээд эд хөрөнгөө захиран зарцуулаагүй эсхүл захиран зарцуулах боломжгүй байсан⁵. Энэ тохиолдолд нас барсан этгээд хүчин төгөлдөр гэрээслэл эсхүл бусад гэрээслэлээр эд хөрөнгөө захиран зарцуулсан байж болох боловч түүний захиран зарцуулаагүй үлдсэн зарим эд хөрөнгөд хамаарах боломжтой. Захиран зарцуулаагүй үлдсэн хэсэг, мөн гэрээслэл хэсэгчлэн хүчинтэй бол хүчингүй болсон хэсэг хууль ёсны өв залгамжлагчид шилжинэ⁶.

Гурав. Нас барсан этгээд бүх эд хөрөнгөө хүчин төгөлдөр гэрээслэлээр өв залгамжлуулахаар заасан ч өв залгамжлагч өвийг хүлээн авахаас татгалзах тохиолдол бий. Энэ нь өв залгамжлах чадваргүй, гэрээслэлээр эд хөрөнгө шилжихээс өмнө өв залгамжлагч нас барсан зэрэг шалтгаантай байж болно⁷.

Хууль ёсны өв залгамжлагчид

Австри улсын Иргэний хуулийн 730 дугаар зүйлд зааснаар хууль ёсны өв залгамжлагчид нас барсан хүний хамгийн ойрын хамаатан садан, түүний эхнэр, нөхөр, бүртгэлтэй хамтрагчид хамаарна⁸. Цус төрлийн хамаатан садан гэдэг нь нэг өвөг дээдсээс гаралтай этгээдээр тодорхойлно. Хамаатан садан хоорондын хууль ёсны өв залгамжлалын тухайд нас барсан этгээд болон өв залгамжлагч нарын хооронд ямар нэгэн харилцаа байгаа эсэхийг тодорхойлох нь чухал ач холбогдолтой. Ихэнх тохиолдолд төрсний гэрчилгээгээр ямар нэгэн харилцаа, удам угсаатай болохыг нотлоход ашигладаг.

а. Тээгч эхийн хүүхдийн өв залгамжлал

Хэрэв хүүхдийг эмнэлгийн нөхөн үржих аргыг ашиглан төрүүлсэн тохиолдолд хууль ёсны өв залгамжлалын эрх өөрчлөгдөхгүй, төрсөн хүмүүсийн адил эрх эдэлнэ⁹. Тээгч эхийн тээсэн хүүхэд удам гарвацийн хувьд "харийн хүн" гэж тооцогддог. Энэ нь Австри улсад тээгч эхийн үйлчилгээг хууль бус гэж үздэгтэй холбоотой¹⁰. Харин өөрийн нөхрийн үрийн шингэнийг ашиглан эмнэлгийн аргаар жирэмсэн болсон тохиолдолд түүнээс төрсөн хүүхэд уг шингэнийг өгсөн эрэгтэй хүний хууль ёсны өв залгамжлагчид тооцогдоно. Мөн үр шилжүүлэн суулгах төвд сайн дураараа үрийн шингэнээ өгсөн тохиолдолд уг хүн хүүхдийн

⁴ Frank Hartwig Armin, Konkret: Vermögenssicherung und Vermögensweitergabe. „Testament. Pflichtteil. Verlassenschaft“6 (UniCredit Bank Austria AG 2011).23f.

⁵ Apathy Peter, Zivilrecht VII – Erbrecht (LexisNexis 2015).s.11, Eccher Bernhard, Erbrecht (Verlag Österreich 2016).s.31.

⁶ Apathy Peter, Zivilrecht VII – Erbrecht (LexisNexis 2015).s.11, Winkler Alexander, Handbuch Erbrecht: Österreichisches Erbrecht und Verlassenschaftsverfahren (Verlag Österreich 2006).s.25.

⁷ Apathy (LexisNexis 2015).s.12.

⁸ Австри улсын Иргэний хууль (1811), Allgemeines bürgerliches Gesetzbuch (ABGB) – JUSTLINE Österreich.

⁹ Winkler Alexander, Erbrecht: Ein Leitfaden für die Praxis2 (Verlag Österreich 2016).s.19.

¹⁰ Winkler Alexander, Erbrecht: Ein Leitfaden für die Praxis2 (Verlag Österreich 2016).s.19; Bernat, Das österreichische Abstammungsrecht im Kontext der me dizinisch unterstützten Fortpflanzung, in Coester-Waltjen/Lipp/Schuhmann/Veit (Hrsg), „Kinderwunschmedizin“ – Reformbedarf im Abstammungsrecht? (2015), 79.



өмнө үүрэг хүлээхгүй¹¹.

б. Эцэг, эхийн систем /Das Parentelensystem/

Өв залгамжлалын эрх зүйд эцэг, эхийн систем үйлчлэх бөгөөд энэ нь нас барсан этгээдийн хамаатнуудыг хэд хэдэн бүлэгт хувааж, хөрөнгө хэрхэн хуваагдахыг зохицуулдаг системчлэл юм. Өөрөөр хэлбэл, өв залгамжлагчдыг үе удмаар нь бүлэглэх арга гэж хэлж болно. Энэ системчлэл нь нас барсан этгээдийн ойрын хамаатан заавал өв залгамжлах ёстой гэсэн утгыг илэрхийлэхгүй бөгөөд өв залгамжлалын бүтцийн зохион байгуулалтыг бий болгож, өв залгамжлагч нар шударга хуваарилалт хийхэд тусалдаг. Энэ системийн ач холбогдол нь нэгдүгээр бүлгийн өв залгамжлагч байхгүй тохиолдолд дараагийн бүлгийн хүмүүс өв залгамжлах эрх нь нээгдэж, тодорхой дэг журмыг бий болгож, маргаан гарах эрсдэлийг бууруулдаг. Өөр өөр бүлэгт багтаж буй өв залгамжлагчид нэгэн зэрэг өв залгамжлах эрхгүй. Хууль ёсны өв залгамжлагчид нас барсан этгээдийн хамгийн ойрын хамаатан садан, түүний эхнэр, нөхөр, бүртгэлтэй хамтрагчид хамаарна¹². Нэгдүгээр зэрэгт, нас барсан этгээдийн үр хүүхэд, ач зээ, хоёрдугаар бүлэгт, нас барсан этгээдийн эцэг, эх, тэдний үр хүүхэд, тухайлбал, түүний ах, эгч нар, тэдний үр хүүхэд, гуравдугаар бүлэгт нас барсан этгээдийн өвөө, эмээ, тэдний үр хүүхэд, түүний авга ах, эгч, нагац ах, эгч, тэдний үр хүүхэд хамаарна. Дөрөвдүгээр бүлэгт, нас барсан этгээдийн өвөг эцэг, эх, тэдний үр хүүхэд хамаардаг¹³ байна. Энэ системчлэл нь "залуу нь ахмадаасаа өмнө" буюу "jung vor alt" зарчим дээр суурилдаг. Нас барсан этгээд үр хүүхэдтэй бол түүний эцэг, эх өв залгамжлах эрх нь хязгаарлагддаг гэсэн үг.

с. Өв залгамжлалын эрх зүй дэх төлөөлөл ба үрчлэлт

Энэ ойлголт нь нас барсан этгээдийн хөрөнгийг өвлөх эрхтэй өв залгамжлагч нас барсан тохиолдолд түүний үр хүүхэд хөрөнгийг тэнцүү хувааж авах¹⁴ буюу өв залгамжлагчийг төлөөлөн хөрөнгийг өвлөх тухай юм. Жишээ нь: А-ийн хөрөнгийг Б өв залгамжлан авах эрхтэй ба Б нь нас барсан тохиолдолд Б-ийн хүүхдүүд өв залгамжлах эрхтэй гэсэн үг. Гэхдээ энэ нь зөвхөн нэг бүлгийн өв залгамжлагч нарт хамааралтай бөгөөд өв залгамжлагчийн үр хүүхэд өв залгамжлах эрх нээгдэж, үүнд эцэг, эх нь оролцох эрхгүй. Төлөөллийг формаль болон материаллаг гэсэн хоёр төрөлд хуваадаг¹⁵. Формаль /албан ёсны/ төлөөлөл нь өв залгамжлагч этгээд нь өв залгамжлахаас татгалзсан, өв залгамжлах эрхээ хасуулсан тохиолдолд түүний үр хүүхэд өвлөх эрх нээгдэнэ. Харин материаллаг татгалзал нь өв хүлээн авахаас бүхэлд нь татгалзсан тохиолдолд түүний үр хүүхэд төлөөлөн авах эрх нээгдэхгүй¹⁶ юм. Жишээлбэл, Иргэн Д нь А, Б, В хэмээх гурван хүүхэдтэй бөгөөд хүүхэд тус бүрд түүний хөрөнгийн гуравны нэгтэй тэнцэх

¹¹ Мөн тэнд

¹² ABGB-Allgemeines bürgerliches Gesetzbuch §730, Allgemeines bürgerliches Gesetzbuch (ABGB) – JUSLINE Österreich last accessed 15 Feb2025.

¹³ ABGB-Allgemeines bürgerliches Gesetzbuch §731.

¹⁴ Winkler Alexander, *Erbrecht: Ein Leitfaden für die Praxis* (Verlag Österreich 2016).s.16; Winkler Alexander, *Handbuch Erbrecht: Österreichisches Erbrecht und Verlassenschaftsverfahren* (Verlag Österreich 2006).s.27.

¹⁵ Zankl Wolfgang, *Erbrecht* (facultas Universitätsverlag 2017).s.35;

¹⁶ Welser Rudolf/Zöchling-Jud Brigitta, *Grundriss des bürgerlichen Rechts. Band II. Schuldrecht Allgemeiner Teil Schuldrecht Besonderer Teil Erbrecht* (Manz 2015).



хөрөнгө хуваарилагдаж байна. Гэвч хоёр охинтой В нь хэдэн жилийн өмнө нас барсан бөгөөд түүний охидууд Д-ын ач охин юм. Энэ тохиолдолд төлөөллийн дагуу В-ийн охидууд түүний хөрөнгийг тэнцүү хэмжээгээр хуваан авах юм¹⁷.

Австри улсын Иргэний хуулийн 197, 199 дүгээр зүйлд хүүхэд үрчлэлтийн тухай зохицуулсан ба энэ зохицуулалттай холбоотойгоор үрчлэн авсан хүүхдийн өв залгамжлалын эрхийн асуудал яригдана. Иргэний хуулийн 197 дугаар зохицуулалтын дагуу үрчлэгдсэн хүүхэд нь төрсөн хүүхдүүдтэй адил эрх эдэлж, хууль ёсны өв залгамжлалд төрсөн хүүхэдтэй адил хэмжээгээр өв залгамжлах эрхтэй.

Хоёрдугаар хэсэг. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс дахь хууль ёсны өв залгамжлал

ХБНГУ-ын Иргэний хуулийн¹⁸ 1924–1930 дугаар хэсэгт нас барсан этгээдийн хөрөнгийг хэрхэн өвлөх тухай хуульчилсан байна. Нас барсан этгээд болон өв залгамжлагч хоёрын хооронд төрөл садан /удамшил/-ийн харилцаа байх ёстой гэж үздэг. Иргэний хуулийн 1589 дугаар хэсэгт зааснаар төрөл садангийн харилцаа нь цусан төрлийн холбоонд үндэслэгдэнэ. Төрөл садангийн харилцаа нь i) **шууд удамшил** буюу эцэг, эхээс төрсөн хүүхэд, ii) **хөндлөн удамшил** буюу нэг эцэг, эхээс төрсөн ах дүүсээр тодорхойлогдоно¹⁹. Энэ садангийн харилцаа нь өв залгамжлалын зэргийг тогтооход ач холбогдолтой. Иргэний хуульд нэгдүгээр зэргийн өв залгамжлагчдад нас барсан этгээдийн үр хүүхэд хамаарах ба хүүхдүүд ижил хувь хэмжээгээр өвлөх тухай заасан байна²⁰.

Хууль ёсны өв залгамжлалд гомолог үр тогтолт буюу эмнэлгийн аргыг ашиглан үр шилжүүлэн суулгах асуудал яригддаг. Гомолог үр тогтолт /homologe Insemination/ гэдэг нь тухайн эмэгтэйн нөхөр эсхүл хамтран амьдрагчийн үрийн шингэнийг ашиглан эмнэлгийн аргаар үр тогтоохыг хэлнэ. Энэ тохиолдолд хүүхдийн эцэг нь донор байдаг тул асуудал гарахгүй. Харин өөр донор ашигласан бол хүүхдийн эцгийг тогтооход эцэг хүн өөрөө эцэг гэдгээ хүлээн зөвшөөрөх (**Erkenntnis des Vaters**), эсхүл шүүхийн шийдвэрээр эцэг тогтоох (**gerichtliche Feststellung der Vaterschaft**) аргыг ашигладаг²¹. ХБНГУ-ын Дээд шүүх 2014 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн шийдвэрээрээ өв залгамжлал эсхүл төрөл саданг тогтоох шаардлагатай бол нас барсан хүнийг эксгумаци хийж (булш нээх), ДНХ шинжилгээ хийхийг зөвшөөрсөн²² байна.

а. Төрөл төрөгсдийн систем

Германы хууль тогтоомжид төрөл төрөгсдийн хууль ёсны өв залгамжлалыг Parentelensystem (төрөл төрөгсдийн шатлалт систем) буюу ихэвчлэн "Ordnungssystem" (дэс дарааллын систем) гэж нэрлэдэг. Энэ систем нь төрөл

¹⁷ Graf Georg, Erbrecht (LexisNexis 2015).s.21.

¹⁸ Bürgerliches Gesetzbuch.

¹⁹ Olzen Dirk/Looschelders Dirk, Erbrecht (de Gruyter 2017).s.30.

²⁰ Bürgerliches Gesetzbuch (BGB) §1924 /BGB – nichtamtliches Inhaltsverzeichnis (Last accessed 10 Feb 2025).

²¹ Kroiß Ludwig/Ann Christoph/Mayer Jörg, BGB. Erbrecht. Band: §§ 1922–23853 (Nomos Verlagsgesellschaft Stand: 2010).

²² Rafaela Goj. Die gesetzliche Erbfolge in Österreich und Deutschland. Diplomarbeit aus Bürgerlichem Recht., Salzburg, September 2018, s.40.



төрөгсдийг дөрвөн зэрэглэлд хуваадаг ба зэрэглэл бүр нь тухайн овог дээдсээс гаралтай бүх үеийн төрөл төрөгсдийг хамарна. Австри улсын адилаар ойрын зэрэглэлийн төрөл төрөгсөд холын зэрэглэлийн хүмүүсийг өв залгамжлах эрхээс хасна. Үүнээс гадна өөр өөр зэрэглэлд багтдаг төрөл төрөгсөд нэгэн зэрэг өв залгамжилж болохгүй²³. Өв залгамжлах зэрэглэлийг товч байдлаар авч үзвэл:

Зэрэглэл	Хамаарах этгээд
Нэгдүгээр зэрэглэл	Өвлүүлэгчийн үр хүүхдүүд
Хоёрдугаар зэрэглэл	Өвлүүлэгчийн эцэг, эх, тэдний хүүхдүүд
Гуравдугаар зэрэглэл	Өвлүүлэгчийн өвөг эцэг, эх
Дөрөвдүгээр зэрэглэл	Хуланц өвөг эцэг, эмэг эх болон тэдний хүүхдүүд
Тавдугаар зэрэглэл	Өвлүүлэгчийн өндөр өвөг эцэг, эмэг эх, тэдний хүүхдүүд

Нэгдүгээр зэргийн өв залгамжлагчид нас барсан этгээдийн үр хүүхдүүд буюу ач, зээ нар орно. Мөн өв нээгдэх үед үр хүүхдийн зарим нэг нь нас эцэслэсэн бол түүгээр дамжуулан өвлүүлэгчтэй холбогдож буй хүүхдүүд өвлөх эрхтэй гэж заажээ²⁴. Өвлүүлэгчийн эцэг, эх, тэдний хүүхдүүд Германы Иргэний хуулийн 1925 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хоёрдугаар зэрэглэлийн өв залгамжлагч гэж үздэг. Хэрэв өвлүүлэгчийн эцэг, эх хоёулаа амьд байгаа тохиолдолд эд хөрөнгийн хагасыг өвлөх эрхтэй, цаашлаад тэдний хүүхдүүдийн тоонд хуваагддаг ба үүнийг "шугаман залгамжлал" гэж нэрлэдэг. Гуравдугаар зэрэглэлд өвлүүлэгчийн өвөө, эмээ, тэдний үр хүүхдүүд хамаарна. Өв нээгдэх мөчид өвлүүлэгчийн өвөг эцэг, эхийн нэг насан эцэслэвэл байвал түүний үр хүүхэд түүнд ноогдох хэсгийг өвлөнө²⁵. Дөрөвдүгээр зэрэглэлд хуланц өвөг эцэг, эмэг эх болон тэдний үр хүүхдүүд багтах ба өв нээгдэх мөчид өвлүүлэгчийн хуланц өвөг эцэг, эмэг эх амьд байвал тэд дангаар, хэд хэдэн этгээд байвал төрлийн холбооноос үл хамааран тэнцүү хэсгээр өвлөнө. Харин өв нээгдэх мөчид өвлүүлэгчийн хуланц өвөг эцэг, эмэг эх нас барсан бол нас барагчийн үр хүүхдүүдээс өвлүүлэгчтэй хамгийн ойр төрлийн хамаатан өвлөнө. Ижил түвшний хэд хэдэн садан байвал тэнцүү хэмжээгээр өвлөх зохицуулалттай.

b. Өв залгамжлал дахь өмчийн дэглэм

Өв залгамжлалын өмчийн дэглэм нь өв залгамжлалын хувийг тогтооход чухал нөлөө үзүүлдэг ба хамгийн түгээмэл гурван өмчлөлийн дэглэм байдаг байна. Үүнд: i) хуулиар тогтоосон өмчлөлийн дэглэм /хуримтлагдсан хөрөнгийн хамтын өмч/, ii) сонголттой өмчлөлийн дэглэм, iii) гэрээгээр тохиролцсон өмчлөлийн дэглэм /хөрөнгийн хамтын өмч/ хамаарна²⁶. Хуулиар тогтоосон өмчлөлийн дэглэмийн үед гэрлэсэн хосуудын гэрлэлтээс өмнөх хөрөнгө нь хамтын өмч гэж тооцогдохгүй. Учир нт хосууд өөрийн хөрөнгөө бие даан захиран зарцуулах

²³ Michalski Lutz, BGB – Erbrecht3 (C.F. Müller Verlag 2006).s17; Werner in Otte (Hrsg), Staudinger BGB: Einleitung zum Erbrecht: §§ 1922–1966. Erbfolge. Buch 5 § 1924 Rz 14 (2016).

²⁴ Bürgerliches Gesetzbuch (BGB) §1924 (3)

²⁵ Bürgerliches Gesetzbuch (BGB) §1924 (4)

²⁶ Tersteegen in Süß, Erbrecht in Europa, 478f; Bundesministerium der Justiz und für Verbraucherschutz, Erben und Vererben, 14; Treutler Rechtsanwälte Fachanwälte Regensburg, Eheliches Güterrecht



эрхтэй. Харин гэрлэлт үргэлжлэх хугацаанд олж авсан хөрөнгө нь салалтын үед тэнцүү хуваагдах ба нэг нь нас барсан тохиолдолд хуримтлагдсан хөрөнгийн нөхөн олговор хийгдэнэ. Энэ нь хоёр янзын аргачлалаар шийдэгдэнэ. Үүнд:

1. Өв залгамжлалын арга
2. Өмчлөлийн эрх зүйн арга²⁷.

Өв залгамжлалын аргаар нөхөн олговор хийх тохиолдолд амьд үлдсэн эхнэр/нөхөр нь өөрийн өв залгамжлах үндсэн хувиас гадна нэмэлт ¼ хувийг (25%) өвлөн авна. Хэрэв нас барсан хүнээс үлдсэн хүүхэд болон ач/зээ нар байвал гэр бүлийн амьд үлдсэн эхнэр/нөхөр нь нийт өв хөрөнгийн хагасыг өвлөнө. Нас барсан этгээдийн хоёрдугаар зэргийн өв залгамжлагч эсвэл өвөө, эмээ нь амьд байгаа тохиолдолд өв залгамжлуулагчийн эхнэр/нөхөр нь нийт өв хөрөнгийн дөрөвний гурвыг өвлөнө. Энэ өмчлөлийн эрх зүйн нэмэлт дөрөвний нэгийг өвлөгч нь хуримтлагдсан хөрөнгө бодитой бий болсон эсэхээс үл хамааран авах эрхтэй²⁸.

Сонголттой өмчлөлийн дэглэм нь гэрлэсэн хосуудын хувийн хөрөнгийг тусад нь авч үзэх, хамтын өмч үүсгэхгүй байх нэгэн төрлийн гэр бүлийн хөрөнгө зохицуулалтын хэлбэр юм. Энэ дэглэм нь амьд үлдсэн гэр бүлийн эхнэр/нөхрийг хохироохгүй байх, хүүхдүүдтэй адил тэнцвэртэй өв залгамжлах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой²⁹. Онцлог нь гэр бүлийн хосууд өөрсдийн хөрөнгийг тусад нь эзэмших, удирдах, ашиглах, захиран зарцуулах эрхтэй, хэрэв гэр бүлийн нэг гишүүн нас барсан тохиолдолд амьд үлдсэн эхнэр/нөхөр нь өв хөрөнгөөс хувь хүртэхдээ хүүхдүүдтэй тэнцүү нөхцөлөөр өвлөнө.

Гэрээгээр тохиролцсон өмчийн дэглэм нь гэрлэлтийн үед эхнэр, нөхрийн хувийн өмч нь нэгдэж, хамтын өмч болдог ойлголт юм. Энэ нь гэрлэлтээс хойш олж авсан бүх өмчийг хамтад нь эзэмших зохицуулалттай. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн нэгдэл тогтоосон гэр бүлийн хувьд гэр бүл болохоос өмнөх болон гэрлэлтийн дараа олж авсан бүх өмч хоёр хүний хамтын өмч болдог. Харин зарим өмч хөрөнгө нь хамтын хөрөнгөд хамаарахгүй³⁰ ба эзэмшигч нь дангаар эзэмших эрхтэй. Тухайлбал, хувийн тэтгэврийн данс, өв залгамжилсан эд хөрөнгө хамтын өмчид тооцогдохгүй. Эхнэр, нөхөр хоёулаа хамтын өмчийн эзэн болох ба адил эрх эдэлж, үүрэг хүлээхээс гадна хамтын шийдвэрээр захиран зарцуулах эрхтэй. Харин гэрлэлт цуцлагдсан тохиолдолд бүх өмчийг хуваах ба нэгдмэл өмч тул өр төлбөр, хариуцлага мөн хамтын байдаг онцлогтой. Энэ хуримтлагдсан ашгийг хэрхэн хуваарилах талаар Иргэний хуулийн 1391, 1931 дэх хэсэгт дөрөвний нэгээр нэмэгдүүлэх боломжтой байхаар зохицуулсан. Жишээлбэл, Нас барсан этгээд нь эхнэр, хоёр хүүхэдтэй, гэрлэлтийн гэрээгүй байжээ. Харин талууд хөрөнгийн хамтын өмчийн гэрээтэй байсан ба Иргэний хуулийн 1371 дүгээр зүйлийн дагуу хуримтлагдсан ашгийн дөрөвний нэг, мөн хуулийн 1931 дүгээр зүйлийн 1-д

²⁷ Tersteegen in Süß, Erbrecht in Europa, 478; Treutler Rechtsanwälte Fachanwälte Re gensburg, Zugewinnngemeinschaft.

²⁸ Bürgerliches gesetybuch (BGB) §1931.

²⁹ Rafaela Goj. Die gesetzliche Erbfolge in Österreich und Deutschland. Diplomarbeit aus Bürgerlichem Recht., Salzburg, September 2018, s.53.

³⁰ Appel Jost/Appel Urte, International Vererben. Deutschland Österreich Schweiz (Books on Demand GmbH 2011).s.54.



заасны дагуу дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээтэй хөрөнгийг авах эрхтэй. Өв залгамжлалын хүрээнд үлдсэн хөрөнгө 2 хүүхдэд хуваагдана³¹.

III. Дүгнэлт

Даяарчлагдаж өнөө цаг үед эрх зүйн харилцаа улам бүр өргөжиж, түүнийг зохицуулах хэм хэмжээ хангалтгүйгээс эрх зүйн хийдэл бий болдог байна. Эрх зүйн хөгжлийн шатанд явж буй манай улсад энэ асуудал нь илүүтэй тохиолдох асуудал юм. Эрх зүйн хийдлийг даван туулах арга зам нь шинээр хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулж боловсронгуй болгох уламжлалт арга давамгайлж байна. Ингэхдээ ижил төстэй эрх зүйн бүлтэй улс орнуудын хууль, эрх зүйн орчныг судлах, сайн туршлагыг нэвтрүүлэх хандлага нэмэгдэж байна.

Судлаачийн хувьд эх газрын эрх зүйн тогтолцооны том төлөөлөл гэгддэг ХБНГУ, Австри улсын Иргэний эрх зүй дэх өв залгамжлалын зарим асуудлыг судалж үзлээ. Судалгааны объект болох хоёр улсын хувьд хууль ёсны өв залгамжлалын эрх зүйн зохицуулалт нь ижил төстэй байна. Хууль ёсны өв залгамжлалын эрх зүй нь эцэг эхийн системийн зарчим дээр суурилж, нас барсан этгээдийн хөрөнгийг юуны түрүүнд ойр дотны хүмүүст үнэн зөвөөр хуваарилах зорилгыг агуулдаг.

Австри улсын Иргэний хууль дахь хууль ёсны өв залгамжлалын зарим асуудлыг сонгон судалсан ойлголтоос тээгч эхийн хүүхдийн өв залгамжлал, өв залгамжлал дахь төлөөлөл, ХБНГУ-ын Иргэний хууль дахь өв залгамжлалын өмчийн дэглэм гэх ойлголт нь цаашид Монгол Улсад гарч болох шинэ асуудал байж болох юм. Хэдийгээр манай улс тээгч эхийн асуудлыг хуулиар зохицуулаагүй боловч гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулагдаж буй энэ цаг үед яригдаж байна. Мөн хоёр улсын хувьд өв залгамжлалын зэрэглэлийг авч үзэхдээ онолын маш нарийн ойлголтоор заагласан байна. Цаашид судлаачийн авч үзсэн онолын ойлголтыг баяжуулан судалж, өөрийн орны онцлогт тохирсон хууль, зүйн орчныг бий болгоход анхаарах шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Иргэний хууль, 2002 он.

Б. Ном, сурах бичиг

1. Б.Буяншиг, *ХБНГУ-ын Иргэний хууль* (кодификацийн бүрэн эх), орчуулгыг нэгтгэсэн анхны хэвлэл, УБ, 2017 он.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. Apathy Peter, *Zivilrecht VII – Erbrecht* (LexisNexis), 2015.
2. Appel Jost/Appel Urte, *International Vererben. Deutschland Österreich Schweiz* (Books on Demand GmbH), 2011.

³¹ Paintner Beate, *Erbrecht anschaulich erklärt* (Rechtsanwälte Paintner PartG mbB 2017).s.18.



3. Bernat, Das österreichische Abstammungsrecht im Kontext der me dizinisch unterstützten Fortpflanzung, in Coester-Waltjen/Lipp/Schuhmann/Veit (Hrsg), „Kinderwunschmedizin“ – Reformbedarf im Abstammungsrecht? 2015.
4. Eccher Bernhard, Erbrecht (Verlag Österreich), 2016.
5. Frank Hartwig Armin, Konkret: Vermögenssicherung und Vermögensweitergabe. „Testament. Pflichtteil. Verlassenschaft“ (UniCredit Bank Austria AG), 2011.
6. Michalski Lutz, BGB – Erbrecht (C.F. Müller Verlag), 2006.
7. Rafaela Goj. Die gesetzliche Erbfolge in Österreich und Deutschland. Diplomarbeit aus Bürgerlichem Recht., Salzburg, September, 2018.
8. Winkler Alexander, Handbuch Erbrecht: Österreichisches Erbrecht und Verlassenschaftsverfahren (Verlag Österreich), 2006.
9. Welser Rudolf/Zöchling-Jud Brigitta, Grundriss des bürgerlichen Rechts. Band II. Schuldrecht Allgemeiner Teil Schuldrecht Besonderer Teil Erbrecht (Manz), 2015.
10. Werner in Otte (Hrsg), Staudinger BGB: Einleitung zum Erbrecht: §§ 1922–1966. Erbfolge. Buch 5 § 1924 Rz 14., 2016.
11. Zankl Wolfgang, Erbrecht (facultas Universitätsverlag), 2017.
12. Австри улсын иргэний хууль (1811) Allgemeines bürgerliches Gesetzbuch (ABGB) – JUSLINE Österreich.
13. ХБНГУ-ын Иргэний хууль (1896) BGB – nichtamtliches Inhaltsverzeichnis.

**Abstract****THE ISSUE OF LEGAL INHERITANCE IN
THE FEDERAL REPUBLIC OF GERMANY
AND THE OF AUSTRIA****SARNAI, B.***Lawyer, Master of Laws /LL.M./*

In the reform of the legal and legal environment, there is a phenomenon of compliance with international standards, continuation of previous legal achievements and successes, and legal reception (borrowing and localizing) from one country's regulations. This borrowing and localizing process has positive aspects such as introducing good practices and quickly overcoming the anomalies of the legal system. The researcher aims to conduct a comparative study within the scope of the topic of inheritance law by studying and providing conclusions on some issues of legal inheritance in the inheritance law of the Federal Republic of Germany and Austria, which are major representatives of the continental legal family. By studying some issues of inheritance law in these two countries, other parties will not only gain new knowledge and information, but also provide possible suggestions and solutions to solve problems that may arise in our legal and legal field in the future.

Keywords: Civil code, inheritance, Austria, Federal Republic of Germany, assets, deceased person.

ТОРГОХ ЯЛ: ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ШҮҮХИЙН ПРАКТИК

Ж.БААСАНЖАВ¹

I. Үндэслэл

II. Үндсэн хэсэг

- Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх торгох ялын эрх зүйн зохицуулалтын түүхчилсэн судалгаа
- Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх торгох ялыг хэрэглэж буй шүүхийн практик

III. Дүгнэлт

¹ Их Засаг Олон Улсын их сургуулийн, Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, магистр.



**ТОРГОХ ЯЛ: ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ,
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ
ШҮҮХИЙН ПРАКТИК**

Ж.БААСАНЖАВ *Их Засаг Олон Улсын их сургуулийн, Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, магистр.*

Түлхүүр үгс

Монгол Улс, Эрүүгийн хууль, торгох ял, эрх зүйн зохицуулалт, түүхэн уламжлал.

Хураангуй: Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын нэг төрөл нь торгох ял бөгөөд манай улсын эрүүгийн эрх зүйн системчлэлээр торгох ял нь эрүүгийн хариуцлагын төрлөөс хамгийн хөнгөн төрөл юм. Торгох ял нь XIII зуун буюу Их засаг хуулийн үед малаар торгох хэлбэрээр хэрэгжиж эхэлснээс хойш түүхийн үе үеийн эрх зүйн актуудад үе залгамжлагдан өнөөг хүрсэн байдлыг дэлгэрүүлэн авч үзэх болно. Торгох ял нь үр нөлөөтэй байгаа эсэх, эрүүгийн хариуцлагын зорилгод нийцэж байгаа эсэх асуудлын талаар өгүүлсэн болно.

I. Үндэслэл. Аливаа эрх зүйн ухагдахууныг судлахдаа тус ухагдахуун нь үндэсний эрх зүйн тогтолцоонд хэрхэн үүссэн, ямар үзэл баримтлалын дагуу хөгжиж ирснийг анхаарч үзэх нь нэн чухал ба түүнээс улбаалан цаашдын хөгжлийн үе шатыг тодорхойлох боломжтой юм. Тухайн эрх зүйн үүсэл хөгжил, үзэл баримтлал нь цаг үеийн онцлог, нийгмийн байдал, түүх зэргийг өөртөө шингээсэн байдагтай холбоотой. Энэ үүднээс өгүүллийн эхний хэсэгт манай улс торгох ялыг хэрхэн хэрэглэж ирсэн талаарх мэдээллийг баримт бичигт дүн шинжилгээ хийх замаар тодорхойлсон болно.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд торгох ял нь олон жилийн уламжлалтай, хамгийн өргөн хэрэглэгддэг хөнгөн ялын төрөл байсан бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эд хөрөнгийн байдал, хувийн байдал зэргийг харгалзан энэ төрлийн ялыг хэрэглэдэг. Судалгааны ажлын явцад Монгол Улсын 2002, 2015 оны Эрүүгийн хууль дахь торгох ялын үндэслэл, хэмжээ, ялгаатай заагдаж торгох ялын хэрэглээ нэмэгдэж ялын бодлогын үр нөлөө, нийгмийн ач холбогдол нь төдийлөн хангагдахгүй байна гэж судлаачийн зүгээс үзэж, цаашид энэ төрлийн ялыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх талаарх асуудлыг хөндсөн болно.



II. Үндсэн хэсэг

1. Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх торгох ялын эрх зүйн зохицуулалтын түүхчилсэн судалгаа

Манай улс торгох ялыг хэрхэн хэрэглэж ирсэн тухай асуудлыг авч үзэхийн тулд XIII зууны үеийн нийгмийн харилцааг зохицуулж байсан Их Засаг хууль, түүнээс хойших Их цааз, Халх журам, Гадаад Монгол Хууль зүйлийн бичиг, Монгол Улсын Хууль зүйлийн бичиг зэрэг эртний хуулийг судлах шаардлагатай.

XIII зууны үед Чингис хааны тогтоосон хуулийг дагаж мөрдөж байсныг дотоод ба гадаадын эрдэмтэд, судлаачид санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн байна. Харин энэ хуулийг "Засаг", "Их Засаг" "Их Засгийн хууль", "Их ёс" гэх зэргээр олон янзаар нэрлэж иржээ. Энэхүү хууль монголчуудыг дэлхий дахинд шударга ёс, амар амгаланг тогтоох, энхийг сахиулах үйлсэд хувь нэмэр оруулахад нэн чухал үүрэг гүйцэтгэснийг эдүгээ нэгэнт үгүйсгэхийн аргагүй болжээ. Нэрт эрдэмтэн Б.Чимид энэ хуулийн талаар "дэлхийн төр, эрх зүйн түүхнээ жишээ болгон өргөмжлөгддөг эртний Вавилоны хаан Хаммурапийн болон Энэтхэгийн хаан Манугийн хууль Грекийн Юстинианы 12 таблиц (хүснэгт)-ийн хууль мэтээс ч дутуугүй хууль зүйн соёл, түүхийн дурсгалт эх сурвалж байсан гэдгээр монголчууд бид бахархаж болох юм"¹ хэмээн бичсэн байдаг. Энэхүү хуулиар зарим гэмт хэрэгт малаар торгох ял ногдуулж байсан мэдээ бий. Жишээлбэл, адуу хулгайлсан этгээд хулгайлсан адууг эзэнд нь буцаан өгөхийн зэрэгцээ есөн адуу нэмж төлөх байдлаар цээрлүүлж байжээ². Ес нугалж, малаар торгох заалт дараагийн хуульд уламжлагджээ. Торгуулийн ялыг өөр ялаар золин авч гүйцэтгэх буюу ялыг өөр хэлбэрээр биелүүлэх боломжгүй байжээ.

Их Цаазад заасан гэмт хэрэгт есөн малаар торгох ялыг буй болгож, түүнийгээ гурав, тав, долоо, ес дахин үржүүлэн төлдөг журмыг хуульчилсан байна. Жишээлбэл, Их цаазад "Хулгай цааз эхлэв. Тэмээний ял арван таван ес, агт азаргыг арван ес, гүүний найман ес, үхэр, даага, хонь гурвуулын зургаан ес авах болов"³ гэж зааж байжээ. Ийнхүү их цаазад есөөр торгох торгуулийг маш өргөн хэрэглэж байсан байна.

1709 онд батлагдсан Халх журам хуулиар монголын нийгмийн олон талт харилцааг зохицуулж байжээ. Энэ хуульд заасан гэмт хэрэгт малаар торгох торгуулийг мөн нэгэн адил өргөн хэрэглэсэн байна. Жишээлбэл, "Сангийн чулуу, нүүрс, шохой хулгай хийвээс гурван ест", "Хулгайч хүн малын эзнийг чулуу, модоор цохиж орхисон гурван ес", "Тарианаас хулгай хийвээс ял нь шохой, нүүрс лүгээ адил", "Ер хан ба харц алиныг ч, гэлэн хүнд ирт үзүүртээр гар хүрвээс дөрвөн ест. Амаар дайрваас гурван ест", "Ер хан ба харц хүн хуврагт архи өгвөөс өгөгч хүний дөрвөн соёолон мориор торгож, хоёрыг нь засагт автугай. Хоёрыг нь гэрч идтүгэй"⁴ гэх зэргээр заасан байна.

¹ Б.Чимид, *Их засгийн хуулийг эрэн сурвалжлах нь – Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал*, хоёрдугаар дэвтэр, Улаанбаатар, 2008, 129 дэх тал.

² В.Я.Рязановский, *Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм, Их засаг хууль*, Орос хэлнээс орчуулсан Ч.Баатар, Улаанбаатар, 2008, 129 дэх тал.

³ *Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл*. Нэгдүгээр боть, 1206–1910, Улаанбаатар, 2010, 110 дахь тал.

⁴ *Мөн тэнд*.



Гадаад Монголын Хууль зүйлийн бичиг торгох ялыг заахдаа жишээлбэл, "Харц хүн илэрхийеэ засаг ба засаг бус ван бэйл бэйс гүн тайж тавнангуудыг дэмий муу үгээр хэлэлцвээс гурван есөн мал торго. Хошууг захирагч занги мэирэний занги түшмэдийг муу үгээр хэлэлцвээс нэгэн есөн мал торго, цөм албанд хадгалж шагнахад бэлтгэ. Хэрэв эзнээ муу үгээр хэлэлцээд хүнд гэрчлэн гаргаваас шүүж магад болбоос бас ч энэ ёсоор шийтгэгтүн⁵" гэсэн байна. Ес торгох ялыг Гадаад монголын хууль зүйлийн бичигт өргөн хэрэглэхээр заажээ. Гадаад Монголын хууль зүйлийн бичигт зааснаас үзэхэд ес торгох ялыг дотор нь 3, 5, 7, 9 хэмээн ангилжээ. Торгуулиар гаргуулах мал нь төрөл ба толгойн тоогоор тодорхойлогдож байжээ. Жишээлбэл, гурван ес торгуульбал, үнээ 1, хонь 1, бяруу 1-ийг; таван ес торгуулбал, үнээ 1, шар 1, хонь 1, бяруу 2; долоон ес торгуульбал, морь 1, шар 1, үнээ 1, хонь 2, бяруу 2; есөн ес торгуульбал, морь 2, шар 2, үнээ 2, хонь 2, бяруу 1-ийг гаргуулах ёстой байжээ.

Алдсан тусгаар тогтнолоо 1911 онд эргэн сэргээж, бие даасан хууль тогтоох үйл ажиллагааг манай улс эхлүүлсэн билээ. Түүний үр дүнд 1000 гаруй заалт бүхий 65 дэвтэр – Монгол Улсын Хууль бичгийг боловсруулан баталж, дагаж мөрдүүлжээ. Энэ хуулиар ес торгох ялыг хэвээр хадгалан үлдээжээ. Тэгэхдээ торгох малын тоо толгойг тодорхой заах торгуулийн санкцыг буй болгожээ. Жишээлбэл, "томилолтоор яваа сайдуудыг дайран өнгөрөх үед хошуудууд харуул манаа болон өргөөний ноёдууд, байцаагч нараар хамгаалуулна. Хамгаалуулах ажилд хойрго хандаж, томилолтоор яваа сайдуудыг хулгайд өртүүлсэн бол хан, аймгийн ноёд, байцаагч нарыг 27 толгой малаар торгож, хуягийг 100 ташуурдаж шийтгэнэ⁶", "цахилгаан шугамыг шатаасан тохиолдолд тайжийн түшмэлийн зэргийг авч 18 толгой малаар торгож шийтгэнэ⁷" "халдвартай өвчин бусдын гэрт орж, өвчин тараасан тохиолдолд есөн малаар торгож, хэрвээ хүн үхэхэд хүрсэн бол мөн хэргээр 27 толгой малаар торгож шийтгэн, хохирогчид олгоно"⁸, "хүнийг гэмтээгээгүй боловч мал хөрөнгийг их хэмжээгээр сүйтгэж, амьдрах аргагүй хэмжээнд хүргэсэн тохиолдолд тайж түшмэлийг 18 толгой малаар торгоно⁹", "хүний малыг алж, нядалсан бол шууд төлүүлж, есөн толгой малаар торгож шийтгэнэ¹⁰" гэх зэргээр заажээ.

Торгох ялын зохицуулалтыг Монгол Улс 1926, 1934 оны Шүүх цаазны бичиг, 1942, 1961, 1986, 2002 оны Эрүүгийн хуульд дараах байдлаар тодорхойлжээ. БНМАУ-ын 1926 оны Шүүх цаазны бичгийн 11 дүгээр зүйлд "Ял торгуульд төгрөг ба мөнгөөр тогтооно"¹¹ гэж заажээ. БНМАУ-ын 1929 оны Шүүх цаазны бичгийн 11 дүгээр зүйлд "торгуулийг төгрөгөөр тогтоож улсын ба орон нутгийн санд

⁵ Мөн тэнд, 469–470 дахь тал.

⁶ Б.Батбаяр, *Монгол Улсын Хууль зүйлийн бичиг монголын анхны нэгтгэн төрөлжүүлсэн (кодификац) хууль болох нь*, хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар, 2024, 186 дахь тал.

⁷ *Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл*, Хоёрдугаар боть, 1911–1926, V сар. Улаанбаатар, 2010, 336 дахь тал.

⁸ Мөн тэнд.

⁹ Мөн тэнд.

¹⁰ Мөн тэнд, 337 дахь тал.

¹¹ *Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911–2009)*, Улаанбаатар, 2011, 283 дахь тал.



хурааваас зохино¹²”, БНМАУ-ын 1934 оны Шүүх цаазны бичгийн 28 дугаар зүйлд “Энэхүү шүүх цаазын бичгийн тусгай зүйлүүдэд заасан хэмжээний дотор шүүх таслах газраас мөнгөөр хэмжээ тогтоон шийтгэхийг торгууль гэнэ. Торгууль ногдуулан шийтгэхэд уул этгээд нь ямар байдлаар амьдран суудаг ба хөрөнгө чинээний байдлыг харгалзан тогтоон ногдуулах бөгөөд хураасан торгуулийг улсын санд оруулна¹³” гэж заасан байна.

БНМАУ-ын 1942 оны эрүүгийн хуулийн 41 дүгээр зүйлд “Энэхүү хуулийн зохих зүйлүүдэд заасан хэмжээний дотор шүүх таслах газраас мөнгөн шийтгэлийн торгууль гэнэ¹⁴”, БНМАУ-ын 1961 оны эрүүгийн хуулийн 23 дугаар зүйлд “Хуульд заасан хэрэгт, хуульд заасан хэмжээгээр зохих тооны мөнгө гаргуулан авахыг торгууль гэнэ¹⁵”, БНМАУ-ын 1986 оны шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд “Энэхүү хуульд заасан тохиолдолд тогтоосон хэмжээгээр шүүхээс мөнгөн шийтгэл оногдуулахыг торгох гэнэ¹⁶” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын 2002 оны эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Энэхүү хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэнэ¹⁷” гэж заасан бол 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар гэмт хэрэг үйлдсэн хүнд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан торгуулийн нэгжтэй тэнцүү хэмжээгээр мөнгөн төлбөр оногдуулахыг торгох ял гэж зааж хэмжээг нь дөрвөн зуун тавин нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байхаар тогтоосон байна. Түүнчлэн торгох ялыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногийн хорих ялаар солихоор хуульчилсан.

Манай улсын эрүүгийн эрх зүй судлалд торгох ялын анхны тодорхойлолтыг Хууль зүйн ухааны доктор Б.Содовсүрэн өгсөн бөгөөд тэрээр “Эрүүгийн хуульд зааснаар шүүхийн тогтоолоор оногдуулсан зохих хэмжээний мөнгө гэмт хэрэг үйлдэгчээс гаргуулж, улсын санд оруулахыг торгох ял гэнэ¹⁸” гэж үзжээ. Хууль зүйн шинжлэх ухааны доктор Г.Совд “БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 23 дугаар зүйлд заасан хэрэгт хуульд заасан хэмжээгээр зохих тооны мөнгө гаргуулан авахыг торгууль гэнэ¹⁹” гэж бичжээ. Үүнтэй төсөөтэй тодорхойлолтыг хуульч Т.Дэндэв өгсөн байна²⁰. 1982 онд нийтийн хүртээл болсон “БНМАУ-ын эрүүгийн хуулийн тайлбар”-ын зохиогчид “Хуульд заасан хэрэгт, хуульд заасан хэмжээгээр зохих тооны мөнгө шүүхийн тогтоолоор гаргуулж авахыг торгууль гэнэ²¹” гэсэн байна. 1989 онд хэвлэгдсэн “БНМАУ-ын эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар”-ын зохиогчид “Эрүүгийн хуульд заасан тохиолдолд тогтоосон хэмжээгээр... шүүхээс мөнгөн шийтгэл оногдуулахыг торгох гэнэ²²” хэмээжээ.

¹² Мөн тэнд, 313 дахь тал.

¹³ Мөн тэнд, 350 дахь тал.

¹⁴ Мөн тэнд, 367 дахь тал.

¹⁵ Мөн тэнд, 424 дэх тал.

¹⁶ Мөн тэнд, 519 дэх тал.

¹⁷ Мөн тэнд, 703 дахь тал.

¹⁸ Б.Содовсүрэн, *БНМАУ-ын эрүүгийн эрх зүй, Ерөнхий анги*, Улаанбаатар, 1964, 119 дэх тал.

¹⁹ Г.Совд, *БНМАУ-ын эрүүгийн эрх зүйн курс*, Улаанбаатар, 1973, 362 дахь тал.

²⁰ Т.Дэндэв, *БНМАУ-ын эрүүгийн эрх зүй дэх ял шийтгэлийн асуудал*, Улаанбаатар, 1975, 52 дахь тал.

²¹ *БНМАУ-ын эрүүгийн хуулийн тайлбар*, Улаанбаатар, 1982, 57 дахь тал.

²² *БНМАУ-ын эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар*, Улаанбаатар, 1989, 41-42 дахь тал.



2. Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх торгох ялыг хэрэглэж буй шүүхийн практик

Шүүхээс торгох ял ногдуулах байдал хүмүүсийн амьдралын нийгэм, эдийн засгийн нөхцөл, төлбөр төлөх чадвараас ихээхэн хамаардаг байна. Санхүүгийн хямрал, хүмүүсийн амьжиргааны түвшний доройтол, ажилгүйдэл, ядуурал ихсэх үед шүүхээс торгох ял ногдуулах явдал эрс багасах хандлагатай байдаг нь судалгааны явцад ажиглагдсан болно. Улс орны эдийн засгийн байдал тогтворжин сайжрахын хэрээр шүүхээс торгох ялыг ногдуулах тоо нэмэгддэг хандлагатай байна.

Улсын дээд шүүх шүүхийн статистик болон практикийг нэгтгэн судалсан дүнгээс үзэхэд зарим шүүх торгох ялын урьдчилан сэргийлэх, хүмүүжүүлэх ач холбогдлыг зөв үнэлэн үзэхгүй байгаагаас хорих ял хэрэглэх хандлага үзэгдэж байна²³ гэдгийг тэмдэглэсэн байна. Хууль зүйн шинжлэх ухааны доктор С.Жанцан 2002–2012 оны 10 жилийн хугацаанд шүүхүүд нийт 2946 хүнд торгох ял ногдуулсан²⁴ гэсэн судалгаа гаргасан бөгөөд энэ нь шүүх нэг жилд дунджаар 300 орчим хүнд торгох ял ногдуулсан гэсэн үг юм. 2012 онд шүүх 272 хүнд торгох ял ногдуулжээ²⁵. Шүүхүүд 2015 онд 370 хүнийг торгох ялаар шийтгэж²⁶ байсан бөгөөд энэ нь нийт ял шийтгүүлэгсдийн 4.8%-ийг эзэлж байв. 2016 онд шүүхүүд 216²⁷ хүнийг торгох ялаар шийтгэсэн нь нийт ял шийтгүүлэгсдийн 3.3%-ийг эзэлсэн байна. Харин сүүлийн жилүүдийн торгох ялыг ногдуулсан байдлыг авч үзвэл 2019 онд 8367, 2020 онд 8296, 2021 онд 7659, 2022 онд 8928, 2023 онд 9544, 2024 онд 10295 хүнийг торгох ялаар шийтгэсэн байна.

Монгол Улс 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хуулийн этгээдийг гэмт хэргийн субъект болгож, торгох ял ногдуулж байхаар заасан билээ. Хуулийн этгээдэд торгох ялыг ногдуулсан байдлыг авч үзвэл 2019 онд 3, 2020 онд 5, 2021 онд 4, 2022 онд 10, 2023 онд 14, 2024 онд 22 хуулийн этгээдийг шүүх торгох ялаар шийтгэсэн байна.

Торгох ял гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 153.1-д заасны дагуу ахлах шийдвэр гүйцэтгэгч торгох ялаар шийтгүүлсэн этгээдийг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн хүлээж авснаар²⁸ эхэлнэ. Шийдвэр гүйцэтгэгч тус хуулийн 153.2-т заасан тогтоолыг хүлээн авсан даруйд ял эдлүүлэх ажиллагааг эхлүүлнэ. Торгох ялаар шийтгүүлсэн ялтанд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, ялтанд ял эдлүүлэх журам, эрх, үүргийг нь тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна. Торгох ялаас зайлсхийсэн бол тохиолдолд "Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солино²⁹" гэж заажээ. Торгох ял оногдуулсан этгээд торгуулийг төлөөгүй тохиолдолд хорих ялаар шууд

²³ Монгол Улсын дээд шүүхийн тогтоолын эмхтгэл (1959–2010), Улаанбаатар, 2015, 201 дэх тал.

²⁴ С.Жанцан, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/. II боть, Улаанбаатар, 2014, 160 дахь тал.

²⁵ Мөн тэнд.

²⁶ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016. Улаанбаатар, 2017, 102–103 дахь тал.

²⁷ Мөн тэнд.

²⁸ "Төрийн мэдээлэл". 2017 он, 24 дүгээр дугаар.


²⁹ Эрүүгийн хууль (2015)-ийн ерөнхий ангийн 5.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.



солих болсноороо торгох ялыг хорих ялтай дүйцүүлж чангатгах гэсэн бодлого болж хувирсан байна.

Хүснэгт 1. Торгох ялыг хорих ялаар сольсон талаарх мэдээлэл

Торгох ялыг хорих ялаар сольсон тохиолдлууд (2019–2024)



Торгох ялаас зайлсхийсэн тохиолдолд шууд хорих ялаар солихгүйгээр тухайн этгээд торгох ял шийтгүүлсэн эрүүгийн хуулийн тусгай ангийн холбогдох зүйлд заасан санцрын хэмжээ хязгаарт багтсан ялаар сольж байх нь үр нөлөөтэй байж болох талтай. Жишээлбэл, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан этгээдэд шүүх эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6.1-д заасны дагуу 1100 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 1.100.000 төгрөгөөр торгох ял шийтгэжээ. Ялтан торгуулиа төлөх эд хөрөнгийн чадваргүй. Энэ тохиолдолд шүүх эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6.1-д байгаа нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялаар солих боломжтой болно. Өөрөөр хэлбэл, одоогийнх шиг хорих ялаар солихгүй гэсэн үг юм. Энэ нь эрүүгийн хууль тогтоомжийг хүмүүнлэг болгоход тодорхой хэмжээгээр нөлөөлнө гэж үзэж байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангиар хөнгөн гэмт хэрэгт торгох ял оногдуулахаар заасан нийт 70 гэмт хэрэг байна. Тухайлбал, хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах (11.3 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг); хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (11.4 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг); хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах (11.5 дугаар зүйл) гэх мэт. Харин торгох ял оногдуулахаар заасан нийт 21 төрлийн хүнд гэмт хэрэг байна. Тухайлбал, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг), сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах (14.9 дүгээр зүйл), хүний цус, эд эрхтнийг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэх, шилжүүлэн суулгах (15.4 дүгээр зүйл) гэх мэт.

Хүнд төрлийн гэмт хэрэгт Эрүүгийн хуульд заасан хамгийн хөнгөн ял болох торгох ял оногдуулж буй нь нийгмийн аюулаар их гэмт хэрэгт ялын бодлогыг



үлэмж сулруулах байдлыг бий болгож болзошгүй юм. Энэ нь эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хорих ялын доод хэмжээг хоёр жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар тогтоосон гэмт хэргийг хүнд гэж заасантай шууд зөрчилдсөн байна. Өөрөөр хэлбэл, хүнд гэмт хэрэгт торгох ял оногдуулснаар хөнгөн гэмт хэргээс зааглагдах боломжгүй болгосон байна.

III. Дүгнэлт

Эрүүгийн хариуцлагын төрөл болох торгох ял нь манай улсын Их Засаг, Их цааз, Халх журам, Гадаад Монголын Хууль зүйлийн бичиг, Монгол Улсын Хууль зүйлийн бичиг зэрэг хууль тогтоомжид заасан өнө эртний ялын бие даасан төрөл болох нь тогтоогдож байна. Мөн түүнээс хойших эрх зүйн эх сурвалжуудад БНМАУ-ын үед дагаж мөрдсөн 1926, 1929, 1934 оны Шүүх цаазны бичиг, 1942, 1961, 1986, 2002, 2015 оны Эрүүгийн хуульд торгох ялыг уламжлал болгон ялын тогтолцоонд ялын бие даасан төрөл болгон эрүүгийн хуулийн тусгай ангийн олон зүйлд зааж ирсэн байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан ялын системчлэлээр торгох ял нь эрүүгийн хариуцлагын хамгийн хөнгөн хэлбэр бөгөөд торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд эрүүгийн хариуцлагын хамгийн хүнд хэлбэр болох хорих ялаар солихгүйгээр нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялаас солих зэрэг хүмүүнлэг арга хэмжээг авах боломжтой юм. Мөн торгох ял нь эрүүгийн хариуцлагын хамгийн хөнгөн хэлбэр мөртлөө энэ ялыг эрүүгийн хуулийн тусгай ангид тодорхойлсон хүнд хэлбэрийн гэмт хэрэг оногдуулах явдал түгээмэл байна. Энэ нь ялын бодлогыг сулруулах, гэмт хэргийн хүнд ба хөнгөн гэж зааглах боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Торгох ялыг тодорхой хугацаан дахь ялтны цалин хөлс ба орлого түүнчлэн хууль бусаар олсон орлого, эд зүйлийн үнийн дүн, үнэлгээ зэрэгтэй холбож тогтоовол мөнгөний ханшаас үл шалтгаалах нөхцөл бүрдэхээс гадна торгох ялын ялтны эд хөрөнгийн эрхийг хязгаарлах цээрлүүлэлтийн үр нөлөөг улам дээшлүүлэх ач холбогдолтой юм. Тухайлбал, хахууль авах гэмт хэргийн бүрэлдэхүүний санкцид хахуулийн хэмжээг тэд дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр торгох нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, урьдчилан сэргийлэх үр нөлөөг дээшлүүлэх боломжтой.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015 он.

Б.Ном, сурах бичиг

1. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн тайлбар, Улаанбаатар, 1982 он.
2. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар, Улаанбаатар, 1989 он.
3. Б.Чимид, *Их засгийн хуулийг эрэн сурвалжлах нь – Төр, нам эрх зүйн*



- шинэтгэлийн эгзэгтэй асуудал, хоёрдугаар дэвтэр, Улаанбаатар, 2008 он.
4. Б.Батбаяр, *Монгол Улсын Хууль зүйлийн бичиг монголын анхны нэгтгэн төрөлжүүлсэн (кодификац) хууль болох нь, хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл*, Улаанбаатар, 2024 он.
 5. Б.Содовсүрэн, *БНМАУ-ын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги*, Улаанбаатар, 1964 он.
 6. В.Я.Рязановский, *Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм, Их засаг хууль*, Орос хэлнээс орчуулсан Ч.Баатар, Улаанбаатар, 2008 он.
 7. Г.Совд, *БНМАУ-ын эрүүгийн эрх зүйн курс*, Улаанбаатар, 1973 он.
 8. *Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном*, 2016, Улаанбаатар, 2017 он.
 9. *Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл*, Нэгдүгээр боть, 1206–1910, Улаанбаатар, 2010 он.
 10. *Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл*, Хоёрдугаар боть. 1911–1926.V сар, Улаанбаатар, 2010 он.
 11. *Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911–2009)*, Улаанбаатар, 2011 он.
 12. *Монгол Улсын дээд шүүхийн тогтоолын эмхтгэл (1959–2010)*, Улаанбаатар, 2015 он.
 13. Т.Дэндэв, *БНМАУ-ын эрүүгийн эрх зүй дэх ял шийтгэлийн асуудал*, Улаанбаатар, 1975 он.
 14. С.Жанцан, *Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/, II боть*, Улаанбаатар, 2014 он.



Abstract

FINE AS A PENALTY: HISTORICAL TRADITION, LEGAL REGULATIONS, AND COURT PRACTICE

BAASANJAV, J.

*Head of the Department of Criminal Law,
School of Law, Ikh Zasag International University, Master*

One type of criminal liability imposed on offenders is a fine, which, according to our country's criminal legal system, is the lightest form of criminal liability. The practice of imposing fines began in the 13th century, during the time of the Ikh Zasag law code, in the form of fines paid in livestock. Since then, it has been implemented through various legal acts throughout history and has carried on to the present day. This will be elaborated upon in terms of the historical context. The effectiveness of fines and whether they align with the objectives of criminal liability will also be discussed.

Keywords: Criminal Law of Mongolia, Fines as a Punishment, Legal Regulation, and Historical Traditions.



СУДАЛГААНЫ ТАЙЛАН



“ПАБЖИ МОБАЙЛ” /PUBG MOBILE/ ТОГЛООМЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ДЭРГЭДЭХ ШҮҮХИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ¹

¹ Энэхүү судалгааг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн Шүүхийн судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн (Ph.D) удирдаж, Иргэний эрх зүйн секторын эрхлэгч А.Нэмүүлэн, секторын судлаач П.Эрхэмбаяр, Г.Амаржаргал, С.Юмжирдулам, Р.Болор болон Э.Эрхбилгүүн нар хийж гүйцэтгэлээ.



ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	168
УДИРТГАЛ	169
ҮНДСЭН ХЭСЭГ.....	170
НЭГ. "ПАБЖИ МОБАЙЛ" ТОГЛООМЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ (ЗОХИЦУУЛАЛТ) ..	170
1.1. "Пабжи мобайл" тоглоомын талаарх ойлголт, түүний үүсэл хөгжил	170
1.2. "Пабжи мобайл" тоглоомын албан ёсны зохицуулалт	172
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ПРАКТИК (ЭРҮҮ БОЛОН ИРГЭНИЙ ХЭРЭГ).....	174
2.1. Эрүүгийн хэргийн шүүхээр "Пабжи мобайл" тоглоомтой холбоотой хэргийг шийдвэрлэж байсан эсэх тухайд	174
2.2. Иргэний хэргийн шүүхээр "Пабжи мобайл" тоглоомтой холбоотой хэргийг шийдвэрлэж байсан эсэх тухайд	178
ГУРАВ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	181
3.1. АНУ	182
3.2. ЯПОН УЛС	182
3.3. БНХАУ	183
3.4. ХБНГУ	185
ДҮГНЭЛТ.....	188
НОМ ЗҮЙ.....	190



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
ИБУИНХУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
ИХ	Иргэний хууль
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
Шүүхийн академи	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи



УДИРТГАЛ

Судлах зүйл

Судалгааны ажлын хүрээнд "Пабжи мобайл" /PubG mobile/ тоглоомын талаарх ойлголт, түүний үүсэл хөгжил, уг тоглоомд холбогдох эрх зүйн зохицуулалт, тоглоомын дүрэм, түүнчлэн уг тоглоомыг тоглохын тулд мөнгө, эд хөрөнгөө бусдад шилжүүлж хохирсон иргэдийн хохирлыг хэрхэн барагдуулж байгааг тогтоох зорилгоор Монгол Улсын болон бусад улсын шүүх энэхүү тоглоомтой холбогдох хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэж буй талаарх шүүхийн практикийг харьцуулан судлах замаар судалгааг хийж гүйцэтгэсэн болно.

Судалгааны хамрах хүрээ

2017 оноос 2024 он хүртэлх хугацаанд "Пабжи мобайл" тоглоомтой холбоотой хэрэг, маргаан Монгол Улсын Эрүү, Иргэний шүүхээр хянан шийдвэрлэгдсэн эсэхийг олж тогтоохын тулд шүүхийн шийдвэрийн цахим санд хайлт хийн, мөн дээрх тоглоомын үүсэл хөгжил, өнөөгийн зохицуулалт болон бусад улсад хэрхэн зохицуулдаг болох, холбогдох хэрэг, маргааныг шүүхүүд нь хэрхэн шийдвэрлэдэг болохыг тогтоохоор БНСУ, БНХАУ, ХБНГУ, АНУ, Япон Улсын шүүхийн практикийг судаллаа.

Судалгааны арга зүй

Судалгааг хийж гүйцэтгэхдээ анализ хийх, харьцуулан судлах болон нэгтгэн дүгнэх арга зүйг ашигласан.

Судалгааны бүтэц

Энэхүү судалгаа нь Удиртгал, Үндсэн хэсэг, Дүгнэлт, Ном зүй гэсэн хэсгээс бүрдэнэ.



ҮНДСЭН ХЭСЭГ

НЭГ. "ПАБЖИ МОБАЙЛ" ТОГЛООМЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ (ЗОХИЦУУЛАЛТ)

1.1. "Пабжи мобайл" тоглоомын талаарх ойлголт, түүний үүсэл хөгжил

"Пабжи мобайл" тоглоом нь "Playerunknown's battlegrounds mobile" үгнээс гаралтай бөгөөд товч байдлаар "PUBG Mobile" хэмээн нэрлэдэг. Тус тоглоом нь анх 1973 онд Америкийн зөөврийн гар утасны үйлдвэр болох "Dyna Tac" гэх компаниас үүдэлтэй¹ бөгөөд 1990-ээд оны сүүлээр гар утас түгээмэл болж эхэлснээр гар утасны тоглоомууд нь маш энгийн бүтэцтэй, голчлон текст дээр суурилсан оньсого, Snake гэх мэт энгийн аркад тоглоомуудтай болон хөгжсөнөөр, цахим тоглоомын суурь тавигджээ.

Тухайн үед гар утасны тоглоомуудын санах ой, график боловсруулах чадвар нь хязгаарлагдмал байсан тул одоо үеийн тоглоомуудтай харьцуулахад сайтар хөгжөөгүй энгийн тоглоомууд нь хүмүүсийн анхаарлыг татдаг байсан. 2000-аад оны дунд үеэс гар утасны тоглоомуудыг суурилуулах боломжтой болсноор ухаалаг гар утасны хэрэглээ улам их өргөжин тэлсэн. Тухайлбал, Iphone загварын утас үйлдвэрлэгдсэнээр гар утасны тоглоомуудын загварыг өөрчлөх чухал боломжууд гарч ирсэн бөгөөд мэдрэгчтэй дэлгэц болон Apple-ийн App Store-ийг ашигладаг ухаалаг интерфейс² нь хөгжүүлэгчдэд шинэ боломжуудыг олгож, хэрэглэгчид олон төрлийн тоглоомыг хялбархан татаж авах боломж үүссэн байдаг³.

"Пабжи мобайл" тоглоомын албан ёсны байгууллага

"Playerunknown's battlegrounds"-ийг хөгжүүлэгч Крафтон (Krafton)⁴ төв компани нь БНСУ-ын Ганнам дүүрэг (Gangnam district)-т байрладаг. Харин Крафтоний охин компани болох Тенсент (Tencent)⁵ компани нь Крафтоны охин компани болох "PubG Studio"-г хамтран бүтээсэн бөгөөд 2018 оны 2-р сард олон нийтэд нээлтээ хийж, 5 дугаар сард тоглоомоо цахимаар БНХАУ руу худалдаанд гаргаж эхэлсэн.

Харин Крафтон нь БНСУ, Япон Улс болон БНЭУ-д шууд хандан удирдах байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг бол бусад бүс нутагт үйлчлэх тоглоомын үйл ажиллагааг Тенсент удирддаг. Мөн "PUBG Studio" нь тулааны төрлийн цахим тоглоомыг хөгжүүлснээрээ олон нийтэд танигдаж эхэлсэн бөгөөд өөр компьютер тоглоомын түгээлтийн платформ болох "Epic Games Store" дээрээс олж тоглох боломжтой байдлаар хөгжжээ.

¹ АНУ-ын анхны гар утас гаргасан компани цахим сан: <https://www.mobilephonemuseum.com/about> (сүүлд үзсэн: 2024.11.27)

² үйлдлийн системтэй холбогдон ажиллах боломжийг хэрэглэгчдэд олгодог сервер.

³ 최근 게임 정보 전달러 : 모바일 게임의 진화: 휴대기기 속 게임 산업의 미래 (2024.11.29. 참조)

⁴ Крафтон (Krafton) компанийн төв БНСУ-д байрладаг байна. <https://krafton.com/en/> (Сүүлд үзсэн: 2024.11.26)

⁵ Тенсент (Tencent) компанийн төв БНХАУ-д байрладаг байна. <https://www.tencent.com/en-us/> (Сүүлд үзсэн: 2024.11.26)



“Пабжи мобайл” тоглоомын бүтэц

2017 оны 3 дугаар сарын 24-ны өдөр хамгийн анх “Пабжи мобайл” тоглоомыг PC тоглоомын түгээлтийн платформ болох Steam гэх нэртэй платформоор дамжуулснаар олон нийтэд хүрч, улмаар хүмүүс тоглож эхэлсэн ба албан ёсоор 2017 оны 12 дугаар сарын 21-нд нээлтээ хийсэн. Энэ нь хожим Xbox One (-XBO-) болон PlayStation 4 (Playstation 4, PS 4) платформуудаар дэлгэрсэн бөгөөд мөн өөр нэг компьютер тоглоомын түгээлтийн платформ болох “Epic Games Store” дээрээс олж тоглох боломжтой байдлаар хөгжжээ.

Мөн “Пабжи мобайл” тоглоомыг БНСУ-д “Какао” нэртэй серверээр дамжуулдаг бөгөөд Какао сервер ашигладаг компьютерыг 15-аас доош насны хэрэглэгчид ашиглахыг хориглодог бол орон даяар ашиглагдаж буй сервер болох Xbox One, PlayStation-ийг насанд хүрээгүй хүүхэд ашиглах боломжгүйгээр бүтээсэн байна. Товчхондоо гар утасны энэхүү цахим тоглоом нь БНСУ-д хамгийн их дэлгэрсэн. Уг цахим тоглоомыг бүтээж, хөгжүүлдэг компаниудыг Тоглоомын салбарын тухай хууль(게임산업법2006)⁶-аар зохицуулдаг байна.

Өнөө үед хөдөлгөөнт тоглоомын хөгжил нь цахим спортыг бий болгоход хувь нэмрээ оруулсан гэж хэлж болохоор юм. Mobile Legends, PUBG Mobile зэрэг тоглоомууд нь гар утасны экспортын зах зээлийг тэргүүлж байгаа бөгөөд тоглогчдын дунд тэмцээн зохион байгуулагдаж эхэлснээр олон сая шүтэн бишрэгчтэй дэлхийн хэмжээний арга хэмжээ болтлоо хөгжжээ. Энэхүү Мобайл спорт (цахим спорт) нь тоглоомын салбарт нэмэгдэж буй шинэ салбар бөгөөд ялангуяа Зүүн Өмнөд Ази, БНХАУ зэрэг бүс нутгийн иргэд түгээмэл тоглодог байна⁷. Нэмж дурдахад, цахим спорт нь тухайн улсын цахим эдийн засгийг сайжруулах хүч нь болсноор зах зээлд нийтдээ 3.8 тэрбум доллароор үнэлэгдсэн. Мөн энэ чиглэлээр Монгол Улсын цахим спортын тамирчид маш амжилттай оролцоор байна⁸.

“Пабжи мобайл” тоглоомын төлбөрийн систем

“Пабжи мобайл” тоглоомыг тоглохын тулд тоглоомын аппликейшнийг татаж авснаар санхүүгийн буюу төлбөрийг төлөх нөхцөл нь гарч ирдэг. Ийнхүү тоглогч тоглоомыг тоглох нөхцөлийн дагуу тухайн төлбөрийг төлснөөр тоглоомыг тоглох эрх нь баталгааждаг. Дээр дурдсанчлан уг тоглоом нь үнэ төлбөртэйгээр PC түгээлтийн платформ болох Steam-ээр дамжуулагддаг байсан бол дамжуулах серверүүд хөгжсөөр гар утсаар үнэгүй тоглох эрхтэй болжээ. Гэсэн хэдий ч тоглоомыг хөгжүүлэх үйл явцыг сайжруулахын тулд тоглогчид өөрсдийн аккаунтад шинээр гарсан машин, буу, хувцас, эдгээрийн өнгө, нэмэлт тоноглол гэх мэтийг худалдан авах зорилгоор худалдан авч, төлбөртэй тоглодог болсон

⁶ 게임산업법, <https://www.law.go.kr/lsSc.do?section=&menuId=1&subMenuId=15&tabMenuId=81&eventGubun=060101&query=%EA%B2%8C%EC%9E%84%EC%82%B0%EC%97%85%EC%A7%84%ED%9D%A5%EC%97%90+%EA%B4%80%ED%95%9C+%EB%B2%95%EB%A5%A0#undefined> (Сүүлд үзсэн: 2024.11.26)

⁷ Мэдээллийн цахим сан (Dorgio information guide) :<https://dorgio.mn/index.php/p/98033> (сүүлд үзсэн: 2024.12.01)

⁸ “УИХ-ын тамгын газар, УИХ-ын намрын ээлжит чуулганы хуралдааны тэмдэглэл”, 2023.12.14, <https://www.parliament.mn/nn/1102/>, (Сүүлд үзсэн: 2024.12.01).



байна⁹.

Энэ арга нь хэрэглэгчдэд тоглоомыг тоглоход саад болж буй саадыг багасгаж, ийнхүү тэднийг тоглоомд хөрөнгө оруулахыг аажмаар дэмжих арга болгон ашигладаг болжээ¹⁰. Улмаар ирээдүйд гар утасны тоглоомууд улам их хөгжсөөр байх бөгөөд өнөө үед хиймэл оюун ухаан, 5G сүлжээ¹¹ зэрэг нь цахим тоглоомын чанар сайжрахад нэлээдгүй түлхэц үзүүлсээр байна.

1.2. "Пабжи мобайл" тоглоомын албан ёсны зохицуулалт

Пабжи мобайл тоглоомыг тоглож буй этгээд буюу хэрэглэгчтэй тухайн тоглоомын эзэмшигч байгууллагын зүгээс байгуулах хэд хэдэн зөвшилцөл, дүрэм, журам байдаг байна. Тэдгээр нь тоглоомыг тоглох үйл явц /in game/-ыг зохицуулахаас гадна эцсийн хэрэглэгчийн зөвшилцөл /End User License Agreement¹²/, тоглоом дотор байрших виртуал бүтээгдэхүүнийг худалдан авахад ашиглагдах мөнгө буюу төлбөрийн хэрэгсэл /unknown cash-UC/-ийг худалдан авах нөхцөл /PUBG Mobile Game Credit Cards-Terms and Conditions¹³/, мөн нууцлалын бодлого /Privacy Policy¹⁴/ зэрэг ерөнхий зохицуулалтуудыг өөртөө багтаадаг. Эдгээрээс тухайн тоглоомын тоглогч болон тоглоомын үйлдвэрлэгч компанийн хооронд байгуулагдах ерөнхий зөвшилцлийг тухайлан дэлгэрүүлэн авч үзье.

Пабжи мобайл тоглоомын хэрэглэгч буюу тоглогч нь тоглоом доторх өөрийн дүрийг хөгжүүлэхдээ тодорхой виртуал хэрэгсэл буюу барааг /virtual goods/ зөвхөн уг тоглоомд ашиглах боломжтой төлбөрийн хэрэгсэл болох UC /unknown cash/-р авдаг. Энэхүү виртуал бараа болон тоглоомын төлбөрийн хэрэгслийг бусдад зарж борлуулах, шилжүүлэх, мөн хөрөнгө оруулалтын зориулалтаар ашиглах боломжгүй буюу зөвхөн тоглоомыг тоглох хүрээнд л ашиглахаар хязгаарлажээ¹⁵.

Дээрх виртуал бараа болон тоглоомын төлбөрийн хэрэгслийг доголдолтой, ашиглах боломжгүй, мөн тухайн хэрэглэгчийн оршин сууж буй улсын хуульд буцаалт хийх эрхийг гэрээгээр хориглох боломжгүй байхаар хуульчилснаас бусад тохиолдолд бодит мөнгөн хэлбэр рүү шилжүүлэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл хэрэглэгч худалдан авалт хийснээрээ буцаах эрхээсээ татгалзаж байна гэж үздэг байна¹⁶.

Уг эцсийн хэрэглэгчийн цахим гэрээн дэх 1-10 дугаар хавсралтаар тухайлсан зарим улсуудын оршин суугчид үйлчлэх журмыг тогтоож өгсөн ба тэдгээрт: Европын Холбоо, ИБУИНХУ, Бразил Улс, БНСУ, Япон Улс, ОХУ, Мароккогийн Хаант

⁹ 게임소개 https://blog.naver.com/playthegame_/223194795301 (Сүүлд үзсэн: 2024.11.26)

¹⁰ Battle Pass: <https://www.fortnite.com/?lang=en-US> (Сүүлд үзсэн: 2024.11.26)

¹¹ Интернет, сүлжээний хурд болон чанарыг сайжруулсан хувилбар.

¹² End User License Agreement, April 28, 2024, <https://www.PubGmobile.com/terms/GBR/#ScheduleAnchorPoint4>

¹³ PUBG Mobile Game Credit Cards-Terms and Conditions, December 02, 2024, <https://www.PubGmobile.com/gamecredits/terms.html>

¹⁴ Playerunknown's Battlegrounds Mobile, Privacy Policy, November 25, 2024, <https://PubGmobile.proximabeta.com/privacy/en.html>

¹⁵ End User License Agreement, 9. Virtual Goods and Game Currency, December 02, 2024, https://www.PubGmobile.com/terms/GBR/#_Toc76489276

¹⁶ End User License Agreement, 10. Refunds, December 02, 2024, https://www.PubGmobile.com/terms/GBR/#_Toc76489276



Улс, Бүгд Найрамдах Тунис Улс, Австрали Улс, Мексикийн Нэгдсэн Улс, болон Канад Улс багтжээ. Эдгээр улсуудад хамаарах онцлох зарим зохицуулалтыг хавсралтуудаас авч үзье. *Хавсралт 1¹⁷*-д: виртуал бараа болон тоглоомын төлбөрийн хэрэгслийн худалдан авалтаа 14 хоногийн дотор ямар нэгэн шалтгаан дурдах шаардлагагүйгээр цуцлах эрхтэй байна. Үүний тулд тоглогч загварын дагуу худалдан авалт хийхээр захиалга хийсэн болон хүлээн авсан огноо, нэр, хаяг, гарын үсэг, огноог бичин илгээхээр заажээ¹⁸.

Харин БНСУ-д улсад үйлчлэх *Хавсралт 3-т*: Насанд хүрээгүй хэрэглэгч виртуал бараа болон тоглоомын төлбөрийн хэрэгслийг худалдан авсныг асран хамгаалагч нь хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд компанийн зүгээс асран хамгаалагч эсхүл тухайн хэрэглэгчид өөрт нь хийсэн худалдан авалтаа цуцлах боломжтой талаар мэдэгдэхээр заасан байна. Харин тухайн насанд хүрээгүй этгээд нь өөрийн хууль ёсны төлөөлөгчийн захиран зарцуулахыг зөвшөөрсөн эд хөрөнгөөр, мөн өөрийгөө насанд хүрсэн хэмээн хууран мэхэлж итгүүлсэн, эсхүл хууль ёсны төлөөлөгчийнхөө зөвшөөрлөөр худалдан авалт хийсэн тохиолдолд цуцлах боломжгүй байхаар тусгажээ¹⁹.

Австрали Улсын хувьд буюу *Хавсралт 8-д* худалдан авалтыг буцаахын тулд тус улсын хэрэглэгчийн тухай хуульд зааснаар хязгаарлагдах буюу тухайн хуульд зааснаас бусад тохиолдолд виртуал бараа болон тоглоомын төлбөрийн хэрэгслийг буцаах боломжгүй байхаар зохицуулжээ²⁰.

Дээрхээс үзэхэд улс улсын хууль тогтоомжоос шалтгаалан өөр өөр зохицуулалт үйлчлэх боломжтойг харж болохоор байна.

Цаашлаад төлбөр төлөхтэй холбоотой зохицуулалтыг илүү дэлгэрүүлэн авч үзвэл: Пабжи мобайл тоглоомын албан ёсны цахим хуудасны төлбөр төлөх /pay/ цэс рүү хандахад "midasbuy²¹" гэх гуравдагч платформыг холбосон байх ба үүгээр дамжуулан тоглоом дотор ашиглах төлбөрийн хэрэгсэл болон УС-г худалдан авдаг байна. Иймд тухайн midasbuy гэх платформын хэрэглэх нөхцөл /Midasbuy Terms of Use/²²-ийг авч үзье.

Энэхүү нөхцөлийн удиртгал хэсэгт "*Хэрэв та 18-аас доош /эсхүл тухайн улсын хуулиар насанд хүрээгүй хэмээн тооцогдох/ настай бол таны эцэг эх, эсхүл асран хамгаалагч энэхүү нөхцөлийг урьдчилан хүлээн зөвшөөрсөн байх шаардлагатай*" гэж, мөн 15.7 дахь хэсэгт "*ямар нэг бүтээгдэхүүнийг худалдан авахаар захиалга хийсэн тохиолдолд та бидэнд өөрийн данснаасаа төлбөрийг татах эрхийг олгож байгаа ба ийнхүү худалдан авалт хийх санаа зорилгогүй байсан зэрэг тохиолдолд ч буцаалт хийгдэх боломжгүй...*" гэж, 12.2 дахь хэсэгт "*Бид ямар нэгэн гуравдагч этгээдийн шаардаж буй*

¹⁷ Европын холбоо, Их Британи, Бразил улсын оршин суугчид үйлчлэх журам

¹⁸ Exhibit 1 to Schedule A-1: Addendum for Cancellation (European Union, UK, and Brazil), December 02, 2024, https://www.PubGmobile.com/terms/GBR/#_Toc76489276

¹⁹ Schedule A-3: Addendum for Residents of South Korea, December 02, 2024, https://www.PubGmobile.com/terms/GBR/#_Toc76489276

²⁰ Schedule A-8: Addendum for residents of Australia, Refunds, December 02, 2024, https://www.PubGmobile.com/terms/GBR/#_Toc76489276

²¹ <https://www.PubGmobile.com/pay/>

²² Midasbuy Terms of Use, August 14, 2023, https://cdn.midasbuy.com/static_page/terms/Clean%20-%20Midasbuy%20-%20Terms%20of%20Use%20-en-%20Aug%202023.html



төлбөрийг хариуцахгүй" гэж тус тус заажээ.

Мөн "Пабжи мобайл" тоглоомын албан ёсны цахим хуудасны туслалцаа үзүүлэх цэс дэх "буцаалт, нэхэмжлэх эрх"-ийн талаар мэдээлэлд дурдсанаар алдаатай худалдан авалт хийсэн тохиолдолд 7 хоногийн дотор буцаалт хийгдэх боломжтой, харин тухайн бүтээгдэхүүн нээгдсэн болон хэрэглэгдсэн тохиолдолд буцаалт хийгдэх боломжгүй талаар дурджээ.

Түүнчлэн тоглоом эзэмшигчийн зүгээс тухайлсан нэг улсад зориулан төлбөр төлөхтэй холбогдуулан журам гаргах тохиолдол байх ба үүний нэг нь БНЭУ юм. Тус журмын /PubG Mobile Game Credit Cards (India)-Terms and Conditions²³/ 3 дахь хэсэгт "Аливаа төлөлт нь эцсийнх буюу буцаах боломжгүй ба ашигласан эсэхээс үл хамааран ямар ч тохиолдолд таны өөрийн тань хийсэн худалдан авалтын төлбөрийг буцаан олгох үүрэг хүлээхгүй" хэмээн заасан байна.

Дээрхээс үзвэл, нийтлэг байдлаар төлсөн төлөлтийг буцаах боломж хязгаарлагдмал буюу төлөлт хийснээс хойш заасан тодорхой хоног дотор ашигласан платформын эзэмшигч байгууллага руу хүсэлт гаргах боломжтой байна. Мөн тоглоомын хэрэглэгчийн зүгээс зайлшгүй уншиж танилцан, зөвшөөрсөн байх шаардлагатай цахим гэрээ /зөвшилцөл/ байгуулдаг. Түүгээр дамжуулан насанд хүрээгүй хүний хийж буй үйлдлийг урьдчилан түүний эцэг эх болон асран хамгаалагч нь зөвшөөрсөнд тооцохоор зохицуулжээ.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ПРАКТИК (ЭРҮҮ БОЛОН ИРГЭНИЙ ХЭРЭГ)

2.1. Эрүүгийн хэргийн шүүхээр "Пабжи мобайл" тоглоомтой холбоотой хэргийг шийдвэрлэж байсан эсэх тухайд

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан болох www.shuukh.mn дэх эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт 2017.01.01-ний өдрөөс 2024.11.27-ны өдрийг хүртэлх хугацаагаар "Пабжи" гэх түлхүүр үгээр хайлт хийхэд нийт **32** шийдвэр илэрсэн. Үүнээс энэхүү судалгаатай холбоотой байж болохуйц гэж үзсэн **4** шийдвэрийг сонгон авч судалсан бөгөөд дээрх хэргүүд нь давж заалдах болон хяналтын шүүхээр хянагдаагүй²⁴.

²³ PubG Mobile Game Credit Cards (India)-Terms and Conditions, December 02, 2024, <https://www.PubGmobile.com/gamecredits/terms.html>

²⁴ Мөн "пабжи" гэх түлхүүр үгээр давж заалдах шатны шүүхийн магадлал болон хяналтын шатны шүүхийн тогтоолуудаас хайлт хийхэд судалгаатай холбоотой гэж үзэхүйц тогтоол, магадлал байгаагүй болно.


Хүснэгт 1. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол.

№	Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	Хэргийн үйл баримт	Шүүхийн дүгнэлт
1	БЭДЭХАШШ 2021.07.09 2021/ ШЦТ/814²⁵	<p>Өсвөр насны яллагдагч О.С нь 2020.10–2021.03.10-ны хооронд өөрийн хөтлөн явуулдаг фейсбүүкийн FIRE.MN пейж хуудсаар “1072 хувьцаа өндөр үнээр авна”, “Пабжи тоглоомын УС зарна” гэх зар байршуулан цахим хэрэгсэл ашиглан, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж үргэлжилсэн үйлдлээр нэр бүхий 55 иргэнээс нийт 701.999 /Долоон зуун нэг мянга есөн зуун ерэн ес/ төгрөгийг өөрийн Хаан банканд эзэмшдэг тоот дансаар шилжүүлэн авч бусдад бага хэмжээний хохирол учруулж залилсан гэмт хэрэгт холбогджээ.</p>	<p>Бусдын эд хөрөнгийг шилжүүлэн авах үйлдлээ хууль бус шинжтэйг мэдсээр атлаа хүсэж үйлдсэн, уг үйлдлээрээ хохирол хор уршигт зориуд хүргэсэн тул О.С-ын үйлдлийг гэм буруугийн санаатай хэлбэр гэж үзнэ.</p> <p>Өмчлөгч, эзэмшигч нь хуулиар тогтоосон хэм хэмжээ хязгаарын дотор өөрийн эд хөрөнгөө чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах, аливаа халдлагаас хамгаалах эрхтэй бөгөөд энэ эрхэд хуурах, цахим хэрэгсэл ашиглах, зохиомол байдлыг зориудаар бий болгох, төөрөгдөлд оруулах аргаар халдан бусдын эд хөрөнгө авсан байх залилах гэмт хэргийн үндсэн шинжийг хангажээ.</p> <p>Өсвөр насны шүүгдэгч О.Сын хууль бус үйлдлийн улмаас хохирогч нарт бодит хохирол учирсан, уг үйлдэл, хохирол 2 хоорондоо шууд шалтгаант холбоотой байна.</p> <p>Баянзүрх дүүргийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан ялах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэл тохирсон, хэргийн бодит байдал тогтоогдсон гэж үзэх үндэслэлтэй.</p> <p>Иймд шүүхээс өсвөр насны шүүгдэгч О.Сыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хуурч, цахим хэрэгсэл ашиглан, зохиомол байдлыг зарцуудаар бий болгон төөрөгдөлд оруулан бусдын эд хөрөнгийг шилжүүлэн авч залилах гэмт хэргийг үргэлжилсэн үйлдлээр үйлдсэн” гэм буруутайд тооцов.</p>

²⁵ Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021.07.09-ний өдрийн 2021/ШЦТ/814 дугаар шийтгэх тогтоол, https://shuukh.mn/single_case/58825?daterange=2017-01-01%20-%202024-11-27&id=1&court_cat=2&bb=1 (сүүлд үзсэн: 2024.11.27)



2	<p>БЗДЭХАШШ 2022.05.02 2022/ ШЦТ/643²⁶</p>	<p>Фейсбүүкт Скай Мей гэх нэртэй хаягаас Пабжи нэртэй тоглоомын хэрэглүүр худалдах тухайн хуурамч зарыг нийтэлж зохиомол байдлыг зориудаар бий болгож, уг зарын дагуу хохирогч Н.А цахим хэрэгсэл ашиглаж, тухайн тоглоомын хэрэглүүрийг худалдах боломжтой мэтээр итгэл төрүүлэн хуурч, бодит байдлыг нуух замаар төөрөгдөлд оруулж, өөрийн нэрээр Хаан банканд эзэмшдэг 5 дугаартай дансаар 20 төгрөгийг шилжүүлэн авч бусдад нийт 167 төгрөгийн буюу бага хэмжээний хохирол учруулж залилсан гэх хэрэгт яллагдагчаар татагджээ.</p>	<p>Баянзүрх дүүргийн прокурорын газраас М.Хд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн зүйлчлэл нь хэргийн бодит байдалтай тохирсон байх тул М.Хг "Хуурч, цахим хэрэгсэл ашиглан, зохиомол байдлыг зориудаар бий болгон төөрөгдөлд оруулан бусдын эд хөрөнгийг шилжүүлэн авч заллах гэмт хэргийг үргэлжилсэн үйлдлээр үйлдсэн" гэм буруутайд тооцов.</p>
3	<p>БЗДЭХАШШ- 2023.01.23 2023/ ШЦТ/110²⁷</p>	<p>Шүүгдэгч нь шууд санаатай, шунахайн сэдэлтээр, амар хялбар аргаар мөнгө олох зорилгоор фейсбүүк, цахим орчинд "Пабжи мобайл" тоглоомын акаунтыг 4.500.000 төгрөгөөр зарна" гэх зарыг байршуулан цахим хэрэгсэл ашиглан, хуурч, зохиомол байдлыг зориудаар бий болгон 2022.03.25-ны өдөр иргэн Пабжи мобайл тоглоомын акаунтыг авахаар Хаан банкны тоот данснаас интернэт банк ашиглан шилжүүлсэн 4.500.000 төгрөгийг, өөрийн эзэмшлийн Хаан банкны тоот дансаар шилжүүлэн авч заллах гэмт хэрэгт тус холбогджээ.</p>	<p>Прокурорын газраас шүүгдэгч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хуулийн зүйл, хэсэг тохирсон гэж үзлээ.</p> <p>Шүүгдэгч нь шууд санаатай, шунахайн сэдэлтээр, амар хялбар аргаар мөнгө олох зорилгоор фейсбүүк, цахим орчинд "Пабжи мобайл" тоглоомын акаунтыг 4.500.000 төгрөгөөр зарна" гэх зарыг байршуулан цахим хэрэгсэл ашиглан, хуурч, зохиомол байдлыг зориудаар бий болгон 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр иргэн Пабжи мобайл тоглоомын акаунтыг авахаар "Хаан" банкны тоот данснаас интернэт банк ашиглан шилжүүлсэн 4.500.000 төгрөгийг, өөрийн эзэмшлийн "Хаан" банкны тоот дансаар шилжүүлэн авч залилсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулан тодорхойлж байна.</p>

Дүн шинжилгээ

Дээрх эрүүгийн шүүхийн шийдвэрүүдээс үзэхэд, "Пабжи мобайл" тоглоомын аккаунт болон тоглоомын хэрэглүүрийг худалдах, тухайн тоглоомын төлбөр, тооцооны хэрэгсэл болох "УС" цэнэглэж өгнө гэх зарыг олон нийтийн сүлжээнд байршуулж бусдын эд хөрөнгийг шилжүүлэн авсан боловч тухайн тохиролцсон

²⁶ Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.05.02-ны өдрийн 2022/ШЦТ/643 дугаар шийтгэх тогтоол, https://shuukh.mn/single_case/66873?daterange=2017-01-01%20-%202024-11-27&id=1&court_cat=2&bb=1 (сүүлд үзсэн: 2024.11.27)

²⁷ Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023.01.23-ны өдрийн 2023/ШЦТ/110 дугаар шийтгэх тогтоол, https://shuukh.mn/single_case/84391?daterange=2017-01-01%20-%202024-11-27&id=1&court_cat=2&bb=1, (сүүлд үзсэн: 2024.11.27)



зүйлийг шилжүүлээгүй болон мөнгийг нь авсан боловч "УС"-ийг цэнэглэж өгөөгүй үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг²⁸-т заасан гэмт хэргийн шинжийг агуулж байна гэж үзэх шүүхийн практик тогтсон болох нь харагдаж байна.

Шийдвэрүүдийн үндэслэлийг авч үзвэл, тухайн гэмт хэргийг иргэний эрх зүйн харилцаанаас хэрхэн ялгагдаж буй талаар тодорхой дурдаагүй бол Монгол Улсын дээд шүүхээс 2002 оны Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйл²⁹-д заасан "Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах" гэмт хэргийг иргэний эрх зүйн харилцаанаас хэрхэн ялгах талаар тайлбарласан тогтоол³⁰ хууль хэрэглээний хувьд өнөөдөр ч чухал ач холбогдолтой болох нь судлаачдын бүтээл болон шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээнээс харагдаж байна.

Тухайлбал судлаач Ц.Гантулгабат, залилах гэмт хэргийн үед гэмт этгээд бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг эзэмших эрхийг хууль бусаар олж авахаас өмнө хохирогчийг хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж, энэхүү үйлдлээ шунахайн сэдэлтээр анхнаасаа зориуд хэрэгжүүлдэг нь иргэний эрх зүйн маргаанаас ялгах гол нөхцөл³¹ гэж дурдсан байна.

Монгол Улсын дээд шүүхийн 2006 оны 51 дүгээр тогтоолд, гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг бүгдийг буюу заримыг шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго төрж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх, тодорхой үйлдэл хийсэн нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад тогтоогдвол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ³² гэж тайлбарлажээ.

Мөн түүнчлэн судлаачдын шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээнд, анхан шатны шүүхээс залилах гэмт хэргийг цагаатгахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.9 дүгээр зүйлийн 1.1, 1.2-т заасан агуулга, үндэслэлийг хангах шаардлагатай. Хохирогч тал нь гомдолтой, хохирол барагдуулаагүй байхад "гэрээ хийгдсэн, гэрээгээ нотариатаар батлуулсан нь иргэний эрх зүйн шинжтэй маргаанд тооцогдоно" гэсэн агуулгаар шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгох нь буруу жишиг³³ болохыг дурдсан байна.

²⁸ Эрүүгийн хууль (2017 он)-ийн тусгай ангийн 17.3 дугаар зүйл. Залилах.

²⁹ Эрүүгийн хууль (2002 он)-ийн 148 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах.

³⁰ Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, "Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан "бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах" гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар", 2006, №51,

³¹ Ц.Гантулгабат, "Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т заасан "залилах" гэмт хэргийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэхэд анхаарах асуудал, <https://legaldata.mn/buteel/pdf?id=1441>, (Сүүлд үзсэн: 2024.11.28)

³² Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, "Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан "бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах" гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар", 2006, №51, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468109108411>, (Сүүлд үзсэн: 2024.11.28)

³³ Нээлттэй нийгэм форум, Шүүхийн шийдвэрийн судалгаа, цуврал 2, "Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ" 2021, 213 дахь тал.



Худалдах-худалдан авах, түрээслэх, эд хөрөнгө хөлслөх гэрээгээр халхавчлан бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг нь анхнаасаа хууль, гэрээнд заасан эд хөрөнгийг нийлүүлэхгүй, үнэ болон хөлсийг зохих журмаар төлөхгүй байх гэсэн субьектив санаа зорилгыг агуулж, түүнийгээ хэрэгжүүлсэн байдаг төдийгүй чанар муутай буюу иж бүрдэл дутуу бүтээгдэхүүн санаатай нийлүүлж өөртөө ашиг олсон, төлбөрийг төлөх боломжтой атлаа зориуд дутуу төлсөн зэрэг хэлбэрээр илэрнэ³⁴.

Нэгтгэн дүгнэхэд, бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг эзэмших, өмчлөх эрхийг буцааж өгөхгүй, хариу төлбөр огт хийхгүй, эсхүл хагасыг нь хийнэ гэсэн субьектив санаа зорилго гэмт этгээдийн хувьд гэмт үйлдлээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө бий болсон эсвэл гэрээ хэрэгжих явцад гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг бүгдийг буюу заримыг шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго төрж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх, тодорхой үйлдэл хийсэн нь гэмт хэргийн шинжтэй үйлдэл тул иргэний эрх зүйн маргаанаас ялгагдаж байна.

2.2. Иргэний хэргийн шүүхээр "Пабжи мобайл" тоглоомтой холбоотой хэргийг шийдвэрлэж байсан эсэх тухайд

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан болох www.shuukh.mn дэх иргэний хэргийн анхан, давах, хяналтын шатны шүүхийн шийдвэрээс 2017.01.01-ний өдрөөс 2024.11.27-ны өдрийг хүртэлх хугацаагаар "пабжи", "пабжи мобайл" гэх түлхүүр үгээр хайлт хийхэд пабжи тоглоомтой холбоотой шүүхийн нийт **4** шийдвэр илэрснээс **3** шийдвэр нь нэхэмжлэгчийн нэхэмжилсэн хохирлыг буцаан олгож шийдвэрлэсэнтэй холбоотой байх тул шүүх хэрхэн шийдвэрлэсэн болохыг доорх хүснэгтэд хураангуйлан оруулсан болно.

³⁴ Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, "Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан "бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах" гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар", 2006, №51,


Хүснэгт №2. Иргэний хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр

№	Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	Хэргийн үйл баримт	Шүүхийн дүгнэлт
	<p>Баянзүрх дүүргийн ИХАШШ-ийн 2024.06.04-ний өдрийн 101/ШШ2024/02989³⁵</p> <p>НИХДЗШШ-ийн 2024.07.17-ны өдрийн 210/МА2024/01411³⁶</p>	<p>Нэхэмжлэгч Х.С нь өөрийн насанд хүрээгүй хүү С.Т нь өөрийнх нь гар утсаар дамжуулан хариуцагч Г.Э рүү 35,138,605 төгрөгийг PUBG тоглоом тоглох зорилгоор шилжүүлсэн. Уг мөнгөнөөс буцааж 5,060,000 төгрөгийг авсан. Г.Э нь насанд хүрээгүй хүүхэдтэй эцэг, эхийн зөвшөөрөлгүй хэлцэл байгуулсан нь хууль зөрчсөн хүчин төгөлдөр бус хэлцэл тул түүний үндэслэлгүйгээр олж авсан 30,078,605 төгрөгийг буцаан гаргуулна гэж, хариуцагч талаас PubG тоглоомыг тоглохдоо олон улсын MIDASBUY сайтад мөнгө төлж эрх авч тоглодог. Тоглоомын эрхийг авч өгөхдөө тухайн хүний царайг харах боломжгүй, хандсан хүнд нь авч өгдөг. С.Т-г насанд хүрээгүй гэж мэдээгүй, өөрөө төлбөрөө төлж тоглоомын эрх авсан. Би урамшуулал болгон авсан 5,060,000 төгрөгийг мөрдөн байцаалтын шатанд буцааж өгсөн. Үлдэх төлбөр нь надад үлдээгүй тул нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөхгүй гэж маргажээ.</p>	<p>Давж заалдах шатны шүүх нь Анхан шатны шүүх үйл баримтыг зөв тогтоосон гэж үзсэн.</p> <p>С.Т болон Г.Э нарын харилцаа нь ИХ-ийн 399 дүгээр зүйлийн 399.1 дэх хэсэгт заасан даалгаврын гэрээний харилцаанд хамаарна.</p> <p>Гэрээг байгуулах үед хариуцагч С.Т-г <i>13 настай гэдгийг мэдсэн, мэдэх боломжтой байсан гэх үйл баримт ИХШХШтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэгт зааснаар тогтоогдоогүй</i> ба С.Т-г гарсан үр дагаврыг хариуцах үүрэгтэй гэж дүгнэсэн нь ИХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1-т заасантай нийцэж байна.</p> <p>Мөн <i>тус харилцаа нь тоглоом, мөрийний шаардах эрх дээрх харилцаанд хамаарахгүй</i> гэдгийг Анхан шатны шүүх зөв дүгнэсэн гэж үзжээ.</p> <p>Түүнчлэн <i>цахим тоглоом нь хуулиар хориглогдоогүй, гэрээг байгуулах үед зохих этгээдээс зөвшөөрөл авах ёстой байсан нөхцөл байдал тогтоогдоогүй</i> тул С. болон Г. нарын байгуулсан гэрээг ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.1, 56.1.8-д зааснаар хүчин бус гэж тооцох үндэслэлгүй бөгөөд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нь ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1.1-д нийцсэн хэмээн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, Г.Э-ээс 752,825 төгрөгийг гаруулж шийдвэрт өөрчлөлт оруулан шийдвэрлэсэн байна.</p>

³⁵ Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024.06.04-ний өдрийн 101/ШШ2024/02989 дугаартай шийдвэр, https://shuukh.mn/single_case/139949?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1 (Сүүлд үзсэн: 2024.12.06)

³⁶ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024.07.17-ны өдрийн 210/МА2024/01411 дугаартай магадлал, https://shuukh.mn/single_case/31098?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1 (Сүүлд үзсэн: 2024.12.06)



	<p>Хан-Уул дүүргийн ИХАШШ-ийн 2024.06.25-ны өдрийн 183/ШШ2024/02812³⁷</p>	<p>Нэхэмжлэгч Х.С нь 13 настай хүү болох С.Т-ыг төлөөлөн <i>ИХ-ийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3, 16.3.1-16.3.3, 17 дугаар зүйлийн 17.1, 17.2, 486 дугаар зүйлийн 486.1, 486.4 болон 56 дугаар зүйлийн 56.1.1, 56.5 дугаар зүйлүүдийг үндэслэн хэлцэл хийсэн талууд нь уг хэлцлээр шилжүүлсэн бүх зүйлээ харилцан буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэгтэй тул хариуцагч О.Х-аас цахим тоглоомыг худалдсан гэж С.Т-өөс авсан 10,530,000 төгрөгийг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг гаргасан.</i></p> <p>Хариуцагч талаас С.Т-г насанд хүрсэн гэж ойлгож тоглоомыг худалдсан, мөн нэхэмжилсэн үнийн дүнг шилжүүлэх үндэслэлгүй, учир нь уг төлбөрийг олон улсын MIDASBUY сайт руу шилжүүлсэн тул эргүүлж өгөх боломжгүй гэж маргажээ.</p>	<p>Шүүхээс <i>ИХ-ийн 16.2 болон 163-д заасан үндэслэлээр хариуцагч О.Х нь С.Т-ийн эцэг, асран хамгаалагч Х.С-ийн зөвшөөрөлгүйгээр 10,530,000 төгрөгийн үнийн дүн бүхий худалдах, худалдан авах гэрээ байгуулсан нь ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.8-д заасныг зөрчсөн гэх үндэслэлтэй, Мөн ИХ-ийн 243 дугаар зүйлийн 243.1. дэх хэсэгт заасныг баримтлан хариуцагч О.Х, С.Т нарын хооронд хийгдсэн худалдах-худалдан авах хэлцлийг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцож, 10,530,000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагаас 1,000,000 төгрөгт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож, үлдэх хэсгийг хангаж шийдвэрлэв.</i></p> <p>Учир нь <i>ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.6-д Хүчин төгөлдөр бус хэлцэл хийсэн буруутай этгээд нь бусдад учруулсан хохирлыг нөхөн төлнө гэж заасан байх ба нэхэмжлэгч Х.С нь өөрийн хүү С.Т гар утсаа ашиглуулах боломж олгосон, хүүхдийг хараа хяналтгүй орхисон, эцгийн хайхрамжгүй байдлаас мөнгийг хариуцагчид шилжүүлсэн байх тул О.Х-аас С.Т-ийн шилжүүлсэн 10,530,000 төгрөгөөс 9,530,000 төгрөгийг буцаан гаргуулахаар шийдвэрлэсэн байна.</i></p>
--	---	--	---

Дээрхээс үзвэл, иргэний хэргийн шүүхэд цахим тоглоом буюу "PubG mobile" тоглоомтой холбоотойгоор эд хөрөнгөөрөө хохирч, улмаар холбогдох төлбөрийг нэхэмжилсэн тохиолдол буюу жишиг бүхий анхан шатны шүүхийн шийдвэр **2**, давж заалдах шатны шүүхийн магадлал **1** байна.

Хүснэгтэд дурдсан шүүхүүдэд нэхэмжлэл, гомдлыг гаргасан этгээд нь нэг этгээд буюу С.Х ба түүний шүүхэд хандаж гаргасан нэхэмжлэл, гомдол нь үйл баримтын агуулгаараа адилхан байх хэдий ч хариуцагч болон нэхэмжлэгчийн зарим нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл нь өөр хоорондоо ялгаатай байна. Тодруулбал, нэхэмжлэгч С.Х нь хариуцагч Г.Э-г үндэслэлгүйгээр олж авсан гэх үндэслэлээр 30,078,605 төгрөгийг гаргуулахаар Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд хандсан бол Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хариуцагч О.Х-ээс цахим тоглоомыг худалдсан гэж 10,530,000 төгрөгийг гаргуулахаар тус тус ханджээ.

Харин Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх болон Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх нь талуудыг "даалгаврын

³⁷ Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024.06.25-ны өдрийн 183/ШШ2024/02812 дугаартай шийдвэр, https://shuukh.mn/single_case/144899?daterange=2017-01-01%20-%202024-12-03&id=1&court_cat=1&bb=1 (Сүүлд үзсэн: 2024.12.06)



гэрээ" байгуулсан гэж үзэн ИХ-ийн 399 дүгээр зүйлийн 399.1, 17 дугаар зүйлийн 17.1, 56 дугаар зүйлийн 56.1.1, 56.1.8, 492 дугаар зүйлийн 492.1 болон ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг үндэслэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн бол Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх нь талуудыг "худалдах, худалдан авах гэрээ" байгуулсан гэж үзэн ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.8, 56.5, 56.6 болон 243 дугаар зүйлийн 243.1-т заасан үндэслэлээр хариуцагч О.Х-аас 9,530,000 төгрөг гаргуулж нэхэмжлэгч Х.С-д олгож, нэхэмжлэлийн шаардлагаас 1,000,000 төгрөгт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

Иймд тус шүүхүүд нь талуудын байгуулсан гэрээний харилцааг өөр өөрөөр тодорхойлж, өөр хоорондоо ялгаатай байдлаар дүгнэн шийдвэрлэсэн байна.

ГУРАВ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Харьцуулсан судалгааны хүрээнд Америкийн Нэгдсэн Улс (АНУ) болон Япон Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ), Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ыг дараах үндэслэлээр сонгон, харьцуулан судаллаа.

Тодруулбал, Япон Улс нь "пабжи мобайл" тоглоомын зохицуулагч төвөөс "хавсралт" болгон гаргасан "тусгайлсан журам"-ыг хэрэглэдэг бол АНУ, БНХАУ болон ХБНГУ зэрэг нь тусгайлан хавсралт бус "нийтлэг журам"-ыг хэрэглэгч улсад хамаарч байна. Өөрөөр хэлбэл, тусгай журмыг тогтоосон улсуудыг сонгон судлах боломжтой байсан хэдий ч "пабжи мобайл"-тай холбоотойгоор гарсан хэрэг, маргаан, түүнийг хянан шийдвэрлэсэн шүүхийн практик хараахан гараагүй байгаа тул харьцуулсан судалгааны хүрээнд сонгон авч, цааш судлаагүй болно.

АНУ-ын хувьд насанд хүрээгүй этгээд эцэг эхийнхээ зөвшөөрөлгүйгээр цахим тоглоомд төлбөр төлсөнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр байсан бол Япон Улсын хувьд тухайлсан шүүхийн шийдвэр байхгүй боловч насанд хүрээгүй этгээд эцэг эхийнхээ зөвшөөрөлгүйгээр цахим тоглоомд төлбөр төлөх асуудал ихсэж байгаа тул хэрхэн шийдвэрлэж байгаа нөхцөл байдлыг тодруулах зорилгоор тус улсуудыг сонгосон болно.

Мөн БНХАУ нь цахим платформын хэрэглээ, цахим тоглоом, үүн дотроо цахим тоглоом доторх худалдан авалттай холбогдох зохицуулалтыг шинэ хууль, дүрэмдээ тусгасан байна. Ингэснээр насанд хүрээгүй хүүхэд эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр цахим тоглоом доторх худалдан авалт хийсэн тохиолдлуудыг шүүхээр шийдвэрлэх нөхцөл бүрджээ. Харин ХБНГУ-ын хувьд цахим тоглоомтой холбоотой харилцааг зохицуулсан байх төдийгүй In-App/In-Game худалдан авалтуудад ямар зохицуулалтыг хэрэглэж байгаа эсэхийг тодорхой тусгажээ. Дээрх үндэслэлүүдээр тус улсуудыг сонгон авч судаллаа.



3.1. АНУ

АНУ нь жишгийн эрх зүйн бүлд хамаардаг бөгөөд шүүхийн шийдвэр голлох эрх зүйн эх сурвалж болдог. Тиймээс судалгааны зүйлд холбогдох шүүхийн шийдвэрийг сонгон судаллаа.

Хүснэгт 3: Шүүхийн шийдвэр 1³⁸

Нэхэмжлэгч: Америкийн Нэгдсэн Улсын Холбооны Худалдааны Комисс

Хариуцагч: Амазон компани

Хэргийн үйл баримт: Америкийн Нэгдсэн Улсын Холбооны Худалдааны Комисс (FTC) 2014 оны 07 дугаар сард Амазон компанийн апп сторид насанд хүрээгүй этгээд эцэг эхийнхээ зөвшөөрөлгүйгээр цахим тоглоомд төлбөр төлсөн тохиолдолд тус компани төлбөрийг буцааж олгох ёстой гэж шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө тус комисс нь Apple болон Google компанитай уг асуудалтай холбоотойгоор буюу эцэг эхийнхээ зөвшөөрөлгүйгээр төлсөн төлбөрийг буцааж олгохоор тохиролцсон байна.

Шүүхийн дүгнэлт: Шүүхээс Амазон компани мэдээлэл өгөх үүргээ хангалттай гүйцэтгээгүй учраас насанд хүрээгүй этгээд зөвшөөрөлгүйгээр цахим тоглоомд төлбөр төлсөн тохиолдолд буцаан олгох нь зүйтэй гэж үзжээ. Амазон компани апп стори дотор тоглоом тоглох зарим тохиолдолд төлбөр авах боломжтой гэсэн мэдэгдэл харагддаг хэмээн тайлбар гаргасан. Гэхдээ шүүхэд хэрэг үүсгэхээс өмнө Амазон компани хэрэглэгч нараас үүнтэй холбоотой олон гомдол хүлээн авсан. Энэ нь тус компанийг мэдээлэл өгөх үүргээ хангалттай гүйцэтгээгүйг харуулж байна гэжээ.

Дээрх шийдвэрээс үзэхэд цахим тоглоомын төлбөрийн талаарх мэдээллийг хэрэглэгч нарт бүрэн мэдээлээгүй буюу компанийн мэдээлэл өгөх үүргээ зөрчсөн гэдэг нь төлбөрийг буцаан олгох үндэслэл болсон байна.

3.2. ЯПОН УЛС

Сүүлийн үед Япон Улсад эцэг эхийнхээ зөвшөөрөлгүйгээр насанд хүрээгүй этгээд цахим тоглоомд төлбөр төлөх тохиолдол ихэссэн. 2022 оны байдлаар тус улсын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төвд тус асуудлаар нийт 4024 удаа хандсан тохиолдол бүртгэгджээ³⁹.

³⁸ FEDERAL TRADE COMMISSION v. AMAZON.COM, C14-1038-JCC, (2022)
<https://www.ftc.gov/system/files/documents/cases/160427amazonorder.pdf>

³⁹ 独立行政法人国民生活センター「子どものオンラインゲーム 無断課金につながるあぶない場面に注意!!」(2023年)1頁~3頁。https://www.kokusen.go.jp/pdf/n-20240313_1.pdf



Хүснэгт 4: Япон Улсад үүссэн тохиолдол

ТОХИОЛДОЛ 1

Бага ангид сурдаг охин ээжийнхээ гар утсаар тоглоом тоглодог байсан. Гар утсанд кредит карт нь холбогдсон байсан бөгөөд охин нь кредит картын нууц кодыг солиод цахим тоглоомын төлбөрийг төлсөн. Ээж нь апп сторид хандан буцааж шилжүүлэхийг хүссэн боловч багахан хэмжээний мөнгийг л буцаан өгөхийг зөвшөөрчээ. Үлдсэн 90,000 гаруй иенийг эргүүлэн авах хүсэлтэй байна гэж Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төвд ханджээ.

ТОХИОЛДОЛ 2

Дунд ангийн хүүхэд нь 5 сарын хугацаанд 50,000 гаруй иен цахим тоглоомд ашигласан болохыг түүний асран хамгаалагч нь олж мэджээ. Асран хамгаалагч нь энэ талаар мэдээгүй байсан учраас цахим тоглоомын төлбөрийг буцааж авах хүсэлтэй байна гэж Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төвд ханджээ.

Үүнтэй холбоотойгоор Япон Улсын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төвөөс хэд хэдэн зөвлөмж гаргасан. Тухайлбал, Иргэний хуульд эцэг эхийнхээ зөвшөөрөлгүй насанд хүрээгүй этгээдийн хийсэн хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах боломжтой боловч хүүхэд эцэг эхийнхээ аккаунт хаягаар нэвтрэн төлбөр төлсөн тохиолдолд эцэг эх нь зөвшөөрсөн хэмээн үзэх боломжтой⁴⁰. Гэсэн хэдий ч одоогийн байдлаар Япон Улсад шүүхийн журмаар маргаан үүсээгүй байна.

3.3. БНХАУ

БНХАУ дахь насанд хүрээгүй хүүхдийн цахим тоглоомын хэрэглээ, эрх зүйн зохицуулалт

БНХАУ нь насанд хүрээгүй хүүхдүүдийн цахим тоглоомд донтох асуудлыг хянах, мөн янз бүрийн платформууд дээр хэт их мөнгөн төлбөрийн зарцуулалт хийхээс сэргийлэх зорилгоор 2023 онд "in-game" (цахим тоглоом доторх худалдан авалт), Пабжи Мобайл цахим тоглоомын тухайд "UC" буюу тус тоглоомын хувцас, эд зүйлсийн худалдаа (items shop) болон шагнал урамшуулалтай холбоотой шинэ дүрмүүдийг гаргажээ.

Эдгээр дүрмүүд нь цахим тоглоом доторх зардлыг хязгаарлахад чиглэгдсэн төдийгүй шагнал урамшууллын системийг хориглохын зэрэгцээ, тоглоом тоглогчдын цахим түрийвчдээ цэнэглэлт хийх дээд хэмжээг тогтоож өгсөн гэдгээрээ онцлог байна.

Уг шинэ дүрмүүдэд насанд хүрээгүй тоглогчдод цахим тоглоом дахь сугалааны тохируулга болон цахим тоглоом дахь хувцас, эд зүйлсийн худалдаа, дуудлага худалдаа хийхийг хориглох заалтыг оруулжээ⁴¹. Дээрх дүрмүүдээс

⁴⁰ 国民生活センター「子どものオンラインゲーム 無断課金につながるあぶない場面に注意！！」（2023年）https://www.kokusen.go.jp/news/data/n-20240313_1.html

⁴¹ Reuters, China announces rules to reduce spending on video games, 2023, <https://www.reuters.com/world/china/china-issues-draft-rules-online-game-management-2023-12-22/> (Сүүлд үзсэн: 2024.12.01).



гадна "Хүүхэд хамгааллын тухай хууль"-аар насанд хүрээгүй хүүхдийн цахим тоглоомын хэрэглээтэй холбогдох дараах хэд хэдэн зохицуулалтыг нэмэлтээр тусгасан байна. Үүнд:

- насанд хүрээгүй хүүхдийн цахим тоглоом тоглох цагийг хязгаарлах,
- хэт их мөнгө зарцуулалтыг хянах чиглэлээр эрчимтэй арга хэмжээ авч байгаа бөгөөд энэ нь хүүхдүүдийг цахим тоглоом тоглохоос үүдсэн эрсдэлүүдээс хамгаалахад чиглэж байна. (Процессын шатандаа явж байна)
- 2021 онд Бээжинд хүүхдүүдийн тоглоом тоглоход зарцуулах цагийг хязгаарласан бөгөөд 18 нас хүрээгүй хүүхдэд чиглэсэн шинэ тоглоомд зөвшөөрөл олгох асуудлыг тодорхой сараар зогсоосон⁴².

БНХАУ-д насанд хүрээгүй этгээд эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр цахим тоглоомд мөнгөн төлбөрийн зарцуулалт хийсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэсэн тухай шүүхийн практик

Энэхүү хэсэгт танилцуулах шийдвэр нь цахим платформууд дээр насанд хүрээгүй хүүхдүүд эцэг эхийн зөвшөөрөлгүй хийсэн мөнгөн төлбөрийн зарцуулалтыг хянахад чиглэсэн байна. Тодруулбал, доорх шийдвэр нь БНХАУ-ын тоглоомын зах зээлд томоохон өөрчлөлтүүдийг авчрах бөгөөд насанд хүрээгүй хүүхдүүдийн хэрэглэгчийн эрх болоод тоглоомын зохион бүтээгч компанийн хариуцлага зэргийг илүү тодорхой болгоход ач холбогдолтой болсон гэж үзжээ.

Хүснэгт 5: БНХАУ-ын дээд шүүхээс маргааныг шийдвэрлэсэн байдал⁴³

БНХАУ-ын дээд шүүх нь насанд хүрээгүй хүүхдүүдийн тоглоом болон тоглоомын шууд дамжуулалтын платформууд дээр зарцуулсан мөнгийг буцаан олгохыг дэмжсэн бөгөөд энэхүү шийдвэр нь хүүхдүүдийн хэт их мөнгөн төлбөрийн зарцуулалттай холбоотой маргааныг шийдвэрлэхэд туслах зорилготой гарсан байна.

Мөн тус шийдвэр нь насанд хүрээгүй хүүхдүүдийн цахим ертөнцөд хэт их мөнгө зарцуулах явдлыг хязгаарлах зорилгоор төрийн байгууллагуудаас гаргасан хэд хэдэн шинэ хууль, дүрэм, зааварчилгаанд үндэслэн гарсан шийдвэр болно.

Дээрх хууль, дүрмүүд, зааварчилгаа нь насанд хүрээгүй хүүхдүүдийн цахим орчинд зарцуулж буй мөнгийг хянах, мөн эцэг эхийн зөвшөөрөлгүй хийсэн худалдан авалтыг бууруулахад чиглэсэн⁴⁴ бөгөөд БНХАУ-ын дээд шүүхийн тус шийдвэр нь эдгээр хууль, дүрмүүдийн хэрэгжилтийг дэмжих алхам болсныг энд цохон тэмдэглэх нь зүйтэй.

⁴² South China Morning Post, China's highest court supports refund for kids' excessive spending on games, live-streaming apps, 2020, https://www.scmp.com/tech/apps-social/article/3085308/chinas-highest-court-supports-refund-kids-excessive-spending-games?module=perpetual_scroll_0&pgtype=article (Сүүлд үзсэн: 2024.12.01).

⁴³ Мөн тэнд.

⁴⁴ Энэхүү БНХАУ-ын дээд шүүхийн тогтоолын эх хувь хаалттай буюу олдоогүй болно.



3.4. ХБНГУ

ХБНГУ дахь насанд хүрээгүй хүүхдийн цахим тоглоомын хэрэглээ, эрх зүйн зохицуулалт

Цахим тоглоом дотроос ямарваа нэг зүйлийг худалдаж авч байвал үүнийг "In-App худалдан авалт" эсхүл "in-Game худалдан авалт" гэж нэрлэдэг. "In-Game худалдан авалт" гэдэгт тоглоомын явцад хийгдсэн бүх худалдан авалтыг ойлгох бөгөөд энэ нь "Пабжи мобайл" тоглоомын хувьд "UC" болно⁴⁵.

ХБНГУ-ын шүүх нь "Хүүхэд хамгааллын тухай хууль" (Jugendschutzgesetz)-ийн дагуу насанд хүрээгүй хүүхдийн цахим худалдан авалтыг хянах шаардлагатай гэж үзсэн байдаг. Уг хууль нь хүүхэд, залуучуудын нийгмийн орчин, цахим хэрэглээг зохицуулдаг ба цахим хэрэглээтэй холбогдох заалтуудаас дурдвал:

Хүснэгт 6: ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалт

§28 Abs. 19. "§ 13 Abs. 1-д заасан нөхцөлд хүүхдэд эсхүл өсвөр насны хүүхдийг дэлгэцийн тоглоомын төхөөрөмж дээр тоглохыг зөвшөөрөх" талаар зохицуулсан байна⁴⁶.

§13 Abs. 1. "Ашиг олох боломжгүй, олон нийтэд байршуулсан электрон дэлгэцийн тоглоомын төхөөрөмжүүд дээр тоглох нь хүүхдүүд болон өсвөр насныханд зөвхөн асран хамгаалагч эсхүл хүмүүжүүлэх эрхтэй хүнтэй хамт байх нөхцөлд л зөвшөөрөгдөх бөгөөд хэрэв программ нь орон нутгийн хамгийн дээд байгууллага эсхүл сайн дурын хяналтын байгууллагуудаас § 14 Abs. 6-д заасан⁴⁷ насны ангилалд нь тохирсон гэж баталсан болон тэмдэглэсэн бол, мөн энэ нь "Мэдээллийн хөтөлбөр" эсвэл "Сургалтын хөтөлбөр" гэж тэмдэглэгдсэн мэдээлэл, зааварчилгаа эсхүл сургалтын зорилготой тохиолдолд зөвшөөрөгдөнө" гэжээ⁴⁸

7 хүртэлх насны хүүхдүүд нь эрх зүйн бүрэн чадамжгүй байдаг учир тэд ямар ч гэрээ, жишээлбэл in-Game, In-App худалдан авалтууд хийх боломжгүй. Харин 7-оос 18 нас хүртэлх хүүхдүүд нь хязгаарлагдмал эрх зүйн чадамжтай байдаг хэдий ч байгуулсан гэрээ нь хүчин төгөлдөр болохын тулд эцэг эхийн зөвшөөрлийг зайлшгүй шаарддаг. Учир нь тус байгуулсан гэрээнээс дараа нь татгалзаж болно гэсэн үг юм⁴⁹.

Үүнээс гадна Иргэний хууль (BGB)-ийн § 110-т зааснаар хүүхдүүд болон өсвөр насны хүүхдүүд нь эцэг эхийн зөвшөөрөлтэйгөөр өөрсдийн хэрэглээний мөнгөө чөлөөтэй зарцуулах эрхтэй⁵⁰. Тухайлбал, хүүхдүүд тоглоом эсхүл чихэр гэх мэт өдөр тутамдаа ашиглах боломжтой биет зүйл худалдаж авах боломжтой. Харин In-App/In-Game худалдан авалтуудад энэхүү заалт хамаарахгүй буюу эдгээр нь

⁴⁵ Verbraucherzentrale: "In-Game" und "In-App" Käufe: Wenn virtueller Spielspass teuer wird, 2024, [In-Game- und In-App-Käufe: Wenn virtueller Spielspaß teuer wird | Verbraucherzentrale.de](#) (abgerufen am 02.12.2024).

⁴⁶ § 28 Absatz 19 JuSchG

⁴⁷ 0-5, 6-11, 12-15, 16-18 гэх насны ангилал хамаарна.

⁴⁸ § 13 Abs. 1 JuSchG

⁴⁹ Bayerisches Staatsministerium, "In-Game" und "In-App" Käufe: Kostenfallen bei Online Spielen, 2023, [In-App- und In-Game-Käufe: Kostenfallen bei Online-Spielen | Verbraucherportal Bayern](#) (abgerufen am 02.12.2024).

⁵⁰ § 110 Abs. BGB



мөнгөний зорилгоос гадуур хэмээн үзэж байна⁵¹.

ХБНГУ-д насанд хүрээгүй этгээд эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр цахим тоглоомд мөнгөн төлбөрийн зарцуулалт хийсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэдэг тухай шүүхийн практик

Тоглоомын компаниудын хувьд хэрэглэгчийн насны хязгаарлалт болон эцэг эхийн зөвшөөрлийг хянаж чадаагүй тохиолдолд хариуцлагын асуудал үүсэж болдог байна.

Хэрэв эцэг эх нь гэрээ байгуулахад зөвшөөрөл өгч байгаагүй эсхүл дараа нь зөвшөөрөл өгөөгүй бол энэ гэрээ хүчин төгөлдөр байгуулагдаагүй гэж үзнэ. Энэ тохиолдолд төлбөр хүлээн авсан тал (эцсийн гүйлгээ/төлбөр хийгдсэн данс) нь тухайн хүүхдийн эцэг эхэд эсхүл хүүхдэд (төлбөр ямар аккаунтаар хийгдсэнээс хамааран) төлбөрийг буцаан төлөх үүрэгтэй болдог байна.

Нөгөөтээгүүр, практик дээр төлбөрийн зарим төрлүүдийн (жишээ нь, кредит карт) хувьд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчтэй (жишээ нь, банк) холбоо барьж, мөнгөний буцаан олголтын нөхцөлүүдийг асуух нь ашигтай байж болно⁵².

Дээрхээс дүгнэн үзэхэд, тоглоомын компаниуд нь насанд хүрээгүй хүүхдүүдийн худалдан авалтыг хянах үүрэгтэй, мөн эцэг эхчүүд нь өөрсдийн хүүхдийг хянах үүрэгтэй байна. Мөн насанд хүрээгүй хүүхэд эцэг эхийн зөвшөөрөлгүй цахим тоглоомын худалдан авалт хийсэн тохиолдолд хариуцлагыг хэн хүлээх вэ гэдэг нь тухайн улс орон, хууль эрх зүйн орчны хамаарлаар өөр өөр байж болох боловч ХБНГУ-ын хувьд авч үзвэл дараах этгээдүүдэд хариуцлага тооцогдох боломжтой байна. Үүнд:

- 1. Тоглоомын компани:** Насанд хүрээгүй хэрэглэгчдийг эцэг эхийн зөвшөөрөлгүй худалдан авалт хийлгэсэн тохиолдолд тухайн тоглоомыг зохион бүтээсэн, хариуцаж байгаа компанид хариуцлага тооцох боломжтой. Ингэхийн тулд тус тоглоомын компанид хүсэлт өгч шалгуулах боломжтой байна.
- 2. Эцэг эх, асран хамгаалагчид:** Хүүхэд цахим тоглоомын худалдан авалтыг эцэг эхийнхээ зөвшөөрөлгүй хийсэн тохиолдолд эцэг эх нь хариуцлага хүлээх ёсгүй боловч, хүүхдийн хариуцлагагүй байдлаас урьдчилан сэргийлэх үүднээс эцэг эх нь тодорхой хяналт тавих үүрэгтэй учир хариуцлага хүлээж болохоор байна.
- 3. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эсхүл хуулийн байгууллагууд (ХБНГУ-д *Jugendschutz.net* байгууллага):** Хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагууд хууль зүйн зөвлөгөө өгч, хариуцлага тооцох шаардлагатай нөхцөл байдалд туслалцаа үзүүлэх боломжтой байна. (Тухайн тоглоомын компанитай холбогдох зэрэг байдлаар)

⁵¹ Anwalt.de, In Game kauf durch ein Kind wann dürfen Eltern das Geld zurückfordern? 2019, [In-Game-Kauf durch ein Kind – wann dürfen Eltern das Geld zurückfordern?](#) (abgerufen am 02.12.2024).

⁵² Bayerisches Staatsministerium, "In-Game" und "In-App" Käufe: Kostenfallen bei Online Spielen, 2023, [In-App- und In-Game-Käufe: Kostenfallen bei Online-Spielen | Verbraucherportal Bayern](#) (abgerufen am 02.12.2024).



Дээрх улсуудаас гадна БНЭУ-ын тухайд авч үзвэл, бусад улсуудын адилаар ийм төрлийн маргааныг шүүхээр шийдвэрлэж буй практик байхгүй боловч эцэг эх нь хүүхдээ шийтгэж арга хэмжээ авсан дараах хоёр тохиолдол байна.

Хүснэгт 7: БНЭУ-д үүссэн тохиолдол

Тохиолдол 1: Эцэг эх нь хүүхдэдээ "өөрсдөө хариуцлага тооцсон" тохиолдол

Нэг хүүхэд Пабжи мобайл тоглоомд донтсоны улмаас эцэг эхийнхээ данснаас 16 лак рупиг алдсан тохиолдол гарсан байх бөгөөд тэрээр эцэг эхдээ сэжиг төрүүлэхгүйн тулд утсан дээрх банкны гүйлгээний зурвасуудыг нь устган, нууцаар тоглодог байжээ. Хүү эцэг эхийнхээ мөнгийг Пабжи мобайл тоглоомд нэг сарын дотор буу зэвсэг, тэмцээний тасалбар, сум зэргийг худалдан авахад зарцуулсан байна. Эцэг эх нь үүнд хяналт тавьж, мэдэх боломжтой байсан эсэх талаар тодруулахад "хүү аавынхаа гар утсыг цахим хичээл хийх зорилгоор ашиглана гэж хэлээд авдаг байсан боловч үнэндээ хэтэрхий их Пабжи мобайл тоглоом тоглодог байсан" гэжээ. Тус хэрэг явдлын дараа хүүгийн аав түүнд мөнгөний үнэ цэнийг ойлгуулахын тулд түүнийг скутер засварын газарт ажиллуулах шийдвэрийг гаргасан байна⁵³.

Тохиолдол 2: 15 настай хүүхэд өвөөгийнхөө тэтгэврийн дансаар Пабжи мобайл тоглоом дотор худалдан авалт хийсэн тохиолдол

15 настай хүүхэд өвөөгийнхөө тэтгэврийн данснаас түүний зөвшөөрөлгүйгээр Пабжи мобайл тоглоомд 2 лак рупигийн зарцуулалт хийсэн тохиолдол гарсан байна. Хүү өвөөгийнхөө тэтгэврийн дансыг ашиглан тоглоом доторх эд зүйлсийг худалдан авч, их хэмжээний мөнгө зарцуулсан нь тогтоогджээ⁵⁴.

Дээрх тохиолдлуудаас үзвэл, Пабжи мобайл тоглоомын апп доторх худалдан авалт, тухайлбал Unknown Cash (UC) зэргээр дамжуулан тухайн компани томоохон орлого олж байна. Гэвч энэ тоглоом өсвөр насныханд сөрөг нөлөө үзүүлж, ихэнхдээ гэр бүлийнхэн нь мөн давхар хохироод үлдэж буй тохиолдлууд газар авчээ. Зарим нь амиа хорлох хүртэл нөхцөл байдалд хүрсэн гэх судалгаа гарсан тул Пакистан улсад албан ёсоор хориглодог болсон байна.

Нөгөөтээгүүр, эцэг эх, асран хамгаалагчдын хувьд хүүхдүүдийн цахим орчинд үйлдэж буй үйлдлийг хянах, мөн бичиг баримт, цахим төлбөрийн системүүдэд хандах эрхийг хязгаарлах нь одоо үед чухал ач холбогдолтой гэдгийг эдгээр тохиолдол тодорхой харуулж байна. Аливаа улсын нийгмийн бодлогоор мөн эцэг эхчүүд мөнгөнд хандах хандлага, мөнгөний үнэ цэнийг хүүхдэд ойлгуулах шаардлагатай болсон байгааг энд дурдах нь зүйтэй юм.

Нэгтгэн дүгнэхэд, эцэг эхчүүд нь хүүхдийнхээ үйлдлийг хянахгүй байснаар өөрсдөдөө болон бусад хүмүүст ийм төрлийн том хохирол учрахад хүргэж буй нийтлэг жишиг ажиглагдлаа.

⁵³ Shubham Verma, PUBG player in Punjab reportedly lost Rs 16 lakh from parents' bank accounts, made to work at scooter repair shop, 2020, <https://www.indiatoday.in/technology/news/story/PubG-player-in-punjab-reportedly-lost-rs-16-lakh-from-parents-bank-accounts-made-to-work-at-scooter-repair-shop-1696748-2020-07-03> (Сүүлд үзсэн: 2024.12.03).

⁵⁴ Monit Khanna, 15 year old spent Rs 2 Lack On PubG, Stole it from grandpa's pencion account 2020, 15-Year-Old Spent Rs 2 Lakh On PUBG, Stole It From Grandpa's Pension Account (Сүүлд үзсэн: 2024.12.04).



ДҮГНЭЛТ

Өнөө үед гар утас гэлтгүй цахимаар тоглох боломжтой хөдөлгөөнт тоглоомууд нь техник технологийн дэвшил, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжсөөр байгаа бөгөөд энэ нь зөвхөн цаг нөхцөөх тоглоомд тооцогдох бус үндэсний хэмжээнд яригдах, мөн эдийн засаг, санхүүгийн байдлыг сайжруулах боломжийг олгодог асар том платформ болон өргөжин тэлсээр байна. Тэр дундаа "Пабжи мобайл" гэх цахим тоглоом нь дэлхий дахинд олныг хамраад нэлээдгүй хугацаа өнгөрч байгаа бөгөөд үүнтэй холбоотой хэрэг, маргаан цөөнгүй гарсаар ийнхүү олон улсын түвшинд хэрхэн шийдвэрлэх асуудал нь шүүх байгууллага болон эрх зүйч, хуульчдын анхаарлыг татаж байна.

Энэ хүрээнд уг тоглоомыг тоглохын тулд мөнгө, эд хөрөнгөө бусдад шилжүүлж хохирсон иргэдийн хохирлыг хэрхэн барагдуулж байгааг тогтоох зорилготойгоор "Пабжи мобайл" тоглоомын гарал үүсэл, холбогдох байгууллага, зохицуулах дүрэм журам, түүнтэй холбоотой гарсан хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн практикийг харьцуулсан судалгааны хүрээнд судлан дараах дүгнэлтийг боловсрууллаа.

Монгол Улсын хувьд "Пабжи мобайл" цахим тоглоом нь хүүхэд, залуучуудын дунд нэлээдгүй цар хүрээг хамарсан хэдий ч хууль, эрх зүйн хүрээнд хараахан албажуулан зохицуулагдаагүй байна. Хэдий тийм боловч сүүлийн жилүүдэд эрүүгийн болон иргэний хэргийн шүүхэд энэхүү тоглоомтой холбоотойгоор хэд хэдэн хэрэг, маргаан гарсан нь хууль, эрх зүйн хүрээнд уг асуудлыг цаашид анхааралдаа авах шаардлага зүй ёсоор үүсэж байгааг харуулж байна. Судалгааны үр дүнгээс тус тоглоомын гарал үүсэл, бусад улсын эрх зүйн хүрээ хязгаар, шүүхийн практикийн жишгийг авч үзвэл:

"Пабжи мобайл" тоглоом нь 1973 онд АНУ-ын зөөврийн гар утасны "Дуна Тас" гэх компаниас үүдэлтэй бөгөөд 2017 оноос эхлэн олон нийтэд хүрч эхэлсэн бол 2018 онд албан ёсоор нээлтээ хийжээ. "PubG mobile" тоглоомыг хөгжүүлэгч компани нь "Крафтон" (Krafton) гэх нэртэй ба БНСУ-ын Ганнам дүүрэгт байрлалтай байна.

БНСУ-д тус тоглоомыг "Какао" нэртэй серверээр дамжуулдаг бөгөөд Какао сервер ашигладаг компьютерыг 15-аас доош насны хэрэглэгчид ашиглахыг хориглодог бол орон даяар ашиглагдаж буй сервер болох Xbox One, PlayStation-ийг насанд хүрээгүй хүүхэд ашиглах боломжгүйгээр бүтээсэн онцлогтой юм. Өөрөөр хэлбэл, "Пабжи мобайл" тоглоомыг тоглож буй этгээд буюу хэрэглэгчтэй тухайн тоглоомын эзэмшигч байгууллагын зүгээс байгуулах хэд хэдэн зөвшилцөл, дүрэм, журам байдаг.

Уг дүрэм, журмын хүрээнд талууд харилцан зөвшилцөж, тоглоомыг цааш үргэлжлүүлэх эсэхээ шийддэг байна. Пабжи мобайл тоглоомын хэрэглэгч буюу тоглогч нь тоглоом доторх өөрийн дүрийг хөгжүүлэхдээ тодорхой виртуал хэрэгсэл буюу барааг /virtual goods/ зөвхөн уг тоглоомд ашиглах боломжтой төлбөрийн хэрэгсэл болох UC /unknown cash/-р авдаг ба ийнхүү буцаалт хийх эрхийг гэрээгээр хориглох боломжгүй байхаар хуульчилснаас бусад тохиолдолд тухайн виртуал барааг буцаах эрхээсээ татгалзаж байгаа хэмээн үздэг онцлог



зохицуулалтыг оруулж өгчээ.

Мөн "Пабжи мобайл" тоглоом нь олон улсад түгэн дэлгэрснээр тухайн тоглоомыг зохицуулагч төв байгууллага нь зарим улсуудын тоглогч нарт үйлчлэх тусгайлсан журмыг гаргажээ. Тухайлбал, БНСУ-ын тоглогч нарт үйлчлэх дүрэм, журмыг албан ёсны "Krafton" гэх сайт дээрээ "Хавсралт №3" файл болгон оруулсан бөгөөд бусад улсын журмыг үзвэл нийтлэг байдлаар төлсөн төлөлтийг буцаах боломжийг хязгаарласан зохицуулалт оруулсан байна.

Бусад улсын шүүхийн практикийн харьцуулсан судалгааны хүрээнд АНУ, Япон Улс, БНХАУ, ХБНГУ болон БНЭУ-ыг сонгон судалсан бөгөөд тухайн улсуудын ач холбогдолтой гэсэн шүүхийн дүгнэлтүүдийг авч үзвэл: АНУ-д "насанд хүрээгүй хүүхэд асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр цахим тоглоомд төлсөнтэй холбоотойгоор Амазон компанид нэлээдгүй гомдол ирсээр байгаа учир тус компанийг мэдээлэл өгөх үүргээ хангалттай биелүүлээгүй гэх үндэслэлээр төлбөрийг нэхэмжлэгчид буцаан олгосон" шүүхийн шийдвэр гарчээ.

Харин БНХАУ-д цахим тоглоомтой холбоотой зардлыг хязгаарлахад чиглэсэн шинэ дүрмийг гаргасан ба цахим тоглоомын аливаа шагнал урамшууллын системийг хориглохын зэрэгцээ, тоглоом тоглогчдын цахим түрийвчдээ цэнэглэлт хийх дээд хэмжээг тогтоосон бөгөөд насанд хүрээгүй тоглогчдыг нэмэлтээр худалдан авалт хийхийг хориглох заалтыг оруулж өгсөн онцлогтой байна. Тийм боловч БНХАУ-ын Дээд шүүх нь насанд хүрээгүй хүүхдүүдийн хэрэглээг хянахгүй байх нь олон тооны маргаан үүсгэж, эцэг, эхийнхээ зөвшөөрөлгүйгээр их хэмжээний зардал гаргах үйлдлийг хийж буй нь сөрөг үр дагаврыг бий болгож байгаа тул насанд хүрээгүй хүүхдүүдийн тоглоом болон тоглоомын шууд дамжуулалтын платформууд дээр зарцуулсан мөнгийг буцаан олгохыг дэмжсэн шийдвэрийг гаргасан байна.

Мөн ХБНГУ-д насны онцлогоос хамааран 18 наснаас доош насны хүүхдүүд нь цахим тоглоомтой холбоотой аливаа худалдан авалт хийхэд заавал эцэг эхийн зөвшөөрлийг авсан байх шаардлагатай бөгөөд зөвшөөрөл аваагүй худалдан авсан тохиолдолд тухайн гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэж, төлбөрийг хүлээн авсан компани төлбөрийг нэхэмжлэгчид буцааж өгөх үүргийг хүлээлгэдэг бол БНЭУ-д эцэг, эх нь насанд хүрээгүй хүүхдүүддээ өөрсдөө хариуцлага тооцох байдлаар асуудлыг шийдвэрлэсэн тохиолдол цөөнгүй байна.

Иймд, харьцуулан судалсан улсуудаас зөвхөн Япон Улс нь "пабжи мобайл" тоглоомын зохицуулагч төвөөс "Хавсралт" болгон гаргасан "тусгайлсан журам"-ыг хэрэглэдэг бол АНУ, БНХАУ болон ХБНГУ-ууд нь тусгайлан хавсралтаар гаргасан бус "нийтлэг журам"-ыг хэрэглэгч улсуудад хамаарч байх бөгөөд уг нийтлэг журмыг баримтлан талуудын байгуулсан гэрээнд үндэслэн дотоодын эрх зүйн зохицуулалтыг хэрэглэж, хэргийг хянан шийдвэрлэдэг байна.

Хэдийгээр "пабжи мобайл" тоглоомын зохицуулагч төвөөс Япон Улсын хэрэглэгчдэд зориулсан тусгай журмыг тогтоож өгсөн боловч өнөөг хүртэл шүүхийн практикт нь жишиг бүхий шүүхийн шийдвэр хараахан гараагүй байна.



НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж

A. Эрх зүйн эх сурвалж

1. Эрүүгийн хууль (2017 он)
2. Эрүүгийн хууль (2002 он)
3. Иргэний хууль (2002 он)
4. Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, "Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан "бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах" гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар", 2006, №51
5. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 2023/ШЦТ/110 дугаар шийтгэх тогтоол
6. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 2021/ШЦТ/814 дугаар шийтгэх тогтоол
7. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 2022/ШЦТ/643 дугаар шийтгэх тогтоол

B. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Ц.Гантулгабат, "Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т заасан "залилах" гэмт хэргийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэхэд анхаарах асуудал
2. Нээлттэй нийгэм форум, Шүүхийн шийдвэрийн судалгаа, цуврал 2, "Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ" 2021

C. Бусад

"УИХ-ын тамгын газар, УИХ-ын намрын ээлжит чуулганы хуралдааны тэмдэглэл", 2023.12.14, <https://www.parliament.mn/nn/1102/>

2. Гадаад хэл дээрх эх сурвалж

A. Англи хэлээр

FEDERAL TRADE COMMISSION v. AMAZON.COM, C14-1038-JCC, (2022) <https://www.ftc.gov/system/files/documents/cases/160427amazonorder.pdf>

B. Солонгос хэлээр

최근 게임 정보 전달러 : 모바일 게임의 진화: 휴대기기 속 게임 산업의 미래

C. Япон хэлээр

国民生活センター「子どものオンラインゲーム 無断課金につながるあぶない場面に注意！！」(2023年) https://www.kokusen.go.jp/news/data/n-20240313_1.html

D. Герман хэлээр

1. ХБНГУ-ын Иргэний хууль 1896 он (Bürgerliches Gesetzbuch)
2. ХБНГУ-ын Хүүхэд хамгааллын тухай хууль, 2002 он (Jugendschutzgesetz)



3. Цахим эх сурвалж

1. Пабжи мобайл тоглоомын албан ёсны цахим хуудас: <https://www.PubGmobile.com>
2. Цахим тоглоомын төлбөр төлөлтийн хэрэгслийн платформын албан ёсны цахим хуудас: <https://www.midasbuy.com/midasbuy/mn>
3. АНУ-ын анхны гар утас гаргасан компани цахим сан: <https://www.mobilephonemuseum.com/about>
4. Крафтон (Krafton) <https://krafton.com/en/>
5. Tencent: <https://www.tencent.com/en-us/>
6. Dorgio information guide: <https://dorgio.mn/index.php/p/98033>
7. Battle Pass: <https://www.fortnite.com/?lang=en-US>
8. Reuters, China announces rules to reduce spending on video games, 2023, <https://www.reuters.com/world/china/china-issues-draft-rules-online-game-management-2023-12-22/>
9. South China Morning Post, China's highest court supports refund for kids' excessive spending on games, live-streaming apps, 2020, https://www.scmp.com/tech/apps-social/article/3085308/chinas-highest-court-supports-refund-kids-excessive-spending-games?module=perpetual_scroll_0&pgtype=article
10. Verbraucherzentrale: "In-Game" und "In-App" Käufe: Wenn virtueller Spielspass teuer wird, 2024, In-Game- und In-App-Käufe: Wenn virtueller Spielspaß teuer wird | Verbraucherzentrale.de
11. Bayerisches Staatministerium, "In-Game" und "In-App" Käufe: Kostenfallen bei Online Spielen, 2023, In-App- und In-Game-Käufe: Kostenfallen bei Online-Spielen | Verbraucherportal Bayern (abgerufen am 02.12.2024).
12. Anwalt.de, In Game kauf durch eiin Kind wann dürfen Eltern das Geld zuruckfordern? 2019, In-Game-Kauf durch ein Kind – wann dürfen Eltern das Geld zurückfordern?
13. Jugend Schutz: Uber uns, 2024, Startseite | jugendschutz.net
14. Shubham Verma, PUBG player in Punjab reportedly lost Rs 16 lakh from parents' bank accounts, made to work at scooter repair shop, 2020, <https://www.indiatoday.in/technology/news/story/PubG-player-in-punjab-reportedly-lost-rs-16-lakh-from-parents-bank-accounts-made-to-work-at-scooter-repair-shop-1696748-2020-07-03>
15. Monit Khanna, 15 year old spent Rs 2 Lack On PubG, Stole it from grandpa's pencion account 2020, 15-Year-Old Spent Rs 2 Lakh On PUBG, Stole It From Grandpa's Pension Account

BNPL (ОДОО АВААД ДАРАА ТӨЛ) ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОЛОН УЛС ДАХЬ ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ СУДАЛГАА

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ДЭРГЭДЭХ
ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ¹

¹ Энэхүү судалгааг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн Шүүхийн судалгааны төвийн дарга, хууль зүйн доктор Б.Дөлгөөн (Ph.D) удирдаж, Захиргааны эрх зүйн секторын эрхлэгч Н.Хулан (LL.M), судлаач О.Тэнхлүүн, Б.Мөнгөншагай, Р.Ануурад, М.Ананд, П.Чинунар болон Үндсэн хууль, олон улсын эрх зүйн секторын судлаач С.Жансая нар хийж гүйцэтгэлээ.



ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	194
УДИРТГАЛ	195
ҮНДСЭН ХЭСЭГ.....	196
НЭГ. "ОДОО АВААД, ДАРАА ТӨЛ" ҮЙЛЧИЛГЭЭГ ОЛОН УЛСАД ХЭРХЭН ТАЙЛБАРЛАЖ, ЗОХИЦУУЛЖ БУЙ ТАЛААР	196
1.1. "Одоо аваад, дараа төл" үйлчилгээний олон улс дахь зохицуулалт	196
1.2. BNPL үйлчилгээг факторингийн үйлчилгээнээс ялгах онцлогууд.....	199
ХОЁР. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БҮРЭН ЭРХ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ ..	201
2.1. Хуулийн зохицуулалтгүй санхүүгийн үйлчилгээг зохицуулах хууль тогтоогчийн эрх, үүрэг	201
2.2. Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагчийн бүрэн эрхэд холбогдох эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ	202
ГУРАВ. ИРГЭНИЙ ХУУЛИЙН 123 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН "ШААРДАХ ЭРХЭЭ ШИЛЖҮҮЛЭХ" ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЛЭЭ	205
3.1. Шүүхийн практик	205
3.2. Монгол Улсын дээд шүүхийн тайлбар	209
3.3. Иргэний хуулийн шинжлэх ухааны тайлбар.....	209
ДҮГНЭЛТ.....	212
НОМ ЗҮЙ.....	214



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Шүүхийн академи	Шүүхийн сургалт судалдаа, мэдээллийн академи
УДШ	Улсын дээд шүүх
ВNPL	Одоо аваад дараа төл
ИБУИНХУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
СЗХЭЗБТХ	Санхүүгийн Зохицуулах Хорооны эрх зүйн байдлын тухай хууль
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан



УДИРТГАЛ

Судалгааны зорилго:

Энэхүү судалгаагаар факторингийн үйлчилгээний эрх зүйн зохицуулалт, Монгол улс дахь хэрэглээг тогтоох, BNPL буюу "одоо аваад, дараа төл" үйлчилгээг Монгол Улсын хуулиар зохицуулж байгаа эсэх, мөн BNPL нь факторингийн үйлчилгээний төрөлд хамаарах, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх санхүүгийн үйл ажиллагаа мөн эсэхийг судлахад оршино.

Судалгааны хамрах хүрээ:

Судалгааны хүрээнд факторингийн үйлчилгээ болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (хуучнаар Банк бус санхүүгийн үйлчилгээний тухай хууль), Зөвшөөрлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны эрх зүйн байдлын тухай хууль хамаарна.

Судалгааны арга зүй:

Судалгааг гүйцэтгэхэд эрх зүйн социологийн судалгааны аргууд болох задлан шинжилж, нэгтгэн дүгнэх (анализ, синтез) арга зүйг ашиглав.

Судалгааны бүтэц:

Энэхүү судалгаа нь удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт гэсэн хэсгээс бүрдэнэ.


ҮНДСЭН ХЭСЭГ

НЭГ. "ОДОО АВААД, ДАРАА ТӨЛ" ҮЙЛЧИЛГЭЭГ ОЛОН УЛСАД ХЭРХЭН ТАЙЛБАРЛАЖ, ЗОХИЦУУЛЖ БУЙ ТАЛААР

1.1. "Одоо аваад, дараа төл" үйлчилгээний олон улс дахь зохицуулалт

Одоо аваад, дараа төлөх (By now, pay later "BNPL") нөхцөлтэй үйлчилгээ нь хэрэглэгчдэд төлбөрөө хүүгүйгээр хэсэгчлэн хувааж төлөх боломжийг олгодог бөгөөд сүүлийн жилүүдэд олон улсад төдийгүй, Монгол Улсад түгээмэл ашиглагдаж буй санхүүгийн үйлчилгээний нэг төрөл юм. Энэхүү үйлчилгээний талаар олон улсад тогтсон тодорхойлолт байхгүй боловч АНУ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах товчоо (англ. *The Consumer Financial Protection Bureau*)-ноос гаргасан тайланд¹ "BNPL нь "дөрөв хувааж төлөх," эсхүл "хувааж төлөх" үйлчилгээ: дөрөв хувааж төлөхөд ихэвчлэн төлбөрийн 25 хувийг урьдчилгаанд төлж, үлдсэн 3 төлөлтийг хүүгүйгээр 2 долоо хоногийн зайтай төлөх юм" хэмээн тайлбарлажээ. Тус тайлбараас BNPL үйлчилгээний үндсэн зарчмыг харж болохоор байна. Тодруулбал, нэг талаас худалдагч, нөгөө талаас худалдан авагч болон BNPL үйлчилгээ үзүүлэгч байгууллага оролцож, худалдан авагч эхний төлбөрөө хийхдээ BNPL үйлчилгээнээс үлдсэн төлбөрийн хувиараа сонгон (1), BNPL үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас хүсэлтийг хүлээн авч нийт төлбөрийг худалдагч талд шилжүүлнэ (2). Ингэснээрээ BNPL үйлчилгээ үзүүлэгч худалдан авагчийн зээлийн эрсдэлийг бүрэн хариуцдаг².

График 1. BNPL үйлчилгээний төлбөрийн схем:



¹ Consumer Financial Protection Bureau, "Buy Now, Pay Later: Market trends and consumer impacts," 2022, p.6.

² Giulio Cornelli, Leonardo Gambacorta and Livia Pancotto, "Buy now, pay later: a cross-country analysis," BIS Quarterly Review, 2023, p.62., https://www.bis.org/publ/qtrpdf/r_qt2312e.pdf, (Сүүлд үзсэн: 2024.01.09).



Олон улсын жишигт худалдан авагч эдгээр төлбөрийг төлөөгүй тохиолдолд BNPL үйлчилгээ үзүүлэгч нь худалдан авагчаас хугацаа хожимдсоны шимтгэл авах; худалдан авалтын гүйлгээ тутамд мерчантаас шимтгэл авах замаар ашиг олдог. Харин худалдагч тус үйлчилгээг худалдан авагчид санал болгосноор илүү олон үйлчлүүлэгчийг татаж бизнесээ өргөжүүлэх боломжтой болдгоороо аль аль талдаа ашигтай үйлчилгээ болдог байна.

Энэхүү үйлчилгээний хурдацтай хөгжил нь уламжлалт зээлийг зохицуулсан хууль, дүрмийн хүрээнээс хальснаар зээлийн дарамт, зээлийн эргэн төлөлт тасалдах зэрэг эрсдэлийг дагуулах, улмаар зохицуулалт хангалтгүйгээс болж зээлийн үнэлгээ тогтоох, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, ил тод байдал зэрэг олон чухал асуудлын хүрээнд хуулийн хийдэл бий болж буй талаар дурджээ³. Энэ нь худалдан авагчийн зээлжих зэрэглэлийг хангалтгүй тогтоох, зээлийн дарамтад оруулах, BNPL үйлчилгээ үзүүлэгч болон худалдагч талын хоорондын шимтгэлийн хэмжээ ил тод биш зэрэг сөрөг үр дагаварт хүргэх нөхцөлийг бүрдүүлэх юм.

Дэлхийн 63 орны төв банкны харьяа Олон улсын төлбөр тооцооны банк⁴ (англ. *Bank for International Settlements*)-аас гаргасан судалгааны тайланд⁵ дийлэнх BNPL үйлчилгээний гэрээ нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомжийн зохицуулалтын хүрээнээс гадуур орхигдсон талаар тэмдэглэжээ. Саяхнаас зарим улсын засгийн газраас BNPL үйлчилгээг зохицуулалттай болгох үүднээс өөрсдийн хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж эхэлсэн байна. Эдгээр зохицуулалт нь худалдан авагчийн эрхийг хамгаалах буюу худалдан авагч хэт өндөр зээлийн дарамтад орохоос сэргийлэх зорилготой юм. Дээрх тайланд дараах улс орнууд BNPL үйлчилгээг хэрхэн зохицуулж буй талаар тоймлон авч үзжээ⁶:

Зөвшөөрөл авах шаардлагатай улсууд:

Швед: BNPL үйлчилгээг цахим худалдаанд өргөнөөр ашигладаг (Эх сурвалж: Sveriges Riksbank (2023)) ба уг үйлчилгээг үзүүлэгчид Хэрэглэгчийн зээлийн тухай хууль (англ. *Consumer Credit Act*)-ийн дагуу Шведийн Санхүүгийн хяналтын газар (англ. *Swedish Financial Supervisory Authority*)-аас тусгай зөвшөөрөл авдаг.

АНУ: BNPL үйлчилгээг санхүүгийн үйлчилгээнд хамаарах эсэх ангиллаас шалтгаалан зохицуулалт муж бүрд ялгаатай байдаг. BNPL үйлчилгээ үзүүлэгчид тусгай зөвшөөрөл авах, эсхүл бүртгүүлэх шаардлагатай байж болох бөгөөд **Зээлийн тухай хууль** (англ. *Credit Act*)-ийг дагаж мөрдөх ёстойг заасан. Одоогийн байдлаар Хэрэглэгчийн эрхийг хамгаалах товчооноос уг үйлчилгээтэй холбоотой болзошгүй эрсдэлийг идэвхтэй судалсаар байна. (Эх сурвалж: CFPB (2022, 2023)).

Зөвшөөрөл авахыг одоогийн байдлаар хуулиар албажуулаагүй улсууд:

³ Luci Irawati, Muhammad Zilal Hamzah, Eleonora Sofilda, "Regulating Buy Now Pay Later (BNPL) in Asean: a Comparative Analysis on Regulatory Challenges and Opportunities," *International Journal of Economics, Management and Accounting*, Volume 1 No., 2024, p.60–81.

⁴ 1930 онд байгуулагдсан олон улсын төлбөр тооцооны хамгийн эртний санхүүгийн байгууллага.

⁵ Giulio Cornelli, Leonardo Gambacorta and Livia Pancotto, *supra* note 2, 69.

⁶ Ibid.



Австрали: 2023 оны 5 дугаар сард Австралийн Засгийн газраас Зээлийн тухай хууль (англ. *Credit Act*)-ийн дагуу холбогдох хуулийн төслийг танилцуулсан⁷ ба Австрали улс нь BNPL үйлчилгээг зохицуулсан туршлагаараа тэргүүлдэг байна. Хуулиар BNPL үйлчилгээ үзүүлэгчдийг тусгай зөвшөөрөл авах, холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдөхийг үүрэг болгосон байна. Үүнээс гадна, хожимдсон болон хугацаа хэтрүүлсэн төлбөрийн торгуулийн дээд хязгаарыг тогтоох, мөн хэрэглэгчийн эрхийг хамгаалах, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагыг тавьдаг (Australian Government (2022)).

ИБУИНХУ: 2023 оны эхээр хууль тогтоогчдын зүгээс BNPL үйлчилгээтэй холбоотой хуулийн төслийн талаар хэлэлцэх үйл явц эхэлсэн. Цаашид тодорхой хэмжээний хөнгөлөлттэйгөөр BNPL үйлчилгээ үзүүлэгчид Санхүүгийн зохицуулах газар (англ. *Financial Conduct Authority*)-ын хяналтын дор үйл ажиллагаагаа явуулах төлөвтэй байна. Мөн BNPL үйлчилгээний талаар төөрөгдөл үүсгэхүйц зар сурталчилгаанд авах арга хэмжээг нэмэгдүүлжээ (Эх сурвалж: HM Treasury (2023)).

Европ: Европын Холбоо 2023 оны 10 дугаар сард Хэрэглэгчийн зээлийн удирдамжийн (англ. *Consumer Credit Directive*) шинэчилсэн найруулгыг баталсан. Үүгээр BNPL гэх мэт бага үнийн дүн бүхий зээлийн хүрээнд хэрэглэгчийг хэт өндөр зээлийн дарамтад орохоос сэргийлэхийг зорьжээ. Мөн зөвшөөрөл авах, бүртгүүлэх гэх мэт нэмэлт нарийвчилсан зохицуулалтыг ирэх 3 жилийн хугацаанд батлах төлөвтэй байна (Эх сурвалж: European Council (2023)).

Канад: Санхүүгийн Хэрэглэгчийн Агентлаг (англ. *Financial Consumer Agency*)-ийн 2021 онд хийсэн судалгааны дараа Канад улс хяналт шалгалтыг эрчимжүүлсэн боловч тодорхой хууль, дүрэм батлаагүй байна. Үүний оронд зах зээлийн байнгын ажиглалтаа дэмжиж, муж даяар зохицуулалтын уялдаа холбоог эрэлхийлсээр байна (Эх сурвалж: FCAC (2021)).

Энэтхэг: BNPL-д зориулсан тусгай зохицуулалт байдаггүй. Энэтхэгийн Нөөцийн Банк (англ. *Reserve Bank of India*) 2022 оны удирдамжаар банк бус байгууллагуудад BNPL үйлчилгээг зээлийн үйлчилгээтэй хослуулан явуулахыг хориглосон байна. (Эх сурвалж: Reserve Bank of India (2022))

Сингапур: Сингапурын Мөнгөний Бодлого Зохицуулалтын Газар (англ. *Singapore's Monetary Authority*)-аас эрх зүйн зохицуулалтын хувьд чөлөөт зарчмыг дэмждэг (Эх сурвалж: Monetary Authority of Singapore (2022)). Тус газраас BNPL үйлчилгээний салбарыг хуульчилж, зээлийн эрхийн үнэлгээ, ил тод байдал, маркетингийн стратеги, зээлийн мэдээлэл солилцох зэрэг олон асуудлыг зохицуулалттай болгосон. Мөн үйлчлүүлэгч нэг бүр BNPL үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай төлбөрийн дээд хэмжээг чөлөөтэй тогтоодог.

Мөн судалгааны сэдвийн дагуу ач холбогдол бүхий дүгнэлтийг бусад улс орны тайланд дурдсан байна. Тухайлбал, ИБУИНХУ дахь BNPL үйлчилгээний талаарх хуулийн төслийн хэлэлцүүлгийн эмхэтгэлд уг үйлчилгээг дараах

⁷ 2024 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн байдлаар BNPL үйлчилгээг зохицуулах хууль батлагдаагүй, хэлэлцүүлгийн шатанд явж байгаа хэвээр байна. <https://lawcouncil.au/resources/submissions/regulating-buy-now-pay-later-in-australia>, (Сүүлд үзсэн: 2024.01.09).



байдлаар тайлбарласан байна: "(Buy-Now, Pay-Later – BNPL) гэх ойлголт нь хүүгүйгээр төлбөрийг 12 сараас хэтрэхгүй хугацаатайгаар хэсэгчлэн хувааж төлөх боломжийг олгодог **зээлийн нэг төрөл юм. Эдгээр нөхцөлүүд зохицуулалтгүй байдаг тул ийм үйлчилгээ үзүүлдэг компаниуд Санхүүгийн Үйлчилгээний Агентлагаас (FCA) тусгай зөвшөөрөл авах, хяналт шалгалтад орох шаардлагагүй, мөн 1974 оны Хэрэглэгчийн Зээлийн хуулийн шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээхгүй.**"⁸

Мөн, 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Энэтхэгийн Нөөцийн Банкаас гаргасан "Дижитал зээлийн ажлын хэсгийн тайлан"⁹-д "Сүүлийн үед шинэ төрлийн бүтээгдэхүүнүүд, тухайлбал "Одоо аваад дараа төл" (Buy Now Pay Later – BNPL) гэх мэт бүтээгдэхүүнүүд хөгжиж байна. Энэ нь борлуулалтын цэг дээрх **зээлийн нэг хэлбэр** бөгөөд худалдан авагчид ихэвчлэн 15–30 хоногийн хүүгүй төлбөр төлөх хугацаа олгодог. Ийм төрлийн гүйлгээнүүдийг зээлийн мэдээллийн товчоонд тайлагнадаггүй, учир нь тэдгээр нь **"зээл" гэсэн тодорхойлолтод хамаардаггүй**. BNPL-ийг ихэвчлэн хэрэглэгчийн оролцоог нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд илүү хялбар туршлага олгох бүтээгдэхүүн гэж тодорхойлдог бөгөөд **зээлийн картыг орлуулах боломжтой ч зээлийн бүтээгдэхүүн гэж тооцогддоггүй**" гэжээ.

Дээрх жишээнүүдээс үзвэл улс орнууд санхүүгийн төлбөрийн шинэ хэрэгсэлд сүүлийн жилүүдэд ихээхэн анхаарал хандуулж буй нь ажиглагдаж байна. BNPL үйлчилгээ нь дэлхий даяар тогтсон хуулийн зохицуулалтгүй, хууль, эрх зүйн хүрээнд зээлийн бүтээгдэхүүний ангилалд албан ёсоор хуульчилж оруулаагүй байгаа тул үйлчилгээг үзүүлэгч байгууллагууд тусгай зөвшөөрөл авах болон бусад хууль, тогтоомжийн дагуу үүрэг хүлээдэггүй талаар олон улсын судалгаануудад тэмдэглэжээ. Иймд гадаад улс орнуудад **шинээр хууль тогтоомж батлах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны үндсэн дээр BNPL үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороотой ижил хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэгч байгууллагын хяналтад орох, тусгай зөвшөөрөл авах, бүртгүүлэх үүргийг хүлээхээр** байна. Харин BNPL үйлчилгээг санхүүгийн бусад үйлчилгээтэй адилтган, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалтын дагуу арга хэмжээ авсан талаарх жишээ судалгаанд авагдсан эх сурвалжуудад тусгагдаагүй байна.

1.2. BNPL үйлчилгээг факторингийн үйлчилгээнээс ялгах онцлогууд

BNPL үйлчилгээ нь факторингийн үйлчилгээнээс зарим талаараа ялгаатай ба тэдгээрийг ялгахын тулд эхлээд факторингийн үйлчилгээг тодруулах шаардлага үүснэ. Факторинг нь бусдын авлагыг худалдан авах буюу факторингийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн харилцагчаас тухайн харилцагчийн хэрэглэгч буюу худалдан авагчийн худалдан авсан бараа, ажил үйлчилгээний харилцагчид төлөгдөх ёстой хүлээгдэж буй мөнгөн төлбөрийн хүрээнд харилцагчаас тухайн авлагыг (хүлээгдэж буй нэхэмжлэлийн шаардлагыг) худалдан авч, харилцагчдаа

⁸ HM Treasury, "Regulation of Buy-Now, PayLater," Consultation on Draft Legislation, 2024, p.6., https://assets.publishing.service.gov.uk/media/6710efdb8a62ffa8df77b28c/Regulation_of_BNPL_consultation_2024_-_final_17.10.pdf, (Сүүлд үзсэн: 2025.01.07).

⁹ Dash J, Choudhary A, P V, et al. "Report of the Working Group on Digital Lending including Lending through Online Platforms and Mobile Apps," Reserve Bank of India, 2021, sec. 5.3.1.5., <https://www.rbi.org.in/Scripts/PublicationReportDetails.aspx?UrlPage=&ID=1189#>, (Сүүлд үзсэн: 2024.01.07).


урьдчилгаа төлбөр хийх санхүүгийн үйлчилгээний нэг төрөл юм¹⁰.

Энэхүү шаардах эрх шилжүүлэх хэлцэл нь сайн дурын үндсэн дээр хийгдэх, талуудын хүсэл зоригийн илэрхийлэл болохын хувьд хариу төлбөртэй эсхүл хариу төлбөргүй байж болно. Гагцхүү уг шаардах эрхийг бусдад шилжүүлснээр шинэ үүрэг гүйцэтгүүлэгч нь тухайн үүргийг шаардах эрхтэй болох юм¹¹.

Факторингийн гэрээний гол онцлог нь харилцагч худалдах, худалдан авах гэрээнээс авах ёстой хүлээгдэж буй авлагаа факторт худалдах, худалдан авах гэрээнээс авах ёстой бараа, үйлчилгээний үнийг тодорхой хувиар бууруулан худалдах явдал юм. Харин худалдан авагч нь харилцагчтай байгуулсан гэрээний дагуу төлөх ёстой төлбөрийг факторт төлөх ёстой юм¹².

Талууд факторингийн гэрээ байгуулахдаа нэгдүгээрт, талуудын хооронд факторингийн гэрээ байгуулагдсан (1) бол гэрээний үйлчлэлийн хугацаанд гарсан бүх шаардах эрх буюу нэхэмжлэлийн үнийн дүнгээ харилцагч нь факторт шилжүүлэх (2), фактор нь шилжин ирсэн шаардах эрхийг хүлээн авч, урьдчилгаа төлбөр хийнэ (3). Хоёрдугаарт, гэрээний хугацаанд харилцагчаас ирүүлсэн шаардах эрхийн үндэслэл болон хэрэглэгчээс энэхүү шаардах эрхийн гүйцэтгэлийг хангах боломжтойг нь нотолсны дараа фактор нь тэрхүү шаардах эрхийг хүлээн авч (4), урьдчилгаа төлбөр хийх (5) гэсэн¹³ дараалалтайгаар явагдана.

График 2. Факторинг үйлчилгээний төлбөрийн схем:



Факторинг болон BNPL үйлчилгээнүүд нь дараах хоёр шинжээрээ ялгаатай байна. Эхний шинж нь факторингийн үйлчилгээгээр эхний ээлжид худалдагч, худалдан авагч нарын хооронд эрх зүйн харилцаа үүсэж байдаг явдал. Тэдний тохирсон үнийн дүнг фактор хүлээн авч, худалдан авагч шаардах эрхийн гүйцэтгэлийг

¹⁰ Д.Лхамжав, *Факторингийн гэрээний эрх зүйн зохицуулалт: Харьцуулсан судлал*, Хууль зүйн магистрын ажил, 2010, 9 дэх тал.

¹¹ Ж. Оюунтунгалаг, *Иргэний эрх зүй I: Ерөнхий анги*, 2020, 172–173 дахь тал.

¹² Д.Лхамжав, *Өмнөх эшлэл* 8, 11.

¹³ Д.Золжаргал, *Факторингийн үйлчилгээг хэрэгжүүлэх арга зам*, Хууль зүйн магистрын диссертац, 2012, 23 дахь тал.



хангах боломжтой гэж үзвэл уг харилцаанд шаардах эрхийг өөрт шилжүүлэн авах хэлбэрээр орж ирдэг. Тэгвэл BNPL үйлчилгээнд хамгийн түрүүнд BNPL үйлчилгээ үзүүлэгч болон худалдан авагч нарын хооронд эрх зүйн харилцаа үүсэж, худалдан авагч эхний төлөлтийг хийснээр худалдагчид барааг шилжүүлж өгөх үүрэг үүсдэг. Үүнийг график 1, 2-оос дэлгэрэнгүй харах боломжтой.

Удаах ялгагдах шинж нь факторинг нь хуулийн этгээдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээ бөгөөд үйлчилгээг ашигласнаар аж ахуй нэгж шууд мөнгөн хөрөнгөтэй болох, нягтлан бодохын ачааллыг хөнгөлж, өр төлүүлэхээр өөрөө хөөцөлдөхгүй давуу талтай¹⁴. Харин BNPL үйлчилгээ нь илүү хувь иргэдэд зориулсан санхүүгийн үйлчилгээ юм. Тиймээс BNPL үйлчилгээ нь иргэдийн санхүүгийн ачааллыг хөнгөвчлөх, төлбөрийн хуваарийг өөрөө сонгох, түргэн шуурхай үйлчилгээ авах зэрэг давуу талуудтай байна.

ХОЁР. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БҮРЭН ЭРХ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ

2.1. Хуулийн зохицуулалтгүй санхүүгийн үйлчилгээг зохицуулах хууль тогтоогчийн эрх, үүрэг

Монгол Улсад санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "СЗХ" гэх) хэрэгжүүлдэг¹⁵. Мөн бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох эрхтэй байна¹⁶.

Монгол Улсад санхүүгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааны жагсаалтыг Санхүүгийн Зохицуулах Хорооны эрх зүйн байдлын тухай хууль¹⁷ (цаашид "СЗХЭЗБТХ" гэх)-ийн 3 дугаар зүйлийн 3.1-д зааж өгсөн ба үүнд банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг хамааруулсан байдаг¹⁸. Харин Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д банк бус санхүүгийн байгууллагаас эрхлэх үйл ажиллагааны жагсаалтад факторингийн үйлчилгээ багтахар хуульчилсан байна¹⁹. Иймд факторингийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага буюу банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийг СЗХ-оос олгоно²⁰. Эдгээр хуулийн зохицуулалтуудын хүрээнд факторингийн үйлчилгээг нэрлэж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын шаардлага, үүрэг, хариуцлагыг заасан боловч BNPL, түүнтэй ижил төрлийн санхүүгийн үйл ажиллагааг хуулиар зохицуулсан зүйл байхгүй. Өмнөх бүлэгт дурдсанчлан факторинг болон BNPL үйлчилгээ хоёул шаардах эрхийг шилжүүлэн авч буй процесс боловч олон улсын

¹⁴ Б.Буянхишиг, *Иргэний эрх зүйн тусгай анги*, 2021, 92 дахь тал.

¹⁵ Санхүүгийн Зохицуулах Хорооны эрх зүйн байдлын тухай хууль (2005)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг.

¹⁶ СЗХЭЗБТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь хэсэг.

¹⁷ *Төрийн мэдээлэл эмхэтгэл* (2005), №46.

¹⁸ СЗХЭЗБТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэг.

¹⁹ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002)-ийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь хэсэг.

²⁰ СЗХЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг.



чиг хандлага эдгээр харилцааг тусдаа ойлголт хэмээн тайлбарладаг тул Монгол Улсад цөөнгүй хэрэглэгчтэй болоод буй BNPL үйлчилгээг алдаагүй зохицуулах нь хэрэгцээ үүсжээ.

BNPL үйлчилгээ нь Монгол Улсад 2019 онд криптовалютын зах зээл эрчимтэй хөгжиж эхэлсэн үетэй зэрэгцэн үүсэж байжээ. Тухайн үед Монгол Улсад криптовалютыг зохицуулах эрх зүйн орчин бүрдээгүйгээс шалтгаалан иргэдээс ихээхэн гомдол, санал ирэх, тэдгээрийг хэрхэх талаар ойлгомжгүй байдал үүсэж байв. 2021 онд СЗХ-оос удаа дараа мэдэгдэл гаргасан ба мэдэгдэлд "... криптовалют, виртуал хөрөнгийн үйлчилгээ хяналт, **зохицуулалтгүй буюу Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын цар хүрээнд хамааралгүй болно**²¹" гэж тайлбарлаж байжээ. Үүнээс үзвэл хууль батлагдах хүртэлх хугацаанд иргэд, хуулийн этгээдэд хориглосноос бусдыг зөвшөөрнө гэх эрх зүйн зарчмын дагуу санхүүгийн шинэлэг үйлчилгээг эрхлэхэд тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй гэх хууль ёсны итгэл үүсэх боломжтой байна.

Зохицуулалтгүй байсан криптовалютын харилцаанд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хурлаас Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг²² баталснаар иргэдийн эрх ашгийг хамгаалах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс сэргийлэх алхам болсон²³. Дээрх жишгээр хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах замаар BNPL үйлчилгээг зохицуулж хэрэглэгчийн эрхийг хамгаалах хэрэгцээ, шаардлагатай. Ингэснээр СЗХ-оос BNPL үйлчилгээ үзүүлэгчид хяналт тавих, тусгай зөвшөөрөл өгөх бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр байна.

2.2. Санхүүгийн Зохицуулах Хорооны хянан шалгагчийн бүрэн эрхэд холбогдох эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ

СЗХ-ны хянан шалгах бүрэн эрхийг СЗХЭЗБТХ-д заахдаа "санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийн биелэлт, дүрэм, журам, зааврын хэрэгжилт, санхүүгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхийг тус тус хянах болон зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээдийн үйл ажиллагааг шалгах" зэргээр тодорхойлсон байна²⁴.

Дээрхээс үзвэл СЗХ хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхдээ **1)** СЗХЭЗБТХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт "Хороо энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Хорооны шийдвэрийг зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээд хэрхэн биелүүлж байгаа байдалд хяналт тавьж, шалгалт хийнэ" гэж хяналт шалгалтад хамаарах этгээдийн хүрээ, хязгаарыг тогтоож нарийвчилж зохицуулсан байна. Харин **2)** Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрэм (2015)-д хяналт шалгалт гэдгийг "санхүүгийн зах зээлийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, хорооноос

²¹ "Санхүүгийн Зохицуулах Хорооноос анхааруулж байна", 2021, <https://www.frc.mn/#/view/2318>, (Сүүлд үзсэн: 2025.01.03).

²² Төрийн мэдээлэл эмхэтгэл (2021), №06.

²³ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл, төслийн үзэл баримтлал, 2021, <https://mojha.gov.mn/wp-content/uploads/2021/01/VASP-%D1%82%D0%B0%D0%BD%D0%B8%D0%BB%D1%86%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.01.03).

²⁴ СЗХЭЗБТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг.



гаргасан шийдвэрийг хамаарах этгээд²⁵ хэрхэн биелүүлж байгааг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээ²⁶ гэж **хяналт шалгалтад хамаарах этгээдийг ялгаатай байдлаар тодорхойлжээ.**

Түүнчлэн хуульд зааснаар зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээд холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг зөрчсөн гэж СЗХ үзвэл хэдийд ч шалгалт хийж болох²⁷ ба хянан шалгагч нь баталсан удирдамжийн дагуу шалгалт хийнэ²⁸. Шалгалтын хүрээнд хянан шалгагчаас тайлан үйлдэх ба зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээдийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт болон шаардлагатай гэж үзсэн бусад асуудлын талаарх дүгнэлтийг тусгах зохицуулалттай байна²⁹.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухайд:

СЗХ-ны хянан шалгагч нь хууль тогтоомжийн дагуу захиргааны шийтгэл оногдуулах бүрэн эрхийг хэрэгжүүлэх³⁰ эрх бүхий албан тушаалтан (цаашид "ЭБАТ" гэх) бөгөөд Зөрчлийн тухай хууль (2017)³¹-д заасан 45 зөрчлийг шалган шийдвэрлэхээр хуульчилсан.³² ЭБАТ нь дараах тохиолдолд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах ба прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй байна.³³ Үүнд:

1. Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль³⁴ (2017)-аар шалган шийдвэрлэхээр харьяалуулсан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг илрүүлсэн;
2. Хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас зөрчлийн талаар гомдол гаргасан, эсхүл мэдээлсэн;
3. Зөрчил үйлдсэн хүн өөрийгөө илчилж ирсэн;
4. Байгууллага, албан тушаалтнаас харьяаллын дагуу зөрчлийн талаарх холбогдох баримтыг шилжүүлэн ирүүлсэн.

Дээр дурдсанаас бусад байдлаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулах боломжгүй ба ЭБАТ буюу санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагчийн хуулиар хүлээсэн чиг үүргийг энд хамааруулан авч үздэг. "Чиг үүрэг" гэдэгт төрийн байгууллагад хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тогтвортой чиглэлийг ойлгоно³⁵.

²⁵ Санхүүгийн Зохицуулах Хорооны улсын байцаагчийн дүрэмд хамаарах этгээд гэдгийг "хорооны зохицуулалтын хүрээнд хамаарах этгээд" гэж тодорхойлсон байна.

²⁶ Санхүүгийн Зохицуулах Хорооны улсын байцаагчийн дүрэм (2015)-ийн 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалт, <https://www.frc.mn/resource/frc/uploads/file/5a0e5a2931df4a9fb2e5da0a3d08290fde893ac1.pdf> (Сүүлд үзсэн: 2025.01.03).

²⁷ СЗХЭЗБТХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэг.

²⁸ СЗХЭЗБТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг.

²⁹ СЗХЭЗБТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалт.

³⁰ СЗХЭЗБТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалт.

³¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017) №24.

³² Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017)-ийн 1.8 дугаар зүйлийн 1.8.6.18 дахь заалт.

³³ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017)-ийн 6.1 дүгээр зүйлийн 6.1.1.1 дэх заалт.

³⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017) №24.

³⁵ Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоол, Чиг үүрэг дахин хуваарилах аргачлалын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, <https://legalinfo.mn/mn/detail?lawid=208323>, (Сүүлд үзсэн: 2025.01.03).



Хорооноос тавих хяналтын тухайд:

Тус байгууллагын хяналт шалгалтыг СЗХ-ны даргаас томилсон хянан шалгагч (улсын байцаагч) гүйцэтгэх³⁶ ба хянан шалгагч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ³⁷:

1. Санхүүгийн зах зээлийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж болон СЗХ-оос гаргасан шийдвэрийг хамаарах этгээд, хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, шалгалт хийнэ;
2. Хамаарах этгээдийн үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавих, шалгалт хийх, хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, таслан зогсоох, холбогдох этгээдэд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах;
3. Хамаарах этгээд, түүний үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлыг шалгаж, шийдвэрлэх;
4. Улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэх.

Дээрх дэд хэсгийг дүгнэвэл, СЗХ-ны хянан шалгагчийн хэрэгжүүлж буй хяналт шалгалт нь төрийн хяналт шалгалтын шинжийг агуулсан байх бөгөөд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд удирдамжтай шалгалт болон дүгнэлт бүхий тайлан гэх агуулга хамаарахгүй юм. Мөн СЗХ нь санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомж, холбогдох бусад дүрэм, журмын биелэлтэд хяналт тавих эрхтэй байх боловч тус хянан шалгах ажиллагааг хэрэгжүүлэхээр томилогдсон хянан шалгагч нь **зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээдийн** үйл ажиллагаа хууль болон дүрэм, журамд нийцэж байгаа эсэхийг хянахаар зохицуулсан байна.

Түүнчлэн хуульд зааснаар хянан шалгагч нь зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих бол СЗХ-ны улсын байцаагчийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан дүрэмд³⁸ "хорооны зохицуулалтын хүрээнд хамаарах этгээд"-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийхээр ялгаатай зохицуулсан байгааг дахин дурдах нь зүйтэй.

Иймд СЗХ-ны хянан шалгагч хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцдаа зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй илрүүлсэн гэж үзэх үндэслэлгүй байх ба хуулиар тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй (тусгай зөвшөөрөл авах этгээдэд хамаарахгүй байгаа), бүртгэлгүй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг хүлээгээгүй байна. Харин хянан шалгагч нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ЭБАТ болох тул хуулиар харьяалуулсан зөрчлийг зөвхөн хуульд заасан үндэслэлийн дагуу шалгаж шийдвэрлэх, хэрэг бүртгэлт явуулах замаар өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх нь хуульд нийцнэ.

³⁶ СЗХЭЗБТХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг.

³⁷ Санхүүгийн Зохицуулах Хорооны улсын байцаагчийн дүрэм (2015)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг.

³⁸ Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 154 дүгээр тогтоол, Санхүүгийн Зохицуулах Хорооны улсын байцаагчийн дүрэм, <https://www.frc.mn/resource/frc/uploads/file/5a0e5a2931df4a9fb2e5da0a3d08290fde893ac1.pdf> (Сүүлд үзсэн: 2025.01.03)



ГУРАВ. ИРГЭНИЙ ХУУЛИЙН 123 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН "ШААРДАХ ЭРХЭЭ ШИЛЖҮҮЛЭХ" ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЛЭЭ

3.1. Шүүхийн практик

BNPL үйлчилгээ нь Монгол Улсад төдийгүй олон улсад ч шинэ үйлчилгээ тул тус үйлчилгээг санхүүгийн аль үйлчилгээний төрөл, хэлбэрт хамаарах талаар тайлбарын ихээхэн зөрүү гардаг, тухайлбал факторингийн үйлчилгээнд хамааруулах явдал байна. Иймд Монгол Улсын шүүхийн практикт факторинг, шаардах эрхээ шилжүүлэх эрхийн талаар хэрхэн тайлбарлаж хэрэглэж байгаа талаар судалж үзлээ.

2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд иргэний хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн нийт хэрэг маргаанд "факторинг" гэх түлхүүр үгээр хайлт хийхэд нийт 7 шүүхийн шийдвэр илэрч байна. Харин давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрийн сангаас илэрц олдсонгүй. Илэрсэн шүүхийн шийдвэрүүдээс 5 шийдвэрт нь нэхэмжлэгчээр "М Ф" гэх ББСБ-аас оролцсон боловч маргааны гол зүйл нь факторингийн үйлчилгээтэй шууд хамааралгүй байна. Талууд хоорондоо хэд хэдэн гэрээ байгуулсан байх бөгөөд үүний нэг нь факторингийн гэрээ байжээ.

Дараагийн шийдвэрийн хувьд нэхэмжлэгч хариуцагчийг эрэн сурвалжлуулах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргасан байх бөгөөд хариуцагчтай байгуулсан зээлийн гэрээгээ факторинг гэж тодорхойлжээ.

Шигтгээ №1.

... Зээлдэгч Д.овогтой А.2022 оны 9 дүгээр сарын 05-ны өдөр ФГ/1501366 тоот барьцаат зээлийн гэрээ (Факторинг) байгуулан, 3,590,000 төгрөгийг жилийн 34,8 хувийн хүүтэй, (сарын 2,9 хувь) 24 сарын хугацаатай **iphone-12 pro маркийн нэг ширхэг гар утас худалдан авах зориулалтаар зээлсэн бөгөөд зээлийн барьцаанд худалдаж авсан гар утсаа барьцаалуулсан.**³⁹

Энэ тохиолдлын хувьд нэхэмжлэгч зээлийн гэрээгээ факторинг гэж давхар нэрлэсэн байх бөгөөд шүүхээс факторингийн үйлчилгээтэй холбоотой тайлбар хийгээгүй.

Сүүлийн шүүхийн шийдвэрийн хувьд хариуцагч нь финтекийн үйлчилгээ үзүүлэгч ББСБ байх бөгөөд маргааны гол зүйл нь факторингийн үйлчилгээтэй шууд хамааралтай биш боловч шүүхийн шийдвэрт дараах агуулгууд тусгагджээ.

³⁹ Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 181/ШШ2024/01494 шийдвэр, https://shuukh.mn/single_case/142142?daterange=2020-01-01%20-%202024-12-30&id=1&court_cat=1&bb=1.

**Хариуцагч Л.Н ББСБХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хариу тайлбар:**

... Л ББСБХК нь Монгол Улсын санхүүгийн зах зээлд анх удаа мэдээллийн технологийн дэвшлийг санхүүгийн үйлчилгээтэй хамтатгасан Финтек бизнесийн загварыг дотоодын санхүүгийн зах зээлд амжилттай нэвтрүүлж харилцагч, хэрэглэгчдийнхээ санхүүгийн асуудлыг түргэн, шуурхай, хялбараар шийдэх зорилготой, ухаалаг гар утсан дээр суурилан L аппликейшнээр дамжуулан цахим зээл болон цахим төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлдэг, зээлийн үйлчилгээ нь 50,000 төгрөгөөс 2,000,000 төгрөг хүртэл зээлийг 7, 14, 21 болон 30 хоногийн хугацаатай олгодог онцлог бичил барьцаагүй хүүгүй зээлийн үйлчилгээ бөгөөд зээлийн шимтгэл нь зээл олгох тохиолдолд тус бүрд нийцэж тооцоологддог, бонус онооны системийг ашиглаж зээлийн нэг удаагийн шимтгэл нь зээлийн хугацааны эцэст төлөгдөх нөхцөлтэй, харилцагчдад зээлийн хэмжээгээ өсгөхөөс өмнө шимтгэлийн хэмжээгээ бууруулах боломжийг олгодог, бичил зээлийн хэмжээ, хугацаанд үндэслэн зээлийн хугацаанаас хамаарах хүү тооцох боломжгүй тул ийнхүү зээлийн шимтгэлийг тооцож, зээл авах үед харилцагчид L аппликейшнд харуулдаг ба харилцагч зээлийн хугацаа, хэмжээнээс хамаарсан шимтгэлийн хэмжээг өөрөө зөвшөөрсөн тохиолдолд зээл авч, хугацааны эцэст зээлийн шимтгэлийн хамт үндсэн зээлийг төлдөг.

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгээс:

... Л ББСБХК-д 2015 оны 6 сарын 24-ий өдөр Санхүүгийн зохицуулах хорооны 293 дугаар тогтоолоор, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 1/493 дугаар гэрчилгээг зээлийн үйл ажиллагаа эрхлэх төрлөөр олгосон, 2018 оны 5 сарын 23-ны өдөр цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, 2019 оны 3 сарын 20-ны өдөр факторинг, итгэлцэл-ийн үйл ажиллагааны төрлөөр тусгай зөвшөөрөл олгогдсон байх тул талуудын хооронд хийгдсэн цахим зээлийн гэрээ олгосон тусгай зөвшөөрлийн дагуу хийгдсэн ажиллагаа байна.

Зээлдэгч Л ББСБ компанийн л.н аппликейшнд өөрийн гар утаснаас хандан, хүсэлт илгээж сонгосон зээл олгогдох боломжтой байх ба Цахим зээлийн эрх нээх гэрээ нь нэг жилийн хугацаатай, энэ хугацаанд зээлдэгч хэрэглээний ба төлбөрийн болон бусад гэсэн 3 төрлийн зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон удаагийн давтамжтайгаар, гэрээний хавсралт хэлцлээр тохиролцон зээл олгогддог, нэг жилийн хугацаанд хэрэгжих Цахим зээлийн эрх нээх гэрээ, түүний хавсралтууд болох хэрэглээний, төлбөрийн зээлийн бүтээгдэхүүний хэлцлүүдийн гэрээний нөхцөл тус компанийн боловсруулж бичигдсэн, зээлийн үйл ажиллагаанд тогтмол хэрэглэдэг хэвлэмэл гэрээний маягт байх ба зээлдэгч тус хэвлэмэл гэрээнд регистр, овог нэр, хугацаа, гарын үсэг зурагдах хэсгүүдэд нөхөх зайнд бичдэг, тухайн зээлийн хэмжээ хугацаа цахим хуудсаар тэмдэглэгддэг гэрээнүүд байна.

Цахим зээлийн эрх нээх гэрээ, түүний хавсралтууд болох хэрэглээний, төлбөрийн зээлийн бүтээгдэхүүний хэлцлүүд нь, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 1.Иргэн, хуулийн этгээд цахим хэлбэрээр данс нээлгэх, хаалгах хүсэлтийг банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд гаргаж болно., 2.Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн цахим хэлбэрээр данс нээж, хаана., хуулийн 20 дугаар зүйл. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох 1. Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид "зээлдүүлэгч" гэх/ тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэж төлөгдөх барьцаа, эсхүл батлан даалттайгаар өөрийн болон түүнд хадгалуулсан бусдын мөнгөн хөрөнгийн зохих хэсгийг өөрийн нэрийн өмнөөс бусад этгээд /цаашид "зээлдэгч" гэх/-д олгохыг банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох /цаашид "зээл" гэх/ гэнэ. 21 дүгээр зүйл.



Зээл олгох ажиллагаа

1. Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, хүүгийн хэмжээ, хугацаа болон бусад нөхцөлийг тогтоон нийтэд мэдээлнэ.

2. Зээлдүүлэгч нь хүү, хугацаа болон бусад нөхцөлийн талаар зээлдэгчтэй харилцан тохиролцож байгуулсан зээлийн гэрээний үндсэн дээр түүнд зээлийн данс нээж, зээл олгоно.,

3. Зээл олгох хэлбэрийг зээлдэгч, зээлдүүлэгч нь зээлийн гэрээндээ харилцан тохиролцоно.,

Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.1.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид зээлдүүлэгч гэх/ нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ. гэж тус тус заасан банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээний шинж агуулга бүхий хуулийн шаардлага хангасан хэлцэл байна.

Үүнээс үзвэл мэдээллийн технологийн дэвшлийг санхүүгийн үйлчилгээтэй хамтатгасан финтек бизнесийн загварт цахим буюу гар утасны аппликейшинд суурилсан үйлчилгээ багтана. Монгол Улсад цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, факторинг, итгэлцэлийн үйл ажиллагааны төрлөөр үйл ажиллагаа явуулах бол Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авах ёстойг харж болохоор байна.

Цаашлаад, шүүхийн шийдвэрийн цахим сангаас УДШ-ийн тогтоолд "шаардах эрх шилжүүлэх" гэх түлхүүр үгээр 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хайлт хийхэд 3624 илэрц байснаас "шаардах эрх шилжүүлэх" тухай бүтэн агуулгыг багтаасан УДШ-ийн 17 тогтоол байна. Үүнд:

- өв шилжсэнтэй холбоотойгоор шаардах эрх шилжсэн тухай маргаан 1;
- шаардах эрх шилжүүлэх, эрх шилжүүлэх гэрээ байгуулсан тухай маргаан 16 байна.

Маргааны үйл баримтуудад ажил гүйцэтгэх, худалдах худалдан авах, зээлийн гэрээнээс үүдэлтэй харилцаанд шаардах эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх тухай гэрээ байгуулсан байх бөгөөд дээрх 17 тогтоолын шаардах эрхээ бусдад шилжүүлсэн хэсэгтэй холбогдуулан маргаан үүсгэсэн 5 тогтоолд УДШ Иргэний хуулийн 123 дугаар зүйлийг дараах байдлаар тайлбарласан байна.



Шигтгээ №3.

<p>УДШ-ийн 2024.10.08-ны өдрийн 214 дүгээр тогтоол</p>	<p>... Иргэний хуулийн 123 дугаар зүйлд заасан шаардах эрх шилжүүлэх, 124 дүгээр зүйлд заасан өр шилжих эрх зүйн асуудал нь үүрэг гүйцэтгүүлэгч, үүрэг гүйцэтгэгч, шаардах эрхийг эсвэл өрийг шилжүүлэн авч буй гуравдагч этгээд гэсэн оролцогч нарын хүсэл зоригоос хамаарах бөгөөд үүрэг гүйцэтгэгч нас барсан тохиолдолд уг шилжилт байх боломжгүй юм⁴⁰.</p>
<p>УДШ-ийн 2020.04.09-ний өдрийн 171 дүгээр тогтоол</p>	<p>... Иргэний хуулийн 123 дугаар зүйлийн 123.2-т зааснаар хууль, гэрээ буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол шаардах эрх эзэмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ шилжүүлж болно. Харин мөн хуулийн 123 дугаар зүйлийн 123.1-д "шаардах эрх шилжих тухай үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэх хүртэл үүрэг гүйцэтгэгч анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэнэ" гэж заасан нь шаардах эрхээ бусдад шилжүүлснээ үүрэг гүйцэтгэгчид мэдэгдээгүй үед үүрэг гүйцэтгэгч хуучин үүрэг гүйцэтгүүлэгчид үүргийг гүйцэтгэсэн бол шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө үүрэг хүлээхгүй агуулгатай зохицуулалт⁴¹.</p>
<p>УДШ-ийн 2021.03.18-ны өдрийн 241 дүгээр тогтоол</p>	<p>... Гэрээний үүргийн талаарх эрх зүйн дүгнэлт хийхэд шаардах эрх шилжүүлэх гэрээ байгуулах талуудын хүсэл зориг, түүний илэрхийлэл, хэрэгцээ, шаардлага, үндэслэл, аль үүргийн ямар хэсгийг, хэрхэн шилжүүлж байгаа нь ойлгомжтой байх шаардлагатай⁴².</p>
<p>УДШ-ийн 2023.02.09-ний өдрийн 27 дугаар тогтоол</p>	<p>... Иргэний хуулийн 123 дугаар зүйлийн 123.2-т заасан "хууль гэрээ буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол шаардах эрх эзэмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрх шилжүүлж болно" гэж заажээ. Шаардах эрх эзэмшигч нь шаардах эрх хэвээр, хүчинтэй байгаа тохиолдолд тухайн эрхээ бусдад шилжүүлж болох ба дээр дурдсанаар "КБ" ХХК нь зээлдэгч А.Б-ийн нас барсантай холбоотойгоор зээлийн гэрээний үүргийг 2019.03.13-ны өдөр даатгалын нөхөн төлбөр хэлбэрээр бүхэлд нь авсан, хамтран зээлдэгч Б.Ш-аас зээлийн төлбөрийг шаардах эрхгүй болсон атлаа, 2020.06.10-ны өдөр "зээлийн өр төлбөр шаардах эрх шилжүүлэх гэрээ"-г "БД" ХК-тай байгуулсан байх тул уг гэрээний дагуу нэхэмжлэгч нь хариуцагчаас мөнгийг шаардах эрх үүсэхгүй байна⁴³.</p>

⁴⁰ УДШ-ийн 2024 оны 10 сарын 08-ны өдрийн 001/ХТ2024/00214 тогтоол, https://shuukh.mn/single_case/10590?daterange=2020-01-01%20-%202024-12-27&id=3&court_cat=1&bb=1.

⁴¹ УДШ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 001/ХТ2020/00171 тогтоол, https://shuukh.mn/single_case/6638?daterange=2020-01-01%20-%202024-12-27&id=3&court_cat=1&bb=1.

⁴² УДШ-ийн 2021 оны 3 дугаар сарын 18-ний өдрийн 001/ХТ2021/00241 тогтоол, https://shuukh.mn/single_case/8173?daterange=2020-01-01%20-%202024-12-27&id=3&court_cat=1&bb=1.

⁴³ УДШ-ийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 001/ХТ2023/00027 тогтоол, https://shuukh.mn/single_case/10165?daterange=2020-01-01%20-%202024-12-27&id=3&court_cat=1&bb=1.



УДШ-ийн өдрийн 258 дугаар тогтоол	2024.11.12-ны	... Иргэний хуулийн 123 дугаар зүйлийн 123.1-д "шаардах эрх шилжих тухай үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэх хүртэл үүрэг гүйцэтгэгч анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүрэг гүйцэтгэнэ.", 123.2-т "хууль, гэрээ буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол шаардах эрх эзэмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ шилжүүлж болно" гэж тус тус заажээ. Хуулийн дээрх зохицуулалтад аливаа шаардах эрхийг шилжүүлэхэд үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэх, эсхүл зайлшгүй зөвшөөрөл авах тохиолдлыг хуульчилсан байна ⁴⁴ .
-----------------------------------	---------------	---

3.2. Монгол Улсын дээд шүүхийн тайлбар

Монгол Улсын дээд шүүхийн 2009 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн тайлбараар⁴⁵ Иргэний хуулийн 123 дугаар зүйлд заасан шаардах эрх шилжүүлэх гэх ойлголтыг тайлбарласан байна:

"Хуулийн 123 дугаар зүйлийн 123.2-т зааснаар "шаардах эрх шилжүүлэх"-д шаардах эрх эзэмшигч нь шаардах эрхээ бусдад шилжүүлэхдээ үүрэг гүйцэтгэгчид энэ талаар мэдэгдэх л үүрэгтэй болохоос түүний зөвшөөрлийг авах, шаардах эрхээ шилжүүлж буй гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний талаар танилцуулах зэрэг ажиллагаа явуулах шаардлагагүй. Харин мөн зүйлийн 123.3-т заасны дагуу үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд шаардах эрх шилжүүлэхийг хязгаарлах талаар харилцан тохиролцсон бол шаардах эрхийг шилжүүлэх ажиллагаа тухайн гэрээний дагуу зохицуулагдана".

3.3. Иргэний хуулийн шинжлэх ухааны тайлбар

Иргэний эрх зүйн чиглэлийн ХБНГУ-ын болон Монгол Улсын шүүхийн шүүгч, эрдэмтэн, багш нарын хамтран бэлтгэсэн "Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Шинжлэх ухааны тайлбар)"⁴⁶-т Иргэний хуулийн 123 дугаар зүйлд зохицуулсан "шаардах эрхээ шилжүүлэх"-тай холбоотой харилцааг дараах байдлаар тайлбарласан байдаг:

⁴⁴ Улсын дээд шүүхийн 2024 оны 11 сарын 12-ны өдрийн 001/ХТ2024/00258 тогтоол, https://shuukh.mn/single_case/10605?daterange=2020-01-01%20-%202024-12-27&id=3&court_cat=1&bb=1.

⁴⁵ "Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 1, 2 дугаар дэд бүлгүүдийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, 2009.6.15, дугаар 18, <http://old.supremecourt.mn/act/view/27>

⁴⁶ Ё.Каят, Э.Шпанглер нар, *Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Шинжлэх ухааны тайлбар)*, дөрөв дэх хэвлэлт, УБ., 2022, 211-216 дахь тал.

**Иргэний хуулийн 123.1 дэх хэсэг**

Энэ нь шаардах эрхээ хүчин төгөлдөр шилжүүлсэн байхыг шаардаж байна. Харин шаардах эрхээ хэрхэн шилжүүлдэг нь 123.2-т тусгагдсан байна.

Иргэний хуулийн 123.2 дахь хэсэг

Энд шаардах эрхийг өөр этгээдэд зарчмын хувьд шилжүүлж болохыг зохицуулсан байх бөгөөд үүнд үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөл шаардлагагүй болохыг тусгажээ. Үүнтэй нэгэн зэрэг энэхүү боломжийн хязгаарыг хийж өгсөн байна.

А. Шаардах эрхийг хэрхэн шилжүүлэх вэ? Энд хуучин болон шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн хооронд гэрээ байгуулагдсан байхыг хууль шаардаж байна. Үүний тулд талууд эрх зүйн чадамжтай байх шаардлагатай. Шаардах эрх шилжүүлэх тухай гэрээ байгуулснаар шаардах эрх нь хуулийн дагуу шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжинэ. Энэ цаг мөчид шинэ үүрэг гүйцэтгүүлэгч нь шаардах эрхийн эзэн нь болно.

Иргэний хуулийн 123.3 дахь хэсэг

Шаардах эрхийг шилжүүлж болохгүй гэсэн гэрээт тохиролцоо анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон үүрэг гүйцэтгэгч нарын хооронд хийгдсэн байсан бол 123.2-т заасны дагуу шаардах эрхийг шилжүүлж болохгүй. Ийм тохиролцоо хийж болох эсэхийг 123.3-т зохицуулсан байна.

Иргэний хуулийн 123.4 дэх хэсэг

123.4 дэх хэсгийн заалт нь шаардах эрх шилжих хэлбэрээр үүрэг гүйцэтгүүлэгч өөрчлөгдөх нь шаардлагын агуулгыг өөрчлөхгүй гэсэн санаанд тулгуурласан байна. Энэ санааг 123.2-т мөн тусгасан байна. 123.4-т мөн шаардах эрх шилжсэнээр үүрэг гүйцэтгэгчийн байдал дордох ёсгүй гэдгийг тусгасан байна.

Иргэний хуулийн 123.5 дахь хэсэг

Энэ заалтын агуулгыг ойлгоход хялбар биш байна. Үгчлэн авч үзвэл шинэ үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчийн анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд эдэлж байсан хариу шаардлагыг хүлээн зөвшөөрөх ёстой байна. Энд үүрэг гүйцэтгэгч нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй үүргийг харилцан тооцох, эсхүл түүний хувьд үүргээ биелүүлэхээс татгалзах боломжтой байх зэрэг тохиолдлыг тусгасан байна (289 ба 209 дүгээр зүйл). Иргэний хуулийн 209 дүгээр зүйлд тусгагдсан үүргийн гүйцэтгэлээс татгалзах эрх нь 213.4-т хэдийнээ тусгагдсан байгаа. Энэ нь үүрэг гүйцэтгэгчийн эсрэг шаардлага биш харин үүрэг гүйцэтгэгчийн шаардлагын эсрэг татгалзаж байгаа явдал буюу хамгаалах арга хэрэгсэл гэсэн үг. Ингэснээр 123.5 дахь хэсгийг хэрэглэх тохиолдол нь зөвхөн үүргийг харилцан тооцохтой л холбоотой гарч ирнэ.

Иргэний хуулийн 123.6 дахь хэсэг

Энэ заалтаар шаардах эрх шилжихэд үүнтэй холбоотой баталгаа, хангах арга болон бусад эрх шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжинэ гэдгийг хуульчилжээ.

Иргэний хуулийн 123.7 дахь хэсэг

Зөвхөн өмчлөгч нь хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлж чадна. Хэрэв өмчлөгч нь тухайн эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх тухай өөр гэрээнүүд бусадтай байгуулж байгаа бол энэ гэрээгээ тэрээр биелүүлж чадахгүй буюу гэрээний нөгөө тал нь өмчлөх эрхийг олж авч чадахгүй. Учир нь тухайн эд хөрөнгө нь анхны гэрээгээр хэдийнээ түүний хөрөнгө биш болсон байгаа. Харин дүрмийн бус нэг тохиолдлыг буюу өмчлөх эрхийг шударгаар олж авах боломжийг 114 дүгээр зүйлд (хөдлөх эд хөрөнгийн хувьд) болон 109.3-т (газрын хувьд) тус тус зохицуулжээ. Харин шаардах эрхийг шилжүүлэх хэлбэрээр шударгаар олж авах боломжгүй.



Иргэний хуулийн 123.8 дахь хэсэг

Энэ хэсэгт шаардах эрх шилжүүлэх гэрээний хэлбэрийг зохицуулжээ. Хэлбэр нь тухайн шилжүүлж буй шаардах эрхийг үндэслэж бий болсон гэрээний хэлбэрт тулгуурладаг. Хэрэв энд газартай холбоотой гэрээ яригдаж байгаа бол, Тухайлбал, газрын үнийг төлөхийг шаардах эрхийн тухай яригдаж байгаа бол, энэ нь мөн л нотариатаар гэрчлүүлсэн байх шаардлагатай.

Иргэний хуулийн 123.9 дэх хэсэг

Шаардах эрх нь нэг эзэмшигчээс нөгөөд хуулийн дагуу шууд шилжинэ гэдгийг хуулиар тогтоосон байж болно. Энэ нь тухайлбал 465.1 дэх хэсгийн заалт буюу батлан даалт юм. Хэрэв үндсэн үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс батлан даагч нь төлбөрийг нь хийсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчийн үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрх нь батлан даагчид шилжинэ. Батлан даагч нь төлбөр хийхийг шаардах эрхтэй болж байна. Хуулийн дагуу шаардах эрх шилжүүлэхтэй холбоотой энэ төрлийн тохиолдолд 123.1 дэх хэсгээс 123.8 дахь хэсэг шаардах эрх шилжүүлэх гэрээтэй нэгэн адил хэрэглэгдэнэ.

Иргэний хуулийн тайлбарт дурдсанчлан 123 дугаар зүйлийн 123.3 дахь хэсэгт шаардах эрхийг шилжүүлж болохгүй нөхцөлийг зохицуулсан. Тэгвэл өмнөх бүлэгт дурдсанчлан BNPL үйлчилгээний хувьд худалдан авагч, BNPL үйлчилгээ үзүүлэгч нарын хооронд эрх зүйн харилцаа түрүүлж үүсдэг тул худалдагч, худалдан авагч нарын хооронд шаардах эрхийг шилжүүлэхгүй байхаар тохиролцох боломжгүй. Мөн 123 дугаар зүйлийн 123.2 дахь хэсэгт шаардах эрхийг шилжүүлэхэд үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөл шаардлагагүй байдаг талаар тусгасан байна. Харин BNPL үйлчилгээг авах эсэх нь зөвхөн үүрэг гүйцэтгэгчийн сонголтын эрхийн асуудал байдаг. Иймд 123 дугаар зүйлийн 123.2 болон 123.3 дахь зохицуулалтууд BNPL үйлчилгээнд хамаарахгүй. Мөн **шаардах эрх** худалдах талаар Хууль зүйн ухааны доктор (Ph.D) Б.Буянхишиг **"Иргэний эрх зүйн тусгай анги"** номд дараах байдлаар дурджээ:

*"Factoring-ийн гэрээ нь холимог гэрээний төрөлд хамаарна. Энд даалгаврын гэрээний (тооцоо гаргах, шаардах эрхийг хэрэгжүүлэх үйлдэл хийх) элементүүд агуулагдсан байх ба мөн зарим нөхцөлд үүнийг **шаардах эрх худалдах**, зээл гэх мэт гэрээний ангилалд хамруулах нь ажиглагддаг. Гэрээний төрлийг зөв зүйтэй тогтоохын тулд энд нэг талаас **энгийн буюу жинхэнэ** нөгөө талаас **энгийн бус factoring** хэмээн **ялгах нь чухал**:*

Энгийн буюу жинхэнэ factoring-ийн гэрээ байгуулах нөхцөлд банк нь үүрэг гүйцэтгэгчийн санхүүгийн эрсдэлийг хүлээж байдаг. ИХ-ийн 123-ын дагуу шаардах эрх шилжүүлэх процесс нь ИХ-ийн 260, 243-д заасан эрх худалдах тухай үүргийн хэлцэлд суурилна. Энэ тохиолдолд аж ахуйн нэгжийн эзэн (=шаардах эрх худалдагч) нь банкны өмнө шаардах эрх нь зүйн үүднээс хүчинтэй эсэхтэй холбоотой хариуцлага хүлээх бол хэрэгжүүлэх боломжтой эсэхийг банк хариуцах юм"



ДУГНЭЛТ

Одоо аваад дараа төл буюу BNPL үйлчилгээ нь сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад ихээхэн өргөн хүрээнд ашиглагдаж эхэлж байгаатай холбогдуулан дэлхийн улс орнууд шинээр хууль батлах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар уг харилцаа зохицуулалтгүй явж ирснийг хуулийн хүрээнд хяналт, шалгалт тогтоож, хэрэглэгчдийн эрхийг хамгаалах, нууцлалыг хадгалах, санхүүгийн нээлттэй, ил тод байдлыг тогтоох нөхцөлийг бүрдүүлсэн байна. ИБУИНХУ-д 2023 оны эхээр BNPL үйлчилгээг зохицуулах талаар хэлэлцүүлгүүд явж, хуулийн төслийг хэлэлцэж байх явцад BNPL үйлчилгээ нь хуулийн зохицуулалтгүй тул үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд төрийн эрх бүхий зохицуулагч байгууллагаас тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй, Хэрэглэгчийн Зээлийн тухай хуулийн шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээхгүй зэргээр тайлбарлаж байжээ. Мөн Энэтхэг улсын онлайн зээлийн үйлчилгээний салбарт томоохон байр суурь эзлээд байгаа BNPL үйлчилгээг хуульд тодорхойлоогүй тул албан ёсоор зээл гэж үздэггүй талаар Энэтхэгийн Нөөцийн Банкнаас гаргасан 2021 оны тайланд дурдсан байна.

ИБУИНХУ, Энэтхэг улсуудаас гадна Австрали, АНУ, Канад, Европын Холбооны улсууд, Швед, Сингапур зэрэг улс орнууд 2022, 2023 онуудад BNPL үйлчилгээнд анхаарал хандуулж эхэлсэн бөгөөд хууль тогтоомж, журамдаа өөрчлөлт оруулж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авах, бүртгүүлэх болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах зохицуулалтыг үйл ажиллагаандаа даган мөрдөх болсон. Эдгээр улс орнуудаас нийтлэг ажиглагдаж буй хандлага нь BNPL үйлчилгээг шинээр гарч ирсэн тодорхой зохицуулалтгүй санхүүгийн үйлчилгээ гэж үзэн хуулийн хүрээнд зохицуулагдаж буй бусад санхүүгийн үйлчилгээнд хамааруулах, адилтган үзсэн жишиг байгаагүй юм. **Өөрөөр хэлбэл зохицуулалтгүй шинэлэг санхүүгийн үйлчилгээнд шинээр хууль тогтоомж батлах, нэмэлт зохицуулалт бий болгохоос нааш үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад тусгай зөвшөөрөл зэрэг шаардлагыг тавихгүй.**

BNPL үйлчилгээг авах явцад худалдагч, худалдан авагч болон шаардах эрхийг шилжүүлж авч буй гуравдагч этгээдүүдийн хооронд үүсэж буй эрх зүйн харилцаа нь факторингийн үйлчилгээтэй ихээхэн төсөөтэй. Гэвч олон улсын чиг хандлагаар уг 2 үйлчилгээг тусдаа бие даасан өөр өөр үйлчилгээ гэж тайлбарлаж байх ба голлох 2 шинжээр нь ялгаж байна. Нэгд, эрх зүйн харилцаа хаана үүсэж буйгаас харагдана. Факторингийн үйлчилгээнд хамгийн түрүүнд худалдагч, худалдан авагч (үүрэг гүйцэтгэгч) нарын хооронд гэрээ байгуулагдаж, дараагаар фактороос үүрэг гүйцэтгэгчийг үүргийн гүйцэтгэлийг биелүүлэх чадвартай гэж үзвэл шаардах эрхийг шилжүүлж авдаг. Харин BNPL үйлчилгээнд худалдан авагч BNPL үйлчилгээ үзүүлэгч нарын хооронд харилцаа түрүүлж үүснэ. BNPL үйлчилгээ үзүүлэгчээс худалдан авагчийн эхний төлөлтийг хүлээн авч, үүний дараагаар худалдагч тал барааг шилжүүлэх үүрэг хүлээх юм. Хоёр дахь ялгагдах шинж нь үйлчилгээнүүд хэн рүү чиглэж байгаагаас харагдана. Факторинг нь хуулийн этгээдүүд рүү чиглэсэн санхүүгийн үйлчилгээ бол BNPL нь хувь хүн, иргэдэд түлхүү зориулагдсан, ингэхдээ эргэн төлөлтийн хуваарийг



өөрөө сонгох, хүү, шимтгэл төлөхгүй зэрэг давуу талтай юм.

Монгол Улсад криптовалютыг 2021 онд СЗХ-оос гаргасан мэдэгдлээр "хяналт, зохицуулалтгүй буюу Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын цар хүрээнд хамааралгүй болно" гэж тайлбарлаж байсан. BNPL үйлчилгээ нь мөн санхүүгийн шинэлэг үйлчилгээ тул Монгол Улсад үйлчилгээг үзүүлэгч аж ахуй нэгжүүд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудад зааснаар СЗХ-оос тусгай зөвшөөрөл авах шаардлага хүлээхээргүй байна. Мөн СЗХЭЗБТХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт зааснаар СЗХ зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээдэд хяналт тавьж, шалгах хийх зохицуулалттай байхаар 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр өөрчлөлт оруулсан байна. Харин 2015 онд батлагдсан Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрэмд хяналт шалгалтын хүрээг хамрагдах субъектийн хувьд (тусгай зөвшөөрөл авсан, аваагүй үл харгалзан) өргөжүүлсэн шинжтэй байгааг дахин дурдах нь зүйтэй.



НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, 2002 он.
2. Санхүүгийн Зохицуулах Хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 2005 он.
3. Санхүүгийн Зохицуулах Хорооны улсын байцаагчийн дүрэм, 2015 он.
4. Зөрчлийн тухай хууль, 2017 он.
5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017 он.

Б. Ном, сурах бичиг

1. Б.Буянхишиг, *Иргэний эрх зүйн тусгай анги*, 2021 он.
2. Д.Лхамжав, *Факторингийн гэрээний эрх зүйн зохицуулалт: Харьцуулсан судлал*, 2010 он.
3. Ж. Оюунтунгалаг, *Иргэний эрх зүй I ерөнхий анги*, 2020 он.
4. Ё.Кают, Э.Шпанглер нар, *Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Шинжлэх ухааны тайлбар)*, дөрөв дэх хэвлэлт, УБ., 2022 он.

В. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Д.Лхамжав, *Факторингийн гэрээний эрх зүйн зохицуулалт: Харьцуулсан судлал*, Хууль зүйн магистрын диссертац, 2010 он.
2. Д.Золжаргал, *Факторингийн үйлчилгээг хэрэгжүүлэх арга зам*, Хууль зүйн магистрын диссертац, 2012 он.

Г. Бусад

1. Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208323>.
2. Улсын дээд шүүхийн 2024 оны 11 сарын 12-ны өдрийн 001/ХТ2024/00258 тогтоол, https://shuukh.mn/single_case/10605?daterange=2020-01-01%20-%202024-12-27&id=3&court_cat=1&bb=1.
3. УДШ-ийн 2024 оны 10 сарын 08-ны өдрийн 001/ХТ2024/00214 тогтоол, https://shuukh.mn/single_case/10590?daterange=2020-01-01%20-%202024-12-27&id=3&court_cat=1&bb=1.
4. УДШ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 001/ХТ2020/00171 тогтоол, https://shuukh.mn/single_case/6638?daterange=2020-01-01%20-%202024-12-27&id=3&court_cat=1&bb=1.
5. УДШ-ийн 2021 оны 3 дугаар сарын 18-ний өдрийн 001/ХТ2021/00241 тогтоол, https://shuukh.mn/single_case/8173?daterange=2020-01-01%20-%202024-12-27&id=3&court_cat=1&bb=1.
6. УДШ-ийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 001/ХТ2023/00027 тогтоол, https://shuukh.mn/single_case/10165?daterange=2020-01-01%20-%202024-12-27&id=3&court_cat=1&bb=1.
7. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 181/ШШ2024/01494 шийдвэр, <https://shuukh.mn/>



single_case/142142?daterange=2020-01-01%20-%202024-12-30&id=1&court_cat=1&bb=1.

8. "Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 1, 2 дугаар дэд бүлгүүдийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол, дугаар 18, 2009.6.15, <http://old.supremecourt.mn/act/view/27>.
9. "Санхүүгийн Зохицуулах Хорооноос анхааруулж байна", 2021, <https://www.frc.mn/#/view/2318>.
10. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл, төслийн үзэл баримтлал, 2021, <https://mojha.gov.mn/wp-content/uploads/2021/01/VASP-%D1%82%D0%B0%D0%BD%D0%B8%D0%BB%D1%86%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0.pdf>.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Англи хэл дээр

1. Consumer Financial Protection Bureau, "Buy Now, Pay Later: Market trends and consumer impacts," 2022.
2. Dash J, Choudhary A, P V, et al. "Report of the Working Group on Digital Lending including Lending through Online Platforms and Mobile Apps," Reserve Bank of India, 2021, <https://www.rbi.org.in/Scripts/PublicationReportDetails.aspx?UrlPage=&ID=1189#>.
3. Giulio Cornelli, Leonardo Gambacorta and Livia Pancotto, "Buy now, pay later: a cross-country analysis," BIS Quarterly Review, 2023.
4. Luci Irawati, Muhammad Zilal Hamzah, Eleonora Sofilda, "Regulating Buy Now Pay Later (BNPL) in Asean: a Comparative Analysis on Regulatory Challenges and Opportunities," *International Journal of Economics, Management and Accounting*, Volume 1 No., 2024.

3. Цахим эх сурвалж

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем – <https://legalinfo.mn/>
2. Монгол Улсын Их Сургуулийн цахим номын сан – <https://catalog.num.edu.mn/>.
3. Санхүүгийн Зохицуулах Хорооны цахим хуудас – <https://www.frc.mn/>.



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ



**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ЗААСАН ТОГТВОРЖУУЛАХ ГЭРЧИЛГЭЭГЭЭР
ТАТВАРЫН ХУВИАС ГАДНА ТАТВАР НОГДУУЛАХ
АРГАЧЛАЛЫГ ДАВХАР ТОГТВОРЖУУЛАХ
ЭСЭХТЭЙ ХОЛБОГДОХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ
ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ДЭРГЭДЭХ
ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ¹

¹ Энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээг Шүүхийн судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн (Ph.D) удирдан, Захиргааны эрх зүйн секторын судлаач М.Ананд гүйцэтгэсэн болно.



УДИРТГАЛ

Энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээгээр сонгон авсан Улсын дээд шүүх (цаашид "УДШ" гэх)-ийн хяналтын тогтоол нь Хөрөнгө оруулалтын тухай хууль¹ (цаашид "ХОТХ" гэх), Татварын ерөнхий хууль² (цаашид "ТЕХ" гэх)-д заасан тогтворжуулах гэрчилгээтэй холбоотой зохицуулалтын талаарх агуулга, ойлголтыг тайлбарлан, шийдвэрлэсэн тогтоол юм. Тухайн хэрэг маргаан нь Ашигт малтмалын тухай хууль³ (цаашид "АМТХ" гэх), ХОТХ, ТЕХ-аар зохицуулагдсан тогтворжуулах гэрчилгээ, хөрөнгө оруулалтын гэрээ, татварын орчин, татварын хувь, хэмжээ зэрэг хуулийн нэр томъёог хэрхэн тодорхойлж тайлбарлахаас хамааран хууль хэрэглээний нэгдмэл байдал үүсгэх чухал ач холбогдолтой байна.

Анхан болон давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэлийн үндсэн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн. Харин хяналтын шатны шүүхийн хувьд уг хэрэг маргааныг шүүх бүрэлдэхүүний олонхын саналаар шийдвэрлэсэн бөгөөд 2 шүүгч Шүүхийн тухай хуулийн⁴ 16 дугаар зүйлийн 16.1.6-д шүүгч бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шийдвэрлэж байгаа хэргийн талаар бие даан хууль хэрэглээний тусгай санал гаргана гэж заасны дагуу тусгай санал гаргажээ.

Уг хэрэг маргааны хүрээнд татварын орчин, татварын хувь, хэмжээ зэрэг хуулийн нэр томъёоны тухайд ХОТХ-ийн төслийг хэлэлцэж байх үеийн хууль тогтоогчийн байр суурийг тодруулан, ХОТХ-аар зохицуулсан тогтворжуулах гэрчилгээ болон Хөрөнгө оруулалтын гэрээний хоорондын ялгааг тодорхойлох замаар холбогдох эрх зүйн зохицуулалт, онолын ойлголтыг судалж, адил төстэй гадаад улс орны эрх зүйн зохицуулалтыг харьцуулах байдлаар дүгнэлт өгөхөд энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний зорилго оршино.

НЭГ. ТАНИЛЦУУЛАХ ХЭСЭГ

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2024/0090⁵

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулж, нэхэмжлэгчийн хяналтын журмаар гаргасан гомдлын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн.

Хэргийн тухай товч:

Хөрөнгө оруулалтын газрын даргын 2015 оны тоот тушаалаар Аж ахуй нэгжийн орлогын албан татвар, Гаалийн татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тогтворжуулахаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан тогтворжуулах гэрчилгээг уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг нэхэмжлэгч хуулийн этгээдэд 2033 он хүртэлх хугацаагаар олгожээ. Гэтэл тогтворжуулах гэрчилгээний хугацаанд мөрдөгдөж байсан ашигт

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2013) №41.

² Төрийн мэдээлэл эмхэтгэл (2019) №22.

³ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2006) №30.

⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2021) №05.

⁵ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/3310?daterange=2024-10-07%20-%202024-10-07&id=3&court_cat=3&bb=1.



малтмалын нөөц ашигласны төлбөр (цаашид "АМНАТ" гэх)-ийн борлуулалтын үнэлгээ тооцох аргачлал болох Засгийн газрын 2014 оны 220 дугаар тогтоолыг 2019 оны 465 дугаар тогтоол болон 2021 оны 174 дүгээр тогтоолуудаар хүчингүй болгож, нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Тус нэмэлт, өөрчлөлтөөр АМНАТ-ийн борлуулалтын үнэлгээг гэрээний үнээс тооцдог байсныг олон улсын жишиг үнээс тооцдог болгосон тул нэхэмжлэгч хуулийн этгээдийн АМНАТ-т төлж буй дүн 208.7 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Нэхэмжлэгч хуулийн этгээдийн зүгээс Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газарт хандан "АМНАТ-ийн хувь, хэмжээг тогтворжуулах гэрчилгээ олгосон 2015 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан буюу 2014 оны 220 дугаар тогтоолд заасан борлуулалтын үнэлгээ тооцох аргачлалаар АМНАТ-ийг тооцон ногдуулж өгнө үү" гэж хүсэлт гаргажээ. Харин хариуцагч Том татвар төлөгчийн газраас "татварын хувь, хэмжээ тогтворжуулах гэдэг нь татварын хувийг тогтворжуулах тухай ойлголт бөгөөд хуульд заасан АМНАТ-ийн хувь нэмэгдээгүй" гэж тайлбарлан хүсэлтийг хангахаас татгалзсан байна.

Иймд нэхэмжлэгч хуулийн этгээд хариуцагчийн татгалзсан шийдвэрийг хууль бус болохыг тогтоолгох, үндэслэлгүйгээр илүү төлүүлсэн 208,688,214,552 төгрөгийг буцаан олгохыг Том татвар төлөгчийн газарт даалгах, маргаан бүхий 465, 174 дүгээр тогтоолуудыг нэхэмжлэгч хуулийн этгээдийн АМНАТ төлөх харилцаанд үйлчлэхгүй болохыг тогтоолгох тухай нэхэмжлэлийн шаардлага гарган шүүхэд маргажээ.

ХОЁР. ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Анхан шатны шүүх⁶: Татварын ерөнхий хуулийн (2008 он) 3 дугаар зүйлийн 3.1-т "татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй" гэж зааснаар аливаа татварын харилцаанд тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг хэрэглэж, татвар тооцох зарчимтай бөгөөд энэ тохиолдолд Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газар нь Засгийн газрын тогтоолыг буруу тайлбарлан хэрэглэж, тогтворжуулах гэрчилгээгээр тогтворжуулсан хувь, хэмжээ нэмэгдээгүй гэж нэхэмжлэгч компанийн хүсэлтээс татгалзсан нь үндэслэлгүй байна.

Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газраас нэхэмжлэгч хуулийн этгээдийн тогтворжуулах гэрчилгээнд заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тогтворжуулахгүйгээр 2021 оны 5 дугаар сараас 2023 оны 10 дугаар сарын хооронд 208.7 тэрбум төгрөгийн илүү төлбөр тогтоосон болох нь хөндлөнгийн аудитын тайлангаар тогтоогдож байна гэж үзсэн.

Иймд анхан шатны шүүхээс үндэслэлгүйгээр илүү төлүүлсэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болох 208,688,214,552 төгрөгийг буцаан олгохыг Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газарт даалгах нь зүйтэй гэж үзэн нэхэмжлэгч хуулийн этгээдийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь

⁶ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 243 дугаар шийдвэр, https://shuukh.mn/single_case/15454?daterange=2024-03-18%20-%202024-03-18&id=1&court_cat=3&bb=1.



хангаж шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүх⁷: Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хянаж үзээд "Хариуцагч захиргааны байгууллагаас Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.1-д зааснаар АМНАТ-ийг илүү төлсөн татварыг буцаан олгох эсэх асуудлыг хяналт, шалгалт явуулах замаар тогтоосны үндсэн дээр шийдвэрлэхээр байхад анхан шатны шүүх нэхэмжлэгчээс тодорхойлсон 208,688,214,552 төгрөгийн үнийн дүнгээр тооцож буцаан олгохоор шийдвэрлэсэн нь үндэслэлгүй байна" гэж үзжээ.

Иймд давж заалдах шатны шүүх "захиргааны байгууллага өөрийн эрхийн хүрээнд холбогдох ажиллагааг зохих журмын дагуу хийж, улмаар илүү төлөлт байгаа эсэх, буцаан олголт олгох эсэх төдийгүй илүү төлөлт байгаа тохиолдолд хэчнээн төгрөгийн буцаан олголт олгогдох эсэх, мөн тогтворжуулалтын гэрчилгээ бүхий хуулийн этгээдийн хувьд анхан шатны шүүхийн хүснэгтээр харуулсан Засгийн газрын тогтоолуудаар татвар ногдуулах хувь хэмжээ өссөн, эсхүл борлуулалтын үнийн өөрчлөлтөөс хувь хэмжээний зөрүү үүссэн эсэхийг тодруулах тогтоох ажиллагаа явуулах нь зүйтэй байх тул үүнтэй холбоотой ажиллагаа явуулахыг хариуцагчид даалгах үндэслэлтэй" гэж дүгнэн анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, нэхэмжлэлийн шаардлагыг зарим хэсгийг хангаж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүхээс шийдвэрлэсэн байдал:

1. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-т "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг дараах хэмжээгээр ногдуулна: 47.3.1. олборлож өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодод худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан нүүрсний нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 2.5 хувь; 47.3.3. энэ хуулийн 47.3.1, 47.3.2-т зааснаас бусад бүх төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5.0 хувь" гэж, 47.17-д "Нүүрс, нүүрсний бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ хуулийн 47.3.3-т заасан хувь дээр тухайн бүтээгдэхүүний нэр төрөл, зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч ... хувийг нэмэгдүүлж тооцох"-оор зааснаас үзвэл нөөц ашигласны төлбөрийг тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний тодорхой хувиар тооцохоор хуульчилсан, уг "хувь" нь Ашигт малтмалын тухай хуулиар шууд тодорхойлогдсон, харин татвар төлөгчийн улсын төсөвт төлөх төлбөрийн "хэмжээ" нь ашигласан нөөцийн хэмжээ, борлуулалтын үнэлгээнээс хамаарч нэмэгдэх, хасагдах боломжтой байна. (8.5)⁸
2. Тухайн тохиолдолд, нүүрсний нөөц ашигласны төлбөрийн хувь өөрчлөгдөөгүй боловч Засгийн газрын маргаан бүхий тогтоолуудаар борлуулалтын үнэлгээ тооцох аргачлалыг өөрчилсний улмаас нэхэмжлэгч хуулийн этгээдийн АМНАТ-ийн хэмжээ нэмэгдсэн нь хэрэгт авагдсан

⁷ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 334 дугаар магадлал, https://shuukh.mn/single_case/7900?daterange=2024-05-22%20-%202024-05-22&id=2&court_cat=3&bb=1.

⁸ "Шийдвэрлэсэн байдал" хэсэгт бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



баримт, талуудын тайлбараар тогтоогдсон, энэ нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан "Тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд татварын хууль тогтоомжид энэ хуулийн 14.1-д заасан албан татвар, төлбөрийн хувь, хэмжээг бууруулах өөрчлөлт орсон тохиолдолд тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд уг өөрчлөлтөд хамаарах ба харин нэмэгдүүлэх өөрчлөлт орсон тохиолдолд уг өөрчлөлтөд хамаарахгүй" байх хөрөнгө оруулагчид хуулиар олгосон баталгааг зөрчсөн, энэ талаарх хоёр шатны шүүхийн дүгнэлтүүд үндэслэлтэй, "татвар ногдуулах төлөхтэй холбоотой аргачлалыг хэм хэмжээний актаар өөрчлөх замаар төсөвт төлөх АМНАТ-ийн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой" гэж шүүх дүгнэхгүй. Энэ ч утгаараа нэхэмжлэгчийн Тогтворжуулах гэрчилгээнд "Ашигт малтмалын тухай хуульд заасан хувь, хэмжээ" гэснийг зөвхөн "хуулиар тогтоосон хувь" гэж, эсхүл "хувь, хэмжээ нь адил" гэж, эсхүл "хуулиар тогтоосон хэмжээ гэдэгт Засгийн газрын тогтоолоор баталсан борлуулалтын үнэлгээ тооцох аргачлал болох захиргааны хэм хэмжээний акт хамаарахгүй" гэж тайлбарлах боломжгүй. Тогтворжуулах гэрчилгээний үр дагавар, ерөнхий агуулга, хүрээ нь Хөрөнгө оруулалтын тухай хуулиар тодорхойлогдоно. (8.6)

3. Иймд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу олгогдсон Тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй хугацаанд нэхэмжлэгч хуулийн этгээдийн АМНАТ-ийн хувь болон хэмжээг нэмэгдүүлэх үр дагавартай аливаа хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт буюу Засгийн газрын тогтоолууд энэ тохиолдолд үйлчлэхгүй, хариуцагч нь татварын хэмжээг нэмэгдүүлсэн үр дагавартай татварын "хууль тогтоомжийн бусад акт"-ыг хэрэглэж Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчээр татварын хэмжээг нэмэгдүүлэн төлүүлсэн нь хууль бус, энэ талаарх нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтэд хариуцагчаас "Гэрчилгээгээр тогтворжуулсан хувь, хэмжээнд Ашигт малтмалын хуулиар өөрчлөлт ороогүй" гэх агуулгаар татгалзсан хариу өгсөн нь үндэслэлгүй байна. (8.7)
4. Өөрөөр хэлбэл, 2015 онд Тогтворжуулах гэрчилгээ олгох үед хуульд заасан байсан "татварын хувь" болон Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6-д заасны дагуу гарсан, тухайн үед мөрдөгдөж байсан Засгийн газрын 2014 оны 220 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын зах зээлд борлуулсан нүүрсэнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох аргачлал"-ын үйлчлэл нь "Э р" ХХК-ийн хувьд тогтворжсон гэж үзэх бөгөөд Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчийн төлөх АМНАТ-ийн хэмжээг ихэсгэх үр дагавар үүсгэсэн 2019, 2021 онд батлагдсан Засгийн газрын тогтоолуудыг баримталж татвар ногдуулсан нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг зөрчсөн байх тул Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01/352 дугаар шийдвэр хууль бус гэж үзнэ. (8.8)



5. Хариуцагч нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага бөгөөд Татварын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т заасан "илүү төлсөн татварыг буцаан авах ...", 12.1.11-т заасан "хөрөнгө оруулалтын хууль тогтоомжид заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ авсан бол уг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд хувь, хэмжээг нь тогтворжуулсан татварыг тогтворжуулсан хувь, хэмжээнээс илүү хэмжээгээр төлөхгүй байх" татвар төлөгчийн эрхийг хангах, энэ үүднээс үндэслэлгүйгээр илүү төлүүлсэн татварын буцаан олгох үүрэгтэй байна. (9.1)
6. Энэ тохиолдолд хариуцагч Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газар шүүхийн шийдвэрийн дагуу Тогтворжуулах гэрчилгээ олгох үед хуульд заасан байсан "татварын хувь" болон тухайн үед мөрдөгдөж байсан Засгийн газрын 2014 оны 220 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын зах зээлд борлуулсан нүүрсэнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох аргачлал"-ын дагуу АМНАТ-ийн ногдлыг тодорхойлж, татварын тооцооллыг хууль тогтоомжид заасны дагуу хийж, илүү төлүүлсэн бол буцаан олгох талаар шийдвэр гаргахыг хариуцагчид даалгаж шийдвэрлэх нь зүйтэй. Түүнчлэн хариуцагчийн зүгээс "нэхэмжлэгч нь татварын хяналт шалгалтад ороод зарим нэг татварын актыг хүлээн зөвшөөрч төлсөн" гэсэн тайлбар гаргаж байх тул энэ нөхцөл байдлыг тодруулах нь зүйтэй гэж үзлээ. (9.5)

Дээрх үндэслэлээр хяналтын шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, "илүү төлөлт байгаа эсэхийг зохих журмын дагуу хянаж, шалгахыг даалгасан" давж заалдах шатны шүүхийн дүгнэлтийн үндэслэлийг өөрчилж, нэхэмжлэгчийн хяналтын журмаар гаргасан гомдлын зарим хэсгийг хангаж, мөн үндэслэлээр нэхэмжлэлийг бүхэлд нь хангасан "анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх" талаарх гомдлыг хангаагүй байна.

Улсын дээд шүүхийн 2 шүүгчийн гаргасан тусгай санал⁹:

1. Хуулийн аутентик тайлбар, зохицуулалтын харилцан уялдаанд авч үзэхэд, "Тогтворжуулах гэрчилгээ"-г энэ хуульд заасан албан татвар, төлбөрийн буюу хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан аж ахуйн нэгжийн орлогын, гаалийн, нэмэгдсэн өртгийн албан татвар ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тогтворжуулах зорилгоор шалгуур хангасан хуулийн этгээдэд олгох бөгөөд зөвхөн татвар, төлбөрийн хувь, хэмжээг гэрчилгээнд заасан хугацаанд тогтворжуулах агуулгатай.
2. Харин "Татварын орчин" гэх агуулгад дээр дурдсан татвар, төлбөрийн хувь хэмжээг тогтворжуулах төдийгүй түүнийг тодорхойлох, ногдуулах, төлөх талаар хууль болон хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Монгол Улсын яам, Засгийн газрын агентлаг зэрэг эрх бүхий бусад

⁹ Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны тусгай санал, 2024.10.07, Дугаар 05, <https://www.supremecourt.mn/mn/printa?id=43800&tp=2&s=75>, (Сүүлд үзсэн: 2025.02.05).



этгээдээс тогтоосон эрх зүйн зохицуулалтын иж бүрдэл хамаарах ба татварын хувь, хэмжээг багтаасан илүү өргөн агуулгатай учир ялгаатай нэр томъёоны тайлбар хийжээ.

3. Мөн хөрөнгө оруулагчийн Монгол Улсад оруулах хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч, өөрөө хүсвэл Засгийн газартай хэлэлцээ хийх замаар "Хөрөнгө оруулалтын гэрээ" байгуулж татварын хувь, хэмжээ, түүнийг тооцох аргачлал, татвар ногдуулалт, төлөх эрх зүйн орчин зэргийг бүхэлд нь, эсхүл Тогтворжуулах гэрчилгээ авснаар хуульд заасан татварын хэмжээг тогтворжуулахаар байна.
4. Дээрхээс нэгтгэн дүгнэхэд, хууль тогтоогчоос хөрөнгө оруулагчийн татварын орчныг тогтвортой байлгах баталгааг хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч нэгдүгээрт, "Тогтворжуулах гэрчилгээ" олгох замаар түүний хүчинтэй хугацаанд хуульд заасан татварын хувь, хэмжээг тогтворжуулах, хоёрдугаарт, Засгийн газартай "Хөрөнгө оруулалтын гэрээ" байгуулах замаар татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг тогтвортой байлгах байдлаар ялгаатай зохицуулсан байна.
5. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг борлуулалтын үнэлгээний тодорхой хувиар ногдуулахаар тогтоосон Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсгийн зохицуулалт нь "Тогтворжуулах гэрчилгээ"-ээр тогтворжуулахаар заасан хуулиар тогтоосон татварын хувь хэмжээнд хамаарна.
6. Харин Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6-д заасан бүрэн эрхийн хүрээнд гаргасан Засгийн газрын тогтоол нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан татварын хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдэлд хамаарна.

Хяналтын шатны шүүхийн тусгай санал гаргасан шүүгчид "нэхэмжлэгчийн хувьд "Хөрөнгө оруулалтын гэрээ" байгуулаагүй; Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-т заасан нэхэмжлэгчид хамаарах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр "5.0" гэх хувь хэмжээнд өөрчлөлт ороогүй; харин "Татварын орчин"-д хамаарах Засгийн газрын тогтоолын дагуу төлөх төлбөрийн хувь, хэмжээ өөрчлөгдсөн энэ тохиолдолд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангах боломжгүй, хариуцагчийн татгалзал, тайлбар үндэслэлтэй" гэж үзжээ.

ГУРАВ. ДҮН ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний хүрээнд сонгон авсан уг хэрэг маргаанаар татварын орчин, татварын хувь, хэмжээ зэрэг нэр томъёог хууль тогтоогчийн үзэл баримтлалын үүднээс тодруулах, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т тусгагдсан Тогтворжуулах гэрчилгээ болон Хөрөнгө оруулалтын гэрээний хоорондын ялгааг тодорхойлох замаар холбогдох онолын ойлголт болон адил төстэй гадаад улс орны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, дүгнэлт өгөхийг зорилоо.



3.1 Эрх зүйн зохицуулалт болон онолын ойлголт

Дүн шинжилгээний хүрээнд сонгон авсан хэрэг маргааныг анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн зүгээс нэхэмжлэгч хуулийн этгээдийн үндсэн нэхэмжлэлийн шаардлагыг ханган шийдвэрлэхдээ ХОТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 14 дүгээр зүйлийн 14.1.4, АМТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.15, 47.17-д тус тус заасан зохицуулалтыг тайлбарлан хэрэглэжээ.

Анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс нэхэмжлэгч хуулийн этгээд нь ХОТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч тул АМТХ-д заасан АМНАТ-ийн хувь тогтворжихын зэрэгцээ түүнд ногдуулж буй АМНАТ-ийн борлуулалтын үнэлгээг тооцох аргачлал мөн адил тогтворжино гэж үзэн АМНАТ-ийн илүү төлөлтийг буцаан олгохыг даалгах байдлаар нэхэмжлэлийн үндсэн шаардлагыг хангажээ. Уг асуудалд хяналтын шатны шүүх эрх зүйн дүгнэлт хийхдээ "Тогтворжуулах гэрчилгээнд АМТХ-д заасан хувь, хэмжээ гэснийг зөвхөн хуулиар тогтоосон хувь гэж, эсхүл хувь, хэмжээ нь адил гэж, эсхүл хуулиар тогтоосон хэмжээ гэдэгт Засгийн газрын тогтоолоор баталсан борлуулалтын үнэлгээ тооцох аргачлал болох захиргааны хэм хэмжээний акт хамаарахгүй гэж тайлбарлах боломжгүй. Тогтворжуулах гэрчилгээний үр дагавар, ерөнхий агуулга, хүрээ нь Хөрөнгө оруулалтын тухай хуулиар тодорхойлогдоно" гэж тайлбарлажээ.

Өөрөөр хэлбэл, шүүхүүд "татварын хувь, хэмжээ" гэдгийг тайлбарлахдаа татварын хувь гэдэг нь хууль тогтоогчийн зүгээс хуульчлан тогтоосон татварын хувь гэж, харин татварын хэмжээ гэдгийг Засгийн газрын тогтоолоор батлан гаргасан АМНАТ-ийн борлуулалтын үнэлгээг тооцох аргачлалыг хэлнэ гэх байдлаар татварын хувь, хэмжээг агуулгын хувьд салгаж тайлбарласан байна. Иймд "татварын хувь, хэмжээ" гэх хуулийн нэр томъёог хууль тогтоогч, онолын болон эрх зүйн зохицуулалтыг агуулга талаас нь хэрхэн ойлгох талаар судалж үзье.

ХОТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1-д дурдагдаж буй "татварын хувь, хэмжээ" гэдгийг анх баталж байх үеийн хууль тогтоогчдын үзэл баримтлал, саналаас харвал:



Улсын Их Хурлын 2013.09.26-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл¹⁰

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийн үеэрх хууль тогтоогчдын үзэл баримтлал

З.Э: Агуулга, нэр хоёр нь зөрөөд байгаа учраас ямар ч татварын орчин биш энэ чинь зарим татварын хувь хэмжээг тогтворжуулах л юм байна шүү дээ. Тэгж агуулгад нь тааруулж нэрлэхгүй бол болохгүй байна. Я.С гишүүн.

Я.С: Энэ хэмжээ байхгүй юмаа бас. Ер нь татварын хэмжээг бид тогтворжуулахгүй шүү дээ. Өглөө Байнгын хороон дээр хэлээд ... авья гэж санал хураалгасан шүү дээ. Д гишүүн санал гаргаад бид хоёр санал гаргаад, хэмжээг татварын хэмжээг тогтворжуулах биш шүү дээ. Татварын хувийг л тогтворжуулах байхгүй юу. Тэр хэмжээ чинь бол тэр нөгөө компани том нь бизнес нь томроод тэр хувийнхаа хэмжээгээр зүгээр одоо өнөөдөр 5 хувийг төлөхдөө 10 мянган юу төлдөг байсан бол дараа нь 5 хувиараа 100 мянгыг төлж болно шүү дээ. Тэр компанийн орлогын юунаас авч байгаа юм чинь.

Жишээ нь, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар чинь тэгнэ биз дээ. 10 хувиар тооцож байгаа. Би өмнө нь тэрбум долларын борлуулалт хийдэг байсан бол дараа нь тэрбум доллараас би 10 хувь гээд 100 саяыг өгдөг байсан бол дараа нь 10 тэрбум болох юм бол би тэрбумыг өгнө шүү дээ. Тэгэхээр хэмжээ тогтворжихгүй байхгүй юу. Таны юугаар татварын хувийг тогтворжуулах гэдгээр энэнийхээ томьёоллыг хийгээд, энэ хэмжээ гэдэг үгийг эндээс авмаар байгаа юм.

Тэгвэл хэмжээг тогтворжуулсан гээд явчихвал дараа нь бас болохгүй, хоёр өөр агуулга шүү дээ. Хувь, хэмжээ гэдэг хоёр агуулга чинь хоёр өөр агуулга байхгүй юу. Тэгээд өглөө бол Байнгын хороон дээр хэлэхдээ Гарамгайбаатар дарга санал хураахдаа энэ хэмжээ гэдгийг хараарай гэж байгаад хураалгасан тийм ээ Гарамгай даргаа. Эдийн засгийн байнгын хороон дээр. Энэ чинь дахиад л ороод ирсэн байна шүү дээ.

Д гишүүний бид хоёрын яриад байдаг өглөөний юм чинь дахиад ороод ирлээ шүү дээ. Тэгээд хэмжээ гэдэг энэ үгийг нь авмаар байна. Хоёрдугаарт, энэ татварын орчноор тэр хэмжээг нь авч байж яахгүй бол. Тэгэхээр бол бараг татварын хувийг тогтворжуулах гэдэгтэй л бараг болчихож байгаа байхгүй юу. Тодорхой зарим татварын хувийг тогтворжуулах.

З.Э: Д гишүүн.

С.Д: Өглөө ярьж байхад тэр хувь гээд таслал тавьчихсан байсан байхгүй юу. Тэгэхээр нь хэмжээ гэж юу юм. Энэ чинь абсалют тоо гээд. Бүр хэлж байгаад, тэгээд тэмдэглүүлнэ гээд. Тэгээд энэ чинь өөрөө нэг л үг байгаа юм хувь хэмжээ гээд. Хувь хэмжээ гэдэг үг нэг үг байхгүй юу. Энэ алдаа дундуур нь таслал тавьснаас болоод юу үүсгээд байгаа юм. Тэгэхээр энэний одоо жинхэнэ бүр сая Б гишүүн тодорхой татварын хувь хэмжээг тогтворжуулах л гэсэн үг байхгүй юу. Тодорхой татваруудын хувь хэмжээг.

З.Э: Хувь болон хэмжээ биш хувь хэмжээ гэдэг.

С.Д: Нэг л үг. Хувь хэмжээ гээд.

З.Э: Таслалгүй үг юм уу.

С.Д: Нэр томьёо нь ч угаасаа тийм.

¹⁰ Монгол Улсын Их Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн Нэгдсэн хуралдаан, <https://www.parliament.mn/nn/13150/>, (Сүүлд үзсэн: 2025.01.31).

**Эдийн засгийн байнгын хорооны 2013.10.02-ны өдрийн хуралдааны тэмдэглэл¹¹****Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх үеэрх хууль тогтоогчдын үзэл баримтлал**

Б.Г: Энэ нөгөө нэг юугаа олсон уу. Нөгөө хувь гээд таслал хэмжээг гээд байсныхаа учрыг олсон уу. Энэ дээр дахиад орж ирж байна шүү дээ. Учраа олчихсон уу тийм ээ.

С.О: Үгүй ээ, ерөөсөө өөрийнхөө татварын хуулинд тэгээд орчихсон юм байна. Тэгэхдээ энд зүгээр бид нар бас протоколд тэмдэглэхгүй бол сүүлд одоо хүмүүс хөрөнгө оруулагчид та нар хувийн ч хэмжээг нь ч гэж. Тэр хувь хэмжээг нэг үг гэж ойлгоноо гээд.

Б.Г: За тэгвэл тэрийг нь тэмдэглэх.

Эндээс хууль тогтоогчид ХОТХ-д зохицуулсан тогтворжуулах гэрчилгээгээр "татварын хувь, хэмжээ" гэдгийг хувь болон хэмжээ гэж агуулгаар нь салгах биш, татварын хувь гэсэн нэг ойлголтыг татварын хувь, хэмжээ гэх холбоо үгээр томъёолох байдлаар хэлэлцсэн байна.

Онолын хүрээнд доктор П.Одгэрэлийн Татварын эрх зүй номд "Татварын хувь хэмжээ гэдэг нь татвар ногдуулах нэгж (суурь)-ээс татварын төлбөрийг тодорхойлох хэмжээ юм. Ихэнхдээ хэмжих нэгж нь хувиар илэрхийлэгддэг байна. Хэмжих нэгж нь өсөлттэй илэрхийлэгдэж буй татварын хувийг прогрессив татварын хувь гэдэг бол, татварын хэмжээ дунджаар адил бол татварын пропорционал хувь гэнэ¹²" гэжээ. Харин татвар ногдуулах нэгж (суурь) гэдэг нь "Ногдуулах татварыг тодорхойлох үндэслэл болох бөгөөд татварын хэмжээг тооцоолох суурь болно" гэж тодорхойлжээ. Энэхүү онолын тодорхойлолтыг хэрэг маргаантай холбон дүгнэвэл татварын хувь, хэмжээ гэдэг нь АМНАТ-ийн хувийг, татвар ногдуулах нэгж (суурь) нь АМНАТ-ийн борлуулалтын үнэлгээг тооцох аргачлалыг тус тус илэрхийлж байна.

Цаашлаад ХОТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Төр нь энэ хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээ олгох замаар татварын хувь, хэмжээг тогтворжуулах, эсхүл түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар татварын орчныг тогтвортой байлгах баталгаа олгоно" гэж, 20 дугаар зүйлийн 20.1-д "Засгийн газар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай түүний гаргасан хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна" гэж тус тус зохицуулжээ. Дээрх зохицуулалтын агуулгаас харвал хууль тогтоогчид тогтворжуулах гэрчилгээ болон хөрөнгө оруулалтын гэрээг хөрөнгө оруулалтын мөнгөн дүн, зорилгоос хамааруулан ялгамжтай байдлаар зохицуулсан нь ажиглагдлаа.

Эндээс "татварын орчин" гэдгийг ХОТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д зааснаар "... хуульд заасан татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох,

¹¹ Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаан, <https://www.parliament.mn/nn/69/>, (Сүүлд үзсэн: 2025.01.31).

¹² П.Одгэрэл, *Татварын эрх зүй*, 2021, 33 дахь тал.



ногдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг¹³ ойлгох бөгөөд тус агуулгад дурдагдсан нөхцөлүүдийг задлан тодорхойлбол:

- Татварын төрөл гэдэг нь ТЭХ-ийн 7 дугаар зүйлийн 7.2-т "Монгол Улсын татвар нь доор дурдсан төрөлтэй байна:" гээд 7.2.1-ээс 7.2.30 хүртэл заасан 30 нэр төрлийн албан татварыг хамааруулан ойлгохоор хуульчилжээ.
- Тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх гэдгийг ТЭХ-ийн 28 дугаар зүйлийн 28.1-д "Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө" гэж зохицуулсан бөгөөд онолын үүднээс авч үзвэл татварлах ажиллагааны нэг хэсэг гэж үздэг байна. Татварлах ажиллагаанд татварыг тодорхойлох, ногдуулах, төлөх, албадан гүйцэтгэх зэрэг цогц ажиллагааны нийлбэрийг хамруулдаг.¹⁴ Тодруулбал татвар ногдуулах зүйл, түүнийг тооцоолох аргачлал болон татвар төлөгчийн эрх, үүргийг тодорхойлох, татвар төлүүлэх процесс ажиллагааг хамтад нь ойлгоно.

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл ХОТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т зааснаар тогтворжуулах гэрчилгээ нь ХОТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-ээс 14.1.4-т заасан аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зөвхөн хувийг тогтворжуулах баталгаа олгож, харин Хөрөнгө оруулалтын гэрээгээр татварын орчныг тогтворжуулж байгаа буюу үүнд татварын хувь болон татварыг тооцоолох аргачлал, татвар тодорхойлох, ногдуулах, төлөх ажиллагаа бүхэлдээ тогтворжих баталгаа олгожээ. Тус тохиолдолд ХОТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан зохицуулалтыг холбогдох татварын хувь, хэмжээ болон татварын орчин гэх хуулийн нэр томъёотой уялдуулан дүгнэх нь тухайн зохицуулалтын агуулгыг зөв тодорхойлон гаргаж ирэхэд дөхөмтэй байна.

Уг хэрэг маргааны хувьд хяналтын шатны шүүх ХОТХ-ийн төслийг хэлэлцэж байх үеийн хууль тогтоогчийн үзэл санаанд суурилан хуулийн хэм хэмжээг тайлбарлах нь тухайн хуулийн зорилго, зарчим, агуулгад нийцнэ гэж үзэж байна. Хэрэв тогтворжуулах гэрчилгээгээр татварын хувийг болон түүнд татвар ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох аргачлалыг давхар тогтворжуулбал хөрөнгө оруулалтын гэрээ, тогтворжуулах гэрчилгээ хоорондын ялгамжтай хуульчилсан хууль тогтоогчийн үзэл санаа, хуулийн зорилго алдагдах эрсдэлтэй байж болох юм.

Хэдийгээр Хөрөнгө оруулалтын тухай хуулиар хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалж, түүнд тогтворжуулах гэрчилгээ олгосонтой холбоотойгоор Захиргааны ерөнхий хуульд заасан "хууль ёсны итгэлийг хамгаалах" зарчим үйлчлэх боловч ХОТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т тогтворжуулах гэрчилгээ болон хөрөнгө оруулалтын гэрээг ялгамжтай байдлаар хуульчилсан учраас тухайн тохиолдол үйлчлэхгүй. Иймд тус тохиолдолд ХОТХ-ийн төслийг хэлэлцэж байх

¹³ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтад 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр буюу сонгон авсан шүүхийн шийдвэр гарсны дараа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

¹⁴ П.Одгэрэл, *Татварын эрх зүй*, 2021, 141 дэх тал.



үеийн хууль тогтоогчийн үзэл, санаа чухал үүрэгтэй. Учир нь Монгол Улсын эх газрын эрх зүйн тогтолцооны хувьд шүүх нь хуулийг бүтээдэггүй, гагцхүү хэрэглэдэг субъект юм.

3.2 Гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт

Дүн шинжилгээний энэхүү хэсэгт Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хуультай адил байдлаар тогтворжуулах гэрчилгээ олгох замаар татварын хувь, хэмжээг тогтворжуулж буй Чилийн Бүгд Найрамдах Улс (цаашид "Чили улс" гэх)-ын эрх зүйн зохицуулалтыг сонгон судаллаа. Монгол Улсын ХОТХ-аар зохицуулж байгаатай адил байдлаар татварыг тогтворжуулж буй гадаад улс орон цөөн байгаа тул уул уурхайн салбарын хүрээнд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжиж буй улс орны татварын бодлогыг судлах зорилгоор Бүгд Найрамдах Кени Улс (цаашид "Кени улс" гэх), Бүгд Найрамдах Перу Улс (цаашид "Перу улс" гэх), Малайз улсыг сонгон судалсан болно.

3.2.1 Чилийн Бүгд Найрамдах Улс

Чили улс нь 2014 онд хийсэн татварын эрх зүйн шинэчлэлийн дагуу 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тухай хуулийг¹⁵ баталсан. Тус хуулийн дагуу гадаадын хөрөнгө оруулагчтай холбоотой асуудлыг "InvestChile" агентлаг хариуцан ажилладаг. Агентлагаас Гадаадын хөрөнгө оруулагчийн гэрчилгээ олгох замаар хөрөнгө оруулагчдын эрх, үүргийг хамгаалдаг байна¹⁶.

Гадаадын хөрөнгө оруулагчийн гэрчилгээ авахад тавигдах шаардлагын хувьд:

- Чили улсад бүртгэлтэй компанид хөрөнгийг шилжүүлсэн байх;
- Доод тал нь 5 сая долларын хөрөнгө оруулалтыг авчирсан байх;
- Гадаадын хөрөнгө оруулагч компанийн Чили улс дахь компанид 10-аас доошгүй хувийг эзэмших зэрэг шаардлагуудыг хуулийн хүрээнд зохицуулсан.

Дээрх хуулийн шаардлагыг хангасан гадаадын хөрөнгө оруулагч нь "InvestChile"-ээс Гадаадын хөрөнгө оруулагчийн гэрчилгээ хүсэж болох бөгөөд ажлын 15 хоногийн дотор шийдвэрлэхээр хуульчилжээ. Тус Гадаадын хөрөнгө оруулагчийн гэрчилгээг эзэмшсэнээр дараах эрхийг эдэлдэг:

- Шилжүүлсэн хөрөнгийг тухайн улс орны хөрөнгө оруулагчид буцаан шилжүүлэх;
- Чилийн хуулиар тогтоосон холбогдох татварын үүргийг биелүүлсний дараа бий болсон ашгийг шилжүүлэх;
- Хуульд заасан зорилгын хүрээнд валютын албан ёсны зах зээлд нэвтрэх;
- Шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхагдахгүй байх;
- Импортоор оруулан ирж буй хөрөнгийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зэрэг эрхүүд хамаардаг.

¹⁵ Law 20.848, New foreign investment regime, 2016, <https://investchile.gob.cl/wp-content/uploads/2017/03/NEW-FOREIGN-INVESTMENT-REGIME.pdf>.

¹⁶ "Regulation for Foreign Investment", RSM, <https://www.rsm.global/chile/en/doing-business-chile/regulation-foreign-investment>, (Сүүлд үзсэн:2025.01.31).



Татварын хувьд 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дөрвөн жилийн хугацаанд гадаадын хөрөнгө оруулагчид "InvestChile" агентлагт хүсэлт гарган татварын тогтворжих байдлын гэрээ байгуулж болох бөгөөд орлогын албан татварын хэмжээг 44.5 хувь байхаар зохицуулжээ.

3.2.2 Олон улсад хөрөнгө оруулалтыг дэмжиж буй татварын бодлогын чиг хандлага

Кени улс нь эдийн засгийн хувьд байгалийн нөөц баялаг ихтэй тул уул уурхай дээр суурилдаг ба Хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуулиар¹⁷ гадаадын хөрөнгө оруулагчдыг дэмжих бодлого баримталдаг. Харин Малайз улсын хувьд газрын тос, байгалийн хийн олборлолт явуулдаг ба эдийн засаг нь аж үйлдвэржилт дээр суурилдаг. Малайз улс нь Хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуулиар¹⁸ гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалдаг. Эдгээр улс орон нь гадаадын хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг тус тусын Хөрөнгө оруулалтыг дэмжих хуулиараа тухайлан үзүүлдэг байна. Хуулиар Хөрөнгө оруулалтын гэрчилгээ олгодог боловч татварын хувь, хэмжээг тогтворжуулах татварын бодлого баримталдаггүй байна.

Перу улсын хувьд татвараа үнэн, зөв тайлагнасан тохиолдолд хөрөнгө оруулагчдад тухайлсан эрх зүйн хамгаалалт, эрхийг хуулиар олгодог. Жишээлбэл, худалдаа, үйлдвэрлэл болон экспорт, импортын эрх чөлөө, гадаад валютыг чөлөөтэй эзэмших, ашиглах баталгаа, зах зээлийн хамгийн таатай валютын ханш, хөрөнгө оруулалтыг чөлөөтэй буцаан экспортлох, дотоодын зээлийг хязгааргүй авах, үндэсний хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй хувьцааг чөлөөтэй худалдан авах эрх зэргүүд орно. Урт хугацааны хөрөнгө оруулалт хийж буй тохиолдолд Перу улсын засгийн газартай хууль, эрх зүйн тогтвортой байдлын гэрээ байгуулах боломжтой¹⁹.

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээгээр сонгон авсан маргааны агуулгын хүрээнд олон улсад татварыг тогтворжуулах байдлаар хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого баримталдаг улс орныг судаллаа. Улс орнууд ихэвчлэн татварыг хөнгөлж, чөлөөлөх байдлаар гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого баримталж байна. Судалгааны үр дүнгээр Чили улс нь Монгол Улсын ХОТХ-д заасантай адил байдлаар татварыг тогтворжуулах асуудлыг хуульчилжээ.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээгээр сонгон авсан УДШ-ийн хяналтын тогтоолоор хуулийн нэгдмэл байдлыг бий болгох ач холбогдол бүхий хэрэг маргааныг хянан хэлэлцсэн байна. Шүүхээс тус маргааны хувьд ХОТХ-д зохицуулсан тогтворжуулах гэрчилгээний эрх зүйн үндсэн шинж чанар болон татварын хувь, хэмжээ, татварын орчин зэрэг хуулийн нэр томъёоны агуулгыг

¹⁷ The Investment Promotion Act, 2009, <https://kenyalaw.org/kl/fileadmin/pdfdownloads/Acts/InvestmentPromotionActCap485B.pdf>.

¹⁸ Promotion of Investments Act, 1986, <https://www.investmalaysia.gov.my/media/f1rpx14/promotions-of-investment-act-1986.pdf>.

¹⁹ "Legal Framework for Investments", Pro inversion, <https://www.investinperu.pe/en/invest/legal-framework-for-investments>, (Сүүлд үзсэн:2025.02.03).



тайлбарлах нөхцөл, шаардлага үүссэн. Ийнхүү эрх зүйн дүгнэлт хийхдээ татварын хувь, хэмжээ гэдэг нь ганцхан татварын хувийг тогтворжуулах бус, татвар ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох аргачлалыг давхар тогтворжуулж байна гэж үзэн нэхэмжлэлийн үндсэн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн юм.

Харин хяналтын шатны шүүх бүрэлдэхүүнээс 2 шүүгч ижил төстэй хэргийг хянан шийдвэрлэхэд хуулийн өрсөлдөх тайлбар байлгах үүднээс тусгай санал гаргажээ. Тусгай саналын үндэслэлд хууль тогтоогчоос тогтворжуулах гэрчилгээ олгох замаар татварын хувь, хэмжээг буюу хувийг тогтворжуулж байгаа бол хөрөнгө оруулалтын гэрээний хувьд татварын орчныг тогтворжуулах зорилгоор байгуулж байна гэж ХОТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан зохицуулалтыг хууль тогтоогчийн үзэл баримтлалтай холбон дүгнэжээ.

Эрх зүйн зохицуулалтаас харвал ХОТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т Тогтворжуулах гэрчилгээгээр гагцхүү татварын хувь, хэмжээг, Хөрөнгө оруулалтын гэрээгээр татварын орчныг тогтворжуулна гэж заажээ. ХОТХ-ийн төслийг хэлэлцэж байх үеийн хувийн хэргээс үзэхэд хууль тогтоогчид татварын хувь, хэмжээг агуулгын хувьд татварын хувь гэж ойлгохоор хэлэлцсэн бол татварын орчин гэх нэр томъёонд татварын хувь болон татвар ногдуулж буй борлуулалтын үнэлгээ тооцох аргачлал бүхэлдээ хамаарна гэж агуулгын хувьд хэлэлцсэн байна.

Хэрэв Тогтворжуулах гэрчилгээгээр татварын хувийг, түүнийг тооцох аргачлалтай давхар тогтворжуулбал Хөрөнгө оруулалтын гэрээ болон Тогтворжуулах гэрээг ялгамжтай хуульчилсан хууль тогтоогчийн үзэл санаа үгүйсгэгдэх нөхцөл байдал үүсэж болох юм. Дотоодын судлаачдын бүтээлээс үзвэл татварын хувь, хэмжээ гэдэг нь АМНАТ-ийн хувийг, татвар ногдуулах нэгж (суурь) нь АМНАТ-ийг тооцоолох аргачлалыг тус тус ойлгохоор байна. Мөн хөрөнгө оруулалтыг татах зорилгоор татварыг тогтворжуулж буй гадаадын улс орон цөөн байгааг дурдах нь зүйтэй бөгөөд ихэвчлэн татварыг хөнгөлөх, чөлөөлөх болон хуулиар эдийн засгийн харилцаанд эрх олгох замаар хөрөнгө оруулалтыг татаж байна.

Шүүхийн зүгээс аливаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хууль тайлбарлах аргуудаас хамгийн тохиромжтой, зохистой аргыг хэрэглэдэг. Хууль тайлбарлах ямар аргыг хэрэглэснээс шалтгаалан хэргийн шийдвэр өөр өөрөөр гарах боломжтой гэдгийг энэхүү хяналтын шатны шүүхийн тогтоол болон бусад шүүгчийн гаргасан тусгай саналаас харж болох юм. Дүн шинжилгээний хүрээнд хуулийн хэм хэмжээг анх батлан гаргах үеийн хууль тогтоогчийн үзэл баримтлалыг тодруулан судлах замаар хэргийн үйл баримттай холбож дүгнэлт хийсэн болно.



НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж:

1. Үндсэн хууль, 1992 он.
2. Ашигт малтмалын тухай хууль, 2006 он.
3. Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 он.
4. Татварын ерөнхий хууль, 2019 он.
5. Шүүхийн тухай хууль, 2021 он.
6. Чилийн Бүгд Найрамдах Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль 2016 он.
7. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 243 дугаар шийдвэр.
8. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 334 дүгээр магадлал.
9. УДШ-ийн 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 001/ХТ2024/0090 дугаар тогтоол.
10. Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны тусгай санал, 2024.10.07, Дугаар 05.

Б. Ном сурах бичиг

1. П.Одгэрэл, *Татварын эрх зүй*, 2021 он.
2. Р.Оюундэлгэр, "Улсын дээд шүүхийн хууль тайлбарлах бүрэн эрхийг Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалын үүднээс шинжлэх нь", *legaldata.mn*, 2023 он.

2. Цахим эх сурвалж:

1. "Legal Framework for Investments", Pro inversion, <https://www.investinperu.pe/en/invest/legal-framework-for-investments>
2. "Regulation for Foreign Investment", RSM, <https://www.rsm.global/chile/en/doing-business-chile/regulation-foreign-investment>.

**"ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ГАРГАСАН
ЗӨРЧИЛДӨӨ ШУУД САНААТАЙ, ЭСХҮЛ
ИЛТЭД БОЛГООМЖГҮЙ ГЭМ БУРУУТАЙ БОЛ
ХУУЛЬД ЗААСАН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ"-ТЭЙ
ХОЛБООТОЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН
ДҮН ШИНЖИЛГЭЭ**

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ДЭРГЭДЭХ
ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ¹

¹ Энэхүү дүн шинжилгээг Шүүхийн академийн судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн (Ph.D) удирдаж, Иргэний эрх зүйн секторын судлаач Г.Амаржаргал хийж гүйцэтгэв.



УДИРТГАЛ

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хийхдээ Улсын дээд шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 001/ХТ2024/00029 дугаар тогтоолыг сонгон авав. Тус шийдвэрийг шүүхийн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг дэмжих, цаашид төсөөтэй хэргүүдийг хянан шийдвэрлэхэд эрх зүйн тогтвортой байдлыг хангах болон хуулийн зохицуулалт дахь зарим тодорхойгүй байдлыг тодорхойлон гаргахад ач холбогдолтой гэх үндэслэлээр сонгосон болно.

Энэхүү дүн шинжилгээ нь шүүхийн шийдвэрийн танилцуулах хэсэг, шийдвэрлэсэн байдал, дүн шинжилгээ, дүгнэлт хэсгээс бүрдэнэ. Шүүхийн шийдвэрийн **танилцуулах хэсэг** нь шүүхийн шийдвэрийн дугаар, шийдвэрийн төлөв, хэргийн тухай товч гэсэн дэд хэсгүүдийг агуулах бол **шийдвэрлэсэн байдал хэсэгт** анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрийг товчлон дурдав. Харин **дүн шинжилгээ хэсэгт** эрх зүйн зохицуулалт болон онолын ойлголт, төсөөтэй шүүхийн шийдвэр, гадаадын зарим улсын (Гүрж, ХБНГУ болон Япон) эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судаллаа. **Дүгнэлт хэсгээр** сонгон авсан шүүхийн шийдлийн үндэслэлд дүгнэлт өгнө.

НЭГ. ТАНИЛЦУУЛАХ ХЭСЭГ

Шүүхийн шийдвэрийн дугаар: УДШ-ийн 001/ХТ2024/00029 дүгээр тогтоол¹

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны магадлалд өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн.

Хэргийн тухай товч

Нэхэмжлэгч Завхан аймгийн прокурорын газар нь хариуцагч А.Д-д холбогдуулан түүний хууль бус шийдвэрийн улмаас төрд учруулсан хохиролд 15,744,144 төгрөг гаргуулах нэхэмжлэлийн шаардлага гаргасан ба үндэслэлээ "... А.Д нь Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газар (цаашид "МХГ" гэх)-ын даргаар ажиллаж байхдаа жолооч С.Г-г 2019.05.13-ны өдрийн Б/20 дугаартай тушаалаар сахилгын шийтгэл ногдуулж ажлаас халсныг шүүхийн шийдвэрээр буруу гэж үзэж, ажилд нь эгүүлэн тогтоож ажилгүй байсан хугацааны олговор гаргуулахаар шийдвэрлэж, нийт 15,744,144 төгрөгийг С.Г-д олгосон тул үүнийг гаргуулах" гэснийг хариуцагч эс зөвшөөрч "... ажлаас чөлөөлөх шийдвэрийг хууль зүйн үндэслэлгүй гаргасан нь буруутай боловч өөрийн шийдвэр үйл ажиллагаатай холбоогүйгээр учирсан хохирлыг хариуцахгүй, өөрөөр хэлбэл ажилд эгүүлэн томилох боломжгүй нөхцөл байдлууд үүссэн, мөн хэргийг шийдвэрлэх хүртэлх хугацаа нь хохирлын хэмжээнд нөлөөлсөн тул хариуцахыг зөвшөөрөхгүй. Миний бие А.Д-д шүүхээс МХГ-ын даргын албан үүргээс түдгэлзүүлсэн шийдвэр гарсан байснаас үүдэн маргааныг шийдвэрлэж чадаагүй. Иймд нэхэмжлэлийн зарим хэсгийг зөвшөөрнө" гэж тус

¹ Шүүхийн шийдвэрийг дэлгэрэнгүй үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/10428?daterange=2024-01-01%20-%202024-08-29&id=3&court_cat=1&bb=1



тус маргажээ.

ХОЁР. ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Анхан шатны шүүх: "... Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрүүдээр С.Г-д нийт 15,744,144 төгрөг олгохоор шийдвэрлэсний дагуу тухайн шийдвэр нь биелэгдсэн байх тул төрд учирсан хохирлыг тухайн шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтан болох А.Д-с гаргуулах үндэслэлтэй. Тухайн цаг хугацаанд С.Г-н гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайг шүүхээр тогтоосон нь хариуцагч А.Д-н төрд учруулсан хохирлоос 2,281,305 төгрөгийг хасаж тооцох үндэслэл байхгүй..." хэмээн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.

Давж заалдах шатны шүүх²: "...Хариуцагч А.Д-н хууль бус шийдвэрийн улмаас төрд 15,744,144 төгрөгийн хохирол учирсан байна. С.Г-н ажилд эгүүлэн тогтоож, ажилгүй байсан хугацааны цалин нөхөх олговор гаргуулахаар шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох цаг хугацаанд МХГ-ын даргын үүргийг гүйцэтгэж байсан Н.О нь шүүхийн шийдвэрийг биелүүлж С.Г-г ажилд нь эгүүлэн авсан нь төрд учирсан хохирлын хэмжээ нэмэгдэхэд нөлөөлөөгүй байна" гэсэн дүгнэлт хийж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүхээс дараах байдлаар тайлбарлан, шийдвэрлэжээ.

1. Иргэний хууль (цаашид "ИХ" гэх)-ийн 498 дугаар зүйлийн 498.2-т төрийн албан хаагчийн албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад учруулсан хохирлыг төр хариуцан арилгасан тохиолдолд мөн хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д зааснаар өөрт учирсан хохирлыг буруутай этгээдээс шаардан гаргуулахад гэм буруутай этгээдийн гэм буруугийн хэлбэр, хэр хэмжээ, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг гэм хорын хохирлыг тооцоход харгалзан үзэх эсэх буюу холбогдох хуулийн зохицуулалтыг хоёр шатны шүүх зөв тайлбарлан хэрэглэсэн эсэх талаар хяналтын шатны шүүх дүгнэлт өгөх нь зүйтэй гэж үзсэн байна. (11)³
2. Албан тушаалтны буюу хариуцагчийн хариуцлага хүлээх үндэслэл нь ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5-д зааснаар тодорхойлогдох бөгөөд энэ хуулийг хэрэглэх талаар Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны 2023.09.19-ний өдрийн 001/ХТ2023/00157 дугаартай тогтоол⁴-д тайлбарласнаар авч үзэх нь зүйтэй. Энэ нь "ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5-д ажилтнаас шаардах эрхийн бүрэлдэхүүн буюу урьдчилсан нөхцөлд гэм буруугийн бүх хэлбэрийг бус тодорхой хэлбэрийг дурдан "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт

² Завхан аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 205/МА2023/00039 дүгээр магадлал, https://shuukh.mn/single_case/28728?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1.

³ "Шийдвэрлэсэн байдал" хэсэгт бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

⁴ Улсын дээд шүүхийн 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 001/ХТ2023/00157 дугаар тогтоол, https://shuukh.mn/single_case/10349?daterange=2023-09-19%20-%202023-09-19&id=3&court_cat=1&bb=1.



учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" гэж заасан. Үүнийг Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт зөрчил гаргасан этгээд уг зөрчилд гэм буруутай байхыг шаардсантай уялдуулан тайлбарлахад төрийн албан хаагч гаргасан зөрчилдөө шууд санаатай, эсхүл илтэд болгоомжгүй гэм буруутай бол тус хуульд заасан хариуцлага хүлээнэ" гэжээ. Гэтэл хоёр шатны шүүх гэм хорын хохирлын хэмжээ нь бүхэлдээ хариуцагчийн гэм буруутай үйлдлээс шалтгаалсан гэж үзсэн нь дээрх хуулиудад нийцээгүй, гэм бурууд хамаарах шалтгаант холбоо, гэм буруугийн хэлбэр, хэр хэмжээг зөв тогтоож чадаагүй, хэргийн нөхцөл байдлыг харгалзан үзээгүй байна. (15)

3. Хариуцагч нь ажилтныг ажлаас буруу халсан гэм буруутай үйлдлийн улмаас төрөөс уг ажилтанд ажилгүй байсан хугацааны олговрыг нөхөн төлсөн байх боловч гэм хорын хохирлын хэмжээ нэмэгдэхэд хариуцагчийн шууд санаатай буруутай үйлдлээс шалтгаалаагүй зарим нөхцөл байдал тогтоогджээ. Хариуцагч А.Д нь жолооч С.Г-г ажлаас халсан нь буруу болохыг тогтоосон шүүхийн шийдвэр 2021.06.02-ны өдөр хуулийн хүчин төгөлдөр болсон ба энэ хугацаанд 2021.03.30-ны өдрөөс 2021.05.25-ны өдөр хүртэл С.Г нь цагдан хоригдож байсан, мөн 2021.06.14-ний өдрөөс хойш хариуцагч нь ажил үүргээ гүйцэтгээгүй болох нь тогтоогдсон. Иймээс дээрх хугацаанд хариуцагчаас өөрөөс нь шалтгаалахгүйгээр С.Г-ыг ажилд эгүүлэн томилох боломжгүй нөхцөл байдал үүссэн байсан тул 2021.03.30-ны өдрөөс С.Г-ыг ажилд нь эгүүлэн томилсон 2021.07.26-ны өдрийг хүртэл хугацааны олговрыг хариуцагч төлөх үндэслэлгүй, энэ хугацаанд учирсан гэм хорын хохирол нь хариуцагчийн гэм буруутай үйлдэлтэй шалтгаант холбоогүй байх тул гэм хорын хохирлоос 2,224,716 төгрөгийг нэхэмжлэлээс хасаж тооцох үндэслэлтэй.

Дээрх дүгнэлтийг үндэслэн, хяналтын шатны шүүхээс ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь зохицуулалтыг хоёр шатны шүүх зөв тайлбарлан хэрэглэж чадаагүй гэж үзэн анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны магадлалд өөрчлөлт оруулан хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэжээ.

ГУРАВ. ДҮН ШИНЖИЛГЭЭ

ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.2-т зааснаар төрийн албан хаагчийн албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад учруулсан хохирлыг төр хариуцан арилгана. Төр ийнхүү өөрт учирсан хохирлыг мөн хуулийн 498.5-аар буруутай этгээдээс шаардан гаргуулахад Төрийн албаны тухай хууль (цаашид "ТатХ" гэх)-ийн 50.1-т *"Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ"* гэх зохицуулалтыг хэрэглэх,



мөн гэм буруутай этгээдийн гэм буруугийн хэлбэр, хэр хэмжээ, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг харгалзан үзэх талаар шүүх голлон дүгнэлт өгчээ.

"Гэм хорын хохирол нь хариуцагчийн гэм буруутай үйлдэлтэй шалтгаант холбоогүй бол хариуцлага хүлээхгүй" гэх агуулга бүхий гэм буруугүй бол хариуцлага хүлээхгүй байх зарчим нь төр гэм хорыг хариуцан арилгасныхаа дараагаар учирсан хохирлоо шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан төрийн албан хаагчаас шаардан гаргуулж байгаатай нийцэх эсэх, мөн хэрхэн уялдах талаар авч үзэх шаардлага үүсэж байна. Өөрөөр хэлбэл хуульд зааснаар төр нь төрийн албан хаагчийн ажиллаж байгаа хуулийн этгээд буюу ажил олгогч болохынхоо хувьд өөрийн ажилтны учруулсан гэм хорыг хариуцаж байгаа нь өөрийн гэм буруутай үйлдлийн улмаас эсхүл бусдын өмнөөс хариуцлага хүлээж байгаа эсэхийг тодорхойлох нь зүйтэй. Мөн ИХ-ийн 498.5 дахь зохицуулалтаар "... 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд..." хэмээн хувийн болон нийтийн эрх зүйн субъектүүдийг нэгтгэн зохицуулсан хэдий ч дээрх шүүхийн шийдвэрээр хэргийн оролцогч талуудаас хамааран Төрийн албаны тухай хуулийн зохицуулалттай уялдуулан тайлбарласныг тус тус үндэслэн үүсэх хууль хэрэглээний асуудал, цаашлаад эдгээр асуудлуудтай холбоотой эрх зүйн зохицуулалт, онолын ойлголт, судлаачдын байр суурь, адил төстэй маргааныг шийдвэрлэж буй дотоодын шүүхийн практикийг судлан, дүгнэлт өгөхөд энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний зорилго оршино.

3.1 Эрх зүйн зохицуулалт болон онолын ойлголт

ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5-д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" хэмээн ажилтан, төрийн албан хаагч, мөрдөгч, прокурор, шүүгчийг, өөрөөр хэлбэл хувийн болон нийтийн эрх зүйн субъектүүдийг хамтатган, зөвхөн "шууд санаатай буюу илтэд болгоомжгүй" гэм буруугийн хэлбэрийн хязгаарлалтыг тогтоон хуульчилсан байна. Мөн уг зохицуулалтаар ажил олгогч болон ажиллуулж байгаа хуулийн этгээд буюу төрийг хамтатган гэм хорыг арилгасан байгууллага гэх байдлаар хуульчилжээ. Иймд юун түрүүнд ИХ-ийн 498 дугаар зүйл дэх ажил олгогчийн хариуцлага хүлээж буй үндэслэл болоод гэм буруугийн хэлбэрийн талаарх судлаачдын тодорхойлолт, байр суурийг авч үзэх нь зүйтэй хэмээн үзлээ.

Зарим судлаачдын хувьд ажил олгогчийн хүлээж буй хариуцлагыг өөрийн гэм буруугийн үүднээс бус, бусдын буюу ажилтныхаа өмнөөс хүлээх хариуцлагад хамаатуулах байдлаар тайлбарласан нь бий. Тухайлбал судлаач Ж.Оюунтунгалаг энэ талаар "... бусдын өмнөөс хүлээх хариуцлагын хувьд Монгол улс нь 1952 оны ИХ-аар албан тушаалтны учруулсан гэм хорыг байгууллага хариуцах, 1963 оны ИХ-аар ажилчин, албан хаагчдын учруулсан гэм хорыг байгууллага хариуцах, 1994 оны хуулиар бусдын өмнөөс хүлээх хариуцлага дээр нэмэгдэж хуулийн этгээдийн ажилтны өмнөөс хүлээх хариуцлага, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурорын байгууллагын албан тушаалтны үйл ажиллагаанаас учирсан хохирлыг арилгах зэрэг төрлүүд нэмэгдсэн байдаг. 2002 оны ИХ-д "бусдын өмнөөс үүрэг хүлээх" үндэслэлүүд нэмэгдээгүй бөгөөд харин илүү тодорхой



болгон найруулагдсан шинжтэй байдаг⁵" хэмээн тодорхойлсон байна.

Р.Пүрэвбаатар судлаачийн хувьд: "Ажил олгогч нь өөрийн гэм буруутай үйлдлийн улмаас 498-р зүйлийн 498.1 дэх хэсгийн дагуу хариуцлага хүлээдэггүй бөгөөд бусдын үйлдэл /эс үйлдэхүй/-ийн өмнөөс хариуцлага хүлээдэг /vicarious liability, liability for the acts of others/ гэж тайлбарлах боломжтой байна. Энэ нь Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.1 дэх хэсгийн зохицуулалтыг гэм буруу гэх урьдчилсан нөхцөлийг ашиглалгүйгээр хариуцлага хүлээлгэх зарчимд суурилсан хэм хэмжээ болохыг нь бүрэн илтгэнэ. Гэм бурууг үндэслэхгүйгээр хариуцлага хүлээлгэх зарчмын хүрээнд авч үзвэл ажил олгогч /байгууллага/ нь тухайн ажилтны үйл ажиллагааны үр дүнд ашиг олж байгаа учраас хариуцлага хүлээх шаардлагатай гэх үндэслэл, эсхүл ажил олгогч /байгууллага/ нь ажиллагсадтай харьцуулахад хохирлыг нөхөн төлөх боломж, бололцоо ихтэй гэх үндэслэл, гэм бурууг үндэслэхгүйгээр хариуцлага хүлээлгэх зарчимд тулгуурласан нь хохирогчийн хувьд нотолгооны хувьд илүү хялбар нөхцөл байдлыг бий болгодог гэх бодлогын шинжтэй үндэслэл зэргийг энд дурдаж болно⁶" гэж тайлбарлажээ.

Харин зарим судлаачид дээрхээс өөрөөр буюу ажил олгогч нь өөрийн гэм бурууг үндэслэн хариуцлага хүлээж байгаа гэх байдлаар: "Иргэний хуулийн 498 дугаар зүйлээр хариуцлага хүлээж буй үндэслэл нь ажилтныг сонгох, ажилд нь хяналт тавихдаа алдаа гаргасан гэж үзнэ. Үүгээрээ бусдын гэм бурууг бус өөрийн гэм бурууг хариуцаж байгаа юм⁷"; "Ажилтан, албан тушаалтан бусдад учруулсан гэм хорыг түүний ажилладаг хуулийн этгээд, албан байгууллага хариуцаж байгаа нь тухайн ажилтан, албан тушаалтны гэм буруугийн төлөө биш, өөрийн гэм буруугийн төлөө хариуцлага хүлээдэг. Энэ нь ажилтан, албан тушаалтныг зөв шилж аваагүй буюу сонгоогүй, тэдэнд мэдлэг, мэргэжлийн үүрэгт ажилтай холбоотой ёс суртахуун, соёл хүмүүжлийн талаар сургалт хийдэггүй, хийсэн боловч зохих шаардлагын хэмжээнд хүрээгүй гэх мэт өөрийн гэм буруугийн төлөө хариуцлага хүлээж байгаа юм⁸"; "Ажилтны учруулсан гэм хорыг арилгах үүргийг ажил олгогчид хуулиар ногдуулсан байгаа нь ажил олгогч нь ажилтныхаа хөдөлмөрлөх явцыг холбогдох хууль тогтоомж, заавар журмын үндсэн дээр хянах үүргээ зохих ёсоор биелүүлээгүй гэм буруутай гэж үзэж байгаатай холбоотой юм⁹" зэрэг тайлбаруудыг хийсэн байна.

Дээрхээс үзвэл ажил олгогч нь ажилтны учруулсан гэм хорыг хариуцахдаа өөрийн эсхүл бусдын гэм бурууг хариуцаж байгааг судлаачид өөр хоорондоо ялгаатай байдлаар тайлбарласан буюу нэгдсэн ойлголтод хүрээгүй байна хэмээн дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл ихэнх судлаачид зөвхөн өөрийн гэм буруутай үйлдлийн улмаас хариуцлага хүлээнэ, хэн нэгний үйлдлийн өмнөөс хариуцлага хүлээхгүй гэж үздэг бол зарим судлаачид бусдын үйлдлийн өмнөөс

⁵ Ж.Оюунтунгалаг, "Гэм хорын тусгай төрөл: Эзэмшигчийн хариуцлага", *legaldata.mn*, 2017, 2 дахь тал, (Сүүлд үзсэн: 2025.01.16)

⁶ Р.Пүрэвбаатар, "Иргэний хуулийн 498-р зүйлийн талаар судлах нь: Харьцуулалт, дүгнэлт", *Хууль дээдлэх ёс*, 81.

⁷ Д.Янжинхорлоо, *Иргэний эрх зүйн үндсэн асуудал, үүргийн гүйцэтгэлийг хангах эрх зүй*, 2017, 150 дахь тал.

⁸ Т.Мөнхжаргал, *Монгол Улсын Иргэний эрх зүй Үүргийн тусгай төрөл*, 2015, 219 дэх тал.

⁹ Монгол Улсын дээд шүүх, *Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг IV)*, 2016, 57–58 дахь тал



хариуцлага хүлээх боломжтой гэж үздэг ба энэ нь гэм бурууг үндэслэхгүйгээр хариуцлага хүлээлгэх зарчимд суурилсан хэм хэмжээний нэг төрөлд хамаарна гэж тайлбарлаж байна. Хэрэв ИХ-ын 498 дугаар зүйлийг бусдын өмнөөс хариуцлага хүлээх ойлголтод хамаарна хэмээн тайлбарласан тохиолдолд ажил олгогч нь өөрийн үйлдлийн улмаас бий болсон хохирлыг бус ажилтны бусдад учруулсан хохирлыг түүний оронд гуравдагч этгээдэд нөхөн төлөх үүрэг хүлээх тул дараа нь ажилтнаасаа 498.5 дахь хэсгийн дагуу хохирлоо шаардах боломжтой байх нь тодорхой гэж дүгнэж болох юм. Өөрөөр хэлбэл ИХ-ын 498.5 дахь хэсгийг тайлбарлахад ажил олгогч бусдын өмнөөс эсхүл өөрийн буруугийн улмаас хариуцлага хүлээж байгаа гэж үзэх эсэх нь ихээхэн ач холбогдолтой байна.

3.2. Төсөөтэй шүүхийн шийдвэр

Дүн шинжилгээний энэхүү хэсэгт дээрх үндсэн тогтоолын хянавал хэсэгт эшлэн тайлбарласан, мөн хэргийн үйл баримт болон эрх зүйн асуудалтай холбоотой адил төстэй хэрэг гэх үндэслэлээр дараах тогтоолын үндэслэлийг тодруулан авч үзье.

Улсын дээд шүүхийн 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 001/ХТ2023/00157 дугаар тогтоол¹⁰:

Хэргийн тухай товч:

Нэхэмжлэгч Монгол Улсын ерөнхий прокурорын газар (цаашид "МУЕПГ" гэх), Төрийн албаны зөвлөл (цаашид "ТАЗ" гэх) нар нь хариуцагч Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "СЗХ" гэх)-ны даргаар ажиллаж байсан С.Д-д холбогдуулан гэм хорын хохиролд 29,226,227 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийг гаргасан ба нэхэмжлэгч МУЕПГ нь нэхэмжлэлийн үндэслэлээ "С.Д нь 2018.07.06-нд Т.Ж-ын албан тушаалыг бууруулж, өөр албан тушаалд томилсон ба үүний дараагаар тус хорооны Ажлын албаны даргын 2018.12.19-ны тушаалаар Т.Ж-г үүрэгт ажлаас нь чөлөөлсөн. Т.Ж холбогдох тушаалуудыг эс зөвшөөрч шүүхээр марган түүнийг ажилд нь эгүүлэн тогтоосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон ба шийдвэрт 2018.07.06-ны өдрөөс 2019.12.03-ны өдрийг хүртэлх хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговорт 29,226,227 төгрөгийг СЗХ-ноос гаргуулан Т.Ж-д олгохоор заасан бөгөөд тус шүүхийн шийдвэр биелэгдсэн.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 103.3, 103.1, ИХ-ийн 497.1, 498.2, 498.5-д зааснаар 29,226,227 төгрөгийг С.Д-ээс гаргуулна." гэж, нэхэмжлэгч ТАЗ-ийн хувьд нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ "... Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсгийг үндэслэн тухайн үед ажиллаж байсан, уг тушаалыг гаргасан буруутай албан тушаалтан нь С.Д тул түүнээс 29,226,227 төгрөгийг гаргуулж төрийг хохиролгүй болгох үндэстэй" гэж тус тус тайлбарлажээ. Харин хариуцагч С.Д нь нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь эс зөвшөөрч, "... ИХ-ийн 498.5-д заасан гэм буруугийн илтэд болгоомжгүй хэлбэр нь гэм хорын ерөнхий зохицуулалтын үндсэн бүрэлдэхүүний нэг болох болгоомжгүй хэлбэрээс

¹⁰ УДШ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 001/ХТ2023/00157 дугаар тогтоол, https://shuukh.mn/single_case/10349?daterange=2023-09-19%20-%202023-09-19&id=3&court_cat=1&bb=1



ялгаатай. ... Тушаалыг чиг үүргийнхээ дагуу гаргасан тул шууд санаатай, эсхүл илтэд болгоомжгүй үйлдлээрээ хохирол учруулсан гэх үндэслэл үгүй. Шүүхээс тус албан тушаал бууруулсан тушаалыг хууль бус болохыг тогтооно гэдгийг урьдчилан харах боломжгүй. Захиргааны хэргийн шүүх хэргийг шийдвэрлэх үед миний бие СЗХ-ны даргын албан тушаалаас чөлөөлөгдсөн байсан тул шүүхийн шийдвэрийг давж заалдах боломж олгогдоогүй. Мөн Т.Ж-д цалин хөлс авч ажиллах боломжтой албан тушаалд томилогдсон ч ажиллахаас татгалзсан эс үйлдэхүй нь хохирлын хэмжээ өсөхөд шууд нөлөөлсөн" гэж маргасан.

Анхан шатны шүүх: Үндсэн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэхдээ "... хууль бус тушаал, шийдвэр гаргасан хариуцагчийн гэм буруу тогтоогдсон тул үүдэн гарсан хохирлыг хариуцан арилгана, ... С.Д-н 2018.07.06-ны өдөр гаргасан Албан тушаал бууруулах тухай тушаал нь хууль зөрчсөн эсэх асуудлыг шүүхээс хянан шийдвэрлэж байх явцад буюу 2018.12.19-ний өдөр Ажлаас халах тухай тушаал гарсан. Уг тушаалыг хариуцагч С.Д гаргаагүй. ... 2018.07.06-ны өдрөөс 2018.12.19-ний өдрийг хүртэлх ажилгүй байсан хугацаанд хамаарах хохирлын хэмжээ 9,306,675 төгрөгийг гаргуулах нь Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.3-т нийцнэ" гэж дүгнэжээ.

Давж заалдах шатны шүүх: Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгохдоо "... ЗЕХ-ийн 103.3-т заасан нэхэмжлэл нь ерөнхий гэм хор буюу иргэн, хуулийн этгээдэд нөхөн төлсөн хохирлын тухайд яригдаж байх тул төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаанд хамаарахгүй. Нийтлэг зохицуулалт болох ИХ-ийн 497, 510 дахь заалтыг баримталсан анхан шатны шүүхийн дүгнэлт буруу, ... Төрийн албаны тухай хуулийн 50.1 дэх хэсгээр төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх тухай заасан. ... СЗХ-ны даргын тушаал нь ажлаас халах, чөлөөлөх бус албан тушаал бууруулах агуулгатай тул дээрх тохиолдолд хамаарахгүй, өөрөөр хэлбэл ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт заасан үндэслэл тогтоогдохгүй байх тул нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох нь зүйтэй" гэж дүгнэсэн.

Улсын дээд шүүх: Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр заасан.

ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт иргэний эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдвал зохих эрх, хууль ёсны ашиг сонирхлын төрлийг тодорхойлсноороо нийтлэг зохицуулалт болох хэдий ч зөрчил гаргасан этгээд зайлшгүй гэм буруутай байхыг шаарддагаараа энэ шаардлагыг тавьдаггүй тусгай зөрчлүүдээс ялгаатай. Өөрөөр хэлбэл, ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.2-т "гэм хор учруулсан этгээд ийнхүү гэм хор учруулсан нь түүний буруугаас болоогүй гэдгийг нотолбол хуульд зааснаас бусад тохиолдолд гэм хор учруулсны хариуцлагаас чөлөөлөгдөнө." гэж зааснаас үзвэл энэ зүйлд хамаарах зөрчлийн бүрэлдэхүүнд



гэм буруугийн аль нэг хэлбэрийг заавал шаардаж байгаагаараа нийтлэг бус, нарийвчилсан зохицуулалт болдог онцлогтой.

ИХ-ийн 498 дугаар зүйл нь албан хаагч, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажилтнуудын бусдад учруулсан хохирлыг хэрхэн арилгахтай холбоотой харилцааг зохицуулсан тусгай хэм хэмжээ бөгөөд мөн зүйлийн 498.5 дахь хэсэг нь ажилтны бусдад учруулсан хохирлыг арилгасан ажил олгогч ажилтнаасаа буцаан шаардах харилцаанд үйлчилнэ. Ийнхүү ажилтнаас шаардах эрхийн бүрэлдэхүүн буюу урьдчилсан нөхцөлд гэм буруугийн бүх хэлбэрийг бус, тодорхой хэлбэрийг дурдан "...шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр..." гэж заасан байна. Иймд Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт зөрчил гаргасан этгээд уг зөрчилд гэм буруутай байхыг шаардсаныг Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь хэсэгтэй уялдуулан тайлбарлах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч гаргасан зөрчилдөө шууд санаатай, эсхүл илтэд болгоомжгүй гэм буруутай бол тус хуульд заасан хариуцлага хүлээнэ. (13)

С.Д-г төрийн эрх бүхий албан тушаалтан бүр мэдэх, сахин биелүүлэх боломжтой анхан шатны шинжтэй захиргааны акт гаргахын өмнө хийгдэх процессын хэм хэмжээний хэрэглээний асуудалд илтэд хайхрамжгүй хандан хууль зөрчин захиргааны акт гаргасанд Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д заасан "буруутай", тодруулбал Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д заасан "илтэд болгоомжгүй" хэлбэрийн гэм буруутай гэж үзэв. Иймд төрийн албан хаагчийн илтэд болгоомжгүй үйлдлийн улмаас бусдад учирсан хохирлыг төр хариуцан арилгасан бол энэ хохирлыг буруутай этгээдээс нэхэмжлэх боломжтой.

Хариуцагч С.Д-ийн төрд учруулсан хохирлын хэмжээг 9,306,675 төгрөгөөр тогтоосон анхан шатны шүүхийн дүгнэлт зөв. Учир нь хариуцагч С.Д нь 2018.07.06-ны өдөр албан тушаал бууруулах тушаал гаргасан бөгөөд Т.Ж-ыг ажлаас халах шийдвэрийг хариуцагч гаргаагүй байх тул 2018.07.06-ны өдрөөс 2018.12.19-ний өдрийг хүртэлх ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговор болох 9,306,675 төгрөгөөр хохирлын хэмжээг тодорхойлно.

Түүнчлэн тус хэрэг маргаанд МҮЕПГ, ТАЗ нь тус тус нэхэмжлэгчээр оролцож байх боловч эдгээрийн нэхэмжлэгч байх эрх зүйн үндсийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар нарийвчлан зохицуулах тул эдгээр байгууллага нь тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т заасан этгээд байна. Ажилтны учруулсан хохирлыг хуульд заасан журмын дагуу арилгасан ажил олгогч-төрийн байгууллага болох СЗХ нь гэм хорыг шаардах эрхтэй этгээд тул дээр дурдсан хохирлын мөнгөн дүнг төлөөлөн нэхэмжлэл гаргасан МҮЕПГ, ТАЗ-д бус СЗХ-нд олгох нь зүйтэй гэж шийдвэрлэсэн.

Уг шүүхийн шийдвэрээс үзвэл ИХ-ийн 498 дугаар зүйлийг албан хаагч, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажилтнуудын бусдад учруулсан хохирлыг хэрхэн арилгахтай холбоотой харилцааг зохицуулсан тусгай хэм хэмжээ хэмээн тодорхойлоод, 498.5 дахь хэсгийн дагуу шаардах эрхийн урьдчилсан нөхцөлд гэм буруугийн бүх хэлбэрийг бус, тодорхой хэлбэрийг дурдан "шууд санаатай болон илтэд болгоомжгүй үйлдлээр" гэж заасан талаар тодорхойлсон байна.



Мөн ТатХ-ийн 50.1 дэх хэсэгт зөрчил гаргасан этгээд гэм буруутай байхыг шаардсаныг үүнтэй холбох замаар буюу төрийн албан хаагч гаргасан зөрчилдөө шууд санаатай, эсхүл илтэд болгоомжгүй гэм буруутай бол тус хуульд заасан хариуцлага хүлээх талаар дүгнэж шийдвэрлэжээ. Ийнхүү ЗЕХ-д зааснаар тухайн төрийн албан хаагч нь мэдвэл зохих процессын шаардлагыг эс биелүүлсэн үйлдэлдээ илтэд болгоомжгүй гэм буруугийн хэлбэр тогтоогдсон хэмээн шүүхээс үзжээ.

3.3. Гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт

Харьцуулсан судалгааны хүрээнд Монгол Улсын 2002 оны ИХ-ийн 498 дугаар зүйлийн зохицуулалтыг батлахад тодорхой нөлөө үзүүлсэн болон дүн шинжилгээгээр голлон хөндөгдөж буй зохицуулалт болох ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь хэсэгтэй төсөөтэй зохицуулалт агуулсан зэргийг үндэслэн Гүрж, ХБНГУ болон Япон улсын эрх зүйн зохицуулалтыг сонгон авч судаллаа.

3.3.1. Бүгд Найрамдах Гүрж Улс

Гүрж улсын ИХ-ийн 1005-р зүйлийн 1005.1 дэх хэсэгт "Аливаа төрийн албан хаагч өөрийн албаны үүргийг зөрчиж, санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр бусдад гэм хор учруулсан бол хохирогчид учирсан хохирлыг төр буюу өөрийн ажиллаж байгаа байгууллагатайгаа хамтран нөхөн төлөх үүрэг хүлээнэ"¹¹ гэж "санаатай буюу илтэд болгоомжгүй" үйлдлээр бусдад гэм хор учруулсан тохиолдолд л зөвхөн төр, төрийн байгууллага өөрийн албан хаагчийн бусдад учруулсан гэм хорыг хамтран хариуцахаар хуульчилсан нь ихээхэн онцлогтой байна.

3.3.2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)

ХБНГУ-ын ИХ¹²-ийн 839-р зүйлийн 839.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч нь гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн албан тушаалын үүргээ санаатай буюу болгоомжгүй гэм буруутайгаар зөрчсөн тохиолдолд төрийн албан хаагч нь гуравдагч этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ. Төрийн албан хаагч нь болгоомжгүй гэм буруутайн улмаас хариуцлага хүлээхээр болсон тохиолдолд хохирогч нь бусад аргаар хохирлыг нөхөн төлүүлэх боломжгүй гэж үзсэн бол төрийн албан хаагч нь хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээнэ" хэмээн зөвхөн төрийн албан хаагчийн талаар зохицуулжээ. Уг зохицуулалтын хоёр дахь өгүүлбэрт дурдагдсан **бусад арга гэдэгт** төр хохирлыг хариуцан арилгах үүрэг хүлээх боломжтойг хамаатуулан ойлгож болохоор байна. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагч болгоомжгүй гэм буруугийн хэлбэрээр гуравдагч этгээдэд хохирол учруулсан тохиолдолд эхний ээлжид төрийн албан хаагчаар хохирлыг нөхөн төлүүлэхээс бусад аргыг ашиглахыг зорих юм.

¹¹ Civil Code of Georgia (1997), <https://matsne.gov.ge/document/download/31702/75/en/pdf>. (Сүүлд үзсэн: 2025,01,16)

¹² German Civil Code (BGB), 2002, https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/englisch_bgb.html#p4249



Мөн ХБНГУ-ын Үндсэн хууль¹³-ийн 34-р зүйлд "Аливаа төрийн албан хаагч нь гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн албан үүргээ зөрчсөн тохиолдолд зарчим ёсоор тухайн этгээдийг ажиллуулдаг төр эсхүл байгууллага хариуцлага хүлээнэ. Санаатай эсхүл илт болгоомжгүй гэм буруутай тохиолдолд өөрт учирсан хохирлоо тухайн этгээдээс шаардах явдлыг хориглохгүй. Хохирол нөхөн төлүүлэхээр болон өөрт учирсан хохирлоо тухайн этгээдээс шаардах тохиолдолд ердийн шүүхэд нэхэмжлэл гаргах явдлыг хориглож болохгүй" гэж зохицуулсан байна.

3.3.3. Япон Улс

Япон Улсын хувьд харин төрийн албаны хариуцлагатай холбоотой харилцааг Төрийн албаны хариуцлагын тухай хуулийн дагуу шийдвэрлэдэг бөгөөд уг хуулийн 1-р зүйлийн 1.1 дэх хэсэгт "Төр болон нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлдэг төрийн албан хаагч нь өөрийн албан үүргээ гүйцэтгэх явцдаа санаатай эсхүл болгоомжгүй гэм буруутайгаар хууль бусаар бусдад хохирол учруулсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээнэ" гэж, тус хуулийн 1.2 дахь хэсэгт "Өмнөх хэсэгт заасан тохиолдлын хувьд төрийн албан хаагч нь санаатай эсхүл илтэд болгоомжгүй гэм буруутай тохиолдолд төр болон нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь тухайн төрийн албан хаагчаас өөрт учирсан хохирлоо шаардах эрхтэй" гэж тус тус зохицуулжээ.

Дээрх гурван улсын эрх зүйн зохицуулалтаас үзэхэд төрийн албан хаагч буюу нийтийн эрх зүйн субъектийн албан үүргээ гүйцэтгэх явцдаа гуравдагч этгээдэд хохирол учруулсан тохиолдолд тухайн гэм хорын хохирлыг хэн хэрхэн хариуцах талаар тусгайлан буюу хувийн эрх зүйн субъектүүдээс ялган зохицуулсан байх ба уялдуулан хэрэглэх бусад зохицуулалтыг мөн хуульчилжээ. Ийнхүү төр өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагч болох ажилтны санаатай, илтэд болгоомжгүй гэм бурууг тодорхойлон хуульчилсан нь Монгол Улсын зохицуулалттай төсөөтэй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Төрийн албан хаагчийн албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад учирсан гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгах ба хэрэв тухайн төрийн албан хаагч шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээрээ гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага /төр/ хохирлоо гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй байхаар ИХ-ийн 498 дугаар зүйлд хуульчилжээ.

Ийнхүү шаардан гаргуулах эрхийг олгохдоо хууль тогтоогчийн зүгээс зөвхөн төрийн албан хаагч, төрөөр хязгаарлалгүй нийтэд нь ажилтан-ажил олгогч гэх байдлаар хуульчилсан байх тул үүнийг хэрхэн тайлбарлан хэрэглэхийг тодорхой болгох, мөн ажил олгогч нь ажилтнаасаа хохирлоо шаардах эрхийн үндэслэл нь ажилтны гэм бурууг ажил олгогч хариуцаж байгаа эсэх, эсхүл ажил олгогч өөрийнхөө гэм бурууг үндэслэж байгаа эсэхийг тодорхойлох шаардлагыг дүн

¹³ Basic Law for the Federal Republic of Germany, 1949, https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html



шинжилгээний хүрээнд сонгон авсан УДШ-ийн 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 001/ХТ2024/00029 дугаар тогтоолоор тодорхойлсон болно.

Иргэний эрх зүйн онолд ажил олгогч нь ажилтны учруулсан гэм хорыг хариуцахдаа өөрийн эсхүл бусдын гэм бурууг хариуцаж байгааг "зөвхөн өөрийн гэм буруутай үйлдлийн улмаас хариуцлага хүлээнэ, хэн нэгний үйлдлийн өмнөөс хариуцлага хүлээхгүй" гэж үздэг бол зарим судлаачид үүнээс өөрөөр буюу "бусдын үйлдлийн өмнөөс хариуцлага хүлээх боломжтой" гэж тайлбарлаж байна. Хэрэв ИХ-ын 498 дугаар зүйлийг бусдын өмнөөс хариуцлага хүлээх ойлголтод хамаарна хэмээн тайлбарласан тохиолдолд ажил олгогч нь өөрийн үйлдлийн улмаас бий болсон хохирлыг бус ажилтны бусдад учруулсан хохирлыг түүний оронд гуравдагч этгээдэд нөхөн төлөх үүрэг хүлээх тул дараа нь ажилтнаасаа 498.5 дахь хэсгийн дагуу хохирлоо шаардах боломжтой хэмээн дүгнэхээр байх тул ажил олгогч бусдын өмнөөс эсхүл өөрийн буруугийн улмаас хариуцлага хүлээж байгаа гэж үзэх эсэх нь ихээхэн ач холбогдолтой.

Монгол Улсын шүүхийн практикт тухайлан төр, төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаан дахь ажилтны учруулсан гэм хорын хохирлыг ажил олгогч хариуцан арилгах, ажилтны гэм буруугийн хэлбэрээс хамааран ажил олгогч өөрт учирсан хохирлоо буцаан шаардахтай холбоотой харилцаанд Төрийн албан хаагчийн тухай хуулийн зохицуулалтыг уялдуулан хэрэглэх байдлаар хувийн эрх зүйн субъектэд холбогдох маргаанаас ялган зааглаж байна хэмээн үзэж болохоор байна. Ийнхүү шийдвэрлэхдээ хуульд заасан илтэд болгоомжгүй буюу шууд санаатай гэм буруу байгаа эсэхийг нарийн харгалзан үзэж хариуцлагыг тус хүрээгээр хязгаарлаж байна.

Гадаадын бусад улс оронд төрийн албан хаагч буюу нийтийн эрх зүйн субъектийг хууль, тогтоомждоо тусгайлан ялгаатай байдлаар зохицуулсан нь манай улсын зохицуулалтаас ялгарч байна. Харин гэм буруугийн хувьд нийтлэг байдлаар санаатай, илтэд болгоомжгүй гэм буруугийн хэлбэрийг тогтоожээ.

Дээрхээс үзвэл дүн шинжилгээний хүрээнд сонгон авсан УДШ-ийн 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 001/ХТ2024/00029 дүгээр тогтоолоор төр өөрт учирсан хохирлоо буцаан шаардахын тулд төрийн албан хаагчийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй гэм бурууг нарийн шалгах шаардлагатай гэх үндсэн асуудлыг хөндсөн хэдий ч Монгол Улсын эрх зүйн зохицуулалтад хувийн болон нийтийн эрх зүйн субъектийг нэгтгэн зохицуулсан байх тул хэрэв хувийн эрх зүйн субъектэд холбогдох хэрэг маргаан гарсан тохиолдолд хэрхэн хуулийг тайлбарлан хэрэглэх, цаашлаад ерөнхий гэм буруугийн зарчим энэ тохиолдолд хэрхэх зэрэг асуултууд гарах боломжтой байна.



НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж:

1. Иргэний хууль, 2002 он.
2. Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2017 он.
3. Завхан аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 205/МА2023/00039 дүгээр магадлал
4. Улсын дээд шүүхийн 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 001/ХТ2023/00157 дугаар тогтоол
5. УДШ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 001/ХТ2023/00157 дугаар тогтоол

Б. Ном, сурах бичиг

1. Д.Янжинхорлоо, *Иргэний эрх зүйн үндсэн асуудал, үүргийн гүйцэтгэлийг хангах эрх зүй*, 2017 он.
2. Т.Мөнхжаргал, *Монгол Улсын Иргэний эрх зүй Үүргийн тусгай төрөл*, 2015 он.
3. Монгол Улсын Дээд шүүх, *Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг IV)*, 2016 он.

В. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Ж.Оюунтунгалаг, "Гэм хорын тусгай төрөл: Эзэмшигчийн хариуцлага", *legaldata.mn*, 2017 он.
2. Р.Пүрэвбаатар, "Иргэний хуулийн 498-р зүйлийн талаар судлах нь: Харьцуулалт, дүгнэлт", *Хууль дээдлэх ёс сэтгүүл*, №81, 2021 он

2. Цахим эх сурвалж:

1. Гүрж улсын хууль тогтоомжийн мэдээллийн нэгдсэн систем: <https://matsne.gov.ge>
2. ХБНГУ-ын хууль тогтоомжийн мэдээллийн нэгдсэн систем: <https://www.gesetze-im-internet.de/>

IV

УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭЭС ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ¹

¹ Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.3-т Улсын дээд шүүх нь "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон шүүхийн үйл ажиллагаа, эрх зүйн байдалтай холбогдсон хууль тогтоомжийн төслийн талаарх саналаа хууль санаачлагчид хүргүүлэх, бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналаа хууль санаачлагчид уламжлах;" гэж заасны дагуу хууль тогтоомжийн төсөлд санал өгөх бүрэн эрхтэй. Энэхүү булангаар УДШ-ээс хууль санаачлагчид хүргүүлсэн зарим саналыг хэвлэн нийтлэв.



**2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДРИЙН
"АРИЛЖААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ"-ИЙН ТӨСӨЛД
УДШ-ЭЭС 2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 13-НЫ
ӨДРИЙН АЛБАН БИЧГЭЭР ХҮРГҮҮЛСЭН САНАЛ**

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ



АРИЛЖААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны боловсруулж байгаа Арилжааны ерөнхий хуулийн төсөл (2023.09.12-ны өдийн байдлаар)-тэй танилцлаа. Хуулийн төслийн эрх зүйн тодорхой байх зарчимд нийцүүлэн бизнесийн харилцааны найдвартай, тогтвортой байдлыг дэмжих үндсэн зорилготой санал нэг байна.

Гэвч хуулийн төсөл нь зарим талаар үзэл баримтлал, агуулга, бүтцийн хувьд тодорхой бус байгаагийн зэрэгцээ зүйл, заалтын томъёолол, найруулгыг сайжруулах шаардлагатайг дурдах нь зүйтэй байна. Төслийн ихэнх зүйл, хэсэг, заалтад агуулга, найруулгын засвар шаардлагатай байх тул энэ талаарх саналыг ажлын хэсгийн хуралдаануудад оролцох явцад хэлэлцүүлж, зарчим, үзэл баримтлалын шинжтэй саналыг үүгээр хүргүүлж байна. Үүнд:

1. Арилжааны ерөнхий хуулийн төслөөр Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг тухайн харилцааны онцлогт нийцүүлэн илүү тодорхой болгох, нарийвчлан зохицуулах хандлагыг баримталжээ. Иргэний хууль нь монист чиг хандлагыг баримталж арилжааны (commercial) ба арилжааны бус харилцааг хамтад нь зохицуулан өнөөдрийг хүртэл үйлчилж ирсний хувьд төсөл батлагдсаны үр дүнд Иргэний хууль хөндөгдөхгүй өнгөрөх боломжгүй. Иймд Иргэний хуульд орох нэмэлт, өөрчлөлтийг цаг хугацааны хувьд зэрэгцүүлэн боловсруулж, холбогдох хэлэлцүүлгийг хугацаа алдалгүй эхлүүлэх нь нэн чухал. Өнөөгийн практикт түгээмэл тохиолддогчлон дагалдах хуулийн өөрчлөлтийг бие даан хэлэлцүүлэхгүй өнгөрөх, үндсэн төслийн араас боловсруулах гэх мэт байдлаар хандвал шүүхийн болон хууль хэрэглээний практикт сөрөг үр дагавартай болохыг анхаарвал зохино.
2. Арилжааны ерөнхий хууль ба Иргэний хуулийн үйлчлэх эрэмбийг анхаарах шаардлагатай. Төслийн Арилжааны хууль тогтоомжийг хэрэглэх гэсэн 5 дугаар зүйлд арилжааны харилцаанд тус хууль нь илүү нарийвчилсан хууль байхаар заасан байна. Нэгэнт арилжааны харилцааг зохицуулах тусгайлсан хууль тул үйлчлэх эрэмбийн хувьд тэргүүн ээлжид үйлчлэх нь зохистой. Гэвч Иргэний хууль нь анх боловсруулагдахдаа эдийн болон эдийн бус амины харилцааны суурь бөгөөд нарийвчилсан хууль байх үндсэн үзэл баримтлалд тулгуурласан. Энэ агуулгаар Иргэний хуулийн 3.3-т "Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ" гэж заан, Иргэний хууль бусад хуультай зөрчилдвөл тухайн хууль нарийвчилсан эсэхээс үл хамааран эхний эрэмбээр үйлчлэх тэргүүлэх хүчин чадалтай байхыг баталгаажуулсан. Хэрэв Арилжааны ерөнхий хуулийн төслийн 5 дугаар зүйл энэ хэвээр дэмжигдвэл тус зохицуулалтын хүрээнд Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн үндсэн үзэл баримтлал хөндөгдөх нь зайлшгүйг анхаарч, үзэл баримтлалын шинжтэй томоохон өөрчлөлт Иргэний хуульд тусах шаардлагатай байх тул цаг алдалгүй томъёоллын зөв хувилбаруудыг санал болгох нь чухал.



3. Төсөлд төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах харилцаанд үйлчлэхгүй байхаар туссан байна. Тус хуулийн нэгэн адил төрийн болон орон нутгийн өмчийг бусдад худалдах, ашиглуулах харилцааг зохицуулсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, төр ба хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг зохицуулсан бие даасан бусад хууль тогтоомжуудтай хэрхэн уялдах нь тодорхойгүй үлджээ. Иймд энэ талаарх хууль санаачлагчийн байр суурийг тодорхой болгох нь зүйтэй.
4. Төслийн үр дүнд шинэ ба шинэлэг зохицуулалт бий болох нь гарцаагүй хэдий ч нэн шаардлагатай бус бол Иргэний хуулийн хэрэглээнд нэгэнт тогтсон, суурь шинжтэй хуулийн нэр томъёог бий болгох нь зохимжтой биш. Тухайлбал төслийн 5 дугаар зүйлд "практик" ба "заншил" гэх хоёр ойлголтыг салгаж хэрэглэжээ. Иргэний хуульд "ажил хэргийн хүрээнд тогтсон заншил" гэх нэр томъёо байх ба энэ нь тус бүс нутагт тогтсон бизнесийн харилцаанд ч хэрэглэгдэх заншлыг төдийгүй бизнес эрхлэгчдийн хооронд үүссэн практикийг хамарсан ойлголт. Энэ мэт Иргэний хуулийн хэрэглээний хүрээнд нэгэнт эргэлзээгүй болсон, арилжааны эрх зүйн мөн чанарт нийцэх томъёоллыг өөрчлөхгүйгээр төсөлд тусгах нь хууль хэрэглээний нэгдмэл байдал, залгамж холбоог хадгалахад тустай.
5. Арилжаа эрхлэгчийн цар хүрээг тогтохдоо төсөлд субъектив ба объектив аль аль хандлагыг баримталсан байна. Компани ба нөхөрлөлийн хэлбэрээр байгуулагдсан этгээдийг шууд арилжаа эрхлэгч гэж үзэхийн зэрэгцээ хувь хүн арилжааны үйл ажиллагаа явуулдаг бол бүртгүүлсэн эсэхээс үл хамааран арилжаа эрхлэгч гэж тооцогдохоор зохицуулжээ. Харин хөдөө аж ахуй (мал аж ахуй, газар тариалан, хүлэмжийн аж ахуй г.м), ойн аж ахуй, бусад анхдагч үйлдвэрлэл явуулдаг хувь хүн бүртгүүлснээс бусад тохиолдолд арилжаа эрхлэгч биш байхаар заасан байна. Энэ хүрээнд төслийн зарим томъёолол тодорхой бус ("анхдагч үйлдвэрлэл" г.м), хэт өргөн, компани ба нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулахаас зайлсхийх боломж олгосон (компани, нөхөрлөлийн хэлбэрээс зайлсхийснээр татварын болон нийгмийн даатгал, нийтийн ба хувийн эрх зүйн бусад харилцаанд тодорхой бус байдлыг үүсгэх сул талтай) байгааг анхаарах нь зүйтэй байна.
6. Арилжаа эрхлэгчийн цар хүрээг тогтоохдоо "чөлөөт мэргэжил"-ийн шинжтэй үйл ажиллагааг хамруулахгүй байх зохицуулалт гадны зарим улсад байна (жишээ нь ХБНГУ-ын Худалдааны тухай хуулийн зохицуулалтад энэ нэршил бий). Энэ нь "чөлөөт мэргэжилтэн"-үүдийн үзүүлж буй үйлчилгээний мөн чанартай холбоотой байдаг. Тухайлбал өмгөөллийн үйлчилгээг арилжааны үйл ажиллагаанд тооцох боломжгүй бөгөөд хэрэв ингэвэл хууль зүйн туслалцааны үйлчилгээ нь ашиг хөөж, хүний эрхийн хамгаалалт сулрах сөрөг тал дагуулдагтай холбоотой. Үзэл баримтлалын түвшинд энэ мэт асуудал хэрхэн туссан нь төсөлд тодорхой бус байна.



7. Ихэнх улс оронд арилжааны бүртгэлийг цахим хэлбэрээр хөтлөх ба бүртгэлийн гол агуулгууд нээлттэй байх онцлогтой. Арилжааны бүртгэл нь нэгт, бизнесийн харилцаанд оролцогч нь харилцагчтайгаа холбоотой үнэн зөв мэдээллийг олж авах, хоёрт, эрх зүйн тогтвортой байдлыг хангах гэсэн хоёр үндсэн зорилгод үйлчилнэ. Худалдаачин нь найдвартай этгээд болохыг бусдад харуулах нэгэн хэрэгсэл болох талаасаа арилжааны бүртгэл хөгжих учиртай. Бүртгэлийн эдгээр зорилго зарим талаар төсөлд туссан боловч бүрэн дүүрэн болж чадсангүй. Бүртгэлээс хасах үндэслэл, сайн дураараа бүртгүүлсэн этгээд сайн дураараа хасагдах, эргэж нэмэгдэх боломж, ийнхүү бүртгэлээс хасагдаж, нэмэгдсэний эрх зүйн үр дагавар зэрэг процессын бус, материаллаг эрх зүйн үндэслэлийг заасан зохицуулалтыг бий болгох нь зүйтэй.
8. Хуулийн төслийн тавдугаар бүлгийг дэлгэрүүлэх, системчлэх шаардлагатай. Иргэний хуулийн төлөөллийн зохицуулалт, бизнесийн ба энгийн төлөөллийг системчлэл муутай хольсноос шүүхийн практикт нэг мөр ойлгох, хэрэглэхэд төвөгтэй байдал үүсдэг. Энэ байдлыг Арилжааны ерөнхий хуулийн төслийг боловсруулах замаар сайжруулах боломжтой. Арилжааны төлөөллийн нарийвчилсан зохицуулалт нь бизнесийн түргэн шуурхай байдлыг дэмжих Арилжааны ерөнхий хуулийн зорилгыг биелүүлэх гол хүчин зүйл тул Иргэний хууль дахь төлөөллийн зохицуулалтыг баяжуулж тусгасан байвал зохино. Төлөөллийн талаарх төслийн зохицуулалт ойлгомжгүй бичилттэй, цэгцгүй, бүхэллэг шинжтэй байгаа нь энэ зорилгыг биелүүлэхэд хангалтгүй, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг алдагдуулах эрсдэлтэй. Иймд арилжааны эрх зүй дэх бүрэн төлөөлөл (прокура), тухайлсан төлөөлөл, ажилтны төлөөлөл гэсэн үндсэн бүтцээр зохицуулалтыг нарийвчилж, сайжруулан томъёолох шаардлагатай.
9. Төслийг бүтцийн үүднээс авч үзвэл арилжааны эрх зүйн тусгай ангид хамаарах, Иргэний хууль дахь гэрээний тусгай төрөл болох худалдааны төлөөлөл, худалдааны зуучлалын харилцааг төслийн ерөнхий ангид "арилжааны төлөөлөл", "арилжааны зуучлал" гэх нэрээр тусгасан нь ойлгомжгүй байна. Түүнчлэн Иргэний хууль дахь гэрээний тусгай төрөл болох худалдааны төлөөллийг "арилжааны төлөөлөл" гэж нэрлэсэн нь дээр дурдсан төлөөллийн ерөнхий зохицуулалтаас ялгаж ойлгоход бэрхшээл үүсгэж байна. Иймд хуулийн төслийн зохих хэсэгт одоогийн хуулийн нэршлээрээ тусгагдах нь зөв.
10. Арилжааны хэлцлийн нийтлэг үндэслэлд гэрээ байгуулах, гэрээний стандарт нөхцөл, үүргийн гүйцэтгэлийг хангах арга, үүргийн зөрчил, үүрэгт олон этгээд оролцох гэх мэт гэрээний эрх зүйн ба үүргийн эрх зүйн институтын олон төрлийн харилцааг багтаасан нь үүргийн эрх зүйн системчлэлийн үүднээс учир дутагдалтай, хууль хэрэглээний алдаатай практикт тогтоох эрсдэлтэй тул сайжруулах шаардлагатай.



11. Арилжааны ерөнхий хууль нь бие даасан, төрөлжсөн хууль болох тул уг хуулийн төсөлд арилжааны гэрээний тусгай төрөл, зарим төрлийн үүргийн гүйцэтгэлийг хангах аргын талаарх бие даасан хуулиудыг нэгтгэх, цэгцлэх арга хэмжээг нэг мөр хийх нь зүйтэй. Тодруулбал, Санхүүгийн түрээсийн тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль зэрэг хуулиуд нь арилжааны буюу худалдааны эрх зүйн эх сурвалжийн шинжтэй тул эдгээр хуулийг энэ хуулийн төсөлд нэгтгэх нь хууль хоорондын зөрчилдөөнийг арилгах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтоох ач холбогдолтой.
12. Төслийн тусгай ангийн зохицуулалт нь гэрээний тусгай төрлүүдийг Иргэний хуулиас шилжүүлэх замаар томъёологджээ. Арилжааны тухай бие даасан хуулийн төсөл боловсруулж байгаа тохиолдолд үүнээс өөр хувилбарыг санал болгох боломжгүй хэдий ч Иргэний хуульд орж буй хэмжээний өөрчлөлтийг бодитойгоор харж, энэ хуулийн төсөлтэй мөр зэрэгцүүлэн боловсруулж явахыг нэн чухал гэж үзэж байгааг дахин дурдаж байна. Түүнчлэн Иргэний хуулийн нэмэлт, өөрчлөлтийн цар хүрээнээс хамаарч уг хуулийг бие даан өргөн мэдүүлэх, дагалдуулан өргөн мэдүүлэх асуудал хөндөгдөж болзошгүйг анхаарах шаардлагатай. Өнөөдрийг хүртэл тогтсон Иргэний хуулийн хэрэглээнээс тус хуульд сайжруулбал зохих зүйл, заалтууд байгаа талаар олон судлаачид адил байр суурьтай байдаг тул нэн шаардлагатай зарим өөрчлөлтийг Арилжааны ерөнхий хуулийн төсөлтэй хамтатган боловсруулах нь цаг хугацаа хэмнэсэн, үр дүнтэй шийдэл болохыг тэмдэглэж байна.
13. Арилжааны ерөнхий хуулийн төсөл нь холбогдох ажлын хэсгээр хэлэлцэгдэх замаар сайжрах боломжтой гэж үзэж төслийн зүйл, заалт бүрээр агуулгын ба найруулгын санал өгөхийг энэ удаад түр хойшлуулав.

**2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДРИЙН
"СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ
ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ
ОРОН СУУЦНЫ ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД
ХӨРӨНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ"-ИЙН ТӨСӨЛД
УДШ-ЭЭС 2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ
ӨДРИЙН АЛБАН БИЧГЭЭР ХҮРГҮҮЛСЭН САНАЛ**

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ



СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

1. Төсөлд өмчийн эрх зүйн бусад зохицуулалттай уялдан нийцүүлэх зорилгоор агуулгын шинжтэй дараах асуудлыг анхаарах шаардлагатай. Үүнд:

Төслийн заалт	Тайлбар, тодруулга
Хуулийн төслийн 4.1.3, 53.1: Нийтийн зориулалттай орон сууцны байшинд сууц өмчлөх эрх, захиран зарцуулах эрхтэй байх	"Нийтийн зориулалттай орон сууцанд сууц өмчлөх эрх" гэсэн ойлголт нь өмчлөх эрхийн нэгэн өвөрмөц хэлбэр мөн. Иргэнлэг эрх зүй (Civil law)-н бүлийн өмчийн эрх зүйд өмчлөх эрхийг "туйлын" бөгөөд "бүрэн эрх" гэж тайлбарлан энэ эрхийн агуулгад өмчийн зүйлээ захиран зарцуулах эрх нэг мөр хамаарна. Энэ үүднээс өмчлөх эрхээс тусдаа захиран зарцуулах эрхийг тодорхойлж салгах шаардлагагүй. Арилжааны буюу бизнесийн эрх зүйн хүрээнд өмчлөгчөөс олгосон эрхийн хүрээнд эд хөрөнгийг өмчлөгч бус этгээд захиран зарцуулах үйлдэл хийх тохиолдол байх боловч тус хуулийн төслийн хүрээнд "өмчлөх эрх" ба "захиран зарцуулах эрх"-ийг энэ үндэслэлээр ялгасан байх боломжгүй.



<p>Хуулийн төслийн 7 дугаар зүйл. Сууц өмчлөгчдийн холбоо дундын өмчийн зүйлийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх</p>	<p>Төслийн тус заалтын хууль зүйн ач холбогдол ойлгомжгүй байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл нь тухайн эд хөрөнгийн талаар эрх зүйн харилцаанд орж буй гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах, бизнесийн тогтвортой байдлыг хадгалах, нийгмийн харилцаанд илэрхий, тодорхой байдлыг дэмжих чиг үүрэгтэй. Энэ ч агуулгаар бүртгэлд итгэсэн шударга итгэл үнэмшлийг "бүртгэл үнэн зөв байх" зарчмын хүрээнд хамгаалдаг. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд өмчлөх эрх, түүнийг хязгаарлаж үүссэн бусад хязгаарлагдмал эрхийг бүртгүүлэх ач холбогдол нь тухайн эд хөрөнгө иргэний ба арилжааны гүйлгээнд тогтмол ордог байх, арилжаа, худалдааны, эсвэл нийгмийн харилцааны идэвхтэй хэрэгсэл болдог байдалтай салшгүй холбоотой. Гэтэл сууц өмчлөгчдийн дундын өмчид хамаарч, дангаар өмчлөлийн зүйлийн салшгүй хэсэг болон түүнийг гүйлгээнд оруулахад дагалдах учиртай дундын өмчийн зүйлийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхийн хууль зүйн ач холбогдол ойлгомжгүй, сууц өмчлөгчдөд нэмэлт дарамт, санхүүгийн ачаалал болох, гуравдагч этгээдийн хувьд бүртгэлийн үр дагаврын талаар тодорхойгүй байдал үүсгэх үндэслэл болохоор байна.</p> <p>Түүнчлэн нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын эд хөрөнгө нь гагцхүү сууц өмчлөгчдийн дундын эд хөрөнгө бөгөөд сууц өмчлөгчдийн холбоо тухайн эд хөрөнгийн хувьд эдийн баялгийн туйлын эрх буюу өмчлөх эрх эдлэх учиргүй болохыг анхаарвал зохино. Өөрөөр хэлбэл, байшингийн дангаар өмчлөлийн зүйлийг улсын бүртгэлд бүртгэсэн бол тухайн байшин дахь дундын өмчийн хэсэг энэ этгээдийн хувьд хуульд заасан хэмжээгээр түүний өмчлөлд байна гэж үзнэ. Иймд байшин дахь дундын өмчийн эд хөрөнгийг дангаар өмчлөлөөс тусад нь, холбооны нэр дээр бүртгэдэггүй. Хэрэв дундын хөрөнгийг дангаар өмчлөлөөс тусад нь бие даасан хөрөнгө гэх агуулгаар бүртгэж эхэлбэл энэ хөрөнгийг дангаар өмчлөлөөс тусдаа иргэний гүйлгээнд оруулах боломжтой мэт ойлголтыг хэвшүүлэх үр дагавартай. Түүнчлэн улсын бүртгэлд дундын эд хөрөнгийг бүртгэхдээ өмчлөгчөөр хэнийг бүртгэх нь төсөлд тодорхой бус байх ба СӨХ-г бүртгэх бол энэ нь онолын хувьд "дундын" биш СӨХ-ны "дангаар өмчлөл"-ийг үүсгэх үр дагавартайг анхаарах ёстой. Хуулийн төслийн үзэл баримтлалыг энэ үр дагаврыг сайтар ойлгож боловсруулсан гэж найдаж байна.</p>
---	--



<p>Хуулийн төслийн 8 дугаар зүйл: Дундын хөрөнгө нь дундаа хамтран өмчлөх хөрөнгө болох тухайд</p>	<p>Монгол Улсын иргэний эрх зүй дэх дундын өмч нь дундаа хэсгээр буюу дундаа хамтран өмчлөлийн үндсэн хоёр хэлбэртэй. Хуулийн төсөлд орон сууцны байшингийн дундын эд хөрөнгө нь хамтаар өмчлөх дундын өмчийн хэлбэртэй байхаар хуульчилжээ. Гэвч нийтийн зориулалттай орон сууцны дундын эд хөрөнгийг энэ хоёр дундын өмчийн аль нэг хэлбэрт шууд хамаатуулах боломжгүй. Энэ нь өөрөө "нийтийн зориулалттай орон сууцны өмчлөх эрх" гэх өвөрмөц өмчлөлийн хэлбэртэйгээ уялдаж тайлбарлагддаг онцлогтой. Өмнө дурдсанчлан өмчлөх эрхийн нэгэн өвөрмөц төрөл болох хувьдаа дундын өмчийн "хэсгээр" ба "хамтаар" хэлбэрийн аль алины шинжийг агуулдаг. Тодруулбал, дундын өмчлөлийн зүйлийн арчлалт, хадгалалт хамгаалалттай холбоотой зайлшгүй зардлыг өмчлөгчдөд дундын өмчлөлийн зүйлээс ногдох хууль зүйн буюу хийсвэр хэмжээнд хувь тэнцүүлэн гаргах нь хэсгээр өмчлөх дундын өмчийн харилцааны үндсэн шинж байдаг бол өмчлөгчдийн тоонд тэнцүү хувааж гаргах нь хамтаар өмчлөх дундын өмчийн шинж байдаг. Энэ талаар Иргэний хуулийн 108 дугаар зүйлд "хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол дундын өмчлөлийн зүйлийг арчлан хамгаалах, хадгалахтай холбогдсон зардал, татвар, хураамж, бусад үүргийг дундаа хэсгээр өмчлөгчид нь өөрт ногдох хэсгээр хувь тэнцүүлэн, дундаа хамтран өмчлөгчид нь тэнцүү хэмжээгээр хариуцах дундын өмчлөлийн зүйлийг ашигласнаас олсон үр шимийг дээр дурдсан хувь хэмжээгээр хуваана гэж заасан. Энэ байдлаас үзвэл нийтийн зориулалттай орон сууцны өмчлөгчдийн дундын өмчлөлийн хэлбэр нь зардал хуваарилалтын зарчмаараа хэсгээр өмчлөх дундын өмчийн болон хамтаар өмчлөх дундын өмчийн аль алины шинжийг агуулжээ.</p>
--	---



<p>Хуулийн төслийн 10 дугаар зүйл: Тодорхой хөрөнгийг дундын өмчид бүртгэх, бүртгэсэн боловч эзэмших, ашиглах гэрээ байгуулах зохицуулалтын тухайд</p>	<p>Тус заалтаар төр, орон нутаг гэх мэт эх үүсвэрийн хүрээнд дундын өмчийн хөрөнгө өсөн нэмэгдэж болохоор зохицуулжээ. Улмаар уг эд хөрөнгө бий болсноор дундын өмчийн эд хөрөнгөд бүртгэхээр заасан байна. Гэтэл нэгэнт дундын өмчид тооцон бүртгэсэн атлаа энэ хөрөнгийн тухайд эзэмших ашиглах гэрээг төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагатай байгуулахаар заажээ. Өөрөөр хэлбэл, төслийн 10.1-ээр эд хөрөнгө дундын өмч гэж тооцогдохоор, төслийн 10.2-оор эд хөрөнгө төрийн эсхүл, орон нутгийн өмч хэвээр үлдэхээр байгаа мэт ялгаатай үр дагавартай зохицуулалт бий болгосон нь ойлгомжгүй болсон байна.</p> <p>Түүнчлэн дээрх үндэслэлээр хүлээн авсан эд хөрөнгөд аливаа доголдол илэрвэл СӨХ шууд гүйцэтгэгчтэй харилцан арилгуулахаар заасан нь зарим талаар шаардах эрх шилжилтийн төвөгтэй байдал үүсгэхээр байна. Учир нь СӨХ, эсхүл сууц өмчлөгчдийн хэн аль нь гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй, түүнчлэн төслийн 10.2-т заасныг үндэслэвэл уг эд хөрөнгийг захиалан бий болгож сууц өмчлөгчдөд шилжүүлж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Энэ тохиолдолд СӨХ, эсхүл сууц өмчлөгчид гүйцэтгэгчид хандан чухам гэрээ, эсхүл өмчийн эрхийн аль салбарт үндэслэж шаардлага гаргах нь тодорхойгүй болно. Иймд эд хөрөнгийн доголдлын тухайд гүйцэтгэгчид бус захиалагчид шаардлага хүргүүлдэг байх нь зүйтэй ба захиалагчаас тухайлан шилжүүлсэн тохиолдолд түүний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг үндэслэн СӨХ шаардах эрх олж авах боломжтой байхаар төслийг томъёолох нь зүйтэй.</p>
<p>Хуулийн төслийн 20.1: өрх ба сууц гэх томъёоллын тухайд</p>	<p>Хуулийн төсөлд "өрх" гэх нэр томъёог "сууц" ба "орон сууц өмчлөгч" гэх нэр томъёотой зэрэгцүүлэн цөөн газарт хэрэглэсэн байна. Нэг сууцанд нэг өрх амьдрах нь түгээмэл боловч нэг сууцанд хэд хэдэн өрх амьдрах ч боломж бий. Төслийн 20.1.1 дэх хэсэг "өрх" бус "сууц"-ыг илтгэсэн эсэх, эсхүл нэг сууцанд хэд хэдэн өрх байх боломжтой болохыг ойлгон тухайлан "өрх" гэх томъёоллыг хэрэглэсэн эсэхийг тодруулж, нэр томъёог нэг мөр болгох шаардлагатай.</p>



<p>Хуулийн төслийн 28.1: СӨХ-ны газрын эрхийн тухай</p>	<p>Тус заалтаар орчны газрыг ашиглах гэрээг сууц өмчлөгчдийн холбоотой байгуулахаар заажээ. Нийтийн зориулалттай орон сууцны хувьд "газар ашиглах эрх" сууц өмчлөгчдийн холбоонд бус сууц өмчлөгчид хадгалагддаг болохыг анхаарч томъёоллыг өөрчлөх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, газар ашиглах эрх нь орон сууц оршин байх тухайн хугацаанд төдийгүй байгалийн гамшиг аливаа шалтгаанаар орон сууц үгүй болсон үед ч газрыг ашиглах эрх бүх сууц өмчлөгчийн хувьд хэвээр хадгалагдах учиртай. Иймд газар ашиглах гэрээг СӨХ байгуулах нь гагцхүү процессын чанартай үйлдэл байх учиртай буюу материаллаг эрхийн хувьд газрын эрх СӨХ-д бус сууц өмчлөгчид хадгалагддаг болохыг баталгаажуулж сууц өмчлөгчдийг төлөөлж СӨХ газар ашиглах гэрээ байгуулдаг байхаар томъёоллыг засвал зохино.</p>
---	--



<p>Хуулийн төслийн 54.1.3, 67.2 дахь заалтууд: сууц өмчлөгчийн саналын эрх</p>	<p>Сууц өмчлөгчийн саналын эрхийн талаар дараах агуулга бүхий зохицуулалт өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийтийн зориулалттай орон сууцны сууц өмчлөгч нь Иргэний хуулийн 148 дугаар зүйлийн 148.1.3-т заасанчлан дундын өмчийн зүйлийг ашиглах, захиран зарцуулахад өөрт оногдох хэсгээр саналын эрхтэй оролцоно гэж заасан. Өөрөөр хэлбэл дундын өмчийн зүйлийг ашиглалт, удирдлагатай холбоотой асуудлаар шийдвэр гаргахад сууц өмчлөгч тус бүрийн саналын эрх адил бус байх ба тэдгээрийн дангаар өмчлөлийн зүйлийн тухайн сууцны нийт дангаар өмчлөлийн талбайд харьцах харьцаатай хувь тэнцүү саналын эрхтэй оролцоно. Энэ нь мөн л хэсгээр өмчлөх дундын өмчийн үндсэн шинж бөгөөд саналын эрхийг хувь тэнцүүлэн тооцохоор Иргэний хуулийн 488 дугаар зүйлийн 488.1-т заасан байна. 2. Иргэний хуулийн 147.2-т Орон сууцны цахилгаан болон явган шат, шатны хонгил, сууц хоорондын талбай болон тагт, сууцны доторх дундын ашиглалтын талбай, орцны хаалга, довжоо, цонх, хог зайлуулах хоолойн засвар үйлчилгээтэй холбогдсон, түүнчлэн өөр нийтлэг зардлыг санхүүжүүлэхэд сууц өмчлөгчдийн оролцох хэмжээг тодорхойлохдоо уг зардлыг тухайн орон сууцны нийт сууцны тоонд хуваана. гэсэн нь ашиглалтын засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг сууц бүр адил төлөх агуулгатай байна. Энэ нь хэсгээр өмчлөх дундын өмчөөс ялгагдах шинж мөн. <p>Хамтаар өмчлөх дундын өмчийн хувьд нэгэнт ногдох хэсгийг урьдчилан тогтоох шаардлагагүй байдаг тул саналын эрхийн хувь хэмжээний асуудлыг зохицуулаагүй, бүх өмчлөгчид энэ талаар санал нэгтэй шийдэл гаргах ёстой гэсэн байр суурийг хууль тогтоогч тусгаж өгсөн байдаг. Хамтран өмчлөх дундын өмчийн үед бүх өмчлөгчийн зөвшөөрлийг авах бөгөөд аль нэг нь зөвшөөрөөгүй үед дундын өмчийг захиран зарцуулах боломжгүй юм. Энэ нь хамтаар өмчлөх дундын өмчийн төрөл нь хамтран ажиллах, хамтаараа ямар нэг зорилго тавьж дундын өмчийг үүсгээгүй, илүүтэй гэр бүлийн гэх мэт зайлшгүй шалтгаанаар үүсэж бий болсон байдагтай холбоотой.</p>
--	---



	<p>Нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчлөл ч мөн адил зайлшгүй шалтгаанаар нөхцөлдөж үүссэн гэх агуулгаар хамтаар өмчлөх дундын өмчтэй төсөөтэй байх хэдий ч өмчлөгч тус бүрийн орон сууцны дангаар өмчлөлийн хэсгийн хэмжээтэй уялдаж зардал хуваарилалтын зарчим тогтдогтой холбоотойгоор ашиглалт, удирдлагын талаар гаргах саналын эрх ч мөн нэгэн адил хэсгээр өмчлөх дундын өмчийн харилцаатай адил байгааг дээрх зохицуулалтаас харж болно. Энэ нь өмнө дурдсанчлан нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчийн эд хөрөнгийг "хэсгээр" ба "хамтаар" гэж шугам татан ялгаж болдоггүйн нэгэн шалтгаан мөн.</p> <p>Сууц өмчлөгчдийн саналын эрхийн тухайд төсөл дээрх агуулгыг илэрхийлэхийг зорьсон мэт байх боловч Иргэний хууль шиг ойлгомжтой илэрхийлэлгүй байгаагаас зөрүүтэй томъёолсон байна. Төслийн 54.1.3-т дундын өмчлөлийг зүйлийг ашиглах захиран зарцуулахад өөрт ногдох хэсгээр саналын эрхтэй гэж заасан нь одоогийн үйлчилж байгаа зохицуулалттай төстэй байх боловч төслийн 67.2-т өмчилж байгаа сууцны тоогоор саналын нэг эрхтэй байна гэж заажээ. Энэ харилцааг одоогийн зохицуулалтын агуулгыг боловсронгуй болгох хүрээнд зөрчилгүй байдлаар онолын үндэстэй томъёолохыг санал болгож байна.</p>
Хуулийн төслийн 56: түрээслэх гэх томъёоллын тухайд	<p>Иргэний хуульд хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгийг бусдын эзэмшил ашиглалтад хариу төлбөртэй болон төлбөргүй шилжүүлэх гэрээний олон төрлийг хуульчилсан бөгөөд эд хөрөнгө хөлслөх, орон сууц хөлслөх, эд хөрөнгийг түрээслэх, эд хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглах гэрээний төрлүүд хамгийн түгээмэл хэрэглэгддэг. Практикт хүн амьдран суух зориулалттай орон сууцыг бусдын эзэмшил ашиглалтад хариу төлбөртэй шилжүүлэх харилцааг орон сууц хөлслөх гэрээний төрөлд хамааруулж, маргаан гарсан үед энэ гэрээний зохицуулалтыг хэрэглэнэ. Түүнчлэн хөлслөх ба түрээсийн гэрээ нь үргэлж хариу төлбөртэй байх ба практикт орон сууцыг хариу төлбөргүй ашиглуулах тохиолдол ч бий. Иймд энэ бүлгийн зохицуулалтыг онолын үндэслэлтэй, практикт нийцсэн зөв нэрээр нэрлэн, агуулгыг тохируулах шаардлагатай.</p>
Хуулийн төслийн 60.3: СӨХ-ны эрх зүйн чадвар, чадамж эхлэх хугацааны тухайд	<p>Төсөлд СӨХ-г байгуулах тухай тогтоолд гарын үсэг зурснаар СӨХ байгуулагдахаар заасан нь эрх зүйн ямар учир холбогдолтой болохыг дахин нягтлах шаардлагатай. Хэрэв СӨХ хуулийн этгээд байх үзэл баримтлалыг сонгосон бол энэ нь хуулийн этгээдийн нэгэн адил улсын бүртгэлд бүртгүүлснээр иргэний эрх зүйн чадвар, чадамжаа олж авах томъёололтой байх нь зүйтэй эсэхийг нягтлах, ийм шаардлагагүй гэж үзвэл үндэслэлийн талаар тодорхой хэлэлцэх нь зүйтэй.</p>



2. Төсөлд найруулгын шинжтэй дараах санал байна. Үүнд:
 - 2.1. Төслийн 11.1 болон бусад хэсгүүдэд хүн, хуулийн этгээд гэх нэр томьёог хэрэглэсэн боловч 12.-т иргэн, хуулийн этгээд гэсэн;
 - 2.2. Төслийн 17.1-д "байгуулахдаа талаар" гэснийг "байгуулах талаар" гэж өөрчлөх;
 - 2.3. Төслийн 54.1.5 ба 54.1.1-ийн агуулга давхацсан;
 - 2.4. Төслийн 63.1.1-ийг дахин найруулах.